



МОНГОЛ УЛСЫН
ДЭЭД ШУУЖ



ХАННС - ЗАЙДЕЛИЙН
САЦ

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН

тайлбар

Улаанбаатар хот



МОНГОЛ УЛСЫН
ДЭЭД ШҮҮХ



Ханнс
Зайделийн
Сан

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ

тайлбар

Улаанбаатар хот
2008 он

ГАРЧИГ

Өмнөтгөл	...4
Номыг хамтран зохиогчдын танилцуулга	...5

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл	Хуулийн зорилт	...9
2 дугаар зүйл	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомж, түүнийг хэрэглэх	...11
3 дугаар зүйл	Хуулийн нэр томъёо	...14
4 дүгээр зүйл	Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаан	...18
5 дугаар зүйл	Захиргааны хэргийн шүүхийн акт, түүнийг заавал биелүүлэх	...21

Хоёрдугаар бүлэг.

6 дугаар зүйл	Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа, шүүхэд нэхэмжлэл гаргах эрх	...22
7 дугаар зүйл	Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах	...26
8 дугаар зүйл	Хэргийг урьдчилан шийдвэрлэх журам	...26
9 дүгээр зүйл	Захиргааны байгууллага, албан тушаалтан гомдлыг хянан үзээд гаргах шийдвэр	...29
10 дугаар зүйл	Захиргааны акт хууль бус болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргах	...33
11 дүгээр зүйл	Захиргааны акт гаргахыг даалгах	...36
12 дугаар зүйл	Маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгох	...36
13 дүгээр зүйл	Захиргааны акт гаргахыг даалгах	...38
14 дүгээр зүйл	Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх	...40
15 дугаар зүйл	Шүүхээс захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим	...43
16 дугаар зүйл	Захиргааны хэргийн нутаг дэвсгэрийн харьяалал	...47
17 дугаар зүйл	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал	...49

Гуравдугаар бүлэг.

18 дугаар зүйл	Хэргийн оролцогч	...50
19 дугаар зүйл	Хэргийн оролцогчдын бүрэлдэхүүн	...54
20 дугаар зүйл	Хэргийн оролцогчийн иргэний эрх зүйн чадвар	...55
21 дүгээр зүйл	Хэргийн оролцогчийн иргэний эрх зүйн чадамж	...56
22 дүгээр зүйл	Нэхэмжлэгчийн эрх, үүрэг	...60
23 дугаар зүйл	Хариуцагчийн эрх, үүрэг	...62
24 дүгээр зүйл	Хариуцагчийн эрх, үүрэг	...64
25 дугаар зүйл	Гуравдагч этгээд, түүнийг татан оролцуулах	...65
26 дугаар зүйл	Нэхэмжлэлийг хэд хэдэн этгээд хамтран гаргах	...66
27 дугаар зүйл	Хамтран хариуцагч	...68
28 дүгээр зүйл	Хариуцагчийг солих	...69
29 дугаар зүйл	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан авах	...71
30 дугаар зүйл	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг төлөөлөх	...72
31 дүгээр зүйл	Төлөөлөгчийн бүрэн эрх	...72
32 дугаар зүйл	Төлөөлөн оролцож болохгүй байдал	...73
33 дүгээр зүйл	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох	...73

Дөрөвдүгээр бүлэг.

34 дугаар зүйл	Нотлох баримт	...74
35 дүгээр зүйл	Нотлох баримт	...102
36 дүгээр зүйл	Захиргааны хэргийг нотлох үүрэг	...102

Тавдугаар бүлэг.

37 дүгээр зүйл	Нэхэмжлэл гаргах, түүнийг хүлээн авах	...112
38 дугаар зүйл	Нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн хэлбэр, бүрдүүлбэр, агуулга	...115
39 дүгээр зүйл	Нэхэмжлэл хүлээн авах	...115

34 дүгээр зүйл	Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах	...115
35 дугаар зүйл	Нэхэмжлэлийг өөр шүүхэд шилжүүлэх	...117
36 дугаар зүйл	Захиргааны хэрэг үүсгэх	...118
37 дугаар зүйл	Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа	...118
38 дугаар зүйл	Нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах	...120
39 дүгээр зүйл	Сөрөг нэхэмжлэл	...121
40 дүгээр зүйл	Иргэн, албан тушаалтныг захиргааны хэргийн шүүхэд дуудан ирүүлэх	...121
41 дүгээр зүйл	Нэхэмжлэлээс татгалзах	...122
42 дугаар зүйл	Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх	...122
43 дугаар зүйл	Нэхэмжлэгч, хариуцагч эвлэрэх	...123
44 дүгээр зүйл	Нэхэмжлэлийн шаардлагыг нэгтгэх, тусгаарлах	...124
45 дугаар зүйл	Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх	...124
46 дугаар зүйл	Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нөхцөл	...125
47 дугаар зүйл	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа	...125
48 дугаар зүйл	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх	...126

Зургадугаар бүлэг

Шүүх хуралдааныг товлон зарлах, түүнд бэлтгэх

49 дүгээр зүйл	Шүүх хуралдааныг товлон зарлах	...126
50 дугаар зүйл	Шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг томилох	...127
51 дүгээр зүйл	Иргэдийн төлөөлөгчийг томилох	...128

Долдугаар бүлэг.

Шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогч, хуралдааны нийтлэг журам

52 дугаар зүйл	Шүүх бүрэлдэхүүн	...129
53 дугаар зүйл	Шүүгч буюу шүүх бүрэлдэхүүнийг солих	...130
54 дүгээр зүйл	Шүүх хуралдаанд оролцогч	...130
55 дугаар зүйл	Шүүх хуралдаанд прокурор оролцох	...131
56 дугаар зүйл	Иргэдийн төлөөлөгч, түүний эрх, үүрэг	...131
57 дугаар зүйл	Захиргааны хэргийн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга	...133
58 дугаар зүйл	Гэрч	...133
59 дүгээр зүйл	Шинжээч	...135
60 дугаар зүйл	Орчуулагч, хэлмэрч	...137
61 дүгээр зүйл	Шүүх хуралдаан	...139
62 дугаар зүйл	Шүүх хуралдаан даргалагч, түүний эрх, үүрэг	...139
63 дугаар зүйл	Шүүх хуралдааны нийтлэг журам	...140
64 дүгээр зүйл	Шүүгч өөрөө татгалзан гарах үндэслэл	...140
65 дугаар зүйл	Татгалзан гарах хүсэлт, татгалзан гарах	...143
66 дугаар зүйл	Шүүгчийн татгалзан гаргасны үр дагавар	...145
67 дугаар зүйл	Шийдвэрийг зөвлөлдөх тасалгаанд гаргах, санал хураах	...146
68 дугаар зүйл	Шүүх хуралдааны тэмдэглэл	...148

Наймдугаар бүлэг.

Анхан шатны шүүх хуралдааны дэг, анхан шатны шүүхийн шийдвэр

69 дүгээр зүйл	Шүүх хуралдааны дэг	...149
70 дугаар зүйл	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, түүнийг гаргах	...166
71 дүгээр зүйл	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хэл	...181
72 дугаар зүйл	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн агуулга	...182
73 дугаар зүйл	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг уншиж сонсгох, хүргүүлэх	...190
74 дүгээр зүйл	Захиргааны хэргийн шүүхээс гаргах бусад шийдвэр	...191
75 дугаар зүйл	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт засвар оруулах	...193
76 дугаар зүйл	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт нэмэлт оруулах	...196
77 дугаар зүйл	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох	...197
78 дугаар зүйл	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх	...201
79 дүгээр зүйл	Захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж	...205
80 дугаар зүйл	Захиргааны хэргийн шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамж	...208

Есдүгээр бүлэг.

	Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	
81 дүгээр зүйл	Давж заалдах гомдол гаргах, гомдлыг хүлээн авах	...214
82 дугаар зүйл	Давж заалдах гомдлын хэлбэр, агуулга	...218
83 дугаар зүйл	Давж заалдах гомдлоос татгалзах	...221
84 дүгээр зүйл	Шүүх хуралдаанд оролцох	...222
85 дугаар зүйл	Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх	...223
86 дугаар зүйл	Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан хэлэлцсэн захиргааны хэргийн шүүхийн магадлал	...226
87 дугаар зүйл	Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөх	...227
88 дугаар зүйл	Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох	...228
89 дүгээр зүйл	Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн заалтыг заавал биелүүлэх	...230
90 дүгээр зүйл	Захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргах	...231

Аравдугаар бүлэг.

	Хяналтын журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	
91 дүгээр бүлэг	Хяналтын журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх	...233

Арваннэгдүгээр бүлэг

	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаар захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг дахин хянах	
92 дугаар зүйл	Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлэх	...253

Арванхоёрдугаар бүлэг.

	Бусад зүйл	
93 дугаар зүйл	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх	...259
94 дүгээр зүйл	Хууль хүчин төгөлдөр болох	...262

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай

/Доктор/jug./, доктор/h.c./, проф.Хайнрих Шолер, Доктор/jug./, доктор/h.c./ Юрген Харбих нарын тайлбар/

Оршил	...263
I, II бүлэг	...265
III-VI бүлэг	...282
VII-XII бүлэг	...315

Хавсралт
Ном зүй

ӨМНӨТГӨЛ

Монгол Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын болон Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчид, ХБНГУлсын эрдэмтэн багш нар, Ханнс-Зайделийн сангийн “Эрх зүйн боловсрол” академийн ажилтнууд, захиргааны эрх зүйн чиглэлд мэргэшсэн бусад хуульчдын хамтын бүтээл болох “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар” номыг та бүхэнд толилуулж байна.

Улсын Дээд шүүхээс эрхлэн цуврал болгон гаргаж буй Монгол Улсын хуулиудын дэлгэрэнгүй тайлбарын хоёр дахь нь энэ ном боллоо.

Энэхүү бүтээл нь хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг тууштай хамгаалах, хуулийн өмнө бүгд тэгш байх зарчмыг хангах их үйлсэд хүчин зүтгэж буй шүүгчдийн мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, онолын сэтгэлгээг хөгжүүлэх, хуулийг зөв тайлбарлан хэрэглэхэд нэмэр болно гэж итгэнэм.

Мөн захиргааны эрх зүйн чиглэлээр ажиглаж буй эрдэмтэд, судлаачид, багш, оюутан нар сургалтын болон эрдэм шинжилгээний ажилдаа хэрэглэх боломжтой юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар номыг гаргахад өөрсдийн оюун ухаан, хүч чадлаа дайчлан ажилласан нийт шүүгчид, шүүгчийн туслахууд, ХБНГУлсын эрдэмтэн багш нар, Ханнс-Зайделийн сангийн “Эрх зүйн боловсрол” академийн ажилтнууд болон уг номыг бүтээхэд дэмжлэг үзүүлж, санхүүжүүлсэн Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төслийн удирдагч доктор, /Ph/ профессор Ц.Сарантуяад гүн талархалаа илэрхийлье.

Номын буян өнөд мөнх оршиж, та бүхний минь
угтах зам, үлдэх мөр тань үргэлж цагаан байх болтугай.

МОНГОЛ УЛСЫН
ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

VORWORT

Wir präsentieren Ihnen den „Ausführlichen Kommentar der Verwaltungsgerichtsordnung“ der im Ergebnis der Zusammenarbeit der Richter der Verwaltungskammer des Obersten Gerichts der Mongolei und des Verwaltungsgerichts der Hauptstadt, der Professoren und Wissenschaftler aus der Bundesrepublik Deutschland, der Mitarbeiter der Akademie „Rechtsbildung“ sowie anderer Juristen und Spezialisten entstand.

Dieser Kommentar ist der zweite Band der Reihe von Gesetzeskommentaren, die von dem Obersten Gericht herausgegeben wird.

Wir hoffen, dass dieses Werk dazu beitragen wird, das Wissen und die beruflichen Fähigkeiten, das theoretische Denken und das Können der richtigen Anwendung der Gesetze durch die Richter, die dazu berufen sind, die Hoheit des Gesetzes, die Grundrechte und –freiheiten der Bürger, die Gerechtigkeit, das Prinzip der Gleichheit vor dem Gesetz zu wahren und zu schützen, vertiefen und entfalten helfen wird.

Dieses Buch kann auch als ein Hilfswerk für die Wissenschaftler, Forscher und Studenten bei der Lehre und Forschung und dem Studium im Bereich des Verwaltungsrechts dienen.

Unser Dank gilt allen Richtern, den Richterassistenten, den deutschen Wissenschaftlern und Professoren, den Mitarbeiter der Akademie „Rechtsbildung“ und besonders Frau Prof. Dr. Ts. Sarantuya, der Leiterin des Projektes der Hanns-Seidel-Stiftung in der Mongolei, die die Schaffung und die Veröffentlichung dieses Kommentars allseitig unterstützt und finanziert hat.

Möge das Wissen, dass das Buch enthält Euch hilfreich sein, und der Weg, der vor Euch steht, und die von Euch hinterlassenen Spuren immer hell und voller Licht sein.

PRÄSIDENT DES OBERSTEN GERICHTS
DER MONGOLEI

S. BATDELGER

ХАМТРАН ЗОХИОГЧИД

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМЫН ТЭРГҮҮН



Оросоогийн ЗАНДРАА (X бүлэг)

1981 онд Хууль цаазны дунд сургууль, 1995 онд МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийг тус тус төгссөн, хуульч.

Монгол Улсын шүүхийн шүүгчийн "Тэргүүн түшээ" зэрэг дэвтэй.

1977-1980 онд хугацаат цэргийн албан хаагч;

1981-1984 онд Хөвсгөл аймгийн шүүхэд шүүгч;

1984-1985 онд Октябрийн районы шүүхэд тогтоол гүйцэтгэгч;

1985-1987 онд Улаанбаатар хотын шүүхэд тогтоол гүйцэтгэгч;

1987-1989 онд Сүхбаатарын районы шүүхэд тогтоол гүйцэтгэгч;

1989-1990 онд Октябрийн районы шүүхэд ахлах тогтоол гүйцэтгэгч;

1990-1992 онд Улаанбаатар хотын хууль зүйн газарт байцаагч, тогтоол

гүйцэтгэлийн албаны дарга;

1995-1999 онд Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгч;

1999-2000 онд Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгч;

2000-2001 онд Нийслэлийн шүүхийн шүүгч;

2001-2004 онд Улсын Дээд шүүхийн шүүгч;

2004 оноос Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн.

ШҮҮГЧ



Дуламын Пунцаг (IV бүлэг)

1975 онд МУИС-ийн хуулийн ангийг төгссөн, хуульч.

Монгол Улсын шүүхийн шүүгчийн "Тэргүүн түшээ" зэрэг дэвтэй.

1969-1971 онд цэргийн албан хаагч;

1975-1977 онд Дорноговь аймгийн хэсгийн ардын шүүхэд шүүгч;

1978-1981 онд Улаанбаатар хотын Сүхбаатарын районы шүүхийн шүүгч;

1981-1994 онд Дархан хотын шүүхийн орлогч дарга, дарга, Ерөнхий шүүгч;

1994-1999 онд Орхон аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч;

1999-2002 онд Улсын Дээд шүүхийн шүүгч;

2002-2004 онд Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн ажлын албаны

дарга;

2004 оноос Улсын Дээд шүүхийн шүүгч

ШҮҮГЧ



Цэвэгмидийн СУМБЯА (II бүлэг, 12-15 дугаар зүйл)

1985 онд Монгол Улсын их сургуулийн хуулийн анги төгссөн, хуульч.
Монгол Улсын шүүхийн шүүгчийн "Дэд түшээ" зэрэг дэвтэй.
1972-1975 онд Өмнөговь аймгийн Баяндалай суманд малчин;
1975-1978 онд Цэргийн албан хаагч;
1978-1980 онд Өмнөговь аймгийн Цогт-Овоо суманд ХЗЭ-н үүрийн нарийн бичгийн дарга;
1985-1987 онд Өмнөговь аймгийн Ардын Депутатуудын хурлын Гүйцэтгэх Захиргаанд зохион байгуулагч;
1987-1989 онд Өмнөговь аймгийн Ерөнхий Арбитрч;
1989-1990 онд Өмнөговь аймгийн Хууль зүй Арбитрын хэлтсийн дарга;
1990-1993 онд Өмнөговь аймгийн шүүхийн дарга;
1993-2005 онд Өмнөговь аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч;
2005-2006 онд Өмнөговь аймгийн шүүхийн шүүгч;
2006 оноос Улсын Дээд шүүхийн шүүгч.

ШҮҮГЧ



Чулууны ТУНГАЛАГ (III бүлэг)

1985 онд ОХУ-ын Эрхүү хотын Улсын их сургуулийн хуулийн анги төгссөн, хуульч.
Монгол Улсын шүүхийн шүүгчийн "Дэд түшээ" зэрэг дэвтэй.
1985-1986 онд Улаанбаатар хотын Багануурын районы прокурорын газарт дадлагажигч ажилтан;
1986-1989 онд Завхан аймгийн прокурорын газарт шүүхийн хяналт хариуцсан прокурор;
1989-1990 онд УЕПГ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэст прокурор;
1990-1996 онд УЕПГ-ын шүүхийн хяналтын хэлтсийн прокурор;
1996-1997 онд Улсын Аюулгүй байдлыг хангах газрын хуулийн зөвлөх;
1997-1998 онд Улсын аюулгүй байдлыг хангах газрын мөрдөн байцаах албаны дарга;
1998-1999 онд Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгч;
1999-2004 онд Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч;
2004 оноос Улсын Дээд шүүхийн шүүгч.

ШҮҮГЧ



Пүрэвийн ЦЭЦГЭЭ(IX, XI бүлэг)

1975 онд Хууль цаазны дунд сургууль, 1983 онд МУИС-ийн хуулийн ангийг тус тус төгссөн, хуульч.
Монгол Улсын шүүхийн шүүгчийн "Дэд түшээ" зэрэг дэвтэй.
1975-1978 онд Архангай аймгийн Батцэнгэл сумын "Улаан туг" нэгдэлд боловсон хүчин;
1983-1984 онд Улаанбаатар хотын Сүхбаатарын районы шүүхэд тогтоол гүйцэтгэгч;
1984-1990 онд Сүхбаатарын районы шүүхэд шүүгч;
1990-1993 онд Улсын Дээд шүүхийн гишүүн;
1993-1994 онд Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн шүүн таслах ажил

эрхэлсэн туслах;

1994-2002 онд Улсын Дээд шүүхэд шүүгч;

2002-2004 онд Улсын Дээд шүүхийн дэргэдэх Судалгааны төвийн захирал;

2004 оноос Улсын Дээд шүүхийн шүүгч.

ШҮҮГЧ



Лхүндэвийн АТАРЦЭЦЭГ (VIII бүлэг)

1985 онд ОХУ-ын Эрхүү хотын Улсын их сургуулийн хуулийн анги төгссөн, хуульч.
Монгол Улсын шүүхийн шүүгчийн "Дэд түшээ" зэрэг дэвтэй.
1985 оны 7 дугаар сараас 1985 оны 11 дүгээр сар хүртэл Дархан хотын шүүхэд нарийн бичгийн дарга;
1985-1990 онд Дархан хотын Найрамдал хорооны шүүхийн шүүгч;
1990-1998 онд Дархан хотын шүүхийн гишүүн, шүүгч;
1998- 2005 он хүртэл Нийслэлийн шүүхийн шүүгч;
2005 оноос Улсын Дээд шүүхийн шүүгч.

ШҮҮГЧ



Хөхийсүрэнгийн БАТСҮРЭН(V, VI, VII бүлэг)

1989 онд ОХУ-ын Дотоод Яамны Академийг хуульч мэргэжилээр төгссөн.
1999 онд ХБНГУ-ын Гёттингений Их Сургуульд хууль зүйн магистр хамгаалсан.

1989-1995 онд Хэнтий аймгийн Цагдан сэргийлэх анги, Баянгол дүүргийн Цагдаагийн хэлтэст эрүүгийн төлөөлөгч;

2000-2004 онд Шүүхийн ерөнхий зөвлөлд мэргэжилтэн;

2004 оноос Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгч,

Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл,

сурталчилгааны үндэсний төвийн Шүүгчдийн сургалтын дэд хорооны гишүүн.



Намсрайн ТУНГАЛАГ

1974-1979 онд МУИС-ийн хуулийн ангийг эрх зүйч мэргэжлээр,
1989-1992 онд Олон улсын харилцааны дээд сургуулийг франц хэлний хэлмэрч мэргэжлээр тус тус суралцаж төгссөн;
1979-1987- Сайд нарын Зөвлөлийн /хуучин нэрээр/ Хэрэг эрхлэх газрын хуулийн хэлтэст мэргэжилтэн яаманд хуулийн зөвлөх;
1992-1999- Хууль зүйн яаманд мэргэжилтэн, лах мэргэжилтэн;
1999 оноос одоог хүртэл Улсын Их Хурлын Тамгын газрын хуулийн хэлтэст зөвлөхөөр ажиллаж байна.

ХБНГУ-ЫН ХАННС-ЗАЙДЕЛИЙН САНГИЙН
“ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ” АКАДЕМИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Норлоогийн ЭРДЭНЭЦОГТ

1982-1988 онд ХБНГУ-ын Фрайберг хотын их сургууль,
1993-1996 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд тус тус суралцаж төгссөн,
1996-1998 онд МГБССН-т хуулийн зөвлөх;
1998-2001 онд Хууль зүй, дотоод хэргийн яаманд мэргэжилтэн, тус яамны дэргэдэх Хууль зүйн мэдээллийн төвийн захирал;
2001 оноос одоог хүртэл Ханнс-Зайделийн сангийн “Эрх зүйн боловсрол” академийн Гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.

БАГШ

Аюурзанын ЭНХТҮЯА

1975-1981 онд ОХУ-ын Воронежкийн их сургуульд суралцаж хуульч мэргэжлээр төгссөн;
1981-1983 онд Булган аймгийн Прокурорын газарт туслах прокурор;
1983-1996 онд Улсын Ерөнхий прокурорын газрын Шүүн таслах ажиллагаанд хяналт тавих болон Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтэст хяналтын прокурор;
1997-2001 онд Улаанбаатар хотын Гаалийн газарт, Гаалийн Ерөнхий газарт хуулийн зөвлөх;
2001 оноос одоог хүртэл Ханнс-Зайделийн сангийн “Эрх зүйн боловсрол” академийн багшаар ажиллаж байна.

Доктор, доктор (h.c.), профессор Хайнрих ШОЛМЕР

1953 – 1960 онд ХБНГУ-ын Мюнхений их сургуулийг хуульч, улс төрийн шинжлэх ухаан мэргэжлээр төгссөн
1957 онд Мюнхений их сургуульд хууль зүйн ухааны докторын зэрэг,
1966 онд Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг тус тус хамгаалсан;
1960-1971 онд Бавари муж улсын Захиргааны хэргийн шүүхийн шүүгч;
1971 оноос одоог хүртэл Людвиг Максимилианы их сургуулийн Эрх зүйн философи болон Улс төрийн шинжлэх ухааны сургуульд профессор;
1972-1975 онд Этиоп улсын Адис Абибагийн их сургуулийн профессор;

1990 оноос одоог хүртэл Этиоп, Монгол Улс, БНХАУ, Марокко зэрэг олон оронд зочин профессороор ажиллаж байна.
1999 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн “Хүндэт доктор” цол хүртсэн.

Доктор, доктор (h.c.) Юрген ХАРБИХ

1956-1964 онд ХБНГУ-ын Мюнхен хотын их сургуульд хуульч мэргэжлээр суралцаж төгссөн, практикум /референдар/ хийсэн,

1964 онд Хууль зүйн хоёрдугаар улсын шалгалт өгсөн;

1964 – 1965 онд Мюнхен хотын Захиргааны шүүх;

1965 – 1972 онд Дээд баварийн Бад Айблингийн захиргаанд ажилласан (төрийн буюу орон нутгийн захиргааны нэгж байгууллага) ;

1971 – 1973 онд Мюнхен хотод референдаруудын ажлын хэсгийн ахлагч, Баварийн захиргааны сургуульд багш;

1973 оноос тус сургуулийн удирдах зөвлөлийн гишүүн;

1974 – 1999 онд тус сургуулийн захирал;

1987 – 1989 онд Мюнхен хотын Бундесверийн их сургуульд төрийн эрх зүйн багш;

1974 – 1999 онд “АРФ” мэргэжлийн сэтгүүлийг хамтран гаргагч;

1982 оноос одоог хүртэл Хөдөлмөрийн шүүхэд орон тооны бус шүүгч;

1989 оноос одоог хүртэл Бенин, Конго, Марокко, Нигер, Тунез, Венесуэл, БНХАУ, Монгол, Польш, ОХУ, Словак, Словени, Чех, Украин, Унгар улсуудад айлчлан их, дээд сургуулиуд, академиуд дээр төрийн болон захиргааны эрх зүйн сэдвүүдээр лекц уншиж байна.

2005 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн “Хүндэт доктор” цол хүртсэн.

МОНГОЛ УЛСЫН ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь иргэн, хуулийн этгээдээс захиргааны актыг хууль бус гэж үзэж, зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар гаргасан гомдол, нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх болон уул захиргааны хэргийг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ТАЙЛБАР

Эрх зүйт төр нь нэгдүгээрт, хүний эрх, эрх чөлөөг дээд үнэт зүйл хэмээн хүлээн зөвшөөрч, хоёрдугаарт, төрийн бүх байгууллага, тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагааны тулгуур зарчмын нэг нь хууль дээдлэх явдал байдгаараа онцлог билээ.

Иймээс ч Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус заасан байна.

Захиргааны байгууллага, түүний албан тушаалтан нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн, хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр бусад этгээд – иргэн, хуулийн этгээдийг захирамжилсан үйлдлийг хэрэгжүүлдэг бөгөөд энэхүү үйлдлээрээ тухайн иргэн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлын хүрээнд халдасны улмаас дээрхи субъектуудын Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь хязгаарлагдах, зөрчигдөх тохиолдол гардаг байна.

Нийтийн захиргаанаас засагласан үйлдлээ хэрэгжүүлж байгаа энэ хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хангах, хууль ёсыг сахиулах нь ардчилсан эрх зүйт төр өөрөө оршин тогтнох үндсэн нөхцлийн нэг учраас захиргааны байгууллага болон түүний албан тушаалтны дээрх үйл ажиллагаанд тавих хяналт зайлшгүй шаардлагатай ажээ. “...байгууллага, албан тушаалтны “нийтийн захиргааны” гэх шинж нь өөрийн ажиллагчдыг биш харин “гуравдагч” гэж ялгадаг хөндлөнгийн хүн, үл харьяалагдах хуулийн этгээдийг хамааруулан, тэднээс заавал биелүүлэх акт дангаараа мэдэж гаргадаг, шаардлагатай бол албадах эрх бүхий байдгаар илэрнэ.”¹

Иймд эрх зүйт төрийн хууль дээдлэх үндсэн зарчмыг баримтлан хүний эрх, эрх чөлөөг хангах хууль зүйн нэг баталгааг бүрдүүлэхийн тулд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийг Улсын Их Хурлаар хэлэлцэж 2002 оны 12

¹ Б.Чимид, Монгол Улсын захиргааны хэргийн шүүхийн мөн чанар, нийгэм- эрх зүйн ач холбогдол – “Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг”, УБ., 2004, 58-р хуудас.

дугаар сарын 26- ны өдөр баталсан билээ. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг:

- Нийтийн захиргааны зүгээс иргэн, хуулийн этгээдэд чиглүүлэн хэрэгжүүлж буй олон төрлийн үйлдлийг иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдол, нэхэмжлэлийг үндэслэн хянах;
- Иргэдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг захиргааны хууль бус үйлдлээс хамгаалах;
- Захиргааны хууль бус актын улмаас зөрчигдсөн иргэн, хуулийн этгээдийн эрхийг нь сэргээж, хохирлыг арилгуулах ажиллагааг зохицуулах зорилгоор гаргажээ.

1.Энэ хуульд зааснаар захиргааны гадагш чиглэсэн буюу өөрийн дотоод үйл ажиллагааг зохицуулахын тулд бус харин өөрт харъяалагдахгүй субъектэд зориулан гаргасан захиргааны актад тавих хяналт нь дотоод буюу дээд шатны захиргааны байгууллагаас тавих хяналт болон хөндлөнгөөс – захиргааны хэргийн шүүхээс хэрэгжүүлэх хяналтаас тус тус бүрдэнэ. Гэхдээ захиргаанд тавих хяналтын ажиллагаа нь зөвхөн тухайн захиргааны акт хаяглагдсан, өөрөөр хэлбэл уг актаар субъектив² эрх нь хөндөгдөж байгаа иргэн, хуулийн этгээд өөрийн хууль ёсны эрхээ хамгаалуулахаар гаргасан гомдол, нэхэмжлэлийг үндэслэн явагдаж эхлэх онцлогтой. "...хүний болон хувийн хуулийн этгээдийн эрх, эрх чөлөө ашиг сонирхлыг захиргааны хууль бус, дур зоргын үйл ажиллагаанаас хамгаалах нь захиргааны хэргийн шүүхийн тэргүүн зэргийн чиг үүрэг мөн."³

Захиргааны актыг хүлээн авсан иргэн, хуулийн этгээд уг актыг хууль бус гэж үзэж, өөрийн зөрчигдсөн эрхийг хамгаалуулахаар тухайн актыг гаргасан байгууллага, албан тушаалтныг шууд харъяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргасны үндсэн дээр дотоод хяналт буюу захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явагдаж эхлэх бол энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2-т заасан тохиолдолд иргэн, хуулийн этгээд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаснаар хөндлөнгөөс буюу захиргааны хэргийн шүүхээс тавих хяналт хэрэгжинэ.

2.Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх болон захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх эрх бүхий субъект нь энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д зааснаар иргэн, хуулийн этгээд юм. Мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т зааснаар "иргэн" нь Монгол Улсын ба гадаад улсын иргэн, харъяалалгүй хүн байна.

Харин хуулийн этгээдийн хувьд бол Монгол Улсын Иргэний хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д зааснаар иргэн, хуулийн этгээдээс үүсгэн байгуулж болох хуулийн этгээдээс эхлээд хуульд заасан журмын дагуу байгуулагддаг нийтийн эрх зүйн хуулийн этгээд байж болно. Жишээ нь, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас аймгийн Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлж Ерөнхий сайдад санал болгох ба түүнийг томилохоос татгалзвал дахин нэр дэвшүүлэх, дахин нэр дэвшүүлсэн хүнийг

² Субъектив эрх гэдэг нь тодорхой этгээд (хувь хүн эсхүл хуулийн этгээд) – ийн бодит эрх буюу хуулиар зөвхөн түүнд олгогдсон тодорхой үйлдэл хийх болон тодорхой үйлдэл хийхийг (эсхүл үйлдэл хийхгүй байхыг) бусдаас шаардах, эрх нь зөрчигдсөн тохиолдолд эрхээ хамгаалуулах зорилгоор шүүхэд хандах боломж юм. Жишээ нь, хувь хүн өөрийн хөрөнгийг өмчлөх, ашиглах, захиран зарцуулах эрхтэй бөгөөд түүний энэ эрхэнд халдахгүй байхыг бусад этгээдээс шаардах эрхтэй байдаг.

³ Б.Чимид, Монгол Улсын захиргааны хэргийн шүүхийн мөн чанар, нийгэм- эрх зүйн ач холбогдол – "Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг", УБ., 2004, 52-р хуудас.

томилохоос татгалзсан нөхцөлд Ерөнхий сайд тухайн шатны Хуралтай зөвшилцөн Засаг даргыг томилох журамтай (хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.3, 10.4). Хэрэв Ерөнхий сайд энэ журмыг зөрчин аймгийн Засаг даргыг тухайн хуралтай зөвшилцөхгүйгээр томилбол аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой.

3. Захиргааны акт нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илэрхий хязгаарласан, зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн болон бодит үнэн байдлыг илэрхийлж чадаагүй баримтууд дээр тулгуурлан гарсан, мөн акт гаргах талаар тогтоосон журмыг зөрчсөн зэрэг тохиолдолд түүнийг хууль бус захиргааны актад тооцдог. Захиргааны хууль бус актын үр дагавар түүнд агуулагдаж байгаа алдаанаас хамаарч өөр өөр байна. Тухайлбал захиргааны актыг илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх (ЗХХШТХ-ийн 9 дүгээр зүйл), маргаантай захиргааны актын зарим хэсгийг, эсхүл бүхэлд нь хүчингүй болгоно (ЗХХШТХ-ийн 10 дугаар зүйл).

4. Захиргааны хэрэг гэдэг нь нэг талаас нийтийн захиргаа, нөгөө талаас нийтийн захиргаанаас хэрэгжүүлсэн захирамжилсан үйлдлийн улмаас субъектив эрх нь хөндөгдсөн иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн нийтийн эрх зүйн агуулгатай маргаанаас үүдэн ЗХХШТХ-д заасны дагуу иргэн, хуулийн этгээд гомдол, нэхэмжлэл гаргаснаар мөн хуульд заасан эрх бүхий субъектээс үүсгэсэн хэрэг юм.

Захиргааны хэрэг дараах онцлог шинжүүдтэй:

- Хэргийн нэг талд нь заавал захиргааны байгууллага, албан тушаалтан оролцоно.
- Захиргаа, иргэний хоорондын захирах, захирагдах харилцаанаас үүссэн маргаан байна.
- Өөр хоорондоо харилцан адилгүй зэрэгцсэн шинжтэй олон төрлийн маргаан байх боломжтой.
- Захирах, захирагдах харилцааны явцад иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөнтэй холбоотой байна.⁴

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь бүхэлдээ:

- Нийтийн эрх зүйн маргааныг шийдвэрлэнэ.
- Уг маргааныг шүүх эцэслэн шийднэ.
- Энэ ажиллагааны үндсэн зорилгын нэг нь иргэдэд эрх зүйн хамгаалал олгож тэдний субъектив эрхийг захиргааны хууль бус халдлагаас хамгаалах явдал байдаг.
- Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад иргэн; нийтийн захиргаа, түүний албан тушаалтан; маргааныг таслах албан тушаалтан (шүүгч) гэсэн тусгай субъектуудын хооронд эрх зүйн харилцаа үүснэ.
- Иргэд болон эрх зүйн бусад субъектийн зүгээс нийтийн захиргаатай үүсгэсэн маргаан нь захиргааны хэргийн шүүхэд харьяалагдана.

⁴ А.Эрдэнэцогт, Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй, УБ., 2006, 81-р хуудас.

- Байцаан шийтгэх ажиллагааны хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу маргааныг хянан шийдвэрлэх ба уг журам нь маргалдагч талууд энэ ажиллагаанд адил тэгш эрхтэйгээр оролцох боломжийг хангадаг.
- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль зүйн “үр дүн” нь захиргааны актын хууль бус эсхүл хүчин төгөлдөр биш (эсрэгээр хууль ёсны бөгөөд хүчин төгөлдөр) гэдгийг захиргааны хэргийн шүүхийн зүгээс тогтоох зэрэг үндсэн шинжүүдээр тодорхойлогдох ажээ.⁵

2 дугаар зүйл. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай
хууль тогтоомж, түүнийг хэрэглэх

- 2.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль⁶, Шүүхийн тухай⁷, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
- 2.2. Захиргааны хэргийн шүүх маргааныг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль болон Монгол Улсын олон улсын гэрээг баримтална.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжид:

- Үндсэн хууль,
- Шүүхийн тухай хууль,
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль,
- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль,
- тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт тус тус багтана.

“Хууль тогтоомж” гэдэг үг Улсын нэр томъёоны комиссын батлан гаргасан жагсаалтад орж хэдий нь нийтлэгдсэний хувьд хуулийн хэвшмэл /тусгай/ нэр томъёо мөн. Энэ нь хууль тогтоох байгууллагаас гаргасан хууль зүйн дээд хүчин чадал бүхий (Үндсэн ба бусад хууль, Улсын Их Хурлын тогтоол, түүгээр “баталсан” дүрэм зэрэг) нийт актын нийлбэр цогц гэсэн утгатай болно. Хууль тогтоомжийн үндсэн дээр гаргасан (Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол...зэрэг) аливаа актыг нийтэд нь хуулийн дэд акт гэж нэрлэх нь зүйтэй.”

1.Монгол Улсын Үндсэн хуулийн төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг тогтоосон 1 дүгээр зүйлийн 2; 14 дүгээр зүйлийн 1-ийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”; 16 дугаар зүйлийн “12/

⁵ Ю.Н.Старилов, Административная юстиция (Проблемы теории), ВГУ, 1998, 59-60-р хуудас.

⁶ Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

⁷ Шүүхийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 29 дүгээрт нийтлэгдсэн.

⁸ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

⁹ Б.Чимид, Монгол Улсын захиргааны хэргийн шүүхийн мөн чанар, нийгэм- эрх зүйн ач холбогдол – “Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг”, УБ., 2004, 47-р хуудас.

төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй; 14/ Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ...нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах...эрхтэй.” гэсэн заалтууд болон шүүх эрх мэдлийн тухай Дөрөвдүгээр бүлгийн 47-55 дугаар зүйлийн заалтууд нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нийтлэг үндэслэл билээ.

Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “...эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын Дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно” гэсэн заалт нь манай улсад захиргааны хэргийн шүүх байгуулах тулгуур үндэслэл болсон юм.

2.Шүүх эрх мэдлийг хуулийн дагуу байгуулагдсан шүүх төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлэх ба шүүн таслах ажлын төрлөөр байгуулагдсан дагнасан шүүхүүд нь иргэн, төр, байгууллага, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх ашгийг хууль бус аливаа халдлагаас хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх нэгдсэн зорилготой. Монгол Улсын Шүүхийн тухай хуульд шүүх нь зохион байгуулалтын ямар бүтэц, тогтолцоотой байх, шүүхийн болон шүүгчийн бие даасан хараат бус байдал, шүүн таслах ажиллагаанд хэрэглэгдэх хууль зэргийг тогтоож, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх баталгаа нь болдгоороо захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжид гол байр суурийг эзэлнэ.

3.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарчмын тухай заасан 13 дугаар зүйлийн 13.1, уг ажиллагаанд оролцогчийн эрхийг залгамжлах тухай 25 дугаар зүйлийн 25.1, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нотлох баримтыг ойлгох, гаргаж өгөх, цуглуулах, үнэлэхэд баримтлах журмын талаархи 30 дугаар зүйлийн 30.1- ийн заалт болон бусад олон зүйл, заалтад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн заалтуудыг мөрдөхөөр тусгажээ. Энэ нь уг хууль захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэр ач холбогдолтойг харуулж байна.

Гэхдээ харилцан тэнцүү биш эрхтэй субъектуудын хооронд буюу захиргааны захирамжилсан актаар субъектив эрх нь зөрчигдсөн иргэн болон уг актыг гаргасан захиргаа (төр) хоёрын хооронд үүссэн маргааныг захиргааны дагнасан шүүхээс шийдэхдээ эрх тэгш субъект хоорондын хувийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан хуулийн заалтыг цаашид ч хэрэглэнэ гэсэн үг биш бөгөөд ингэх ч боломжгүй юм. “...хянан шийдвэрлэх ажиллагаа (процесс)-ны зарчим, журмын хувьд адилсах зарим талтай учир энэ хуульд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиас бүгд олон зүйлийг хамаатуулж заасан нь чухал учир шалтгаантай.

Ингэхдээ Монголын шүүгчдийн хувьд захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд тулгамдах магадлалыг багасгаж дөхөмтэй болгохыг бодолцсон юм. Алсдаа шинэ төрийн шүүхийн практикийг үндэслэн түүний онцлогийг тусган тусад нь хуульчлах буй заа.”⁸

4. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжид Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль мөн чухал байрыг эзэлнэ. Учир нь захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх шатанд гомдолд тавигдах шаардлага, гомдлыг хүлээн авах, бүртгэх, түүнд хариу өгөх зэрэгт мөн хуулиар тогтоосон журмыг баримтлахаар ЗХХШТХ-д (хуулийн 6.2, 6.4) зохицуулсан байна. Түүнчлэн Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай, Өмгөөллийн тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Иргэний зэрэг хуулиудаас гадна материаллаг бусад хуулиуд энд мөн хамаарна. “Нэн ялангуяа энэ нь захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааг эс зөвшөөрвөл гомдол гаргах журмыг тусгайлан зохицуулсан хуулиудад хамаарна.”⁹

5. Хуулийн 2.2-т маргааныг хянан шийдвэрлэхдээ захиргааны хэргийн шүүхээс баримтлах хуулийн хүрээг тодорхойлж өгчээ. Захиргааны хэргийн шүүгч хэрэг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хуулиар тогтоосон төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг чанд мөрдөж, Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуульд захирагдах ёстой. Хуулийн 2.2-т зааснаас үзэхэд захиргааны хэрэг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хуулиар тогтоосон тулгуур зарчмуудыг нэн тэргүүнд баримтлах ба ЗХХШТХ нь захиргааны процессын суурь хууль болно.

Энэ нь Үндсэн хуульд нийцүүлэн гаргасан бусад хуулиуд ЗХХШТХ-тай нэг ижил түвшингийн боловч захиргааны хэргийн шүүгч хэрэг хянан шийдвэрлэхдээ маргаантай харилцааг зохицуулсан заалт ЗХХШТХ-д байхгүй өөрөөр хэлбэл “хуулийн хийдэл”-тэй тохиолдолд л тэдгээрийг хэрэглэх боломжтой гэж ойлгогдож байна. Харин тухайн маргаантай харилцааг зохицуулсан хууль байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулж байгаа хуулийг хэрэглэх бөгөөд тийм хууль байхгүй тохиолдолд захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн утга агуулга, ерөнхий үндэслэлийг удирдлага болгон хэргийг хянан шийдвэрлэх зарчмыг баримтлах юм.

Олон улсын гэрээний хувьд Монгол Улс албан ёсоор нэгдэн орсон олон улсын гэрээний заалтуудыг хэрэг хянан шийдвэрлэхдээ баримтлах ба Монгол Улсын Дээд шүүхийн “Монгол Улсын Олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 09 дүгээр тогтоолд¹⁰ энэ талаар тодорхой тайлбарлажээ.

Хууль тогтоомжийн үндсэн дээр гарсан хуулийн дэд актуудыг захиргааны хэргийн шүүхээс тухайн захиргааны хэрэгтэй холбогдуулан мөн авч үзэх боловч шийдвэр гаргахдаа тэдгээрийг баримтлах боломжгүй байна (ЗХХШТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.5).

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

⁸ Б.Чимид, Монгол Улсын захиргааны хэргийн шүүхийн мөн чанар, нийгэм- эрх зүйн ач холбогдол – “Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг”, УБ., 2004, 48-р хуудас.

⁹ А.Эрдэнэцогт, Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй, УБ., 2006, 30-р хуудас.

¹⁰ Монгол Улсын Дээд шүүхийн 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 09 дүгээр тогтоол

3.1. Энэ хуульд дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- 3.1.1. "захиргааны байгууллага" гэж нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага, түүнчлэн Засгийн газрын байгууллагын зарим үүргийг төлөөлөн гүйцэтгэдэг Засгийн газрын бус байгууллага, хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр бусдыг захирамжилсан шийдвэр гаргаж, нийтлэг үйлчилгээ үзүүлдэг сургууль, эмнэлэг, холбоо, харилцаа, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны болон шашны байгууллага зэрэг нийтийн эрх зүйн субъект болох байгууллагыг;
- 3.1.2. "захиргааны албан тушаалтан" гэж энэ хуулийн 3.1.1-д заасан байгууллагын нийтийн эрх зүйн хүрээнд захирамжлах, зохион байгуулах бүрэн эрхийг бие даан хэрэгжүүлдэг төрийн жинхэнэ албан хаагч, түүнчлэн нийтийн эрх зүйн холбогдолтой асуудлаар бусдыг захирамжилсан шийдвэр гаргадаг төрийн бус албан тушаалтныг;
- 3.1.3. "иргэн" гэж Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг;
- 3.1.4. "захиргааны акт" гэж нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар захиргааны байгууллага, албан тушаалтнаас амаар буюу бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон эрх зүйн үр дагавар шууд бий болгодог нэг удаагийн захирамжилсан бусад арга хэмжээ /үйлдэл, эс үйлдэхүй/-г; энэ хуулиар захиргааны байгууллагын хэм хэмжээ тогтоосон шийдвэр /зарлиг, тогтоол, дүрэм, заавар, журам/-ийг захиргааны актад хамааруулна;
- 3.1.5. "үйл ажиллагаа" гэж үйлдэл, эс үйлдэхүйг;
- 3.1.6. "эс үйлдэхүй" гэж иргэн, хуулийн этгээдээс эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хэрэгжүүлэх, хамгаалуулахаар гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх үүргээ захиргааны байгууллага, албан тушаалтнаас хуульд заасан хугацаанд биелүүлээгүй буюу шийдвэрлэхгүй орхигдуулсныг
- 3.1.7. "нэхэмжлэл" гэж иргэн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус актын улмаас зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны хэргийн шүүхэд хандаж гаргасан өргөдлийг;
- 3.1.8. "гомдол" гэж захиргааны хууль бус актын талаар тухайн байгууллагын удирдах дээд шатны нь байгууллага, албан тушаалтанд болон шүүхэд хандаж гаргасан нэхэмжлэлээс бусад өргөдлийг;
- 3.1.9. "шүүхийн шийдвэр" гэж анхан шатны шүүхээс захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд гаргасан баримт бичгийг;
- 3.1.10. "шүүхийн тогтоол" гэж захиргааны хэрэг хянан шийдвэрлэх аливаа ажиллагааны талаар шүүх бүрэлдэхүүнээс гаргасан анхан шатны шүүхийн хуралдааныхаас бусад баримт бичиг, мөн Улсын дээд шүүхийн хуралдаанаар хяналтын журмаар захиргааны хэргийг хянан хэлэлцээд гаргасан баримт бичгийг;

- 3.1.11. "шүүхийн магадлал" гэж давж заалдах шатны шүүхээс захиргааны хэргийг хянан хэлэлцээд гаргасан баримт бичгийг;
- 3.1.12. "шүүгчийн захирамж" гэж захиргааны хэрэг хянан шийдвэрлэх аливаа ажиллагааны талаар шүүгчээс дангаараа гаргасан баримт бичгийг;
- 3.1.13. "энгийн магадлал" гэж захиргааны байгууллага, албан тушаалтнаас хууль зөрчсөн үйл ажиллагааны шалтгаан, нөхцлийг арилгуулахаар тэдгээр байгууллага, албан тушаалтанд шаардаж захиргааны хэргийн шүүхээс гаргасан баримт бичгийг.

ТАЙЛБАР

Хуулийн энэ зүйлд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, захиргааны хэргийн шүүхэд холбогдох үндсэн гол ойлголтууд болох захиргааны байгууллага, албан тушаалтан, захиргааны акт зэргийг тодорхойлсон байна.

1.Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1.-д: "нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг...нийтийн эрх зүйн субъект болох байгууллагыг захиргааны байгууллага гэж ойлгоно" гэсэн байна. Өөрөөр хэлбэл төрийн нэрийн өмнөөс тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаагийн хувьд нийтийн эрх зүйн (нэг талаас иргэд, нөгөө талаас төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй байгууллагын хооронд үүссэн харилцааг зохицуулдаг) хэм хэмжээнд үндэслэн хөндлөнгийн, эрх зүйн бие даасан бусад субъектээс дагаж биелүүлэх шийдвэр гаргаж, түүний хэрэгжилтийг хангах зорилгоор шаардлагатай тохиолдолд албадлага хэрэглэдэг, ингэснээрээ иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөнддөг байгууллагуудыг нийтийн захиргаа буюу захиргааны байгууллага гэсэн нэг нэр томъёогоор илэрхийлжээ. Мөн захиргааны байгууллагад:

- төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага;
- засгийн газрын байгууллагын зарим үүргийг төлөөлөн гүйцэтгэдэг засгийн газрын бус байгууллагууд;
- нийтлэг үйлчилгээ үзүүлдэг байгууллагын захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, шашны байгууллага зэрэг нийтийн эрх зүйн субъект болох бусад байгууллага хамаарахыг дурджээ.

Хуулийн энэ заалтад "төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага" гэж заасан бөгөөд энд:

- Монгол Улсын Засгийн газар;
- Монгол Улсын яамд;
- Тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагууд;
- Бүх шатны Засаг дарга нарыг хамааруулдаг.

Хэдийгээр хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-ийн заалтын хүрээнд нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн гадагш чиглэсэн үйлдэл (шийдвэр, үйл ажиллагаа) хэрэгжүүлдэг Засгийн газар орох боловч түүний үйлдлийг захиргааны хэргийн шүүхийн хяналтанд хамааруулахгүй байхаар ЗХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2005 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар¹¹ тогтоосон байна.

¹¹ Энэ хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2005 оны дүгээрт нийтлэгдсэн.

Яамд нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага¹² юм. Засгийн газрын бүтцэд удирдлагын ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн яамд ажилладаг.

Яамыг УИХ-аас томилсон Засгийн газрын гишүүн–Монгол Улсын сайд удирдаж тухайн яамны үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилтийг Засгийн газрын өмнө хариуцдаг. Сайд нь өөрийн эрх хэмжээний асуудлаар Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргаж биелэлтийг нь хангуулах арга хэмжээ авна.

Тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагууд: Засгийн газрын бүтцэд салбар хоорондын, эсхүл тусгай эрх хэмжээг хэрэгжүүлэн төрийн захиргааны байгууллагууд ажиллах ба эдгээр агентлагууд нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, салбарт тохируулах, хэрэгжүүлэх чиг үүрэгтэйгээр ажиллана¹³. Агентлагийн дарга нар нь мөн хариуцсан асуудлаараа хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргаж биелэлтийг нь зохион байгуулна.

Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хороо, багийн Засаг дарга нар нь:

- тухайн нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлдэг (Үндсэн хуулийн 60-р зүйлийн 60.1) засаг төрийн төлөөлөгч юм. Тэрээр харьяа нутаг дэвсгэртээ төрийн хууль тогтоомж, Засгийн газар, харьяа дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө хариуцна.
- Засаг дарга тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлнэ (Үндсэн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1). Өөрөөр хэлбэл нутгийн өөрийн удирдлагын гүйцэтгэх байгууллага юм.

Засаг дарга нар эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжид нийцсэн, тухайн нутаг дэвсгэртээ үйлчлэх захирамж гаргана.

Засгийн газрын байгууллагын зарим үүргийг төлөөлөн гүйцэтгэдэг засгийн газрын бус байгууллагад Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан журамд үндэслэн тодорхой чиг үүргийг хэрэгжүүлж, үүнтэй холбоотойгоор улсын төсвөөс санхүүждэг, гүйцэтгэж байгаа чиг үүрэгтэйгээ холбогдсон ажлаа Монгол Улсын зохих сайдын өмнө хариуцдаг байгууллагыг ойлгоно. Засгийн газрын бус байгууллагыг ЗХХШТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д тодорхойлсон захиргааны байгууллагад хамааруулж байгаа гол үндэслэл нь тухайн байгууллага төлөөлөн гүйцэтгэж буй үүргээ биелүүлэх зорилгоор нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг явдал юм. Засгийн газрын бус байгууллагад эрх зүйн байдлын хувьд ямар ч байгууллага (төрийн бус байгууллага, компани гэх мэт) хамаарсан гэсэн тэдгээр нь:

1. гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын тогтолцоонд багтдаггүй байх;
2. засгийн газрын байгууллагын зарим үүргийг төлөөлөн гүйцэтгэх;
3. төлөөлөн гүйцэтгэх үүрэг нь нийтийн эрх зүйн хүрээнд хамаарах;
4. үйл ажиллагаа нь захиргааны актын шинж агуулсан байх¹⁴ ёстой ажээ.

¹² Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 3-р зүйлийн 3.1. Энэ хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2004 оны 16 дугаарт нийтлэгдсэн.

¹³ Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3-р зүйлийн 3.1.. Энэ хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2004 оны 16 дугаарт нийтлэгдсэн.

¹⁴ Хууль зүйн үндэсний төвөөс эрхлэн гаргасан цуврал гарын авлага №7, УБ., 2005, 66-67-р хуудас.

Хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр нийтлэг үйлчилгээ үзүүлдэг байгууллагын захиргаа нь үзүүлж буй үйлчилгээтэйгээ холбогдуулан мөн бусдыг захирамжилсан шийдвэр гаргадаг тул хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1.-д заасан захиргааны байгууллагын хүрээнд хамаарч байна. Нийтлэг үйлчилгээ үзүүлдэг сургууль, эмнэлэг, холбоо, харилцаа, эрчим хүчний болон шашны зэрэг байгууллагуудын үйл ажиллагаа нь тухайн харилцааг зохицуулсан Боловсролын, Эрүүл мэндийн, Харилцаа, холбооны тухай зэрэг тус тусын хуулиар тодорхойлогддог.

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн нийтийн Хурал, Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид байдаг. Тухайн засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэр дээр оршин суугаа 18 насанд хүрсэн, сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэд нийтээрээ оролцсон сонгуулиар иргэдийн төлөөлөгчдийн Хурлыг сонгоно. Эдгээр байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн бүхий л асуудлыг бие даан зохион байгуулж, үйл ажиллагаандаа Үндсэн хуулиар тогтоосон төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг баримтална.

Хурлын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд хэлэлцсэн асуудлаараа тогтоол гаргадаг. Үндсэн хуулийн 63 дугаар зүйлийн 63.2-т зааснаар Хурлын тогтоол нь хууль тогтоомжид нийцсэн байх ёстой бөгөөд түүнийг тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэд заавал биелүүлнэ.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1.-д тодорхойлсон нийтийн захиргааны байгууллагад дээр дурдсан байгууллагуудаас гадна нийтийн эрх зүйн субъект болох бусад байгууллага орох бөгөөд энд ямар байгууллага хамаарах нь “мэргэжил шаардах, “будилуулж мэдэх” хэсэг нь болно.”¹⁵

Гэхдээ хэрэгжүүлж буй үйлдэл (захиргааны акт) нь нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн гадагш чиглэсэн, заавал биелэгдэх шинжтэй байх нь тэднийг энэ хүрээнд хамааруулах үндсэн шалгууруудын нэг болно.

2.Нийтийн захиргааны албан тушаалтанд төрийн жинхэнэ албан хаагч, төрийн бус албан тушаалтан гэсэн хоёр ангиллын албан тушаалтныг ойлгохоор хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т заажээ. Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд зааснаар төрийн албан тушаал нь хэд хэдэн ангилалд хуваагдах бөгөөд үүнээс захиргааны болон тусгай албан тушаалын ангилалд багтах удирдах, гүйцэтгэх албан тушаалыг мэргэжлийн үндсэн дээр байнга эрхэлж байгаа Монгол Улсын иргэнийг төрийн жинхэнэ албан хаагч гэдэг. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д дурдсан төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн байгууллагад төрийн жинхэнэ албыг хааж байгаа албан тушаалтан нь нийтийн эрх зүйн хүрээнд захирамжлах, зохион байгуулах бүрэн эрхийг бие даан хэрэгжүүлнэ.

Харин мөн тэнд дурдсан нийтийн захиргааны бусад байгууллагын (засгийн газрын бус байгууллага, нийтлэг үйлчилгээ үзүүлдэг болон бусад) албан тушаалтнууд төрийн жинхэнэ албан хаагчаас эрх зүйн байдлын хувьд огт өөр бөгөөд төрийн бус

¹⁵ .Б.Чимид, Монгол Улсын захиргааны хэргийн шүүхийн мөн чанар, нийгэм- эрх зүйн ач холбогдол – “Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг”, УБ., 2004, 57-р хуудас.

албан тушаалтан зөвхөн нийтийн эрх зүйн холбогдолтой асуудлаар бусдыг захирамжилсан шийдвэр гаргаж байгаагаараа энэ хуулийн “захиргааны албан тушаалтан” гэсэн ойлголтонд хамаарч байна.

3.Захиргааны акт буюу нийтийн захиргаа, албан тушаалтны зүгээс бичгээр, амаар, бусад хэлбэрээр (эс үйлдэхүй, төрөл бүрийн тэмдэг ашигласан зэрэг) илэрхийлэгдэх бусдыг захирамжилсан үйлдэлд хуулийн 3.1.4-т зааснаар:

- Захиргааны байгууллагын захирамжилсан шийдвэр;
- Эрх зүйн үр дагавар шууд бий болгодог нэг удаагийн захирамжилсан бусад арга хэмжээ (үйлдэл, эс үйлдэхүй);
- Захиргааны байгууллагын зарлиг, тогтоол, дүрэм, заавар, журам гэсэн хэм хэмжээ тогтоосон шийдвэр хамаарч байна.
- Захиргааны акт нь дараах үндсэн шинжүүдийг өөртөө агуулах бөгөөд түүний аль нэг байхгүй бол түүнийг захиргааны актад тооцдоггүй байна. Үүнд:
- Захирамжилсан шийдвэр болон нэг удаагийн захирамжилсан бусад арга хэмжээ. Төрийн эрх мэдлийг төлөөлж буй захиргааны зүгээс бусад субъектэд хандан хэрэгжүүлж байгаа засагласан буюу заавал биелэгдэх чанартай, шаардлагатай тохиолдолд албадлага хэрэглэх, эрх зүйн үр дагавар шууд бий болгох нэг талын зохицуулалт байдаг.
- Гаргах субъект нь захиргааны байгууллага, албан тушаалтан. Зөвхөн нийтийн захиргаа, түүний албан тушаалтнаас хэрэгжүүлэх арга хэмжээ юм.
- Нийтийн эрх зүйн хүрээнд гарна. Төрийн болон нийтийн ашиг сонирхлыг хангаж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад чиглэгдэж, нийтийн эрх зүйн хэм хэмжээнд үндэслэн гарна.
- Тодорхой нэг тохиолдлыг зохицуулна. Захиргааны энэ арга хэмжээ нь нийтийн захиргаа, тодорхой иргэн хоёрын хооронд үүссэн харилцааг зохицуулах зорилготой. Иймээс тухайн иргэний үйлдлийг үүссэн тодорхой нөхцөл байдалтай нь уялдуулан захиргааны зүгээс журамлахад чиглэгдэж байдаг.
- Эрх зүйн үйлчлэлээрээ гадагш чиглэсэн байна. Захиргааны байгууллага нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргах хуулиар өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд захиргаанаас тусдаа бие даан оршиж байгаа эрх зүйн субъекттэй үүссэн харилцааг зохицуулахаар энэ арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Захиргааны байгууллагын хэм хэмжээ тогтоосон шийдвэр нь нийгмийн тодорхой төрлийн харилцааг олон удаа давтан зохицуулахад чиглэгдсэн байдаг. Гэхдээ ийм акт нь өмнө нэгэнт тогтоосон хэм хэмжээг хуулбарлах бус харин түүнийг нарийвчлан тодруулах эсхүл өөрчлөх замаар шинэ журам тогтоодог.

Хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг захиргааны байгууллагаас зарлиг, тогтоол, дүрэм, журам, зааврын хэлбэрээр гаргана. Хэм хэмжээ тогтоосон ийм шийдвэрт иргэн, хуулийн этгээд гомдол, нэхэмжлэл гаргаснаар түүнийг захиргааны актын нэгэн адил хянах боломжийг энэ хуулиар олгож байгаа нь захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа өргөн хүрээнд хянагдаж, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол захиргааны халдлагаас илүү хамгаалагдана гэсэн үг юм. “Хэм хэмжээ тогтоосон актыг шүүхэд маргах гол онцлог нь тэдгээрийг хууль бус гэж үзэж хүчингүй

болгуулах гомдол, нэхэмжлэл гаргаж байгаа дан ганц этгээдийн субъектив эрхийг хөндөөд зогсохгүй бусад этгээдийн ашиг сонирхлыг хөнддөгт байдаг...”¹⁶

4 дүгээр зүйл. Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаан

- 4.1. Захиргааны хэргийн шүүх энэ хуулийн 3.1.1., 3.1.2.-т заасны дагуу дараахь байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны хууль бус актад холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ:
- 4.1.1. Монгол Улсын Засгийн газар /Энэ заалтыг 2005.4.28- ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/;
 - 4.1.2. Монгол Улсын Засгийн газрын гишүүн /Ерөнхий сайд, сайд/;
 - 4.1.3. Монгол Улсын яам;
 - 4.1.4. Монгол Улсын Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг;
 - 4.1.5. Төрийн албаны Зөвлөл, түүний салбар байгууллага;
 - 4.1.6. Сонгуулийн ерөнхий хороо /Энэ заалтыг 2005.4.28- ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/;
 - 4.1.7. Монголбанк;
 - 4.1.8. Үнэт цаасны хороо;
 - 4.1.9. яамны харьяа болон харьяа бус захиргааны акт гаргадаг бие даасан агентлаг, түүнтэй адилгах газар, зөвлөл, товчоо, төв, сан зэрэг байгууллага;
 - 4.1.10. аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга;
 - 4.1.11. аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг /хэлтэс, газар/;
 - 4.1.12. улсын хяналт шалгалтын болон захиргааны хяналтын байгууллага, тэдгээрийн хянан шалгагч, байцаагч, цагдаагийн, тагнуулын, хилийн цэргийн байгууллага, түүний захиргааны таслан зогсоох болон шийтгэлийн арга хэмжээ авах эрх бүхий бүх албан тушаалтан;
 - 4.1.13. аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн нийтийн Хурал, тэдгээрийн Тэргүүлэгчид;
 - 4.1.14. төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг болон холбоо, харилцаа, эрчим хүчний системийн захиргаа зэрэг үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг байгууллага;
 - 4.1.15. сүм хийдийн захиргаа;
 - 4.1.16. шийдвэр, үйл ажиллагааг нь захиргааны хэргийн шүүхэд давж гомдол гаргаж байхаар хуульд тусгайлан заасан нийтийн эрх зүйн субъект болох бусад байгууллага, албан тушаалтан.

¹⁶ ХЗҮТ-өөс эрхлэн гаргасан “Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн” гарын авлага, УВ., 2004, 77-р хуудас.

- 4.2. Энэ хуулийн 4.1-д заасан байгууллагын зөвхөн гадагш /бусдаас/ дагаж мөрдөх буюу заавал биелүүлэх захиргааны акт нь захиргааны хэргийн шүүхэд хамаарна.
- 4.3. Шүүх, прокурорын байгууллага, түүнчлэн эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын байцаан шийтгэх, эсхүл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай¹⁷ хуулийн дагуу явуулсан үйл ажиллагааны талаар иргэн, хуулийн этгээдээс шүүхэд гаргасан гомдлыг эрүүгийн болон иргэний хэргийн шүүх хянан шийдвэрлэнэ.

ТАЙЛБАР

1. Захиргааны хэргийн шүүхэд иргэн, хуулийн этгээдийн гаргасан нэхэмжлэлийн дагуу үйл ажиллагаа нь хянагдах захиргааны байгууллага, албан тушаалтныг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д жагсаажээ. Нийтийн захиргаанд хамаарах эдгээр байгууллага, албан тушаалтны гаргасан захиргааны хууль бус акт нь хөндлөнгийн этгээд болох иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөний улмаас нэг талаас эрх ашиг нь зөрчигдсөн тухайн иргэн, нөгөө талаас захиргаа хоёрын хооронд үүссэн маргааныг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх замаар тэдний үйл ажиллагаанд хяналт тавина.

Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1- д “Монгол Улсын Засгийн газар”, 4.1.6-д “Сонгуулийн ерөнхий хороо” гэж тус тус заасныг Үндсэн хуулийн цэц 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 2/02 дугаар дүгнэлтдээ

“1. ...Хууль тогтоогчоос Засгийн газрын шийдвэрийг захиргааны хэргийн шүүх хянаж байхаар хуульчилсан нь Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон Засгийн газар, Улсын Их Хурлын эрх хэмжээнд халдсан гэх үндэслэл тогтоогдож байна. Захиргааны хэргийн шүүхэд төрийн гүйцэтгэх дээд байгууллагын шийдвэрийг хянах эрх хэмжээ Үндсэн хуулиар олгогдоогүй байна.

2. ... Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр хуульд нийцээгүй тохиолдолд захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэж байхаар ЗХХШТХ-иар хуульчилсан нь Үндсэн хуулиар Үндсэн хуулийн цэцэд тусгайлан олгосон эрх хэмжээнд халдсан байна”¹⁸ гэж үзээд эдгээр заалт Үндсэн хууль зөрчсөн болохыг тогтоож, Улсын Их Хурал 2005 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар энэ заалтуудыг хүчингүй болсонд тооцжээ.

Иймээс Монгол Улсын Засгийн газар болон Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан захиргааны хууль бус актад холбогдох маргаан захиргааны хэргийн шүүхийн харьяалалд хамаарахгүй юм.

(Захиргааны акт, хууль бус актад холбогдох тайлбарыг хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 болон 3 дугаар зүйлийн 3.1.4-т хийсэн тайлбараас үзнэ үү. Захиргааны хууль бус

¹⁷ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

¹⁸ Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/02 дугаар дүгнэлт “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2005 оны 14 дүгээрт нийтлэгдсэн.

актын талаар Монгол Улсын Дээд шүүхийн “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” 2006 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 37 дугаар тогтоолд мөн тайлбарласан байна.¹⁹)

2.Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д жагсаасан байгууллага, албан тушаалтнууд нь нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг нийтийн эрх зүйн субъект учраас тэдний үйл ажиллагаа захиргааны хэргийн шүүхийн хяналтанд байх ёстой бөгөөд зөвхөн гадагш (бусдаас) дагаж мөрдөх буюу заавал биелүүлэх захиргааны акт нь захиргааны хэргийн шүүхэд хамаарахыг мөн зүйлийн 4.2-т тодруулан заажээ.

Захиргааны байгууллага өөрийн чиг үүргээ гүйцэтгэхийн тулд маш олон төрлийн үйлдэл хэрэгжүүлдэг бөгөөд тэднийг эрх зүйн шинж чанараас нь үл хамааруулан гадагш чиглэсэн, дотогш чиглэсэн гэсэн хоёр үндсэн хүрээнд хуваан авч үзнэ.

Дотогш чиглэсэн захиргааны үйл ажиллагаа тухайн байгууллагын дотоод хүрээнээс гадагш хальж үйлчлэхгүй. Тухайлбал байгууллагын дотоод дүрэм, журмыг эрх бүхий албан тушаалтан, дээд шатны байгууллага нь батлан гаргах ба тэдгээрийг зөвхөн тухайн байгууллагын ажилтнууд болон харъяа доод шатны нэгжүүдэд дагаж мөрдөнө. Гадагш чиглэсэн үйл ажиллагаа нь захиргааны байгууллагад үл хамаарах, бие даасан эрх зүйн субъектэд (хувь хүн, хуулийн этгээд) хандан хэрэгжих бөгөөд тэр нь:

- нийтийн болон хувийн эрх зүйн аль алины хэм хэмжээгээр зохицуулагдана.
- нийтийн эрх зүйн хүрээнд, нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдан хэрэгжиж байгаа үйл ажиллагаа нь төрийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахад чиглэсэн ажиллагаа юм.
- нийтийн эрх зүйн хүрээнд явагдаж байгаа ажиллагааны илэрхийлэгдэх хэлбэр нь үйлчлэлийн хувьд тодорхой асуудлаар тодорхой этгээдэд үйлчлэх захиргааны акт, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэр гэсэн хоёр хэлбэртэй байна.
- мөн энэ хүрээнд нийтийн эрх зүйн гэрээний хэлбэрээр үйл ажиллагаа хэрэгждэг.

Гэхдээ хуульд заасан эдгээр байгууллага, албан тушаалтнуудын захиргааны акт гарснаар захиргааны хэргийн шүүхэд хандах нөхцөл бүрдэхгүй бөгөөд захиргааны актаар тухайн нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн байх ёстой.

Мөн эрх зүйн үйлчлэлээрээ гадагш чиглэсэн байна. Жишээ нь, төрийн захиргааны албан хаагчийг ажлын шаардлагаар байгууллага дотор нь ижил түвшингийн өөр ажилд томилох, түүнд байгууллагын удирдлагаас үүрэг даалгавар өгөх зэрэг нь тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулахад чиглэгдэж байгаа бол албан хаагчийг ажлаас нь халах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр тухайн иргэнтэй үүссэн хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгон ингэснээрээ түүний үндсэн эрхийг хөндөж байгаа учраас уг акт гадагш чиглэсэн байна.

3.Хуулийн 4.3.-т нийтийн эрх зүйн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг шүүх, прокурорын байгууллага, түүнчлэн эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын байцаан шийтгэх, эсхүл шүүхийн шийдвэр

¹⁹ Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл, 2008 он, 101-106 дугаар тал

гүйцэтгэх хуулийн дагуу явуулсан үйл ажиллагааны талаар иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдлыг эрүүгийн болон иргэний хэргийн шүүх хянан шийдвэрлэхээр заажээ.

Харин эдгээр байгууллагаас нийтийн эрх зүйн хүрээнд бусдыг захирамжилсан захиргааны акт гаргасан тохиолдолд түүний улмаас эрх ашиг нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээдийн нэхэмжлэлээр захиргааны хэргийн шүүх маргааныг хянан шийдвэрлэх боломжтой.

5 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн акт,
түүнийг заавал биелүүлэх

- 5.1. Захиргааны хэргийн шүүхийн акт нь шийдвэр, тогтоол, магадлал, энгийн магадлал, шүүгчийн захирамж гэсэн хэлбэртэй байна.
- 5.2. Захиргааны хэргийн шүүхийн хүчин төгөлдөр актыг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа холбогдох бүх байгууллага, албан тушаалтан, иргэн заавал биелүүлнэ.
- 5.3. Захиргааны хэргийн шүүхийн актыг биелүүлээгүй этгээдэд энэ хууль, Эрүүгийн хууль²⁰ болон хууль тогтоомжийн бусад актад заасан хариуцлага хүлээлгэнэ.

ТАЙЛБАР

1. Захиргааны хэргийн шүүх нь захиргааны хууль бус актад холбогдох маргааныг хянан шийдвэрлэх явцдаа олон төрлийн баримт бичгийг гаргах боловч эдгээрээс хуулийн 5.1.-д зааснаар шийдвэр, тогтоол, магадлал, энгийн магадлал, шүүгчийн захирамж нь захиргааны хэргийн шүүхийн акт гэсэн ангиллыг бүрдүүлж байна. Захиргааны хэргийн шүүхийн актын тодорхойлолтыг хуулийн 3.1.9.–3.1.13 дахь хэсэгт өгчээ.

Анхан шатны шүүхээс захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд гаргасан баримт бичгийг шүүхийн шийдвэр гэнэ. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсгээс бүрдэнэ (ЗХХШТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.1.). Шүүхийн энэ актад тавигдах хууль ёсны шаардлагыг мөн хуулийн 72.2.-72.6, 75-76 дугаар зүйлүүдэд тус тус тодорхойлон заажээ.

Шүүхийн тогтоолд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх аливаа ажиллагааны талаар шүүх бүрэлдэхүүнээс гаргасан анхан шатны шүүхийн хуралдааныхаас бусад баримт бичиг хамаарна. Жишээлбэл, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахдаа захиргааны хэргийн шүүх тогтоол гаргана (хуулийн 34.2), захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт засвар оруулсан тухай шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргана (хуулийн 75.3.). Шүүхийн тогтоол гэж энэ төрлийн баримт бичгээс гадна Улсын Дээд шүүхийн хуралдаанаар хяналтын журмаар захиргааны хэргийг хянан хэлэлцээд гаргасан баримт бичгийг нэрлэдэг.

2. Давж заалдах шатны шүүхээс захиргааны хэргийг хянан хэлэлцээд гаргасан баримт бичиг болох шүүхийн магадлал нь захиргааны хэргийн шүүхийн актын нэг юм. Захиргааны хэргийг анхан шатны шүүх хянан хэлэлцээд гаргасан шийдвэрийг давж

²⁰ Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

заалдах шатны шүүх хянаад уг шийдвэрийг хэвээр үлдээх, өөрчлөх, хүчингүй болгох шийдвэрийн аль нэгийг заавал гаргана (хуулийн 86.2).

3. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүгч хуульд заасан журмын дагуу зохион байгуулах, тодорхой асуудлыг шийдвэрлэхдээ шүүхийн актын нэг болох захирамжийг дангаараа гаргана. Захиргааны хууль бус актыг хянуулахаар иргэн, хуулийн этгээдийн гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, түүнийг харъяалмын дагуу өөр шүүхэд шилжүүлэх, нэхэмжлэлийн дагуу захиргааны хэрэг үүсгэх гэхчлэн хуульд заасан олон тохиолдолд шүүгч тухай бүр захирамж гаргана.

4. Энгийн магадлал гэж захиргааны байгууллага, албан тушаалтнаас хууль зөрчсөн үйл ажиллагааны шалтгаан, нөхцлийг арилгуулахаар тэдгээр байгууллага, албан тушаалтанд шаардаж захиргааны хэргийн шүүхээс гаргасан баримт бичгийг хэлнэ. Захиргааны хэргийн шүүхийн энэ акт нь захиргааны байгууллага, албан тушаалтан өөрийн үйл ажиллагаандаа дүгнэлт хийж ажлаа өөрчлөн засч залруулахад ач холбогдолтойгоос гадна шүүхийн бусад актын нэгэн заавал биелэгдэх, төрийн албадлага хэрэглэх боломжийг агуулсан баримт бичиг юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа,
шүүхэд нэхэмжлэл гаргах эрх

6 дугаар зүйл. Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах

- 6.1. Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээд захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны хууль бус акт нь түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хүлээн авснаас, эсхүл мэдсэнээс хойш 30 хоногийн дотор тухайн байгууллага, албан тушаалтныг шууд харъяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдлоо гаргана.
- 6.2. Гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай²¹ хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 6.3. Энэ хуулийн 6.1.-д заасан хөөн хэлэлцэх хугацаа зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтэрсэн нь тогтоогдвол захиргааны байгууллага, албан тушаалтан уг хугацааг хэтэрснээс хойшхи гурван сарын дотор нөхөн сэргээж болно. Хугацаа сэргээхтэй холбогдсон гомдлыг шүүхэд гаргана.
- 6.4. Энэ хуулийн 6.1.-д заасан байгууллага, албан тушаалтан иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хүлээн авч 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж хариу өгнө. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор сунгаж болно. Хугацаа сунгасан тухай гомдол гаргасан иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэнэ.

ТАЙЛБАР

1.Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа нь захиргааны байгууллагын хянан шийдвэрлэх ажиллагаа болохоос, захиргааны эрх зүйн маргааны нэг хэсэг биш. Энэхүү ажиллагаа гомдол гаргаснаар эхэлж, гомдлыг хянах, талуудыг сонсох, шинжээчийн дүгнэлт, гэрчийн мэдүүлэг бусад нотлох баримтыг судлах, үнэлэх ажиллагаа явагдаж эцэст нь захиргааны акт гаргаснаар дуусгавар болдог. Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагааг шүүх бус дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан явуулж байгаа нь захиргааны байгууллагын нэгдмэл байдлыг болон дотоод хяналтыг харуулж байгаа юм. Мөн Монгол Улсын Үндсэн

²¹Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

хуулийн²² нэгдүгээр зүйлийн 2-т "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", арван зургадугаар зүйлийн 12-т "Монгол Улсын иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй" гэсэн заалттай бүрнээ нийцэж байгаа болно.

Захиргааны байгууллага үйл ажиллагаандаа алдаа, зөрчил гаргах явдал тохиолддог тул эрх зүйт төрийн зарчмын дагуу захиргааны гадагш чиглэсэн ажиллагаанд /захиргааны акт/ хяналт тавьдаг систем байх ёстой. Хяналтын энэ системийн гол зорилго нь:

- хүний эрх, эрх чөлөөг хамгаалах,
- захиргааны хууль бус үйлдлийг засч залруулах явдал юм.

Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагааг "хоёрдмол" шинжтэй ажиллагаа гэж үзэх нь учир дутагдалтай бөгөөд тухайн ажиллагаа нь өөрөө "хоёрдмол" шинжгүй бөгөөд цэвэр захиргааны байгууллагын хянан шийдвэрлэх ажиллагаа, харин энэхүү ажиллагааг явуулах нь процессийн /шүүхийн/ урьдчилсан нөхцөл болдог²³.

Түүнтэй адил захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа захиргааны байгууллагын үйл ажиллагааны нэг хэсэг биш. Захиргааны байгууллагын үйл ажиллагаа тодорхой захиргааны акт гарснаар дуусгавар болдог. Харин захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагааг үүний араас хяналт тавих "бие даасан" захиргааны байгууллагын хянан шийдвэрлэх ажиллагаа гэж хэлж болно.

Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа энэ хуулийн 6,7,8,9,10,11 дүгээр зүйлээр болон бусад хуулийн холбогдох зүйлээр зохицуулагдаж байгаа. Харин Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн бусад хэм хэмжээг хэрэглэхдээ холбогдох хууль тогтоомжид тухайн харилцааг зохицуулсан заалт байхгүй бол адилтган хэрэглэж болно гэсэн зарчмыг баримтлах нь зөв болов уу.

2.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлээр захиргааны актын эсрэг шүүхэд нэхэмжлэл гаргахын өмнө захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулахаар зохицуулсан байна. Амжилтанд хүрээгүй захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа нь дараагийн /шүүхийн/ процессийн урьдчилсан нөхцөл болдог.

Захиргааны байгууллага, албан тушаалтны акт гаргах ажиллагаа болон процессийн /шүүхийн/ ажиллагааны дундах шат гэдэг нь түүний зорилгоос харагдаж байна.

Нэгдүгээрт, захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа нийтийн захиргааны байгууллагад өөрийн хяналтыг хэрэгжүүлэх боломж олгох, хоёрдугаарт иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцад хамгаалахад чиглэгдэх, ингэснээр шүүхийн ачааллыг багасгах зорилготой.

²² Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

²³ Friedhelm Hufen. Verwaltungsprozessrecht.,5.Auflage Verlag C.H.Beck Muenchen 2003 S.66.

3.Хууль тогтоогч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “хуульд өөрөөр заагаагүй бол...” гэж тодотгож өгсөн нь Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 12–т заасантай нэгэн адил төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаар бус төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас иргэдийг хамгаалсан /идэвхтэй эрх зүйн хамгаалалт олгосон/ заалт гэдгийг улам тодруулж өгсөн.

Жишээ нь Ашигт малтмалын тухай²⁴ хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-д тусгай зөвшөөрлийг цуцалсан шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд хандах эрхтэй байхаар зохицуулсан тул захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй тусгай зөвшөөрөл эзэмшигч шууд нэхэмжлэл /захиргааны хэргийн шүүхэд/ гаргаж болно. Үүгээр “хуульд өөрөөр заагаагүй бол” заавал захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулж байхаар зохицуулсан байна.

Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа нь объектив гомдол шийдвэрлэх ажиллагаа бус харин иргэн, хуулийн этгээдийн субъектив эрхийг хамгаалахад чиглэгдсэн ажиллагаа гэдэг нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “... захиргааны хууль бус акт нь түүний эрх, хууль ёсны ашиг сонирхолыг зөрчсөн гэж үзвэл...” гэж зааснаас харагдаж байна. Иймд тухайн захиргааны актаар тухайн иргэн, хуулийн этгээдийн /өөрийн/ эрх, хууль ёсны ашиг сонирхол /хамгаалсан хэм хэмжээ, үндсэн эрх зэрэг/ зөрчигдсэн байж болохоор байна гэж үзсэн тохиолдолд гомдол гаргах эрх нээгдэх нэг гол нөхцөл болно. Тиймээс захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаагаар “ерөнхий” гомдлыг бус, гомдол гаргагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн эсэхийг хянан шийдвэрлэнэ.

Энэхүү заалтаар мөн гомдол гаргах ерөнхий хугацааг 30 хоногийн дотор байхаар тогтоож өгсөн. Тодорхой маргааны хувьд холбогдох хуульд өөрөөр зохицуулсан бол тухайн хуулиар тогтоосон хөөн хэлэлцэх хугацааг баримтална. Монгол Улсын Иргэний хуулийн²⁵ 71-82 дугаар зүйлүүдэд хугацааг тоолох, тодорхойлох журмыг тогтоосон байна. Гомдол гаргах хугацааг иргэн, хуулийн этгээд “холбогдох захиргааны актыг хүлээн авсан, эсхүл мэдсэн” үеэс эхлэн тоолно, өөрөөр хэлвэл холбогдох захиргааны актыг хүлээлгэж өгөөгүй, эсхүл мэдэгдээгүй бол хугацаа тоологдохгүй. Гомдол гаргагч 30 хоногийн хугацаандаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гомдлоо гаргаагүй бол холбогдох захиргааны актанд гомдол гаргах эрхээ алдана. Хугацаа хэтэрсэн гэдэг үндэслэлээр шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан гомдлыг буцаавал иргэн, хуулийн этгээд шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй болно. Зөвхөн хугацаа сэргээхтэй холбогдсон гомдлыг шүүхэд гаргаж²⁶ болно.

Монгол Улсын Дээд шүүхийн 1991 оны 9-р сарын 25- ны өдрийн 90 дүгээр тогтоолын 6-д :дээд шатны байгууллага гэж тухайн байгууллагыг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, албан тушаалтныг сонгох, томилох, тэдний гаргасан тушаал,

²⁴ Ашигт малтмалын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2006 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

²⁵ Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

²⁶ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-ийг хар.

шийдвэр, тогтоол, захирамжийг өөрчлөх буюу хүчингүй болгох эрх бүхий удирдах байгууллагыг ойлгоно²⁷ гэж тайлбарласан байна.

Эндээс үзэхэд “шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан” гэж тухайн захиргааны байгууллагыг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, албан тушаалтныг сонгох, томилох, тэдний гаргасан захиргааны актыг өөрчлөх буюу хүчингүй болгох эрх бүхий шууд удирдах захиргааны байгууллага, захиргааны албан тушаалтан гэсэн утгаар ойлгож болохоор байна. Жишээ нь дүүргийн Засаг даргыг шууд харьяалах дээд шатны захиргааны албан тушаалтан нь нийслэлийн Засаг дарга, Цагдаагийн ерөнхий газрыг шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага Хууль зүй, дотоод хэргийн яам байна.

4.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т гомдолд тавигдах шаардлага, агуулгыг тодорхойлж өгсөн байна. Гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд²⁸ заасан шаардлагыг хангасан байх ёстой гэж зохицуулсан байна. Үүнд захиргааны актанд гомдлыг бичгээр гаргана, хамтран гомдол гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах буюу эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргахаар зохицуулсан байна. Иймээс захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиглага явуулахын тулд гомдлыг бичгээр гаргах шаардлагатай бөгөөд амаар, утсаар болон бусад хэлбэрээр /дараа бичгээр гаргахад хэлж санал бодлоо илэрхийлэх хэлбэрээр/ гаргасан гомдол шаардлага хангахгүй гэсэн үг.

“Бичгээр гаргана” гэдэг нь тойруу утгаар тухайн гомдлыг тухайн иргэн, хуулийн этгээд гаргасан гэдэг нотлох баримт болж, өөрийн хүсэл зоригоор эрх зүйн харилцаанд орсныг бататгаж өгч байгаа явдал юм²⁹. Тухайн гомдолд заавал өөрөө гарын үсэг зурсан байхыг шаардахгүй /бусдаар төлөөлүүлэн зурж болно/ бөгөөд харин тухайн гомдол гаргагчийн өмнөөс, түүний хүсэлтээр бичигдсэн гэдэг нь тодорхой байхад хангалттай. Гомдлыг цахим сүлжээгээр дамжуулан гаргаж болно³⁰. Жишээ нь факсаар, e-майлаар. Гэхдээ практикт гомдлоо хугацаандаа гаргасан эсэх маргаан үүсэхэд нотлох боломж багатай.

²⁷ Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл. УБ хот. 2004 он. 417 дахь талд.

²⁸ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйл. Өргөдөл, гомдолд тавих шаардлага:

1. Бичгээр гаргасан өргөдөл, гомдолд овог, нэр оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсгээ зурна. Хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүлэн зурж болно. /Энэ хэсэгт 2003 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/
2. Өргөдөл, гомдлыг иргэд бичгээр хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах буюу эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргана.
3. Өргөдөл, гомдол гаргахад энэ зүйлд зааснаас бусад зүйл шаардахыг хориглоно.

²⁹ Friedhelm Hufen. Verwaltungsprozessrecht., 5. Auflage Verlag C.H. Beck Muenchen 2003 S.83.

³⁰ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-ийг хар.

Нэхэмжлэлийн агуулгад тавигдах шаардлагыг³¹ гомдол гаргахад адилтан хэрэглэж болохгүй. Гэхдээ гомдолд өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хэрхэн сэргээлгэхийг хүсэж байгаагаа тодорхой илэрхийлсэн байвал зохино. Жишээ нь албадан нүүлгэх захирамжийг хүчингүй болгуулахыг хүсэж байна г.м.

5.Хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т хөөн хэлэлцэх хугацааг 30 хоног байхаар зааж, зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаа хэтэрвэл гомдол хүлээн авсан захиргааны байгууллага, албан тушаалтан хугацаа хэтэрснээс хойшхи гурван сарын дотор хугацааг нөхөн сэргээж болохоор заажээ.

Зайлшгүй хүндэтгэн үзэх шалгаан гэдгийг гомдол гаргагч хүндээр өвчилсөн, хорио цээрийн дэглэм тогтсон, байгалийн гамшиг тохиолдсон, албан томилолтоор явсан гэх мэт өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар гомдол гаргах боломжгүй байсныг ойлгоно.

Харин хууль мэдэхгүй байсан нь хүндэтгэн үзэх шалтгаан болохгүй гэж Дээд шүүхээс албан ёсоор тайлбарласан байна³². Хэрвээ хугацааг нөхөн сэргээгээгүй бол захиргааны хэргийн шүүхэд хугацаа сэргээлгэх гомдол гаргаж болохоор зохицуулсан байна. Мөн Дээд шүүхээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан "... хөөн хэлэлцэх хугацаа..." нь мөн зүйлийн 6.1-д заасан "холбогдох захиргааны актыг хүлээн авснаас, эсхүл мэдсэнээс хойш 30 хоног" гэсэн хугацаагаар тодорхойлогдоно. Энэ хугацаанд гомдлоо хүндэтгэн үзэх шалтгааны улмаас гаргаж чадаагүй иргэн, хуулийн этгээд, байгууллага нь зөвхөн "хөөн хэлэлцэх хугацаа"-г сэргээлгэхээр урьдчилан шийдвэрлэх эрх бүхий захиргааны байгууллага, албан тушаалтанд хандана.

Мөн зүйл, хэсэгт зааснаар шүүхэд гомдол гаргасан тохиолдолд шүүх зөвхөн хөөн хэлэлцэх хугацааг сэргээлгэхтэй холбогдсон гомдол нь үндэслэлтэй эсэхийг хянаж, шүүгч захирамж гаргана³³ гэж албан ёсоор тайлбарласан байна. Хэрвээ шүүхээс гомдлыг хангахгүй орхих шийдвэр гаргавал тухайн захиргааны акт хүчин төгөлдөр үйлчлээд явна.

6.Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "хуульд өөрөөр заагаагүй бол" гомдлыг хүлээн авсан захиргааны байгууллага, албан тушаалтан 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж хариу өгөхөөр зохицуулсан байна. Шаардлагатай бол тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно, харин энэ тухайгаа гомдол гаргагчид мэдэгдсэн байх ёстой. Гомдлыг хүлээн авахдаа Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан шаардлагыг³⁴ хангасан эсэхийг шалгана. Хүлээн авснаар хянан шийдвэрлэх хугацаа тоологдож эхэлнэ.

³¹ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийг хар.

³² Монгол Улсын Дээд шүүхийн 1991 оны 9-р сарын 25- ны өдрийн 90 дүгээр тогтоолын 11 дэх заалт.

³³ Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 7-р сарын 03- ны өдрийн 37 дугаар тогтоолын 3 дахь заалт.

³⁴ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10, 12, 13, 14 дүгээр зүйлийг хар.

7 дугаар зүйл. Хэргийг урьдчилан шийдвэрлэх журам

- 7.1. Захиргааны байгууллага, албан тушаалтан гомдлыг урьдчилан шийдвэрлэх талаар дараах ажиллагаа явуулна:
- 7.1.1. захиргааны акт хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгах;
 - 7.1.2. гомдол гаргагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч, шаардлагатай бол эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн гуравдагч этгээдэд хэрэг шийдвэрлэх он, сар, өдөр, газрыг мэдэгдэж, уг ажиллагаанд хүсэлтээр нь байлцуулах.
- 7.2. Энэ хуулийн 7.1.2.-т заасан этгээд хүрэлцэн ирээгүй бол тэдгээрийн оролцоогүйгээр хэргийг урьдчилан шийдвэрлэж болно.
- 7.3. Шаардлагатай гэж үзвэл шинжээч томилон дүгнэлт гаргуулна.
- 7.4. Урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцын талаар тэмдэглэл хөтөлнө. Уг тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:
- 7.4.1. шийдвэр гаргаж байгаа байгууллагын нэр, хаяг, албан тушаалтны овог, эцгийн нэр, нэр;
 - 7.4.2. шийдвэр гаргасан, хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулсан он, сар, өдөр, газар;
 - 7.4.3. гомдол гаргагч, хариуцагч, бусад оролцогчын овог, эцгийн болон өөрийн нэр;
 - 7.4.4. гомдлын агуулга, шаардлага;
 - 7.4.5. шинжээчийн дүгнэлт, гэрчийн мэдүүлэг бусад нотлох баримт;
 - 7.4.6 тэмдэглэл хөтөлсөн болон гомдлыг шийдвэрлэсэн албан тушаалтан, захиргааны байгууллагын эрх баригчийн гарын үсэг.
- 7.5. Хамтын удирдлага бүхий захиргааны байгууллага гомдлыг хэлэлцсэн бол асуудал шийдвэрлэх ердийн журмыг баримтлан шийдвэр гаргана.
- 7.6. Гомдлыг хүлээж авсан байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 45, 46 дугаар зүйлд заасан журмын дагуу маргаантай захиргааны актын биелэлтийг гомдол бүхий хэргийг хянан шийдвэрлэх хүртэл түдгэлзүүлж болно.

ТАЙЛБАР

1. Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан урьдчилан шийдвэрлэх ажиллагааг яаж явуулахыг хууль тогтооч энэхүү журмаар хуульчилж өгсөн. Ингэснээр дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан энэхүү журмын дагуу маргаан бүхий захиргааны актыг хянан шийдвэрлэх үүрэгтэй.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 12-т заасан "... Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн ... гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй" гэсэн заалттай бүрнээ нийцэж байгаа болно.

Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа гомдлыг дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан хүлээн авснаар эхэлж /ЗХХШТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4./ эцсийн шийдвэр гаргаснаар /ЗХХШТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1./ дуусна. Эдгээрийн хоорондох хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн 7 дугаар зүйлээр журамлаж өгсөн.

2.Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д хянан шалгах ажиллагааны шалгах хүрээг тодорхойлж, гомдол гаргагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн гуравдагч этгээдэд хэрэг шийдвэрлэх он, сар, өдөр, газрыг заавал мэдэгдэж, уг ажиллагаанд хүсэлтээр нь байлцуулахаар зохицуулсан.

Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасны дагуу гомдолыг хүлээн авсан дээд шатны байгууллага, албан тушаалтан захиргааны актыг хууль тогтоомжинд нийцэж байгаа эсэхийг юуны түрүүн шалгах үүрэгтэй. Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан гомдолд заасан үндэслэлээр хязгаарлахгүйгээр тухайн маргааныг бүхэлд нь /эрх зүйн болон хэргийн нөхцөл байдлыг/ хянан үзэх үүрэгтэй гэсэн үг.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид, тэдгээрийн эрх үүргийн талаархи асуудал практикийн чухал учир холбогдолтой.

Захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдыг хоёр ангилна:

1. хэргийн оролцогч
2. бусад оролцогч гэж.

Захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд туслах чиг үүрэгтэй оролцогчдыг бусад оролцогч гэнэ. Жишээ нь: төлөөлөгч, гэрч, өмгөөлөгч, хэлмэрч, шинжээч, орчуулагч г. м. /ЗХХШТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1.2., 7.3., 7.4.3. /

Хэргийн оролцогч гэж гомдол гаргагч, хариуцагчийг хэлнэ /ЗХХШТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.4.3./. Гомдол гаргагч нь захиргааны хууль бус акт нь түүний эрх, хууль ёсны ашиг сонирхолыг зөрчсөн гэж үзэж байгаа иргэн, хуулийн этгээд, харин хариуцагч нь тухайн хэргийг хянан шийдвэрлэж байгаа захиргааны байгууллага, албан тушаалтны шууд харьяалах доод шатны захиргааны байгууллага, албан тушаалтан байна.

Харин гомдлыг хэд хэдэн этгээд хамтран гаргасан, хэд хэдэн этгээд хариуцагч болсон тохиолдолд хэрхэн зохицуулахыг хуульд тусгайлан заагаагүй. Харин ямар ч тохиолдолд тэдгээр нь урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд бие даан оролцох эрхтэй байх болов уу.

Монгол Улсын Дээд шүүхээс³⁵: "... бие даан оролцох эрхтэй" гэдгийг албан ёсоор тайлбарласан бөгөөд энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, нэхэмжлэлийн /гомдлын/ шаардлагад тайлбар өгөх, нэхэмжлэгчтэй /гомдол гаргагчтай/ болон хариуцагчтай эвлэрэх, нэхэмжлэлийн /гомдлын/ шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх эсхүл татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаанд /урьдчилан шийдвэрлэх хуралдаанд/ оролцож мэтгэлцэх, шүүхийн /дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтны/ шийдвэрт гомдол /нэхэмжлэл/ гаргах зэрэг эрхтэй гэж ойлгохоор байна.

³⁵ Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 7-р сарын 03- ны өдрийн 37 дугаар тогтоолын 9 дэх заалт.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйд /ИХШХШТХ³⁶- ийн 22 дугаар зүйлийн 22.1./ зохигчид, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нарыг хэргийн оролцогч хэмээн үздэг бол захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд тийм биш байдаг.

Тодруулбал гомдол гаргагч, нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн төлөөлөгч болон өмгөөлөгч нь захиргааны хэргийн бие даасан оролцогч бус зөвхөн төлөөлүүлж буюу өмгөөлүүлж байгаа этгээдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалж буй этгээд байх ажээ.

Хэргийн болон шүүх хуралдааны оролцогчид нь тус тусдаа эрх зүйн ашиг сонирхол, эрх үүрэгтэй. Энэ байдлыг зөв тодорхойлон харгалзах нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд чухал ач холбогдолтой.

3. Мэдэгдсээр байтал гомдол гаргагч, бусад оролцогч хүрэлцэн ирээгүй бол тэдгээрийн оролцоогүйгээр хэргийг урьдчилан шийдвэрлэж болохоор хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т зохицуулсан. Дээд шатны байгууллага, албан тушаалтан шаардлагатай гэж үзвэл шинжээч томилон дүгнэлт гаргуулах эрхтэйгээр хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т зохицуулсан.

Урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцын талаар хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т заасны дагуу тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлд шийдвэр гаргаж байгаа байгууллага, албан тушаалтны /ЗХХШТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.4.1./ болон хэргийн оролцогчдийн талаархи мэдээлэл /ЗХХШТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.4.3./, хэзээ, хаана шийдвэрлэсэн /ЗХХШТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.4.2./, гомдлын агуулга, шаардлага /ЗХХШТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.4.4./, шинжээчийн дүгнэлт, гэрчийн мэдүүлэг болон бусад нотлох баримтын талаар /ЗХХШТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.4.5./ тусгана.

Шийдвэрийг захиргааны байгууллага гаргасан бол тухайн захиргааны байгууллагын эрх баригч, албан тушаалтан гаргасан бол тухайн албан тушаалтан өөрөө болон тэмдэглэл хөтөлсөн этгээд тэмдэглэлд гарын үсэг зурж баталгаажуулна /ЗХХШТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.4.6./. Шийдвэр гаргасан болон урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулсан хугацаа, газар өөр өөр байж болно. Тэгвэл тусад нь тэмдэглэлд тусгана. Тэмдэглэл нь бүтцийн хувьд шүүгчийн захирамж, шүүхийн шийдвэртэй төстэй байдаг³⁷.

4. Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан шийдвэрээ өөрийн эрх хэмжээний хүрээнд, шууд харьяалах доод шатны захиргааны байгууллага, албан тушаалтнаас хараат бус, бие даан гаргана.

Харин хамтын удирдлага бүхий захиргааны байгууллага бол асуудлыг шийдвэрлэх ердийн журмыг баримтлан шийдвэр гаргахаар хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д зохицуулсан. Жишээ нь “төрийн жинхэнэ албан хаагчийг ажлаас үндэслэлгүй халсан тухай” гомдлыг Төрийн албаны тухай хуулийн³⁸ дагуу хамтын удирдлага бүхий захиргааны байгууллага болох Төрийн албаны зөвлөл шийдвэрлэхдээ ердийн журмыг баримтлана, өөрөөр хэлбэл гишүүдийн ердийн олонхийн саналаар шийдвэр гаргана.

³⁶ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

³⁷ В.Дурнер, “Монгол Улсын захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”, /Ханнс- Зайделийн сан/, УБ, 2004 он, 64 дэх тал.

³⁸ Төрийн албаны тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн

5. Гомдлыг дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан хүлээн авсан бол тухайн захиргааны акт хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгах явцдаа ЗХХШТХ-ийн 45, 46 дугаар зүйлд заасан журмын дагуу маргаантай захиргааны актын биелэлтийг захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явагдаж дуустал түдгэлзүүлж болно.

Энэ нь ЗХХШТХ-ийн 46 дугаар зүйлд заасан захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нөхцөл болон өөр хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргаж тухайн актын биелэлтийг түдгэлзүүлж болно гэсэн үг. Мөн хэм хэмжээ тогтоосон захиргааны актыг зөвхөн хуульд тусгайлан түдгэлзүүлж болохоор заасан тохиолдолд түдгэлзүүлж болно /ЗХХШТХ-ийн 45 дугаар зүйлийн 45.2./.

Хууль тогтоогч захиргааны хэргийн шүүх ЗХХШТХ-ийн 46 дугаар зүйлд заасан захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нөхцөл болон өөр хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд маргаан бүхий захиргааны актын биелэлтийг заавал түдгэлзүүлэхээр, харин дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан түдгэлзүүлэх эсэхийг бие даан шийдвэрлэхээр зохицуулж өгсөн.

Гэхдээ зарим сурах бичигт:” ... дээд шатны захиргаа, ЗХХШТХ-ийн 46 дугаар зүйлд заасан түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдлаас бусад тохиолдолд маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ гэдэг агуулгаар ойлгож, хүлээн авах нь захиргаанд өөрт нь тустай юм.

Учир нь ийнхүү түдгэлзүүлсэнээр хэрэв доод шатны захиргааны шийдвэр, үйл ажиллагаа нь хууль бус байвал түүний улмаас учрах хохирлоос урьдчилан сэргийлэх боломжтой болно”³⁹ гэснийг эрх зүйт төрийн үндсэн зарчмийн дагуу харгалзан үзэх нь зүйтэй болов уу.

Жишээ нь: “Газар чөлөөлөх” шийдвэрт гомдол, эсхүл шүүхэд нэхэмжлэл гаргаснаар гомдол гаргагч, эсхүл нэхэмжлэгч дээд шатны захиргааны байгууллагын шийдвэр, шүүхийн /мөн дээд шатны/ шийдвэрээр тухайн захиргааны акт хууль зүйн үндэслэлтэй гэдэг нь тогтоогдол түдгэлзлэлийн үйлчлэлийн дагуу актыг биелүүлж “тухайн газрыг чөлөөлөх” үүрэг хүлээхгүй⁴⁰.

8 дугаар зүйл. Захиргааны байгууллага, албан тушаалтан

гомдлыг хянан үзээд гаргах шийдвэр

- 8.1. Энэ хуулийн 6.1-д заасан захиргааны байгууллага, албан тушаалтан гомдлын дагуу хэргийг хянан үзээд дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана.
 - 8.1.1. захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх;
 - 8.1.2. маргаан бүхий захиргааны акт нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг захиргааны актыг бүхэлд нь, эсхүл холбогдох хэсгийг хүчингүй болгох;
 - 8.1.3. захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус эс үйлдэхүй нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол захиргааны

³⁹ А.Эрдэнэцогт, “Монгол Улсын захиргааны процессийн эрх зүй”, УБ, 2006 он, 109 дэх тал.

⁴⁰ P.Lohmann, “Allgemeines Verwaltungsrecht”, München, 1998, Seite 214.

зохих акт гаргахыг тухайн захиргааны байгууллага, албан тушаалтанд даалгах.

- 8.2. Энэ хуулийн 8.1.-д заасан захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэрийг холбогдох захиргааны байгууллага, албан тушаалтан заавал биелүүлнэ.

ТАЙЛБАР

1. Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр захиргааны акт болох нь

Хэрвээ дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан гомдлыг хянан үзээд доод шатны захиргааны байгууллага, албан тушаалтны гаргасан захиргааны акт хууль тогтоомжид нийцээгүй гэж үзвэл хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан шийдвэрийн аль нэгийг гаргана. Тиймээс хэлбэрийн хувьд энэ нь захиргааны акт мөн⁴¹.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д заасны дагуу гомдлыг шийдвэрлэсэн тухай хариуг биечлэн амаар буюу харилцах утсаар, эсхүл бичгээр болон бусад тохиромжтой хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй.

ЗХХШТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан шийдвэрийг заавал бичгэн хэлбэрээр гаргах шаардлагатай. Доод шатны захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны актыг шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан хүчингүй болговол, тухайн шийдвэр эрх зүйн үр дагавартай, мөн гомдол гаргагчийн хувьд “эерэг” шинжтэй.

Харин гуравдагч этгээдийн хувьд энэ нь “сөрөг” шинжтэй байж болох бөгөөд бие даасан захиргааны актын шинжийг агуулах тул тухайн этгээд шууд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нээгдэнэ /ЗХХШТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.2./ Иймээс тухайн шийдвэр захиргааны актад тавигдах шаардлагыг хангасан байх шаардлагатай.

Энэ нь Монгол Улсын Дээд шүүхээс⁴²: “ Хуулийн 6-10 дугаар зүйлд зааснаар доод шатны захиргааны байгууллага, албан тушаалтны актыг сонирхогч этгээдийн гомдлоор урьдчилан шийдвэрлэх журмаар хянаж шийдвэрлэсэн дээд шатны байгууллага, албан тушаалтан хамтран хариуцагч болохгүй.

Харин доод ба дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан нь бие дааж үйл ажиллагаа явуулсан, тодорхой үр дагавар бий болгосон захиргааны акт гаргасныхаа хувьд хамтран хариуцагч байж болно.” гэж тайлбарласнаар батлагдаж байна.

Хэрвээ дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан гомдлын дагуу доод шатны захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны актыг шалгаад хууль тогтоомжид нийцэж байна гэж үзвэл ямар шийдвэр гаргахыг шүүхээс гаргах шийдвэр шиг хуулиар тодорхой зохицуулж өгөөгүй.

Энэ нь гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох, гомдлын шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг хэрэгсэхгүй болгох зэрэг шийдвэрээс гадна гомдол гаргагчийн эрх

⁴¹ F.Hufen, “Verwaltungsprozessrecht”, Verlag C.H.Beck, München, 2003, Seite 129.

⁴² Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 7-р сарын 03- ны өдрийн 37 дугаар тогтоолын 9 дэх заалт.

зүйн байдлыг улам дордуулсан “*reformatio in peius*” шийдвэр гаргаж болно⁴³ гэсэн үг. Жишээ нь, “торгууль ногдуулсан тухай” захиргааны актанд гомдол гаргасан хэргийг хянаад дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан торгуулийн хэмжээг ихэсгэсэн шийдвэр гаргах.

Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан ийм төрлийн шийдвэр гаргах эрхтэй эсэх талаар хуульчдийн дунд үе үе маргаан үүсдэг бөгөөд харин ямарч тохиолдолд гомдол гаргагч шүүхэд нэхэмжлэл гаргаж хамтран хариуцагчаар татах эрхтэйг бүгд хүлээн зөвшөөрдөг⁴⁴.

2. Доод шатны захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны актыг шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан шалгаад хүчингүй болгох шаардлагатай гэж үзвэл хуулийн 8 дугаар зүйлйн 8.1-д заасан шийдвэрүүдийн аль нэгийг гаргана. ЗХХШТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан тохиолдол байвал хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасан “захиргааны акт илт хууль бус болохыг зөвшөөрсөн” өөрөөр хэлбэл тухайн захиргааны акт анхнаасаа хүчин төгөлдөр бус гэсэн шийдвэр гаргана.

Тухайн захиргааны акт хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг шалгах явцад илт хууль бус болох нь тогтоогдвол гомдол гаргагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн эсэхийг шалгах шаардлагагүй.

Харин тухайн захиргааны акт илт хууль бус гэсэн шинжийг агуулаагүй, өөрөөр хэлбэл хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан тохиолдол илрээгүй бол тухайн “маргаан бүхий акт” тухайн гомдол гаргагчийн⁴⁵ /нэхэмжлэгчийн/ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн эсэхийг шалгах шаардлагатай.

Хууль тогтоогч ЗХХШТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.2-д гомдол гаргагчийн гэж заагаагүй, харин “нэхэмжлэгчийн” гэж заасан нь тухайн гомдол гаргагч цаашид /шүүхэд/ “нэхэмжлэгч” байж болно гэж үзсэн тохиолдолд, өөрөөр хэлбэл хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1-д заасан нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах үндэслэл байхгүй гэж дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан үзээд хянан шалгах ажиллагаа явуулсан гэдгээр ойлгоно.

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-д заасан “маргаан бүхий захиргааны акт нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг захиргааны актыг бүхэлд нь, эсхүл холбогдох хэсгийг хүчингүй болгох” шийдвэрийг захиргааны акт бүхэлдээ, эсхүл холбогдох хэсэг нь хууль тогтоомжид нийцээгүй болон тухайн захиргааны акт гарснаар тухайн гомдол гаргагчийн субъектив эрх, хууль ёсны ашиг сонирхол бодитоор зөрчигдсэн гэж үзвэл гаргана. Хуулийн дээрхи хоёр нөхцөл хоёулаа байгаа тохиолдолд гомдол үндэслэлтэй болно. Хууль тогтоомжид нийцээгүй захиргааны акт шууд тухайн гомдол гаргагч руу чиглэсэн “дарамталсан” шинжтэй бол үргэлж нэхэмжлэгчийн /гомдол гаргагчийн/ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн байдаг⁴⁶.

Харин гуравдагч этгээд гомдол гаргасан бол тухайн гомдол гаргагчийн субъектив эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн эсэхийг тогтооход хүндрэл учирдаг.

⁴³ F.Hufen, “Verwaltungsprozessrecht”, Verlag C.H.Beck, München, 2003, Seiten 137-141.

⁴⁴ E.Eyermann, Verwaltungsgerichtsordnung Kommentar, Verlag C.H.Beck, München, 2000, Seiten 562-564.

⁴⁵ ЗХХШТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.2-дахь заалтыг хар.

⁴⁶ F.Hufen, “Verwaltungsprozessrecht”, Verlag C.H.Beck, München, 2003, Seite 103.

Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан хууль тогтоомжид нийцээгүй захиргааны акт тухайн нэхэмжлэгчийг хамгаалсан хэм хэмжээг /хамгаалах хэм хэмжээний онол/, саналыг авах хуулийн зохицуулалтыг эсхүл гомдол гаргагчийн үндсэн эрхийг шууд зөрчсөн нөхцөл байдал үүссэн эсэхийг шалгах шаардлагатай.

Жишээ нь объектив байдлаар хууль тогтоомжид нийцээгүй захиргааны акт /газрын зөвшөөрөл/ тухайн гомдол гаргагч гуравдавч этгээдийн /хөршийн/ субъектив эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчөөгүй бол гомдлыг үндэслэлгүй гэж үзэн хэрэгсэхгүй болгоно.

Жишээ нь түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэдэг үндэслэлээр барилга барих зөвшөөрлийг хүчингүй болгуулахаар гаргасан хөршийн гомдол.

Захиргааны байгууллага, албан тушаалтны эс үйлдэхүй⁴⁷ хууль бус бөгөөд иргэн, хуулийн этгээдийн субъектив эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн байна гэж дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан үзвэл ЗХХШТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.3-д заасан захиргааны зохих акт гаргахыг даалгах шийдвэр гаргана. Мөн адил дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус эс үйлдэхүй тухайн иргэн, хуулийн этгээдийг хамгаалсан хэм хэмжээг эсхүл гомдол гаргагчийн үндсэн эрхийг шууд зөрчсөн нөхцөл байдал үүссэн эсэхийг шалгах шаардлагатай.

Захиргааны байгууллага, албан тушаалтны эс үйлдэхүйд гуравдагч этгээд гомдол гаргах эрх зүйн үндэслэл байхгүй, яагаад гэвэл эрх зүйн үр дагавар үүсэхгүй учраас субъектив эрх зөрчигдөх нөхцөл байдал үүсэхгүй. Доод шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хэрэгжүүлэх, хамгаалуулахаар гомдол гаргасан, өөрөөр хэлбэл ЗХХШТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д заасан “иргэн, хуулийн этгээд” мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-д заасан дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргасан “иргэн, хуулийн этгээд” байна гэдэг үүднээс хууль тогтоогч зориуд “нэхэмжлэгч” эсхүл “гомдол гаргагч” зэрэг нэр томъёог хэрэглээгүйг харгалзан үзэх нь зүйтэй байх.

Иймээс анхлан захиргааны байгууллага, албан тушаалтанд эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хэрэгжүүлэх, хамгаалуулахаар гомдол гаргасан иргэн, хуулийн этгээд дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-д заасан шийдвэр гаргуулах шаардлага бүхий гомдол гаргах эрхтэй.

3.Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэрийг холбогдох захиргааны байгууллага, албан тушаалтан заавал биелүүлэхээр зохицуулсан.

Энэ нь хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-8.1.3-д заасан шийдвэрийг зөвхөн тухайн захиргааны акт гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтан бус бусад бүх холбогдох нийтийн захиргааны байгууллага, албан тушаалтан заавал биелүүлэх шаардлагатай гэсэн үг.

Жишээ нь дүүргийн Засаг даргын “албадан нүүлгэх” захирамжийг Нийслэлийн Засаг дарга хянан үзээд “илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрсөн” шийдвэр гаргасан бол зөвхөн дүүргийн Засаг дарга бус холбогдох газрын албад, цагдаагийн болон бусад байгууллага, албан тушаалтан заавал биелүүлэх үүрэгтэй.

⁴⁷ ЗХХШТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.6-дахь заалтын тодорхойлолтыг хар.

4. Хууль тогтоомжид нийцээгүй захиргааны актыг илт хууль бус, маргаан бүхий гэж хоёр ангилдаг.

Илт хууль бус захиргааны акт анхнаасаа хүчин төгөлдөр бус байдаг тул “илт хууль бусыг хүлээн зөвшөөрөх” шийдвэр гаргадаг. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан “илт хууль бус” шинжийг агуулаагүй хууль тогтоомжид нийцээгүй захиргааны актыг маргаан бүхий гэдэг бөгөөд хэрвээ маргаан бүхий акт нэхэмжлэгчийн субъектив эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол “хүчингүй болгох” шийдвэр гаргадаг.

Захиргааны дээд байгууллага, албан тушаалтан хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан шийдвэрийг заавал бичгээр гаргаж талуудад мэдэгдэнэ⁴⁸. Шийдвэрээ тэмдэглэлд тусгах эсхүл тусд нь гаргах талаар хуульд тодорхой зохицуулалт алга, иймээс энэ нь дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтны эрх хэмжээний асуудал юм.

Захиргааны дээд байгууллага, албан тушаалтан тухайн хэргийг хянан үзээд хуульд заасан хугацаанд хэргийн талаар шийдвэр гаргах объектив эрх зүйн үүрэг хүлээнэ. Хянан шийдвэрлэх ажиллагааны явцын талаар мэдээлэх, зөвлөгөө өгөх зэргийг тухайн асуудлыг шийдвэрлэсэн гэж үзэхгүй.

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасан шийдвэрийг дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтнаар гаргуулахын тулд иргэн, хувийн эрх зүйн хуулийн этгээд шууд харьяалах доод шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хэрэгжүүлэх, хамгаалуулахаар анхлан гомдол гаргасан байх шаардлагатай.

Мөн тухайн захиргааны байгууллага, албан тушаалтан гомдлыг хянан шийдвэрлэх үүргээ хуульд заасан хугацаанд биелүүлээгүй буюу шийдвэрлэхгүй орхигдуулсан байхыг давхар шаардана. “Хуульд заасан хугацаанд” гэдгийг тухайн харилцааг нарийвчилан зохицуулсан хуульд “тусгай” хугацааг тодорхой заагаагүй бол ЗХХШТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан “ерөнхий” хугацаанд гэдгээр ойлгоно. Тусгай хугацаа нь ерөнхий хугацаанаас богино тогтоогдогоороо онцлогтой⁴⁹.

9 дүгээр зүйл. Захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргах

9.1. Захиргааны байгууллага, албан тушаалтан дараахь тохиолдолд захиргааны актыг илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргана:

9.1.1. захиргааны акт утга агуулгын илэрхий алдаатай;

9.1.2. бичгийн хэлбэрээр гаргасан захиргааны актыг батлан гаргасан байгууллага, албан тушаалтан нь тодорхойгүй;

9.1.3. захиргааны акт гаргах эрх хэмжээгүй захиргааны байгууллага, албан тушаалтан гаргасан;

⁴⁸ ЗХХШТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4-дэх заалтыг хар.

⁴⁹ А.Эрдэнэцогт, “Монгол Улсын захиргааны процессийн эрх зүй”, УБ, 2006 он, 123 дахь тал.

- 9.1.4. захиргааны актыг гүйцэтгэх субъект тодорхой бус;
 - 9.1.5. хууль бус үйлдэл, эс үйлдэхүйг гүйцэтгэхийг шаардсан;
 - 9.1.6. нийтийн ёс зүйн хэм хэмжээг илт зөрчсөн;
 - 9.1.7. захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй;
 - 9.1.8. захиргааны акт гаргах хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн;
 - 9.1.9. захиргааны акт өөр бусад байдлаар холбогдох хууль зөрчсөн.
- 9.2. Захиргааны актын аль нэг заалт илт хууль бус бөгөөд тухайн заалтгүйгээр захиргааны актын агуулга ойлгомжгүй болоход хүрвэл захиргааны актыг бүхэлд нь илт хууль бус гэж тооцно.

ТАЙЛБАР

1. Ач холбогдол: Хууль тогтоогч хуулийн 9 дүгээр зүйлд дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтны “захиргааны акт илт бус болохыг хүлээн зөвшөөрсөн” шийдвэр гаргах тохиолдлуудыг нэг бүрчлэн тоочих аргаар хуульчилж өгсөн. Энэ хууль болон бусад хууль тогтоомжид “илт хууль бус” захиргааны акт байх эрх зүйн үр дагаварыг тогтоож өгсөн нөхцөлд тухайн захиргааны акт илт хууль бус байна.

Захиргааны акт эрх зүйн илт алдаатай, энэхүү алдаа нь хэн ч харсан илэрхий байвал илт хууль бус захиргааны акт гэж тодорхойлдог⁵⁰. Эрх зүйн илт алдаатай гэдэг нь одоо үйлчилж байгаа үндсэн хуулийн үндсэн зарчмуудад, эсхүл одоогийн эрх зүйн тогтолцооны үнэт зүйлсийн ойлголтонд харшилж байна гэдэг үндэслэлээр эрх зүйн одоогийн тогтолцоотой ямарч нөхцөлд нийцэхгүй байгааг ойлгоно.

Хэн ч харсан илэрхий алдаа гэдэг нь тухайн хэргийн нөхцөл байдлыг мэддэг хувь хүн /хуульч бус хүн байх ёстой/ хараад л илэрхий алдаатай байна гэдгийг амархан тогтоох боломжтой байхыг хэлнэ. Илт хууль бус захиргааны акт ямар нэгэн эрх зүйн үр дагаварт хүргэдэггүй тул гарсан үеээсээ хүчин төгөлдөр бус байдаг. Иймээс захиргааны байгууллага, албан тушаалтан болон шүүхээс тухайн захиргааны акт илт хууль бус /илт хүчин төгөлдөр бус/ болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргадаг.

Захиргааны акт илт хууль бус байх тохиолдлуудыг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1.-9.1.9-д зааж өгсөн.

2. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д заасан “захиргааны акт утга агуулгын илэрхий алдаатай” гэдэгт актыг гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтны хүсэл зориг тухайн актад бүрэн гүйцэд илэрхийлэгдээгүй, актын заалтууд нь хоорондоо зөрчилдсөнөөс хоёрдмол утгатайгаар ойлгогдож болохоор агуулга нь тодорхой бус байхыг хэлнэ.

Түүнчлэн найруулга зүйн болон үг, үсэг, тооны алдаа нь үр дагаварын хувьд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихөөр байвал тухайн актыг утга агуулгын

⁵⁰ U.Battis, “Allgemeines Verwaltungsrecht”, C.F.Müller Verlag, Heidelberg, 2002, Seite 166.

илэрхий алдаатайд тооцож болно⁵¹ гэж Улсын дээд шүүхээс албан ёсоор тайлбарласан байна.

“Илэрхий алдаа” гэдэгт зөвхөн тухайн захиргааны актыг хүлээн авагч алдааг хараад танихаас гадна жирийн иргэн хэн ч хараад танихаар алдааг хэлнэ. Утга агуулгын алдааг захиргааны актыг хүлээн авагчийн субъектив төсөөлмөөр юмуу туршлагатай хуульчийн нарийн ажиглалтаар бус гярхай хэн ч харсан илэрхий байх ёстой. Жишээ нь иргэн А-гийн гэр олгох хүсэлт болон амжиргааны түвшинг харгалзан иргэн Б-д нэг удаагийн буцалтгүй тусламж олгох шийдвэр гаргах.

3.Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т заасан “батлан гаргасан байгууллага, албан тушаалтан тодорхойгүй” гэдэгт тухайн захиргааны акт бичгэн хэлбэрээр гарч холбогдох иргэн, хуулийн этгээд хүлээн авсан боловч ямар байгууллагын хэн гэдэг албан тушаалтан гаргасан нь тодорхойгүйн улмаас шүүхэд нэхэмжлэл, дээд байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах боломжгүй болох тохиолдлыг хэлнэ.

Үндсэн хуулинд заасан төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрх⁵² болон шүүхэд гомдол гаргах эрх⁵³ зэрэг иргэний үндсэн эрхүүдийг зөрчсөн актууд анхнаасаа хүчин төгөлдөр бус байдаг нь энэхүү заалтаар нотлогдож байна. Жишээ нь “албадан нүүлгэх” шийдвэрийг ямар байгууллага, албан тушаалтан гаргасан нь тодорхойгүйн улмаас гомдол гаргах эрхээ эдлэх боломжгүй болох.

4.Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т заасан “эрх хэмжээгүй захиргааны байгууллага, албан тушаалтан гаргасан” гэдэгт эрх зүйт төрд нийтийн захиргааны байгууллага, албан тушаалтны хариуцах үүрэг, түүний эрх хэмжээг хууль тогтоомжоор нарийн зааглан тогтоосон байдаг бөгөөд тухайн байгууллага, албан тушаалтанд эрх мэдлийг нь хуулиар тусгайлан зөвшөөрч олгосон тохиолдолд тодорхой захиргааны акт гаргах боломжтой гэсэн шаардлагыг зөрчиж захиргааны акт гаргасан тохиолдлыг хэлнэ. Өөрөөр хэлбэл захиргааны байгууллага, албан тушаалтан өөрт хуулиар тусгайлан эрх олгогдоогүй асуудлаар захиргааны акт гаргавал илт хууль бус гэж үзнэ. Үүнд эрх хэмжээ ба нутаг дэвсгэрийн хамаарал багтана⁵⁴. Жишээ нь, Б дүүргийн Засаг дарга Х дүүрэгт газар эзэмших зөвшөөрөл олгосон захирамж гаргах.

5.Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-т заасан “захиргааны актыг гүйцэтгэх субъект тодорхой бус” гэдэгт нийтийн эрх зүйн хүрээнд иргэн, байгууллагын хооронд үүссэн тодорхой харилцааг, эсхүл тодорхой тохиолдлыг нийтийн ашиг сонирхлын үүднээс зохицуулах зорилгоор гаргасан боловч хэн биелүүлэх нь тодорхой байх шаардлагыг хангаагүй, өөрөөр хэлбэл анхнаасаа хэрэгжих боломжгүй захиргааны акт гаргасан тохиолдлыг хэлнэ. Жишээ нь, жилийн өмнө үйл ажиллагаа явуулахаа албан ёсоор зогсоосон “Т” зоогийн газрын үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр гаргах.

6.Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5-д заасан “хууль бус үйлдэл, эс үйлдэхүйг гүйцэтгэхийг шаардсан” гэдэгт холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээж болохоор,

⁵¹ Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 7-р сарын 03- ны өдрийн 37 дугаар тогтоолын 4 дэх заалт.

⁵² Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 12 дугаар хэсгийг хар.

⁵³ Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 14 дүгээр хэсгийг хар.

⁵⁴ П.Одгэрэл. “Захиргааны эрх зүйн ерөнхий анги” УБ хот. 2004 он. 120-121 дэх тал.

өөрөөр хэлбэл эрүүгийн хэрэг эсхүл захиргааны зөрчилд тооцогдож болохоор үйлдэл, эс үйлдэхүй гүйцэтгэхийг тухайн актыг биелүүлэх субъектээс шаардсан захиргааны акт гаргасан тохиолдлыг хэлнэ. Жишээ нь, Эрүүгий хуулийн 137 дугаар зүйлийг зөрчин орон байранд нь нэвтрэхийг шаардсан шийдвэр захиргааны байгууллагаас гаргах⁵⁵.

7.Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6-д заасан “нийтийн ёс зүйн хэм хэмжээг илт зөрчсөн” гэдэгт эрх, үүрэг тодорхой хэмжээгээр бий болгон уламжлагдан хэрэглэгдэж байгаа, нийтээр дагаж мөрдөн дадал хэвшил болсон зан заншил, ёс суртахууны хэм хэмжээг тухайн захиргааны байгууллага, албан тушаалтан зөрчсөн байхыг ойлгоно⁵⁶ гэж Дээд шүүхээс тайлбарлажээ. Энэхүү зөрчил нь илт, хэн ч харсан илэрхий байх ёстой. Жишээ нь, Ч дүүргийн Засаг даргаас “Эрх чөлөөний талбайд” нүцгэн хүмүүсийн цуглаан “Рее-Show” зохион явуулахад зөвшөөрөл олгох.

8.Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.7-д заасан “захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй” гэдэгт захиргааны байгууллага, албан тушаалтан тухайн харилцааг хуулиар зохицуулаагүй байхад болон хуулиар тогтоосон хязгаарлалтыг зөрчих, түүнчлэн хуулиас гадуур нэмэлт хязгаарлалт тогтоох, бүрэн эрхээ хэтрүүлэх зэргээр захиргааны акт гаргасныг ойлгоно⁵⁷ гэж Улсын Дээд шүүхээс тайлбарласан байна. Жишээ нь, 5-аас дээш давхар барилга байгууламжинд цахилгаан шаттай байх хуулийн шаардлагыг зөрчин 6 давхар барилгад цахилгаан шатгүй барилга барих зөвшөөрөл олгох.

Цааш нь Дээд шүүхээс:“Түүнчлэн тухайн харилцааг зохицуулсан хуулийн тодорхой заалтыг хэрэглээгүй буюу хуулийн ерөнхий заалтыг хэрэглэсэн, эсхүл хуулийн заалтыг хэрэглэхгүйгээр захиргааны акт гаргасан зэргийг “захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй” гэдэгт хамааруулж үзнэ³⁷” гэж тухайн заалтыг дэлгэрүүлж тайлбарласан байна. Үүнээс үзэхэд хуулийн ямар нэгэн зүйл, заалтыг хэрэглэлгүй гаргасан захиргааны акт анхнаасаа хүчин төгөлдөр бус байх нь. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 1-д заасан “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалттай бүрнээ нийцэж байна.

9.Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8-д заасан “захиргааны акт гаргах хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн” гэдэгт захиргааны байгууллага, албан тушаалтан хуулиар тогтоосон хугацаанд үйл ажиллагаа явуулах үүргээ биелүүлэлгүй хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсний дараа тодорхой үндэслэл заасан эсэхээс үл хамааран иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илт зөрчсөн буюу шууд дордуулсан захиргааны акт гаргасныг ойлгоно. Жишээ нь, захиргааны зөрчил гаргасан иргэнд зөрчил гарсан өдрөөс хойш 3 сар өнгөрсний дараа захиргааны шийтгэл ногдуулах шийдвэрийг эрх бүхий захиргааны байгууллагаас гаргах.

10.Хуулийн “9 дүгээр зүйлийн 9.1.9-д заасан “... өөр бусад байдлаар холбогдох хууль зөрчсөн” гэдэгт хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-9.1.8-д тодорхойлон зааснаас

⁵⁵ Амьдралд тэр болгон тохиолдоод байдаггүй.

⁵⁶ Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 7-р сарын 03- ны өдрийн 37 дугаар тогтоолын 5 дахь заалт.

⁵⁷ Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 7-р сарын 03- ны өдрийн 37 дугаар тогтоолын 6 дахь заалт.

бусад хэлбэрээр хууль зөрчсөн байхыг ойлгоно⁵⁸” гэж Улсын Дээд шүүхээс албан ёсоор тайлбарласан байна. Захиргааны байгууллага, албан тушаалтны гаргасан тухайн акт хууль зөрчсөн байхаас гадна эрх зүйн илт алдаатай, энэхүү алдаа нь хэн ч харсан илэрхий байх ёстой тохиолдлууд энд хамаарна. Жишээ нь улс төрийн шалтгаанаар иргэнд газар өмчлүүлэхээс татгалзсан шийдвэр гаргах.

11.Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг захиргааны актын аль нэг заалт илт хууль бус тохиолдолд тухайн актын эрх зүйн үр дагаварыг хуульчилж өгсөн маш чухал зохицуулалт. Захиргааны акт хэд хэдэн заалтаас бүрдэж болох бөгөөд аль нэг заалт илт хууль бус гэж тогтоогдсон нөхцөлд тухайн заалтгүйгээр захиргааны актын агуулга бүрэн гүйцэд илэрхийлэгдэх эсэхийг шалгаад, хэрвээ тухайн заалтгүйгээр актын агуулга ойлгомжгүй болоход хүрвэл захиргааны актыг бүхэлд нь илт хууль бус гэж тооцсон шийдвэр гаргана.

Зөвхөн аль нэг заалтыг илт хууль бус болохыг, эсхүл тухайн актыг бүхэлд нь илт бус болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргах эсэхийг тогтоох субъектив үндэслэл нь захиргааны байгууллага, албан тушаалтан илт хууль бус заалтгүйгээр тухайн захиргааны актыг гаргах боломжгүй байсан, объектив үндэслэл нь илт хууль бус заалт тухайн захиргааны актын гол хэсэг учраас үлдсэн хэсгийг нь тусад нь гаргах боломжгүй байх байсан болно⁵⁹.

Иргэний эрх зүйн илт хууль бусад тооцох зарчмаас ялгаатай нь дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан захиргааны актыг бүхэлд нь илт хууль бусад тооцохдоо эрх зүйн хамгаалалт /Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 3 дахь хэсэг/, захиргааны байгууллагын хууль биелүүлэх үүрэг /Үндсэн хуулийн гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг/, нийтийн ашиг сонирхлыг харгалзан үзэхийг шаарддаг. Иймээс захиргааны актын аль нэг заалт нь илт хууль бус гэдэг нь тогтоогдвол, зөвхөн тухайн заалтгүйгээр актын агуулга ойлгомжгүй болсон нөхцөлд захиргааны актыг бүхэлд нь илт хууль бусад тооцож болно.

⁵⁸ Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 7-р сарын 03- ны өдрийн 37 дугаар тогтоолын 6 дахь заалт.

⁵⁹ U.Battis, “Allgemeines Verwaltungsrecht”, C.F.Müller Verlag, Heidelberg, 2002,Seite 167.

10 дугаар зүйл. Маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгох

10.1. Маргаан бүхий захиргааны акт иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн нь тогтоогдсон бол энэ хуулийн 6.1.-д заасан захиргааны байгууллага, албан тушаалтан уг актыг хүчин төгөлдөр үйлчилж байгаа, эсхүл ирээдүйд хүчин төгөлдөр болох эсэхээс үл хамааран бүхэлд нь буюу холбогдох хэсгийг хүчингүй болгосон шийдвэр гаргана.

ТАЙЛБАР

Хүчингүй болгох гэдэг нь захиргааны байгууллага, албан тушаалтан эсхүл шүүх тусгай шийдвэр гаргаснаараа захиргааны актын эрх зүйн бүхий л үйлчлэлийг алга болгохыг хэлнэ⁶⁰. Захиргааны актыг иргэн, хуулийн этгээдийн гомдол, нэхэмжлэлээр хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд захиргааны байгууллага, албан тушаалтан эсхүл шүүхээс хүчингүй болгодог.

Шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан тухайн захиргааны актын холбогдох хэсгийг эсхүл бүхэлд нь хүчингүй болгож болно. Захиргааны актын холбогдох хэсгийг хүчингүй болгох боломжтой гэдэг нь цаг хугацаа, орон зай, агуулга болон хувь хүн, хуулийн этгээдийн талаар хүчингүй болгох хязгаарлалт хийж болно гэсэн үг.

Цаг хугацааны хязгаарлалт гэдэгт захиргааны акт гарсны дараа эрх зүйн болон хэргийн нөхцөл байдал өөрчлөгдсөнөөр тухайн захиргааны актын холбогдох хэсэг хууль бус болсныг хэлнэ. Жишээ нь, хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нийгмийн халамжийн хуульд нэмэлт өөрчлөлт орох. Орон зайн хязгаарлалт жишээ нь зам барих төлөвлөгөөнд өөрчлөлт орсноор хийгдэж болно.

Хувь хүн, хуулийн этгээдийн талаархи хязгаарлалт жишээ нь гомдол, нэхэмжлэлийг хэд хэдэн этгээд гаргасан тохиолдолд аль нэгэн этгээд нь иргэний эрх зүйн чадамжгүй эсхүл төлөөлөх эрхгүй гэдэг нь тогтоогдсон зэрэг тохиолдолд үүснэ. Агуулгын хязгаарлалтыг ихэвчлэн маргааныг зохицуулж байгаа зүйлд, тухайн хэсгийг захиргааны актын бусад хэсгээс салгаж болох нөхцөлд хийдэг. Энэ нь тухайн захиргааны актад нэмэлт өөрчлөлт оруулж байгаатай адил юм.

Эрх зүйн хүчинтэй /маргаан бүхий/ захиргааны актыг шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэнэ.

Хэрвээ захиргааны акт илт хууль бус /анхнаасаа хүчин төгөлдөр бус⁶¹/ бол дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан эсхүл шүүх түүнийг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргадаг. Зорилгоо биелүүлээд дуусгавар болсон захиргааны актад энэхүү зохицуулалт нэгэн адил хамаарна⁶². Эрх зүйн үр дагаврын хувьд өөр өөр байдаг тул төрийн албан тушаалтан, шүүгч нар маргаан бүхий захиргааны актыг илт хууль бус актаас ялгаж зөв шийдвэр гаргах мэдлэгтэй байх шаардлагатай.

⁶⁰ H.Maurer, "Allgemeines Verwaltungsrecht", C.H.Beck Verlag, München, 2002, Seite 283.

⁶¹ ЗХХШТХ-ийн 70 дугаар зүйлийн 70.2.3-дахь заалтыг хар.

⁶² H.Maurer, "Allgemeines Verwaltungsrecht", C.H.Beck Verlag, München, 2002, Seite 287.

Маргаан бүхий захиргааны актыг одоо үйлчилж байгаа, эсхүл ирээдүйд хүчин төгөлдөр болохоос үл хамааран зөвхөн иргэн, хуулийн этгээдийн гомдлоор тухайн иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн нь тогтоогдсон нөхцөлд дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан хүчингүй болгосон шийдвэр гаргана.

Харин хууль тогтоомжид нийцээгүй /гарснаасаа эсхүл хянан шийдвэрлэх явцад/ захиргааны актыг анхлан гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтан хэзээ ч буцаан авч хүчингүй болгох эрхтэй, эрхтэйгээр барахгүй үүрэгтэй. Энэ нь захиргааны байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомжид нийцээгүй захиргааны акт гаргаснаар зөрчигдсэн хууль ёсны харилцааг буцаан засаж байгаа гэдгээрээ хууль дээдлэх эрх зүйт төрийн үндсэн зарчимтай болон Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасантай нийцэж байгаа юм. Бүх нийтэд үйлчилдэг, хууль ёсны харилцааг эргэн тогтоосноор эрх тэгш байдал, материаллаг шударга ёс үйлчилж байна гэж үздэг⁶³. Захиргааны эрх зүйн онолоор захиргааны актыг “дарамт учруулсан” /үүрэг хүлээлгэсэн/, “ээрэг байдал бий болгосон” /эрх олгосон/ гэж хоёр хуваадаг.

Хууль тогтоомжид нийцээгүй “дарамт учруулсан” захиргааны актыг буцаан авч хүчингүй болгоход дээрхи зарчим шууд үйлчилдэг бол “ээрэг байдал бий болгосон” актыг хүчингүй болгоход дээрхи зарчим шууд үйлчлэх эсэх нь маргаантай асуудлын нэг болоод байгаа⁶⁴. Үүнд нэг талаас төрийн хууль дээдлэх үндсэн зарчим нөгөө талаас хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулах үндсэн зорилго болон Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлд заасан иргэний эрх, эрх чөлөөг харгалзан үзэх шаардлагатай юм.

Эрх зүйт төрийн эдгээр үндсэн зарчмуудыг зөв хэрэглэснээр иргэдийн төр /нийтийн захиргааны байгууллага/-д итгэх итгэл нэмэгдэж Үндсэн хуулийн итгэл үнэмшилтэй байх зарчим хэрэгжих юм. Жишээ нь цэргийн албанаас чөлөөлсөн, Монгол Улсын иргэний харьяат болгосон, иргэнд газар өмчлүүлсэн зэрэг шийдвэр “ээрэг байдал бий болгосон” захиргааны акт тул эдгээрийг буцаан авч хүчингүй болгохдоо дээрхи зарчмуудыг харгалзан үзэх шаардлагатай. Мөн Монгол Улсын олон улсын гэрээ, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлах шаардлагатай /Монгол Улсын Үндсэн хуулийн аравдугаар зүйл, ЗХХШТХ-ийн 2 дугаар зүйлийн 2.2-ийг хар/.

11 дүгээр зүйл. Захиргааны акт гаргахыг даалгах

11.1. Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан дараах тохиолдолд захиргааны зохих акт гаргахыг тухайн захиргааны байгууллага, албан тушаалтанд даалгана:

11.1.1. захиргааны акт гаргахаас үндэслэлгүйгээр татгалзсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгож, захиргааны акт гаргах;

⁶³ U.Battis, “Allgemeines Verwaltungsrecht”, C.F.Müller Verlag, Heidelberg, 2002, Seite 181.

⁶⁴ H.Maurer, “Allgemeines Verwaltungsrecht”, C.H.Beck Verlag, München, 2002, Seiten 290-293.

- 11.1.2. захиргааны байгууллага, албан тушаалтны эс үйлдэхүйн улмаас иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн нь тогтоогдсон.
- 11.2. Захиргааны байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 11.1.-д зааснаас бусад үйлдэл хийж гүйцэтгэхийг даалгасан шийдвэр гаргаж болно.

ТАЙЛБАР

1.Захиргааны байгууллага, албан тушаалтны цаг хожих гэсэн эс үйлдэхүй, эрх зүйн хэм хэмжээг зөрчин захиргааны акт гаргахаас үндэслэлгүйгээр татгалзсан шийдвэрийг таслан зогсоох зорилгоор хуулийн энэхүү зохицуулалтыг хийж өгсөн. Энэхүү заалтыг хэрэглэх урьдчилсан нөхцөл нь тухайн иргэн, хуулийн этгээд урьдчилан хүсэлт, гомдол гаргасан байхыг шаардана. Өөрөөр хэлбэл захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан хүсэлт, гомдол шууд харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтанд эсхүл шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах эрх нээгдэх урьдчилсан нөхцөл болно.

Хуулийн 9, 10 дугаар зүйлд дээд байгууллага, албан тушаалтан захиргааны актыг хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгаж шийдвэрээ гаргадаг бол, хуулийн 11 дүгээр зүйлд заасан шийдвэрийг захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны акт гаргаагүй үйлдэл, эс үйлдэхүй хууль тогтоомжид нийцсэн эсэхийг хянан шалгаж шийдвэрээ гаргадгаараа онцлогтой байдаг.

Захиргааны акт гаргахаас татгалзсан шийдвэр нь захиргааны акт гаргаагүй үйлдэл гэж; хуульд заасан хугацаанд хүсэлт, гомдлыг хянан шийдвэрлэх үүргээ захиргааны байгууллага, албан тушаалтан биелүүлээгүй буюу шийдвэрлэхгүй орхигдуулсныг эс үйлдэхүй гэж тодорхойлдог⁶⁵. Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 12-т заасан “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхээ” эдлэхэд энэхүү заалт маш чухал үүрэг гүйцэтгэх учиртай.

Захиргааны акт гаргаагүй үйлдэл, эс үйлдэхүйн эсрэг иргэн, хуулийн этгээд захиргааны акт гаргахыг даалгах шаардлага бүхий гомдол, нэхэмжлэл гаргадаг. Тодорхой хэлбэл маргааны зүйл нь захиргааны акт гаргахаас үндэслэлгүйгээс татгалзсан шийдвэр, захиргааны байгууллага, албан тушаалтны эс үйлдэхүй нь миний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж байна гэсэн гомдол гаргагчийн үндэслэл юм.

Харин захиргааны байгууллага, албан тушаалтан захиргааны акт гаргах эрхтэй эсэх, захиргааны акт гаргах үндэслэл байгаа эсэх зэрэг асуудлууд маргааны зүйл биш бөгөөд харин шийдвэрийн үндэслэл байж болно. Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан болон шүүх эрх мэдлийн байгууллагаас маргааны зүйлийг зөв тодорхойлохоос шийдвэр зөв, үндэслэлтэй, бүрэн гүйцэд гарах эсэх нь шалтгаалдаг. Гомдол гаргагчийн гол зорилго нь захиргааны акт гаргахыг даалгах шийдвэр гаргуулах явдал байдаг.

2.Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтнаас доод шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд ямар

⁶⁵ ЗХХШТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.5, 3.1.6-дахь заалтыг хар.

тохиолдолд захиргааны акт гаргахыг даалгах шийдвэр гаргахыг хууль тогтоогч тодорхой хуульчилж өгсөн.

Хэрвээ захиргааны байгууллага, албан тушаалтан захиргааны акт гаргахаас үндэслэлгүйгээр татгалзсан шийдвэр гаргасан бол тухайн татгалзсан шийдвэрийг хүчингүй болгож, холбогдох захиргааны актыг гаргахыг даалгах шийвэр гаргана /хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1./ Энд татгалзсан шийдвэрийг хүчингүй болгох заалт шийдвэрийн нэг хэсэг болж байгаа боловч гомдлын үндсэн шаардлага нь захиргааны акт гаргахыг даалгах гэдгийг үргэлж санаж байх шаардлагатай.

Хэрвээ холбогдох захиргааны байгууллага, албан тушаалтан хуульд заасан хугацаанд захиргааны акт гаргаагүй, мөн гаргахаас татгалзсан шийдвэр ч гаргаагүй, өөрөөр хэлбэл захиргааны байгууллага, албан тушаалтны эс үйлдэхүй байвал тодорхой хүсэлт, гомдол гаргасан иргэн, хуулийн этгээд захиргааны акт гаргахыг даалгах шаардлага бүхий гомдол гаргана.

Тухайн захиргааны байгууллага, албан тушаалтны эс үйлдэхүйн улмаас гомдол гаргагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн гэдэг нь тогтоогдвол дээд шатны байгууллага, албан тушаалтан захиргааны акт гаргахыг даалгасан шийдвэр гаргана /хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2./. Гомдол гаргагч захиргааны акт гаргахыг даалгах шаардлага бүхий гомдол гаргахдаа өөрт “ээрэг байдал” бий болгохыг, өөрөөр хэлбэл анх байгаа байдлаасаа илүү нөхцөл байдал хүсэмжилдэг.

Тиймээс гомдол гаргагч захиргааны актыг хүчингүй болгох бус, харин өөрт “ашигтай” захиргааны акт гаргахыг холбогдох захиргааны байгууллага, албан тушаалтанд даалгахыг хүсдэг. Тиймээс, алдаа гаргахгүйн тулд захиргааны акт гаргахаас татгалзсан шийдвэрийг зарчмын хувьд “дарамт учруулсан” захиргааны акт гэж үзэж болохгүй. Жишээ нь нийтийн тээврийн үйлчилгээний эрх олгохоос татгалзсан шийдвэр.

3.Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-д заасны дагуу дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан шаардлагатай бол захиргааны акт гаргахыг даалгахаас бусад үйлдэл хийж гүйцэтгэхийг даалгасан шийдвэр гаргаж болно. Захиргааны хэргийн шүүх захиргааны актыг гаргахгүй байгаа явдал болон эс үйлдэхүй нь хууль бус гэж тогтоогдсон бол шаардагдах захиргааны актыг гаргахыг тухайн захиргааны байгууллага, албан тушаалтанд даалгах⁶⁶ шийдвэрийг гаргадаг бол дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд захиргааны акт гаргахыг даалгах шийдвэр гаргахаас гадна бусад шаардагдах үйлдэл хийж гүйцэтгэхийг даалгах шийдвэр гаргах эрхийг хуулиар олгосон.

Энэ нь нийтийн эрх зүйн захиргааны байгууллагын үйл ажиллагааны ерөнхий зарчмуудтай болон Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 12-т заасантай нийцэж байна.

Захиргааны акт гаргахаас бусад үйлдэл хийж гүйцэтгэхийг даалгах шаардлага бүхий гомдлын маргааны зүйл нь захиргааны байгууллага, албан тушаалтны одоо үйлдэгдэж байгаа, эсхүл ирээдүйд үйлдэгдэх үйлдэл түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж байна гэсэн гомдол гаргагчийн үндэслэл юм. Өөрөөр хэлбэл гомдол гаргагч захиргааны актыг бус, захиргааны хууль бус үйлдэл, эс үйлдэхүйг зогсоохыг шаарддаг.

⁶⁶ ЗХХШТХ-ийн 70 дугаар зүйлийн 70.2.4-дэх заалтыг хар.

Жишээ нь нийтийн зам засварын ажлын тодорхой үйлдэлд, тухайлбал 22 цагаас хойш чимээ шуугиан гаргахгүй байх шаардлага бүхий гомдол гаргах. Энэ нь нийтийн зам талбайг засах тодорхой шийдвэрийг хүчингүй болгох шаардлага бус, харин иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхээ эдлэхийг хүссэн шаардлага юм.

12 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхэд
нэхэмжлэл гаргах эрх

- 12.1. Иргэн, хуулийн этгээд дараах тохиолдолд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй:
- 12.1.1. хуульд тусгайлан заасан;
 - 12.1.2. Дээд шатны захиргааны байгууллага албан тушаалтнаас энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан журмын дагуу гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн;
 - 12.1.3. Захиргааны байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 8-р зүйлд заасан журмын дагуу гаргасан шийдвэрийг биелүүлээгүй;
 - 12.1.4. Шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан гомдлыг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлээгүй.
- 12.2. Харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан байхгүй бол иргэн хуулийн этгээд нь зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар энэ хуулийн 6.1-д заасан хугацаанд Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргана.

ТАЙЛБАР

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд "Монгол Улсын иргэн, төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй"⁶⁷ гэж заасан байна. Үндсэн хуулийн энэхүү заалт нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгалаа олж хэрэгжих баталгааг энэ зүйлээр тодорхойлжээ.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхийг Үндсэн хууль болон энэ хуулиар баталгаажуулж өгсөн байна. Энэ нь зөвхөн иргэнээр хязгаарлагдах бус эрх нь зөрчигдсөн, эсвэл маргаантай байгаа эрх, эрх чөлөө болон хамгаалагдвал зохих хууль ёсны ашиг сонирхлоо захиргааны шүүхээр хамгаалуулах хэрэгцээ шаардлага бүхий хуулийн этгээдэд нэгэн адил хамаарах юм. Шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нь зөвхөн өөрийн эрх ашиг зөрчигдсөнөөр хязгаарлагдахгүй бусад этгээдийн эрх, хууль ёсны эрх ашиг сонирхол нь зөрчигдсөн тохиолдолд тэднийг шүүхээр хамгаалуулах зорилгоор хэрэгжих боломж хуулиар олгогдож байгаа юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаас үзэхэд нэхэмжлэл гаргах эрх нь захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус эрх зүйн акт, үйлдэл,

⁶⁷ Монгол Улсын Үндсэн хууль 2002 он

/эс үйлдэхүйн/ улмаас үүсдэг. Өөрөөр хэлбэл Захиргааны хэргийн шүүх захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагаатай холбогдуулан иргэн, хуулийн этгээдээс гаргасан нэхэмжлэлээр захиргааны хэргийг хянан шийдвэрлэнэ гэсэн үг юм.

Шүүхээр эрхээ хамгаалуулахаар мэдүүлэх эрх нь энэ хуулиар тогтоосон журмаар хэрэгжинэ.

Шүүхэд нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд нь хэргийн ба шүүхийн харьяалал, нэхэмжлэл, гомдлын агуулга, хэлбэр болон нотлох баримт бүрдүүлэх зэрэг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохих журмыг баримтлах шаардлагатай. Энэ тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нь зөвхөн анхан шатны шүүхэд хандах замаар бус мөн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад үе шатанд /давж заалдах болон хяналтын шатанд/ нэгэн адил хэрэгжинэ.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.1.1 дэх хэсгийн "Хуульд тусгайлан заасан" гэдэг нь иргэн, хуулийн этгээд захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны хууль бус акт нь түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл урьдчилан шийдвэрлүүлэх ажиллагаагүйгээр нэхэмжлэлээ шүүхэд шууд гаргаж болохыг заажээ. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 26 хуульд маргаан бүхий захиргааны актын талаар шүүхэд нэхэмжлэлээ гаргах хугацааг тусгайлан заагаагүй байна. Энэ тохиолдолд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д зааснаар холбогдох захиргааны актыг хүлээн авснаас хойш эсвэл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэж ойлгох нь зүйтэй.

Хэрэв нэхэмжлэгч зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хугацааг хэтрүүлсэн нь тогтоогдвол шүүгч захирамж гарган түүнийг сэргээж болно. Ер нь шүүгч нэхэмжлэл гаргах хугацааг дууссан гэсэн шалтгаанаар нэхэмжлэлийн өргөдлийг хүлээн авахаас татгалзах эрхгүй. Учир нь нэхэмжлэл, гомдлын хөөн хэлэлцэх хугацааг тодорхойлохдоо хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн эсэхийг шалгаж, сэргээх боломжтой байдаг тул нэхэмжлэл, гомдлыг хүлээн авахаас шууд татгалзах боломжгүй юм.

Иргэн, хуулийн этгээдийн эрхийг хамгаалах талаарх нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх өөр журмыг хуулиар тогтоосон болно. Тухайлбал дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтнаас энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан журмын дагуу гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн гэдэг нь маргаан бүхий захиргааны акт хууль бус үйлдэл, эс үйлдлийн талаар дээд шатны байгууллага, албан тушаалтанд гаргасан гомдол, хүсэлтийг хянан үзээд гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд иргэн, хуулийн этгээд нь Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргана гэсэн үг юм. Энэ тохиолдолд маргааныг шүүхийн бус өөр байгууллагаар урьдчилан хянаж шийдвэрлэсний дараа уг шийдвэрийг эс зөвшөөрсөн бол нэхэмжлэгч шүүхэд гомдлоо гаргах эрхтэй бөгөөд шүүх нэхэмжлэгчийн гаргасан гомдлоор хэргийг хянан шийдвэрлэнэ гэсэн ойлголт юм.

Тухайлбал: Патентын тухай хуулийн 27 дугаар зүйлд шинэ бүтээл бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт шүүлт хийхтэй холбогдон гарсан гомдлыг Оюуны өмчийн газар 6 сарын дотор хянан шийдвэрлэж хариуг бичгээр мэдэгдэнэ. Уг шийдвэрийг эс

зөвшөөрвөл маргалдагч тал шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш гомдлоо 30 хоногийн дотор шүүхэд гаргах эрхтэй гэж заасан байна.

Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т захиргааны байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан журмын дагуу гаргасан шийдвэрийг биелүүлээгүй гэдэг нь хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх талаар доод шатны захиргааны байгууллага, албан тушаалтан ямар нэгэн үйл ажиллагаа явуулахгүй байхыг хэлнэ.

Захиргааны акт илт хууль бус болохыг нь дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан зөвшөөрөөд байхад уг актыг хэрэгжүүлэх эсвэл маргаан бүхий захиргааны акт нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөнийг тогтоож захиргааны актыг бүхэлд нь буюу холбогдох хэсгийг хүчингүй болгоод байхад үйл ажиллагаагаа зогсоохгүй үргэлжлүүлэн явуулсныг ойлговол зохино.

Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т заасан "Шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан гомдлыг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлээгүй" гэдгийг тухайн хуульд гомдол хянан шийдвэрлэх тусгайлсан хугацаа тогтоогоогүй бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасны дагуу Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан 30 хоног гэж ойлгоно.

Ер нь хуулиудад гомдол гаргах хугацааг өөр өөрөөр заасан байдгийг анхаарах нь зүйтэй юм. Жишээлбэл: Орон сууц хувьчлах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Сууц эзэмшигч нь сууц хувьчлахтай холбоотой гомдлыг орон сууц хувьчлах товчоонд гаргах ба уг гомдлыг 14 хоногийн дотор шийдвэрлэнэ", мөн хуулийн 2 дах хэсэгт "Сууц эзэмшигч орон сууц хувьчлах товчооны шийдвэрийг эс зөвшөөрвөл төрийн өмчийн хороонд гомдол гаргаж болно. Төрийн өмчийн хороо гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 20 хоногийн дотор хянан шийдвэрлэж хариуг өгнө" гэж заасан байна. Иймд захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан гомдлыг хүлээн аваад хуульд заасан хугацаанд буюу шүүхэд тусгайлан хугацаа заагаагүй бол 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж хариу өгөөгүй бол Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болно.

Хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан Харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан байхгүй тохиолдолд иргэн, хуулийн этгээд захиргааны байгууллага, албан тушаалтны гаргасан захиргааны хууль бус акт нь түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хүлээн авснаас эсвэл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор зөрчигдсэн эрхээ хамгаалуулахаар Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргана. Харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй гэдгийг захиргааны акт гаргаж байгаа эрх бүхий субъектийн харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтныг гэж ойлгоно. Орон нутагт харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй, биеэ дааж үйл ажиллагаа явуулдаг захиргааны байгууллага, албан тушаалтан байна. Тухайлбал аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний Тэргүүлэгчдийн дарга гэх мэт байж болох юм.

13 дугаар зүйл: Шүүхээс захиргааны хэрэг хянан шийдвэрлэх
ажиллагааны зарчим

13.1. Захиргааны хэргийн шүүх Захиргааны хэрэг хянан шийдвэрлэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 4-11 дүгээр зүйлд заасан зарчмыг баримтална.

ТАЙЛБАР

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдлөг болговол зохих зарчмууд нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үүсдэг бэрхшээл, төвөгтэй эрх зүйн хийдэл, салаа утгаар ойлгох тодорхойгүй асуудлыг үндэслэлтэй зөв шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмууд нь зөвхөн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар бус Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарчмуудаар зохицуулагддаг. /Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 4-11 дүгээр зүйл/

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмуудын нийтлэг ач холбогдол нь Захиргааны хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч иргэн, захиргааны байгууллагуудад адил тэгш эрхтэйгээр оролцох боломжийг бүрдүүлж өгдөг онцлогтой. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь дараах зарчмуудад үндэслэнэ.

1. Мөрдөн шалгах зарчим
2. Диспозитив зарчим
3. Мэдэгдэх ба сонсгох зарчим
4. Хууль ёсны зарчим
5. Тэгш байдлын зарчим
6. Мэтгэлцэх зарчим
7. Шүүх хуралдааныг амаар, шууд явуулах зарчим
8. Шүүх хуралдааныг тасралтгүй явуулах зарчим
9. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчим

1. Мөрдөн шалгах зарчим

Мөрдөн шалгах зарчмын агуулга нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэхэд чиглэгддэг. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 37 дугаар зүйлийн 37.2-т зааснаар хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг Захиргааны хэргийн шүүх хүлээдэг.

Мөрдөн шалгах зарчмаар хэргийн бүхий л байдлыг илрүүлж тогтооход чиглэгдэх бөгөөд энэ нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад энгийн шүүхийн үйл ажиллагаанаас ялгагдах онцлог зарчим юм. Захиргааны хэргийн нотлох баримтыг цуглуулах үүргийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд Захиргааны хэргийн шүүх гүйцэтгэхээр заасан нь оролцогч талуудад тэгш эрхтэйгээр

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлдэг. Нөгөө талаар шүүх талуудын гаргаж өгсөн нотлох баримтаар хязгаарлахгүйгээр шаардлагатай гэж үзсэн нотлох баримтыг холбогдох этгээдээс шаардан авах, энэхүү шаардлагыг биелүүлээгүй гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэх эрхтэй байгаа нь уг зарчмын хэрэгжих баталгаа болж өгдөг. Энэхүү зарчмыг нотлох баримтад дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хэрэгжүүлдэг.

Мөрдөн шалгах зарчим нь төрийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэхэд чиглэгддэг бөгөөд Захиргааны хэргийн шүүх өөрийн санаачилгаараа талууд санал, хүсэлт гаргаагүй байсан ч холбогдох нотлох баримтуудыг зохигчдоос шаардан гаргуулах, маргаан бүхий асуудлаар үзлэг хийх гэрчүүдийг дуудан мэдүүлэг авахаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нь дээрх зарчмыг хэрэгжүүлж байгаа хэрэг юм.

2. Диспозитив зарчим

Диспозитив зарчим гэдэг нь Захиргааны хэргийн шүүх хэрэг маргааныг зохигчдын гаргасан нэхэмжлэлийн үндсэн дээр буюу нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд шийдвэрлэхийг ойлгоно. Өөрөөр хэлбэл шүүх өөрийн санаачилгаар хэрэг үүсгэхгүй, зөвхөн нэхэмжлэл, өргөдөл гомдол, хүсэлтээр хэрэг үүсгэж, талуудын хүсэл зоригийн үндсэн дээр Захиргааны хэргийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагддаг.

Диспозитив зарчмын хүрээнд нэхэмжлэгч нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлэх, талууд эвлэрвэл шүүх уг маргааныг дуусгавар болгодог. Энэхүү зарчим нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 41, 42, 43 дугаар зүйлд зааснаар хангагдах учиртай.

3. Мэдэгдэх ба сонсгох зарчим

Энэ зарчим нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим боловч нөгөө талаар материаллаг эрх зүйн үндсэн зарчмын нэг байх бөгөөд хууль тогтоомжид тусгалаа олж хэрэгждэг. Мэдэгдэх ба сонсгох зарчмын гол агуулга нь:

1. Ямар нэгэн шаардлага тавигдаж байгаа этгээдэд уг шаардлагын гол зүйлийн талаар урьдчилан мэдэгдэх

2. Тэрхүү шаардлагын талаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг түүнд олгох явдалаар илэрхийлэгдэнэ. Өөрөөр хэлбэл мэдэгдэх ба сонсгох зарчим нь мэдэгдэх буюу мэдээлэл авах, өгөх, уг мэдэгдлийн талаар өөрийн байр суурийг илэрхийлэх түүний шийдвэрт хууль ёсоор нөлөөлөх боломж гэсэн 3 элементээс бүрддэг байна. Мэдэгдэх гэдгийг материаллаг эрх зүйн үүднээс авч үзвэл нийтийн захиргаа нь захиргааны акт батлан гаргасныхаа дараа бус харин батлан гаргахасаа өмнө эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдэд энэ тухай мэдэгдэж, түүнд өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах боломж олгохыг хэлнэ.⁶⁸

⁶⁸ А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”

Мэдэгдэх гэдэг нь процессын эрх зүйн үүднээс авч үзвэл оролцогчдыг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд урьж оролцуулахаар урьдчилан мэдэгдэхийг хэлдэг байна.

Сонсгох эрх нь захиргааны байгууллага, албан тушаалтны зүгээс тавьж байгаа шаардлагын талаар эрх ашиг нь хөндөгдөж буй этгээд өөрийн байр суурийг илэрхийлж эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах нөхцөл боломж юм. Өөрөөр хэлбэл захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нотлох баримт гаргаж өгөх, шүүхэд хүсэлт гаргах, шүүх хуралдаанд үг хэлэх зэргээр илэрдэг.

Захиргааны хэргийн оролцогч түүний өмгөөлөгч, төлөөлөгч нь нотлох баримт гаргаж өгөх, үнэлэхийг Захиргааны хэргийн шүүхээс шаардах эрх нь шүүхийн шийдвэрт хууль ёсоор нөлөөлөх боломж бөгөөд өөрийгөө сонсгох зарчмын хэрэгжих баталгаа нь болдог. Захиргааны хэргийн шүүх нь талуудаас нотлох баримт гаргуулсан болон шинжээчийн дүгнэлтийн талаар хэргийн оролцогчдоод мэдэгдэх ёстой. Талуудын хэлсэн санал хүсэлтийг шүүх шийдвэр гаргахдаа харгалзах ёстой байдаг. Эдгээр нь мэдэгдэх ба сонсгох зарчмын илэрхийлэл нь юм.

4. Хууль ёсны зарчим

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа нь хууль ёсны дагуу явагдах шаардлага тавигдахаас гадна Захиргааны хэргийн шүүх захиргааны байгууллага албан тушаалтны эрх зүйн акт, үйл ажиллагаа, хууль ёсны байх зарчим зөрчигдсөн эсэхийг анхаарах ёстой. Энэ зарчим нь захиргааны байгууллагад "хуулиар тусгайлан олгосон эрх" хуульд заасан "үндэслэл" "журам" "хэлбэр"-ийн шаардлага гэсэн ойлголтыг өөртөө агуулж байдаг. Өөрөөр хэлбэл захиргааны байгууллага, албан тушаалтны гаргасан эрх зүйн акт нь тэдэнд хуулиар тусгайлан олгосон эрх хэмжээнд нь багтсан эсэх, хууль тогтоомжид заасан үндэслэлтэй эсэх, хуульд заасан журам хэлбэрийг баримталсан эсэхийг шалгаж шийдвэрлэдгээр хэрэгждэг байна.

5. Тэгш байдлын зарчим

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд аль нэг тал нь давуу байр суурьтай оролцох боломжгүй юм. Тэгш байдлын зарчим нь:

-Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд талуудын эрхийг тэнцвэржүүлэх

-Шүүх төвийг сахих болон шударгаар асуудалд хандах үүргээр илэрч байдаг.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын аль нэг тал нь захиргааны байгууллага, албан тушаалтан байдаг учир тэдний эрхийг адил тэнцүү хангах нь чухал юм. Үүний тулд Захиргааны хэргийн шүүх юуны өмнө дэмжиж туслах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд шүүхэд гаргасан нэхэмжлэл нь хуульд заасан бүрдүүлбэрийн шаардлагыг хангаагүй бол нэхэмжлэгчид уг шаардлагыг хангах боломж олгох, оролцогч төлбөрийн чадваргүй болох нь тогтоогдвол түүнийг шүүхийн нөхөн төлөх зардлаас чөлөөлөх, нөхөн төлөх зардлын хэмжээг багасгах, буюу хойшуулах эсвэл хэсэгчлэн төлүүлж болдог. Энэ нь талуудыг тэнцвэржүүлсний үндсэн дээр өөрийгөө сонсгох боломжийг олгох зорилго бүхий юм. Шүүхийн төвийг сахих байр суурь

нь аль нэг талыг барихгүй байх аливаа асуудалд шүүх шударгаар хандах гэсэн агуулгатай юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт зааснаар иргэн шударга шүүхээр шүүлгэх эрхтэй бөгөөд Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдах нь төвийг сахих зарчмын агуулгыг илэрхийлнэ. Шүүгч хуульд заасан үндэслэлээр өөрөө татгалзан гарах нь тэгш байдлын зарчмыг хэрэгжүүлэх нэг хэлбэр юм. Хуульд заасан үндэслэлээр шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг татгалзан гаргах нь төвийг сахих зарчмын хүрээнд багтдаг байна.

6. Мэтгэлцэх зарчим

Энэ зарчим нь төвийг сахисан шийдвэр гаргагч /шүүх, шүүгч/ -ийн өмнө харилцан эсрэг сонирхол бүхий талууд өөр өөрсдийн байр суурийг өрсөлдөн нотлох хэлбэрээр илэрнэ. Мэтгэлцээний аль нэг тал байхгүй эсвэл талууд шүүхэд байр сууриа харилцан илэрхийлэх боломж нь тэнцүү хэмжээнд байж чадахгүй бол мэтгэлцэх зарчим зөрчигдөхөд хүрнэ. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэтгэлцэх зарчим нь хэрэг хянан шийдвэрлэхэд оролцогч талуудын тэгш эрхийн үндсэн дээр хэрэгждэг онцлогтой. Мэтгэлцэх зарчим нь ерөнхийдөө талууд болон тухайн хэрэгт оролцож байгаа бусад оролцогчоос шүүхийн өмнө тэдгээрийн шаардлага болон няцаалтын үндэс болсон нөхцөл байдлыг нотлохын тулд харилцан санал бодлоо илэрхийлэх маргааны хэлбэрээр явагдана. Мэтгэлцэх зарчим нь нийтлэг журмын дагуу захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэх, дуусгавар болгох зэрэг нь талуудын хүсэл зоригоос хамаарах бөгөөд энэ байдлыг шүүхийн зүгээс туйлын ховор тохиолдолд хязгаарлана. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч аль нэг тал нь ямагт захиргааны байгууллага, албан тушаалтан байдаг онцлогийг харгалзах шаардлагын үүднээс захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэтгэлцэх зарчим хэрэгжих онцлогтой. Өөрөөр хэлбэл иргэний болон бусад энгийн шүүхийн үйл ажиллагааны адилаар мэтгэлцэх зарчим нь бүрэн утгаараа төгс хэрэгжих боломжгүй байдаг. Учир нь Захиргааны хэргийн шүүх хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүрэгтэй байдаг тул хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэх явцад хэргийн оролцогчдын мэтгэлцэх эсэх талаарх байр суурийг үл харгалзан мэтгэлцэх буюу эсвэл зөвхөн мэтгэлцээний үр дүнг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгох нь Захиргааны хэргийн шүүх хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байгааг харуулах үзүүлэлт болно. Мэтгэлцэх зарчим нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөн шалгах зарчмын үйлчлэлээр хязгаарлагддаг.

7. Шүүх хуралдааныг амаар, шууд явуулах зарчим

Захиргааны хэргийн шүүх хуралдаан амаар явагдана. Шүүх хуралдааны бэлтгэл ажил бичгийн хэлбэрээр /нэхэмжлэл гаргах, хариуцагчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, шүүхийн мэдэгдэх хуудас/ явагддаг боловч шүүх хуралдаан хуралдахгүйгээр шийдвэр гаргах боломжгүй байдаг. Шүүх хуралдааныг нээх, ирц шалгаж танилцуулах, оролцогчдын эрх үүргийг нь тайлбарлаж өгөх, нотлох баримтыг шинжлэх, хэргийн

оролцогч өөрийгөө сонгох, хуралдаан даргалагч хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой хэлэлцүүлэх шүүхийн шийдвэрийг уншиж сонгох, шүүх хуралдааныг хаах зэрэг нь зөвхөн амаар явагдана. Шүүх хуралдааныг шууд явуулах гэдэг нь шүүх хуралдааны явцад хийгдэх нотолгооны ажиллагааг багтаасан ойлголт юм. Тухайлбал нотлох баримтыг шинжлэн судлах хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоох ажиллагаа хамаарах бөгөөд уг ажиллагааг шүүх хуралдааны үеэр хийгээгүй буюу дутуу хийсэн бол шүүх хуралдааныг шууд явуулах зарчим зөрчигдсэн гэж үзнэ.

8. Шүүх хуралдааныг тасралтгүй явуулах зарчим

Захиргааны хэргийн шүүх хуралдааныг өдрийн цагаар, амрах зайлшгүй шаардлагаас бусад цагт тасралтгүй явуулна. Захиргааны хэргийн шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч шүүх хуралдаанаар нэгэнт хэлэлцээд эхэлсэн хэргийг хянан шийдвэрлэж дуусах буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулах, түдгэлзүүлэх хүртэл өөр хэргийг хянан шийдвэрлэх эрхгүй байдгаар уг зарчим хэрэгжинэ. Шүүх хуралдааныг тасралтгүй явуулах зарчмын ач холбогдол нь шүүх, шүүгчийн анхаарлыг нэг хэрэгт төвлөрүүлж дотоод итгэлийг нь бүрдэхэд нөлөөлөх бүх нөхцөлүүдийг хангахад чиглэгддэг. Энэхүү байдлаараа уг зарчим нь шүүхийн анхаарлаа төвлөрүүлэх зарчимтай шууд уялдаатай хэрэгждэг.

9. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчим

Энэхүү зарчим нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад зарчмуудтай нягт уялдаатай хэрэгждэг онцлогтой юм. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчмын хууль зүйн үндэслэл нь Үндсэн хуулийн 54 дүгээр зүйлд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэнэ гэсэн заалт юм. Шүүх хуралдаан нээлттэй явагдах зарчмын дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ч шүүх хуралдаанд сууж, энэ талаар олон нийтэд мэдээлэх боломжтой байдаг. Гэхдээ шүүх хуралдаан нээлттэй явагдах зарчим нь зарим тохиолдолд хэрэгжүүлэх боломжгүй байх явдал гардаг. Тухайлбал хэргийн үйл баримт эсвэл үйл явдал, төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах бол хэргийн оролцогчдын хүсэлтээр шүүх хуралдааныг хаалттай явуулж болдог.

Шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчим нь олон нийтийг мэдээлмээр хангах зорилгыг агуулдаггүй харин шүүх хуралдааныг хуульд заасан нөхцөл журмын дагуу явуулах зохигчдын эрх тэгш байдлыг хангахад оршино.

Ийнхүү шүүх хуралдааныг нээлттэй явуулах нь шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд ил тод нээлттэй байхаас гадна тэднээс шүүхийн үйл ажиллагаанд хяналт тавих нэг арга хэрэгслэл болдог байна.

Захиргааны хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод нээлттэй байдал нь шүүх хуралдааныг сонирхсон хөндлөнгийн этгээдүүдийг шүүх хуралдааны танхимд чөлөөтэй оруулах эрхээр хангасан байх, өөрөөр хэлбэл захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид бус этгээдүүд шүүх хуралдааныг сонирхох байдлаар илэрнэ.

Шүүх хуралдааны нээлттэй ажиллагааны явцыг сонирхсон этгээдүүдэд бичиж тэмдэглэх мөн техник хэрэгсэл ашиглахыг шүүгч зөвшөөрч болно. Фото зураг авах, видео бичлэг хийх, шүүх хуралдааныг радио, телевизээр нэвтрүүлэг хийх эрхийг зөвхөн шүүхийн зөвшөөрлөөр олгох боловч энэ үйл ажиллагаа нь шүүх хуралдааныг хэвийн явуулахад сөрөг нөлөө үзүүлэхгүй байх төдийгүй шүүхийг хүндэтгэх, шүүх хуралдааны танхимд тогтоосон журмыг сахих, хуралдаан даргалагчийн шийдвэрт захирагдах зэрэг зарчимд нийцсэн байх учиртай.

14 дүгээр зүйл: Захиргааны хэргийн нутаг дэвсгэрийн харьяалал

14.1. Нэхэмжлэлийг тухайн шийдвэр гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтны оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүхэд гаргана.

ТАЙЛБАР

Тухайн маргааныг шийдвэрлүүлэхээр хариуцагчийн оршин байгаа газрын шүүхэд хандах зохицуулалтыг *захиргааны хэргийн нутаг дэвсгэрийн харьяалал* гэж үздэг.

Өөрөөр хэлбэл нутаг дэвсгэрийн харьяалал гэдгийг анхны шийдвэр гаргасан захиргааны байгууллага албан тушаалтны үйл ажиллагаа явуулж байгаа газрын Захиргааны хэргийн шүүхэд хамаарна гэж ойлговол зохино.

Захиргааны байгууллага албан тушаалтны оршин байгаа газар гэдгийг хариуцагч болох захиргааны байгууллага албан тушаалтны байнга оршин суудаг буюу үйл ажиллагаагаа явуулж буй газрыг хэлнэ.

Захиргааны хэргийн шүүхийн нутаг дэвсгэрийн харьяалал гэдэгт тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүхэлдээ хамаарна.

Тухайлбал: Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт байнга оршин, үйл ажиллагаагаа явуулдаг захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны хууль бус акттай холбоотой маргаан нь бүхэлдээ тус аймгийн захиргааны хэргийн шүүхэд харьяалагдана.

Тайлбарлаж буй асуудлаар:

1. Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэн болон дээд шатны захиргааны байгууллагын эс үйлдхүйн улмаас уг ажиллагаа явагдаагүй бол захиргааны маргааны харьяаллын тухайд нэхэмжлэлийн зүйл нь анх маргаан үүсгэсэн захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр байх уу? эсхүл хэргийг урьдчилан шийдвэрлэсэн дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр болон эс үйлдхүй байх уу гэдэг асуудал гарч ирдэг. Энэ тохиолдолд нэхэмжлэлийн шаардлагаа хэрхэн тодорхойлох нь нэхэмжлэгчийн эрх байдаг боловч анхны шийдвэр гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэрийн харьяалмаар хэргийг шийдвэрлэж байгаа одоогийн практик буруу биш юм.

Жишээ нь: Өмнөговь аймгийн Орон сууц хувьчлах товчооны шийдвэрийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг Өмнөговь аймгийн Захиргааны хэргийн шүүхэд л гаргахаас биш уг шийдвэрийн талаарх гомдол хүсэлтийг Орон сууц хувьчлах тухай

хуульд зааснаар урьдчилан шийдвэрлэсэн Төрийн өмчийн хорооны байнга оршин байгаа буюу байнгын үйл ажиллагаагаа явуулж байгаа газрын шүүх болох Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхэд гаргахгүй юм.

Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн 2005 оны 2/02 тоот дүгнэлтийн дагуу Улсын Их Хурал хууль гаргаж Засгийн газрыг Захиргааны хэргийн шүүхийн хяналтаас гаргасны улмаас төрийн захиргааны төв байгууллага, түүний удирдлагын гаргасан захиргааны акттай холбоотой гомдлыг засгийн газраас хянан үзээд иргэн, хуулийн этгээдийн гомдлын шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн иргэнээс Захиргааны хэргийн шүүхэд хандаж гаргасан нэхэмжлэл нь Захиргааны хэргийн шүүхэд харьяалагдах эсэх нь тодорхойгүй байгаа юм.

Энэ тохиолдолд нэг талаас шүүхэд хандах эрхийн тухай асуудал хөндөгдөж байгаа бол, нөгөө талаас үүргийг хязгаарласан хуулийн зохицуулалт байгаа эсэхийг анхаарах шаардлагатай болж байгаа юм.

Ер нь нийтийн засгийн хууль бус шийдвэрийн талаар шүүхэд хандах иргэний эрхийг ямар нэг хэлбэрээр хязгаарлаж хасах нь үндсэн хуулиар боломжгүй тул энэ нь хууль бус үйлдэл юм.

Иймд Засгийн газрын гишүүн, Сайдын шийдвэртэй холбоотой маргааныг Засгийн газраас хянан үзээд хэвээр үлдээвэл иргэн хуулийн этгээд тухайн хууль бус гэж үзэж буй анхны шийдвэрийн талаар Захиргааны хэргийн шүүхэд хандах эрх нь нээлттэй байна гэсэн үг юм. Учир нь Засгийн газрыг Захиргааны хэргийн шүүхийн хяналтаас гаргасан явдал нь Засгийн газрын гишүүн, сайд, яамны шийдвэрийн талаар шүүхэд гомдол гаргах иргэний эрхийг нь хязгаарлах үндэслэл болохгүй юм.

Энэ талаар хуулийн 4.1.1-4.1.3-ын тайлбараас үзнэ үү.

15 дугаар зүйл: Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал

- 15.1. Аймаг, нийслэлийн Захиргааны хэргийн шүүх энэ хуульд заасны дагуу үүсгэсэн захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.
- 15.2. Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим захиргааны хэргийг дараах журмаар хянан шийдвэрлэнэ.
 - 15.2.1. Аймаг, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүх анхан шатны журмаар шийдвэрлэсэн хэргийг давж заалдах шатны;
 - 15.2.2. Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн болон анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэртэй хэргийг хяналтын шатны;
- 15.3. Монгол Улсын Дээд шүүх шаардлагатай гэж үзвэл ямар ч хэргийг татан авч анхан шатны журмаар хянан шийдвэрлэх эрхтэй.

ТАЙЛБАР

Тухайн захиргааны хэрэг аль шатны Захиргааны хэргийн шүүхэд харьяалагдахыг хуулиар зохицуулж өгснийг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал гэнэ.

Өөрөөр хэлбэл анхан болон давж заалдах, хяналтын шатны Захиргааны хэргийн шүүхийн алинд харьяалагдах нь шүүхийн харьяалал болно.

Тайлбарлаж буй Захиргааны хэргийг Хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлд захиргааны хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн ердийн харьяаллыг дараах байдлаар тодорхойлсон байна.

1. Аймаг, нийслэлийн Захиргааны хэргийн шүүх энэ хуульд заасны дагуу үүсгэсэн захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.
2. Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим аймаг, нийслэлийн Захиргааны хэргийн шүүх анхан шатны журмаар шийдвэрлэсэн захиргааны хэргийг давж заалдах шатны журмаар, мөн аймаг, нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн анхан шатны журмаар шийдвэрлэсэн болон Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны журмаар шийдвэрлэсэн хэргийг хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэхээр заажээ.

Энэ нь Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим нэг талаас давж заалдах шатны шүүхийн харьяаллаар анхан шатны Захиргааны хэргийн шүүхийн шийдвэртэй хэргийг хянаж байгаа боловч нөгөө талаар анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалтай хэргийг хяналтын шатны шүүхийн харьяаллаар хянаж байгаа хэрэг юм.

Түүнчлэн нэхэмжлэгч, хариуцагч талын аль нэг, эсхүл хамтран нэхэмжлэгч буюу хамтран хариуцагчийн аль нэг нь давж заалдах гомдол гаргасан байхад нөгөө нь хяналтын журмаар гомдол гаргасан тохиолдолд давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэнэ.

Анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийг шууд Улсын Дээд шүүхийн хяналтын шатанд хянуулж болохоор Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан боловч энэ нь хэргийн оролцогч талуудын эрхийг шүүхийн бүхэл бүтэн нэг шатаар хохироож байгаа хэрэг юм.

Ер нь хэргийг давж заалдах шатны журмаар хянах, хяналтын шатны журмаар хянах үйл ажиллагаа нь хуульд зааснаар өөр өөр зохицуулалттай байдаг учир Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бүрэн дүүрэн хангах үүднээс аль болохоор хуульд заасны дагуу шүүхийн харьяаллыг анхаарч ажиллах нь чухал юм.

Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал бол ерөнхий харьяалал юм. Харин Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхүүдийн хооронд хэрэг шилжүүлэх тухай асуудлыг Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн шийдвэрлэж харьяалал тогтоож байхаар хуульд заажээ.

Энэ талаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн тайлбараас үзнэ үү.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн онцгой харьяаллыг зааж өгчээ.

Монгол Улсын Дээд шүүх шаардлагатай гэж үзвэл ямар ч хэргийг татан авч анхан шатны журмаар хянан шийдвэрлэх эрхтэй.

Харин ямар үндэслэлээр Улсын Дээд шүүх захиргааны хэргийг татан авч анхан шатны журмаар хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой зохицуулаагүй байгаа юм.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хэргийн оролцогч

16 дугаар зүйл. Хэргийн оролцогчдын бүрэлдэхүүн

- 16.1. Нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийг хэргийн оролцогч гэнэ.
- 16.2. Нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь захиргааны хэргийн бие даасан оролцогч бус зөвхөн төлөөлүүлж буюу өмгөөлүүлж байгаа этгээдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалж буй этгээд мөн.

ТАЙЛБАР

1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх журмын дагуу шүүхэд гаргасан нэхэмжлэлийг үндэслэн шүүгчээс захиргааны хэрэг үүсгэсэн, хариуцагч талд тодорхой шаардлага тавьж байгаа нэхэмжлэгч болон

- тухайн маргаж буй захиргааны актыг гаргасан хариуцагч түүнчлэн
- захиргааны хэргийн шүүхээс уг захиргааны хэргийг шийдвэрлэхэд оролцуулах нь зүйтэй гэж үзсэн гуравдагч этгээд тус тус хэргийн оролцогч юм.
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмыг хангах зорилгоор оролцож буй нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн төлөөлөгч болон эрх зүйн туслалцаа үзүүлж байгаа өмгөөлөгч хэргийн оролцогчдын бүрэлдэхүүнд ордоггүй. Эдгээр нь нэхэмжлэгч хариуцагчийн хоорондын эрх зүйн харилцаанд оролцдоггүй бөгөөд харин тэдний төлөө буюу оролцогчдын эрхийг өмнөөс нь хэрэгжүүлдэг.

1.1. Нэхэмжлэгч гэж захиргааны хууль бус актын улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж, эрхээ сэргээлгэхээр Захиргааны хэргийн шүүхэд хандсан иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.

Нэхэмжлэгч “иргэн” гэдэгт захиргааны эрх зүйн харилцаанд оролцогч Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ойлгоно. Гадаад улсын харьяат мөн болохыг гэрчилсэн хууль ёсны нотолгоотой хүнийг гадаадын иргэн гэнэ.⁶⁹ Харин харьяалалгүй хүн гэж аль нэг улсын нутаг дэвсгэрт түр болон байнга оршин сууж буй тухайн улсын хийгээд өөр ямар нэг улсын харьяат болохыг гэрчлэх бичиг баримтгүй хүн юм.

Иргэн өөрийн наснаас үл шалтгаалан нэхэмжлэгч байж болох бөгөөд хэрвээ газрын өмчлөгч мөн бол нярай хүүхэд түүнчлэн бусдын адилаар эрх эдэлж, үүрэг хүлээж буй сэтгэцийн согогтой этгээд ч мөн адил нэхэмжлэгч байж болно.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар /цаашид ЗХХШТХ гэх/ захиргааны байгууллага, албан тушаалтан /төрийн жинхэнэ албан хаагч/ нь захиргааныхаа эсрэг Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах боломжгүй байна. Энэ субъект “иргэн” гэх томъёололд эрх зүйн чадамжийн хувьд бүрэн утгаар дүйхгүй бөгөөд тэдгээрийн эрх, үүрэг нь хууль тогтоомжоор тусгайлан тогтоогддог. *Жишээ нь:*

⁶⁹ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйл.

Хүнсний үйлдвэр, үйлчилгээний хяналтын улсын байцаагчийн гаргасан “захиргааны шийтгэл ногдуулах тухай” шийдвэрийг улсын ахлах байцаагч хүчингүй болговол улсын байцаагч уг шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй байна. Энэ тохиолдолд улсын байцаагч иргэний нэгэн адил шүүхэд хандан нэхэмжлэл гаргах эрх хэмжээгүй. Учир нь түүний объектив эрхийг хууль тогтоомжоор тусгайлан заажээ.

Харин улсын байцаагчийг ажлаас халбал түүний субъектив эрх хөндөгдөж байх тул энэ тохиолдолд тэрээр “иргэн” гэх томъёололд бүрэн багтан орж өөрийн зөрчигдсэн эрхээ хамгаалуулахаар Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байна.

Нэхэмжлэгч “хуулийн этгээд”-ийн хувьд хувийн эрх зүйн хуулийн этгээд байх бөгөөд:

- өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй
- өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг
- үйл ажиллагаанаасаа бий болсон үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг
- нэхэмжлэгч, хариуцагч байж чадах
- тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг
- Зохион байгуулалтын нэгдлийг хэлнэ.⁷⁰

Нэхэмжлэгч нь захиргааны байгууллага албан тушаалтанд өргөдөл, хүсэлт гаргасан буюу захиргааны актын үйлчлэл чиглэгдсэн этгээд байхаас гадна захиргааны тухайн шийдвэр гаргах ажиллагаанд оролцоогүй этгээд ч байж болдог. Тухайлбал: Захиргаа хэн нэгэн этгээдэд эрх олгосон акт /барилга, байгууламж барих эрх олгох, аж ахуйн үйл ажиллагаа явуулах гэх мэт/ гаргаснаар гуравдагч этгээд эсхүл хөршийн этгээдийн эрх ашигт нөлөөлдөг. Энэ тохиолдолд эдгээр субъект нь нэхэмжлэгч болж тухайн актыг эсэргүүцэж нэхэмжлэл гаргаж болно.

Жишээ нь: Нийслэлийн Засаг дарга А нийтийн эзэмшлийн 2 орон сууцны хоорондох газрыг үйлчилгээний барилга барих зориулалтаар “Б” компанид эзэмшүүлэх шийдвэр гаргажээ. “Б” компанийн барилга, “С” орон сууцны байшинд амьдардаг 8 айлын цонхыг бүрэн таглаж тухайн айлууд байгалийн гэрэл үзэхгүй болж хохирсон байна. Оршин суугчид “цонх хааж шинээр барьсан барилга нь амьдрах нөхцөл, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна” гэж нэхэмжлэл гаргажээ.

Нийслэлийн Засаг даргын “Б” компанид газар эзэмшүүлсэн, барилга барих зөвшөөрөл олгосон шийдвэрийг гаргахад “С” орон сууцны байшинд оршин суугчид оролцоогүй боловч тухайн захиргааны актын улмаас иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн учраас тэдгээр нь Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэгч болжээ.

1.2. Захиргааны хууль бус акт гаргаж өөрийнх нь эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэж нэхэмжлэлд дурьдсан захиргааны байгууллага, албан тушаалтан захиргааны хэргийн хариуцагч байна. Тухайн этгээд хариуцлага хүлээх ёстой эсэхийг хэрэг хянан хэлэлцсэний эцэст шүүх шийдвэрлэдэг учир нэхэмжлэлийг шүүх хүлээн авч, захиргааны хэрэг үүсгэхдээ нэхэмжлэлд дурьдсан, нэхэмжлэгчийн заасан этгээдийг хариуцагчаар оролцуулна. Гэтэл нэхэмжлэгчийн сонгож авсан этгээдийг биш харин шүүх өөрийн санаачлагаар эсхүл хариуцагчаар татагдсан этгээдийн хүсэлтээр өөр хариуцагчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд

⁷⁰ Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг

оролцуулах алдаа шүүхийн практикт цөөнгүй гардаг. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, журмыг зөрчиж буй ноцтой алдаа юм.

ЗХХШТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1-д хариуцагч байж болох захиргааны байгууллага, албан тушаалтныг жагсаасан байна.

Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газар;⁷¹
 2. Монгол Улсын Засгийн газрын гишүүн /Ерөнхий сайд, сайд/;
 3. Монгол Улсын яам;
 4. Монгол Улсын Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг;
 5. Төрийн албаны Зөвлөл, түүний салбар байгууллага;
 6. Сонгуулийн ерөнхий хороо;⁷²
 7. Монголбанк;
 8. Санхүүгийн зохицуулах хороо;
- /Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*
9. яамны харьяа болон харьяа бус захиргааны акт гаргадаг бие даасан агентлаг, түүнтэй адилтгах газар, зөвлөл, товчоо, төв, сан зэрэг байгууллага;
 10. аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга;
 11. аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг /хэлтэс, газар/;
 12. улсын хяналт шалгалтын болон захиргааны хяналтын байгууллага, тэдгээрийн хянан шалгагч, байцаагч, цагдаагийн, тагнуулын, хилийн цэргийн байгууллага, түүний захиргааны таслан зогсоох болон шийтгэлийн арга хэмжээ авах эрх бүхий бүх албан тушаалтан;
 13. аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн нийтийн Хурал, тэдгээрийн Тэргүүлэгчид;
 14. төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг болон холбоо, харилцаа, эрчим хүчний системийн захиргаа зэрэг үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг байгууллага;
 15. сүм хийдийн захиргаа;
 16. шийдвэр, үйл ажиллагааг нь захиргааны хэргийн шүүхэд давж гомдол гаргаж байхаар хуульд тусгайлан заасан нийтийн эрх зүйн субъект болох бусад байгууллага, албан тушаалтан.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчаар “захиргааны байгууллага” болон “албан тушаалтан” гэсэн хоёр субъект оролцдог. Хэрэв хариуцагчаар захиргааны байгууллагыг заасан бол шүүх уг байгууллагад холбогдуулж захиргааны хэрэг үүсгэх ба харин байгууллагыг төлөөлөх албан тушаалтныг итгэмжлэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна.

Байгууллагын удирдлага нь тухайн байгууллагын эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргаж, түүнийгээ дээд шатны байгууллагын өмнө хариуцдаг тул нэхэмжлэлд заасан

⁷¹ Энэ заалтыг Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 202 дүгнэлт, Улсын Их Хурлын 2005 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон.

⁷² Энэ заалтыг мөн адил хүчингүй болгосон.

маргаан бүхий захиргааны актыг ёсчлон гаргасан байгууллагын дарга нь албан тушаалтны хувиар биш захиргааны байгууллагын нэрийн өмнөөс оролцоно гэж ойлгоно.

Харин төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой болон салбарын хуулиудаар бие дааж шийдвэр гаргах эрхийг зохицуулсан тохиолдолд байгууллагын удирдлага, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь захиргааны албан тушаалтны хувиар хариуцагч болдог.

1.3.Тухайн захиргааны хэргийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн болон зөрчигдөх боломжтой иргэн, хуулийн этгээдийг гуравдагч этгээдээр татан оролцуулж болдог. Ингэхдээ хүсэлт гаргаснаар эсхүл шүүх өөрийн санаачлагаар татан оролцуулна. Маргааны зүйлийн талаар нэхэмжлэгч, хариуцагчаас өөр этгээд шаардлага гаргах тохиолдол байдаг бөгөөд түүнийг бие даасан шаардлагатай гуравдагч этгээд гэж нэрлэжээ. Иймд шүүх бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах эсэхийг шийдвэрлэхгүй, харин тэрээр ийм шаардлага гаргасан тул хэргийн оролцогч болохыг баталж шүүгчийн захирамж гаргах ба түүний шаардлагыг нэхэмжлэгч, хариуцагч нарт гардуулах, танилцуулах ажиллагааг хийнэ. Хэрэв захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр гуравдагч этгээдийн хувьд эрх зүйн үр дагавартай байхаар өөрөөр хэлбэл эцсийн шийдвэр нь нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн хувьд зөвхөн зэрэг гарахаар бол түүнийг оролцуулах зайлшгүй шаардлага үүсдэг. Тухайлбал: Барилгын зөвшөөрлийг хүчингүй болгуулахаар хөршөөс нэхэмжлэл гаргасан бол тухайн барилгыг бариулж байгаа этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр татан оролцуулах шаардлагатай. Татан оролцуулбал зохих гуравдагч этгээдийг татан оролцуулаагүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд алдаа гарсан гэж үзэх бөгөөд шүүхийн шийдвэр нь материаллаг эрхийн хувьд хүчин төгөлдөр бус юм.

Гуравдагч этгээдийн эрх зүйн байдал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх, үүргийг хуулийн 21 дүгээр зүйлд тусгасан байна.

/Хуулийн 21 дүгээр зүйлийн тайлбарыг үзнэ үү/

2.Нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тодорхой ашиг сонирхлын үүднээс өөрийн нэрийн өмнөөс оролцдог бол тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь төлөөлүүлж байгаа этгээдээс олгосон итгэмжлэл болон хууль зүйн туслалцаа авч байгаа талын хүсэлтээр бусдын ашиг сонирхлыг хамгаалж оролцдог. Тийм ч учраас хуульд нэхэмжлэгч, хариуцагчийн эрх, үүрэг, төлөөлөгч болон өмгөөлөгчийн бүрэн эрхийг тус тусад нь зохицуулжээ.

Иргэний хэргийн нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эдлэх зарим эрхийг төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлээр хязгаарласнаас бусад тохиолдолд бүрэн эдэлдэг бол захиргааны хэргийн хувьд итгэмжлэлд заавал тусгайлан заахыг шаарддаг.

Мөн төлөөлөгч, өмгөөлөгчийн эрх зүйн байдал нь өөр юм. Хууль зүйн дээд боловсролтой, ял шийтгэлгүй, тогтоосон журмын дагуу мэргэжлийн шалгаруулалтад

орж, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан иргэнийг өмгөөлөгч гэнэ⁷³.

Харин төлөөлөгч нь иргэний эрх зүйн чадамжтай л бол заавал хуульч байхыг шаардахгүй бөгөөд тухайн маргаантай зүйлийн асуудлаар мэргэшсэн юм уу ямар ч иргэн байж болно. Иймээс өмгөөлөгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгчөөр оролцохоосоо илүү өмгөөлөгчөөр оролцож бүрэн эрхээ хэрэгжүүлэх нь зохимжтой.

17 дугаар зүйл. Хэргийн оролцогчийн иргэний эрх зүйн чадвар

- 17.1. Захиргааны хэргийг Захиргааны хэргийн шүүхэд хянан шийдвэрлэхэд иргэн, хуулийн этгээд оролцох эрхтэй.
- 17.2. Хуулийн этгээдийн эрхгүй боловч тухайн захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай холбоо, сан зэрэг нэгтгэлийг шүүгч захирамж гаргаж уг захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулж болно.

ТАЙЛБАР

1.Иргэний эрх зүйн чадвар гэж эрх эдэлж, үүрэг хүлээх чадвар юм. Хүн бүр иргэний эрх зүйн чадвартай байх бөгөөд энэ нь түүний төрсөн үеэс эхэлж, нас барснаар дуусгавар болно.

Иргэний эрх зүйн чадварыг хязгаарлахыг хуулиар хориглосон байдаг. Харин хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсэж хуульд заасан журмын дагуу татан буугдаж, бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно.

Энд яригдаж буй хуулийн этгээдэд хувийн эрх зүйн болон нийтийн эрх зүйн хуулийн этгээд адил хамаарч байна. Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэж, бүртгэлээс хасах журмыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай 2003 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар тогтоожээ.

Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадварыг гагцхүү хуульд заасан үндэслэл, журмаар хязгаарлана. Тухайлбал: Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд зааснаар шударга өрсөлдөөнд харш үйл ажиллагааг хориглох, хязгаарлах, таслан зогсоох зэргээр хуулийн этгээдийн эрх зүйн чадварыг хязгаарласан байна.

2.Энэ зүйлд заасан холбоо, сан зэрэг нэгтгэлийг ЗХХШТХ-ийн 16.1, 21 дүгээр зүйлд заасан гуравдагч этгээд гэж үзэж болохгүй. Эдгээр нэгтгэлийг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мэдлэг нь шаардлагатай гэж шүүхээс үзсэн байгууллагууд гэж ойлгох хэрэгтэй. Шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж буй нэгтгэлийн эрх энэ тохиолдолд зөрчигдсэн байх шаардлагагүй. Өөрөөр хэлбэл шүүгчээс захирамж гаргах замаар тухайн нэгтгэлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахаар гаргасныг эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэр гэж үзнэ. Хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогч нь иймд захирамж гаргах тухай

⁷³ 2002.05.16 өдөр батлагдсан Өмгөөллийн тухай хууль.

саналыг шүүгчид гаргаж болох ч шүүгчийн хувьд үүнийг заавал биелүүлэх албагүй. Холбоо, сан зэрэг нэгтгэл нь Монгол Улсын Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 26-28 дугаар зүйлүүдэд заасан хуулийн этгээдийг тодорхойлж буй шинжүүдийг агуулаагүй байх⁷⁴ бөгөөд нийтийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэх зорилготой, хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан нэгтгэл юм.

Хуулийн этгээдийн эрхгүй холбоо, сан зэрэг нэгтгэлийн иргэний эрх зүйн чадвар нь байгуулагдсанаар үүсч, татан буугдсанаар дуусгавар болно. Холбоо, санг үүсгэн байгуулах баримт бичигт зааснаар түүний удирдлага төлөөлнө.

18 дугаар зүйл. Хэргийн оролцогчийн иргэний эрх зүйн чадамж

- 18.1. Шүүхэд захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр заагдсан эрхээ өөрөө хэрэгжүүлж үүргээ биелүүлэх, хариуцлага хүлээх буюу төлөөлөгчөөрөө гүйцэтгүүлэх чадварыг иргэний эрх зүйн бүрэн чадамжтай этгээд эдэлнэ.
- 18.2. Иргэний эрх зүйн зарим чадамжтай, эсхүл сэтгэцийн өвчний, мансууруулах бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч төлөөлөн хамгаална.
- 18.3. 16-18 хүртэлх насны иргэн өөрөө хүсвэл түүний эцэг, эх, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр захиргааны хэргийн шүүхэд биечлэн оролцох эрхтэй.

ТАЙЛБАР

1. Шүүхэд захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр заагдсан эрхээ өөрөө хэрэгжүүлж, үүргээ биелүүлэх, хариуцлага хүлээх буюу төлөөлөгчөөрөө гүйцэтгүүлэх чадварыг иргэний эрх зүйн бүрэн чадамжтай буюу 18 насанд хүрсэн иргэн эдэлнэ.

Төлөөлөгчөөрөө гүйцэтгүүлэх чадвар гэдэгт эрх зүйн чадамжтай этгээдийг сайн дурын буюу гэрээний үндсэн дээр бусдаар төлөөлүүлэх хэлбэр орох ба харин эрх зүйн чадамжгүй эсхүл зарим буюу бүрэн бус чадамжтай этгээдийн хууль ёсны төлөөлөл үүнд хамаарахгүй юм.

2.7-оос 14 хүртэлх насны хүнийг иргэний эрх зүйн зарим чадамжтай гэж үздэг ба өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх, ахуйн чанартай жижиг хэлцлийг хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр хийж болдог.

Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож, түүнд асран хамгаалалт тогтоодог. Иргэний эрх зүйн зарим чадамжтай, мөн сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон этгээд нь шүүхэд эрхээ өөрөө хэрэгжүүлэх чадваргүй тул түүний зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эцэг, эх, асран хамгаалагч нь төлөөлөн хамгаална.

⁷⁴ 2002.01.10 өдөр батлагдсан Монгол Улсын Иргэний хууль.

Мансууруулах бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдэг иргэнийг эрх зүйн чадамжгүй гэж тооцдоггүй. Харин мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэж, гэр бүлээ эдийн засгийн талаар хүнд байдалд оруулсан насанд хүрсэн этгээдийн иргэний эрх зүйн чадамжийг шүүх сонирхогч этгээдийн хүсэлтээр хуулиар тогтоосон журмаар хязгаарлаж, харгалзан дэмжигч томилж болдог. Иймээс энэ зүйлд заасан мансууруулах бодис согтууруулах ундаа байнга хэрэглэдэг боловч иргэний эрх зүйн чадамжийг нь шүүх хязгаарлаагүй этгээд нь захиргааны актын улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд өөрөө биечлэн болон сайн дурын үндсэн дээр төлөөлөгчөөрөө дамжуулан эрхээ хэрэгжүүлэх боломжтой.

Харин мансууруулах бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас иргэний эрх зүйн чадамж нь хязгаарлагдсан этгээд нь хязгаарлагдаагүй чадамжийнхаа хүрээнд эрхээ хэрэгжүүлж болно.

3. Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай байна. Эдгээр иргэд Иргэний хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т заасан тохиолдолд эрхээ бие даан хэрэгжүүлдэг. Шүүх бүрэн бус чадамжтай буюу 16-аас 18 хүртэлх насны иргэнийг өөрийнх нь хүсэлт, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийнх нь зөвшөөрлөөр иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцож болдог. Ингэж тооцогдсон 16-аас 18 хүртэлх насны иргэн зөрчигдсэн эрхээ шүүхэд өөрөө биечлэн болон төлөөлөгчөөрөө дамжуулан хамгаалах эрхтэй.

Харин шүүхээс хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцогдоогүй боловч 16-18 хүртэлх насны иргэн өөрөө хүсвэл түүний эцэг, эх, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даан оролцож болно. Энэ тохиолдолд шүүх дээрх этгээдийн хүсэлт болон эцэг, эх, харгалзан дэмжигчийн зөвшөөрлийг зайлшгүй бичгээр гаргуулан авах ёстой бөгөөд тэдгээр нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн нэрийн өмнөөс оролцож, хэргийн оролцогчийн эрх, үүргийг эдэлнэ гэсэн үг юм. Энэ насны оролцогч этгээд нь зарчмын хувьд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох чадвартай байдаг тул шүүхийн зүгээс тухайн этгээдийн эцэг эх, асран хамгаалагч нарт насанд хүрээгүй этгээдийн хүсэлтийг харгалзахыг санал болгох нь зүйтэй.

19 дүгээр зүйл. Нэхэмжлэгчийн эрх, үүрэг

19.1. Нэхэмжлэгч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараах эрх эдэлнэ:

19.1.1. нэхэмжлэлээ өөрчлөх, түүний шаардлагын хэмжээг ихэсгэх буюу багасгах, нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагчтай эвлэрэх;

19.1.2. захиргааны хэргийн шүүхийн болон эсрэг талын шаардлага, тайлбар, нотлох баримт, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл, хуулбар хийх, тэдгээрт тайлбар өгөх, шүүх хуралдаанд оролцох;

- 19.1.3. нотлох баримт гаргаж өгөх, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, бусад нотлох баримт цуглуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах;
 - 19.1.4. шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, прокурор, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг хуульд заасан үндэслэлээр татгалзан гаргахыг шаардах;
 - 19.1.5. шүүх хуралдааны бусад оролцогчид асуулт тавих;
 - 19.1.6. захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргах;
 - 19.1.7. хуульд заасан бусад эрх.
- 19.2. Нэхэмжлэгч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараахь үүрэг хүлээнэ:
- 19.2.1. захиргааны хэргийн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх;
 - 19.2.2. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих;
 - 19.2.3. захиргааны хэргийн шүүхийн тавьсан шаардлага, шийдвэрийг биелүүлэх.

ТАЙЛБАР

1.1.Энэ хэсэгт нэхэмжлэгчийн үндсэн эрхийг жагсаасан байна.

Нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагыг тухайн хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцүүлэх тухай шүүгчийн захирамж гаргах аас өмнө өөрчлөх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд өөрчлөгдсөн нэхэмжлэлийг хариуцагчид танилцуулах, тайлбар авах, нотлох баримт цуглуулах зэрэг шүүгчээс хийх ажиллагаа шинээр эхэлнэ.

Нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг ихэсгэх эрх анхан шатны шүүхийн аль ч шатанд хэрэгжих боломжтой бөгөөд хариуцагчид нэхэмжлэлийн хувийг гардуулах, хариу тайлбар авах зэрэг ажиллагааг журмын дагуу гүйцэтгэнэ. Нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх нь нэхэмжлэлийн шаардлагын агуулгыг өөрчилж буй хэрэг бөгөөд харин ихэсгэж байгаа асуудал нь нэхэмжлэлийн зүйлийг нэмэгдүүлэх, түүнчлэн маргаан бүхий захиргааны актаас үүдэлтэй хохирлын хэмжээтэй холбогдсон шаардлага байж болно гэх мэт.

Нэхэмжлэлийн шаардлагыг багасгаж байгаа нь нэхэмжлэлийн тухайн хэсгээс татгалзаж байгаа гэсэн үг юм. Энэ эрх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд хэрэгжинэ.

Нэхэмжлэлээс татгалзах нь диспозитив зарчмын нэг илрэл бөгөөд хэргийг давж заалдах журмаар эсвэл хяналтын журмаар хэлэлцэж байгаа үед ч татгалзаж болно. Нэхэмжлэлээс татгалзахын тулд нэхэмжлэгч өөрийн шаардлагыг цаашид хэрэгжүүлэхгүй гэдэг нэг талын хүсэл зоригийн илэрхийлэл гаргах замаар мэдэгдэх бөгөөд нэхэмжлэлээс татгалзах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн дуусгах боломжийг бүрдүүлж өгдөг тул хариуцагчаас зөвшөөрөл авах шаардлагагүй байна. Үүнийг шүүх хуралдааны бус үед бичгээр гаргах ба шүүгч нэхэмжлэгчийн нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж хэргийг хэрэгсэхгүй болгох тухай захирамж гаргана.

Харин шүүх хуралдааны явцад энэ талаар мэдэгдсэн бол хуралдааны ажиллагааг дуусгаж, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаж, гарын үсэг зуруулна.

/Энэ талаар хуулийн 41 дүгээр зүйлийн дэлгэрэнгүй тайлбараас үзнэ үү/

Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан тохиолдолд уг асуудлаар дахин нэхэмжлэл гаргах эрхгүй болдог. Хэргийг давж заалдах журмаар эсвэл хяналтын журмаар хэлэлцэх явцад нэхэмжлэлээсээ татгалзсан бөгөөд давж заалдах эсвэл хяналтын шатны шүүхэд хандсан нь үндэслэлтэй тохиолдолд анхан шатны шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон бол түүнээс татгалзсан шалтгааныг баталгаажуулна. Харин нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн байсан үед давж заалдах болон хяналтын шатанд татгалзвал шийдвэрийг хүчингүй болгож нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох тухай магадлал, тогтоол гаргана.

Нэхэмжлэгч, хариуцагч нар маргааныг хуулийн хүчин төгөлдөр шийдвэрээр шийдэж дуусахаас өмнө хэдийд ч эвлэрч болно. Шүүх хуралдаанаас өмнө эвлэрсэн бол түүний агуулгыг бичгээр үйлдэн эвлэрлийн гэрээ байгуулна. Эвлэрэл байгуулахад талууд харилцан буулт хийж, анхны шаардах эрхийн оронд эвлэрлээс үүдсэн шинэ шаардах эрх гарч ирэх тул тэдний эвлэрсэн нь хууль зүйн үндэслэлтэй байсан эсэхийг шүүх тогтоосны дараа эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох захирамж гаргана. */Хуулийн 43 дугаар зүйлийн дэлгэрэнгүй тайлбарыг үзнэ үү/*

Шүүх хуралдааны явцад эвлэрвэл хуралдааны тэмдэглэлд тусгаж, талуудаар гарын үсэг зуруулж баталгаажуулна. Хэргийг давж заалдах журмаар эсвэл хяналтын журмаар хэлэлцэх явцад нэхэмжлэгч, хариуцагч нар эвлэрсэн бол цаашдын ажиллагаа нь нэхэмжлэлээс татгалзсан үеийнхтэй адил байна.

1.2.Энэ хэсгийн зохицуулалтыг хуулийн 31, 62.2-т зааснаар захиргааны процессыг тодорхойлдог мөрдөн шалгах зарчимтай холбож үзэх шаардлагатай. Шүүхэд танилцуулсан бүхий л баримтыг үзэж танилцах боломж нэхэмжлэгчид байх ёстой. Нэхэмжлэгчийн зүгээс хэргийн материалтай танилцах түүнээс тэмдэглэл, хуулбар хийх, тэдгээрт тайлбар өгөх түүнчлэн шүүх хуралдаанд оролцох эрхийг хангах бүхий л боломж нөхцөлийг бүрдүүлэх нь шүүхийн үүрэг мөн. Энэ нь шүүхийн зүгээс нэхэмжлэгчийг дан объект мэтээр үзэхээс татгалзсан эрх зүйт төрийн үндсэн зарчмын илрэл юм. Шүүхийн өөрийн бүрдүүлсэн болон эсрэг талаас шүүхэд ирүүлсэн аливаа баримтыг нэхэмжлэгчид уншуулах, гардуулах, хүргүүлэх, хэргийн материалтай танилцуулах ажиллагааг шүүх гүйцэтгэх бөгөөд түүнээс тэмдэглэл, хуулбар хийхэд зохих төлбөрийг шүүхэд мөрдөгддөг журмыг баримтлан нэхэмжлэгч өөрөө төлнө. Хэргийн материалтай танилцах эрхийг хэрэгжүүлэхэд шүүх өрөө, сандал, ширээ гаргаж өгөх зэргээр шаардлагатай нөхцөлийг бүрдүүлнэ. Шүүх хуралдаанд оролцох эрхэд шүүх хуралдаан дээр үг хэлэх эрх зүй ёсоор багтана. Нэхэмжлэгчийн оронд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгч оролцож байгаа ч гэсэн шүүх хуралдаанд биечлэн оролцож, үг хэлэх эрхээ хэрэгжүүлнэ гэсэн үг юм.

1.3.Нэхэмжлэгч өөрийн шаардлагыг нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөх эрхтэйгээс гадна хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий зарим ажиллагааг гүйцэтгүүлэхээр шүүхэд хүсэлт гаргадаг. Энэ нь гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, өөрөө олж авах боломжгүй, хуулиар түүнд ийм эрх олгогдоогүй ажиллагааг шүүхээр гүйцэтгүүлэх талаар хүсэлт гаргах гэх мэт. Нотлох баримт гаргуулах тухай хүсэлтийг шүүх шууд хэрэгжүүлэх үүрэг хүлээхгүй бөгөөд гагцхүү тухайн нөхцөл байдлыг

тодруулахад шаардлагатай нотлох баримтыг шаардана. /Хуулийн 31.8-ийн тайлбарыг үзнэ үү/

Хүсэлтийг бичгээр гаргах ба хүсэлтдээ ямар хүнийг ямар асуудлаар гэрчээр асуулгах шаардлагатай байгаа, түүний нэр, хаяг, тусгайлан мэдлэг шаардагдах ямар асуудлаар ямар үндэслэлийг нотлох зорилгоор шинжээчийн дүгнэлт гаргуулах саналтай байгаа зэргийг тусгана. Харин шинжээчийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасны дагуу шүүхээс томилдог тул ямар байгууллага, мэргэжилтнээр дүгнэлт гаргуулах талаар нэхэмжлэгч хүсэлтдээ заах шаардлагагүй юм.

“Бусад нотлох баримт цуглуулах талаар хүсэлт гаргана” гэдэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан ажиллагааг шүүхээр гүйцэтгүүлэх тухай хүсэлт хамаарна.

Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тодруулахын тулд үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааг зөвхөн шүүх гүйцэтгэдэг тул энэ талаар нэхэмжлэгч хүсэлт гаргасан байх шаардлагатай. Шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах нэхэмжлэгчийн эрх нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.7, 69 дүгээр зүйлийн 69.1, 74 дүгээр зүйлийн 74.2-т заасан үндэслэл бий болсон тохиолдолд хэрэгжинэ. Энэ нь хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх явцад шинээр нотлох баримт шаардагдах, мөн нэмэлт нотлох баримт цуглуулах, гэрчийн мэдүүлэг авах, шинжээч томилох, ирээгүй оролцогчийг шүүх хуралдаанд зайлшгүй оролцуулах шаардлагатай гэсэн үндэслэлээр нэхэмжлэгч шүүх хуралдааныг хойшлуулах тухай хүсэлт гаргана гэсэн үг юм. Түүнчлэн шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хүрэлцэн ирж чадаагүй боловч биеэр оролцох хүсэлтэй байгаа оролцогчийг зайлшгүй оролцуулах саналтай байгаа тохиолдолд нэхэмжлэгч хуралдааныг хойшлуулах талаар хүсэлт гаргаж болно. /Хуулийн 69 дүгээр зүйлийн тайлбарыг үзнэ үү/

1.4.Нэхэмжлэгч нь шүүх бүрэлдэхүүн буюу шүүгчийг, прокурор, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг хуульд заасан үндэслэлээр татгалзан гаргах эрхтэй болно. /Хуулийн 64 дүгээр зүйлийн тайлбарыг үзнэ үү/

Татгалзан гаргах хүсэлтийг нэхэмжлэгч бичгээр шүүх хуралдаан эхлэхээс өмнө эсхүл шүүх хуралдаан дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд гаргах эрхтэй. Хүсэлтэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчоос хэнийг нь татгалзан гаргах хүсэлтэй байгааг тодорхой зааж, ийнхүү татгалзан гаргах болсон үндэслэлээ дэлгэрэнгүй тусгасан байна. Татгалзан гаргах хүсэлт нь зөвхөн хуульд заасан үндэслэлд тулгуурласан байх ёстой ба хуульд заагдаагүй үндэслэлээр гаргасан хүсэлтийг хангах боломжгүй юм.

1.5.Шүүх хуралдаанд биеэр оролцож буй нэхэмжлэгч хуралдааны бусад оролцогчид шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр хэргийн нөхцөл байдлыг тодруулахад чиглэгдсэн тухайн хэрэгт хамааралтай асуудлаар асуулт тавьж болно. Шүүх хуралдаан даргалагч нэхэмжлэгчийн энэ эрхийг хэрэгжүүлэх боломжийг олгох үүрэгтэй.

1.6.Нэхэмжлэгчийн шаардлагыг хангаагүй буюу түүний шаардсан хэмжээнд хүрч хангаагүй нь шүүхийн шийдвэрийг давж заалдах буюу хяналтын журмаар гомдол гаргах

үндэс болдог. Гомдлыг хуульд заасан хугацаа, үндэслэл, журмын дагуу гаргана.
/Хуулийн 77 дугаар зүйлийн тайлбарыг үзнэ үү/

1.7.Нэхэмжлэгч энэ зүйлд заасан ерөнхий эрхээс гадна бусад зүйлүүдэд тусгасан тусгай эрхийг эдэлнэ. Тухайлбал: Хяналтын шатны шүүхэд маргааны зүйлийн талаарх мэдлэгтэй мэргэжлийн хүнээр төлөөлүүлэх */Хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн тайлбарыг үзнэ үү/* захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт засвар оруулах хүсэлт гаргах, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт нэмэлт оруулах хүсэлт гаргах, давж заалдах гомдлоосоо татгалзах, Захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргах эрх гэх мэт */Хуулийн 75, 78, 83, 90 дүгээр зүйлүүдийн тайлбарыг үзнэ үү/*

Хуульд заасан бусад эрх гэдгийг энэ хуульд заасан гэж ойлговол зохино.

2.1.Хуульд нэхэмжлэгч шүүхийн дуудсан хугацаанд хүрэлцэн ирэх үүрэгтэй байхаар заасан нь нэхэмжлэгч уг маргааныг үүсгэсэн субъектийн хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд идэвхтэй, хариуцлагатай байхыг шаардсан агуулгыг илэрхийлжээ. Шүүхийн дуудсанаар гэдэгт шүүхэд хүрэлцэн ирэхийг нэхэмжлэгчид энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасан журмаар мэдэгдсэн байхыг хэлнэ. Шүүхэд дуудах журмыг нэг бүрчлэн биелүүлсэн боловч нэхэмжлэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүхэд болон шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан үр дагавар үүснэ.

2.2.Нэхэмжлэгч энэ хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг сахина. *Жишээ нь: Нэхэмжлэлийг 20 буюу түүнээс дээш этгээд хамтран гаргасан тохиолдолд шүүгч тэдэнд төлөөлөгчөө захиргааны хэрэг үүсгэснээс хойш 14 хоногийн дотор томилохыг санал болгох бөгөөд энэ хугацаанд төлөөлөгчөө томилоогүй бол шүүгч тэдний дундаас төлөөлөгчийг шүүгчийн захирамж гаргаж томилно.*

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг шүүх хуульд заасан арга хэрэгслээр сахиулахаас гадна шүүхийн дотоод үйл ажиллагааг зохицуулсан журмаар мөрдүүлж болно. *Жишээ нь: Нэхэмжлэгч нэхэмжлэлээ аль шүүгчээр шийдвэрлүүлэхийг сонгохгүй, харин шүүгчдийн зөвлөлгөөнөөр тогтоосон журмын дагуу хүлээн авсан шүүгч нэхэмжлэлийг шийдвэрлэх, хэргийн материалаас хуулбар хийхэд тогтоосон журмын дагуу зохих төлбөрийг төлөх гэх мэт.*

Шүүх хуралдааны танхимд тогтоосон журам, дэгийг баримтлан явуулах нь хуралдаан даргалагчийн үүрэг бөгөөд эдгээр журам, дэгийг нэхэмжлэгч сахих учиртай.
/Хуулийн 63, 69 дүгээр зүйлийн тайлбараас үзнэ үү/

2.3.Шүүхийн хуульд нийцсэн шаардлагыг нэхэмжлэгч биелүүлэх үүрэгтэй. Жишээ нь: нэхэмжлэгч захиргааны шүүхээс түүнд нотлох баримт гаргах тухай тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй */Хуулийн 31.2 дахь хэсгийн тайлбарыг үзнэ үү/*

Хуульд “Захиргааны хэргийн шүүхийн акт” гэсэн нэр томъёог хэрэглэсэн ба акт нь шийдвэр, магадлал, энгийн магадлал, шүүгчийн захирамж гэсэн хэлбэртэй байна. “Шүүхийн хүчин төгөлдөр актыг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа холбогдох бүх байгууллага, албан тушаалтан, иргэн заавал биелүүлнэ” гэсэн шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчим юуны өмнө хэргийн оролцогчдод хамааралтай юм.

Нэхэмжлэгч шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй ба гомдол гаргаагүй эсхүл дээд шатны шүүхүүд гомдлыг хангаагүй бол шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх үүрэгтэй болно.

20 дугаар зүйл. Хариуцагчийн эрх, үүрэг

- 20.1. Хариуцагч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараах эрх эдэлнэ:
- 20.1.1. захиргааны хэргийн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх;
 - 20.1.2. нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх, эсхүл татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах, нэхэмжлэгчтэй эвлэрэх;
 - 20.1.3. захиргааны хэргийн шүүхийн болон эсрэг талын шаардлага, тайлбар, нотлох баримт, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл, хуулбар хийх;
 - 20.1.4. гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, нэмэлт нотлох баримт цуглуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах;
 - 20.1.5. энэ хуулийн 19.1.4.-19.1.7.-д заасан эрх.
- 20.2. Хариуцагч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараах үүрэг хүлээнэ:
- 20.2.1. нэхэмжлэлийн талаар бичгээр тайлбар гаргах, захиргааны хэргийн шүүхээс шаардсан нотлох баримтыг гаргаж өгөх;
 - 20.2.2. захиргааны хэргийн шүүхээс тавьсан шаардлага, шийдвэрийг биелүүлэх, шүүх хуралдаанд оролцох;
 - 20.2.3. захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх.

ТАЙЛБАР

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хариуцагчийн эдлэх эрх, хүлээх үүрэг нь нэхэмжлэгчийнхээс ялгаатай. Нэхэмжлэгч нь шүүхэд нотлох баримт гаргаж өгөх эрхтэй бол хариуцагч шүүхээс шаардсан нотлох баримтыг гаргаж өгөх үүрэгтэй байна. Шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх нь нэхэмжлэгчийн үндсэн үүрэг байдаг бол хариуцагч ийм үүрэг хүлээхгүй, харин хүрэлцэн ирэх эрхтэй байна.

1.1. Шүүхэд дуудагдсан хариуцагч шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэхийг хариуцагчийн үндсэн эрхэд хамааруулсан энэ зохицуулалт нь зохих журмын дагуу шүүхэд дуудагдсан этгээд хүрэлцэн ирэх үүрэгтэй гэсэн энэ хуулийн 40 дүгээр зүйлтэй зөрчилдсөн.

1.2. Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх, нэхэмжлэгчтэй эвлэрэх боломжтой байдаг. Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх эсэх тухайгаа нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор

эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд шүүхэд мэдэгдэх үүрэгтэй гэж хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т тусгайлан үүрэг болгон заасан байна. */Хуулийн 38 дугаар зүйлийн тайлбарыг үзнэ үү/*

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлснийг нэхэмжлэгч шүүхэд баталснаар бодит байдалтай нийцсэн гэж үзэх бөгөөд энэ тохиолдолд шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгож, хариуцагч шаардлагыг биелүүлсэн тухай шүүгчийн захирамж гаргах ёстой. Хуульд дээрх тохиолдлыг хэрхэн шийдвэрлэхийг нарийвчлан зохицуулаагүй тул хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д заасан журмаар шүүгчийн захирамж гаргана.

Хариуцагч дээрх эрхээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тусгай хугацааны дотор хэрэгжүүлэх боломжтой тул хариуцагчид нэхэмжлэлийг гардуулах үед эрхийг нь сайтар тайлбарлах ёстой. Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, шаардлагыг сайн дүраар биелүүлэх нь түүний хүсэл зоригийн илэрхийлэл бөгөөд шүүгч хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох захирамж гаргана.

Харин нэхэмжлэгчтэй эвлэрэх нь нэхэмжлэгч, хариуцагч нар харилцан буулт хийж хоорондоо тохиролцсон эвлэрлийн гэрээ байгуулдаг. Нэхэмжлэгч, хариуцагч хоёрын эвлэрсэн нь хуульд харшлаагүй эсхүл бусад этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй бол шүүгч тэдний эвлэрлийг батална. */Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтын тайлбарыг үзнэ үү/*

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй, татгалзаж байгаа бол тайлбартаа үндэслэлийг зааж, нотлох баримтаа хамтад нь ирүүлнэ. Сөрөг нэхэмжлэл гаргах нь хариуцагчийн үндсэн эрхээс гадна, хуулийн 39 дүгээр зүйлээр тусгайлан зохицуулсан эрх юм. Сөрөг нэхэмжлэл гаргах нь үндсэн нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах арга хэрэгсэл биш харин эрх зүйн хэд хэдэн маргааныг нэг дор шийдвэрлэх боломжийг бүрдүүлдэг. Сөрөг нэхэмжлэлийг үндсэн нэхэмжлэлийн адил хүлээн авахаас татгалзах нөхцөл байгаа эсэхийг шалгахгүй байхаар хуульд заасан боловч маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгуулах болон захиргааны акт гаргуулах тухай нэхэмжлэлтэй холбогдуулан сөрөг нэхэмжлэл гаргаж болохгүй. Сөрөг нэхэмжлэлийг үндсэн нэхэмжлэлийн адил нэхэмжлэлийн хэлбэр, бүрдүүлбэр зэрэг хуульд заасан шаардлагыг хангасан байдлаар гаргана. */Хуулийн 39 дүгээр зүйлийн тайлбарыг үзнэ үү/*

1.3.Захиргааны хэргийн шүүхийн болон эсрэг талын шаардлага, тайлбар, нотлох баримт, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хуулбар хийх эрх нь хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-т заасан нэхэмжлэгчийн үндсэн зарим эрхтэй адил байна. Харин нэхэмжлэлийн талаар тайлбар өгөх, шүүх хуралдаанд оролцохыг эрхэд нь биш үүрэгт нь хамааруулжээ. */Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтын тайлбарыг үзнэ үү/*

1.4.Гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, нэмэлт нотлох баримт цуглуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах талаар хүсэлт гаргах хариуцагчийн эрх нь хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3-т заасан нэхэмжлэгчийн эдгээр эрхтэй адил байна. Харин нэхэмжлэгчийн хувьд нотлох баримт гаргаж өгөх эрхтэй байдаг бол хариуцагч үүрэгтэй байхаар заажээ. */Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалтын тайлбарыг үзнэ үү/*

1.5.Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-19.1.7-д заасан нэхэмжлэгчийн эдлэх эрхийг хариуцагч мөн адил эдэлнэ гэж ойлгоно. */Хуулийн 19.1.4-19.1.7 дахь заалтын тайлбарыг үзнэ үү*

2.1.Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөх эсэх тухайгаа шүүхэд бичгээр тайлбарлана. Шүүх хуульд зааснаас богино хугацаанд эсхүл тогтоосон хугацаанаас өмнө хариуцагчаас тайлбарыг шаардаж болохгүй юм. Учир нь энэ хугацаанд хариуцагч тайлбар гаргах үүргээ биелүүлээгүй бол Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэх нөхцөл болдог. Шүүх хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг гаргаж өгөхийг хариуцагчаас шаардах бөгөөд үүндээ ямар нотлох баримт гаргуулахаа нэрлэн заасан, хуульд заасан шаардлагыг хангасан байхыг сануулсан, гаргаж өгөх тогтоосон хугацааг зайлшгүй заасан байх ёстой. Шүүхээс шаардсан нотлох баримтыг гаргаж өгөөгүй нь хариуцагчид хуулийн 38 дугаар зүйлийн 38.4-д зааснаар хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог. Харин шүүх хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөөгүй баримтыг хариуцагчаас шаардан гаргуулж болохгүй. */Хуулийн 31 дүгээр зүйлийн тайлбарыг үзнэ үү/*

2.2.Шүүхээс тавьсан шаардлага, шийдвэрийг биелүүлэх үүрэг нь нэхэмжлэгчийн хүлээх үүрэгтэй ижил байна. */Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.3 дахь заалтын тайлбарыг үзнэ үү/* Харин нэхэмжлэгч шүүх хуралдаанд оролцох эрхтэй байдаг бол хариуцагчийн хувьд үүрэг болгожээ.

Шүүх хэргийн болон шүүх хуралдааны оролцогчийг шүүхийн мэдэгдэх хуудсаар шүүхэд болон шүүх хуралдаанд дуудан ирүүлэх бөгөөд хариуцагчийг шүүхийн дуудсанаар шүүхэд ирэх эрхтэй байхаар зохицуулсан хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалттай энэ зүйл зөрчилдсөн. Хариуцагч шүүх хуралдаанд оролцох үүргээ биелүүлээгүй нь анхан шатны шүүх хуралдааны хувьд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасан үр дагавар бий болох бөгөөд эдгээр нь хариуцагч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдлыг зохицуулсан байна.

Хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2-т зааснаар шүүх хуралдаанд ирээгүй хариуцагчийг зайлшгүй оролцуулах шаардлагатай гэж үзвэл шүүх бүрэлдэхүүн тогтоол, шүүгч захирамж гаргаж шүүх хуралдааныг 14 хүртэл хоногийн хугацаагаар хойшлуулж болдог. Давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд хариуцагч оролцох үүрэг хүлээгээгүй бөгөөд харин биеэр оролцохыг хүсвэл тухайн шүүх, хуралдаан хэзээ, хаана болохыг түүнд мэдэгдэж шүүх хуралдаанд биеэр оролцох эрхийг нь хангах ёстой.

2.3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэг нь хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.2, 19.2.3-т заасан нэхэмжлэгчийн үндсэн үүрэгтэй адил байна. */Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.2, 19.2.3 дахь заалтын тайлбарыг үзнэ үү/*

21 дүгээр зүйл. Гуравдагч этгээд, түүнийг татан оролцуулах

- 21.1. Захиргааны тухайн хэргийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн бөгөөд бие даасан шаардлагатайгаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах нь зүйтэй гэж захиргааны хэргийн шүүх шийдвэрлэсэн иргэн, хуулийн этгээдийг гуравдагч этгээд гэнэ.
- 21.2. Тухайн захиргааны хэрэгт татан оролцуулахаар захиргааны хэргийн шүүх шийдвэрлэсэн гуравдагч этгээд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

ТАЙЛБАР

Бусад иргэн, хуулийн этгээдээс гаргасан нэхэмжлэлтэй хэрэгт өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан оролцох иргэн, хуулийн этгээдийг гуравдагч этгээд гэж хэлнэ. Гуравдагч этгээдээр захиргааны байгууллага, албан тушаалтан оролцож болохгүй.

1. Захиргааны тухайн хэргийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж буй этгээд нь нэхэмжлэгч болон сөрөг нэхэмжлэл гаргасан хариуцагчаар оролцох хууль зүйн үндэслэлгүй тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даасан шаардлагатай гуравдагч этгээдээр оролцдог. Өөрөөр хэлбэл бие даасан шаардлагатай гуравдагч этгээд бол нэхэмжлэгчийн болон хариуцагчийн шаардлагаас агуулгын хувьд өөр шаардлага тавьж буй этгээд юм. *Жишээ нь: Сумын Засаг дарга иргэн А-д олгосон газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож, газар чөлөөлүүлэх захирамж гаргажээ. А энэ захирамжийг хүчингүй болгуулах шаардлага гаргасан ба түүнтэй тохиролцон сумын Засаг даргын зөвшөөснөөр газрыг нь ашиглаж, үр шимийг нь хүртэж байсан иргэн Б өөрт учирсан хохирлоо арилгуулахаар хариуцагчид шаардлага гаргажээ. Иймд шүүх бие даасан шаардлага гаргасан этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах эсэхийг шийдвэрлэхгүй. Харин тэрээр ийм шаардлага гаргасан тул хэргийн оролцогч болохыг баталж шүүх тогтоол, шүүгч захирамж гаргах ба түүний шаардлагыг нэхэмжлэгч, хариуцагч тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид гардуулах ажиллагааг хийнэ. Гуравдагч этгээдийн бие даасан шаардлага нэхэмжлэлийн бүх шаардлагыг хангасан байвал зохино.*

Гуравдагч этгээдийн бие даасан шаардлага ба нэхэмжлэгч, хариуцагчийн хооронд үүссэн эрх зүйн маргааныг шүүгч тус тусад нь шийдвэрлэнэ. Бие даасан шаардлагатай гуравдагч этгээд нь практикт ихэвчлэн нэхэмжлэгчийн талд тохиолдох тул түүнийг ялгах шаардлагатай. Хамтран нэхэмжлэгчийн шаардлага нь адил байдаг бол бие даасан шаардлагатай гуравдагч этгээдийн шаардлага өөр байдаг. Бие даасан шаардлагатай гуравдагч этгээд оролцогчийн бүх эрхийг эдэлж, үүргийг хүлээдэг.

2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийг оролцуулж болохыг заасан байна. Шүүхээс гарах шийдвэр нь маргаж байгаа зүйлийн талаар бие даасан шаардлага гаргаагүй этгээдийн эрх үүрэгт муугаар нөлөөлөхөөр байвал шүүхийн шийдвэр гарахаас өмнө уг этгээдийн өөрийнх

нь эсхүл шүүхийн санаачлагаар болон зохигчийн хүсэлтээр бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн хувиар оролцуулж болно.

Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд бол хэргийн оролцогчийн аль нэгтэй нэгэн адил шаардлагатай байгаа этгээд юм. Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд нь нэхэмжлэгч, хариуцагчийн аль нэгтэй эрх зүйн харилцаанд орсон байдаг ба нэхэмжлэгч, хариуцагч хоёрын хооронд үүссэн маргаан хэрхэн шийдвэрлэгдсэнээс шалтгаалж ирээдүйд түүнд холбогдуулан нэхэмжлэл гаргах эсхүл хэн нэгэнд холбогдуулан нэхэмжлэл гаргах шаардлага үүсэх боломжтой тул өөрийн эрхэд муугаар нөлөөлөх аливаа шийдвэрийг гаргуулахгүй байхын тулд нэхэмжлэгч, хариуцагчийн аль нэгний талд тухайн хэрэгт оролцуулах шаардлагатай болдог. Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийг шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж гаргаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулах бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т "...оролцуулж болно" гэж зааснаас үзвэл шүүхийн зөвшөөрлийн дагуу хийгдэнэ гэж ойлгогдож байна. Шүүх тухайн этгээдийг гуравдагч этгээдээр оролцуулж ч болох ба шаардлагагүй гэж үзвэл оролцуулахгүй ч байж болно.

Заавал татан оролцуулах шаардлагатай гуравдагч этгээд нь шүүхээс гарах шийдвэр түүний хувьд эрх зүйн үр дагавартай байдгаараа онцлогтой. Энэ нь нэхэмжлэлийн агуулгаас хамааралтай байна. Захиргааны актыг хүчингүй болгуулах, илт хүчин төгөлдөр бусыг хүлээн зөвшөөрүүлэх, захиргааны акт гаргахыг даалгах зэрэг нэхэмжлэлүүд нь хоёр тийшээ үйлчилгээтэй захиргааны актад холбогдож байх тул уг актад холбогдох иргэн, хуулийн этгээдийг шүүх заавал татан оролцуулах шаардлага гарна. *Жишээ нь: Тендерийн хорооны шийдвэрийг хүчингүй болгоно уу гэсэн нэхэмжлэлд тендерт ялагчаар тодорхой этгээдийг заавал оролцох гуравдагч этгээдээр татан оролцуулна.*

Иргэнд газар эзэмших зөвшөөрөл олгохоос Засаг дарга татгалзсан тул тэрээр "даалгах" нэхэмжлэл гаргажээ. Гэтэл өөр нэг иргэн ийм зөвшөөрлийг "даалгах" шийдвэр шүүхээс гаргах нь миний эрх, хууль ёсны ашиг сонирхолд муугаар нөлөөлнө гэж үзэж тухайн шүүхэд хандвал шүүх энэ тохиолдолд уг иргэнийг гуравдагч этгээд оролцуулах эсэхийг цэгнэн үзэх шаардлага гарч байна.

Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд оролцогчийн бүх эрхийг эдэлж, үүрэг хүлээдэг бол бие даасан шаардлага гаргаагүй нэхэмжлэгч талын гуравдагч этгээд нэхэмжлэл гаргасан үндэслэл ба нэхэмжлэлийг өөрчлөх, нэхэмжлэлийн шаардлагыг ихэсгэх буюу багасгах, нэхэмжлэлээсээ татгалзах, нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөх, эвлэрэхээс бусад оролцогчийн эрхийн эдэлж, үүргийг хүлээнэ. Харин хариуцагч талын гуравдагч этгээд нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх, сөрөг нэхэмжлэл гаргах, нэхэмжлэгчтэй эвлэрэхээс бусад хариуцагчийн эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн эдлэх ёсгүй эдгээр эрх нь тухайн захиргааны хэргийн үндсэн нэхэмжлэлтэй холбоотой болох нь харагдаж байна. Иймд бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн нэхэмжлэгч, хариуцагч хоёрын хоорондох маргаанд аль нэг талыг дэмжиж оролцож байгаа бөгөөд практикт ихэвчлэн хариуцагчийн талд оролцдог.

22 дугаар зүйл. Нэхэмжлэлийг хэд хэдэн этгээд хамтран гаргах

- 22.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгэн адил шаардлага бүхий нэхэмжлэлийг хэд хэдэн нэхэмжлэгч хамтран гаргаж болно.
- 22.2. Энэ хуулийн 22.1.-д заасан тохиолдолд нэхэмжлэгчид дундаасаа төлөөлөгч томилон итгэмжлэл буюу бүрэн эрх олгож, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрсдийгөө төлөөлүүлэн оролцуулах эрхтэй.
- 22.3. Нэхэмжлэлийг 20 буюу түүнээс дээш этгээд хамтран гаргасан тохиолдолд шүүгч тэдэнд төлөөлөгчөө энэ хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу захиргааны хэрэг үүсгэснээс хойш 14 хоногийн дотор томилон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахыг санал болгоно.
- 22.4. Энэ хуулийн 22.3.-т заасан хугацаанд нэхэмжлэгчид төлөөлөгчөө томилоогүй бол шүүгч тэдний дундаас төлөөлөгчийг нь томилно.
- 22.5. Төлөөлөгчийн тоо 3-аас илүүгүй байх ба энэ тохиолдолд шүүгч төлөөлөгчийн бүрэн эрхийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2-т зааснаар хязгаарлаж болохгүй.

ТАЙЛБАР

1. Захиргааны хууль бус актын улмаас 2 болон түүнээс дээш этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нэгэн зэрэг зөрчигдөх тохиолдол гардаг. Эдгээр нь зөрчигдсэн эрхээ сэргээлгэхээр нэгдэж, хариуцагчид нэгэн адил шаардлага тавьсан нэхэмжлэлийг хамтран гаргаж болно. Нэхэмжлэлийг хамтран гаргасан этгээд нь:

- Нэгдмэл ашиг сонирхолтой бол
- Нэгэн адил эрх эдлэх буюу үүрэг хүлээсэн бол
- Шаардлага нь эрх зүйн маргааны нэг зүйлд хамаарч байгаа бол
- Маргааныг хуульд зааснаар шийдвэрлэхэд нэгдсэн үр дүн гарахаар байгаа бол хамтран нэхэмжлэл гаргасныг хүлээн авахыг зөвшөөрдөг.

2. Нэхэмжлэлийг хэд хэдэн этгээд хамтран гаргасан тохиолдолд нэхэмжлэгч бүр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхтэй ч өөрсдийгөө төлөөлөх төлөөлөгчийг дундаасаа томилон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж болно. *Жишээ нь: Энэ хэсэгт нэхэмжлэлийг хамтран гаргасан 2-19 этгээдийн талаар яригдаж байгаа бөгөөд тэдгээр нь дундаасаа төлөөлөгч томилоогүй тохиолдолд хуульд заасан нэхэмжлэгчийн эрх, үүргийг тус бүрдээ эдэлнэ. Энэ нь нэхэмжлэлийг хамтран гаргасан этгээдүүд нэхэмжлэгчийн эрх, үүргийг тус бүрдээ эдэлж байна гэдгээр харилцан төлөөлж байгаа этгээдүүдийн ашиг сонирхолд нийцээгүй эрхийг хэрэгжүүлнэ гэсэн үг биш юм.*

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамтран оролцож байгаа нэхэмжлэгчид ямагт ижил ашиг сонирхолтой нэгдмэл баг гэдгийг ойлгох нь чухал. Харин дундаасаа төлөөлөгч томилоогүй, хамтарсан нэхэмжлэгчдийн хувьд шүүх тэдгээрийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжийг бүхий л талаар хангасан байх учиртай. Нэхэмжлэгчид дундаасаа төлөөлөгч томилбол төлөөлөгчийн бүрэн эрхийн талаар итгэмжлэл олгоно. Нэхэмжлэгчдийн дундаас томилогдсон төлөөлөгч өөрөө нэхэмжлэгч байдаг тул түүний хуульд заасан эдлэх ёстой эрхийг нь эдлүүлэхгүй байхаар хязгаарлаж болохгүй. Энэ талаар хуулийн 22 дугаар зүйлийн 22.5-д тусгайлан заажээ. Төлөөлөгчийн тоо 3-аас илүүгүй байх ёстой. Нэхэмжлэгчид төлөөлөгчөө томилсон тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцох шаардлагагүй бөгөөд нэхэмжлэгчдийн дундаас томилогдсон төлөөлөгч хэргийн оролцогч тул хэргийн бусад оролцогч болох нэхэмжлэгчийн төлөөлөгчөөс эрх зүйн байдлын хувьд ялгаатай юм.

3.Ихэвчлэн хэм хэмжээ тогтоосон захиргааны акттай холбоотой нэхэмжлэлд олон тооны нэхэмжлэгч оролцдог. Нэхэмжлэгчдийн тоо 20 буюу түүнээс дээш байвал шүүгч тэдэнд захиргааны хэрэг үүсгэснээс хойш 14 хоногийн дотор төлөөлөгчөө томилохыг санал болгодог. Энэ тохиолдолд нэхэмжлэгчид төлөөлөгчөөр хэнийг томилохоо өөрсдөө мэдэж шийдвэрлэнэ.

4.Хуульд заасан хугацаанд төлөөлөгчөө томилоогүй нь шүүгч өөрөө мэдэж нэхэмжлэгчдийн дундаас төлөөлөгчийг томилох нөхцөл бүрдэнэ. Шүүгч төлөөлөгчийг томилохдоо нэхэмжлэгч нартай ярилцаж тэдний саналыг сонсохоос гадна төлөөлөгчөөр томилогдох гэж буй этгээдээс зайлшгүй саналыг авах шаардлагатай. Шүүгч төлөөлөгчийг томилохдоо шүүгчийн захирамж гаргана.

5.Шүүгч нэхэмжлэгчдийн дундаас 3-аас илүүгүй нэхэмжлэгчийг төлөөлөгчөөр томилох бөгөөд тэдгээр нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгчийн эрхийг эдэлж, үүрэг хүлээж оролцоно. Нэхэмжлэгчдийн дундаас томилогдсон төлөөлөгч нь өөрөө нэхэмжлэгчдийн нэг байдаг тул нэхэмжлэгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эдлэх эрхийг нь ямар нэг байдлаар хязгаарлаж болохгүй юм.

23 дугаар зүйл. Хамтран хариуцагч

- 23.1. Нэг нэхэмжлэлд хэд хэдэн хариуцагч байж болох ба тэдгээр нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даан оролцох эрхтэй.
- 23.2. Хамтран хариуцагчид нь ашиг сонирхлын зөрчилгүй, уг хэргийг хянан шийдвэрлэхэд бүгд оролцох шаардлагагүй, түүнчлэн хэргийн шийдвэрт сөргөөр нөлөөлөхгүй гэж үзвэл хэн нэгийгээ томилон өөрсдийгөө төлөөлүүлэн оролцуулж болно.

ТАЙЛБАР

1. Эрх зүйн хэм хэмжээний актыг хуулиар олгосон эрхийн дагуу 2 буюу түүнээс дээш субъект батлан гаргасан, мөн захиргааны байгууллага, албан тушаалтан хамтын шийдвэр гаргасан зэрэг тохиолдолд тухайн хэргийн хариуцагч нь хэд хэдэн этгээд байж болдог. Нэхэмжлэлд хэдэн хариуцагч байхыг нэхэмжлэгч эхлээд өөрөө шийддэг ба шүүх нэхэмжлэгчийн хариуцагчаар татсан этгээдэд холбогдуулан хэрэг үүсгэнэ. *Жишээ нь: Дэд бүтцийн сайд Улсын мэргэжлийн хяналтын газрын даргын хамтарсан тушаалаар "Барилга угсралтын ажлыг эрхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох журам" баталсан байх бөгөөд уг журмыг эсэргүүцэж гаргасан нэхэмжлэлд Дэд бүтцийн яам Улсын мэргэжлийн хяналтын газрыг хамтран хариуцагчаар татсан байна.*

Хамтран хариуцагчаар татагдсан этгээдүүд өөр өөр ашиг сонирхолтой байгаа тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даан оролцох бөгөөд бие биеэ харилцан төлөөлөхгүй юм.

2. Нэг хэрэгт хариуцагчаар татан оролцуулсан 2 буюу түүнээс дээш этгээд нь ашиг сонирхлын зөрчилгүй, уг хэргийг хянан шийдвэрлэхэд бүгд оролцох шаардлагагүй бөгөөд маргааныг шийдвэрлэхэд нэгдсэн үр дагавар гарахаар байна гэж үзсэн тохиолдолд хэн нэгийгээ томилон харилцан төлөөллийг хэрэгжүүлж болдог.

Хамтран хариуцагчийн төлөөлөгч нь өөрөө хариуцагч учраас, мөн харилцан төлөөллийг хэрэгжүүлж буй этгээд тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даасан оролцогч болж хариуцагчийн эдлэх эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ. Хамтран хариуцагчийн төлөөлөгчийн хуульд заасан эрхийг хязгаарлаж болохгүй бөгөөд хариуцагчийн төлөөлөгч болох хэргийн бусад оролцогчоос эрх зүйн хувьд ялгаатай. Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 54 дүгээр зүйлийн 54.2-т зааснаар хариуцагчийн төлөөлөгч бол хэргийн бие даасан оролцогч бус харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмыг хангах зорилгоор оролцдог бөгөөд төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлийн хүрээнд эрхээ хэрэгжүүлдэг этгээд юм.

Хамтран хариуцагчид нь төлөөлөгчдөө итгэмжлэл олгосноор түүний бүрэн эрх нь хэрэгжих учиртай.

24 дүгээр зүйл. Хариуцагчийг солих

- 24.1. Хариуцагчаар татагдсан этгээд уг нэхэмжлэлийн жинхэнэ хариуцагч биш болох нь нотлох баримтаар тогтоогдвол түүнийг шүүгч нэхэмжлэгчийн зөвшөөрснөөр жинхэнэ хариуцагчаар солино.
- 24.2. Хариуцагчийг солихыг нэхэмжлэгч зөвшөөрөөгүй бол уг этгээдийг шүүгч хамтран хариуцагчаар татан оролцуулна.
- 24.3. Хариуцагчийг нотлох баримт цуглуулахаас өмнө солих бөгөөд хэрэв тийнхүү цуглуулсны дараа солиход хүрвэл шинээр тогтоогдсон хариуцагч буюу хамтран хариуцагч уг хэргийн нотлох баримтыг шинээр цуглуулж үнэлүүлэхийг шаардах эрхтэй.

ТАЙЛБАР

1.Нэхэмжлэгч, хариуцагчаа андуурсан эсхүл нэхэмжлэлд дурьдсан энэ хэрэгт хариуцагчаар татагдсан этгээд тухайн шаардлагыг хариуцах этгээд биш бол шүүх түүнд холбогдох нэхэмжлэлийг үндэслэлгүй гэж үзэж, хэрэгсэхгүй болгох учиртай. Хэдий тийм боловч хариуцагчийг солих боломжийг хууль тогтоогч шүүхэд олгожээ.

Тухайн хэрэгт хариуцагчаар татагдсан этгээд уг нэхэмжлэлийн жинхэнэ хариуцагч биш болох нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тодорхой болсон бол нэхэмжлэгч өөрийн анх сонгосон этгээдийг өөр этгээдээр солихыг хүсэж болно. Энэ тохиолдолд шүүх хариуцагчийг солих ажиллагаа хийнэ.

Нөгөө талаар Захиргааны хэргийн шүүхийн мөрдөн шалгах зарчимтай холбоотойгоор хариуцагчийг солих санаачлагыг шүүгч гаргаж болох боловч зөвхөн нэхэмжлэгчийн зөвшөөрснөөр энэ ажиллагааг гүйцэтгэнэ.

Хариуцагчийг солих ажиллагаа ихэнхдээ нэхэмжлэгчийн санаачлагаар хийгдэх ёстой ба харин цөөн тохиолдолд түүний зөвшөөрснөөр явагдах боломжтой байна.

2.Нэхэмжлэгч өөрийн сонгосон хариуцагчийг солих хүсэлт гаргаагүй, түүгээр ч үл барам шүүхэд зөвшөөрөхгүйгээ илэрхийлсэн байхад хамтран хариуцагчийг шүүх татан оролцуулж байгаа нь үндсэндээ хариуцагчийг солих ажиллагаатай агуулгын хувьд адил юм. Шинэ хариуцагчид өөр нэр өгч хуучин хариуцагчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэвээр үлдээж байгаагаараа хариуцагчийг солих ажиллагаанаас ялгаатай байна.

Гэхдээ шүүхийн практикт жинхэнэ хариуцагчийг нэхэмжлэгч хүлээн зөвшөөрөхгүй байх тохиолдол бараг гардаггүй байна.

Нэхэмжлэгч жинхэнэ хариуцагчийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа үндэслэлийг шүүх судалж үзэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл нэхэмжлэгч захиргааны тухайн маргаанд холбогдолгүй, хамааралгүй этгээдийг хариуцагчаар татсан гэж гомдол гаргаж болно.

Шүүх нэхэмжлэлийг шийдвэрлэхдээ нэхэмжлэгчийн биш харин өөрийн сонгосон хариуцагчид хариуцлага ноогдуулах нь нэхэмжлэлийн шаардлагыг биш харин өөр шаардлагыг шийдвэрлэж байгаа тул шүүх шийдвэрлэж буй маргаанд ямар ч сонирхолгүй хөндлөнгийн байр суурьтай байх зарчим зөрчигдөнө. Түүнчлэн нэхэмжлэгч шинээр татан оролцуулсан хариуцагчаар шаардлага хангуулах хүсэлт гаргаагүй тул

шүүх түүний эсрэг шийдвэр гаргах ч боломжгүй юм. Иймэрхүү шийдэл нь өөр хоорондоо зөрчилдөөнтэй байх тул шүүх хамтран хариуцагчаар татан оролцуулах ажиллагааг огт хийхгүй байх нь зохимжтой юм.

3.Хариуцагчийг солих ажиллагааг хийх угтвар нөхцөл нь шүүхийн цуглуулсан нотлох баримтаар тухайн маргаантай хэрэгт хариуцагч биш этгээдийг оролцуулсан болох нь тогтоогдсон тохиолдолд хийх ёстой.

Гэвч нотлох баримтыг цуглуулахаас өмнө хариуцагчийг солино гэсэн энэ зүйл, заалтын агуулгыг шүүх нотлох баримт цуглуулах ажиллагааг гүйцэтгэхээс өмнө гэж ойлгох нь зүйтэй болов уу.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт цуглуулах үүргийг шүүх хүлээдэг. Энэ нь хэргийн оролцогчдоос нотлох баримт гаргаж өгөхөд саад болохгүй учир нэхэмжлэгчээс гаргаж өгсөн нотлох баримтаар хариуцагчаар татагдсан этгээд нь уг нэхэмжлэлийн жинхэнэ хариуцагч биш болох нь тодорхой болсон тохиолдол юм.

Иймд нотлох баримт цуглуулсны дараа шинээр тогтоогдсон хариуцагч буюу хамтран хариуцагчийн шаардсанаар шүүх нотлох баримтыг шинээр цуглуулж үнэлнэ.

Хариуцагчийг солих ажиллагаа захиргааны хэргийн анхан шатны журмаар хянан шийдвэрлэхэд явагдах бөгөөд шүүх хуралдаанаас өмнө, шүүх хуралдаан дээр ч хийж болно.

Хариуцагчийг солих ажиллагааг шүүхийн тогтоол, шүүгч захирамжаар гүйцэтгэх ба шүүхийн энэ ажиллагаанд хэргийн оролцогч хуулийн 90 дүгээр зүйлд заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

25 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан авах

25.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн эрхийг залгамжлахад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

ТАЙЛБАР

1.Эрх залгамжлан авах гэж нэхэмжлэгч, хариуцагч, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдийн аль нэг нь уг эрх зүйн маргаанаас гарсан /хүн нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон, хуулийн этгээд татан буугдсан, шаардлага ба үүргээ бусдад шилжүүлсэн/ бол шүүх тэрхүү оролцогчийг сонирхогч этгээд буюу эрх залгамжлагчийн гаргасан хүсэлтээр эрх залгамжлан авбал зохих этгээдээр солихыг хэлнэ.⁷⁵

Нэхэмжлэгч, хариуцагч, бие даасан шаардлагатай гуравдагч этгээд нас барсан бол шүүх тэдгээрийг эрх залгамжлан авагчаар сольж болно.

Иргэний хуулийн 23 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу оролцогч этгээдийг сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэр гарч, хүчин төгөлдөр болсон бол шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд түүнийг эрх залгамжлан авагчаар сольж

⁷⁵ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.

болно. Мөн Иргэний хуулийн 24 дүгээр зүйлд зааснаар оролцогч иргэнийг нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр гарсан тохиолдлыг энэ зүйл, хэсэгт хамааруулан ойлгоно.

Иргэний хуулийн 32 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу хэргийн оролцогч хуулийн этгээд татан буугдсан бол түүний эрх залгамжлагчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж болно. Хэргийн оролцогч тухайн захиргааны хэрэгт шийдвэрлэгдэж байгаа маргаан дахь эрх, хууль ёсны ашиг сонирхлоо сэргээлгэх тухай шаардах эрхээ бусдад шилжүүлсэн бол шаардах эрхийг шилжүүлж авсан этгээдээр оролцогчийг сольж болно.

Харин маргаан бүхий захиргааны актыг гаргаж бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн захиргааны байгууллага, албан тушаалтан хариуцагчийн хувьд хүлээх үүргээ бусдад шилжүүлэх тухай ойлголтыг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэгжүүлэхэд түвэгтэй юм.

Энэ ажиллагаа Захиргааны хэргийн шүүхийн практикт ихэвчлэн нэхэмжлэгчид хамааралтай гэж ойлгох нь зүйтэй болов уу.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлал зөвхөн материаллаг эрх шилжиж байгаа тохиолдолд байх боломжтой болно. *Жишээ нь: Ажлаас хууль бусаар халагдсан улсын байцаагч "А"-ын гомдлыг Төрийн албаны зөвлөл хянан үзээд маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгож, ажилд нь эгүүлэн тогтоох шийдвэр гаргасан байна. Энэ шийдвэрийг захиргааны байгууллага биелүүлээгүй тул "А" шүүхэд хандсан ба тэрээр хэрэг хянан шийдвэрлэх явцад нас барснаар улсын байцаагчийг ажилд томилохыг даалгах тухай нэхэмжлэлтэй хэрэгт түүний эрх залгамжлагчийг оролцуулах боломжгүй. Учир нь тухайн нэхэмжлэгчийн шаардлага "А"-ын хувийн байдалтай /субъектив эрх/ холбоотой юм.*

Эрх залгамжлан авах ажиллагаа хэрэг хянан шийдвэрлэх аль ч шатанд гүйцэтгэж болно гэдгийг анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд гэж ойлгохоос гадна давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ч эрх залгамжлан авах явдал байж болно гэсэн үг юм.

2. Эрх залгамжлан авахын эрх зүйн үр дагавар нь эрх залгамжлагчид эрх, үүрэг шилжих тэр үеэс эхлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цааш үргэлжлэн явагдагт оршино. Өөрөөр хэлбэл эрх залгамжлагч өмнөх этгээдийн эрх, үүргийн дагуу хийсэн үйлдлийн хариуцлагыг хүлээнэ гэсэн үг юм. Иймд эрх залгамжлагчийг сольсноор уг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхнээс нь дахин явуулах боломжгүй байдаг. Нэхэмжлэгч, хариуцагчийн эрх, үүрэг хууль ёсоор эрх залгамжлагчид шилжих ёстой боловч шилжүүлээгүй байвал энэ нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх нэг үндэслэл болдог⁷⁶ нь оролцогчдын эрх тэгш байдлыг хангахад чиглэгджээ.

26 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг төлөөлөх

⁷⁶ Захирааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.1.

- 26.1. Иргэний эрх зүйн чадамж бүхий иргэн мэргэжлийн хувьд шаардлагатай гэж үзвэл хяналтын шатны шүүхэд захиргааны хэргийг хянан хэлэлцэхэд төлөөлөгчөө оролцуулна.
- 26.2. Хууль, эрх зүйн бусад акт болон үүсгэн байгуулах баримт бичгийн дагуу олгогдсон эрх хэмжээний хүрээнд байгууллагын эрх баригч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлнө.
- 26.3. Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийн төлөөлөгчөөр оролцох байгууллагын эрх баригч нь өөрийн албан тушаал, эрх хэмжээгээ гэрчилсэн баримт бичиг, бусад ажилтан олгогдсон итгэмжлэлээ захиргааны хэргийн шүүхэд үзүүлнэ.
- 26.4. Итгэмжлэл нь Иргэний хуулийн 64.2-т заасан шаардлагыг хангасан байна.

ТАЙЛБАР

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэний эрх зүйн чадамж бүхий иргэн бусдаар төлөөлүүлэх зохицуулалтыг шууд заагаагүй боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд тэрээр өөрийгөө төлөөлүүлэх эрхтэйг хуулийн 26-28 дугаар зүйд заажээ.

1. Захиргааны хэргийг анхан шатны болон давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэхэд өөрөө биечлэн оролцсон иргэний эрх зүйн чадамжтай /өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар бүхий/ иргэн өөрийнхөө зөрчигдсэн эрхийг шүүхийн эцсийн буюу хяналтын шатны шүүхээр сэргээж тогтоолгоход тухайн асуудлын талаар мэдлэгтэй, мэргэжлийн хүний туслалцаа хэрэгтэй гэж үзвэл уг шатанд хэргийг хянан хэлэлцэхэд өөрөө биш төлөөлөгчөө оролцуулах эрхтэй. Харин иргэнийг төлөөлөх мэргэжлийн этгээд нь тухайн захиргааны актыг гаргах үйл ажиллагаанд оролцсон болон төрийн албан хаагчийн хувьд хууль тогтоомжоор хориглосон тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож болохгүй юм.

2. Энэ зүйд заасан хуулийн этгээдэд нэхэмжлэгч хувийн эрх зүйн хуулийн этгээд болон хуулийн 4 дүгээр зүйд заасан хариуцагч болох захиргааны байгууллага хамаарч байна.

Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус актын улмаас зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар нэхэмжлэл гаргасан хуулийн этгээд, мөн захиргааны хэрэгт хариуцагчаар татагдсан захиргааны байгууллагыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд:

- байгууллагын эрх баригч
- эрх баригчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн аль нэг төлөөлнө.

Байгууллагын эрх баригч хууль, эрх зүйн бусад акт болон үүсгэн байгуулах баримт бичгийн дагуу олгогдсон эрх хэмжээний хүрээнд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлнө.

Хариуцагч болох захиргааны байгууллагын эрх баригч нь хууль болон эрх зүйн бусад актаар олгогдсон эрх хэмжээний хүрээнд Захиргааны хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагаа төлөөлнө.

Жишээ нь: Хуулийн 4.1.3-т заасан Монгол Улсын яамыг Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 22.1-д зааснаар яамны сайд, 4.1.4-д заасан Монгол Улсын Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийг Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.9-т зааснаар агентлагийн дарга тус тус төлөөлнө.

Хариуцагч захиргааны байгууллагыг эрх баригчаас олгосон итгэмжлэлээр дурын хүн биш харин тухайн байгууллагын ажилтан төлөөлнө.

3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийн төлөөлөгчөөр оролцох байгууллагын эрх баригч нь өөрийн албан тушаал, эрх зүйн байдлыг тодорхойлсон баримтыг, итгэмжлэлээр оролцох ажилтан нь итгэмжлэлийг шүүхэд гаргаж өгнө.

Эдгээр баримт нь хэргийн оролцогчийн төлөөлөгчийн бүрэн эрхийг тодорхойлох тул нотлох баримтын хуульд заасан шаардлагыг хангасан байвал зохино.

Хуулийн этгээдийн төлөөлөгчөөр оролцох байгууллагын эрх баригч нь бие даасан оролцогч, харин түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд түүнд олгосон итгэмжлэлийн хүрээнд хуулийн этгээдийг төлөөлөх тул захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогч юм.

Иймээс захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт “Сангийн яамыг төлөөлж сайд ..., Сангийн яамыг төлөөлж, итгэмжлэгдсэн төлөөлөгч ...” гэж бичиж байвал зохимжтой.

4.Төлөөлөгчийн бүрэн эрхийг тодорхойлсон баримт болох итгэмжлэл нь Иргэний хуулийн 64.2-т заасан шаардлагыг хангасан байна. Итгэмжлэл нь итгэмжлэгчээс өөрийн нэрийн өмнөөс хууль зүйн тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх эрхийг нөгөө этгээдэд /итгэмжлэгдэгчид/ олгосноо бичгээр тодорхойлсон эрх зүйн хүчин чадал бүхий баримт бичиг юм.

Итгэмжлэлд тавигдах шаардлага:

- итгэмжлэлд төлөөлүүлэгч гарын үсэг зурсан байх
- хуулийн этгээдийн итгэмжлэлд эрх баригч гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан байх
- олгосон он, сар, өдрийг заах
- хуульд заасан бол нотариатаар гэрчлүүлэх
- итгэмжлэлийг тодорхой хугацаагаар олгох бол хугацааг заах шаардлагатай юм.

Шүүхийн практикт хуулийн этгээдийн эрх баригч ихэвчлэн тушаал гаргаж төлөөлөгчийг томилох, тодорхойлолт, албан бичиг зэргээр төлөөлөгчид итгэмжлэл олгосноо илэрхийлдэг бөгөөд төлөөлөгч чухам ямар эрх эдэлж, үүрэг хүлээхийг итгэмжлэлд нарийвчлан заах ёстой.

Итгэмжлэлд тусгагдаагүй эрх, үүргийг төлөөлөгч хэрэгжүүлсэн бол түүнийг тухайн үйлдэлд бусдыг төлөөлөх эрхгүй гэж үзнэ.

27 дугаар зүйл. Төлөөлөгчийн бүрэн эрх

- 27.1. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулна.
- 27.2. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлд тусгайлан заасан тохиолдолд дараахь эрх эдэлнэ:
 - 27.2.1. нэхэмжлэлийн өргөдөлд гарын үсэг зурах;
 - 27.2.2. нэхэмжлэлийг хүлээн авах;
 - 27.2.3. нэхэмжлэлийн шаардлагаас бүрэн буюу хэсэгчлэн татгалзах;
 - 27.2.4. нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх;
 - 27.2.5. эвлэрэх;
 - 27.2.6. захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг давж заалдах, эсхүл_хяналтын журмаар гомдол гаргах;
 - 27.2.7. төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлийг бусдад шилжүүлэх;
 - 27.2.8. захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах.

ТАЙЛБАР

1.Төлөөлөл нь төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад эрх зүйн туслалцаа үзүүлэх, нотлох баримт цуглуулах, тэдгээрийг судлахад нь шүүхэд туслах, хууль ёсны үндэслэлтэй зөв шийдвэр гаргуулах зорилготой юм. Төлөөлөгч нь төлүүлэгчээс олгосон эрх хэмжээний хүрээнд түүний эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалахын тулд бүх арга хэмжээг авах үүрэгтэй. Гагцхүү эдгээр арга хэмжээ нь хуулиар зөвшөөрөгдсөн хэлбэр, агуулга үндэслэлтэй байна. Тухайлбал: захиргааны тухайн маргааныг төлөөлүүлэгчид ашигтайгаар шийдвэрлэхийн тулд хууль зөрчсөн ямар нэг үйлдэл, жишээ нь: хуурамч нотлох баримт гаргаж болохгүй.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийг хэргийн оролцогч гэж, /16.1/ нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь захиргааны хэргийн бие даасан оролцогч бус зөвхөн бусад оролцогч байхаар /16.2, 54.1/ ангилж, хэргийн оролцогч буюу нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн эрх, үүргийг хуулийн 19, 20, 21 дүгээр зүйлд тодорхойлсон. Энэ нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйлд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийг хэргийн оролцогчид хамааруулж, тэдгээрийн эрх, үүргийг хуулийн 25 дугаар зүйлд адилтган зааснаас зарчмын ялгаатай.

2.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох төлөөлөгчийн бүрэн эрхийг ерөнхий болон тусгай эрх гэж хоёр хувааж авч үзэж болно. Төлөөлөгч нь зарим тодорхой эрхийг тухайлбал: Захиргааны хэргийн шүүхийн нотлох баримттай танилцах болон эсрэг талын шаардлага, тайлбар, шүүх хуралдааны үед бусад оролцогчид асуулт тавих, хүсэлт гаргах, шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах зэрэг эрхийг эдлэхгүйгээр захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлүүлэгчийн ашиг сонирхлыг хамгаалах боломжгүй. Иймээс эдгээр эрхийг ерөнхий эрхэд хамааруулна. Харин хуулийн 27.2-т заасан тусгай эрхүүд, өөрөөр хэлбэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны объектод шууд хамаарах эрхийг тухайлбал: нэхэмжлэлийн өргөдөлд гарын үсэг зурах, нэхэмжлэлийг хүлээн авах зэрэг эрхийг зөвхөн итгэмжлэлд тусгайлан заасан тохиолдолд төлөөлөгч хэрэгжүүлэх боломжтой болох юм. Гэхдээ

- нэхэмжлэлийн шаардлагаас бүрэн буюу хэсэгчлэн татгалзах, /27.2.3/
- нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх, /27.2.4/
- эвлэрэх, /27.2.5/
- захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргах /27.2.6/ зэрэг эрхүүд нь хуулийн 19.1.1, 19.1.6, 20.1.2, 20.1.5-д заасан үндсэн эрхүүдтэй давхцаж байгааг анхаармаар байна. Төлөөлөгчийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлахгүйн тулд төлөөлүүлэгч этгээд нь хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцохооргүй бол төлөөлөгчийн бүрэн эрхийг нэлээд өргөн хэмжээтэй байхаар тодорхойлох нь зүйтэй.

2.2. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлд “итгэмжлэлийг бусдад шилжүүлэх эрх”-ийг олгосон тохиолдолд энэ эрхийг эдэлнэ. Гагцхүү итгэмжлэлийг бусдад шилжүүлэхдээ төлөөлүүлэгчид мэдэгдэж, түүний зөвшөөрлийг заавал авсан байвал зохино. Энэ талаар “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” Улсын Дээд шүүхийн 2006 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 37 дугаар тогтоолын 10-д тайлбарлажээ.

Төлөөлүүлэгч өөрийн олгосон итгэмжлэлийг шилжүүлэн авах гуравдагч этгээдийг хүлээн зөвшөөрөөгүй нь төлөөлөгчөөсөө татгалзсан байдалд хүргэх тул энэ тухай шүүхэд даруй мэдэгдэнэ. Төлөөлүүлэгч өөрийгөө төлөөлөх этгээдийг өөрөө мэдэж сонгоно.

2.3. Төлөөлөгч Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхээ шүүхэд бичгээр хүсэлт гаргах замаар хэрэгжүүлнэ.

28 дугаар зүйл. Төлөөлөн оролцож болохгүй байдал

- 28.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг 18 насанд хүрээгүй болон эрх зүйн зарим буюу бүрэн чадамжгүй этгээд төлөөлөн оролцож болохгүй.
- 28.2. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар, эсхүл ажиллаж байгаа байгууллагаа төлөөлөн тухайн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагаанд оролцож байгаагаас бусад тохиолдолд шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч.

ТАЙЛБАР

1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгчөөр оролцож болохгүй этгээдийг хуульд тодорхой тусгажээ.

- Эрх зүйн бүрэн бус чадамжтай буюу 14-өөс 18 нас хүртэлх насны этгээд
- Эрх зүйн зарим чадамжтай буюу 7-оос 14 хүртэлх насны этгээд
- Эрх зүйн бүрэн чадамжгүй буюу 7хүртэлх насны хүүхэд, сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон этгээд нь бусдаар төлөөлүүлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог тул тэдгээр нь бусдыг төлөөлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжгүй юм.

2.Шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгчөөр оролцох боломж нь хуулиар хязгаарлагдсан байна. Тэдгээр нь зөвхөн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар бусдыг төлөөлж болно.

Хуулийн 4.3-т “Шүүх, прокурорын байгууллага, түүнчлэн эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын байцаан шийтгэх, эсхүл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу явуулсан үйл ажиллагааны талаар иргэн, хуулийн этгээдээс шүүхэд гаргасан гомдлыг эрүүгийн болон иргэний хэргийн шүүх хянан шийдвэрлэнэ” гэж заасан тул эдгээр нь Захиргааны хэргийн шүүхийн хариуцагч болохгүй нь ойлгомжтой байна.

Харин дээрх байгууллагуудын захиргааны үйл ажиллагаатай холбоотой нэхэмжлэлд шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар ажиллаж байгаа байгууллагаа төлөөлж болохыг хуулиар зөвшөөрсөн байна. Энэ тохиолдолд эдгээр албан тушаалтан хуулийн этгээдийг төлөөлөх хэлбэрээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно.

29 дүгээр зүйл. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох

- 29.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч гэрээний үндсэн дээр аль нэг талыг төлөөлөн оролцож болно.
- 29.2. Талууд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд өмгөөлөгчийн туслалцаа авч болно.
- 29.3. Тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн бүрэн эрх нь хууль зүйн туслалцаа авч байгаа талын хүсэлтээр тодорхойлогдоно.
- 29.4. Өмгөөлөгч нь захиргааны хэрэг хянан хэлэлцэхэд гэрээгээр оролцохдоо Өмгөөллийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

ТАЙЛБАР

1. Өмгөөллийн үйл ажиллагаа нь гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийг төлөөлөх төлөөллийн нэг хэлбэр юм. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцуулах хүсэлтийг эрх зүйн туслалцаа авч байгаа тал буюу хэргийн оролцогч гаргах ба өөрийн өмгөөлөгчид итгэмжлэл гаргаж өгсөн байна.

Өмгөөлөгчид олгосон итгэмжлэл нь Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2-т заасан шаардлагыг хангасан ямар эрх, үүргийг өмгөөлөгчид олгож байгааг тусгайлан заасан байвал зохино. Хэрвээ хэргийн оролцогч өмгөөлөгчид өөрийгөө бүрэн төлөөлөх эрх олгож байгаа бол өмгөөлөгч хэргийн оролцогчийг бүрэн төлөөлнө.

2. Өмгөөлөгч нь захиргааны хэргийн урьдчилан шийдвэрлэх шат болон Захиргааны хэргийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд оролцож болно.

3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эдлэх эрх, үүрэг нь эрх зүйн туслалцаа авч буй этгээд буюу хэргийн оролцогчийн /үйлчлүүлэгчийн/ эрх, үүргээс үүдэлтэй байдаг. Тухайлбал: үйлчлүүлэгч нь тодорхой хүсэлт гаргасан тохиолдолд л өмгөөлөгч давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй байна.

4. Өмгөөлөгч өөрийн үйл ажиллагааг энэ хуульд болон Өмгөөллийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу явуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Нотлох баримт

30 дугаар зүйл. Нотлох баримт

30.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нотлох баримтыг ойлгох, гаргаж өгөх, цуглуулах, үнэлэхдээ энэ хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37, 40-45, 47-49, 51 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

ТАЙЛБАР

Монгол улсад Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль үйлчилж 80 гаруй жил болохдоо цаг үеийн шалгуурууд үзэл баримтлалыг дагаж, нэлээд боловсронгуй болсон хуулиуд юм. Тиймээс хууль тогтоогч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хэрэглэж болох Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим бүлэг, зүйл, хэсгийг авч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд суулгаж өгсөн байна.

Эрүүгийн, иргэний, захиргааны эрх зүйн нотолгоо гэдэг ухагдахуун нь үндсэндээ адил агуулгатай тул Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нотлох баримтыг ойлгох, гаргаж өгөх, цуглуулах, үнэлэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 /Нотлох баримт/, 40 /нотлох баримтыг үнэлэх/, 41 /шүүхийн даалгавар түүнийг биелүүлэх/, 42 /зохигчийн тайлбар/, 43 /Гэрчийн мэдүүлэг/, 44 /бичмэл нотлох баримт/, 45 /эд мөрийн баримт/, 47 /Шинжээч, түүний эрх, үүрэг, шинжээчийн дүгнэлт/ 48 /хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон бусад ажиллагаа/, 49 /орчуулагч, хэлмэрч/, 51 /тэмдэглэл/ дүгээр зүйлд заасан журмыг баримтална гэж хуульчилсан.

Нотлох баримтыг ойлгох, гаргаж өгөх, цуглуулах, үнэлэх асуудал нь захиргааны хэргийн шүүхийн оролцогчид болон шүүх, шүүгчийн үйл /процедур/ ажиллагаандаа баримталбал зохих горим. Харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37, 40-45, 47-49, 51 дүгээр зүйлүүд нь нотлох баримтын төрлийг тус тусад нь тодорхойлсон хууль зүйн шинжлэх ухааны онолын шинжтэй ойлголт. Энэ хоёр нийлж шүүхийн нотолгоо гэсэн цогц ойлголтыг илэрхийлж байгаа хэрэг. Тэгэхээр юуны өмнө шүүхийн нотолгооны талаар авч үзэх хэрэгтэй болно. Дараа нь нотлох баримтыг ойлгох, гаргаж өгөх, цуглуулах, үнэлэх асуудал гарч ирж байна. Мэдээж нотлох баримт байж гэмээ нь нотлох баримтыг цуглуулах, олж авах, үнэлэх тухай яригдах тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37, 40-45, 47-49, 51 дүгээр зүйлээс эхлэн тайлбарлах нь зүйтэй гэж үзсэн болно.

Үүнээс гадна нотлох баримтын тухай ойлголт, нотолгооны хэрэгслийн талаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйл болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40-45, 47-49, 51 дүгээр зүйлд, захиргааны хэргийн нотлох баримтыг гаргаж өгөх, цуглуулах үүргийн болон нотлох баримтад тавигдах шаардлагын талаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасан тул, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30, 31 дүгээр зүйлийн дарааллыг иш үндэс болгож байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-ийн “Шүүх хэргийн оролцогчдын гаргасан нотлох баримтыг ... үнэлнэ” гэсэн нь захиргааны хэргийн шүүх нотлох баримтыг өөрөө цуглуулах, бүрдүүлэх, үнэлэх зарчим /үүрэг/- тай нь зөрчилдөх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 42 дугаар зүйлийн “зохигчийн тайлбар” гэсэн нэр нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Хэргийн оролцогчдын тайлбар” гэсэн томъёололтой нийцэхгүй байх, хоёр өөр хуулийн адил төрлийн заалтуудын санаа нь хууль тус бүртээ давхардсан, аль нэг хуулийн заалт нөгөө хуулийн хэд хэдэн зүйл, заалтад хуваагдсан, эсхүл зарим харилцаа аль алинд нь шууд зохицуулагдаагүй байдаг тул байхгүй заалтыг нөгөө хуулиас авах, сонгон хэрэглэхэд бэрхшээл гарна. Тэгэхээр ишлэл болгон хэрэглэх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт, нэр томъёог шууд утга, агуулгаар нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх боломжгүй байгаа юм.

Ийм учраас Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-дэх хэсэгт "... энэ хуульд өөрөөр заагаагүй бол ..." гэж тодотгож өгснийг үндэслэн ишлэл авч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалтуудыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлалд нийцүүлж, захиргааны байгууллага, албан тушаалтан, иргэд, хуулийн этгээдэд ойлгомжтой байх үүднээс тайлбар хийлээ.

Захиргааны хэргийн шүүхийн нотолгоо ба
нотлох баримтын тухай ойлголт.

Нотолгоо бол хүн төрөлхтний өдөр тутам хэрэглэдэг танин мэдэхүйн үйл ажиллагааны нэг төрөл боловч практикт танин мэдэхүйн үйл явц нь аяндаа урган гарч тодорхой зорилго агуулсан байдаг. Тэгвэл шүүхийн нотолгоо нь бодит үнэнийг тогтоох, аливаа хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэх зорилготой танин мэдэхүйн үйл ажиллагаа юм.

Нотлох баримт гэсэн ойлголт нь нотолгооноосоо урган гарсан хууль зүйн нэр томьёо. Энэ утгаар нь авч үзвэл нотолгоо амьдралын явцад хэрэгждэг байхад нотлох баримт бол хуульд заасан хүрээнд бий болдог хууль зүйн шинжлэх ухааны ойлголт.

ХБНГУлсын хуульч эрдэмтэн Юпп Ёоахимски "Нотлох баримтаар зөвхөн бодит нөхцөл байдлыг л тогтоож болно. Харин эрх зүйн дүгнэлт, үзэл санаа нь нотлох баримтын зүйл болдоггүй" гэж нотлох баримт анхдагч, түүнийг үнэлэх нь хоёрдогч гэдгийг томьёолж ач холбогдлыг маш товчоор үнэлсэн нь бий¹.

Захиргааны хэргийг хуульд нийцүүлэн, зөв шийдвэрлэх үндсэн нөхцөл нь шүүх тухайн хэргийн нотлогдвол зохих байдлыг зөв тодорхойлж, нотолгооны хэрэгслүүд болон хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, хуулиар зөвшөөрөгдсөн² хуульд заасан арга журмаар олж авсан нотлох баримтуудыг бүрэн цуглуулж, түүнд хууль зүйн үндэслэлтэй дүгнэлт хийх явдал юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрт гаргах шүүхийн аливаа шийдвэрүүд гагцхүү нотлох баримтад тулгуурладаг тул шүүхийн нотолгоо нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зорилтыг хангах хэрэглүүр болоод

¹ Монгол Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар. Мюнхен хот. 2004 он, хуудас 68 дугаар тал

² Монгол Улсын Дээд шүүхийн 7 дугаар сарын 3-ны өдрийн 33 дугаар тогтоол

³ Д.Баярсайхан "Эрх зүйн онол" УБ хот 2000 он

зогсохгүй, эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх үндсэн арга нь болдог билээ.

Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг тогтоох зорилгоор нотлох баримтыг цуглуулж, шинжлэн судалж, үнэлж байгаа шүүхийн болон хэргийн оролцогчдын хамтын үйл ажиллагааг захиргааны хэргийн шүүхийн нотолгоо гэж тодорхойлж болно. Шүүхийн нотолгоо нь:

1. нотолгооны зүйл,
2. нотолгооны хэрэгсэл,
3. нотлох баримт гэсэн ойлголтуудаас бүрдэх бөгөөд эдгээр нь шинжлэх ухааны бие даасан ухагдахуун боловч бие биенээ тодорхойлдог өөр хоорондоо харилцан хамааралтай танин мэдэхүйн шинжтэй бодит үйл ажиллагаагаар дамжин хэрэгждэг үйл явц юм.

Эрх зүйн тулгуур баримтуудад нотолгооны зүйлийг “нотлогдвол зохих зүйл” гэж үзсэн байдаг³.

Иргэний хэргийн хувьд нэхэмжлэлийн шаардлага, хариуцагчийн татгалзлын үндэслэлийг тодорхойлж байгаа нөхцөл байдлууд буюу зохигчдын хооронд байгуулсан гэрээ, хэлцэл, үүрэг үүсгэсэн гэм хор, өв залгамжлах зэрэг тэгш эрхийн үндсэн дээр хэрэгжих байдлууд нь нотолгооны зүйл буюу нотлогдвол зохих зүйл болдог.

Тэгвэл захиргааны хэргийн нотолгооны зүйл буюу нотлогдвол зохих зүйл нь зөвхөн нэхэмжлэлийн шаардлагад хамаарах маргаан бүхий захиргааны акттай⁷⁷ холбоотой үйл баримтууд байна. Захиргааны хэргийн шүүхийн үндсэн ажил бол захиргааны актын хууль зүйн үндэслэлийг хянахад чиглэдэг болохоор нэг төрлийн нотолгооны зүйлтэй ажилладаг гэж үзэж болохоор байна.

Захиргааны акт нь тушаал, захирамж, албан шаардлага, дүгнэлт, шийдвэр, дүрэм, заавар, үйлдэл, эс үйлдэхүй гэх мэт олон хэлбэртэй байх бөгөөд үр дагавраасаа хамаарч нотолгооны зүйл нь өөр, өөр агуулгатай байна. Тухайлбал, захиргааны актыг хүчингүй болгуулах, илт хүчин төгөлдөр болохыг хүлээн зөвшөөрүүлэх, актыг өөрчлүүлэх, төлбөрийг багасгуулах гэх мэт.

Захиргааны хэргийн нотолгооны зүйл болох үйл баримт гэдэгт:

1. Нэхэмжлэлд дурьдагдсан шаардлагын үндэслэл болж байгаа үйл баримт;
2. Хариуцагчийн татгалзлын үндэслэл болж байгаа үйл баримт;
3. Сөрөг нэхэмжлэлийн үндэслэл болж байгаа үйл баримт;
4. Бие даасан шаардлага гаргаж байгаа гуравдагч этгээдийн шаардлагын үндэслэл болж байгаа үйл баримт зэрэг багтана.

⁴ “Захиргааны акт” гэж нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар захиргааны байгууллага, албан тушаалтнаас амаар буюу бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон эрх зүйн үр дагавар шууд бий болгодог нэг удаагийн захирамжилсан үйл ажиллагаа; Энэ хуулиар захиргааны байгууллагын хэм хэмжээ тогтоосон шийдвэр /тогтоол, дүрэм, заавар, журам/-ыг захиргааны актад хамааруулна.

Нотолгооны зүйлээ зөв оновчтой тодорхойлохын тулд юуны өмнө нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн санаа зорилго, нэхэмжлэлийн шаардлага, хариуцагчийн тайлбар, татгалзал, гуравдагч этгээдийн шаардлага, гомдлын утга агуулгыг сайтар судлахын зэрэгцээ тэдгээрийг харьцуулж үзэх нь чухал ач холбогдолтой. Нотлогдвол зохих зүйлээ зөв тогтоох нь хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, зайлшгүй шаардлагатай нотолгооны хэрэгслийг олох, цуглуулахад дөхөмтэй болохын дээр хэрэглэгдвэл зохих хуулиа тодорхойлох, хэргийг шуурхай, үнэн зөв шийдвэрлэх урьдчилсан нөхцөл нь болно. Энэ сэдвийн дор захиргааны хэргийн нотолгооны хэрэгсэл гэсэн ойлголтыг товч дурьдах нь зүйтэй болов уу. Нотолгооны хэрэгсэл гэсэн ойлголт нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой тусгагдаагүй, онолын шинжтэй ойлголт юм.

Нотолгооны хэрэгсэл нь өөрөө шууд нотлох баримт болдоггүй бөгөөд танин мэдэхүйн үйл явцын үр дүнд баримтат мэдээлэл буюу нотлох баримт болдог. Хэрэгт цугларсан үйл баримт бүхэлдээ нотолгооны хэрэгсэл болно.

Хэргийн оролцогч /нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд/-дийн нэхэмжлэл, тайлбар, гомдол, хүсэлт болон түүнд хавсаргаж ирүүлсэн бичмэл баримт, нотолгоо болгосон кино ба гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэг, бусад зүйлс, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх санаачилгаараа эсхүл хэргийн оролцогчдын хүсэлтээр олж цуглуулсан бичмэл болон эд мөрийн баримт, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, шүүхийн үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааны болон шүүх тэмдэглэл зэргийг захиргааны хэргийн нотолгооны хэрэгсэл гэж үзнэ.

Нотолгооны хэрэгслийг түүний хэлбэр, агуулгаас нь хамаарч:

1. Нэхэмжлэгч, хариуцагч гуравдагч этгээд тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн тайлбарууд.
2. Гэрчийн мэдүүлэг;
3. Бичмэл баримт;
4. Эд мөрийн баримт;
5. Шинжээчийн дүгнэлт;
6. Шүүхийн даалгавар;
7. Тэмдэглэл;
8. Нотолгооны бусад хэрэгслүүд гэж ангилна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйл.

Нотлох баримт

- 37.1. Хэргийн оролцогчоос өөрийн шаардлага ба татгалзлаа үндэслэж байгаа, шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, хуульд заасан арга хэрэгслээр олж авсан бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ.

37.2. Хэргийн нотлох баримт нь зохигч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээдийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл ба эд мөрийн баримт, эсхүл баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, кино ба гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэг, ул мөрнөөс буулгаж авсан хэв, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг нотолгооны хэрэгслээр тогтоогдоно.

ТАЙЛБАР

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтаас үзвэл иргэний хэргийн нотлох баримт гэсэн ойлголтоос захиргааны хэргийн нотлох баримтын талаарх ойлголт нь нэг талаар өргөн нөгөө талаар явцуу ойлголт гэж үзэж болохоор байгаа юм.

Захиргааны хэргийн нотлох баримтыг олох, цуглуулах, бүрдүүлэх ажиллагаанд хэргийн оролцогчдоос гадна шүүх өөрийн санаачилгаар болон оролцогчдын хүсэлт, шаардлагаар оролцох үүрэг хүлээдгийн дээр захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хэргийн оролцогчид анхан шатны шүүхэд хэлэлцэгдээгүй шинэ нотлох баримт гаргаж өгөх эрх нээлтэй байдаг онцлогтой тул өргөн ойлголт гэж үзэж байгаа юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нотлох баримт нь тодорхой эрх бүхий субъект /Захиргааны байгууллага, албан тушаалтан гэх мэт/-ийн гаргасан зөвхөн маргаан бүхий захиргааны актын гаргах болсон шалтгаан, түүний мөн чанар, агуулга, үр дагаврыг тогтооход чиглэгддэг тул явцуу хүрээнд хийгдэх ажиллагаа гэж үзсэн болно.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30, 31, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлд “нотолгооны хэрэгсэл” гэсэн ухагдахуун үндсэндээ тусгагдаагүй, зөвхөн “нотлох баримт” гэсэн нэр томъёог хэрэглэсэн. Тэгэхээр нотолгооны хэрэгслийг гаргах, илрүүлэх буюу заах, олж авах, цуглуулах, судалж шалгах гэсэн ойлголтуудаас нотлох баримтад тавигдах шаардлагыг хангасан, шүүх, шүүгч үнэлэх боломжтой нотлох баримтыг ялгамжтай авч үзэх шаардлагатай. Нотолгооны хэрэгслийг ашиглан шүүхийн нотлох баримтыг тогтоодог тул нотлох баримт, нотолгооны хэрэгсэл гэдэг ойлголтуудыг нэгэн зүйл мэтээр ойлгож болохгүй. Иймээс юуны өмнө тэдгээрийн харилцан хамаарлыг авч үзэх нь чухал.

Хэргийн оролцогчдоос ирүүлсэн болон шүүхийн шаардаж гаргуулсан баримт материал нь нотлох баримт, нотолгооны хэрэгслийн “цуглуулга” юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн “Хэргийн нотлох баримт нь ... нотолгооны хэрэгслээр тогтоогдоно” гэсэн заалт нь дээрх хоёр ойлголтын ялгаатай гэдгийг нотолсны дээр харилцан хамаарлыг нь хуульчилсан заалт юм.

Нөгөө талаар мөн зүйлийн 1 дэх хэсэгт “ ... шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, хуульд заасан арга хэрэгслээр олж авсан бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ” гэж

нотлох баримтад тавигдах шаардлагыг тодорхойлжээ. Энд дор дурьдсан шалгуурыг хуульчилжээ.

Шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байх. Нотлох баримт нь захиргааны тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд шууд хамааралтай, зайлшгүй ач холбогдолтой байх ёстой. Хэргийн оролцогчид олон хуудас, их л материал байвал нотолж байна гэсэн хандлагатай байдаг. Тэгвэл шүүхэд ач холбогдолтой байх нь чухал. Хэргийн бодит нөхцөл байдлыг тогтооход ач холбогдолтой л бол хэрэгт цугларсан нотолгооны хэрэгсэл бүгдээрээ нотлох баримт болж чадах магадлал өндөр байдаг. Гэхдээ ач холбогдолтой боловч тухайн хэрэгт хамааралгүй, хуульд заасан арга, журмаар олж аваагүй байхыг үгүйсгэх аргагүй.

Ер нь нотлох баримтын хууль ёсны үндэслэлийг зөвхөн хэлбэршүүлсэн талаас нь хандаж өрөөсгөл дүгнэлт хийж болохгүй. Магадгүй хуульд заасан журам, шаардлагыг хангасан */Нотариатаар гэрчлүүлсэн гэх мэт/* боловч хууль бус арга замаар */Тулган шаардах, залилан мэхлэх гэх мэт/* олж авсан, бодит биш */Хуурамч гэх мэт/* баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон байх явдал гардаг. “Цуглуулга” дотор маань хуулиар зөвшөөрөгдөөгүй, тухайн хэрэгт хамааралгүй баримт байж л байдаг. Эдгээрийг нотлох баримтыг шинжлэн судлах, үнэлэх явцад нотлох баримтаас хасах, гаргаж өгсөн этгээдэд нь эгүүлэн өгөх замаар шийдвэрлэж, шүүх гагцхүү нотлох баримтын шаардлага хангасан баримттай үлдэж, түүнийгээ үнэлэх учиртай. Энд л нотлох баримт, нотолгооны хэрэгсэл гэдэг ойлголтуудын зааг ялгаа, харилцан хамаарал нь харагдах болно.

Тухай хэрэгт ач холбогдолгүй нотолгооны хэрэгслийг нотлох баримтаас хасах, үнэлэхгүй байх, буцаах, гаргаж өгсөн этгээдэд нь эргүүлж өгөх талаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйлд зохицуулалт бий. Шүүх ач холбогдолгүй нотолгооны хэрэгслээс татгалзах үүрэгтэй.

Нотлох баримтын ач холбогдлын тухайд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе, шатанд шүүгч үнэлгээ өгч явдаг бичигдээгүй хууль үйлчилдэг. Энэ үнэлгээ нь нотлох баримтыг үнэлэх гэдэг ойлголт биш харин нотолгооны хэрэгсэлд өгч байгаа үнэлэлт, дүгнэлт. Үүнийг Захиргааны хэрэг хянан шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар нээлттэй болгож өгсөн юм. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогоос хамааралтайгаар оролцогчдын гаргасан баримтуудад шүүгч үнэлгээ өгөөд хангалтгүй гэж үзвэл тухайн хэрэгт зайлшгүй ач холбогдолтой нотлох баримтыг хайж эхэлнэ. Нотлох баримт шүүхээр олуулах, гаргуулах тухай оролцогчдын хүсэлт болгоныг хүлээж авах албагүй. Харин энэ хүсэлтээр тавьж байгаа шаардлага нь ач холбогдолтой юу гэдгийг анхаарах хэрэгтэй.

Хуульд заасан арга хэрэгслээр олж авсан байх. Хэргийн оролцогчоос гаргасан, цуглуулсан баримт хуульд заасан арга хэрэгслээр олж авсан байхын дээр шүүхээр нотлох баримтыг гаргуулах шаардлага ч хуулийн хүрээнд байвал зохино. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүх хэргийн оролцогчдын хүсэлт, шаардлагаар болон өөрөө санаачилгаараа нотлох баримтыг олох, цуглуулах үүрэг

хүлээдэг болохоор тэр ажиллагаа нь мөн л хуульд заасан арга, журмыг баримталсан байх ёстой.

"Арга хэрэгсэл" гэж хөндлөнгийн этгээдийг оролцуулсан шүүхийн үзлэг, туршилт, таниулан олуулах ажиллагаа нь тэмдэглэлтэй, түүнд оролцсон этгээдүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байх, хууль сануулж гэрчийг байцаах, архивын лавлагааг эрх бүхий этгээдээс гаргуулах, криминалистикийн аргаар нотолгооны хэрэгслийг бэхжүүлэх, баримтыг нотариатаар батлуулах, шүүгчийн захирамжаар шинжээч томилж дүгнэлт гаргуулах, нотлох баримтыг цуглуулах, гаргуулах, олуулах талаар өөр орон нутгийн шүүхэд хугацаатай даалгавар өгч түүнийхээ биелэлтийг авах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчид эрүүгийн болон иргэний хэрэгт цугларуулсан шийдвэрийн үндэслэл болгосон баримт зэрэг хуульд заасан шаардлага, дараалал, хэлбэр, агуулгад нийцүүлсэн үйлдэл, үйл ажиллагааг ойлгоно.

Орчин үед хэргийн оролцогчид баримт материалыг шинээр хийх, үйлдвэрлэх, хуулбарлах, олшруулах, өөрчлөх, засварлах техникийг өргөнөөр ашиглаж хуурамч нотолгоо гаргах, шүүхийн шийдвэрийг өөрт ашигтай гаргуулахын тулд бусдыг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх, айлган сүрдүүлэх, дарамтлах, цахим шуудан, интернэт, факс, диктафон, телевиз, CD-ний аливаа мэдээллийг нотолгоо болгох, зарим нотариатч нар ямар ч хяналтгүйгээр шинээр хийсэн, хуулбарласан, өөрчилсөн, засварласан баримтыг баталгаажуулах зэргээр хууль бус арга, хэрэгслэл ашиглах явдал ихсэж байна.

Иймд шүүгч хуульд заасан арга хэрэгслэлээр олж авсан нотлох баримт мөн эсэхийг нарийн шалгах, бусад нотолгооны хэрэгслэлээр давхар батлах шаардлага гарна.

Тухайн хэрэгт хамааралтай байх. Нотолгооны хэрэгсэл нь нэхэмжлэлийн зүйл, хариуцагчийн тайлбар, гуравдагч этгээдийн гомдол шаардлагын аль нэгийг нотолсон эсхүл үгүйсгэсэн шинжтэй байх ёстой. Тэгэхлээр нэг хэргийг шийдвэрлэхийн тулд шүүгч хэргийн нөхцөл байдлыг тогтоож чадах маш олон үйл баримтыг цуглуулна. Тэр цугларсан баримтууд бүгдээрээ тухайн хэрэгтэйгээ шууд ба шууд бусаар хамааралтай, ач холбогдолтой байх ёстой.

Нотлох баримтын хамаарал гэж тухайн захиргааны хэргийн үйл явдлын талаар мэдээлэл өгч чадах нотлох баримтын чадварыг хэлнэ.⁷⁸

Ямар нэг нотолгооны хэрэгсэл нь хэргийн нөхцөл байдалтай шалтгаант холбоо байхгүй бол түүнийг хэрэгт хамааралгүй гэж үзэж гаргаж өгсөн этгээдэд нь буцаан өгөх, нотлох баримтаас хасах тухай шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед шийдвэрлэнэ. Ингэхдээ тайлбарлаж ойлгуулах нь чухал.

Хэрэгт хамааралтай, хамааралгүй гэдгийг шууд урьдчилан тогтооход бэрхшээл бий. Тийм учраас нотлох баримтыг шалгах, үнэлэх явцад нотлох баримтын хамаарлыг тогтоох нь илүү үр дүнтэй. Ер нь нотлох баримт тухайн хэрэгт хамааралтай эсэхийг эхэлж шалган тогтоосны дараа ач холбогдлыг нь үнэлдэг.

Хэргийн бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай байх. Хэрэгт ач холбогдолтой, хуульд заасан арга журмаар олж авсан баримт зөвхөн нэг л зүйлийг

⁷⁸ А.Эрдэнэцогт Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй 2006 он. 180 дахь тал

тогтооход хангалттай байж болно. Тэгвэл бодит байдал /үнэнийг/-ыг тогтоох чадвартай, шүүхийн эцсийн шийдвэрийн агуулгыг тодорхойлж чадахуйц олон төрлийн нотлох баримт шүүхэд заавал хэрэгтэй. Шүүх бодит үнэнийг л тогтоох үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлэх арга зам нь тухайн хэрэгт гарцаагүй шаардлагатай нотлох баримтыг заавал олж авсан байх явдал юм. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар мөрдөн шалгах эрхийг Захиргааны хэргийн шүүхэд олгосон явдал бол энэ шаардлагыг хангах бололцоог бүрдүүлсэн ач холбогдолтой. Үүнээс үүдэн шаардлагагүй нотолгооны хэрэгслэлийг хасах, үнэлэхгүй байх гэсэн ойлголт гардаг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн
41 дүгээр зүйл. Шүүхийн даалгавар, түүнийг биелүүлэх

- 41.1. Шийдвэрлэж байгаа хэргийн талаар өөр орон нутгаас нотлох баримт бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байвал зохигчийн хүсэлтийг үндэслэн, шүүгч захирамж гарган тодорхой ажиллагаа гүйцэтгэхийг зохих шүүхэд даалгана.
- 41.2. Энэ хуулийн 41.1-д заасан захирамжид хэргийн товч агуулга, бүрдүүлбэл зохих нотлох баримтыг зааж, даалгавар биелүүлэх хугацааг тогтооно.
- 41.3. Шүүхийн даалгавар хүлээн авсан шүүх түүнийг тогтоосон хугацаанд заавал биелүүлнэ.
- 41.4. Шүүхийн даалгавар биелүүлэхэд хөтөлсөн тэмдэглэл, бүрдүүлсэн бүх материалыг хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүхэд тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

ТАЙЛБАР

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 41 дүгээр зүйлүүд давхардсан шинжтэй адил төрлийн заалттай юм.

Захиргааны хэргийн шүүхэд хэлэлцэгдэх хэргийн талаар өөр орон нутаг болон гадаад улсаас нотлох баримт гаргуулах шаардлагатай гэж шүүх үзвэл Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4-т зааснаар тодорхой ажиллагаа гүйцэтгэж ирүүлэхийг харьяалах шүүхэд даалгана. Шүүхийн даалгавар хүргүүлэх, түүнийг биелүүлэх ажиллагааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 39, 41 дүгээр зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийг ишлэл болгон хэрэглэхээр заагаагүй ч хилийн чанадад захиргааны хэргийн шүүхийн даалгавар гүйцэтгэх ажиллагааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлд зааснаар гүйцэтгэнэ гэж ойлгох нь зүйтэй. Шүүхийн даалгавар биелүүлсэн тэмдэглэл, ирүүлсэн материал нь нотолгооны хэрэгсэл болно.

Нотлох баримтыг өөр аймаг, хот, дүүргийн шүүх, гадаад орны шүүх болон эрх бүхий этгээдээр бүрдүүлэх нэг угтвар нөхцөл нь тухайн хэргийн зохигчийн гаргасан хүсэлт эсхүл захиргааны хэргийн шүүхийн санаачилга юм. Нөгөө талаар шүүхийн даалгавраар бүрдүүлбэл зохих нотлох баримт нь хэргийг үндэслэл бүхий шийдвэрлэхэд ач холбогдолтой, уг нотлох баримтыг бүрдүүлж үнэлэлт өгөх зайлшгүй шаардлагатай байх учиртай.

Шүүхийн даалгаврыг шүүгчийн захирамжаар бусад шүүхэд даалгасан хэлбэрээр өгнө. Захирамжид хэргийн товч агуулга, бүрдүүлбэл зохих нотлох баримт, даалгаврыг гүйцэтгэх хугацааг тус тус заана.

Хэргийн товч агуулга гэдэгт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн нэхэмжлэл, тайлбар, гомдлын агуулгыг тусгана. Энэ нь шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсгийн агуулгатай адил байдлаар бичигдэнэ гэсэн үг. Түүнчлэн холбогдох нэхэмжлэл, хариуцагчийн тайлбар, бусад материалуудыг хуулбарлан хүргүүлж болно.

Даалгавар гүйцэтгэх шүүх хэргийн талаар хэдий чинээ хангалттай мэдээлэлтэй байна тэр хэмжээгээр даалгавар чанартай биелэгдэнэ. Бүрдүүлбэл зохих нотлох баримтыг заахдаа ямар нотлох баримт бүрдүүлэх, хаанаас, хэнээс, ямар арга замаар, хэрхэн бүрдүүлэх, энэ нь хэрэгт ямар ач холбогдолтой болохыг тусгана. Ингэж тодорхой заах нь даалгаврыг шаардлагын хэмжээнд биелүүлэх урьдчилсан нөхцөл болно.

Хэргийн талаар тодорхой мэдээлэл өгөхгүй, дан шүүгчийн захирамж явуулдгаас нотолгооны шаардлага хангахгүй “чанаргүй” баримт ирдгийг анхаарах хэрэгтэй.

Даалгавар биелүүлэх хугацаа нь даалгавар биелүүлэх шүүхэд даалгасан ажиллагааг тухайн хугацаанд гүйцэтгэх боломжтой хугацаа байх нь зүйтэй. Нөгөө талаар хэргийг хуулийн хугацаанд нь хянан шийдвэрлэхэд анхаарч хугацааг тогтооно.

Шүүхийн даалгавар хүлээн авсан шүүх түүнийг шүүгчийн захирамжид тогтоосон хугацаанд заавал биелүүлнэ. Иймээс даалгавар хүлээн авсан шүүх нь түүнд заагдсан нотлох баримтын бүрдүүлэх цаг хугацааг тогтоож, хугацаанд нь биелүүлэх арга хэмжээ авах үүрэгтэй. Даалгаврыг зөвхөн хугацаанд нь биелүүлэх төдийгүй бүрдүүлсэн нотлох баримт нь шаардлага хангасан, захирамжид заасан ажиллагааг бүрэн гүйцэтгэсэн, хуульд заасан арга хэлбэрээр бүрдүүлсэн байх шаардлагатай.

Даалгаврыг хүлээн авч биелүүлсэн шүүх түүнийг хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүхэд тогтоосон хугацаанд хүргүүлэхдээ шүүхийн даалгаврыг биелүүлсэнтэй холбоотой бүх материалыг хавсаргана. Хилийн чанадад буй нотлох баримт нь захиргааны хэргийг хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий шийдвэрлэхэд зайлшгүй ач холбогдолтой баримт байх учиртай.

Нөгөө талаар шаардлагатай нотлох баримт гадаад улсад байгаа бөгөөд түүнийг хэргийн оролцогчид Монгол улсын шүүхэд авч ирэх боломжгүй байх, гадаадад байгаа нотлох баримт түүний батлагдсан хувь, хуулбарыг өөрөө гаргах, цуглуулах эрх зүйн боломжгүй зэрэг нөхцөлд шүүхийн даалгавраар гүйцэтгүүлэх хэрэгтэй. Гадаадад гүйцэтгэх ажиллагаа нь шүүх өөрөө эсхүл эрх бүхий байгууллагаар дамжуулах гэсэн хоёр арга замаар хийгдэнэ. Гэхдээ энэ хоёр аргын аль аль нь тухайн улсын зохих байгууллагад хандана гэсэн үг юм.

Шүүх, өөрөө нотлох баримтыг бүрдүүлэх талаар гадаад улсын зохих байгууллагад хандаж болох үндэслэл нь:

- Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд энэ тухай заасан;
- Хоёр улсын хооронд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан, уг гэрээнд шүүх өөрөө тухайн улсын зохих байгууллагад хандаж болохоор заасан байх явдал байдаг.

Монгол Улс захиргааны хэргийн талаар аль ч улс оронтой эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй. Гэхдээ манай улсаас эрүүгийн болон иргэний хэргийн талаар харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан орнуудтай харилцах боломж байгаа гэж үзэж байна.

Хилийн чанадад нотлох баримт бүрдүүлэх ажиллагааг тухайн улсын шүүхээр нотлох баримтыг олуулах, гаргуулах замаар хэрэгжүүлнэ. Харин тухайн улсын шүүх ажиллагаагаа өөрийн орны хэрэг хянан шийдвэрлэх хуулийн дагуу явуулдаг. Иймээс нотлох баримтыг заавал манай улсын хуулийн зохицуулалтын дагуу бүрдүүлэх үүрэг хүлээдэггүй.

Манай улсын шүүх нь гадаад улсын аль нэг шүүхэд дипломат харилцаанаас гадуур хандаж болохгүй. Шүүхийн хүсэлтийг биелүүлэх журам гол төлөв тухайн улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээгээр, ийм гэрээ байхгүй тохиолдолд дипломат шугамаар тохиролцдог.

Шүүх өөрөө нотлох баримтыг бүрдүүлэх талаар гадаад улсын зохих байгууллагад хандах журам, эрх зүйн үндэслэл тодорхойгүй бол эрх зүйн туслалцаа хүсэх ердийн аргыг хэрэглэх боломжтой. Энэ нь тухайн улсын Засгийн газарт хандах явдал байдаг. Энд тогтсон нийтлэг журам бий. Гадаад улсын шүүхээс нотлох баримтыг хилийн чанадад бүрдүүлэх эрх зүйн туслалцаа хүссэн тухай хууль зүйн яаманд хандана. Хууль зүйн яам уг хүсэлтийг гадаад харилцааны яаманд уламжилна. Гадаад харилцааны яам хүсэлтийг элчин сайдын яамаараа дамжуулах буюу дипломат шугамаар нотлох баримтыг бүрдүүлэх улсын гадаад харилцааны яаманд явуулдаг.

Ийм дамжлага нь бэрхшээлтэй байдаг тул аль болохоор өөрийн орны хэмжээнд байгаа, олж болох нотлох баримтыг сайтар бүрдүүлж хэргийг шийдвэрлэх талаар санаачилгатай ажиллах хэрэгтэй.

Монгол Улсаас гадаад оронд суугаа Элчин сайдын дэргэд элчин консул ажилладаг бөгөөд консул нотариатын үүрэг гүйцэтгэдэг. Тэгэхлээр зарим нотолгооны хэрэгслийг консул баталгаажуулан үйлдэл хийж ирүүлэх явдал практикт гарна. Тэр нь хэрэгт хамааралтай, ач холбогдолтой байж болно.

42 дугаар зүйл. Зохигчийн тайлбар буюу
захиргааны хэргийн оролцогчдын тайлбар

42.1. Зохигчийн шүүхэд гаргасан тайлбар бодит үнэнд нийцсэн байна.

42.2. Зохигч нэг талын гаргасан тайлбар, нотлох баримтын талаар эсрэг тал өөрийн тайлбараа холбогдох нотлох баримтын хамт гаргаж болно.

- 42.3. Энэ хуулийн 42.2-т заасан тайлбарыг зохигч тал гаргахдаа нөгөө талын гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн буюу түүний зарим хэсгийг хүлээн зөвшөөрч болно.
- 42.4. Нэг талын гаргасан тайлбарыг эсрэг тал эсэргүүцээгүй, эсхүл хуулиар тогтоосон хугацаанд тайлбар өгөөгүй бол тайлбарыг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

ТАЙЛБАР

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан “Зохигч” гэсэн нэр нь “захиргааны хэргийн оролцогчид” гэсэн томъёололтой дүйж байгаа тул цаашид энэ утгаар нь тайлбарлах нь зүйтэй.

Захиргааны хэргийн оролцогчийн тайлбар гэдэгт нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага, нэхэмжлэлээсээ татгалзсан болон хариуцагчтай эвлэрсний баталгаа түүний үндэслэл, хариуцагчийн татгалзал, нэхэмжлэлийн зарим хэсгийг эсхүл бүрэн хэмжээгээр хүлээн зөвшөөрсний болон нэхэмжлэгчтэй эвлэрсэн тухай баталгаа түүний үндэслэл, гуравдагч этгээдийн гомдол, шаардлага түүний үндэслэл хамаарна.

Хэргийн оролцогчдын хүсэл, зорилгоос хамаарч нэхэмжлэл, тайлбарууд нь өөр, өөрийн ашиг сонирхлыг илэрхийлсэн, хамгаалсан агуулгатай, нотлох баримт болохуйц шинж багатай байдаг. Иймээс оролцогчдын тайлбарыг бусад нотолгооны хэрэгслээр зайлшгүй давхар батлах шаардлагатай.

Харин Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 41, 42, 43 дугаар зүйлд заасан нөхцөл байдал бий болбол заавал бусад нотолгооны хэрэгслээр батлах шаардлага тавигдахгүй байж болно. Гэхдээ оролцогчид эвлэрсэн, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд энэ нь бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх эсэх нь нотлогдсон байх ёстой.

Шүүх хэргийн оролцогчдын тайлбарыг албадан гаргуулж болохгүй бөгөөд хуулиар тогтоосон арга журмаар гаргасан тайлбар нь нотолгооны хэрэгсэлд тооцогдоно.

Хэргийн оролцогчдын шүүхэд гаргасан тайлбар бодит үнэнд нийцсэн байна гэдэг нь харьцангуй ойлголт. Захиргааны хэргийн оролцогчдын шүүхэд гаргасан тайлбар бодит үнэнд нийцсэн байхыг хууль шаарддаг. Бодит үнэнд нийцсэн тайлбар өгөх үүрэг нь оролцогчид, түүний төлөөлөгч, өмгөөлөгчөөс хэргийн үйл баримт, гэм буруу байгаа эсхүл түүнийг үгүйсгэх замаар мэтгэлцэх зарчмын хэрэгжилтийг хязгаарлаж байгаа хэрэг биш юм. Зохигч гагцхүү бодит байдалд нийцсэн тайлбар өгөх нь хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт гаргах үүрэгтэйгээ шууд хамааралтай. Ийнхүү хуульд заасан “тайлбар бодит үнэнд нийцсэн байна”, “бодит үнэнд нийцсэн тайлбар өгөх” гэдгийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай

хуулийн 31 дүгээр зүйлд заасан нотлох баримт гаргах, цуглуулах, бүрдүүлэх талаарх зохицуулалттай харьцуулж үзэх нь зүйтэй.

Тухайлбал, “хэргийн оролцогч хуурамч нотлох баримт гаргах”, “хууль бус аргаар цуглуулах”-ыг хориглох, нотлох баримтыг гаргах, цуглуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол тэдгээр нь нотлох чадвараа алдана, нотлох баримтаас хасагдана, шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй гэсэн заалтууд нь агуулгаараа бодит үнэнийг шаардаж байгаа юм.

Хуулиар тогтоосон журмын дагуу гаргасан хэргийн оролцогчийн /тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээдийн/ тайлбар нь нотолгооны хэрэгсэлд тооцогдоно.

Хэргийн оролцогчдын нэг талын тайлбар гэдэгт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн тайлбар хамаарна. Тайлбар бол талуудын өөр өөрсдийн ашиг сонирхол, шүүхэд хандаж байгаа тус бүрийн зорилготой холбоотой байдаг.

Нэхэмжлэгчийн тайлбар нь нэхэмжлэлийн шаардлагыг батлах, хариуцагч, гуравдагч этгээдийн тайлбар, татгалзалд няцаалт өгөхөд чиглэгдэнэ. Нэхэмжлэгч хэзээ ч нэхэмжлэлээсээ татгалзах эрхтэй.

Хариуцагчийн тайлбар нь нэхэмжлэлийн шаардлагыг өөрийнхөө эрх ашигт нийцүүлэн тайлбарлах, эсхүл түүнд няцаалт өгөх, үгүйсгэх агуулгатай байна. Баталгаажуулсан, өөрөөр хэлбэл нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг болон бүрэн хэмжээгээр хүлээн зөвшөөрөх агуулгатай ч байж болно. Нөгөө талаар тэр сөрөг нэхэмжлэл гаргах эрхтэй. Сөрөг нэхэмжлэл нь татгалзалтайгаа шууд холбоотой байхын дээр тухайн хэргийн хүрээнд байх ёстой.

Гуравдагч этгээдийн тайлбар нь нэхэмжлэгч эсхүл хариуцагчийн тайлбар хүсэлтийг дэмжсэн, нөгөөг нь үгүйсгэсэн шинжтэй байдаг. Түүнээс гадна бие даасан шаардлага гаргах эрх энд хамаарна. Гуравдагч этгээд эвлэрэн хэлэлцэх, сөрөг нэхэмжлэл гаргах агуулгатай тайлбар гаргахыг хуулиар хориглодог ч гомдлоосоо татгалзаж болохыг зөвшөөрнө.

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх нь хэргийн нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрсөн явдал биш юм. Хэргийн нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрсөн нь хуульд заасан аль нэг шаардах эрхийг бий болгох хэм хэмжээний бүрэлдэхүүнийг хангадаг. Тэгэхээр нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн буюу зарим хэсгийг хүлээн зөвшөөрсөн, зохигч эвлэрсэн явдал бусдын эрх, эрх чөлөө хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй, хуульд харшлаагүй байх ёстой. Иймээс зохигчийн гаргасан тайлбарыг шүүх хэргийн нөхцөл байдалтай харьцуулан судлах шаардлагатай юм.

Хэргийн оролцогчийн нэг талаас гаргасан тайлбарыг эсрэг тал эсэргүүцээгүй, эсхүл хуулиар тогтоосон хугацаанд түүнийг үгүйсгэсэн, няцаасан хариу тайлбар өгөөгүй бол уг тайлбарт тусгагдсан шаардлага, үйл баримтыг хүлээн зөвшөөрсөнд тооцох нийтлэг зарчим үйлчилнэ. Жишээлбэл: Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор, эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд хариу тайлбар гаргаж өгөх үүрэгтэй. Тайлбар гаргаагүй явдал нь эсрэг талын нэхэмжлэл, гомдлыг хүлээн зөвшөөрсөнд тооцох үндэслэл болно.

Хэргийн оролцогчдын нэг талаас шүүхэд ирүүлсэн аливаа баримтыг (нэхэмжлэл, хариу тайлбар, нотлох баримт) эсрэг талд уншуулах, гардуулах, хүргүүлэх ажиллагааг шүүх гүйцэтгэнэ. Нэхэмжлэлийг шүүх хүлээн авахдаа хоёр ба түүнээс дээш хувийг шаарддаг нь хариуцагчид түүнийг гардуулах зорилготой. Үүний зэрэгцээ хариуцагчийн хариу тайлбарыг мөн бичгийн хэлбэрээр авч, нэхэмжлэгч нарын тоогоор хувилсан байх учиртай.

Энэ үүрэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод явагдах зарчимтай салшгүй холбоотой. Нөгөө талаар хянан шийдвэрлэгдэж буй хэргийн талаарх бүх баримттай хэргийн оролцогч нэг бүрчлэн танилцаж, тухайн асуудлаар бүрэн мэдээлэл, мэдлэгтэй болсон байх эрхтэйгээс гадна өөрийн санал, бодлоо чөлөөтэй, бүрэн илэрхийлэх, шаардлагатай гэж үзсэн нотлох баримт гаргах боломжийг бүрдүүлж байгаа хэрэг юм. Илэрхий үйл баримт байгаа нөхцөлд хэргийн оролцогчдыг эвлэрүүлэх зорилгоор шүүгч тэднийг ойлголцуулах арга хэмжээ авч болно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн
43 дугаар зүйл. Гэрчийн мэдүүлэг

- 43.1. Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байдлыг мэдэж байгаа хэн ч гэрч байж болно.
- 43.2. Гэрчийг шүүх хэргийн оролцогчийн хүсэлтээр дуудаж мэдүүлэг авна.
- 43.3. Гэрчээр дуудагдсан этгээд шүүхэд заавал хүрэлцэн ирэх ба үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэгтэй. Мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, зориуд худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хууль⁷⁹ заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 43.4. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүхийн дуудсанаар ирж чадахгүй гэрчээс байгаа газарт нь очиж мэдүүлэг авч болно.
- 43.5. Гэрч шүүхийн дуудсанаар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг албадан ирүүлэхийг шүүхээс цагдаагийн байгууллагад даалгаж, холбогдох зардлыг гэрчээр гаргуулахаар тогтоож болно.
- 43.6. Гэрчүүдийн мэдүүлэгт ноцтой зөрүү байвал тэдгээрийг нүүрэлдүүлэн мэдүүлэг авч болно. Шүүгч нүүрэлдүүлэн мэдүүлэг авахдаа гэрчүүдээс бие биеэ таних

⁷⁹ Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

эсэх, хоорондоо ямар харилцаатай болохыг асууна. Дараа нь тодруулах гэж байгаа зүйлийн талаар гэрчүүдээс ээлжлэн мэдүүлэг гаргуулна. Мэдүүлэг өгсний дараа шүүгч гэрчүүдэд асуулт тавьж болно. Харилцан нүүрэлдэж байгаа гэрчүүд бие биедээ асуулт тавьж болохгүй.

- 43.7. Зохигчийн эхнэр, нөхөр, эцэг, эх, хүүхдийг зөвхөн өөрсдийнх нь зөвшөөрснөөр гэрчээр мэдүүлгийг авч болно. Энэ тохиолдолд тэд гэрчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
- 43.8. Дараах хүнийг гэрчээр дуудах буюу мэдүүлэг авч болохгүй:
- 43.8.1. үүргээ гүйцэтгэх замаар уг хэргийн байдлыг мэдэх болсон зохигчийн төлөөлөгч буюу эрүүгийн хэргийн өмгөөлөгч;
- 43.8.2. иргэний эрх зүйн чадамжгүй этгээд.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн

58 дугаар зүйл. Гэрч

- 58.1. Захиргааны хэргийн шүүхээс маргааныг шударгаар шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байдлыг мэдэж байгаа этгээдийг гэрч гэнэ.
- 58.2. Гэрч захиргааны хэргийн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирж, хэргийн талаарх мэдээлэл, нөхцөл байдлыг мэдүүлэх үүрэгтэй.
- 58.3. Гэрч үнэн зөв мэдүүлэг өгч, шүүгч, хэргийн оролцогч болон хянан шийдвэрлэх ажиглагааны бусад оролцогчийн асуултад хариулна. Гэрчүүдийг нүүрэлдүүлэн мэдүүлэг авахдаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6.-д заасан журмыг баримтална.
- 58.4. Санаатайгаар худал мэдүүлэг өгсөн, эсхүл мэдүүлэг өгөхөөс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан, зайлсхийсэн гэрчид Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 58.5. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүхийн дуудсанаар ирж чадахгүй гэрчээс байгаа газарт нь очиж мэдүүлэг авч болно.
- 58.6. Гэрч шүүхийн дуудсанаар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг албадан ирүүлэхийг шүүхээс цагдаагийн байгууллагад даалгаж, холбогдох зардлыг гэрчээр гаргуулахаар тогтоож болно.

ТАЙЛБАР

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар зүйлийн “Гэрч”, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 43 дугаар зүйлийн “Гэрчийн мэдүүлэг” гэсэн гарчиг доторх заалтууд нь үндсэндээ адил утга, агуулгатай. Харин өгүүлбэр зүйн байрлал, нэр томъёоны хувьд ялгаатай байна. Иймд захиргааны эрх зүйн талаас нь тайлбарлав.

Захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий бодит байдлыг мэдэж байгаа этгээд гэрч байж болно. Гэрч нь амьд хүн байх бөгөөд түүний мэдүүлэг нь нотолгооны хэрэгсэл мөн. Харин гэрчийн мэдүүлэг нь бодит үнэнийг тогтооход ач холбогдолтой, үнэн зөв байвал нотлох баримт болж чадна. Хэн ч гэрч байж болох боловч үзэгдэл юмсыг танин мэдэх чадвартай, иргэний эрх зүйн чадамж бүхий этгээд байна. Шүүхээр хянан хэлэлцэгдэж байгаа хэрэгт ямар нэгэн сонирхолгүй байх ёстой. Түүнчлэн үүргээ гүйцэтгэх замаар уг хэргийн байдлыг мэдэх болсон зохигчийн төлөөлөгч, өмгөөлөгч болон иргэний эрх зүйн чадамжгүй этгээд гэрчээр оролцож болохгүй.

Хэрэг явдал түүнтэй холбоотой үйл баримтыг үзсэн, сонссон, байлцсан зэргээр тодорхой мэдлэг, мэдээлэл бүхий этгээдийг хуульд заасан журмын дагуу эрх, үүргийг нь танилцуулсны үндсэн дээр байцаалт авч баталгаажуулсан тэмдэглэлийг гэрчийн мэдүүлэг гэнэ.

Захиргааны хэргийн шүүгч хэргийн оролцогчийн хүсэлтээр болон өөрийн санаачилгаар гэрчийн мэдүүлгийг урьдчилан авсан байхын дээр шаардлагатай гэж үзвэл түүнийг шүүх хуралдаанд оролцуулна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2-т “Гэрчийг шүүх хэргийн оролцогчийн хүсэлтээр дуудаж мэдүүлэг авна” гэж заасныг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикт шууд хэрэглэх боломжгүй. Хэрэгт ач холбогдолтой зүйлийг мэддэг, харсан үзсэн этгээдийг хэргийн оролцогчийн хүсэлт гаргасан эсэхийг харгалзахгүйгээр захиргааны хэргийн шүүх гэрчээр татан оролцуулж болно. Харин хэргийн оролцогчдоос гэрчээр хэн нэгэн этгээдийг байцаалгах, мэдүүлгийг нь авахуулахыг хүсч, шаардаж байгаа бол тухайн этгээдээс ямар байдлыг тодруулах, ямар мэдээлэл авах, мэдүүлэг нь шаардлага, татгалзал, тайлбарын ямар үндэслэлийг нотлох, тухайн маргааныг шийдвэрлэхэд ямар ач холбогдолтой болохыг дурьдсан байхын дээр гэрчийн хаягийг заасан байвал зохино.

Шүүхэд гэрчээр дуудагдсан этгээд шүүхийн мэдэгдэх хуудсанд заасан хугацаанд заавал хүрэлцэн ирэх, шүүхэд үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэгтэй. Худал мэдүүлэг өгөх нь хэргийн бодит байдлыг үнэн зөв тогтоож, шүүхээс үндэслэл бүхий шударга шийдвэр гаргахад саад учруулдаг үр дагавартай.

Гэрчийн мэдүүлэг худал байна гэдэг бол болсон байдал буюу үйл баримтын мөн чанарыг зориуд үгүйсгэх, хуурамчаар батлах, үнэн байдлыг мушгин гуйвуулсан байхаас гадна мэдсэн үзсэн, сонссон зүйлээ огт хэлэхгүй байх үйлдэл эс үйлдэхүйн хэлбэрээр үйлдэгдэх гэмт хэрэг болно. Иймээс мэдүүлэг өгөхөөс татгалзсан, зайлсхийсэн, худал мэдүүлэг өгсөн гэрчийн этгээдийг Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Гэрч шүүх, шүүгчийн дуудсанаар шүүхэд хүрэлцэн ирж мэдүүлэг өгнө. Хэрэв шүүхийн дуудсанаар хүндэтгэн үзэх шалтгаанаар ирж чадахгүй гэрчээс байгаа

газарт нь очиж мэдүүлэг авч болно. Хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт гэрч нь өндөр настай болсон, өвчтэй болон хоригдож байгаа, цэргийн албанд дайчлагдсан, хорио цээрийн дэглэм тогтоосон зэргээс өөрийн биеэр шүүхэд ирж чадахгүй болсныг хамааруулан ойлгоно. Гэрч энэ байдлаа шүүхэд мэдэгдэх үүрэгтэй.

Гэрч шүүхийн дуудсанаар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг албадан ирүүлж болно. Гэрчийг шүүгчийн захирамжаар албадан ирүүлэхийг цагдаагийн байгууллагад даалгана. Ийнхүү албадан ирүүлэхэд гарсан зардлыг гэрчээс гаргуулахаар тогтоож болно.

Нэг хэрэгт хэд хэдэн гэрчийн мэдүүлгийг авахад гэрчүүдийн мэдүүлэг хоорондоо зөрөх, бодит байдлаас хэт гажсан байх явдал тохиолддог. Гэрчүүдийн мэдүүлэгт ноцтой зөрүү байвал тэдгээрийг нүүрэлдүүлэн мэдүүлэг авч болно. Мэдүүлэгт ноцтой зөрүү байх нь гэрчүүдийн мэдүүлэг хоорондоо эрс тэс зөрүүтэй байх, болсон явдал, үйл баримтын талаар эсрэг байдлаар мэдүүлэх, нэг нь няцаахад нөгөө нь батлах зэрэг өөр байдлаар илэрхийлэгдэнэ.

Шүүгч гэрчүүдийг нүүрэлдүүлэн мэдүүлэг авахдаа дараах журмыг баримтална. Үүнд:

- Ямар асуудлаар гэрчийн мэдүүлэг авах болсныг тайлбарлах;
- Гэрчийн мэдүүлэг өгөх эсэх, татгалзах үндэслэл байгаа эсэх;
- Гэрчүүдээс бие биенээ таних эсэхийг асууж, хариултыг тэмдэглэнэ;
- Гэрчүүд хоорондоо ямар харилцаатай болохыг асууж, тодруулна;
- Үүний дараа тодруулах гэж байгаа зүйлийн талаар гэрчүүдээс ээлжлэн асууж, мэдүүлэг гаргуулна. Мэдүүлэг өгсний дараа шүүгч дахин тодруулах зүйл байвал гэрчүүдээс асууна.

Нүүрэлдэх замаар мэдүүлэг гаргаж байгаа гэрчүүд бие биедээ асуулт тавьж болохгүй. Хэрэв харилцан асуулт тавьж ярилцвал мэдүүлгийн зөрүүг арилгах, мэдүүлэгт зөрүү гарсны учир шалтгааныг тогтооход муугаар нөлөөлж болох талтай байдаг.

Монгол улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол улсын иргэн өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх” эрхийг баталгаатай эдэлнэ гэж заажээ. Өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх бол тус улсын иргэн хүний, түүний гэр бүлийн гишүүд ойр төрөл садангуудын хувийн халдашгүй эрхийг хамгаалах баталгаа болно.⁸⁰ Энэ баталгааны дагуу ардчилсан нийгэмд хувь хүний халдашгүй эрх нь зөвхөн хувь хүний төдийгүй, түүний гэр бүлийн гишүүд, төрөл садангийн хүмүүсийн хамт хуулийн хамгаалалт хүртдэгийн нэгэн чухал үзүүлэлт юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эхнэр, нөхөр, эцэг, эх, хүүхдийг зөвхөн тэдгээрийн өөрсдийн нь зөвшөөрснөөр гэрчийн мэдүүлэг авч болохоор зохицуулсан. Тэдгээр нь нэгэнт гэрчийн мэдүүлэг өгөхийг өөрөө зөвшөөрсөн бол

⁸⁰ Г.Совд нар. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар УБ хот. 2000 он. хуудас 115

хуульд зааснаар гэрчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Гэхдээ тэдгээр нь зөвхөн бие биеийнхээ эсрэг мэдүүлэг өгөх явдалтай холбоотой зохицуулалт гэдгийг анхаарах хэрэгтэй. Энэ нь үнэн зөв мэдүүлэг өгөх, худал мэдүүлэг өгвөл хуульд заасан хариуцлага хүлээнэ гэсэн үг.

Үүргээ гүйцэтгэх замаар уг хэргийн байдлыг мэдэх болсон зохигчийн төлөөлөгч гэж

- Захиргааны болон иргэний хэрэгт хэргийн оролцогчдыг төлөөлөн захиргааны байгууллага ба шүүх, арбитрт төлөөлөгч, хуулийн зөвлөгчийн хувиар оролцож байсан
- Мөн хэргийн оролцогчидтой холбоотой эрх зүйн бусад маргаанд түүнийг төлөөлөн оролцож байсан.
- Хэргийн оролцогчидтой холбоотой эрүүгийн хэрэгт өмгөөлөгчөөр оролцож байсан этгээдийг ойлгоно.

Хэдийгээр хуулиар зохицуулаагүй ч албан үүргийнхээ хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль нэг үе шатанд оролцож байсан шүүгч, прокурор, арбитрч нар гэрч байж болохгүй.

Иргэний эрх зүйн чадамжгүй этгээдийг шүүхэд гэрчээр дуудах буюу мэдүүлэг авч болохгүй. Өөрөө хэлбэл болсон үйл явдлыг ой ухаандаа тогтоон хадгалах, түүнээ бусдад зөв илэрхийлж чадахгүй хүн гэрч болохгүй гэсэн үг. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд "Иргэний эрх зүйн чадамжгүй этгээд" гэдгийг Иргэний хуулийн 18 дугаар зүйлд заасан иргэний эрх зүйн чадамжгүй иргэнтэй адилтгаж үзнэ.

Хэргийн оролцогчид өөрийн тайлбарын нотолгоо болгож хүмүүсээс бичүүлж авсан "тодорхойлолт" нэртэй баримтуудыг шүүхэд ирүүлдэг. Энэ нь нотолгооны хэрэгсэл биш юм. Яагаад гэвэл Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн агуулга нь хэргийн оролцогчид тэдгээрийн өмгөөлөгч, төлөөлөгч нар гэрчээр асуулгах хүнээ зааж, хүсэлт гарган, шүүгчээр мэдүүлэг авахуулах эрхтэй байхаар тусгайлан зохицуулсан тул бусдын "тодорхойлолт" гэх баримт нь нотолгооны хэрэгсэл болж чадахгүй. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 58, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 43 дугаар зүйлд заасан үндэслэл, журмаар авсан гэрчийн мэдүүлэг нь нотолгооны хэрэгсэл, нотлох баримтад тооцогдоно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн
44 дүгээр зүйл. Бичмэл нотлох баримт

- 44.1. Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий бичгийн хэлбэртэй баримтыг бичмэл нотлох баримт гэнэ.
- 44.2. Бичмэл нотлох баримтыг шүүхэд эхээр нь, хэрэв эхийг өгөх боломжгүй бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг өгнө. Хуулбарыг өгсөн үед шаардлагатай гэж үзвэл шүүх жинхэнэ эхийг шаардан авах эрхтэй. Бичмэл нотлох баримтыг шаардан авахад бэрхшээлтэй байвал зохигчийн хүсэлтээр түүний хадгалагдаж байгаа газарт нь шүүх үзлэг явуулах ба шинжлэн судалж болно.
- 44.3. Шүүхийн шийдвэр гарсны дараа бичмэл баримтын эхийг түүнийг гаргаж өгсөн этгээд хүсвэл буцаан өгч болно. Харин уг баримтын нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг хэрэгт үлдээнэ.

ТАЙЛБАР

Захиргааны хэргийн шүүхэд хамгийн ач холбогдолтойд тооцогдох нотолгооны хэрэгсэл бол бичмэл баримт юм. Хэргийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий фактуудыг агуулсан бүх төрлийн тогтоол, захирамж, албан бичиг, зураг, тэмдэглэл, зураглал, гэрээ зэрэг нь бичмэл нотолгооны хэрэгсэл болно. Бичмэл баримтыг түүний агуулга, хэлбэр, төрлөөс нь хамаарч 3 ангилна. Үүнд:

1. *Захирамжилсан баримт.* Захиргааны байгууллага, албан тушаалтны тогтоол, захирамж, тушаал, шийдвэр, гэрээ хэлцэл, иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, өргөдөл, гомдол, гэх мэт иргэн, албан байгууллагын үйл ажиллагаа, хүсэл зоригийг илэрхийлсэн, эрх, үүрэг бий болгосон шинжтэй баримтууд захирамжилсан баримтад хамаарна. Эдгээр нь захиргааны хэрэг үүсгэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл болдог онцлогтой “нотолгооны” хэрэгсэл юм. Үүнээс үзвэл нотолгооны зүйл буюу захиргааны акт маань өөрөө бичмэл хэлбэрээр гардгийнхаа хувьд нотолгооны хэрэгсэл болох төдийгүй шууд нотлох баримт ч болдог байна.

2. *Гэрчилж тодорхойлсон баримт.* Үйлдэл, үйл ажиллагааг үгүйсгэсэн, эсхүл баталж, тодорхойлсон шинжтэй тэмдэглэл, захидал, үнэмлэх, лавлагаа, зураг, зураглал зэрэг нь албан бус, хэлбэрийн хувьд энгийн нотолгооны хэрэгсэлд хамаарах бөгөөд бусад нотолгооны хэрэгслээр давхар баталгаажсан байх шаардлагатай.

3. *Тогтоосон баримт тухайн факт /үйл баримт/-ыг эрх бүхий байгууллага, албан тушаалтан бүртгэж, баталгаажуулж байхаар хуульд зааснаар тэдгээрээс олгосон гэрчилгээ, лиценз, лавлагаа нь нотолгооны хэрэгсэл болох бөгөөд түүнийг олгох үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд байгаа эсэхийг нотлох үүргийг хэргийн оролцогчид болон шүүх хүлээнэ.*

Түүнчлэн бичмэл нотлох баримтыг бүрдүүлбэрийн төрлөөр нь энгийн ба нотариатаар гэрчлэгдсэн, гаргасан субъектээр нь албан бичиг баримт, албан бус бичиг баримт гэж ангилан⁸¹ үзэж болно. Хэргийн оролцогчоос бичмэл нотлох баримтыг гаргахдаа шүүхэд эх хувиар нь өгнө. Хэрэв бичмэл нотлох баримтын эхийг өгөх боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хувийг өгнө. Хуулбарыг өгсөн үед түүнийг эх хувьтай нь тулган шалгах, хэргийн бусад нотлох баримттай харьцуулан үзэх хэрэгтэй. Шаардлагатай гэж шүүх үзвэл бичмэл нотлох баримтын жинхэнэ эхийг өөрийн санаачилгаар шаардан авах, гаргуулах эрхтэй байдаг.

Шүүх жинхэнэ эхийг шаардсаны дагуу хэргийн оролцогчид болон шаардлагыг хүлээсэн этгээд уг бичмэл нотлох баримтыг шүүхэд гарган өгөх үүрэгтэй. Шүүхэд ирүүлэхэд бэрхшээлтэй байвал хадгалагдаж байгаа газарт нь шүүх үзлэг явуулж, түүнийг шинжлэн судалж болно. Тухайлбал: Шүүгчийн шаардсан бичмэл баримтын эх байгууллагын архивын их хэмжээтэй нэгжид үдэгдсэн, зардал, чирэгдэл гарахаар байх зэргээр түүнийг гадагш гаргах боломжгүй байж болно. Харин энэ бичмэл нотлох баримт нь хэрэгт хамааралтай, ач холбогдолтой зүйл байх ёстой.

Бичмэл нотлох баримтын эхийг шүүхэд гаргаж өгсөн этгээд нь түүнийг буцаан авахыг хүсэх эрхтэй. Бичмэл баримтын эхийг буцаан авах тухай хүсэлтийг шүүхийн шийдвэр гарсны дараа гаргана. Зохигчийн хүсэлтэд үндэслэн шүүхээс бичмэл баримтыг буцаан олгохдоо уг баримтын нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг хэрэгт үлдээнэ. Шүүхийн бичмэл нотлох баримтын эхийг буцаан олгосон талаар дэлгэрэнгүй тэмдэглэл үйлдэн хэрэгт хавсарган уг бичмэл баримтыг буцаан авсан этгээдээр гарын үсэг зуруулж баталгаажуулсан байх хэрэгтэй.

Бичмэл нотлох баримтыг эхээр нь, хэрэв эхийг нь өгөх боломжгүй бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг гаргаж өгөх үүргийг бүх тал хүлээнэ. Нотолгооны энэ шаардлагыг үл ойшоож, “хуулбар үнэн”, “...баримтаас хуулбарлав” гэсэн тэмдэг, тэмдэглэлтэй баримт ирүүлдэг, түүнийг нь шүүх хүлээн авч нотлох баримтын хэмжээнд үнэлдэг явдал оршсоор байна. Ийм хууль бус арга, журмаар гаргасан бичмэл баримтыг хүлээн авсан, үнэлсэн нь хэргийн бусад оролцогчдод эргэлзээ төрүүлэх, шүүхэд үл итгэх байдлыг бий болгох, нөгөө талаар шүүхийн шийдвэр хууль ёсны болж чадахгүй хүчингүй болох үндэслэл болно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн
45 дугаар зүйл. Эд мөрийн баримт

- 45.1. Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтоож чадах биет зүйлийг эд мөрийн баримт гэнэ.
- 45.2. Эд мөрийн баримтыг хэрэгт, эсхүл тусгай байр, саванд тодорхой бүртгэлтэйгээр хадгална. Шүүхэд авчирч хадгалах боломжгүй эд мөрийн баримтыг түүний байгаа газарт нь үзлэг хийж, энэ тухай тэмдэглэл хөтөлнө.

⁸¹ Иргэний хуулийн тайлбар 2007 он

Шаардлагатай бол уг эд мөрийн баримтын талаар гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэг хийж бэхжүүлэн хэрэгт хавсаргах буюу түүнийг битүүмжилж болно. Хүнсний ба түргэн муудаж, гэмтэх бусад зүйлд үзлэгийг шүүхээс хэргийн оролцогчдод мэдэгдэж даруй хийнэ. Үзлэг хийсний дараа уг зүйлийг хуульд өөрөөр заагаагүй бол гаргаж өгсөн этгээдэд буцаан олгоно.

- 45.3. Шаардлагатай бол эд мөрийн баримтыг эзэмшигч, эсхүл зохих баг, хорооны Засаг дарга, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, цагдаагийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд хадгалуулж болно. Хадгалахаар авсан этгээд эд мөрийн баримтыг хэвийн байдлаар хадгалах үүрэгтэй.
- 45.4. Энэ хуулийн 120.2-т заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд эд мөрийн баримтыг хуульд өөрөөр заагаагүй бол эзэмшигчид буцаан олгоно. Харин эд мөрийн баримтын кино ба гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэгийг хэрэгт үлдээнэ.

ТАЙЛБАР

Шүүхээр хянан хэлэлцэгдэж байгаа захиргааны хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлуудыг агуулж байгаа эд зүйлсийг эд мөрийн баримт гэнэ. Эд мөрийн баримтад тухайн маргаанд шууд ба шууд бус ач холбогдолтой бүх төрлийн эд зүйл, зарим тохиолдолд бичмэл баримт хамрагдана. Эд мөрийн баримтад тавигдах гол шаардлага бол гагцхүү хуульд заасан арга, хэрэгслэлээр олж авсан байхын дээр анхны байдлаараа бэхжсэн байх явдал юм.

“Биет зүйл” гэдэгт хөдлөх болон үл хөдлөх эд юмс, тэдгээрийн бүрдэл хэсэг, үл мөр, дүрслэл зэрэг хамаарна.

Эд мөрийн баримтыг хэрэгт хадгалах боломжгүй байвал тусгай байр, саванд хадгалах ба уг эд мөрийн баримтын талаар бүртгэл хөтөлж шүүхэд болон хэрэгт хадгална. Эд мөрийн баримтыг шүүхэд авчирч хадгалах боломжгүй овор хэмжээ ихтэй эд зүйл, түргэн муудаж гэмтэх хүнсний бүтээгдэхүүн байж болно. Жишээ нь: газар, барилга байгууламж, машин, техник, ургаа мод бут, сүү, мах, өндөг, айраг, жимс гэх мэт. Ийнхүү шүүхэд авчирч хадгалах боломжгүй эд мөрийн баримтыг байгаа газарт нь үзлэг хийж, шаардлагатай бол эд мөрийн баримтын гэрэл зураг авах, зураглал, дүрс, дуу авианы бичлэг хийх зэргээр бэхжүүлэн тэмдэглэл хөтлөн баталгаажуулан хэрэгт хавсаргана. Шүүх үзлэг хийсний дараа хуульд өөрөөр заагаагүй бол түүнийг гаргаж өгсөн этгээд болон өмчлөгчид нь буцаан олгож болно. Түүнчлэн эд мөрийн баримтыг битүүмжлэн хамгаалах, хадгалуулах аргыг хэрэглэж болдог. Эд мөрийн баримтад үзлэг хийх, түүнийг хамгаалах, хадгалах, бэхжүүлэх болсноо шүүх хэргийн оролцогчдод заавал урьдчилан мэдэгдэж, энэ ажиллагаандаа тэднийг оролцуулах үүрэгтэй.

Шүүхэд ирүүлсэн эд мөрийн баримтыг хадгалах асуудал чухал байдаг. Эд мөрийн баримтыг хадгалахаар авсан этгээд нь түүнийг муутгахгүй, хэвийн байдлаар хадгалж, хамгаалах үүрэгтэй. Шүүхэд авчирч хадгалснаас бусад нотлох баримтыг хадгалж, хамгаалах шаардлагатай бол дараах хүмүүс, байгууллага, албан тушаалтанд хадгалуулна. Үүнд:

- Эд мөрийн баримтыг эзэмшиж байгаа этгээдэд хадгалуулж болно. Эд мөрийн баримтыг эзэмшигч нь түүнийг хадгалж хамгаалах найдвартай бас бололцоотой байх ёстой.
- Эд хөрөнгийн байгаа газрын баг, хорооны Засаг даргад түүнийг хадгалж хамгаалах үүрэг болгосон арга хэмжээ авч болно.
- Хуульд заасан журмын дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд хадгалуулж болно.
- Цагдаагийн байгууллага, түүний эрх бүхий албан тушаалтанд эд мөрийн баримтыг хадгалж, хамгаалахыг даалгаж болно. Ийнхүү нотлох баримтыг хадгалж, хамгаалах үүргийг бусдад хүлээлгэхдээ шүүгч захирамж гаргаж, хүлээх үүргийг тодорхой заасан байвал зохино.

Захиргааны хэргийн эд мөрийн баримтыг хэрэгт заавал хавсаргаж хадгалах шаардлагатай болон хуульд өөрөөр заагаагүй бол өмчлөгч, эзэмшигч болон бусад этгээдэд буцаан олгож шилжүүлнэ. Эд мөрийн баримтын эзэмшигчид буцаан олгоходоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.2-т заасан хугацаа өнгөрсний дараа буюу нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд тэдгээрийн өмгөөлөгч, төлөөлөгч шийдвэр, магадлалыг гардан авснаас хойш, давж заалдах (14 хоног) хяналтын журмаар гомдол гаргах (30 хоног) хугацаа өнгөрсний дараа буцаан олгоно. Харин эд мөрийн баримтыг кино ба гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэг зэрэгт буулган авч энэ тухай тэмдэглэл үйлдэж, хэрэгт хавсаргах шаардлагатай.

Эд мөрийн баримт нь хуульд заасны дагуу хурааж улсын орлого болгох, эрх бүхий /Цагдаагийн, эмнэлгийн, ариун цэврийн/ байгууллагад шилжүүлэх, устгавал зохих зүйл бол шилжүүлсэн, устгасан тухай акт үйлдэж хэрэгт хавсаргана.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйл.

Шинжээч, түүний эрх, үүрэг, шинжээчийн дүгнэлт

- 47.1. Хэрэг хянан шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулахын тулд хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүгч захирамж гарган шинжээчийг томилно.
- 47.2. Шинжээч нь мэргэжлийн байгууллага, эсхүл тухайн чиглэлээр мэргэжил эзэмшиж мэргэшсэн, уг хэргийн талаар хувийн болон албаны сонирхолгүй этгээд байна.
- 47.3. Шинжээч байгууллагаас томилогдсон бол тухайн байгууллагын нэрийн өмнөөс, бусад шинжээч өөрийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргаж түүний үнэн зөвийг хариуцна.
- 47.4. Шаардлагатай тохиолдолд шүүгч хэд хэдэн этгээдийг шинжээчээр томилж болох бөгөөд тэдгээр нь санал нэгтэй байвал нэг дүгнэлт гаргаж, гарын үсгээ

зурна. Харин аль нэг шинжээч бусад шинжээчийн дүгнэлттэй санал нийлэхгүй байвал дүгнэлтээ тусад нь гаргаж болно.

- 47.5. Дахин шинжээч томилох тохиолдолд өмнө нь уг хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргахад оролцсон этгээд оролцохгүй.
- 47.6. Шинжээч шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх, тавьсан асуултад үнэн зөв хариулах үүрэгтэй. Шинжээч санаатайгаар худал дүгнэлт гаргавал Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 47.7. Шинжээчид өгсөн материал дүгнэлт гаргахад хангалтгүй буюу шинжээч оногдсон үүргийг биелүүлэхэд шаардагдах мэдлэг эзэмшээгүй байвал дүгнэлт гаргахад татгалзаж болно.
- 47.8. Шинжээч шаардлагатай гэж үзвэл тухайн хэргийн материалтай танилцах, нэмэлт материал гаргаж өгөхийг шүүхэд хүсэх эрхтэй.
- 47.9. Шинжээч дүгнэлтээ бичгээр гаргана. Дүгнэлтэд ямар шинжилгээ хийсэн, түүний үндсэн дээр гарсан дүгнэлт, шүүгчээс тавьсан асуултад өгсөн үндэслэл бүхий хариултыг тодорхой бичнэ.
- 47.10. Шинжээч хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдлыг олж тогтоовол энэ талаар шүүхээс асуулт тавигдаагүй ч гэсэн дүгнэлтээ оруулах эрхтэй.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн

59 дүгээр зүйл. Шинжээч

- 59.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгайлан эзэмшсэн мэдлэгтэй, уг хэргийн талаар хувийн болон албаны сонирхолгүй, энэ хуульд заасны дагуу захиргааны хэргийн шүүхээс томилогдсон этгээдийг шинжээч гэнэ.
- 59.2. Нотлох баримтыг шинжлэх даалгавар авсан этгээд захиргааны хэргийн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирж, тавигдсан асуудлаар бодитой дүгнэлт өгнө.
- 59.3. Шинжлүүлэхээр өгсөн материал хангалтгүй, эсхүл оногдсон үүргийг биелүүлэхэд эзэмшсэн мэргэжил, мэдлэг нь шаардлага хангахгүй гэж үзвэл шинжээч дүгнэлт өгөхөөс татгалзаж болно.
- 59.4. Шинжээч нь дүгнэлт өгөхөд шаардлагатай гэж үзвэл хэргийн материалтай танилцах, асуулт тавих, нэмэлт материал гаргаж өгөх тухай хүсэлтээ шүүхэд гаргах эрхтэй.
- 59.5. Санаатайгаар худал дүгнэлт өгсөн, эсхүл дүгнэлт өгөхөөс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан шинжээчид Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

- 59.6. Шинжээч байгууллагаас томилогдсон бол тухайн байгууллагын нэрийн өмнөөс, бусад шинжээч өөрийн нэрийн өмнөөс дүгнэлтээ бичгээр гаргаж, түүний үнэн зөвийг хариуцна. Дүгнэлтэд ямар шинжилгээ хийсэн, түүний үндсэн дээр гарсан дүгнэлт, шүүгчээс тавьсан асуултад өгсөн үндэслэл бүхий хариултыг тодорхой бичнэ. Шинжээч хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдлыг олж тогтоовол энэ талаар шүүхээс асуулт тавигдаагүй ч гэсэн дүгнэлтдээ оруулах эрхтэй.
- 59.7. Шаардлагатай тохиолдолд шүүгч хэд хэдэн этгээдийг шинжээчээр томилж болох бөгөөд тэдгээр нь санал нэгтэй байвал нэг дүгнэлт гаргаж, гарын үсгээ зурна. Харин аль нэг шинжээч бусад шинжээчийн дүгнэлттэй санал нийлэхгүй байвал дүгнэлтээ тусад нь гаргаж болно.
- 59.8. Дахин шинжээч томилох тохиолдолд өмнө нь уг хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргахад оролцсон этгээд оролцохгүй.

ТАЙЛБАР

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дугаар зүйлийн “шинжээч”, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 43 дугаар зүйлийн “Шинжээч, түүний эрх, үүрэг, шинжээчийн дүгнэлт” гэсэн гарчиг доторх заалтууд нь адил утга, агуулгатай байгаа. Харин өгүүлбэр зүйн байрлал, нэр томъёоны хувьд ялгаа бий.

Шинжээч томилж, дүгнэлт гаргуулах асуудлыг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлд зааснаар оролцогчдын хүсэлтээр эсхүл шүүх өөрийн санаачилгаараа хэргийг шүүх хуралдаанд бэлтгэх ажиллагааны үед шүүгчийн захирамж, шүүх хуралдаанаар хэлэлцэх үед шүүхийн тогтоол гарган, мэргэжлийн байгууллагыг эсхүл тухайн асуудлаар мэргэшсэн тодорхой хүнийг шинжээчээр томилж шийдвэрлэнэ.

Захиргааны хэргийн шүүн таслах ажиллагаанд шинжлэх ухаан, техник, технологи шүүх эмнэлэг, нягтлан бодох бүртгэл, мал эмнэлэг, геологи, барилга архитектур, криминалистикийн зэрэг салбаруудаар шинжээч томилж дүгнэлт гаргуулах шаардлага байнга гарах болжээ.

Хуульд заасан “тусгай мэдлэг” гэдэг нь шүүгч хүн дагнан эзэмшээгүй, хуульчийн эзэмшсэн мэргэжил мэдлэгээс өөр, илүү нарийн мэдлэг, чадварыг хэлнэ. Шүүгч уг асуудлаар тусгай мэдлэг эзэмшсэн, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх чадвартай бол шинжээч томилох шаардлагагүй байж болохыг үгүйсгэх аргагүй ч дээд шатны шүүхийн шүүгчид тухайн асуудлаар мэдлэг, дутагдахаар байж болохыг бас л анхаарах ёстой.

Захиргааны хэргийн шүүх, шүүгч шинжээч томилохдоо хэргийн оролцогчийн хүсэлтийг үндэслэхээс гадна шаардлагатай гэж үзвэл санаачилгаараа шинжээч томилох эрхтэй. Эндээс шинжээч томилох, дүгнэлт гаргуулах эрх зөвхөн шүүхэд хадгалагдах бөгөөд хэргийн оролцогчид өөрийн дур зоригийн дагуу шинжээчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулах эрхгүй, тийм боломж ч байхгүй юм.

Шинжээч нь уг хэргийн талаар хувийн болон албаны ямар нэг сонирхолгүй хөндлөнгийн этгээд байх ёстой. Татварын төлбөр тооцоотой холбоотой маргаанд холбогдох асуудлаар шинжээч томилохдоо татвар төлөгчийн дотно найз нөхдийн болон төрөл садангийн холбоотой эсхүл хамтарч ажилладаг этгээдийг томилбол тэр нь *хувийн сонирхол* нөгөө талаар татварын маргаан таслах зөвлөлийн гишүүн, татвар төлөлтөд хяналт тавих байгууллага /татварын ерөнхий газар, сангийн яам/-ын мэргэжилтэнг томилбол *албаны сонирхолтой* байна гэсэн үг.

Мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдийг шүүх шинжээчээр томилсон бол тухайн байгууллага шинжилгээ хийх, дүгнэлт гаргах хүнээ өөрөө томилж шийдвэрээ гаргасан байна. Байгууллага нь нэг буюу хэд хэдэн шинжээчийг томилж болно. Энэ шинжээч нь байгууллагын нэрийн өмнөөс дүгнэлт гаргана. Харин шинжээчийн дүгнэлтийн үнэн зөвийг тухайн байгууллага, эсхүл томилсон албан тушаалтан хариуцах учиртай. Шинжээчээр иргэн томилогдсон бол өөрийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргана. Шинжилгээ, дүгнэлтийнхээ үнэн зөвийг тэр өөрөө хариуцна.

Маргаантай асуудлыг шинжлэн судлах, дүгнэлт гаргахад ээдрээ төвөгтэй, цаг хугацаа шаардлагатай, өргөн цар хүрээтэйн улмаас хамтарсан бүрэлдэхүүнээр дүгнэлт гаргуулах шаардлагатай гэж шүүгч үзвэл шүүгч хэд хэдэн этгээдийг шинжээчээр томилж болно. Тухайлбал; Газрын алба, төрийн албаны зөвлөл, барилгын инженер, ариун цэврийн улсын байцаагчдын нэгдсэн дүгнэлт гаргуулахаар томилж болно. Эдгээр шинжээчид нь санал нэгтэй байвал нэг дүгнэлт гаргаж, бүгд гарын үсэг зурна. Харин дүгнэлтийг санал нэгтэй гаргаж чадаагүй бол өөр саналтай шинжээч дүгнэлтээ тусад нь гаргаж тус тусдаа гарын үсэг зурж баталгаажуулна.

Шинжээчийн дүгнэлт асуудлыг тодруулж чадаагүй гэж үзэх үндэслэл байгаа, эргэлзээ бүхий гарсан, шинжээч нь хувийн болон албаны сонирхолтой байсны улмаас дүгнэлт үндэслэл муутай болсон, дахин шинжээч томилох нь судалгаа шинжилгээ явуулах илүү боломжоор хангагдсан, асуудлыг илүү нарийвчлан тодруулах нөхцөл бүрдсэн гэх мэт шалтгаанаар хэргийн оролцогчоос дахин шинжээч томилох хүсэлт гаргаж болно. Уг хүсэлтийг шүүх үндэслэлтэй гэж үзвэл дахин шинжээч томилно. Энэ тохиолдолд өмнө нь уг хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргасан этгээд оролцож болохгүй.

Шинжээч нь шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх үүрэгтэй. Тэрээр шүүхээс тавьсан асуултад үнэн зөв хариулах үүрэгтэй. Хэрэв шинжээч санаатайгаар зориуд худал дүгнэлт гаргавал Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлд зааснаар эрүүгийн хариуцлага хүлээнэ. Шинжээчийн дүгнэлт худал байна гэдэг нь шинжилгээний үр дүнгийн талаар бүрэн буюу зарим хэсгийг зориуд худлаа тодорхойлсон байхыг ойлгоно. Гэхдээ шинжээчийн мэдлэг чадвар дутагдсан, шинжээчид ирүүлсэн материал хангалтгүй, дутуу байсан зэргээс шалтгаалж дүгнэлт буруу гарсан бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

Шинжээч дүгнэлт гаргахаас хуульд заасан үндэслэлээр татгалзах эрхтэй. Шүүхээс шинжээчид өгсөн материал нь шинжилгээ хийх, дүгнэлт гаргах шаардлага хангахгүй байгаа болон шинжээч нь шүүхээс дүгнэлт гаргуулахаар даалгасан үүргийг биелүүлэхэд шаардлагатай мэдлэг эзэмшээгүй, өөрөө үндэслэл бүхий үнэн зөв дүгнэлт гаргах чадваргүй бол дүгнэлт гаргахаас татгалзаж болно.

Нөгөө талаар шинжээчээр дүгнэлт гаргуулахаар хүргүүлсэн баримтууд нь дүгнэлт гаргахад хангалттай биш бол шаардлагатай нэмэлт материалыг гаргаж өгөхийг шүүхээс хүсэж болно.

Шинжээч дүгнэлтээ заавал бичгээр гаргаж томилсон шүүхэд ирүүлнэ. Шинжээчийн дүгнэлтэд ямар зорилгоор шинжилгээ хийсэн, шинжилсэн арга, хэлбэр, дүгнэлтийн агуулгыг нэг бүрчлэн тодорхой бичнэ. Мөн шинжээчийн дүгнэлтэд шүүгчээс ямар асуулт тавьсан, уг асуултад ямар хариу өгсөн, түүний үндэслэлийг дэлгэрэнгүй тусгасан байх шаардлагатай.

Шинжээч нь хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдлыг олж тогтоосон бол шүүх шаардсан эсэхийг харгалзахгүйгээр дүгнэлтэдээ тусгах эрхтэй. Хуульд заасан “хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдал” гэдэг нь шинжээч дүгнэлт гаргах явцдаа шүүгчийн тавьсан асуултаас гадна хэргийг шийдвэрлэхэд зайлшгүй ач холбогдол бүхий зүйлийг шинжлэн тогтоосныг хэлнэ.

Шинжээчийн дүгнэлт нь нотолгооны онцгой хэрэгсэл биш бөгөөд нотлох баримтын бусад төрлийн нэгэн адил шүүх хэрэгт цугларсан бусад нотлох баримттай тал бүрээс нь харьцуулан үзсэний үндсэн дээр тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв талаас нь үнэлэх ёстой.

Шинжээчийн дүгнэлтийг шийдвэрийн үндэслэл болгосон бол энэ талаар шүүхийн шийдвэрээс харах боломжтой байх учиртай. Түүнд шинжээчийн дүгнэлт юунд тулгуурласан, шинжилгээнд ямар баримт гаргаж өгсөн, тэдгээр нь бүрэн судлагдсан эсэх, шүүхээс тавигдсан асуулт, түүнд ямар хариу өгөгдсөн, уг хариу дүгнэлтийг шүүх хэрхэн үнэлсэн тухай шийдвэрт тодорхой тусгагдах ёстой.

Маргаантай асуудлын талаар сонирхогч этгээд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө улсын мэргэжлийн хяналтын байгууллага, түүний улсын байцаагч, төрийн албаны салбар зөвлөл зэрэг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хандаж, дүгнэлт гаргуулж байна. Энэ нь шинжээчийн дүгнэлт биш бөгөөд ихэвчлэн хэн, ямар зорилгоор хандсанаас хамаарч тэд тухайн этгээдийн хүсэл, сонирхолд нийцсэн дүгнэлт гаргах явдал түгээмэл ажиглагддаг. Ийм замаар гаргасан дүгнэлтүүд нотолгооны хэрэгсэл болох боловч зайлшгүй дахин нягтлах, хэргийн бусад нотолгоотой харьцуулах шаардлагатай.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон бусад ажиллагаа

- 48.1 Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тодруулахын тулд шүүх үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааг хөндлөнгийн 2-оос доошгүй гэрчийг байлцуулан хэргийн оролцогчдыг оролцуулан хийх бөгөөд энэ тухай тэмдэглэл үйлдэж, түүнд уг ажиллагаанд оролцогчдоор гарын үсэг зуруулна. Харин хэргийн оролцогч ирээгүй нь уг ажиллагаа явуулахад саад болохгүй.
- 48.2 Хөндлөнгийн гэрчээр уг хэрэгт хувийн болон албаны сонирхолгүй, эрх зүйн бүрэн чадамжтай иргэнийг оролцуулна. Хөндлөнгийн гэрч түүнийг байлцуулан хийсэн ажиллагааны явц, агуулга, дүнг баталж өгөх үүрэгтэй. Хөндлөнгийн гэрч тэмдэглэлд засвар оруулахаар санал гаргах эрхтэй.

48.3 Хөндлөнгийн гэрч энэ хуулийн 48.2-т заасан үүргээ биелүүлээгүй бол түүнд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ТАЙЛБАР

Эрх зүйн маргааныг үндэслэлтэй шийдвэрлэх үүднээс хүний танин мэдэж болох янз бүрийн аргыг ашиглаж болно. Үүний нэг хэсэг нь нотолгооны бусад хэрэгсэл буюу шүүхээс явуулах үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагаа бөгөөд түүнийг баталгаажуулсан тэмдэглэл юм. Аливаа үйлдэл эсхүл тэмдэглэл нь дангаараа нотолгооны хэрэгсэл болж чадахгүй. Тухайн хэрэгт ач холбогдолтой нөхцөл, байдлыг нотлох, бэхжүүлэх зорилготой үйлдэл, түүнийг бичгийн хэлбэрээр илэрхийлсэн тэмдэглэлтэйгээ нийлж нотолгооны хэрэгсэл болдог. Хэргийн нөхцөл байдлыг тодруулахад чиглэсэн хойшлуулшгүй ажиллагааг маргалдагч талуудын хүсэлтээр эсхүл шүүх өөрийн үзэмжээр газар дээр нь туршилт, үзлэг хийж магадлах шаардлага захиргааны хэрэг хянан шийдвэрлэх явцад гардаг. Ялангуяа шүүхэд ирүүлэх боломжгүй зарим зүйлийг газар дээр нь үзэх, баримт бичгийг эхтэй нь харьцуулан тулгаж тодруулах, ямар нэгэн объектын байршлыг тодорхойлох зэрэг зорилгоор хийсэн үзлэг, бодит байдлыг тогтоох туршилт, таньж олуулах ажиллагааг шүүх өөрөө явуулж үйлдсэн тэмдэглэл нь маргааныг хянан шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдолтой нотолгооны хэрэгсэл болно. Нөгөө талаар шүүхийн үзлэг, туршилт нь шүүгчийн нотлох баримтыг эргэлзээгүйгээр үнэлэх итгэлийг бий болгодог эерэг үр дагавартай.

Эдгээр ажиллагаа явуулах тухай хэргийн оролцогч нарт мэдэгдэж, тэднийг уг ажиллагаанд оролцуулна. Үүнээс гадна хөндлөнгийн гэрчээр хоёроос доошгүй хүнийг байлцуулна.

Шүүх, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааг хэрхэн явуулсан, ямар арга замаар уг ажиллагааг явуулсан, түүнд оролцсон, байлцсан хүмүүс албан тушаалтан, ямар эрх, үүрэгтэйгээр хэрхэн оролцсон тухай нэг бүрчлэн тэмдэглэл үйлдэнэ. Тэмдэглэлд уг ажиллагаанд оролцсон хүмүүсээр гарын үсэг зуруулна.

Хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон бусад ажиллагаа нь шүүх нотлох баримт бүрдүүлэх нэгэн арга болдог. Уг ажиллагааг явуулахад хэргийн оролцогч ирээгүй явдал нь түүнд саад болохгүй бөгөөд энэ шалтгаанаар тухайн ажиллагааг хойшлуулах буюу зогсоох түүнээс татгалзах үндэслэл болдоггүй.

Манай шүүхүүдэд ажиглагдсан нэг дутагдал бол шүүхийн үзлэгийг “хэргийн газрын үзлэг” болгож шүүгчийн туслах эсхүл нарийн бичгийн дарга нар хийдэг явдал юм. Тэдний хийсэн үзлэг нь нотлох баримт байтугай нотолгооны хэрэгсэл ч болж чадахгүйн дээр хуульд заасан арга журмаар авагдаагүй, нотлох чадваргүй “цаас” гэж үзэхээс өөр аргагүй.

Шүүгчгүйгээр, шүүх бүрэлдэхүүнгүйгээр шүүх гэсэн ойлголт бий болохгүй. Энэ үүднээс авч үзвэл шүүгч, шүүх бүрэлдэхүүн үзлэгийг удирдан явуулж, шүүгчийн туслах нарийн бичгийн дарга үйл ажиллагааных нь тэмдэглэлийг үйлдсэн нөхцөлд жинхэнэ

шүүхийн үзлэг болох төдийгүй захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн үндэслэл болж чадна.

Нүүрэлдүүлэн байцаах ажиллагаа түүний тэмдэглэл захиргааны хэргийн нотолгооны бусад хэрэгсэлд хамааруулж болно гэж үзэж байна. Нүүрэлдүүлэн байцаах ажиллагаа нь нотолгооны зүйлийг зөв тодорхойлох, хэргийг шалгах аргаа сонгох, нотолгооны хэрэгслүүдийг харьцуулан үзэх, ямар баримтаар ямар шаардлага, татгалзлаа нотолж, үгүйсгэж байгааг нь тодруулахад энэ аргыг хэрэглэх нь ач холбогдолтой юм.

Шүүхийн үзлэг, туршилтыг явуулахад 2-оос доошгүй хөндлөнгийн гэрчийг оролцуулсан байх учиртай. Тэдний эрх үүрэг нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 58, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 43 дугаар зүйлд заасан "Гэрч"-ийн эрх, үүргээс ялгаатай.

Хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон бусад ажиллагаанд хөндлөнгийн гэрчээр оролцох хүмүүст хамаарах шалгуур үзүүлэлт, хязгаарлалтыг хуульд тогтоон зохицуулжээ. Хөндлөнгийн гэрчээр оролцох хүмүүст хамаарах шалгуур, хязгаарлалт нь тухайн хэрэгт хувийн болон албаны сонирхолгүй, 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн байна.

Хөндлөнгийн гэрч тухайн хэрэгт хувийн болон албаны сонирхолтой бол энэ тухайгаа шүүхэд мэдэгдэн уг ажиллагаанд хууль, тогтоосон журмын хүрээнд буюу шүүхээс явуулж байгаа үзлэг, туршилтын явцад бүрэн гүйцэд байлцаж уг ажиллагааны явц хэрхэн яаж явагдсан, юуг ямар аргаар тогтоосныг батална. Хөндлөнгийн гэрч үүргээ хэрэгжүүлэхдээ хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон бусад ажиллагаа явуулсан тухай тэмдэглэлийг уншин танилцаж, түүнийг үнэн зөв бичигдсэн эсэхийг баталж гарын үсэг зурж баталгаажуулах, түүнд засвар оруулахаар санал гаргах, саналаа тусгуулах эрхтэйгээр оролцоно.

Хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол түүнд хууль, тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ гэж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т заасан. Гагцхүү одоогоор хөндлөнгийн гэрчид эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэх тухай тодорхой заалт тусгагдаагүй байна. Гэхдээ шүүхийг үл хүндэтгэсэн гэж үзэж болох юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн
49 дүгээр зүйл. Орчуулагч, хэлмэрч

- 49.1. Хэргийн оролцогч монгол хэл мэддэггүй, эсхүл хэлгүй, дүлий бол түүний хүсэлтээр орчуулагч, хэлмэрчийг шүүгч захирамж гарган томилно. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогч орчуулагч, хэлмэрчийн үүргийг гүйцэтгэхийг хориглоно.
- 49.2. Орчуулагч, хэлмэрч тухайн этгээдийн нэхэмжлэлийн шаардлага, тайлбар, мэдүүлэг, татгалзал буюу оролцогчийн шаардлага, тайлбар, мэдүүлэг, татгалзал, шүүх хуралдааны болон бусад ажиллагаа, шүүхийн шийдвэрийн агуулгыг орчуулж, хэлмэрчилж өгөх, хэргийн материалтай танилцахад нь туслах үүрэгтэй.

- 49.3. Орчуулагч, хэлмэрч шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх, үнэн зөв орчуулах, хэлмэрчлэх үүрэгтэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн

60 дугаар зүйл. Орчуулагч, хэлмэрч

- 60.1. Хэргийн оролцогч монгол хэл мэддэггүй, эсхүл хэлгүй, дүлий бол түүний хүсэлтээр орчуулагч, хэлмэрчийг захиргааны хэргийн шүүгч захирамж гарган томилно.
- 60.2. Орчуулагч, хэлмэрч захиргааны хэргийн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирж, тухайн этгээдийн нэхэмжлэлийн шаардлага, тайлбар, мэдүүлэг, татгалзал буюу оролцогчийн шаардлага, тайлбар, мэдүүлэг, татгалзал, шүүх хуралдааны болон бусад ажиллагаа, шүүхийн шийдвэрийн агуулгыг үнэн зөв, бүрэн орчуулж, хэлмэрчилж өгөх, хэргийн материалтай цаг хугацаанд нь танилцахад туслах үүрэгтэй.
- 60.3. Орчуулагч, хэлмэрч нь орчуулгыг тодруулахаар асуулт тавьж болно.
- 60.4. Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогч орчуулагч, хэлмэрчийн үүрэг гүйцэтгэхийг хориглоно.

ТАЙЛБАР

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 60, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 49 дугаар зүйлийн “Орчуулагч, хэлмэрч” гэсэн гарчиг доторх заалтууд нь адил утга, агуулгатай байна. Иймд захиргааны эрх зүйн нотолгоо, нотлох баримт гэсэн агуулгад нийцүүлэх нь зүйтэй гэж үзсэнээс гадна Хууль тогтоогч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн “Нотлох баримт” гэсэн хэсэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 49 дугаар зүйлийн “Орчуулагч, хэлмэрч” гэсэн заалтыг оруулж ирсэн тул товч тайлбар хийж байна.

Хэргийн оролцогч монгол хэл мэддэггүй эсхүл хэлгүй, дүлий бол тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангахад нь туслалцаа үзүүлэх зорилгоор захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн захирамжаар орчуулагч, хэлмэрч томилно. Энэ нь Монгол улсын Үндсэн хуулиар баталгаажуулснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг монгол хэлээр явуулах зарчим, хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг хэрэгжүүлэхтэй шууд холбоотой. Монгол улсын Үндсэн хуулийн тавин гурав дугаар зүйлд “шүүн таслах ажиллагааг монгол хэлээр явуулна. Монгол хэл мэдэхгүй хүнд хэргийн баримт сэлтийг хэлмэрчлүүлэн бүрэн танилцуулах бөгөөд шүүх хуралдаан дээр эх хэлээр нь үг хэлэх эрх олгоно” гэж заасныг хэрэгжүүлэх баталгаа нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 60, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 49 дугаар зүйлийн “Орчуулагч, хэлмэрч” гэсэн гарчиг доторх заалтууд юм.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг монгол хэлээр явуулж, төрийн албан хэрэг хөтлөх бичгээр баталгаажуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч монгол хэл мэдэхгүй бол өөрийн эх хэл, буюу мэддэг хэл бичгээр, хэрэв хараагүй, хэлгүй, дүлий зэрэг шалтгааны улмаас төрийн албан ёсны хэл, бичгээр харилцаж чадахгүй бол дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан шүүхэд тайлбар, мэдүүлэг өгөх, үг хэлэх, нотлох баримт гаргаж өгөхдөө орчуулагч, хэлмэрчээр дамжуулан харилцана. Мөн түүнчлэн Шүүхийн тухай хууль /2002 оны/-ийн 10 дугаар зүйлд шүүн таслах ажиллагааг монгол хэлээр явуулах бөгөөд монгол хэл мэдэхгүй хүн хэргийн баримт сэлтийг орчуулан авах буюу хэлмэрчлүүлэн бүрэн танилцах, шүүх хуралдаан дээр эх хэлээрээ үг хэлэх, орчуулагч, хэлмэрч авах эрхтэй болохыг заасан.

Орчуулагч, хэлмэрч нь нэг талаас монгол хэл мэдэхгүй, хэлгүй, дүлий зэрэг хэргийн оролцогчоос шүүхэд хандаж нэхэмжлэл, тайлбар өгөх, нотлох баримт гаргах, шүүх хуралдаанд оролцох, үг хэлэх, мэтгэлцэх гэх мэтээр эрх үүргээ хэрэгжүүлэхэд шууд үйлчилдгээс гадна хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх тэдгээрийн эрхийг хангах нөхцөлийг бүрдүүлдэг. Шүүх хэргийн оролцогчийн энэ талаарх хуульд заасан эрхийг хангах, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орчуулагч, хэлмэрчээс бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид тэдний үүргийг гүйцэтгэх, орчуулга хийх буюу хэлмэрчлэхийг хориглоно.

Нэхэмжлэлийн шаардлага, тайлбар, мэдүүлэг, татгалзал, нотлох баримт зэргийг орчуулах, мэтгэлцэх боломжийг хангах, шүүхийн дуудсан цагт хүрэлцэн ирж, үүргээ гүйцэтгэх, шүүх хуралдааны явцыг бүрэн хэмжээгээр орчуулж, хэлмэрчилж өгөх үүрэгтэй.

Орчуулга худал байх, худал хэлмэрчлэх гэдэг нь нэг хэлнээс нөгөө хэлэнд бичгээр буюу яриагаар хөрвүүлэхдээ утга санааг нь өөрчлөн ойлгуулах, орчуулж, хэлмэрчилж хэлэх ёстой зүйлийг хэлэхгүй орхих, бичээгүй, хэлээгүй зүйлийг нэмж оруулах зэрэг хэлбэрүүдээр илэрнэ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай Монгол улсын хуульд зааснаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас олгосон тусгай зөвшөөрөлтэй хүн шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд орчуулагч, хэлмэрч хийх ёстой.⁸²

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5-д “Санаатайгаар буруу орчуулсан, хэлмэрчилсэн, эсхүл орчуулга хийхээс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан хэлмэрчид Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заажээ.

Орчуулагч, хэлмэрч бол мэргэжил эзэмшсэн иргэн бөгөөд түүний орчуулга, хэлмэрчлэл бол нотолгооны хэрэгсэл, нотлох баримт биш гэж үздэг. Шүүх нотлох

⁸² Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай Монгол улсын хууль. 15 дугаар зүйл 15.5.2 дахь заалтаас үзнэ үү.

баримтад тулгуурлан хэрэг шийдвэрлэх үүрэгтэй болохоос зөв ч бай, буруу ч бай орчуулга, хэлмэрчлэлд тулгуурлан хэрэг шийдвэрлэхгүй.

Харин орчуулагч, хэлмэрч нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг бусад оролцогч мөн. Ийм ч учраас Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-ийн “бусад оролцогч” гэсэн хэсэгт оруулжээ.

Ер нь шүүх хуралдаанаас өмнөх шатанд хэргийн оролцогчид орчуулагч, хэлмэрчээ өөрөө сонгох, шүүх хуралдааны үед шүүх, шүүгч томилдог байх нь зүйтэй. Нөгөө талаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид өөрийн орчуулагч, хэлмэрчээ шүүх хуралдаанд оруулах сонирхолтой төдийгүй ийнхүү шаарддагийг анхаарч үзүүштэй санагддаг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн
51 дүгээр зүйл. Тэмдэглэл

- 51.1. Анхан шатны шүүх хуралдаан болон хэргийн оролцогч оролцож байгаа бол давж заалдах, хяналтын шүүх хуралдаанд тэмдэглэл үйлдэнэ.
- 51.2. Үзлэг, туршилт хийх, таньж олуулах, нүүрэлдүүлэн мэдүүлэг авах зэрэг хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагаа гүйцэтгэхэд тэмдэглэл үйлдэнэ.
- 51.3. Тэмдэглэлийг энэ хуулийн 7.1-д заасан шаардлагад нийцүүлэн үйлдэнэ.
- 51.4. Тэмдэглэлийг шүүх хуралдааны үед шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон бусад ажиллагааны үед шүүгч, түүний даалгаснаар шүүгчийн туслах үйлдэнэ.
- 51.5. Тэмдэглэлд ямар ажиллагааг хэн, хэзээ, хаана явуулсан, түүний эхэлсэн ба дууссан цаг, ажиллагаанд оролцсон буюу байлцсан хүн нэг бүрийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, түүнчлэн ажиллагааны дараалал, явц, илэрсэн нөхцөл байдлыг бичнэ. Тэмдэглэлийг уг ажиллагаа явуулахад оролцсон буюу байлцсан бүх хүн уншиж танилцах бөгөөд тэмдэглэлд засвар оруулахаар санал гаргах эрхтэйг тэдэнд тайлбарлаж өгнө.
- 51.6. Тэмдэглэлд уг ажиллагааг явуулсан этгээд болон түүнд оролцсон буюу байлцсан бүх хүн гарын үсэг зурна. Тэдгээр нь гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй.
- 51.7. Тэмдэглэлд гэрэл зураг, зураглал, ул мөрнөөс буулгаж авсан хэв болон хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой бусад зүйлийг хавсаргаж болох бөгөөд тэмдэглэлд энэ тухай заана.

ТАЙЛБАР

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 68 дугаар зүйлийн “Шүүх хуралдааны тэмдэглэл” гэсэн заалт нь нотолгооны болон нотлох баримтын онолын хувьд нэлээд явцуу заалт тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 51 дүгээр зүйлийн “Тэмдэглэл” гэсэн заалтад голлон анхаарлаа хандуулаа.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиар тогтоосон журмыг шүүх, шүүгч, хэргийн оролцогчид сахин биелүүлэх үүрэгтэй. Энэ үүргээ хэрхэн ёсчлон биелүүлснийг нь харах “толь” бол тэмдэглэл юм. Шүүхийн ажиллагааны бүхий л үе шат, үйл явц, шийдвэрийн агуулгыг бүрэн тусгаж баримтжуулсан нотолгооны хэрэгслийг тэмдэглэл гэнэ.

Тэмдэглэл бол бичмэл баримтын биеэ даасан хэлбэр мөн бөгөөд нотлох баримт бүрдүүлэх нэгэн арга мөн.

Тэмдэглэл хоёр төрөлтэй байна. Нэгдүгээрт; Үйлдлийн тэмдэглэл. Хоёрдугаарт; Шүүх хуралдааны тэмдэглэл.

Үйлдлийн тэмдэглэл гэж хэргийн оролцогчтой шүүх, шүүгч, шүүхийн ажилтнаас харилцсан байдал болон нотлох баримтыг гаргах, хүлээн авах, олж цуглуулах, бэхжүүлэх, шинжлэн судлах, хадгалах, шилжүүлэх, устгах зэрэг ажиллагааг баримтжуулсныг тусгасан бичмэл баримтыг, шүүх хуралдааны тэмдэглэл гэж бүх шатны шүүхийн хуралдааны үед болсон үйлдэл, үйл ажиллагаа, оролцогчдын эрхийг хангасан байдал, мэтгэлцээний явц, нотлох баримтыг шинжлэн судалсан тухай болон шүүхийн шийдвэрийн агуулга зэргийг бүрэн тусгасан бичмэл баримтыг хэлнэ.

Үйлдлийн тэмдэглэл нь шүүгчийн санаачилгаар эсхүл оролцогчдыг хүсэлтээр хэргийг хянах шүүх хуралдааныхаас бусад аль ч үе шатанд үйлдэгдэж болно.

Хэргийн оролцогч давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд оролцоогүй бол шүүх хуралдааны тэмдэглэл үйлдэхгүй байж болдог. Харин захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхэд хэлэлцэгдээгүй нотлох баримтыг шинжлэн судлах, үнэлэх эрхтэй тул шаардлагатай гэж үзвэл хэргийн оролцогч хуралдаанд оролцоогүй ч гэсэн нотлох баримтыг хэрхэн хэлэлцсэнээ оролцогчдод ойлгомжтой болгохын тулд тэмдэглэл үйлдэж тэдэнд танилцуулж болно.

Үзлэг, туршилт, таньж олуулах, нүүрэлдүүлэн мэдүүлэг авах ажиллагааны тэмдэглэл нь тухайн нотолгооны хэрэгслийг тайлбарлахад орсон тул энд дурьдаж байгаа үйлдлийн тэмдэглэлд хамааруулах шаардлагагүй гэж үзлээ.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэхэд хуульд заасан журмын дагуу тэмдэглэл үйлдэх шаардлага байнга гардаг. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “тэмдэглэл үйлдэнэ”, “баталгаажуулна”, “баримтжуулна”, “мэдэгдэнэ”, “эрх үүргийг нь тайлбарлана” гэх мэтийн олон заалт шаардлага бий. Энэ бүхэн нь бүгд л тэмдэглэл үйлд гэсэн санаа юм. Түүгээр ч үл барам шүүх санаачилгаараа болон хэргийн оролцогчдын хүсэлтээр хуульд зааснаас гадна ямар ч ажиллагаан дээр үйлдлийн тэмдэглэл хөтлөх шаардлагатай болдог.

Шүүх хуралдааны болон хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагаанд тэмдэглэлийг монгол хэлээр, төрийн албан ёсны бичгээр үйлдэнэ. Шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдаан болон хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааг дүрс болон дууны бичлэгт буулгаж болох боловч заавал бичгээр үйлдсэн хувийг хэрэгт авсан байх ёстой.

Шүүх хуралдааны тэмдэглэлийг хуралдаан эхлэхээс шүүх хуралдааныг хаах хүртэл хөтөлнө. Тэмдэглэлийг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга бичнэ.

Харин хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон бусад ажиллагааны тэмдэглэлийг уг ажиллагааг явуулж байгаа шүүгч эсхүл шүүгчийн даалгаснаар шүүгчийн туслах, шүүхийн нарийн бичгийн дарга үйлдэж болно.

Тэмдэглэлд дараах зүйлүүдийг тусгагдсан байж хууль ёсны нотолгооны хэрэгсэл болно.

- Хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон ямар ажиллагаа явагдсан;
- Уг ажиллагааг хэн, хэзээ, хаана явуулсан;
- Түүний эхэлсэн ба дууссан цаг;
- Ажиллагаанд оролцсон, байлцсан, хүн нэг бүрийн овог, эцгийн нэр, өөрийн нэр, хаяг, шаардлагатай гэж үзвэл ажил, албан тушаалыг.
- Ажиллагааны дараалал, явц, илэрсэн нөхцөл байдлыг тус тус тодорхойлон бичнэ.
- Ажиллагаагаар шийдвэрлэсэн, тогтоосон зүйл

Шүүх хуралдааны тэмдэглэлд уг ажиллагаа явуулсан шүүгч, тэмдэглэл үйлдсэн этгээд /шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга/ гарын үсэг зурна. Мөн тухайн ажиллагаанд оролцсон хүмүүс, байлцсан хүн тэмдэглэлийг уншиж танилцан бүгд гарын үсэг зурна. Эдгээр хүмүүс нь гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй. Тэмдэглэлд засвар оруулахаар санал гаргах эрхтэй болохыг шүүгчээс тэдэнд тайлбарлаж өгөх үүрэгтэй бөгөөд тэдний санал, оруулсан засвар, нэмэлт бүрэн тусгагдсан байвал зохино.

Тэмдэглэлд нотолгооны ач холбогдолтой зарим зүйлийг хавсаргаж болно. Жишээ нь: фото болон дүрс бичлэг, зураг ба зураглал, ул мөрнөөс буулгасан хэв, эд зүйл, баримт зэргийг хавсаргаж болох юм. Харин тэмдэглэлд ямар зүйлийг хавсаргасан тухай заавал тусгана.

31 дүгээр зүйл. Захиргааны хэргийг нотлох үүрэг

- 31.1. Захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэнэ.
- 31.2. Захиргааны хэргийн шүүх хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг байгууллага, албан тушаалтан, иргэнээс гаргаж өгөхийг шаардах эрхтэй бөгөөд холбогдох этгээд уг шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 31.3. Оролцогч, түүний өмгөөлөгч, төлөөлөгч нотлох баримт гаргаж өгөх, үнэлэхийг захиргааны хэргийн шүүхээс шаардах эрхтэй.
- 31.4. Нотлох баримт гаргах, цуглуулах талаар хуульд заасан журмыг зөрчиж олж авсан нотлох баримт нотлох чадвараа алдах бөгөөд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.
- 31.5. Энэ хуулийн 31.2.-т заасан шаардлагыг биелүүлээгүй гэм буруутай этгээдэд Захиргааны хариуцлагын тухай⁸³ хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 31.6. Төрийн байгууллага, хуулийн этгээд, хувь хүний гаргаж өгсөн бичмэл нотлох баримтыг уг хэргийн талаар захиргааны хэргийн шүүхээс гаргасан шийдвэр

⁸³ Захиргааны хариуцлагын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 4-5 дугаарт нийтлэгдсэн.

хүчин төгөлдөр болсны дараа анх гаргаж өгсөн этгээдийн хүсэлтээр буцааж өгч болох бөгөөд шаардлагатай гэж үзвэл хуулбарыг хэрэгт хавсаргана.

31.7. Шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт зайлшгүй шаардагдвал хуралдааныг нэг удаа хойшлуулна. Энэ тохиолдолд шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

31.8. Захиргааны хэргийн шүүх хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасах бөгөөд тийм баримтыг шаардан гаргуулж болохгүй.

ТАЙЛБАР

Нотлох үүрэг. Захиргааны байгууллага, албан тушаалтнаас нийтийн эрх зүйн хүрээнд гаргасан, захирамжилсан шинжтэй актын үр дагавар нь эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчлөө гэж үзсэн иргэн, хуулийн этгээд уг эрхээ хамгаалуулахаар Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах эрхтэй бөгөөд уг нэхэмжлэл, хүсэлт, гомдол үндэслэлтэй эсэхийг хэргийн оролцогчид болон шүүх нотлох үүрэгтэй. Өөрөөр хэлбэл тухайн актын хууль зүйн үндэслэлийг нотлох баримтад тулгуурлан хянана гэсэн үг. Захиргааны актын хууль зүйн үндэслэлд:

1. Захиргааны акт гаргах болсон нөхцөл, шалтгаан;

2. Актыг гаргахдаа хуулийн зүйл, заалтыг хэрхэн хэрэглэсэн;

3. Актыг боловсруулах, ёсчлох, хүргүүлэх шаардлага;

4. Зорилгодоо нийцсэн эсэх;

5. Акт улмаас үүссэн үр дагавар тус тус хамаарах бөгөөд үүнийг шүүх нотлох баримтаар хөдөлбөргүй тогтоох үүргийг хүлээнэ. Нотолгооны энэ зарчим бол захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог бөгөөд онол, арга зүйн хувьд судлагдах шаардлагатай сэдэв мөн.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-ийн “Захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэнэ” гэсэн өгүүлбэрийг шууд утгаар нь ойлговол зөвхөн шүүхэд үүрэг болгосон мэт харагдаж байна. Ялангуяа “үнэлэх” нь хэнтэй ч хуваалцахгүй шүүхийн хуулиар хүлээсэн үүрэг.

Тэгвэл бид “нотлох баримтыг цуглуулах” гэдэг ойлголтын утга, агуулгыг дэлгэрүүлэн авч үзэх хэрэгтэй болж байна. Хүн аливаа зүйлийг цуглуулах үйлдэл хийхдээ хүссэн зүйлээ бэлээр олж авах, өөрт байгаагаа нийлүүлэх, эрж хайх, бусдын өгснийг авах, бусдаас янз бүрийн арга /гуйх, зээлэх, хулгайлах, залилах гэх мэт/ -аар авах зэрэг хавсарсан үйлдэл хийж зорилгодоо хүрдэг. Тэр ч байтугай зохиомлоор бий болгох аргыг ч хэрэглэнэ.

Хэргийн оролцогч заргаа авахын тулд хүн л юм болохоор нотолгоогоо өөрөө дээрх аргаар л олж авна, цуглуулна, түүнийгээ шүүхэд өгнө, үнэлэхийг шаардана. Ийнхүү олж авч, цуглуулж нотолгоо болгож байгаа хэрэгслүүдэд нотлох баримт

болохуйц шаардлага хангасан нотолгооны хэрэгсэл ч байна, шаардлага хангахгүй ч байж болно.

Шүүх нь үүнийг хүлээн авч нотлох баримт болохуйц шаардлага хангасан нотолгооны хэрэгсэл мөн үү гэдэгт мэргэжлийн дүгнэлт хийнэ.

Тэгэхээр хэргийг шударгаар шийдвэрлэх үүрэгтэй шүүхэд хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, зайлшгүй шаардлагатай нотлох баримтыг ялган авах, өөрөө хуульд заасан арга, журмаар олж авч, цуглуулан үнэлэх үүрэг өөрийн эрхгүй бий болно. Нотлох баримтыг цуглуулах, үнэлэхийн харилцан хамаарал, гол агуулга нь энэ юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “нотлох баримтыг цуглуулах” гэдэг ойлголтод;

1. нотлох баримтыг гаргах;
2. нотлох баримтыг илрүүлэх буюу заах;
3. нотлох баримтыг олж авах;
4. нотлох баримтыг судалж шалгах гэсэн харилцан бие биенээ нөхцөлдүүлсэн, хоорондоо салшгүй үйл ажиллагаанууд хамаарна.

Эрх зүйн шинжлэх ухааны эрдэмтэд, судлаачид дээрх ажиллагаануудыг нотолгооны үе шат⁸⁴ гэж нэрлэдэг бөгөөд цэвэр нотлох баримт гэдэг ойлголттой холбон тайлбарладаг байна. Нотлох баримтыг цуглуулах /илрүүлэх буюу заах, олж авах, судалж шалгах/ ажиллагааг үе шатаар нь ангилан тайлбарлахад Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-31.6 дахь хэсэг хамт тайлбарлагдах болно.

Нотлох баримтыг гаргах. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30, 31 дүгээр зүйлүүдэд “нотлох баримт гаргах, гаргаж өгөх, цуглуулах” гэсэн заалтууд орсон нь хэргийн оролцогчид өөрт байгаа болон олж авсан нотолгоогоо шүүхэд өгөх эрхтэй, үүрэгтэй гэдгийг тодорхойлсон заалт юм. Өөрт байгаа хэрэгт ач холбогдолтой гэж үзсэн баримтаа шүүхэд гаргаж өгөхгүй байх явдал гардаг. Үүнийг шүүгч өөрөөс нь шаардан гаргуулж болно. Тийм учраас хэргийн оролцогч нотолгоогоо шүүхэд гаргаж өгөх үүрэгтэй гэж үзэж байгаа юм. Шүүн таслах ажиллагаанд мэтгэлцэх зарчим хэрэгжиж байгаа өнөө үед эрүүгийн хэргийн холбогдогчоос бусад Үндсэн хуулийн Цэц, иргэн, захиргаа, арбитрын хэргийн оролцогчид өөрийн нэхэмжлэл, тайлбараа батлах, нотлох үүргийг хүлээх учиртай.

Хэргийн оролцогчид тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчөөс өөрт байгаа эсхүл хуульд заасан үндэслэл журмаар олж авсан баримтыг өөрийн шаардлага буюу татгалзлын үндэслэлийг баталгаажуулах зорилгоор анхан болон давж заалдах шатны шүүх хуралдаан эхлэхээс өмнө хуульд заасан журмаар шүүхэд гарган өгнө.

Хэргийн оролцогчдоос нотлох баримтын чанартай баримтыг нэхэмжлэл, тайлбартай хамт ирүүлж байгаа бол нэхэмжлэл, тайлбарыг хүлээн авах журмаар бусад үед гарган өгч байгаа бол хөндлөнгийн гэрч, бусад этгээдийг байлцуулан албан ёсны (үйлдлийн тэмдэглэл) баримт үйлдэх журмаар шүүх хүлээн авна. Энэхүү эрх,

⁸⁴ Г.Батзориг “Гэмт хэргийн нотолгооны ерөнхий онол” 2002 он
Б.Галдаа “Монгол Улсын Нотолгооны эрх зүйн үндсэн асуудал” 2001 он

үүргийн нэгдэл нь нотлох баримтыг гаргах ажиллагааны үндсэн арга төдийгүй хуульчлагдсан журам нь юм. Харин гарган өгсөн нотолгооны хэрэгсэл нь тухайн хэрэгт хамааралтай юу, ач холбогдолтой юу гэдэг нь өөр асуудал.

Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлд “Нотлох баримтыг анхан шатны шүүх хуралдаан эхлэхийн өмнө гаргаж өгнө”, мөн хуулийн 161 дүгээр зүйлийн 161.5-д “Давж заалдах гомдлын үндэслэлд анхан шатны шүүхээр шийдвэрлээгүй шинэ нотлох баримтыг заах эрхгүй” гэж нотлох баримтыг анхан шатны шүүх хуралдаан эхлэхийн өмнө зөвхөн хэргийн зохигчид гаргах үүрэгтэй байхаар заажээ.

Гэтэл Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.6-д “Давж заалдах гомдолд баримт бичгийг ... хавсаргаж болно”, 85 дугаар зүйлийн 85.6-д “Давж заалдах журмаар хэрэг хянан хэлэлцсэн захиргааны хэргийн шүүх шинээр цуглуулсан, хуулийн шаардлага хангасан, эргэлзээгүй нотлох баримтыг үнэлж дүгнэх, үндэслэл болгох эрхтэй” гэж захиргааны хэргийн оролцогчдод нотлох баримт гаргах илүү өргөн эрх олгосон байна. Ийнхүү хэргийн оролцогчдоос давж заалдах шатны шүүхэд шинэ нотлох баримт гаргах эрх олгож байгаа нь шүүх нотлох баримтыг тал бүрээс нь бодитой шинжлэн судлах үнэлэх бололцоог нэмэгдүүлсэн ач холбогдолтой юм.

Хуулийн дээрх заалт нь давж заалдах шатны шүүхэд нэгэнт ирүүлсэн нотлох баримт болохуйц баримтыг шүүх хуралдаанаар хэлэлц, нотлох баримтын шаардлагыг хангаж байвал үнэл, хэрвээ эргэлзээтэй байвал үнэлэх шаардлагагүйн дээр нотлох баримтаас хасаж болно гэсэн агуулгатай юм. Гэхдээ давж заалдах шатны шүүх нотлох баримтын олох, цуглуулах үүрэг хүлээх үү гэдэг маргаантай асуудал. Судлаачийн хувьд давж заалдах шатны шүүх нотлох баримтыг олох, цуглуулах үүрэг хүлээхгүй зөвхөн оролцогчдын гаргасан, ирүүлсэн баримтыг хүлээн авч үнэлэх эсэхээ шүүх хуралдаанаар шийдвэрлэх ёстой гэж үздэг. Учир нь захиргааны хэргийн давж заалдах шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хяналтын шатны шүүгч нар гүйцэтгэж байгаатай холбон тайлбарлаж байгаа юм.

Нотлох баримтыг олж авах. Аливаа зүйл хүссэн зоргоор олддоггүй. Түүнчлэн бусдын хүсээд олж чадаагүй зүйлийг хүсээгүй этгээд олох бүр ч хэцүү. Ийм л нөхцөлд шүүх, шүүгч анхнаасаа өөрөө хүсээгүй ч эцсийн эцэст өөрийн эрхгүй өөрөө хүсч нотлох баримт олох үүрэг хүлээдэг нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог юм. Олуулахыг оролцогчид шаардана, шүүхэд өөрт нь тодорхой нотлох баримтыг олж авах сонирхол үүсдэг.

Мэдээж шүүх, хуульд заасан арга, журмаар захиргааны хэргийн нотлох баримтыг олж авах ёстой. Үүний тулд бусад шүүхэд даалгавар өгч түүний биелэлтийг хангуулах, зохигчийн тайлбар гаргуулах, гэрчийн мэдүүлгийг авах, бичмэл нотлох баримтыг гаргуулах, хүлээн авах, эд мөрийн баримтыг бэхжүүлэх, шинжээч томилж дүгнэлт гаргуулах, шүүхийн үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааг явуулах, үйлдлийн болон шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх зэрэг ажиллагааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37-51 дүгээр зүйлд заасан арга журмаар гүйцэтгэнэ. Түүнээс гадна бусдын эзэмшил, өмчлөлд байгаа тухайн хэрэгт ач

холбогдолтой зүйлийг шаардах, хүсэх, тохиролцох, албадах аргаар олж авна. Хууль ганцхан “шаардана” гэсэн арга хэрэглэхээр заасан бий.

Гэхдээ хэн нэгэн этгээдийн өмчлөлд нь байгаа зүйлийг аваад хэрэг хянан шийдвэрлэгдсэний дараа буцаан олгох, үйлдвэрлэлийн зориулалтын зүйл гаргуулснаас алдагдал гарахаар байвал алдагдлыг нөхөхөөр тохиролцох, хүсэлт болгох зэрэг аль болох эерэг арга хэрэглэх нь зүйтэй. Хэрэв хэрэг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримт гаргаж өгөхөөс татгалзсан, нуусан тохиолдолд шаардах, түүгээр ч зогсохгүй албадлагын арга хэрэглэж болох юм.

Шууд авах боломжгүй овор, хэмжээ ихтэй, амархан муудаж, гэмтэх бараа материалыг газар дээр нь үзлэг хийх, эзэмшигчид нь болон тодорхой эрх бүхий этгээдэд хадгалуулах, хамгаалуулах аргаар ч нотлох баримтыг олж авч болно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 50 дугаар зүйлд заасан арга. журмаар нотлох баримтыг хамгаалах, хадгалах тухай асуудлыг шийдвэрлэнэ. Тухайлбал; Хэрэг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримтыг өөрчлөх, устгах, бусдад шилжүүлэх, нуун дарагдуулах зэргээр уг хэргийг хянан шийдвэрлэхэд саад учруулж болох үндэслэл тогтоогдож байвал хэргийн оролцогч болон Захиргааны хэргийн шүүх өөрийн санаачилгаараа уг нотлох баримтыг хамгаалах, хадгалуулахаар шүүгчийн захирамж гаргаж, Цагдаагийн эсхүл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүлээлгэн өгч болно. Шүүхийн шийдвэрийг тухайн даалгавар хүлээсэн байгууллага, албан тушаалтан нэн даруй биелүүлэх үүрэгтэй.

Хэргийг анхан шатны шүүх шийдвэрлэх үедээ хамгаалалтыг үргэлжлүүлэх, нотлох баримтыг хэнд шилжүүлэх, эзэнд нь буцаан өгөх эсэх, гарсан зардлыг хэнээр төлүүлэх тухай шийдвэрлэх бөгөөд шүүхийн шийдвэрийн дагуу ямар ажиллагаа хийсэн тухай үйлдлийн тэмдэглэл хөтөлж хэрэгт хавсаргасан байвал зохино.

Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3-т хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч, төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг байгууллага, албан тушаалтан, иргэнээс гаргаж өгөхийг шүүхээр шаардуулан гаргуулах эрхийг нь хуульчилсны дээр шүүхийн шаардлагыг холбогдох этгээд биелүүлэх үүрэгтэй гэж заасан. “Холбогдох этгээд” гэж хэн бэ. Тухайн хэрэгт ач холбогдолтой нотолгоо болж болох баримт материалыг эзэмшил /эзэмших, ашиглах, захиран зарцуулах/-дээ байлгаж байгаа иргэн, хуулийн этгээдийг холбогдох этгээд гэнэ. Тэр шүүхийн шаардлагыг заавал биелүүлж шаардсан нотолгооны хэрэгслийг гаргаж өгөх, тайлбарлах үүрэгтэй.

Шаардлагыг ёсчлон биелүүлээгүй, биелүүлэхээс санаатай татгалзан гэм буруутай этгээдэд Захиргааны хариуцлагын тухай⁸⁵ хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. Тухайн этгээдийг шүүхийг үл хүндэтгэсэн гэсэн үндэслэлээр түүний гэм буруугийн хэр хэмжээг харгалзан Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 5000-25000 төгрөгөөр торгох, эсхүл 7-14 хоногийн

⁸⁵ Захиргааны хариуцлагын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 4-5 дугаарт нийтлэгдсэн.

хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна. Гэхдээ холбогдох этгээдийг шийтгэхдээ гол нь биш хэрэгцээтэй нотлох баримтаа орж авах нь шүүхэд гол учраас шүүгчид нотлох баримт гаргаж өгөөгүй этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэсэн практик бараг байхгүй.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5-ийн "... бусад нотлох баримт...", Өмгөөллийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.7-ийн "Хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай баримт бичгийг байгууллага, аж ахуйн нэгжээс гаргуулан авахаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгчид хүсэлт гаргах, баримт сэлтийг бэхжүүлэх зорилгоор дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглах" гэх зэрэг заалтууд нь нотлох баримтыг олж авах эрхийг оролцогчид, түүний өмгөөлөгч нарт олгосон агуулгатай болохыг анхаарах нь зүйтэй.

Нотлох баримтыг илрүүлэх буюу заах. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд тухайн маргаантай холбоотой нотлох баримт түүний эх сурвалжийг илрүүлэх ажиллагаа явуулах⁸⁶, хаана, ямар нотлох баримт, мэдээлэл байгааг өргөдөл, гомдол, хүсэлт, тайлбартаа зааж шүүхээр гаргуулах эрхтэй.

Нотлох баримтыг илрүүлэх нь оролцогчдын чадвар, чадамж, эрх зүйн боловсролтой холбоотой байдаг бол нотлох баримтыг заах нь өөрөө олох боломжгүй нотолгоог шүүхийн журмаар олж авахад чиглэсэн үйлдэл хамаардаг. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамгийн түгээмэл хийгддэг ажиллагаа бол оролцогчдын заасан нотлох баримтыг шүүх илрүүлэх, байгаа газраас нь гаргуулах, олж авах, цуглуулах ажиллагаа юм.

Хэргийн оролцогч хүсэлт гарган шүүхээр нотлох баримт бүрдүүлэх тохиолдолд тухайн нотлох баримтаар ямар нөхцөл байдлыг тогтоох гэж байгааг дурьдах, тодруулж өгөх, хаана байгаа, хэрхэн олж болох талаар тодорхой мэдээллийг шүүхэд өгөх шаардлагатай. Сүүлийн үед зарим өмгөөлөгч тийм нотолгоо хэрэгтэй гэж хүсэлт тавьчхаад зориуд эх сурвалжийг нь заахгүй шүүхийн ажиллагааг хүндрүүлэх байдал ажиглагдаж байна.

Илрүүлсэн, заасан нотлох баримтыг гаргуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Өөр хангалттай нотолгоо шүүхэд байгаа болон тухайн хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй баримт гаргуулахыг шаардвал заавал эрж хайх, олох, гаргуулах ажиллагаа хийх шаардлагагүй байж болно.

⁸⁶ Өмгөөлөлийн тухай хууль. 12 дугаар зүйл

12.2.3. Эрүү, иргэний хэргийн нотлох баримттай танилцах, тэмдэглэл хийх, шаардлагатай материалыг өөрийн зардлаар хувилж хуулбарлан авах;

12.2.4. нотлох баримт гаргаж өгөх, шинэ нотлох баримт шаардах буюу хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах, шинжээчийн дүгнэлт гаргуулах санал хүсэлт тавих;

12.2.7. хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай баримт бичгийг байгууллага, аж ахуйн нэгжээс гаргуулан авахаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгчид хүсэлт гаргах, баримт сэлтийг бэхжүүлэх зорилгоор дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглах;

Нотлох баримтыг бүрдүүлэх: Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хамгийн хариуцлагатай үе шат бол нотлох баримтын бүрдлийг хангах ажиллагаа юм. Нэг л хэргийн тухайд авч үзэхэд шүүхийн ажлын ачаалал энд л төвлөрдөг. Хуульд заасан хугацаанд хэргийн бүрдлийг хангана гэдэг ихээхэн идэвх, чармайлт, цаг хугацаа шаардсан ажил.

Захиргааны болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх хуулиар нотлох баримтыг бүрдүүлэх талаар тусгайд нь зохицуулсан заалт үндсэндээ байхгүй. Гэхдээ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “Хуулиар тусгайлан хугацаа тогтоогоогүй бол захиргааны хэргийн шүүх нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш аймгийн төвд 40, нийслэлд 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.” “Шүүхэд хангалттай нотлох баримт бүрдсэн бол тухайн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр товлон зарлана.” гэсэн заалт нь хэргийн бүрдлийг хангах хугацааны хуулийн зохицуулалт гэж үзэхээс өөр аргагүй.

Шүүхээр хянан хэлэлцэгдэх, хэрэгт хамааралтай баримт сэлтийг эрж олох, шаардан гаргуулах, бэхжүүлэх талаар шүүхийн явуулж байгаа үйл ажиллагааг бүхэлд нь нотлох баримтыг бүрдүүлэх ажиллагаа гэнэ.

Хэргийг бодитой шийдвэрлэхэд хангалттай нотлох баримт цугларсан байх ёстой. Ер нь шүүх нотлох баримтыг бүрдүүлж болох бүхий л аргыг хэрэглэж байж бодит үнэнийг тогтоох боломжийг олж авдаг. Энэ үүднээс авч үзвэл нотлох баримтыг бүрдүүлэх ажиллагаа нь шүүхэд ногдох хариуцлага мөн. Шүүгчийн мэдлэг, дадлага, идэвх чармайлттай ч холбоотой.

Нотлох баримтыг бүрдүүлэх ажиллагаа нь нотлох баримтыг цуглуулах ажиллагаатай нэлээд төстэй хэдий ч ялгагдах онцлог бий. Тухайлбал нотлох баримтыг цуглуулах ажиллагаанд хэргийн оролцогчид оролцдог тэдний идэвхтэй оролцоо хэрэгтэй байдаг бол хэргийн бүрдэл хангагдаж байгаа эсэхийг тэд сонирхохгүй.

Нотлох баримтыг хэргийн оролцогчдоос хүлээн авна, бусдаас гаргуулна, шаардана, даалгана, албадна, эрж хайна, өөрөө газар дээр нь үзнэ, туршина, мэргэшсэн байгууллага, хүмүүсээр дүгнэлт гаргуулна, тэгээд хэрэгт цугларсан нотлох баримт үнэнийг тогтооход хангалтгүй гэж үзвэл оролцогчдод нэмэлт нотлох баримт гаргахыг санал болгох, шаардах зэргээр бололцоотой бүх арга хэмжээг шүүгч авна.

Тухайн хэргийн болон маргалдагч талуудын хувь заяа нотлох баримтын бүрдлээс ихээхэн хамааралтай. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд хангалттай нотлох баримт цугларсан эсэхийг тухайн хэрэг дээр ажиллаж байгаа шүүгч дотоод итгэл, мэдлэг туршлага дээрээ тулгуурлан дүгнээд шүүхээр хэлэлцэх боломжтой эсэхийг тогтоодог.

Хэргийн бүрдэл хангагдаагүй бол шүүхийн шийдвэр хүчингүй болох үндэслэл болно. Нотлох баримтын бүрдэл хангагдаагүйгээс шүүх хуралдаан хойшлох, шүүхийн шийдвэр үндэслэл муутай гарч бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчих, дээд шатны шүүх хэргийн талаар бодитой дүгнэлт хийх боломжгүй болох, шийдвэр хүчингүй болж өөрчлөгдөх зэрэг сөрөг үр дагавар бий болдог. Давж заалдах, хяналтын шатны

шүүхээр хянагдсан захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн 34.0 хувь нь нотлох баримтын бүрдэл хангаагүй байснаас хүчингүй болж, анхан шатны шүүхээр дахин шийдвэрлэгдсэн байна.

Нотлох баримтыг судлан шалгах. Нотолгооны ач холбогдол бүхий байдлуудыг тогтоох талаар шүүхээс гүйцэтгэж байгаа шинжилгээ, танин мэдэхүйн ажиллагаа буюу тухайн нотлох баримтаар хэргийн бодит үнэнийг тогтоох боломж, нөхцөл бүрдсэн эсэхэд хэргийн оролцогчид, шүүх, шүүгчийн зүгээс үнэлгээ өгч байгаа үйл ажиллагааг нотлох баримтыг судлан шалгах үе шат гэнэ.

Шүүгч гар дээрээ байгаа хэргийг хэргийн оролцогчдоод хүссэн цагт нь уншуулж танилцуулж байх үүрэгтэй. Ийнхүү танилцаж байгаа нь тэдний зүгээс хэрэгт цугларсан баримтад өөрийн дүн шинжилгээ хийж нотлох баримт судлан шалгаж байгаагийн нэг хэлбэр мөн.

Ер нь хэрэгт цугларсан нотолгооны хэрэгслүүд маань нэхэмжлэлийн зүйл, татгалзал, тайлбар, гомдлыг нотолж чадаж байна уу, нотлох баримт болохуйц шинжийг агуулж байна уу, дутуу байна уу, дахин шинэ нотолгоо гаргах, шаардах боломж байна уу гэдэгт сонирхогч этгээдүүд байнга санаа зовж байдаг. Энэ талаарх хүсэлт, саналаа ихэвчлэн шүүх хуралдааны явцад илэрхийлэх боломж олддог. Харин ийнхүү хэрэгт цугларсан баримтад өөрийн дүн шинжилгээ хийж байгаа явдал нь нотлох баримтыг үнэлж байгаа хэрэг биш, зөвхөн нотлох баримтыг судлан шалгах шүүхийн ажиллагаанд хамтран оролцож саналаа илэрхийлж байгаа хэлбэр юм.

Нотлох баримт болохуйц шинж гэдгийг арай тодруулж үзье. Тодорхой хэргийг нотолгооны аль нэг хэрэгслээр, эсхүл хэд хэдэн хэрэгслийн тусламжтайгаар шийдвэрлэж болох нөхцөл байдлыг нотлох баримт болохуйц шинж гэнэ. Нотлох баримт болохуйц шинж нь тухайн хэрэгт хамааралтай баримт мэдээллийг олж авсан үндэслэл, арга, журам нь хууль ёсны эсэхийг тодорхойлох чанар гэж үздэг. Нотлох баримт болохуйц нотолгооны хэрэгслэл мөн үү, нотолгооны хэрэгслэл нь хэрэгт хамааралтай, нотолгооны ач холбогдолтой эсэх, хуулиар зөвшөөрөгдсөн болон хуульд заасан арга журмаар олж авсан, хуульд зааснаар баталгаажсан эсэхийг шүүгч байнга хянаж байдаг. Түүнээс гадна шүүхэд цугларсан нотлох баримт хууль ёсны дагуу цуглуулсан эсэх, хэргийг шийдвэрлэхэд хангалттай эсэх, эргэлзээгүй, үнэн бодитой эсэхийг ч шалгах ёстой.

Иймд шүүх хуралдааны мэтгэлцээний шатанд хэрэгт авагдсан бүх нотолгооны хэрэгслийг нэг бүрчлэн судлан шалгаж үнэлэгдэх нотлох баримтад тооцох эсэх, нотлох чадвараа алдах, нотлох баримтаас хасагдах эсэх талаар оролцогчид өөр өөрийн дүгнэлт хийнэ. Үүнийг нотлох баримтыг үнэлэхтэй шууд адилтган ойлгож болохгүй. Яагаад гэвэл шүүхэд хэлэлцэгдээгүй, хэрэгт хамааралгүй, ач холбогдолгүй, хуульд заасан арга журмаар олж аваагүй нотлох баримтыг үнэлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэл болгож болохгүй байдагт оршино.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4-ийн “Нотлох баримт гаргах, цуглуулах талаар хуульд заасан журмыг зөрчиж олж авсан нотлох баримт нотлох чадвараа алдах бөгөөд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй”, 31.8-ийн “Захиргааны хэргийн шүүх хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасах бөгөөд тийм баримтыг шаардан гаргуулж болохгүй” гэсэн заалтууд нь нотлох баримт болж чадахгүй нотолгооны хэрэгслийг томьёолсны дээр нотлох баримтад хууль зүйн утгаар тавигдах шаардлагыг тодорхойлжээ.

Шүүх хуралдаанд бэлтгэх ажиллагааны явцад болон шүүх хуралдааны мэтгэлцээний үед иргэдийн төлөөлөгч, хэргийн оролцогчид нотлох баримтын нотолгооны ач холбогдлыг өөр өөрийн байр сууринаас дүгнэж үнэлүүлэх, нэмэлт нотолгоо шаардах зэргээр санал хүсэлтээ шүүх, шүүгчид хандаж гаргана.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйл буюу
Захиргааны хэргийн нотлох баримтыг үнэлэх

- 40.1. Шүүх хэргийн оролцогчийн гаргасан нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ.
- 40.2. Нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлнэ.
- 40.3. Шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй.
- 40.4. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон буюу нийтэд илэрхий үйл баримт хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй.
- 40.5. Анхан шатны шүүхэд гаргаагүй нотлох баримтыг давж заалдах болон хяналтын журмаар гаргасан тохиолдолд шүүх түүнийг үнэлэхгүй. Харин шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах гэж байгаа бол энэ заалт хамаарахгүй.

ТАЙЛБАР

Нотлох баримтыг үнэлэх нь шүүхийн нотолгооны хамгийн хариуцлагатай эцсийн үе шат бөгөөд нотлох баримтыг судлан шалгах үйл ажиллагаатай шууд холбоотойгоор хослон хэрэгждэг. Тухайн хэрэгт хамааралтай, нотолгооны ач холбогдолтой, хуульд заасан арга журмаар олж авсан нотлох баримтыг шүүгч өөрийн эрх зүйн ухамсраа удирдлага болгон дотоод итгэлээрээ үнэлнэ. Нотлох баримтыг үнэлэх ажиллагаа зөвхөн зөвлөлдөх тасалгаанд шүүх бүрэлдэхүүний хэмжээнд хэрэгждэг онцгой үйл ажиллагаа мөн.

"Шүүхэд цугларсан нотлох баримтын нотолгооны шинж, зориулалтыг нь шүүх, хууль зүйн талаас нь үнэлэлт, дүгнэлт хийх оюун санааны бүтээлч хандлагыг нотлох баримтыг үнэлэх гэнэ.⁸⁷

Хуульд заасан үндэслэл журмаар цугларсан нотлох баримтууд нь шүүхээр хянан хэлэлцэгдэж байгаа нэхэмжлэлийн шаардлага, хариуцагчийн татгалзлын үндэслэлийг ямар нэг байдлаар батлах, эсхүл няцааж үгүйсгэхэд шууд чиглэгдсэн шинжтэй байдаг.

Нотлох баримтыг үнэлэх ажиллагаа нь шүүгчийн дотоод итгэлээр хэрэгждэг болохоор шүүгчдийн мэдлэг, боловсрол, мэргэжлийн ур чадвар, дадлага, хууль хэрэглэх арга, итгэл үнэмшилтэй шууд хамааралтай. Иймээс ч хуульд шүүх хэргийн оролцогчийн гаргасан нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр, хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь, өөрийн дотоод итгэлээр үнэлнэ.⁸⁸ гэж заажээ.

Шүүх хуралдааны үед хэргийн оролцогчид нотлох баримтыг үнэлүүлэх тухай өөрсдийн санал, хүсэлтээ гаргах, шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтаас нэг тал татгалзсан ч нөгөө тал нь түүнийг иш татах эрх хуулиар олгогдсон байдаг. Энэ эрхийг зарим судлаачид, хуульчид тайлбарлахдаа нотлох баримтыг үнэлэх ажиллагаанд тэднийг оролцож байгаа хэлбэр гэж үздэгтэй санал нийлэхгүй байна. Харин нотлох баримтыг шүүх шинжлэн судлах ажиллагаанд оролцож байгаа хэлбэр мөн.

Шүүгчид нотлох баримтуудыг үнэлэхдээ хэрэгт авагдсан нотлох баримтад тавигдах шаардлагыг хангасан нотолгооны хэрэгслүүдийг хооронд нь харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг танин мэдэхүйн янз бүрийн аргуудыг хэрэглэж шүүхийн шийдвэрийн үндэслэл болгох нь зүйтэй. Ингэж чадваас шүүхийн шийдвэр маань үнэн бодитой, шударга, ойлгомжтой болно.

Дотоод итгэл нь хуульд заасан арга журмаар цуглуулж, бэхжүүлсэн бүх нотлох баримт нь тухайн хэрэгтэй хамааралтай, ач холбогдолтой, хангалттай, үнэн зөв, эргэлзээгүй байдлыг бүхэлд нь хянан үзсэнээр тодорхойлогдоно.

Нөгөө талаас нь шүүх, шүүгчийн үзэл бодол, итгэл үнэмшил гэж тодорхойлж болно. Шүүгчийн дотоод итгэл нотлох баримт нэг бүрийг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд бодитойгоор шинжлэн тогтоосны үндсэн дээр бүрэлдэн тогтдог. Хийсвэр ямар нэгэн үндэслэл муутай баримтууд дээр тулгуурлаж дотоод итгэл нь зөв, бодитой бүрэлдэн тогтохгүй. Ийнхүү дотоод итгэлээр нотлох баримтыг үнэлэхдээ шүүгч өөрт төлөвшсөн эрх зүйн ухамсрыг удирдлага болгодог.

Шүүх, шүүгчийн нотлох баримтыг үнэлэх арга барил, ур чадвар өөр өөр байх хэдий ч дийлэнх шүүгчид тодорхой дараалалтайгаар нотлох баримтыг үнэлж итгэл

⁸⁷ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй /Ерөнхий анги/, 108 дахь тал, УБ хот, 2004 он

⁸⁸ Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 40 дүгээр зүйл, УБ хот, 2002 он

үнэмшил нь бий болдог байна. Өөрөөр хэлбэл нотлох баримтыг үнэлдэг шүүхийн нэлээд төлөвшсөн арга юм. Энэ нь нэгдүгээрт; нотлох баримтын бүрдэл хангагдсан эсэхийг, хоёрдугаарт; үнэлэгдэх нотлох баримт нь хэрэгт авагдсан байхын дээр заавал шүүх хуралдаанаар хэлэлцсэн байхыг, гуравдугаарт; тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, зайлшгүй шаардлагатай болохыг, дөрөвдүгээрт; нотлох баримт үнэн зөв, эргэлзээгүй, хөдөлбөргүй байна уу гэдгийг шалгаж үнэлнэ.

Хэргийн оролцогчоос гаргасан нотлох баримтын үнэн зөв болохыг зөвхөн шүүх үнэлнэ. Шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон нотлох баримт байж болохгүй.

Монгол улсын Дээд шүүх тайлбарласнаар “шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн зөв гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй” гэдэгт хэргийн оролцогч өөрийн гаргасан болон хэргийн бусад оролцогчийн гаргасан нотлох баримтыг шүүгч урьдчилан үнэлэхгүй бөгөөд гагцхүү шүүх тал бүрээс нь хэргийн байдалтай бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр шүүгч дотоод итгэлээрээ үнэлнэ гэж ойлгоно. Энэ нь шүүхийн шийдвэрийг шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтын үндсэн дээр гаргадагтай холбоотой бөгөөд шийдвэр хууль ёсны, үндэслэл бүхий байх гол шалгуур нь юм.

Захиргааны хэргийн нотлох баримтыг үнэлэхэд нэгэнт тогтоогдсон буюу нийтэд илэрхий үйл баримтыг дахин нотлохгүй байх зарчим үйлчилдэг. Хууль тогтоомжид зааснаар нэгэнт тогтоогдсон үйл баримт гэдэгт дараах баримт хамаарна.

- Эрүү, иргэн, захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон аливаа үйл баримт нь захиргааны өөр хэргийг шийдвэрлэхэд “нэгэнт тогтоогдсон” гэж тооцогдоно. Энэ үйл баримт нь тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон этгээдийн хувьд өөр хэрэгт хэргийн оролцогчоор орж байгаа тохиолдолд л “нэгэнт нотлогдсон” гэсэн ойлголтод хамаарна. Харин хүчин төгөлдөр шийдвэртэй тухайн хэргийн оролцогч биш этгээдийн хувьд хүчин төгөлдөр шийдвэрээр нотлогдсон үйл баримтын талаар өөр хэрэгт маргах эрх нь нээлттэй байх бөгөөд шүүх тухайн хэрэгт цугларсан нотлох баримтыг хянан хэлэлцэж хуульд заасан журмын дагуу үнэлсний үндсэн дээр ердийн журмаар шийдвэрлэнэ.
- Үндсэн хуулийн Цэцийн болон Арбитрын хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт нотлогдсон үйл баримтыг тухайн ажиллагаанд оролцсон талууд нь захиргааны хэрэгт оролцогч бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дахин нотлохгүй.

Захиргааны хэргийн хяналтын шатны шүүхэд шинээр гаргасан нотлох баримтыг хяналтын шатны шүүх үнэлэхгүй.

Нотлох баримтыг үнэлэх явцад гэм буруу тогтоогдохгүй, эргэлзээтэй байх явдал гардаг. Ийм нөхцөлд эрүүгийн эрх зүйд, хэргийг хангалттай шалгасан боловч гэм буруу нь нотлогдохгүй эсхүл эргэлзээтэй бол гэм буруугүйд тооцно⁸⁹, шүүгдэгчид

⁸⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэг

ашигтайгаар шийдвэрлэнэ⁹⁰, иргэний эрх зүйд нотлогдохгүй бол нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгоно гэсэн зарчим үйлчилдэг. Энэ нь зарчим ч захиргааны хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаанд адил утгаар үйлчилнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Нэхэмжлэл гаргах, түүнийг хүлээн авах

32 дугаар зүйл. Нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн хэлбэр, бүрдүүлбэр, агуулга

- 32.1. Нэхэмжлэлийг хариуцагчийн оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүхэд бичгээр гаргах бөгөөд нэхэмжлэгч, эсхүл түүнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлж буй этгээд гарын үсэг зурсан байна. Энэ хуулийн 4.1.1-4.1.3-т заасан тохиолдолд нэхэмжлэлийг Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимд гаргана.
- 32.2. Нэхэмжлэлд дараахь зүйлийг тусгана:
 - 32.2.1. нэхэмжлэлийг захиргааны хэргийн ямар шүүхэд гаргаж байгаа;
 - 32.2.2. нэхэмжлэгч, хариуцагчийн овог, эцгийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, оршин байгаа газрын хаяг;
 - 32.2.3. нэхэмжлэлийн шаардлагын агуулга;
 - 32.2.4. хавсаргасан баримт бичгийн жагсаалт.
- 32.3. Нэхэмжлэлийг төлөөлөгч гаргасан бол итгэмжлэл буюу гэрээг хавсаргана.
- 32.4. Нэхэмжлэлд нэхэмжлэгч, эсхүл төлөөлөгч гарын үсэг зурж, нэхэмжлэл болон түүнд хавсаргасан баримт бичгийг хариуцагчийн тоогоор хувилж өгнө.
- 32.5. Энэ хуулийн 32.2.3-т заасан нэхэмжлэлийн шаардлагын агуулга гэдэгт дараахь зүйлийн аль нэг багтана:
 - 32.5.1. захиргааны байгууллагаас гаргасан захиргааны акт нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөнийг нотолж чадах бол тухайн актыг хүчингүй болгуулах;
 - 32.5.2. захиргааны байгууллагаас гаргасан захиргааны акт илт хууль бус гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх;
 - 32.5.3. маргаан бүхий захиргааны акт нэхэмжлэгчийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн болон түүнээс үүдэн гарах хохирлын тухай;

⁹⁰ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг

32.5.4. захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус эс үйлдэхүй нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хэрхэн зөрчсөн, түүний үр дагаврыг арилгах тухай зааж, зөрчигдсэн эрхээ хэрхэн сэргээлгэхийг хүсч байгаа.

ТАЙЛБАР

Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, өөрийн зөрчигдсэн эрхээ сэргээлгэх, хамгаалуулах эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14-т баталгаажуулж өгсөн. Ийм ч учраас нэхэмжлэл нь иргэн, хуулийн этгээдийн хувьд тэдний субъектив эрхийг хангах хэрэгсэл юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэл гэж иргэн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус актын улмаас зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны хэргийн шүүхэд хандаж гаргасан өргөдлийг гэж ойлгоно. Захиргааны хэргийн шүүхэд хандаж гаргасан нэхэмжлэл нь дараах онцлогыг агуулсан байдаг. Үүнд:

- Нэхэмжлэлийн агуулга нь захиргааны хууль бус акттай холбоотой байна.
- Нэхэмжлэлийн шаардлага нь зөвхөн захиргааны байгууллага албан тушаалтны эсрэг чиглэгддэг
- Нэхэмжлэл нь маргаан бүхий захиргааны актын үйлчлэлийг сааруулан зогсоох, улмаар захиргааны актыг хүчингүй болгох зэрэг эрх зүйн үр дагавар бүхий хамгаалалтын цогц шинжийг агуулдаг
- Нэхэмжлэл нь бүрдүүлбэр хангаагүй үндэслэлээр буцаадаггүй, түүнийг хангах боломжийг нэхэмжлэгчид олгодог⁹¹

Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хуулиар аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтоосон бөгөөд хариуцагчийн оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүх нь тухайн маргаан бүхий захиргааны акт гаргасан захиргааны байгууллага албан тушаалтны байнга оршин үйл ажиллагаагаа явуулж байгаа газрын байршил нутаг дэвсгэрийн харьяалалаар тодорхойлогдоно.

Захиргааны хэргийн шүүхэд хандаж гаргасан нэхэмжлэлийг зөвхөн бичгээр гаргах бөгөөд түүнд нэхэмжлэгч эсхүл түүнийг хэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлж буй этгээд гарын үсэг зурсан байна. Харин нэхэмжлэгчийг төлөөлж захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан этгээд энэ хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.1-т тусгайлан заасан нэхэмжлэлийн өргөдөлд гарын үсэг зурах эрхийг нэхэмжлэгчээс заавал авсан байна.

Нэхэмжлэлийг тухайн шүүхийн шуудангийн хаягаар ирүүлж болно.

⁹¹ А.Эрдэнэцогт “Монгол улсын захиргааны процессын эрх зүй” 2006 он 219 дэх тал

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д иргэн, хуулийн этгээдээс захиргааны актыг хууль бус гэж үзэж, зөрчигдсөн эрхээ..." гэж зааснаас үзэхэд иргэн хуулийн этгээдийн зөвхөн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд л шүүхэд хандах эрхтэй байдаг.

Захиргааны хэрэг, маргааны онцлогоос хамааран захиргааны хэргийн шүүхийн харьяалал энэхүү зүйлд тусгайлан зохицуулагдсан бөгөөд Энэ хуулийн 4.1.1-4.1.3-т заасан тохиолдолд нэхэмжлэлийг Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимд гаргана⁹².

Нэхэмжлэлийн бүрдүүлбэр гэж энэ зүйлд нэрлэн заасан нэхэмжлэлд тавигдах шаардлагуудыг дараах зүйлсийг ойлгоно. Үүнд:

1. нэхэмжлэлийг захиргааны хэргийн ямар шүүхэд буюу Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд эсхүл энэ зүйлд зааснаар Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимд гаргаж байгаагаа тодорхой бичнэ.

2. нэхэмжлэгч, хариуцагчийн овог, эцгийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол нэр, оршин байгаа газрын хаягийг тодорхой заана.

3. Хавсаргасан баримт бичгийн жагсаалтыг нэг бүрчлэн бичнэ.

4. Нэхэмжлэлийг төлөөлөгч гаргасан бол итгэмжлэл буюу гэрээг

5. Нэхэмжлэлд нэхэмжлэгч, эсхүл төлөөлөгч гарын үсэг зурж, нэхэмжлэл болон түүнд хавсаргасан баримт бичгийг хариуцагчийн тоогоор хувилж өгнө.

Нэхэмжлэлийг хэрэгт авагдах үндсэн хувиас гадна хариуцагчийн тоогоор хувилан шүүхэд ирүүлэх бөгөөд нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилах нь нэхэмжлэгчийн үүрэг юм.

Захиргааны хэргийн анхан шатны шүүх нэхэмжлэлийн бүрдүүлбэр, хэлбэрийн талаар иргэд, хуулийн этгээдэд мэдээлэл өгөх зорилгоор нэхэмжлэлийн загварууд, түүнд тавигдах шаардлага зэрэг холбогдох мэдээлүүдийг "Шүүхийн мэдээллийн самбар"-т байрлуулж, дээрх мэдээллийг агуулсан гарын авлагыг шүүхийн мэдээлэл, лавлагааны албанд хангалттай тоогоор байлгана. Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл, тэдгээрийг нотлох баримтыг нэхэмжлэлд тодорхой дурдсан байхад нотлох баримтыг заавал хавсаргахыг шүүхээс шаардахгүй бөгөөд нэхэмжлэлд тусгагдсан нотлох баримтыг хавсаргаагүй нь нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болохгүй. Нотлох баримтыг хавсаргаж ирүүлсэн тохиолдолд хавсаргасан баримт бичгийн жагсаалтыг заавал гаргуулна.

Нэхэмжлэлийн шаардлагын агуулга гэдгийг нь энэхүү хуулийн 32.5-д зааснаар ойлгоно.

Иргэн, хуулийн этгээдээс захиргааны актыг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргаснаар нэхэмжлэгч болон хариуцагч /захиргааны байгууллага, албан тушаалтан/ -ийн хооронд үүссэн эрх зүйн үр дагаварыг өөрчилөхөд чиглэгддэг бол захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх тухай нэхэмжлэл нь захиргааны акт утга агуулгын илэрхий алдаатай, уг актыг гаргасан захиргааны байгууллага албан

⁹² Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсгийг 2005 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон

тушаалтан тодорхойгүй зэрэг энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрүүлэх замаар захиргааны акт анхнаасаа илт хууль бус байсан гэдгийг тогтооход оршдог.

Захиргааны хууль бус актын улмаас үүдэн гарах хохирлыг нөхөн төлүүлэх, арилгуулах талаар нэхэмжлэл гаргаж болох бөгөөд хохиролын хэмжээний талаар хэргийн оролцогчид маргавал иргэний шүүхээр шийдвэрлүүлнэ.

Үүдэн гарах хохирол гэдэг нь хууль бус захиргааны акт гарснаар нэхэмжлэгчид учирсан бодит хохирол бөгөөд захиргааны хууль бус актын улмаас ирээдүйд учирч болох, урьдчилан таамагласан бодит бус хохирол биш юм.

Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус эс үйлдэхүй нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хэрхэн зөрчсөн, түүний үр дагаврыг арилгах тухай зааж, зөрчигдсэн эрхээ хэрхэн сэргээлгэх өөрөөр хэлбэл эрх сэргээх тухай нэхэмжлэлийн ерөнхий шаардлага байж болно.

33 дугаар зүйл. Нэхэмжлэл хүлээн авах

- 33.1. Нэхэмжлэлийг тухайн захиргааны хэргийн шүүхийн нарийн бичгийн дарга хүлээн авч, ийнхүү хүлээн авсан нэхэмжлэл, хавсаргасан материалын хуудасны тоо, огноо, цаг, минутыг нэхэмжлэлд тэмдэглэн, нэхэмжлэл бүртгэх дэвтэрт бүртгэж баримтжуулна.
- 33.2. Нэхэмжлэл нь энэ хуулийн 32.2-т заасан бүрдүүлбэр хангаагүй бол хүлээн авсан шүүгч 7-14 хоногийн хугацаа тогтоон нэхэмжлэгчид уг шаардлагыг хангах боломж олгоно.
- 33.3. Нэхэмжлэгч шүүгчийн тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй бол уг нэхэмжлэлийг буцаана.

ТАЙЛБАР

Нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүхийн нарийн бичгийн дарга ажлын өдрүүдэд ямар нэгэн хязгаарлалт тогтоолгүйгээр хүлээн авах ба энэ тухай зохих бүртгэлийг хөтлөж баримтжуулна. Шүүх нэхэмжлэл хүлээн авсан тухайгаа баримтжуулж байгаа нь хөөн хэлэлцэх хугацааг тоолох, түүнийг тасалдсан эсэхийг тодорхойлох болон маргааныг хуульд заасан хугацаанд шийдвэрлэх түүнд хяналт тавих зэрэгт ач холбогдолтой байдаг. Нэхэмжлэлийг шүүгчдийн зөвлөлгөөнөөс тогтоосон хувиарын дагуу тухайн шүүгчид өдөрт нь шилжүүлнэ.

Хэрэв иргэн, хуулийн этгээд нэхэмжлэлийн бүрдүүлбэрийн хангахгүйгээр Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл ирүүлсэн тохиолдолд уг нэхэмжлэлийг хүлээн авсан шүүгч 7-14 хоногийн хугацаа тогтоон нэхэмжлэгчид хуульд заасан шаардлагыг хангах боломж олгоно. Шүүгчээс тогтоосон энэ хугацаанд нэхэмжлэгч нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаж ирүүлээгүй бол нэхэмжлэлийг нэхэмжлэгчид буцаах тухай

шүүгчийн захирамж гаргаж, буцаана. Энэ нь нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах зохицуулалтаас ялгаатай.

34 дүгээр зүйл. Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах

34.1. Шүүгч дараахь тохиолдолд нэхэмжлэл хүлээн авахаас татгалзана:

- 34.1.1. захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус;
- 34.1.2. тухайн захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус ;
- 34.1.3. захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг биелүүлээгүй ба энэ журмыг хэрэглэх боломжтой;
- 34.1.4. нэхэмжлэгч нь эрх зүйн бүрэн чадамжгүй бөгөөд түүнийг төлөөлсөн этгээд байхгүй;
- 34.1.5. нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан;
- 34.1.6. нэхэмжлэлд дурдсан үйл баримт, хариуцагчийн гэм буруугийн талаар, эсхүл уг нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, түүнчлэн хэргийг хэрэгсэхгүй болгосон хуулийн хүчин төгөлдөр захиргааны хэргийн шүүхийн шийдвэр буюу шүүгчийн захирамж байгаа;
- 34.1.7. нэхэмжлэгч болох иргэн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан боловч эрх, үүрэг нь эрх залгамжлагчид шилжээгүй;
- 34.1.8. захиргааны акт нь Үндсэн хууль зөрчсөн нь тогтоогдсон бөгөөд Үндсэн хуулийн цэцийн харьяаллын маргаан бол;
- 34.1.9. захиргааны акт нь эрүүгийн эрх зүйн маргаан бол;
- 34.1.10. захиргааны акт нь иргэний эрх зүйн маргаан бол.

34.2. Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахдаа захиргааны хэргийн шүүх тогтоол, шүүгч захирамж гарган татгалзсан шалтгааныг зааж, нэхэмжлэлийг энэ хуулийн 34.1.3.-34.1.6.-д заасан тохиолдолд нэхэмжлэгчид буцаах бөгөөд бусад тохиолдолд холбогдох байгууллагад нь шилжүүлнэ.

ТАЙЛБАР

Захиргааны байгууллага албан тушаалтнаас гаргасан захиргааны акттай холбоотой нэхэмжлэл бүрийг Захиргааны хэргийн шүүх хүлээн авах үүрэггүй. Энэ зүйлд заасан нөхцөл байгаа тохиолдолд тухайн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.

Маргаан бүхий акт нь захиргааны хэргийн харьяалалын бус өөрөөр хэлбэл уг акт нь Үндсэн хууль зөрчсөн нь тогтоогдсон бөгөөд Үндсэн хуулийн цэцийн харьяаллын маргаан, эрүүгийн эрх зүйн маргаан, иргэний эрх зүйн маргаан бол Захиргааны хэргийн шүүхийн харьяалалын бус гэж үзнэ.

Харин захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан мөн боловч нутаг дэвсгэрийн харьяалалаар байгуулагдсан тухайн захиргааны хэргийн шүүхийн харьяалалын бус түүнчлэн энэ хуульд Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимд нэхэмжлэл гаргахаар тусгайлан заасан субъектэд хамаарах захиргааны актын

талаарх нэхэмжлэлийг тухайн захиргааны хэргийн шүүхийн харьяалалын бус гэж ойлгоно.

Захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг биелүүлээгүй гэдэгт маргаан бүхий захиргааны акт гаргасан байгууллага албан тушаалтны шууд харьяалах дээд шатны байгууллага албан тушаалтанд гомдол гаргаж шийдвэрлүүлэх ажиллагаа заавал хийгдсэн байхыг шаардах бөгөөд энэ журмыг хэрэглэх боломжтой гэдэгт дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байхыг хэлнэ.

Хэрэв нэхэмжлэлийг шууд шүүхэд гаргахаар хуульд тусгайлан заасан бол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахгүй.

Нэхэмжлэгч нь эрх зүйн бүрэн чадамжгүй гэснийг Иргэний хуульд зааснаар 7 хүртэлх насны, сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцсон этгээдийн ойлгох бөгөөд түүнийг төлөөлсөн этгээд байхгүй гэдэг нь итгэмжлэлийг нэхэмжлэлд хавсаргаагүй, итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зураагүй байхыг ойлгоно. Нэхэмжлэл гаргасан этгээд эрх зүйн бүрэн чадамжгүй болох нь захиргааны хэрэг үүсгэхээс өмнө мэдэгдвэл түүний гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.

Эрх зүйн бүрэн чадамжгүй этгээдийг төлөөлөх бүрэн эрхтэй этгээд тухайн асуудлаар нэхэмжлэл гаргахад дээрх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан явдал саад болохгүй.

Нэхэмжлэгч нь эрх зүйн чадамжтай боловч түүнийг өөр этгээд төлөөлж нэхэмжлэл гаргасан тохиолдолд төлөөлүүлэгчийн бүрэн эрхээ баталсан баримтыг нэхэмжлэлийн хамт ирүүлээгүй бол нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан гэж үзнэ.

Хуулийн этгээдийг төлөөлж, нэхэмжлэл гаргасан этгээд нь өөрийн бүрэн эрхийг нотолсон баримтыг шүүхэд ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн баримт нь хуульд заасан шаардлагыг хангаагүй бол бол түүнийг хуулийн этгээдийн төлөөлөгч гэж үзэх боломжгүй юм.

Нэхэмжлэлд дурдсан үйл баримт, хариуцагчийн гэм буруугийн талаар, эсхүл уг нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, түүнчлэн хэргийг хэрэгсэхгүй болгосон хуулийн хүчин төгөлдөр захиргааны хэргийн шүүхийн шийдвэр буюу шүүгчийн захирамж байгаа тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах бөгөөд нэхэмжлэлд дурдсан үйл баримт, хариуцагчийн гэм буруугийн талаар хуулийн хүчин төгөлдөр иргэний хэргийн шийдвэр, шийтгэх тогтоол байхыг мөн хамааруулж ойлгоно. Энэ тохиолдолд шүүх нэхэмжлэлийн шаардлага, зүйл, үндэслэл, хэргийн оролцогч, тухайн шийдвэрээр уг хэргийн үйл баримтыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тодорхой бичнэ.

35 дугаар зүйл. Нэхэмжлэлийг өөр шүүхэд шилжүүлэх

- 35.1. Энэ хуулийн 34.1.1., 34.1.2., 34.1.8., 34.1.10.-т заасан үндэслэл байвал нэхэмжлэлийг харьяалагдах шүүхэд буюу Үндсэн хуулийн цэцэд, мөн хуулийн 34.1.9.-д заасан үндэслэл байвал прокурорт тус тус шилжүүлнэ.
- 35.2. Нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж хүчин төгөлдөр болсны дараа шилжүүлнэ.
- 35.3. Тухайн хэргийн шүүхийн харьяалмын талаар гарсан шүүх хоорондын маргааныг Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын тэргүүн шийдвэрлэнэ.

ТАЙЛБАР

Нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүх хүлээн авч хэрэг үүсгэх эсэх тухай үндэслэлийг хянах явцад уг нэхэмжлэлийг өөр шүүх харьяалан шийдвэрлэхээр бол шилжүүлэх тухай асуудал хөндөгдөнө. Нэхэмжлэлийг шүүхийн тогтоол шүүгчийн захирамжаар маргаан бүхийн акт иргэний эрх зүйн маргаан бол харьяалагдах шүүхэд нь, Үндсэн хуулийн цэцийн харьяалалын маргаан бол Үндсэн хуулийн цэцэд, захиргааны акт эрүүгийн эрх зүйн маргаан бол прокурорт тус тус шилжүүлнэ.

Харин шүүх нэхэмжлэлийг харьяалмын дагуу нэгэнт хүлээн авч хэрэг үүсгэсний дараа өөр шүүхэд шилжүүлэх үндэслэл тогтоогдвол уг хэргийг тал бүрээс нь бүрэн, зөв, шуурхай шийдвэрлэх үүднээс шүүхийн тогтоол буюу шүүгчийн захирамжаар шилжүүлнэ. Ийнхүү шилжүүлсэн хэргийн талаар гарсан шүүх хоорондын маргааныг Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын тэргүүн шийдвэрлэнэ.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан үндэслэл байвал шүүгч 7-оос доошгүй хоногийн дотор нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, нэхэмжлэгчид буцаах буюу холбогдох байгууллагад шилжүүлэх тухай захирамж гаргана. Шүүгчийн туслах захирамжийг гарсан өдөрт нь нэхэмжлэгчид мэдэгдэж, баримт үйлдэнэ. Шүүгчийн туслах захирамжийг нэхэмжлэл, түүнд хавсаргасан материалын хамт 3 хоногийн дотор нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө. Нарийн бичгийн дарга холбогдох бүртгэлд тэмдэглэн, нэхэмжлэгч болон холбогдох байгууллагад хүргүүлэхээр бичиг хүргэгч, эсхүл шуудан хүргэгчид бүртгэлд гарын үсэг зуруулж, хүлээлгэн өгнө.

36 дугаар зүйл. Захиргааны хэрэг үүсгэх

- 36.1. Шүүгч энэ хуулийн 34.1.-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор захиргааны хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

Энэ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзсэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар шүүгч захирамж гаргана гэж заасны дагуу нэхэмжлэлийг хүлээн авсан шүүгч 7 хоногийн дотор захиргааны хэрэг үүсгэх тухай шүүгчийн захирамж гаргана. Хэрэг үүсгэсэн шүүгчийн захирамж гармагц Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс баталсан журмын дагуу индексжүүлэн, энэ тухай мэдээллийг Шүүхийн бүртгэлийн программд бүрэн, зөв оруулна.

37 дугаар зүйл. Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа

37.1. Нэхэмжлэл хүлээн авч, хэрэг үүсгэсэн шүүгч дараахь ажиллагаа явуулна:

- 37.1.1. хариуцагчийг дуудан ирүүлж, нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримт бичгийн хувийг гардуулж, энэ тухайгаа баталгаажуулах;
- 37.1.2. хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, гэрчийг дуудаж мэдүүлэг авах, шинжээч, орчуулагч, хэлмэрч томилох болон шаардлагатай бусад ажиллагаа явуулах;
- 37.1.3. хэргийн оролцогчид эрх, үүргийг нь амаар тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд бичиж, гарын үсэг зуруулах;
- 37.1.4. шаардлагатай бол холбогдох шүүхэд шүүхийн даалгавар явуулах;
- 37.1.5. талуудыг эвлэрүүлэх арга хэмжээ авах;
- 37.1.6. нэхэмжлэлийн үнэ, захиргааны хэргийн шүүхийн зардлын тухай шийдвэрлэх.

ТАЙЛБАР

Нэхэмжлэлийг хүлээн авч захиргааны хэрэг үүсгэсэн шүүгч дараах ажиллагаа хийж гүйцэтгэнэ.

Хариуцагчийг мэдэгдэх хуудсаар /утсаар, факс г.м/ шүүхэд дуудан ирүүлж нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримт бичгийн хувийг хуульд заасан хугацаанд гардуулан өгөх бөгөөд энэ тухай баримт үйлдэн, хэрэгт хавсаргана. Хуульд зааснаар нийслэлд 7, орон нутагт 14 хоногийн дотор хариуцагчид нэхэмжлэлийн хувь, түүнд хавсаргасан баримт бичгийг гардуулах үүргийг шүүх хүлээнэ. Нэхэмжлэлийн хувийг шүүгч өөрийн байранд, дуудагдан ирсэн хариуцагчид гардуулж эрх үүргийн тайлбарлан өгнө.

Шүүхийн мэдэгдэх хуудсаар хэргийн оролцогчийг дуудан ирүүлэх ажиллагаа, мэдэгдэх хуудас хүргүүлэх, гардуулах, баримтжуулах ажиллагааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэх учир нэхэмжлэлийн хувь, хавсаргасан баримтийг гардуулах ажиллагааг адилтган үзэж, хариуцагчид батлагаат шуудан, шүүхийн ажилтанаар хүргүүлэн, энэ тухайгаа шүүгч баримтжуулсан тохиолдолд гардуулсан, хүргүүлсэнд тооцож болохоор байна. Энэ тохиолдолд гардуулсан, хүргүүлсэн баримт бичгүүд хариуцагчид хүрсэн, түүнийг хэн, хэзээ, хэрхэн хүлээж авсан тухай баримт тухайн хэрэгт авагдсан байх ёстой.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үнэлэх үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэдэг.

Энэ нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3-т заасан нэхэмжлэгчийн ... бусад нотлох баримт цуглуулах, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах зэрэг хүсэлт гаргах эрх, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т заасан хариуцагчийн гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах хүсэлт гаргах эрх, 20.1.2-т заасан хариуцагчийн захиргааны хэргийн шүүхээс шаардсан нотлох баримтыг гаргаж өгөх үүрэгтэй гэснээр баталгаажиж байна. Түүнчлэн хэрэг үүсгэсэн шүүгч хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37, 40-45, 47-49, 51 дүгээр бүлэг хамаарахыг анхаарах ёстой.

Хэрэгт ач холбогдолтой нотлох баримт гэдэг нь хэргийн оролцогчдын маргаж буй зүйлд хамааралтай, бодит үнэнд нийцсэн байхаас гадна нотлох баримт цуглуулах, бүрдүүлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу явуулсан байхыг ойлгоно.

Гэрчийг дуудаж мэдүүлэг авах, шинжээч, орчуулагч, хэлмэрч томилох болон ажиллагаагааг явуулахдаа хэргийн оролцогчийн хүсэлтээр эсхүл шүүх өөрөө санаачилан хийх бөгөөд гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид эрх, үүргийг тайлбарлаж энэ тухайгаа баримтжуулан хэрэгт хавсаргасан байна.

Захиргааны хэрэг үүсгэсэнээс хойш хэргийн оролцогч нар өөрийн шаардлага, татгалзалаа нотлох баримтыг шүүхэл ирүүлэх эрхтэйгээс гадна шаардлагатай тохиолдолд шүүх нотлох баримтыг өөрөө бүрдүүлэх үүрэгтэй.

Шаардлагатай гэдэг нь хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардалгатай нотлох баримтад хамааралтай байхыг ойлгоно.

Хүсэлт гаргасан гэдэг нь хэргийн оролцогчоос энэ ажиллагааг шүүхээр гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг бичгээр гаргасан байхыг ойлгоно.

Нэхэмжлэлийн шаардлага, хэргийн нөхцөл байдлаас хамааран шүүгч хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлтийг хангах эсэхийг захирамжаар шийдвэрлэнэ.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хуульд заагдсан тодорхой зохицуулалт, журам, хугацаанд явагддаг тул хэргийн оролцогчидод эрх, үүргийг тайлбарлан ойлгуулах нь чухал байдаг.

Эрх, үүрэг тайлбарласан баримт хэрэгт хавсаргаагүй, баримтад талууд гарын үсэг зураагүй нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, хэргийн оролцогчийн эрхийг эдлүүлээгүй гэж үзнэ.

Шүүх шийдвэрлэж байгаа хэргийн талаар өөр аймаг, орон нутгаас нотлох баримт бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 30, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 41 дүгэрэ зүйлд заасны дагуу даалгавар гүйцэтгүүлэх тухай захирамж гаргана.

Шүүхийн даалгавараар тухайн орон нутагт байгаа эд мөрийн баримтад үзлэг хийх, гэрчийн мэдүүлэг авахуулах гэх мэт байж болно. Гэхдээ шүүхийн даалгавраар хийгдэх ажиллагаа нь бүрдүүлбэл зохих нотлох баримт нь хэргийг үндэслэл бүхий шийдвэрлэхэд ач холбогдолтой, уг нотлох баримтыг бүрдүүлж шүүхээс үнэлэлт өгөх зайлшгүй шаардлагатай байх учиртай.

Даалгавар биелүүлэх хугацаа нь даалгавар хүлээн авсан шүүх шүүгчийн захирамжид дурьдсан хугацаанд гүйцэтгэх боломжит хугацаа байна. Мөн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн хуулийн хугацааг харгалзан тогтоох ёстой.

Даалгаварыг хүлээн авсан шүүх захирамжид заагдсан ажиллагаагааг хугацаанд нь заавал гүйцэтгэхийн зэрэгцээ уг ажиллагаагааг бүрэн гүйцэт, бүрдүүлсэн нотлох баримт нь хуулийн шаардлага хангасан байх даалгаварыг гүйцэтгэн хүргүүлэхдээ даалгавар гүйцэтгэхтэй холбоотой баримт, материал, тэмдэглэл, шүүхийн зардал гарсан бол зардлын баримтыг хавсаргана.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хариуцагч нь эрх бүхий байгууллага албан тушаалтан байдаг бөгөөд тодорхой тохиолдолд өөрийн гаргасан шийдвэрээ өөрчлөх боломж тэдэнд хуулиар олгогдсон байдаг. Иймд хэрэг үүсгэсэн шүүгч талуудын эвлэрүүлэх арга хэмжээ авах ажиллагааг явуулах эрхтэй байдгаараа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанаас ялгаатай байна.

Харин нэхэмжлэгч болон хариуцагчийн эвлэрэл нь бусдын эрх хууль ёсны эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хөндөхөөргүй байх ёстой.

Захиргааны хэргийн шүүхийн зардал нь шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдон гарах зайлшгүй зардлыг хэлнэ.

38 дугаар зүйл. Нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах

- 38.1. Хэрэг үүсгэсэн өдрөөс хойш нийслэлд 7, орон нутагт 14 хоногийн дотор шүүгч нэхэмжлэлийг хариуцагчид гардуулна.
- 38.2. Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор, эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөх эсэх тухайгаа шүүхэд бичгээр мэдэгдэх үүрэгтэй.
- 38.3. Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй бол тайлбартаа үндэслэлийг зааж, нотлох баримтаа хамтад нь гаргаж ирүүлнэ.
- 38.4. Энэ хуулийн 38.2., 38.3.-т заасан хугацаа болон шаардлагын дагуу тайлбараа гаргаж өгөөгүй гэм буруутай албан тушаалтанд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ТАЙЛБАР

Захиргааны хэрэг үүсгэмэгц шүүгч, шүүгчийн туслах нь хаана, хэзээ хүрэлцэн ирж нэхэмжлэлийн хувийг гардан авахыг мэдэгдэх хуудсаар хариуцагчид мэдэгдэж, энэ тухай баримтыг хэрэгт хавсаргана. Мэдэгдэх хуудсыг шүүгч, шүүгчийн туслах бичсэн өдөртөө шүүхийн бичиг хүргэгчид хүлээлгэн өгч, бүртгэлд тэмдэглүүлнэ. Бичиг хүргэгч мэдэгдэх хуудсыг хүлээн авснаас хойш хэргийн оролцогчдод 3 хоногийн дотор Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 77.2-77.9-д заасан журмын дагуу хүргэж, мэдэгдэх хуудсыг хүлээн авсан баримтад тухайн этгээдээр гарын үсэг зуруулж, баримтжуулан шүүгч, шүүгчийн туслахад бүртгэлд тэмдэглэн, буцааж өгнө. Шүүгч, шүүгчийн туслах хариуцагчид нэхэмжлэлийн хувийг гардуулан, гарын үсгийг гаргацтай зуруулж, баримт үйлдэн, хэрэгт хавсаргана. Шүүгчийн туслах нэхэмжлэлд хавсаргасан

баримтуудаас хариуцагчийн шаардлагатай гэж үзсэн нотлох баримтуудыг тэдний зардлаар хуулбарлан өгч болно.

Нэхэмжлэлийн хувийг хүлээн авсан хариуцагч нэхэмжлэлийн шаардлагын талаархи тайлбарыг шүүхэд гаргах үүрэгтэй. Хариуцагчийн тайлбар нь бодит үнэнд нийцсэн, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь буюу хэсэгчлэн зөвшөөрсөн эсхүл татгалзсан хэлбэртэй байж болно.

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагын талаарх тайлбараа 14 хоногийн, эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй байна.

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь буюу хэсэгчлэн зөвшөөрөхгүй тохиолдолд тайлбарт энэ тухай үндэслэлийг зааж , холбогдох нотлох нотлох баримтын бүрдүүлээр ханган хавсарган ирүүлнэ.

Шаардлагатай бол зохих ажиллагааг хийлгэхээр шүүхэд хүсэлт гаргаж болно.

Энэ хүсэлт нь нэхэмжлэлийн шаардлага, татгалзалтай холбоотой байх ёстой.

Хариуцагч нэхэмжлэлийн хүлээн авсанаас хойш 14 хоногийн, эсхүл шүүхээс тогтоосон хугацааны дотор тайлбар ирүүлээгүй бол гэм буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэнэ.

Энэ тохиолдолд хуульд заасан хугацаанд тайлбар, нотлох баримт ирүүлээгүй нь хүндэтгэн үзэх шалтгаан байсан эсэхийг тогтоох шаардлагатай.

39 дүгээр зүйл. Сөрөг нэхэмжлэл

- 39.1. Хариуцагч нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх явцад үндсэн нэхэмжлэлтэй хамруулан хянан шийдвэрлүүлэхийн тулд шүүх хуралдаанаар хэлэлцэхийн өмнө сөрөг нэхэмжлэл гаргах эрхтэй.
- 39.2. Сөрөг нэхэмжлэл гаргахдаа нэхэмжлэл гаргах нийтлэг журмыг баримтална.
- 39.3. Маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгуулах болон захиргааны акт гаргуулах тухай нэхэмжлэлтэй холбогдуулан сөрөг нэхэмжлэл гаргахыг хориглоно.

ТАЙЛБАР

Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан зорилтоос үзэхэд иргэн, хуулийн этгээдээс захиргааны актыг хууль бус гэж үзэж, зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар гаргасан нэхэмжлэлийг шүүх хянан шийдвэрлэхтэй хобогдсон харилцааг зохицуулахад оршиж байна. Өөрөөр хэлбэл захиргааны байгууллага албан тушаалтан хариуцагч байхаар зохицуулагдсан атал хэрэг хянан шийдвэрлэх явцад хариуцагч, нэхэмжлэгчийн үндсэн нэхэмжлэлтэй хамруулан сөрөг нэхэмжлэл гаргах эрхтэй байхаар хуульчилсан нь агуулгын хувьд зөрчилтэй байна.

Сөрөг нэхэмжлэлд тавигдах шаардлага нь нэхэмжлэлд тавигдах шаардлагатай нэгэн адил байна.

40 дүгээр зүйл. Иргэн, албан тушаалтныг захиргааны хэргийн шүүхэд дуудан ирүүлэх

- 40.1. Шүүгч хэргийн оролцогч, гэрчийг шүүхийн мэдэгдэх хуудсаар захиргааны хэргийн шүүх болон шүүх хуралдаанд дуудан ирүүлнэ.
- 40.2. Шүүхийн мэдэгдэх хуудсыг бичих, түүнийг хүргэх, гардуулах болон хариуцлага хүлээлгэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77.2-77.9-д заасныг баримтална.

ТАЙЛБАР

Шүүхийн мэдэгдэх хуудсыг хүлээн авсан хэргийн оролцогч шүүхэд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.9-д заасны дагуу хэргийн оролцогчийг албадан ирүүлэх захирамж гаргана. Хэргийн оролцогчийг албадан ирүүлэх тухай захирамжийг шүүгчийн туслах гарсан өдөрт нь шүүхийн хуягт хүлээлгэн өгч, албадан ирүүлэх ажиллагааг шүүхийн хуяг гүйцэтгэнэ. /3 хоногийн дотор/

41 дүгээр зүйл. Нэхэмжлэлээс татгалзах

- 41.1. Нэхэмжлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд нэхэмжлэлээсээ татгалзах эрхтэй.
- 41.2. Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсанаа бичгээр илэрхийлэх бөгөөд шүүх хуралдааны явцад нэхэмжлэлээсээ татгалзвал хуралдааны ажиллагааг дуусгаж, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаж, гарын үсэг зуруулна.
- 41.3. Нэхэмжлэлээсээ татгалзсан этгээд уг асуудлаар дахин нэхэмжлэл гаргах эрхээ алдах бөгөөд энэ нь бусад этгээд уг асуудлаар бие даасан нэхэмжлэл гаргахад саад болохгүй.

- 41.4. Шүүгч нэхэмжлэгчийн нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж хэргийг хэрэгсэхгүй болгох тухай захирамж гаргаж, захиргааны хэргийн шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийн асуудлыг шийдвэрлэнэ.

ТАЙЛБАР

Нэхэмжлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд нэхэмжлэлээсээ татгалзах эрхтэй. Хэрвээ шүүх хуралдааны үеэс бусад үед нэхэмжлэлээсээ татгалзвал энэ тухай шүүхэд бичгээр мэдэгдэнэ. Харин шүүх хуралдааны үед нэхэмжлэгч нэхэмжлэлээс татгалзсан тохиолдолд энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаж, нэхэмжлэгчийн гарын үсгийг тэмдэглэлд зуруулна. Нэхэмжлэлээсээ татгалзсан этгээд уг асуудлаар дахин нэхэмжлэл гаргах эрхээ алдах боловч энэ нь бусад этгээд уг асуудлаар бие даасан нэхэмжлэл гаргахад саад болохгүй. Энэ тохиолдолд шүүгч “нэхэмжлэгчийн нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж хэргийг хэрэгсэхгүй болгох” тухай захирамж гаргана.

42 дугаар зүйл. Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх

- 42.1. Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хэмжээгээр хүлээн зөвшөөрч, энэ нь бусад этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхөөргүй, хуульд харшлаагүй байвал шүүгч хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай захирамж гаргана.
- 42.2. Шүүгч захирамж гаргахдаа захиргааны хэргийн шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийн асуудлыг шийдвэрлэнэ.
- 42.3. Энэ хуулийн 42.1-д заасан захирамжийг захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн нэгэн адил журмаар биелүүлнэ.

ТАЙЛБАР

Хариуцагч, нэхэмжлэлийн шаардлагыг хууль зүйн үндэслэлтэй гэж үзэн бүрэн хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн бол түүнийг энэ зүйлд зааснаар “нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн”-нд тооцно.

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрч буйгаа ихэнхдээ шүүхэд бичгээр мэдэгдэх бөгөөд энэ нь нэг талын хүсэл зоригийн илэрхийлэл байдаг тул нэхэмжлэгч үүнийг хүлээн зөвшөөрөх эсэх нь ач холбогдолгүй. Нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч хүлээн зөвшөөрөх нь хэргийн нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрөхөөс ялгаатай гэж үздэг байна.

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн бол энэ нь бусад этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхөөргүй, хуульд харшлаагүй гэдэг талаар шүүгч захирамждаа нотлох баримтыг үндэслэн дүгнэлт хийсэн байх ёстой. Энэ тохиолдолд шүүгч хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай захирамж гаргана.

43 дугаар зүйл. Нэхэмжлэгч, хариуцагч эвлэрэх

- 43.1. Нэхэмжлэгч, хариуцагч харилцан буулт хийж, нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх, шаардлагыг биелүүлэх арга замаа тодорхойлох зэргээр хоорондоо тохиролцож эвлэрлийн гэрээ байгуулж, маргаанаа дуусгавар болгож болно.
- 43.2. Нэхэмжлэгч, хариуцагч нар нь эвлэрсэн тохиролцоогоо бичгээр илэрхийлж, гарын үсгээ зурсан байна. Шүүх хуралдааны явцад эвлэрвэл хуралдааны тэмдэглэлд тусгаж, гарын үсэг зуруулна.
- 43.3. Нэхэмжлэгч, хариуцагч хоёрын эвлэрсэн нь хуульд харшлаагүй, эсхүл бусад этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй нь тогтоогдвол шүүгч эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай захирамж гаргаж, захиргааны хэргийн шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хурсамжийн тухай асуудлыг шийдвэрлэнэ.
- 43.4. Энэ хуулийн 43.1.-д заасны дагуу эвлэрсэн бол уг маргааныг захиргааны шүүх дахин авч хэлэлцэхгүй.

ТАЙЛБАР

Нэхэмжлэгч, хариуцагч харилцан буулт хийж, нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх, шаардлагыг биелүүлэх арга замаа тодорхойлох зэргээр хоорондоо тохиролцож эвлэрлийн гэрээ байгуулж, маргаанаа дуусгавар болгож болох бөгөөд хэрвээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээд оролцож байгаа бол энэ тохиолдолд гурвалсан эвлэрлийн гэрээ хийгдэнэ. Талууд хүсэл зоригоо бүрэн тусгай бичих бөгөөд энэ талаар дэлгэрэнгүй заана. Эвлэрлийн гэрээ шүүх хуралдааны бусад үед заавал бичгээр хийх бөгөөд шүүх хуралдааны үер хэргийн оролцогчид эвлэрвэл энэ талаар шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаж, гарын үсэг зуруулна. Талууд ийнхүү эвлэрсэн нь хуульд харшлаагүй, эсхүл бусад этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй нь тогтоогдсон байх шаардлагатай бөгөөд шүүгч эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай захирамж, шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргана. Нэхэмжлэгч хариуцагч эвлэрснээр уг маргаантай эрх зүйн харилцаа нэг мөр дуусгавар болно.

44 дүгээр зүйл. Нэхэмжлэлийн шаардлагыг нэгтгэх, тусгаарлах

- 44.1. Аль нэг захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд тухайн маргаантай хэрэг байгаа, эсхүл нэг нэхэмжлэгчээс өөр өөр хариуцагчид гаргасан нэхэмжлэлтэй хэд хэдэн хэргийг захиргааны хэргийн шүүх нэг ажиллагаагаар нэгтгэн хэлэлцэж болно.

44.2. Нэгтгэн гаргасан, эсхүл хэд хэдэн нэхэмжлэгч гаргасан буюу хэд хэдэн хариуцагчид холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн шаардлагатай нэг буюу хэд хэдэн хэргийг шүүгчийн захирамжаар тусгаарлаж болно.

Захиргааны хэргийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг нэгтгэх болон тусгаарлах асуудал нь хэргийн оролцогчийн хүсэл сонирголоос үл шалтгаалж шүүх шийдвэрлэнэ.

Шүүх ингэж шийдвэрлэх болсон шалтгаан, үндэслэлийг захирамжид тодорхой заана.

Нэхэмжлэлийг хэд хэдэн этгээд гаргасан эсхүл хэд хэдэн хариуцагчид холбогдох нэхэмжлэлийн шаардлагаас зарим хэсгийг нь тусгаарлаж болно. Ингэж тусгаарлаж буй шаардлага, үндэслэлээ шүүх захирамждаа мөн зайлшгүй тусгана.

Хэд хэдэн нэхэмжлэгчийн өөр өөр хариуцагчид гаргасан нэхэмжлэлийг нэгтгэх, тусгаарлах асуудал хэргийн бодит нөхцөл байдлыг тогтоох, нотлох баримтыг үнэлэх, хэргийг түргэн шуурхай хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой.

45 дугаар зүйл. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх

45.1. Энэ хуулийн 46 дугаар зүйлд болон өөр хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүгч захирамж гаргаж, маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ.

45.2. Хэм хэмжээ тогтоосон захиргааны актыг зөвхөн хуульд зааснаар түдгэлзүүлж болно.

ТАЙЛБАР

Энэ хуулийг зохицуулалт нь Захиргааны хэргийн шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулж, урьдчилсан байдлаар нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг шүүхийн түр хамгаалалтанд авч байна гэсэн үг юм. Гэхдээ энэ нь шүүхэд гаргаж буй нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагаас ихээхэн хамаардаг учир зөвхөн маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгуулах тухай шаардлага бүхий нэхэмжлэлд л шүүх өөрийн санаачилгаар, талуудыг хүсэлтээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болно. Энэ нэхэмжлэлийн шаардлагаас өөр, жишээ нь Захиргааны актыг илт хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар нэхэмжлэлийн шаардлагтай байхад энэ арга хэмжээг хэрэглэхгүй. Учир нь энэ нь угаасаа гарах ёсгүй акт байхтай холбоотой юм.

Хэм хэмжээ тогтоосон захиргааны акт буюу хуулийн дэд актын биелэлтийг түдгэлзүүлэх асуудал зөвхөн хуульд тусгайлан зааснаар зохицуулагдана.

46 дугаар зүйл. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нөхцөл

46.1. Захиргааны актын биелэлтийг дараахь тохиолдолд түдгэлзүүлж болохгүй;

- 46.2. захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь бусдын амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, хуулийн этгээдэд илт хохирол учруулахаар бол
- 46.3. иргэн, хуулийн этгээдээс албан татвар, төлбөр, хураамж гаргуулах тухай акт бол;
- 46.3. захиргааны журам зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэсэн болон уг зөрчлийг таслан зогсоох тухай захиргааны хяналтын байгууллага, албан тушаалтны шийдвэр бол;
- 46.4. хууль тогтоомжид заасан тохиолдолд үл маргалдах журмаар биелүүлэх бол.

ТАЙЛБАР

Хуульд зааснаас бусад тохиолдолд л захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болно. Харин энэ зүйл захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй үндэслэлүүдийг тусгайлан заасан байна. Үүнд,

- биелэлтийг түдгэлзүүлсэн нь хэргийн оролцогчдоос гадна өөр нэг гуравдагч этгээдийн буюу иргэн, хуулийн этгээд, төрд илт хохирол учруулахаар бол,
- Маргаан бүхий захиргааны акт нь иргэн, хуулийн этгээдээс албан татвар, төлбөр, хураамж гаргах тухай бол,
- захиргааны журам зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэсэн болон уг зөрчлийг таслан зогсоох тухай захиргааны хяналтын байгууллага, албан тушаалтны шийдвэр бол,
- хуульд зааснаар үл маргах журмаар буюу заавал биелүүлэхээр зохицуулагдсан бол, эдгээр тохиолдлуудад захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй.

47 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа

- 47.1. Хуулиар тусгайлан хугацаа тогтоогоогүй бол захиргааны хэргийн шүүх нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш аймгийн төвд 40, нийслэлд 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.
- 47.2. Хэргийг давж заалдах болон хяналтын шатны захиргааны хэргийн шүүхээс дахин хэлэлцүүлэхээр буцаасан бол уг хэргийг тухайн захиргааны хэргийн шүүх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.
- 47.3. Шаардлагатай тохиолдолд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хугацааг тухайн захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор, 15 хоногоор 2 дахь удаагаа сунгаж болно.
- 47.4. Хугацааг тоолох, тодорхойлоход Иргэний хуульд заасан журмыг баримтална.

47.5. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусад хугацааг энэ хуулийн 47.1.-д заасан хугацааны дотор шүүх тогтоож болно.

ТАЙЛБАР

Хуулиар тусгайлан хугацаа тогтоогоогүй бол захиргааны хэргийн шүүх нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш орон нутагт 40 хоногийн дотор, нийслэлд 30 хоногийн дотор хэргийг хянан шийдвэрлэх, Хэргийг давж заалдах болон хяналтын шатны захиргааны хэргийн шүүхээс дахин хэлэлцүүлэхээр буцаасан бол уг хэргийг тухайн захиргааны хэргийн шүүх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

Шаардлагатай тохиолдолд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хугацааг тухайн захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор, 15 хоногоор 2 дахь удаагаа сунгаж болно. Энэ тохиолдолд шүүгчдийн зөвлөлгөөний тогтоол гарна.

48 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх

48.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 80 дугаар зүйлийг баримтална.

ТАЙЛБАР

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбарын холбогдох хэсгийг үзнэ үү.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Шүүх хуралдааныг товлон зарлах, түүнд бэлтгэх

49 дүгээр зүйл. Шүүх хуралдааныг товлон зарлах

49.1. Захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэхэд хангалттай нотлох баримт цугларсан гэж үзсэн, эсхүл энэ хуулийн 47.1.-д заасан хугацаа дууссан, түүнчлэн шаардлагатай бусад тохиолдолд шүүгч захирамж гаргаж, шүүх хуралдааныг хэзээ, хаана болохыг товлон зарлана.

49.2. Хэргийн болон шүүх хуралдааны оролцогчдод шүүх хуралдаан хэзээ, хаана болох товыг шүүхийн мэдэгдэх хуудсаар мэдэгдэнэ.

ТАЙЛБАР

1.Шүүгч захирамж гаргаж, шүүх хуралдааныг хэзээ, хаана болохыг товлон зарлана гэдгийг энэ хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д "... шийдвэр гаргахаас бусад

тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар захиргааны хэргийн шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.” гэж заасны дагуу шүүх хуралдааныг товлон зарласан тухай шүүгчийн захирамж юм.

Харин “...хангалттай нотлох баримт цугларсан...” гэдэг нь тухайн хэргийг бүх талаас нь бодитойгоор үнэн зөв шийдвэрлэхэд хэрэгт ач холбогдол бүхий зайлшгүй шаардлагатай баримт мэдээлэлийг хуульд заасан журмын дагуу олж авсан байхыг хэлнэ.

2. “...хуулийн 47.1-д заасан хугацаа дууссан,...” энэ хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д “хуулиар тусгайлан хугацаа тогтоогоогүй бол захиргааны хэргийн шүүх нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш аймгийн төвд 40, нийслэлд 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ” гэж зааснаар аймгийн төвд 40, нийслэлд 30 хоногийн хугацаа дуусан тохиолдолд шүүх хуралдааныг товлон зарлана.

Энэ нь зөвхөн дээрхи хугацаанд шүүх хуралдааныг товлон зарлана гэсэн явцуу утга биш бөгөөд энэ хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-т “шаардлагатай тохиолдолд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хугацааг тухайн захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор, 15 хоногоор 2 дахь удаагаа сунгаж болно.” гэж зааснаар орон нутагт 85, нийслэлд 75 хоногийн дотор шүүх хуралдааныг товлон зарлах эрх нээлттэй байна гэж үзэхээр байна.

3. “...шаардлагатай бусад тохиолдолд...” гэдэг нь хуульд тусгайлан заасан тохиолдолд жишээ нь Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гомдлыг шүүгч ажлын 6 өдрийн дотор багтаан хянан шийдвэрлэнэ.” гэж зааснаар шүүх ажлын 6 өдөрт багтаан шүүх хуралдааныг товлон зарлана. Үүнээс гадна цаг хугацаанаас хамааралтай эрх зүйн үр дагаварыг хэрэг хянаж байгаа шүүгч тооцож хуралдааныг хуульд заасан хугацаа болзолыг харгалзахгүйгээр мөн хугацаанаас өмнө шүүх хуралдааныг зарлаж болно. Жишээ нь Байглын голомтот гоц халдвартай өвчний улмаас гадаадаас оруулж ирж байгаа эм тарианы сонгон шалгаруулалттай холбоотой маргаан гэх мэт.

Хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-т зааснаар “хэргийн болон шүүх хуралдааны оролцогчдод шүүх хуралдаан хэзээ, хаана болох товыг шүүхийн мэдэгдэх хуудсаар мэдэгдэнэ.”

“Шүүхийн мэдэгдэх хуудас” гэдэг нь шүүх хуралдаан хэзээ, хаана болох хурлын товыг хэргийн оролцогчдод мэдэгдэж шүүхээс ирүүлж буй албан ёсны баримт юм. /стандарт/

“Мэдэгдэнэ” гэдэг нь “шүүхийн мэдэгдэх хуудас”-ыг шүүхийн ажилтан биечлэн хүргэж өгөх эсхүл баталгаат шуудангаар, утас, факс, цахилгаанаар дамжуулахыг түүнчлэн шүүхийн мэдэгдэх хуудас өгөхийг өөр этгээдэд даалгахыг тус тус хэлнэ.

50 дугаар зүйл. Шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг томилох
50.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, түүнчлэн хэргийг шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэх бол шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан

даргалагчийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлд заасны дагуу томилно.

ТАЙЛБАР

Шүүхийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1. дэх хэсэгт зааснаар тухайн шүүхэд нийт шүүгчдийн зөвлөлгөөн ажиглана. Шүүгчдийн зөвлөлгөөн нь жилд хоёроос доошгүй удаа байхаас гадна тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, эсхүл шүүгчийн олонхын саналаар ээлжит бус зөвлөлгөөнийг зарлан хийлгэж болно.

Хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг томилох хуваарийг шүүгчдийн зөвлөлгөөнөөр тогтооно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбарын холбогдох хэсгийг үзнэ үү.

51 дүгээр зүйл. Иргэдийн төлөөлөгчийг томилох

- 51.1. Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийг Шүүхийн тухай хуульд заасны дагуу оролцуулна.
- 51.2. Тухайн шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасны дагуу томилно.
- 51.3. Энэ хуулийн 51.2.-т заасны дагуу томилогдсон иргэдийн төлөөлөгч нь татгалзан гарах үндэслэл байхгүй бол шүүх хуралдаанд заавал оролцоно.

ТАЙЛБАР

Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ хуульд заасан журмын дагуу иргэдийн төлөөлөгчийг оролцуулна. Иргэдийн төлөөлөгчийг сонгогчдын нэрсийн жагсаалтыг үндэслэн шүүгчдийн зөвлөлгөөнөөс тогтоосон журмын дагуу сонгон авах ажлыг тухайн шүүхийн тамгын хэлтэс зохион байгуулж, шүүх хуралдаанд оролцуулна.

Сонгогчдын нэрсийн жагсаалт гэдэг нь сонгуулийн насанд хүрсэн Монгол Улсын иргэн, тухайн тойргийн сонгогч гэж ойлгоно.

Иргэдийн төлөөлөгч нь энэ хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т заасан шүүх хуралдааны бусад оролцогч бөгөөд хэргийг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэхэд оролцоно.

Хэргийг дангаар хянан шийдвэрлэхэд болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд иргэдийн төлөөлөгч оролцохгүй.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогч, хуралдааны нийтлэг журам

52 дугаар зүйл. Шүүх бүрэлдэхүүн

- 52.1. Захиргааны хэргийн шүүх дараахь хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ:
 - 52.1.1. энэ хуулийн 4.1.1-4.1.3-т заасан байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны акттай холбоотой;
 - 52.1.2. аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан захиргааны акттай холбоотой;
 - 52.1.3. урьд нь шүүгч анхан шатны журмаар дангаараа шийдвэрлэж гаргасан шийдвэр нь давж заалдах, эсхүл хяналтын шатны шүүхээс хүчингүй болсон.
- 52.2. Энэ хуулийн 52.1-д зааснаас бусад хэргийг захиргааны хэргийн шүүхийн шүүгч дангаар шийдвэрлэнэ.
- 52.3. Давж заалдах шатны журмаар хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.
- 52.4. Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхим 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.
- 52.5. Хяналтын шатны шүүх хуралдаанаас тогтоол гаргана. Тогтоолд шүүх хуралдаан даргалагч, илтгэсэн шүүгч гарын үсэг зурна. Тогтоолд анхан шатны болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын агуулга, түүний үндэслэл, гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тусгана.
- 52.6. Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолыг гомдол гаргагч этгээд хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хууль зөрчсөн үндэслэлээр Улсын дээд шүүхэд гомдол гаргаж болно. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл дүгнэлт гаргаж уг хэргийг Улсын дээд шүүхийн хуралдаанаар хэлэлцүүлнэ.
- 52.7. Ерөнхий шүүгчийн дүгнэлтэд гомдлын үндэслэл, хэрэг шийдвэрлэсэн байдал, хууль зөрчсөн гэсэн үндэслэлийг тусгасан байна.
- 52.8. Улсын дээд шүүхийн хуралдаан Улсын дээд шүүхийн нийт шүүгчдээс бүрдэнэ. Энэхүү хуралдаанаас тогтоол гаргах бөгөөд энэ нь эцсийн шийдвэр болно.

ТАЙЛБАР

Монгол Улсын Үндсэн хуулийн 52 дугаар зүйлийн 1, 3-т “Бүх шатны шүүх хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ,... хуульд тусгайлан зүйлчлэн заасан зарим хэргийг шүүгч дангаар хянан шийдвэрлэж болно”, Шүүхийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.-т “Шүүх хамтын зарчмаар хэрэг, маргааныг хянан хэлэлцэж шийдвэр гаргана” гэж тус тус заасан байна.

Хамтын зарчмаар хэрэг маргааныг хянан шийдвэрлэх нь хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчим юм. 52 дугаар зүйлийн 52.1-д зааснаас бусад хэргийг захиргааны хэргийн шүүхийн шүүгч дангаар шийдвэрлэнэ.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим нь аймаг, нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогчдын гомдлоор давж заалдах журмаар хянан шийдвэрлэхдээ 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэнэ. Харин Дээд шүүх захиргааны хэргийн шийдвэр, магадлалыг хэргийн оролцогчид, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн гомдлоор хяналтын журмаар хянан хэлэлцэхдээ 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэнэ.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэсэн тогтоолыг тухайн хэргийн оролцогч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хууль зөрчсөн үндэслэлээр Улсын Дээд шүүхэд гомдол гаргаж болох бөгөөд Ерөнхий шүүгч уг гомдлыг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд дүгнэлт гаргана. Ийнхүү гаргасан дүгнэлтийг Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн (17 шүүгчийн дийлэнх олонхын ирцтэйгээр) хуралдаанаар хянан хэлэлцэж, шүүхийн эцсийн шийдвэрийг мөн хамтын зарчмын дагуу гаргадаг.

53 дугаар зүйл. Шүүгч буюу шүүх бүрэлдэхүүнийг солих

53.1. Шүүгч буюу шүүх бүрэлдэхүүнийг солиход Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 83 дугаар зүйлийг баримтална.

ТАЙЛБАР

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбарын холбогдох хэсгийг үзнэ үү.

54 дүгээр зүйл. Шүүх хуралдаанд оролцогч

54.1. Шүүх хуралдаанд оролцогчийг энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хэргийн болон бусад оролцогч гэж ангилна.

- 54.2. Шүүх хуралдаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгч, прокурор, нэхэмжлэгчийн болон хариуцагчийн төлөөлөгч, өмгөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг бусад оролцогч гэнэ.

ТАЙЛБАР

Энэ хуулийн 16 дугаар зүйлийн тайлбарыг үзнэ үү.

55 дугаар зүйл. Шүүх хуралдаанд прокурор оролцох

- 55.1. Прокурор шүүх хуралдаанд төрийг төлөөлөн оролцох бөгөөд захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны хууль зүйн үндэслэлийн талаар дүгнэлт гаргана.
- 55.2. Прокурор захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

ТАЙЛБАР

Прокурор нь шүүх хуралдааны бусад оролцогч бөгөөд шүүх хуралдаанд төрийг төлөөлж оролцож захиргааны байгууллага албан тушаалтанаас гаргасан захиргааны акт, тэдгээрийн үйл ажиллагаанд хууль зүйн дүгнэлт гаргана. Тэрээр шүүх хуралдаанд ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлд заасан эрхийг эдэлж оролцоно.

56 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгч, түүний эрх, үүрэг

- 56.1. Захиргааны хэргийг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд 3 хүртэл иргэдийн төлөөлөгч оролцуулна.
- 56.2. Иргэдийн төлөөлөгч нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:
- 56.2.1. шүүхийн байранд хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх;
 - 56.2.2. нотлох баримт шинжлэхэд оролцох;
 - 56.2.3. нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд, гэрч, шинжээчид асуулт тавих;
 - 56.2.4. нэмэлт нотлох баримт цуглуулах талаар хүсэлт гаргах;
 - 56.2.5. хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн гэм буруутай эсэхийн талаар дүгнэлт гаргах;

56.2.6. өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлыг задруулахгүй байх;

56.2.7. энэ хуульд заасан шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэх.

56.3. Энэ хуулийн 56.2.5-т зааснаар хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн гэм буруутай эсэхийн талаар гаргасан иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүх хуралдаанд уншиж сонсгоно.

ТАЙЛБАР

1. Монгол Улсын Үндсэн хуулийн тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийг хуульд заасан журмын дагуу оролцуулна”, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 -д “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ хуульд заасан журмын дагуу иргэдийн төлөөлөгч оролцуулна” гэж тус тус заасан бөгөөд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчмуудын нэг юм.

Энэ хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т зааснаар иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдааны бусад оролцогч байна.

Шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчид хэрэг хянан шийдвэрлэхэд дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:

- Иргэдийн төлөөлөгч тухайн хэрэг, маргааны үйл баримт, гэм буруугийн талаар шүүхэд хөндлөнгөөс дүгнэлт өгөхийн тулд юуны өмнө хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх эрхээр хангагдсан байна. Шүүх хуралдааны оролцогч болгон энэ эрхээр хангагдаад байдаггүй, зөвхөн хэргийн оролцогч, шинжээч, иргэдийн төлөөлөгчид олгогдсон эрх юм. Иргэдийн төлөөлөгч нь энэ эрхээ хэрэгжүүлэхдээ талуудаас шүүхэд ирүүлсэн бичгийн нотлох баримтыг шүүхээс хувилж, хуулбарлан авч болно.
- Иргэдийн төлөөлөгчийн онцгой нэг эрх бол шүүх хуралдааны явцад нотлох баримтыг шинжлэн судлахад оролцох явдал юм. Тэрээр энэ эрхээ хэрэгжүүлэхдээ шинжлэх ухааны үндэслэл, нарийн математик тооцоо болон эрх зүйн талаас бус энгийн байдлаар хэргийн нөхцөл байдал тухайн нотлох баримтаар нотлогдож байгаа эсэх хэрэв нотлогдож байгаа бол зохигчийн хэн нь гэм буруутай байгааг тодорхойлж өгнө.
- Тухайн хэрэг, маргааны бодит байдлыг тогтоохын тулд иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдааны оролцогчдоос асуулт асуух замаар өөрт шаардлагатай байгаа зүйлийг тодруулна. Шүүх хуралдааны оролцогчдоос асуулт асуух эрх нь зөвхөн хэргийн оролцогч болон иргэдийн төлөөлөгчид олгогдсон эрх юм.
- Иргэдийн төлөөлөгч нь дээр дурдсан гурван үндэслэлийн дагуу тухайн хэргийн үйл баримт, гэм буруугийн талаар шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орохын өмнө дүгнэлтээ гаргана. Түүний гаргасан дүгнэлт нь бичгийн хэлбэрээр гарсан байх бөгөөд үүнийгээ шүүх хуралдаанд уншиж сонсгоно. Иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж байгаа хэрэг, маргааны талаар эрх зүйн дүгнэлт хийхгүй боловч зохигчийн тайлбар үнэнд нийцэж буй

эсэх, нотлох баримт ямар үйл баримтыг яаж нотолж байгаа, гэрчүүдийн мэдүүлэг хэрхэн итгэл, үнэмшил төрүүлж байгаа, мөн гэм буруугаас хамаарах шаардах эрхийг хэлэлцэх үед зохигчийн буруу байгаа эсэх зэрэг шүүх шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой нөхцөл байдлуудыг тогтооход тусална.

- Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцох нь түүний иргэний үүргээ биелүүлж байгаа нэг хэлбэр юм. Хэдийгээр түүнийг шүүх хуралдаанд албадан оролцуулж болохгүй боловч иргэний үүргээ ухамсартайгаар биелүүлэх нь шүүн таслах ажлыг хуульд заасан шаардлагын дагуу явуулахад чухал ач холбогдолтой байдаг.
- Иргэдийн төлөөлөгч нь хэргийн материалтай танилцах болон шүүх хуралдааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлын нууцыг бусдад задруулахгүй байх үүрэгтэй. Ялангуяа шүүх хуралдаан бүхэлдээ болон зарим хэсэг нь хаалттай явагдсан тохиолдолд шүүх хуралдааны бусад оролцогчийн нэгэн адил түүнээс нууц задруулахгүй байх баталгааг бичгэн хэлбэрээр авсан байх шаардлагатай. Хэрэв тэрээр өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулбал Эрүүгийн хуулийн 85, 136, 164 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.
- Иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдааны танхимд тогтоосон журмыг сахих, шүүх хуралдаан даргалагчийн шийдвэрт захирагдах үүрэгтэй.
- Иргэдийн төлөөлөгч хэргийн үйл баримт, хэргийн оролцогчдын гэм буруугийн талаар гаргасан дүгнэлтийг шүүх хуралдаанд уншиж сонсгоно.

57 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга

- 57.1. Захиргааны хэргийн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь шүүх хуралдаан явуулах бэлтгэлийг хангаж, шүүх хуралдааны ирцийг бүртгэж, шүүгч, шүүх бүрэлдэхүүнд танилцуулах, хуралдааны ажиллагааг тэмдэглэл үйлдэн баталгаажуулах, шүүхийн шийдвэрийг хүргүүлэх, гүйцэтгэх хуудах олгох, хүргүүлэх, хэргийг цэгцэлж, үдэх, архивт шилжүүлэх ажиллагааг гүйцэтгэнэ.

ТАЙЛБАР

1. Шүүхийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1., 74.2.-т “Бүх шатны шүүхэд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга ажиллана... Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь хууль зүйн дээд боловсролтой, ял шийтгэлгүй, Монгол Улсын иргэн байна” гэж тодорхойлсон байна.

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь шүүх хуралдааны бусад оролцогч юм.

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь шүүх хуралдаанд оролцож, хуралдааны тэмдэглэл хөтлөх, хэргийг шүүх хуралдаанд бэлтгэх, хэрэг хянан шийдвэрлэсний дараа архивт шилжүүлэх түүнчлэн шүүхээс гаргасан эрх зүйн баримт бичгүүдийг хуульд заасан журмын дагуу хэргийн оролцогчдоод гардуулах ажиллагааг гүйцэтгэнэ.

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь албан үүргийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа тул уг ажиллагаанд хувийн сонирхолгүй оролцогч байхыг шаардана.

58 дугаар зүйл. Гэрч

- 58.1. Захиргааны хэргийн шүүхээс маргааныг шударгаар шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байдлыг мэдэж байгаа этгээдийг гэрч гэнэ.
- 58.2. Гэрч захиргааны хэргийн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирж, хэргийн талаархи мэдээлэл, нөхцөл байдлыг мэдүүлэх үүрэгтэй.
- 58.3. Гэрч үнэн зөв мэдүүлэг өгч, шүүгч, хэргийн оролцогч болон хянан шийдвэрлэх ажиглагчааны бусад оролцогчийн асуултад хариулна. Гэрчүүдийг нүүрэлдүүлэн мэдүүлэг авахдаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 43.6.-д заасан журмыг баримтална.
- 58.4. Санаатайгаар худал мэдүүлэг өгсөн, эсхүл мэдүүлэг өгөхөөс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан, зайлсхийсэн гэрчид Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 58.5. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүхийн дуудсанаар ирж чадахгүй гэрчээс байгаа газарт нь очиж мэдүүлэг авч болно.
- 58.6. Гэрч шүүхийн дуудсанаар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг албадан ирүүлэхийг шүүхээс цагдаагийн байгууллагад даалгаж, холбогдох зардлыг гэрчээр гаргуулахаар тогтоож болно.

ТАЙЛБАР

Гэрч гэж тухайн хэргийн талаар тогтоовол зохих нөхцөл байдлыг мэдэж байсан этгээдийг хэлнэ⁹³.

Гэрч “хэргийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байдлыг мэдэж байгаа” гэдэг нь нэгэнт шүүхээс маргаан үүсгэн хянан шийдвэрлэж буй хэргийн хувьд чухал ач холбогдол бүхий үйл явдалд өөрийн биеэр оролцсон эсвэл энэ тухай мэдэж байсан гэх байдлаар ойлгоно. Иймээс гэрч шүүхээс хэргийг шударга ёс, эрх зүйн ухамсарт тулгуурлан шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой хэргийн оролцогч байдаг. Гэрчийн онцлог болон оролцооны тухайд 59 дүгээр зүйлийн тайлбарт авч үзсэн байгаа.

Хэдийгээр энэ хуулиар чухам ямар этгээд гэрчээр оролцож болох, болохгүйг хязгаарласан байдлаар зохицуулаагүй боловч процессын эрх зүйн нийтлэг зарчим ёсоор гэрчээр оролцож буй этгээд нь өөрийн үйлдлийн учир холбогдлыг бүрэн ухамсарлах чадвартай, насны болон сэтгэхүйн хувьд эрх зүйн бүрэн чадамжтай этгээд байхыг шаардана. Шүүхийн процесст гэрчээс мэдүүлэг авахдаа шүүх хуралдааны явцад болон хуралдаанаас өмнөх шатанд авч болно. Дээрх шатуудын алинд нь ч байсан гэрч шүүхэд хүрэлцэн ирэх асуудал түүний гол үүрэг байдаг. Ийнхүү гэрч шүүхэд дуудагдсан тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хойшлуулшгүйгээс бусад

⁹³ С. Нарангэрэл, Эрх зүйн толь бичиг 2007 он, 151 дэх тал

тохиолдолд шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх үүрэгтэй.⁹⁴ Гэрчийн шүүхээс дуудан ирүүлэх тохиолдолд шүүхийн мэдэгдэх хуудасны тусламжтайгаар чухам ямар хэргийн улмаас, аль шүүхэд, хэзээ очихыг тусгасан байна.

Нэгэнт гэрчээр дуудагдсан этгээд шүүхээс тогтоосон хугацаанд хүрэлцэн очих боломжгүй болсон тохиолдолд энэ тухайгаа шүүхэд мэдэгдэх үүрэгтэй байдаг. Ийнхүү мэдэгдэх байдал гэрчийг шүүх засаглалыг илтэд үл хүндэтгэсэн, хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг тасалдуулсан гэх байдлаас түүнийг чөлөөлөх гол үндэслэл болно.

Байцаан шийтгэх эрх зүй дэх гэрчийн нэг чухал зарчим бол гэр бүлийн гишүүдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх явдал байдаг. Уг зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулийн 16.14 дэх хэсэгт “ . . . өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх . . . ” хэмээн баталгаажуулсан байдаг. Уг зарчимтай гэрчийн гол үүрэг болох үнэн, зөв мэдүүлэх өгөх үүрэгтэй зөрчилдөнө. Өөрөөр хэлбэл гэрч мэдүүлэх өгөхдөө шударгаар мэдүүлэх үүрэгтэй байдаг. Энэ нь хэргийн нөхцөл байдлыг тодруулах үүднээс гэрчийн мэдүүлэг үнэн байх ёстой. Иймээс ч гэрч хэн нэгний ашиг сонирхлын үүднээс бус (ялангуяа аль нэг хэргийн оролцогчийн ашиг сонирхлын өмнөөс) гагцхүү өөрийн мэдэж буй үйл явдалыг л шүүхийн өмнө гэрчилж оролцоно. Тиймээс л гэрчид санаатайгаар худал мэдүүлэг өгсөн эсхүл мэдүүлэг өгөхөөс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан тохиолдолд Эрүүгийн хуульд заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг нь гэрчийг шударгаар мэдүүлэхийг баталгаажуулсан эрх зүйн арга юм.

Гэр бүлийн гишүүдийнхээ эсрэг мэдүүлэг өгөх тохиолдолд хэрхэх асуудал гарч ирсэн. Энэ ч учиртай бөгөөд дийлэнх тохиолдолд гэрчээр мэдүүлэг өгч буй этгээд гэр бүлийн гишүүдийнхээ ашиг сонирхлыг хамгаалах ба улмаар худал мэдүүлэг өгөх боломжтой байдаг. Иймээс гэрчийн гол үүрэг болох шударга мэдүүлэх үүргээ зөрчиж эрүүгийн хуульд зааснаар хариуцлага хүлээхэд хүрдэг. Тиймээс л гагцхүү өөрийн гэр бүлийн гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй байдгаар дээрх зарчим хэрэгждэг. Уг эрхийг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч урьдчилан сануулж гэрчид энэ тухай тайлбарлан ойлгуулах замаар уг зарчмыг хэрэгжүүлнэ.

Гэрчээр дуудагдсан этгээд шүүхэд өөрийн биеэр хүрэлцэн ирэх үүрэгтэй байдаг. Гэрч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүхэд өөрийн биеэр хүрэлцэн ирж чадахгүй тохиолдолд шүүгч өөрийн биеэр очиж мэдүүлэг авч болохыг заажээ.

Гэрч тухайн шүүхийн харьяалах нутаг дэвсгэрт оршин суудаггүй бол энэ хуулийн 30.1-д “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нотлох баримтыг ойлгох, гаргаж өгөх, цуглуулах, үнэлэхдээ энэ хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37, 40-45, 47-49, 51 дүгээр зүйлд заасан журмыг баримтална” гэж заасны дагуу гэрчийн оршин суугаа нутаг дэвсгэрийн шүүхэд даалгавар өгөх замаар шийдвэрлэнэ.

⁹⁴ Ю.Ёоахимски. Монгол Улсын иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар. Мюнхен. 79 дэх тал.

59 дүгээр зүйл. Шинжээч

- 59.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгайлан эзэмшсэн мэдлэгтэй, уг хэргийн талаар хувийн болон албаны сонирхолгүй, энэ хуульд заасны дагуу захиргааны хэргийн шүүхээс томилогдсон этгээдийг шинжээч гэнэ.
- 59.2. Нотлох баримтыг шинжлэх даалгавар авсан этгээд захиргааны хэргийн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирж, тавигдсан асуудлаар бодитой дүгнэлт өгнө.
- 59.3. Шинжлүүлэхээр өгсөн материал хангалтгүй, эсхүл оногдсон үүргийг биелүүлэхэд эзэмшсэн мэргэжил, мэдлэг нь шаардлага хангахгүй гэж үзвэл шинжээч дүгнэлт өгөхөөс татгалзаж болно.
- 59.4. Шинжээч нь дүгнэлт өгөхөд шаардлагатай гэж үзвэл хэргийн материалтай танилцах, асуулт тавих, нэмэлт материал гаргаж өгөх тухай хүсэлтээ шүүхэд гаргах эрхтэй.
- 59.5. Санаатайгаар худал дүгнэлт өгсөн, эсхүл дүгнэлт өгөхөөс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан шинжээчид Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 59.6. Шинжээч байгууллагаас томилогдсон бол тухайн байгууллагын нэрийн өмнөөс, бусад шинжээч өөрийн нэрийн өмнөөс дүгнэлтээ бичгээр гаргаж, түүний үнэн зөвийг хариуцна. Дүгнэлтэд ямар шинжилгээ хийсэн, түүний үндсэн дээр гарсан дүгнэлт, шүүгчээс тавьсан асуултад өгсөн үндэслэл бүхий хариултыг тодорхой бичнэ. Шинжээч хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдлыг олж тогтоовол энэ талаар шүүхээс асуулт тавигдаагүй ч гэсэн дүгнэлтдээ оруулах эрхтэй.
- 59.7. Шаардлагатай тохиолдолд шүүгч хэд хэдэн этгээдийг шинжээчээр томилж болох бөгөөд тэдгээр нь санал нэгтэй байвал нэг дүгнэлт гаргаж, гарын үсгээ зурна. Харин аль нэг шинжээч бусад шинжээчийн дүгнэлттэй санал нийлэхгүй байвал дүгнэлтээ тусад нь гаргаж болно.
- 59.8. Дахин шинжээч томилох тохиолдолд өмнө нь уг хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргахад оролцсон этгээд оролцохгүй.

ТАЙЛБАР

Шинжээч гэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гагцхүү шүүхээс өгсөн даалгаврын дагуу өөрийн тусгай мэдлэг, чадвараа ашиглах замаар хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тодруулах үүрэг бүхий хэрэгт хувийн болон, байгууллагын ашиг сонирхолгүй хөндлөнгийн байр сууринаас шүүхэд дүгнэлт гарган оролцдог хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчийг хэлнэ. Хэргийн талаар *хувийн ашиг сонирхолгүй* гэдэг нь хэргийн бусад оролцогчидтой өөрөөр хэлбэл нэхэмжлэгч, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, нэхэмжлэгчийн өмгөөлөгч, хариуцагч, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, түүний өмгөөлөгч, гуравдагч этгээд, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчтэй төрөл садан, хувийн харилцааны хувьд дээрх хэргийн оролцогчидтой нэгэн ижил байр суурьтай байхыг ойлгоно. Энэ нь шинжээч дүгнэлтээ тэдний ашиг сонирхлын үүнээс гаргах боломжийг бүрдүүлэн өгөхөд хүргэнэ. *Албаны сонирхолгүй* гэдэг нь шүүхээс хянан шийдвэрлэж буй хэргийн эцсийн шийдвэрийн үр дүнд шинжээчээр томилогдож буй байгууллага, албан тушаалтаны үйл ажиллагаанд нөлөөлөхүйц бус байхыг шаардана. Өөрөөр хэлбэл өөрийн байгууллага, эрхэлж буй албан тушаалын үүднээс дүгнэлтээ гаргахгүй байхыг ойлгоно.

Зөвхөн шинжээчид л тусгай мэдлэг, чадвартай байх шаардлага тавигддаг. Энэ нь хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгчийн эзэмшээгүй мэдлэг, чадваруудыг ойлгодог.⁹⁵

Тусгай мэдлэгийг бие даасан мэргэжил эзэмшсэний үр дүнд олж авдаг бол тусгай чадвар нь хүний үйл ажиллагааны байнгын дадал зуршлын хүрээнд бүрэлдэн тогтдог.

Шүүхийн шинжилгээ явуулах зорилгоор шүүхээс татан оролцуулсан тусгай мэдлэг бүхий этгээд⁹⁶ буюу шинжээч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо тусгайлсан эрх зүйн статустайгаар буюу хэргийн нөхцөл байдлыг тодруулах зорилготойгоор оролцдог тул түүний гаргаж буй дүгнэлт хэрэгт шууд ач холбогдолтой байдаг. Иймд шүүхээс шинжээчийг дүгнэлтээ гаргахаас өмнө урьдчилан хууль сануулдаг. Үүний ач холбогдол нь хэргийн нөхцөл байдлыг бүрэн, гүйцэд тогтоохын тулд томилогдсон шинжээч хувийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих, гадны нөлөөнд автах байдлыг хязгаарладаг эрх зүйн хязгаарлалт болдог. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар уг зарчмыг “*санаатайгаар худал дүгнэлт өгсөн, эсхүл дүгнэлт өгөхөөс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан шинжээчид Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ*” хэмээн тусгажээ. Шинжээч санаатайгаар худал дүгнэлт гаргасан, дүгнэлт өгөхөөс үндэслэлгүйгээр зайлсхийсэн тохиолдолд манай улсын хувьд Эрүүгийн хуулийн 255⁹⁷ дугаар зүйлд заасан эрүүгийн хариуцлагын хүлээлгэдэг нь шинжээчийг дүгнэлт гаргахдаа саадгүй байх зарчмыг эрүүгийн эрх зүйн

⁹⁵ Ю.Ёоахимски. Монгол Улсын иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар. Мюнхен. 85 дах тал.

⁹⁶ С. Нарангэрэл, Эрх зүйн толь бичиг 2007 он, 593 дэх тал

⁹⁷ 255.1 . . . шинжээч дүгнэлт гаргахаас хууль бусаар татгалзсан, зайлсхийсэн . . . бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

аргаар баталгаажуулж буй зохицуулалт юм. Түүнчлэн Эрүүгийн хуулийн 256⁹⁸ дугаар зүйлд шинжээчийг дүгнэлтээ гаргахад нөлөөлөхөөс хамгаалсан байдаг.

Шинжээч нь хэргийг хянан шийдвэрлэж буй шүүгч, шүүх бүрэлдэхүүний эзэмшээгүй буюу илүүтэйгээр нарийн мэргэшил шаардсан асуудлын хүрээнд шүүхээс томилон оролцуулдаг. Ингэхдээ мэдлэгийн аль ч салбарын хүрээг хамаар ч болно.

Шүүгчийн хувьд шинжээч бол түүний туслагч болдог. Өөрөөр хэлбэл хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтуудыг илрүүлэн гаргаж ирснээр шүүхийн шийдвэрийн үндэслэлийг бүрдүүлж өгдөг. Энэ нь Захиргааны хэргийн шүүх шиг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь мөрдөн шалгах зарчимтай шууд холбоотой байдаг.

Шинжээчээр албан байгууллагыг тусгайлан томилж болно. Харин уг байгууллагаас чухам ямар шинжээч оролцох эсэхийг байгууллагын эрх баригч шийдвэрлэнэ. Ийнхүү шинжээч байгууллагаас томилогдсон бол өөрийн дүгнэлтээ байгууллагынхаа нэрийн өмнөөс гаргана.

Хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан хэд хэдэн шинжээчийг зэрэг томилж болно. Энэ нь шинжлүүлж буй асуудлын онцлог, цар хүрээг гол шалгуур болгодог. Нэгдүгээрт, шинжлүүлж буй асуудал нь мэдлэгийн олон төрлийн салбарыг хамарч байгаа, хоёрдугаарт, давтан шинжилгээ хийлгэх шаардлагатай болсон, гуравдугаарт, шинжилж буй асуудал нь харьцангуй их цаг хугацаанд явуулах шаардлагатай болсон тохиолдолд хэдэн ч шинжээчийг томилохыг хууль тогтоогчийн зүгээс хязгаарлаагүй байна.

Шинжээч дүгнэлт гаргахдаа баримтлах гол зарчим бол бодит байдлыг тогтоох зарчим юм. Хэдийгээр шүүхээс чухам ямар зүйлсийг тогтоохыг заах боловч шинжилгээ хийх явцад хэрэгт ач холбогдол бүхий зүйлсийг тодруулан гаргаж ирвэл түүнийгээ дүгнэлтдээ тусгах эрхийг нь олгосон.

Давтан шинжилгээ хийх тохиолдолд өмнө шинжээчээр томилогдсон шинжээч, байгууллагыг томилохыг хориглодог.

60 дугаар зүйл. Орчуулагч, хэлмэрч

- 60.1. Хэргийн оролцогч монгол хэл мэддэггүй, эсхүл хэлгүй, дүлий бол түүний хүсэлтээр орчуулагч, хэлмэрчийг захиргааны хэргийн шүүгч захирамж гарган томилно.
- 60.2. Орчуулагч, хэлмэрч захиргааны хэргийн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирж, тухайн этгээдийн нэхэмжлэлийн шаардлага, тайлбар, мэдүүлэг, татгалзал буюу оролцогчийн шаардлага, тайлбар, мэдүүлэг, татгалзал, шүүх хуралдааны болон бусад ажиллагаа, шүүхийн шийдвэрийн агуулгыг үнэн зөв, бүрэн орчуулж,

⁹⁸ 256.1. Хүч хэрэглэх, эд хөрөнгийг нь устгахаар заналхийлэх, шан харамж өгөх зэргээр . . . шинжээчээр худал дүгнэлт гаргуулсан, орчуулагчаар худал орчуулуулсан, хэлмэрчээр худал хэлмэрчлүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуугаас гурван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

256.2. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, эсхүл их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

хэлмэрчилж өгөх, хэргийн материалтай цаг хугацаанд нь танилцахад туслах үүрэгтэй.

- 60.3. Орчуулагч, хэлмэрч нь орчуулгыг тодруулахаар асуулт тавьж болно.
- 60.4. Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогч орчуулагч, хэлмэрчийн үүрэг гүйцэтгэхийг хориглоно.
- 60.5. Санаатайгаар буруу орчуулсан, хэлмэрчилсэн, эсхүл орчуулга хийхээс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан хэлмэрчид Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ТАЙЛБАР

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй хэргийн оролцогчдын аль нэг нь монгол хэл мэдэхгүй эсвэл төрөлхийн болон олдмол шалтгааны улмаас хүний хэлж буй зүйлсийн ярианы тусламжтай ойлгож чадахгүй тохиолдолд орчуулагч, хэлмэрчийг шүүхээс оролцуулна. Ингэхдээ хэлмэрч орчуулагч нь хэргийн үндсэн оролцогчид болох нэхэмжлэгч, гуравдагч этгээдэд шүүхийн ажиллагааны аль ч шатанд эх хэл дээрээ тайлбар мэдүүлэг өгөх эрхээ эдлэх боломжийг бүрдүүлдэг.

шатанд эрхээ эдлэх боломжийг бүрдүүлдэг.

Орчуулагч, хэлмэрчийг гагцхүү шүүхээс томилох бөгөөд хэргийн бусад оролцогчид уг үүргийг нь гүйцэтгэхийг хориглоно. Учир нь орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар процессын ажиллагаанд оролцож буй этгээдийн шаардлага, татгалзлын үндэслэлийг бие даасан шинжтэйгээр эдлүүлэх байдлаар ойлгогдоно. Нэгэнт шүүхээс орчуулагч, хэлмэрчээр томилогдсон тохиолдолд уг этгээдийнхээ эрхийг эдлүүлэх үүднээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд тэдэнд туслах үүрэгтэй.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд орчуулагч, хэлмэрч оролцох шаардлага нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан *мэтгэлцэх*, 10 дугаар зүйлд тусгагдсан *шүүн таслах ажиллагаа явуулах хэлний зарчмуудаас үүдэлтэй*. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 8.1-т *Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн* гэх заалт, Төрийн албан ёсны хэлний тухай хуулиас улбаатай. Өөрөөр хэлбэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нь өөрийн шаардлага татгалзлын үндэслэл болж буй зүйлсийг шүүх хуралдааны явцад илэрхийлэх нь мэтгэлцэх зарчим хэрэгжиж буй гол баталгаа болдог. Иймээс уг зарчим хэрэгжихэд Монгол хэл мэдэхгүй, шүүх бүрэлдэхүүн, шүүгч бусад оролцогчдын гаргаж буй тайлбар, нотлох баримтуудад өөрийн байр суурийг илэрхийлэх байдлыг хангах үүднээс орчуулагч, хэлмэрч оролцуулна. Монгол Улсын хувьд шүүн таслах үйл ажиллагаа нь төрийн албан ёсны хэл болох "Монгол хэл" дээр явагдах байдлыг баталгаажуулсан. Энэ нь гадаадын иргэн, хуулийн этгээдүүд Монгол хэл мэдэхгүй байдал, эд эрхтний байдлаас шалтгаалан шүүх хуралдаанд оролцогчдын хэлж буй зүйлсийг ойлгож чадахгүй байгаа нь шүүхээр эрхээ

хамгаалуулах байдлыг нь хязгаарлахгүй бөгөөд түүнийг нь эдлүүлэх боломжийг орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар хангадаг.

Шүүх хуралдааны үйл явцыг нарийн бичгийн дарга тэмдэглэл хөтлөх замаар баталгаажуулах бөгөөд уг тэмдэглэл Монгол хэл дээр хөтлөгдөнө. Үүнд хэлмэрч орчуулагчийн тусламжтайгаар хэргийн оролцогчийн тайлбар, шаардлагыг тусгана. Орчуулагч, хэлмэрч нь шүүгчийн туслагч болж байдаг. Нөгөө талаасаа оролцогчдын эрхийг хангуулах шүүх тогтолцооны чухал оролцогчдын нэг юм.

61 дүгээр зүйл. Шүүх хуралдаан

61.1. Энэ хуулийн 42, 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд захиргааны хэргийг гагцхүү шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

ТАЙЛБАР

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх болон нэхэмжлэгч хариуцагч эвлэрэхээс бусад тохиолдолд хэргийг шүүх хуралдаанаар шийдвэрлэнэ.

Шүүх хуралдаан гэдэг нь тодорхой дэгийн хүрээнд шүүхээс хууль хэрэглэх замаар хэргийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтуудыг баталгаажуулан шийдвэр гаргах процессын үе шат юм.

Шүүх хуралдаанаар хэргийг шийдвэрлэхэдээ монгол хэлээр явуулж төрийн албан хэрэг хөтлөх бичгээр бичиж баримтжуулан мэтгэлзэх зарчмыг хангаж, нээлттэй, тасралтгүй байх зарчмыг хангасан байна.

62 дугаар зүйл. Шүүх хуралдаан даргалагч, түүний эрх, үүрэг

62.1. Захиргааны хэргийг шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байгаа бол тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс томилогдсон шүүгч, Ерөнхий шүүгч шүүх бүрэлдэхүүнд орж байгаа тохиолдолд Ерөнхий шүүгч, дангаар хэргийг хянан шийдвэрлэж байгаа бол шүүгч шүүх хуралдааныг тус тус даргална.

62.2. Шүүх хуралдаан даргалагч хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу явуулах, хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох, хэргийн оролцогч эрх, үүргээ хэрэгжүүлэх, мэтгэлцэх зарчмыг хангах, шүүх хуралдааны дэгийг сахиулах талаар шаардлагатай арга хэмжээ авна.

ТАЙЛБАР

Шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1-д зааснаар бүх шатны шүүхийн шүүгч шүүх хуралдааныг даргалах эрхтэй байна.

Захиргааны хэргийг шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байгаа бол тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс томилогдсон шүүгч, хэрэв шүүх бүрэлдэхүүнд тухайн шүүхийн Ерөнхий шүүгч оролцож байгаа бол Ерөнхий шүүгч даргална. Харин

шүүгч дангаар хэргийг хянан шийдвэрлэж байгаа бол тухайн шүүгч шүүх хуралдааныг даргална.

Шүүх хуралдаан даргалагч нь шүүх хуралдааныг даргалахдаа

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу явуулах;
- Хэргийн оролцогч эрх үүргээ хэрэгжүүлэх боломжийг хангах;
- Мэтгэлцэх зарчмыг хангах;
- Шүүх хуралдааны дэгийг сахиулах үүргийг хүлээнэ.

Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааныг нээх, ямар хэрэг хянан хэлэлцэж байгааг зарлан мэдэгдэх, шүүх хуралдааны бүрэлдэхүүнийг танилцуулах хэргийн оролцогч болон шүүх хуралдааны оролцогч нарт эрх үүргийг тайлбарлах, гэрчийг шүүх хуралдааны танхимаас тусгаарлах шийдвэр гаргах, шүүх бүрэлдэхүүнийг татгалзах эсэхийг хэргийн оролцогчдоос асуух, нотлох баримт шинжлэн судлах дарааллыг тогтоох, шүүх хуралдааны дэгийг зөрчсөн этгээдэд арга хэмжээ авах зэрэг хуулиар түүнд олгогдсон эрх үүргийг хэрэгжүүлнэ.

63 дугаар зүйл. Шүүх хуралдааны нийтлэг журам

- 63.1. Шүүх хуралдааны танхимд байгаа бүх хүн захиргааны хэргийн шүүхийг хүндэтгэх, хуралдааны танхимд тогтоосон журмыг сахих, хуралдаан даргалагчийн шийдвэрт захирагдах үүрэгтэй.
- 63.2. Шүүх хуралдаанд оролцогч тайлбар, мэдүүлэг өгөх, дүгнэлт гаргахдаа суудлаасаа босно.
- 63.3. Хуралдаанд оролцогч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас суудлаасаа босч чадахгүй бол хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр суугаагаараа үг хэлж болно.
- 63.4. Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч хуралдааны танхимд орж ирэх, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг уншиж сонсгох үед танхимд байгаа бүх хүн суудлаасаа босно.
- 63.5. Шүүх хуралдааны журам зөрчсөн этгээдэд эхний удаа хуралдаан даргалагч урьдчилан сануулна. Дахин зөрчил гаргасан этгээдийг хуралдаан даргалагчийн захирамжаар шүүх хуралдааны танхимаас гаргаж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан журмаар торгууль ногдуулна.
- 63.6. Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, гэрч, шинжээчийг шүүх хуралдааны танхимаас гаргасан тохиолдолд хуралдаан даргалагчийн захирамжаар шүүх хуралдааныг тодорхой хугацаагаар хойшлуулах, эсхүл тэдгээрийн тайлбар, мэдүүлгийг сонсохгүйгээр захиргааны хэргийг хянан шийдвэрлэх боломжтой гэж

үзвэл үргэлжлүүлэн явуулах бөгөөд хуралдаан даргалагч уг этгээдэд түүний байхгүйд хэлэлцсэн асуудлыг танилцуулна.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ., 2007, хамтын бүтээл, 244-246 дахь талыг үзнэ үү.

64 дүгээр зүйл. Шүүгч өөрөө татгалзан гарах үндэслэл

- 64.1. Дараах үндэслэл байвал шүүгч захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд үл оролцох ба өөрөө татгалзан гарах үүрэгтэй:
- 64.1.1. урьд нь уг захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгч, өмгөөлөгч, прокурор, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчээр оролцож байсан;
 - 64.1.2. уг захиргааны хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн төрөл садан, эсхүл шүүх бүрэлдэхүүнд хоорондоо төрөл, садангийн холбоотой хүмүүс орсон;
 - 64.1.3. хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, эсхүл уг захиргааны хэргийг шударгаар шийдвэрлэж чадах талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал;
 - 64.1.4. анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэх болсон.
- 64.2. Энэ хуулийн 64.1.4-т заасан журам нь Улсын дээд шүүхэд хамаарахгүй.
- 64.3. Энэ хуулийн 64.1-д зааснаас бусад үндэслэлээр шүүгчийг татгалзаж үл болно.
- 64.4. Энэ хуулийн 64.1.1-64.1.3-т заасан заалт нь иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргад нэгэн адил хамаарна.
- 64.5. Шинжээч энэ хуулийн 64.1.1-64.1.3-т зааснаас гадна дараахь тохиолдолд дүгнэлт гаргахаас татгалзана:
- 65.1.1. албан тушаалын буюу бусад байдлаар хэргийн оролцогч нь шинжээчид нөлөөлж болох байвал;
 - 65.1.2. урьд нь түүний хийсэн шинжилгээний дүгнэлт уг захиргааны хэргийн үндэс болсон.
- 64.6. Энэ хуулийн 64.1-д заасан татгалзан гарах үндэслэл байвал шүүгч, иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга энэ тухайгаа шүүх хуралдаан эхлэхээс өмнө, эсхүл татгалзан

гарах үндэслэл шүүх хуралдааны явцад илэрхий болсон бол тухайн үед мэдэгдэж татгалзан гарах үүрэгтэй.

ТАЙЛБАР

Шүүгч өөрөө татгалзан гарах үндэслэл нь шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож үл болох Үндсэн хуулийн зарчмаас үүдэлтэй.

Энэхүү зарчмын "...хэн боловч..." гэдгийг заавал бусдад хамаатуулж ойлгох шаардлагагүй бөгөөд шүүгчийн хараат бус байдалд өөрийн хувийн ашиг сонирхол /субъектив үнэлгээ/ ч нөлөөлж үл болно гэсэн утгаар ойлгож болно. Эндээс шүүгчийн өөрөө татгалзан гарах үндэслэл үүсч байна.

Шүүгч өөрөө татгалзан гарах үндэслэл нь тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгч өөрийн хувийн ашигт сонирхлоос хараат бус байх, ашиг сонирхлын зөрчилдөөнөөс ангид байлгах зорилготой юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн "Шүүгч өөрөө татгалзан гарах үндэслэл" гэх 64 дүгээр зүйлийн "Шүүгч өөрөө..." гэдэг нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогтой холбон тайлбарлаж болох юм. Энэ нь захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь мөрдөн шалгах зарчимтай хамаатай байна. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар нотлох баримтыг бүрдүүлэх, цуглуулах, үнэлэх үүргийг бий болгодог. Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх явцад шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллангаанд оролцож болохгүй хуульд заасан үндэслэл бий болсон тохиолдолд дээрх процессын зарчмын дагуу хамгийн түрүүнд шүүгч өөрөө татгалзан гарах үүрэгтэй юм. Нөгөө талаар шүүгч хуульд заасан үндэслэл бий болсон тохиолдолд хэргийн оролцогчдын аль нэг нь шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргаагүй бол шүүгч тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос өөрөө татгалзан гарах эрхтэй.

Хэдийгээр захиргааны хэргийн оролцогчид шүүгчийг хуульд заасан үндэслэлээр татгалзах хүсэлт гаргах эрхтэй байгаа боловч энэ нь ихэвчлэн шүүгчийн зүгээс хуульд заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд өөрөө татгалзан гарах бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй тохиолдолд хэрэгжих дараагийн шатны ажиллагаа байдаг. Захиргааны хэргийн оролцогчид хуульд заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд шүүгчийг татгалзан гарах хүсэлт гаргаагүй буюу хэргийг оролцогчид хүсэлт гаргаснаас үл хамааран шүүгч өөрөө татгалзан гараагүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуулийн дагуу явагдаагүй гэж үзэж болохоор байна.

Хуульд заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд шүүгч өөрөө татгалзан гарах үүрэгтэйгээс гадна иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах талаар хэргийн оролцогч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч, прокурор, хүсэлт гаргах эрхтэй.

Энэ зүйлд шүүгчийг татгалзан гаргах үндэслэлээс гадна иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах журмыг давхар зохицуулсан байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.6-т зааснаар 64.1-д заасан татгалзан гарах үндэслэл байвал шүүгч, иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга энэ

тухайгаа шүүх хуралдаан эхлэхээс өмнө, эсхүл татгалзан гарах үндэслэл шүүх хуралдааны явцад илэрхий болсон бол тухайн үед мэдэгдэж татгалзан гарах үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, энэхүү заалтаас харахад "өөрөө татгалзан гарах үүрэг" зөвхөн шүүгчид үүсэхгүй бөгөөд, иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргад хамаарахаар байна.

Захиргааны хэргийг урьд нь хянан шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгч, өмгөөлөгч, прокурор, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчээр оролцож байсан шүүгч тухайн хэргийг дахин хянан шийдвэрлэхэд оролцож үл болох бөгөөд өөрөө татгалзан гарах үүрэгтэй.

"урьд нь" гэдгийг тухайн захиргааны хэргийг анхан шатны, давж заалдах болон хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэж байсныг ойлгоно. Хуульд заасан энэ үндэслэл бүрдсэн тохиолдолд хэргийн оролцогчид шүүгчийг татгалзан гарах хүсэлт гаргах эрхтэй.

Шүүгч тухайн захиргааны хэргийн болон шүүх уралдаанд оролцогчийн төрөл садан эсхүл шүүх бүрэлдэхүүнд хоорондоо төрөл, садангийн¹ холбоотой хүмүүс орсон бол шүүгч уг захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд оролцохгүй. Эндээс захиргаан хэргийн болон шүүх хуралдаанд оролцогч" гэдгийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16, 54 дүгээр зүйлд зааснаар ойлгоно.

Тухайн захиргааны хэргийг дангаар шийдвэрлэх эсхүл шүүх бүрэлдхүүнд орсон шүүгч хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, эсхүл уг захиргааны хэргийг шударгаар шийдвэрлэж чадах талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй. "Хувийн харилцаатай,..." гэдгийг ердийн танил, эсхүл хөршийн харилцаанаас илүү дотно харилцаа гэж ойлгоно.

"Үндэслэл бүхий эргэлзээ" гэдэг нь шүүгчийн хараат бус байдал алдагдсан нь заавал нотлогдсон байх шаардлагагүй бөгөөд тухай шүүгч гадны нөлөөнд бодитой автагдсан нь чухал биш юм. Шүүгч гадны нөлөөнд автагдаж, хараат бус байдал нь алдагдсан, эсхүл тийм байдал ирээдүйд бий болж болзошгүй талаар хангалттай үндэслэл бүхий эргэлзээ байгаа тохиолдолд хэргийн оролцогчид шүүгчийг татгалзан гарах хүсэлт гаргана.

Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэх болсон бол тухайн захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгч оролцож болохгүй юм. Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.4-т захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгч дахин оролцож болохгүй үндэслэлийг нэлээд ерөнхий байдлаар зохицуулсан бөгөөд үүнийг дараахь байдлаар салгаж ойлгох нь зүйтэй. Тухайлбал, анхан шатны шүүхийн шүүгчийн хувьд, Захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэх, түүнчлэн түүний оролцоотойгоор хэргийг хэрэгсэхгүй болгохоор гарсан шүүхийн тогтоол, магадлалыг хүчингүй болгосон бол анхан шатны журмаар

дахин хэрэг хэлэлцэхэд оролцож болохгүй. Мөн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн хувьд, давж заалдах шатны шүүхэд хэрэг хянан хэлэлцэхэд оролцсон шүүгч уг хэргийг анхан шатны болон хяналтын журмаар хянан хэлэлцэх, түүнчлэн түүний оролцоотойгоор гаргасан магадлалыг хүчингүй болгосон бол давж заалдах шатны шүүхээр уг хэргийг дахин хянан хэлэлцэхэд оролцож болохгүй. Хяналтын шатны шүүхийн шүүгчийн хувьд, хяналтын журмаар хэрэг хэлэлцэхэд оролцсон шүүгч уг хэргийг анхан шатны болон давж заалдах шатны шүүхээр хянан хэлэлцэх, түүнчлэн түүний оролцоотойгоор гаргасан тогтоолыг хүчингүй болгосон бол хяналтын шатны шүүхээр уг хэргийг дахин хянан хэлэлцэхэд оролцож болохгүй.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2-т дээрх 64.1.4-т заасан журам Улсын дээд шүүхэд хамаарахгүй гэж зааснаар дээрх журам нь зөвхөн анхан шатны шүүхийн шүүгчид л хамаарахаар байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1-д зааснаас бусад үндэслэлээр шүүгчийг татгалзаж үл болно. Хэргийн оролцогчид зөвхөн хуульд заасан үндэслэлээр шүүгчийг татгалзан гарах хүсэлт гаргана.

65 дугаар зүйл. Татгалзан гаргах хүсэлт, татгалзан гарах

- 65.1. Энэ хуулийн 64.1-д заасан үндэслэлээр шүүгч, иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргахыг зохигч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч, прокурор, гуравдагч этгээд хүсч болох ба энэ тохиолдолд захиргааны хэргийн шүүх хэргийн оролцогчийн санал болон татгалзан гаргагдаж байгаа этгээд хүсвэл түүний тайлбарыг сонсоно.
- 65.2. Татгалзан гаргах тухай асуудлыг шүүх бүрэлдэхүүн тогтоол, шүүгч захирамж гаргаж шийдвэрлэнэ.
- 65.3. Шүүгчийг татгалзан гаргах тухай асуудлыг түүнийг байлцуулахгүйгээр бусад шүүгчид шийдвэрлэх ба санал тэнцвэл уг шүүгчийг татгалзан гаргасанд тооцно.
- 65.4. Хэд хэдэн буюу хэргийг дангаар шийдвэрлэх шүүгчийг, түүнчлэн шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлтийг тухайн захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч шийдвэрлэж, захирамж гаргана.
- 65.5. Иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлтийг захиргааны хэргийг хэлэлцэж байгаа шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч шийдвэрлэнэ.

65.6. Ерөнхий шүүгч дангаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх явцад түүнийг татгалзсан буюу тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан бол шүүгчдийн зөвлөлгөөн олонхийн саналаар шийдвэрлэн тогтоол гаргана.

ТАЙЛБАР

Шүүгч, иргэдийн төлөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь энэ хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.1-64.1.4-д заасан татгалзан гарах үндэслэл байвал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарч, хуульд заасан үүргээ биелүүлэх ёстой. Энэ нь тухайн татгалзан гарч буй хүний болон мэргэжлийн ёс зүйгээр тайлбарлагдана. Дээр дурьдсан этгээдүүд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах үндэслэл бий болсныг мэдсэн даруйдаа хүсэлтээ гаргана.

Шүүгчийн хувьд хуульд заасан татгалзан гарах үндэслэл байгааг мэдсээр байж, уг хэргийг хянан шийдвэрлэсэн нь түүний шийдвэр хэр зэрэг бодитой болсноос үл шалтгаалан тухайн шийдвэр хүчингүй болох эрх зүйн үр дагавар үүснэ. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөн үндэслэл болно.

Энэ зүйлд зааснаар шүүгч, иргэдийн төлөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь хуульд заасан үндэслэл бий болсон тохиолдлыг мэдсэн даруйдаа өөрөө татгалзан гарахыг тэдгээрт хуулиар үүрэг болгон заасан. Харин нэхэмжлэгч, хариуцагч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч, гуравдагч этгээд энэ хуулийн 64 дүгээр зүйлд заасан үндэслэл бий болсныг мэдсэн даруйдаа шүүхэд татгалзах тухай хүсэлтээ гаргана. Энэ хүсэлтийг шүүх хуралдаанаас буюу шүүх хуралдаан эхлэхээс өмнө гаргаж болно.

Ашиг сонирхлын зөрчил байгаа, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхол ноцтой хөндөгдөнө гэж үзсэн бол нэхэмжлэгч, хариуцагч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч, гуравдагч этгээд нь хэргийн бодит байдлыг тогтооход албан үүргийнхээ дагуу оролцдог шүүгч болон иргэдийн төлөөлөгч, шинжээч, (хэлмэрч) орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах хүсэлтийг шүүхэд гаргаж болно.

Энэ хуулийн 64 дүгээр зүйлд шүүгч болон шүүх хуралдааны оролцогч болох иргэдийн төлөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь хэргийн оролцогчидтой хувийн харилцаатай, түүнчлэн уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ бусдад төрүүлэхээр нөхцөлд татгалзлыг дээр дурдсан этгээдүүд өөрсдөө гаргаж байгаа учраас ямар нэг хүндрэл учрахгүй байх талтай.

Шүүгч, иргэдийн төлөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга энэ зүйлд зааснаар татгалзан гарах тухай хүсэлт гаргахдаа ямар шалтгааны улмаас татгалзан гарах болсон тухай тайлбарлана.

Шүүгчийг татгалзан гаргах асуудал үндэслэлтэй эсэхийг татгалзан гарах хүсэлт гаргасан буюу хэргийн оролцогчийн хүсэлтээр татгалзагдсан шүүгчийг байлцуулахгүйгээр шүүх бүрэлдэхүүний бусад шүүгчид шийдвэрлэнэ.

Шүүгчийг татгалзан гаргах эсэх асуудлыг шүүх бүрэлдэхүүний бусад үлдсэн шүүгчдийн олонхын саналаар шийдвэрлэх боловч санал тэнцсэн үед уг шүүгчийг татгалзан гаргасанд тооцно. Анхан болон давж заалдах шатны шүүх гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэргийг хянан шийдвэрлэдэг учир нэг шүүгчийг татгалзсан буюу шүүгч өөрөө татгалзсан тохиолдолд ямагт хоёр шүүгч үлдэх учир тэдгээрийн санал зөрсөн үед тухайн шүүгчийг татгалзан гаргасанд тооцогдох болно. Түүнчлэн хяналтын шат буюу Дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанд энэ журам нэгэн адил хамаарна.

Хэргийг шүүх бүрэлдэхүүнээр болон дангаар шийдвэрлэж байгаа шүүгчийг, татгалзсан тухай хүсэлтийг шүүх хуралдааны өмнө эсхүл шүүх хуралдааны явцад гаргасан бол уг хүсэлтийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч шийдвэрлэнэ.

Энэ тохиолдолд тухайн шүүхийн Ерөнхий шүүгч захирамж гарган хүсэлтийг хангах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хэргийн оролцогч, иргэдийн төлөөлөгчийн хүсэлтийг тухайн хэргийг шийдвэрлэхээр томилогдсон шүүх бүрэлдэхүүн эсхүл шүүгч захирамж, шүүх бүрэлдэхүүн тогтоолоор шийдвэрлэх болно.

Тухайн шүүхийн Ерөнхий шүүгч хэргийг дангаар хянан шийдвэрлэх явцад буюу шүүх бүрэлдэхүүнийг бүхэлд нь хэргийн оролцогч, иргэдийн төлөөлөгч татгалзан гаргах хүсэлт гаргасан тохиолдолд шүүгчдийн зөвлөлгөөн уг асуудлыг хүлээн авах эсэхийг шийдвэрлэнэ.

66 дугаар зүйл. Шүүгчийг татгалзан гаргасны үр дагавар

- 66.1. Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг хангасан бол захиргааны хэргийг өөр бүрэлдэхүүн, шүүгч хянан шийдвэрлэнэ.
- 66.2. Тухайн захиргааны хэргийн шүүхийн бүх шүүгчийг татгалзан гаргасан, эсхүл бүх шүүгч уг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд урьд оролцож дахин оролцох боломжгүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд оролцох шүүгч хүрэлцэхгүй болсон тохиолдолд хэргийг ижил шатны өөр захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар дээд шатны шүүхэд шилжүүлнэ.
- 66.3. Энэ хуулийн 66.2-т зааснаар захиргааны хэрэг шилжиж ирсэн тохиолдолд дээд шатны захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч захирамж гарган зохих шатны өөр шүүхэд шилжүүлж, тухайн шүүхийн шүүгч зохих хуваарийн дагуу хүлээн авч хянан шийдвэрлэнэ.

Энэ хуулийн 64 дүгээр зүйлд заасан үндэслэл бий болсон гэж үзсэн тохиолдолд татгалзан гарах буюу татгалзан гаргах хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ямар нэг үр дагавар үүсэхгүй харин уг хүсэлтийг хангасан бол тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс тогтоосон журмыг баримтлан хэргийг өөр шүүх бүрэлдэхүүн, өөр шүүгч шийдвэрлэнэ.

Хуульд заасан үндэслэл бий болсон гэж үзэж тухайн шүүхийн бүх шүүгчид татгалзан гарсан эсхүл хэргийн оролцогч болон иргэдийн төлөөлөгчийн хүсэлтээр тухайн шүүхийн бүх шүүгчийг татгалзан гаргагдсан, мөн бүх шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд урьд оролцож дахин оролцох боломжгүй болсон бол хэргийг адил шатны өөр шүүхээр шийдвэрлүүлэхээр тухайн шатны Ерөнхий шүүгч захирамж гарган шилжүүлнэ.

Тухайн шүүхийн бүх шүүгчийг татгалзан гаргасан, эсхүл бүх шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд урьд оролцож дахин оролцох боломжгүй, мөн шүүх бүрэлдэхүүнд оролцох шүүгч хүрэлцэхгүй болсон шалтгаанаар шилжиж ирсэн хэргийг хүлээж авсан адил шатны шүүх өөрийн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс тогтоосон хуваарийн дагуу хэргийг шүүгчид хуваарилна.

67 дугаар зүй. Шийдвэрийг зөвлөлдөх тасалгаанд гаргах, санал хураах

- 67.1. Бүх шатны захиргааны хэргийн шүүх шийдвэрээ зөвлөлдөх тасалгаанд гаргана.
- 67.2. Зөвлөлдөх тасалгаанд захиргааны хэргийг шийдвэрлэх талаар шүүгчийн гаргасан санал нууц байна.
- 67.3. Шүүх бүрэлдэхүүн асуудал бүрийг олонхийн саналаар шийдвэрлэнэ /Энэ хэсэгт 2005 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/.
- 67.4. Хуралдаан даргалагч өөрийн саналыг бусад шүүгчийн дараа гаргана.
- 67.5. Асуудал шийдвэрлэхэд шүүгч саналаа өгөхөөс татгалзах эрхгүй.
- 67.6. Улсын дээд шүүхэд хяналтын шатны журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүх бүрэлдэхүүний санал тэнцвэл тухайн асуудлаар олонхийн санал аваагүйд тооцно.

ТАЙЛБАР

Бүх шатны шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангах нөхцөлийн нэг бол шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд шийдвэр гаргах явдал юм.

Шүүхийн шийдвэрийг зөвлөлдөх тасалгаанд гаргах нь тухайн хянан хэлэлцсэн хэргийн талаар гадны нөлөөгүй бодитой шийдвэр гаргах нэг нөхцөл болдог. Шүүхийн шийдвэрийг зөвлөлдөх тасалгаанд гаргаж байх шаардлагыг хэрэгжүүлэх баталгаа бол тухайн шүүх шаардлага хангасан шүүгчдийн зөвлөлдөх тасалгааг бий болгосон байвал зохино. Шүүхийн зөвлөлдөх тасалгаанд шүүгч гар утастай орох, ярихыг хориглоно.

Шүүгчид зөвлөлдөж байгаа үед зөвлөлдөх тасалгаанд уг хэргийг хэлэлцсэн шүүх бүрэлдэхүүнээс гадна өөр хүмүүс байж болохгүй.

Шүүгч нь шүүхийн хараат бус байдлыг хангаж, шүүгчийн тангаргийг сахин биелүүлэхдээ гадны аливаа дарамт, шахалт, сүрдүүлэг болон хувийн сонирхлын үүднээс танил тал харах зэрэг сөрөг нөлөөлөөс ангид байж гэмээнэ шүүхийн шийдвэрийг үндэслэлтэй гаргана. Шүүгчээс шүүхийн шийдвэр гаргахад өгсөн санал, ямагт нууц байх ёстой.

Зөвлөлдөх тасалгаанд хянан хэлэлцсэн шүүхийн шийдвэрийн талаархи шүүгчдийн санал нууц байснаараа шүүгч хэлэлцэж буй асуудалд өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, түүнийхээ үндэслэлийг онол, практикт тулгуурлан хамгаалах, ингэснээрээ шийдвэр гаргах саналаа чөлөөтэй гаргах боломжийг бүрдүүлж байгаа чухал хүчин зүйл юм.

Зөвлөлдөх тасалгаанд шүүхийн шийдвэр гаргах явцад тэмдэглэл хөтөлдөггүй бөгөөд улмаар шүүгчдийн саналын тоог шүүхийн шийдвэрт тусгадаггүй.

Шүүхийн шийдвэр гаргахдаа шүүгчдийн олонхын саналаар асуудал бүрийг шийдвэрлэнэ.

Хуульд шүүгчдээс хэн нь эхэлж санал гаргах талаар тодорхой зохицуулалат байхгүй байна

Хэдийгээр хуульд энэ талаар зохицуулаагүй ч хамгийн залуу шүүгч эхэлж санал гаргаад түүний дараа ахмад шүүгч, эцэст нь шүүх хуралдааны даргалагч саналаа гаргах нь хамгийн зохимжтой дараалал юм⁹⁹.

Энэ зүйлд зааснаар шүүх хуралдааны даргалагч өөрийн саналыг бусад шүүгчдийн дараа гаргаж байгаа явдал нь санал зөрөх тохиолдолд асуудлыг нэг мөр шийдвэрлэхэд ач холбогдолтой байж болох юм. Нөгөө талаас шүүх бүрэлдэхүүний бусад шүүгчдэд дотоод итгэлээрээ асуудал бүрийг шийдвэрлэх боломжийг олгох, өөрөөр хэлбэл шүүгчийн хараат бус байх хуулийн шаардлагыг биелүүлж байгаа нэг хэлбэр гэж үзэж болох юм.

“Шүүх хуралдаан даргалагч өөрийн саналыг бусад шүүгчдийн дараа гаргана” гэсэн зохицуулалт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гардан явуулсан шүүгч хэргийн талаарх өөрийн субъектив санаа, бодлоор бусад шүүгчдийн гаргах саналыг хөтлөхгүй байх, тэдний саналыг чөлөөтэй гаргуулах зорилготойгоор хуульд тусгагдсан гэж ойлгогдож байна.

Харин шүүгч нь санал өгөхөөс түдгэлзэх буюу татгалзаж болохгүй.

Шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд ямар ч нөхцөлд хэргийн талаар тодорхой шийдвэр гаргах нь тэдгээрийн үүрэг юм.

Харин хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэж байхад тухайн 3 шүүгч гурван өөр санал гаргавал хэрхэн шийдвэрлэх талаар хуулийн зохицуулалт

⁹⁹ Юпп Ёоахимски. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар. Мюнхен. 2004. 167-р тал.

одоогоор байхгүй тул дахин санал гаргах журмаар асуудлыг заавал олонхын саналаар шийдвэрлэж дуусгана.

Харин Улсын Дээд шүүхийн хяналтын шатны хуралдаанаар шүүгчдийн санал тэнцэх асуудлыг Дээд шүүхийн хуралдааны дэгийн 44 дүгээр зүйлд “Дээд шүүхийн шүүх бүрэлдэхүүний санал тэнцвэл “олонхын санал аваагүй” гэж үзэж, дүгнэлтийг хүлээн аваагүйд тооцно” гэж журамласан байна.

68 дугаар зүйл. Шүүх хуралдааны тэмдэглэл

- 68.1. Шүүх хуралдааны тэмдэглэлд хуралдааныг хэзээ, хаана хийсэн, эхэлсэн, дууссан цаг, шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, хэргийн ба шүүх хуралдааны оролцогчдын овог, эцгийн нэр, нэр, хаяг, тэдний ирц болон тэдэнд эрх, үүргийг тайлбарласан байдал, хэргийн болон шүүх хуралдааны оролцогчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, нотлох баримтыг шинжилсэн байдал, шүүх бүрэлдэхүүн, шүүгчээс захиргааны хэргийн талаар асууж тодруулсан байдал, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн агуулга, түүнд гомдол гаргах хугацаа, журмыг тайлбарласан байдлыг бичнэ.
- 68.2. Шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор тэмдэглэлийг бэлэн болгох ба түүнд шүүх хуралдаан даргалагч буюу шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.
- 68.3. Хэргийн оролцогчид нь шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж болно.
- 68.4. Тэмдэглэлтэй холбогдон гарсан саналын талаар шүүгч захирамж гаргана.
- 68.5. Шүүх хуралдааны тэмдэглэл алдаатай бичигдсэн тохиолдолд шүүгч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 96.3-т заасны дагуу засвар хийж баталгаажуулна.

ТАЙЛБАР

Шүүх хуралдааны тэмдэглэл нь давж заалдах болон хяналтын шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл, шүүх хуралдааны хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зөрчсөн эсэх, зарим тохиолдолд хэргийн бодит байдлыг тогтооход ч чухал ач холбогдолтой баримт юм.

Шүүх хуралдааны тэмдэглэлд шүүх хуралдааныг хэзээ, хаана хийсэн, эхэлсэн, дууссан цаг, шүүх бүрэлдэхүүн, нарийн бичгийн дарга, хэргийн оролцогч, шүүх хуралдааны оролцогчдын нэр, эцгийн нэр, шүүх хуралдааны ирц, хэргийн оролцогч, шүүх хуралдааны оролцогч нарын эрх үүрэг танилцуулж, тайлбарласан байдал, хэргийн ба шүүх хуралдаанд оролцогчдын тайлбар, тэдгээрийн мэтгэлцээн, нотлох баримтыг шинжилсэн байдал, асуулт, хариулт, шүүхийн шийдвэрийн агуулга, түүнд гомдол гаргах

хугацаа, журам зэргийг хэргийн оролцогчдод тайлбарласан байдал тодорхой тусгагдсан байх шаардлагатай.

Шүүх хуралдааны тэмдэглэлд хэргийн оролцогчийн тайлбарыг тусгахдаа үг бүрчлэн бичих боломжгүй бол агуулгыг алдагдуулахгүйгээр бичиж болно. Харин гэрчийн мэдүүлгийг аль болох үг бүрчлэн бичих шаардлагатай.

Бүх шатны шүүхийн шүүх хуралдааны үйл ажиллагааны явцыг дэс дараалан буулгаж бичсэн шүүх хуралдааны нарийн бичгийн даргаас үйлдсэн хууль зүйн баримтыг шүүх хуралдааны тэмдэглэл гэнэ.

Шүүх хуралдааны тэмдэглэл нь шүүхийн нотолгооны хэрэгслийн нэг төдийгүй шүүх мэтгэлцэх зарчмыг хэрхэн хэрэгжүүлж байгаа болон шүүх хуралдаан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг хангасан эсэхийг баталгаажуулсан баримт юм.

Шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолын үндэслэл ба тогтоох хэсгийн заалтын гол утга санааг бичиж баримтжуулсныг шүүхийн шийдвэрийн агуулга гэнэ.

Түүнчлэн шүүх хуралдааны тэмдэглэлд гэрчүүдэд эрх, үүрэг танилцуулж, гарын үсэг зуруулж авна. Мөн шүүгч болон шүүх бүрэлдэхүүнээс амаар гаргасан шийдвэрийг заавал тусгана.

Шүүх хуралдаан даргалагч хэргийн оролцогч нарт шүүхийн шийдвэрт гомдол гаргах талаар хэрхэн тайлбарласныг тэмдэглэлд заавал тусгана.

Шүүх хуралдааны тэмдэглэлийг шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 3 хоногт багтаан шүүх хуралдаан даргалагч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж бэлэн болгоно.

Шүүх хуралдааны тэмдэглэлийг гараар болон компьютераар бичих бөгөөд хэрэв техник хэрэгсэл ашигласан бол бичгийн хэлбэрт буулгана.

Хэргийн оролцогчид шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцах эрхтэй бөгөөд хэрэв алдаатай бичигдсэн гэж үзвэл шүүх хуралдаан даргалагчид танилцуулж засвар хийхийг шаардана. Энэ тохиолдолд шүүгч тэмдэглэлийг хянаж засварлах шаардлагатай гэж үзвэл 3 хоногийн дотор засвар хийж, энэ тухай тэмдэглэлд тусгаж, даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Анхан шатны шүүх хуралдааны дэг, анхан шатны шүүхийн шийдвэр

69 дүгээр зүйл. Шүүх хуралдааны дэг

69.1. Захиргааны хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдааны дэг нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 98, 99 дүгээр зүйл, 100.2-100.4, 101-113 дугаар зүйлд заасан журмаар зохицуулагдана.

- 69.2. Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй тохиолдолд захиргааны хэргийн шүүх хангалттай нотлох баримт цугларсан гэж үзвэл уг хэргийг хянан шийдвэрлэж болох бөгөөд тэдгээрийг заавал байлцуулах шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдааныг хойшлуулж дахин дуудах ба 2 дахь удаагаа ирээгүй бол нэхэмжлэлийг буцаана.
- 69.3. Нэхэмжлэгч ирээгүй тохиолдолд нийтийн ашиг сонирхлын үүднээс захиргааны хэргийн шүүх хэргийг түүний эзгүйд хянан шийдвэрлэж болно.

ТАЙЛБАР

Эрүү, иргэн, захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэхэд хэргийн оролцогч төдийгүй шүүх хуралдааны танхимд байгаа бүх хүн хуулиар тогтоосон журам, дэгд захирагдах учиртай.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн /цаашид хууль, ЗХХШТХ гэх/ 63 дугаар зүйлд шүүх хуралдааны нийтлэг журам, уг журмыг зөрчсөнөөс үүсэх үр дагаврын асуудлыг зохицуулсан тул энэ талаарх дэлгэрэнгүй тайлбарыг үзнэ үү.

Захиргааны хэргийг хянан хэлэлцэх анхан шатны шүүх хуралдааныг тогтсон журмын дагуу ямар дэг баримталж явуулах талаар хуулийн 69 дүгээр зүйлд тодорхой зохицуулжээ.

1. Захиргааны болон иргэний хэргийн аль аль нь шүүхэд гаргасан нэхэмжлэлийн үндсэн дээр үүсгэгдэж, хянан шийдвэрлэгддэг учраас хууль тогтоогчид Захиргааны хэргийг хянан хэлэлцэх анхан шатны шүүх хуралдааны дэг нь иргэний хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэх дэгтэй зарим талаар адил байхаар тухайлбал Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн /цаашид ИХШХШТХ гэх/ 98, 99, 100.2-100.4, 101-113 дугаар зүйлд заасан журмаар зохицуулагдахаар хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д ишлэл татаж заажээ.

Иймд энэ талаар ИХШХШТХ-ийн холбогдох зүйл, заалтын дэлгэрэнгүй тайлбараас үзэж болно.¹⁰⁰

Гэвч ИХШХШТХ-ийн 10 дугаар бүлгийн “Анхан шатны шүүх хуралдааны дэг”-ийн талаарх бүх зүйл, заалт нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэгдэх ажиллагаанд нэг адил мөрдөгдөнө гэж ойлгох нь учир дутагдалтай.

Зөвхөн ЗХХШТХ-д тусгайлан ИХШХШТХ-иас ишлэл авч заасан дээр дурьдсан зүйлүүд л хэрэглэгдэнэ гэдгийг анхаарах нь зүйтэй байна.

Анхан шатны шүүх хуралдааны дэгийг дарааамаар нь авч үзвэл:

1. шүүх хуралдааныг нээнэ. (ИХШХШТХ-ийн 98 дугаар зүйлийн 98.1.)

¹⁰⁰ Тайлбар: ИХШХШТХ-ийн дэлгэрэнгүй тайлбар , УБ, 2007, 263-289

- 2.ирц танилцуулна. (мөн хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1.)
- 3.зохигч, оролцогч шүүх хуралдаанд ирээгүй бол шүүх хуралдаан хийх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. (мөн хуулийн 100, ЗХХШТХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2, 69.3/
- 4.орчуулагч, хэлмэрчид эрх үүрэг, хүлээлгэх хариуцлагыг сануулж, тэмдэглэлд гарын зуруулна (ЗХХШТХ-ийн 60, ИХШХШТХ-ийн 101 дүгээр зүйл).
- 5.гэрчийг танхимаас гаргана (ИХШХШТХ-ийн 102 дугаар зүйл).
- 6.шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүнийг танилцуулж, татгалзан гаргах эрхтэйг тайлбарлана (мөн хуулийн 103 дугаар зүйл).
- 7.хэргийн оролцогчийн эрх, үүргийг тайлбарлана (мөн хуулийн 104 дүгээр зүйл).
- 8.хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэх (мөн хуулийн 105 дугаар).
- 9.нэхэмжлэлийн шаардлагыг танилцуулна (мөн хуулийн 105 дугаар зүйлийн 105.1.)
- 10.нэхэмжлэгч нэхэмжлэлээ дэмжиж байгаа, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрч байгаа, зохигчид эвлэрэх боломжтой эсэхийг тус тус тодруулна (мөн хуулийн 106 дугаар зүйлийн 106.2.).
- 11.зохигчдын тайлбарыг хянан хэлэлцэнэ.(мөн хуулийн 107 дугаар зүйлийн 107.3.)
- 12.нотлох баримтыг шинжлэн судална (мөн хуулийн 108 дугаар зүйл).
- 13.гэрчийн мэдүүлгийг авна (мөн хуулийн 109 дүгээр зүйл).
- 14.бичмэл болон эд мөрийн баримтыг шинжлэн судална (мөн хуулийн 110 дугаар зүйл).
- 15.шинжээчийн дүгнэлт сонсгоно (мөн хуулийн 111 дүгээр зүйл).
- 16.зохигчдоос нэмж тодруулах зүйл байгаа эсэхийг асууна (мөн хуулийн 112 дугаар зүйл).
- 17.иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлтийг сонсоно. Дүгнэлтийг бичгээр авна (мөн хуулийн 113 дугаар зүйл).
- 18.шүүх хуралдаан завсарласныг мэдэгдэж, шүүгч, шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орно (ЗХХШТХ-ийн 67, ИХШХШТХ-ийн 114 дүгээр зүйл).
- 19.шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг сонсгож, тайлбарлаж шүүх хуралдааныг хаана (ЗХХШТХ-ийн 73 дугаар зүйлийн 73.1).¹⁰¹

Одоо эдгээрийг дэлгэрэнгүй авч үзье.

1.1. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хуралдааны танхимд хэргийн оролцогч болон бусад хүмүүсийг оруулах, шүүх хуралдаан нээхэд танхимд оролцогчид боссон байхыг танилцуулах зэрэг ажлыг зохион байгуулна.

Хуралдаанд оролцогчид байраа эзэлж бэлэн болсны дараа шүүх бүрэлдэхүүн танхимд орж ирэх ба хуралдаан даргалагч шүүгч шүүх хуралдааныг нээснийг мэдэгдэж, дараах асуултуудыг хамруулсан агуулга бүхий танилцуулга хийнэ. Үүнд:

- Нэхэмжлэгчийн нэр
- Хариуцагчийн нэр
- Нэхэмжлэлийн шаардлага

¹⁰¹ Тайлбар: ИХШХШТХ-ийн дэлгэрэнгүй тайлбар , УБ, 2007, 263-289

- Нэхэмжлэлийг шүүх хэзээ хүлээн авсан болох

Шүүх хуралдааныг нээх ажиллагаа нь хэргийг хянан хэлэлцэх ажиллагааны эхлэл учраас шүүгч, шүүх бүрэлдэхүүн, хуралдааны нарийн бичгийн дарга нар бэлтгэл ажлыг сайтар хангахад онцгой анхаарах шаардлагатай.

Нарийн бичгийн дарга нь шүүх хуралдаанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар видео бичлэг, гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэгийг шинжлэн судалбал шаардагдах техник хэрэгслийг бэлэн болгох, эд мөрийн баримтыг танхимд байршуулах, хуралдаанд хэвлэл, мэдээллийн төлөөлөгч оролцох хүсэлт гаргасан бол тэднийг байлцуулах болон бусад шаардлагатай асуудлуудыг хариуцаж бэлэн болгоно.

1.2.Танхимд байгаа бүх хүмүүс сууж байраа эзэлсний дараа шүүгчийн зөвшөөрснөөр нарийн бичгийн дарга шүүх хуралдаанд хүрэлцэн ирсэн оролцогчдыг бүртгэж мэдээлнэ.

Хэргийн оролцогчоос хэн нэг нь шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй тохиолдолд уг этгээдэд мэдэгдэх хуудсыг гардуулж өгсөн эсэх, гардуулж өгсөн бол хэдийд ямар журмаар гардуулсан, энэ талаар ямар баримт байгаа, мэдэгдэх хуудсыг хүлээн авсан этгээд ямар шалтгаанаар ирээгүй болох тухай даргалагчид илтгэж танилцуулна.

Шүүх хуралдааны мэдэгдлийг хэргийн оролцогчдоод хуульд заасан журмын дагуу хүргүүлсэн байх, түүнийг нэхэмжлэгч гардан авсан байх, энэ талаар хэрэгт баримтыг хавсаргасан байвал зохино.

Хуульд хэдийгээр дээрх мэдээллийг шүүх хуралдаан “даргалагчид” гэж зохицуулсан боловч нарийн бичгийн дарга нь ирцийг нийтэд танилцуулна гэж ойлгоно.

Нарийн бичгийн даргаас шүүх хуралдаанд оролцогчдын ирцийн талаар мэдээлсний дараа хуралдаан даргалагчаас шүүх хуралдаанд хүрэлцэн ирсэн оролцогч нэг бүртэй танилцана.

Уг танилцах ажиллагааг тэдний биеийн байцаалтын талаар асууж, хариулт авах журмаар явуулна.

Одоогийн практикт шүүх хуралдаанд оролцож байгаа этгээдийн биеийн байцаалтын талаарх хамгийн үнэн зөв баримт болох иргэний үнэмлэхийг тэр бүр шалгадаггүй.

Шүүх хуралдаанд оролцож байгаа этгээд нь тухайн нэхэмжлэгч, хариуцагч, бусад оролцогч өөрөө мөн эсэхийг шүүх таних ганц баримт нь иргэний үнэмлэх юм.

Иймд шүүх хуралдаанд оролцогчдын иргэний үнэмлэх, /түүнтэй адилтгах баримт бичиг, үнэмлэх байхгүй бол ажлын газрын үнэмлэх, жолооны үнэмлэх гэх мэт/ холбогдох бичиг баримтыг шалгах нь зөв. Энэ талаар хуралдааны тэмдэглэлд тусгагдсан байвал зохино.

Шүүх хуралдаанд төлөөлөгч оролцож байгаа бол төлөөлөгчийн бүрэн эрхийг мөн шалгана.

Ер нь “шалгах” ...магадлан байцааж үзэх, хянах¹⁰² гэсэн үгийн утгаас нь авч үзсэн ч шүүх бүрэлдэхүүн хэргийн болон шүүх хуралдааны оролцогчийн бүрэн эрхийг гэрчилсэн баримт бичгийг заавал үзэх хэрэгтэй.

¹⁰² И.Дамбажав, Д.Алтан –Од, Д.Солонго “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг”, УБ хот, 2006 он, 1031 дүгээр тал

Төлөөлөгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох ганц боломж нь төлөөлүүлэгчээс олгогдсон итгэмжлэл бөгөөд шүүх итгэмжлэл нь хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах шаардлагатай. Мөн түүний хугацааг анхаарвал зохино.

Итгэмжлэлд тавигдах шаардлагын талаар хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн тайлбараас үзнэ үү.

1.3.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий зарчмууд болох диспозитив, мөрдөн шалгах, нотлох үүрэг, өөрийгөө сонсгох зарчим буюу шүүхэд мэдүүлэх эрх, шүүх хуралдааныг амаар явуулах, шүүгчийг татгалзан гаргах ба шүүгч өөрөө татгалзах, шүүх хуралдаан нээлттэй явуулах зэрэг зарчмуудыг хэрэгжүүлэх нэг илрэл нь шүүх хуралдаанд оролцогчдыг бүрэн оролцуулж тэднийг мэтгэлцэх боломжоор хангаж, үүний үр дүнд үнэн зөв, үндэслэл бүхий шийдвэр гаргах явдал юм.

Хэргийн оролцогчдын хэн нэг нь шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй тохиолдолд шүүх хуралдааныг тэдний оролцоогүйгээр үргэлжлүүлэн явуулах эсэхийг шүүх бүрэлдэхүүн зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай болно.

Энэ асуудлыг хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

Шүүх хуралдааны нарийн бичгийн даргаас ирц мэдээлсний дараа хуралдаан даргалагч шүүх хуралдаанд оролцох мэдэгдэл авсан хэн нэг нь ирээгүйгээс хуралдааныг үргэлжлүүлэх эсэх талаар бусад ирсэн оролцогчийн саналыг сонсох нь зөв юм. Уг асуудлыг ямар журмаар хэлэлцэх талаар дор дэлгэрүүлэн тайлбарлана.

Нэхэмжлэгч, хариуцагч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч шүүх хуралдаанд ирээгүйгээс үүсэн гарах үр дагаврын талаар хуульд ИХШХШТХуулийн 100 дугаар зүйлийн 100.2-100.4-т зааснаар зохицуулахаар ишлэл авсан байх боловч, нэхэмжлэгч шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүйгээс гарах холбогдлын талаар ЗХХШТХуулийн 69 дүгээр зүйлийн 69.2, 69.3-т тусгайлан зохицуулсан байна. Иймд эдгээр зүйлүүдийг хамтад нь авч үзэх нь зүйтэй гэж үзэв.

Хуульд тусгайлан заасны дагуу нэхэмжлэгч, хариуцагч, тэдний өмгөөлөгч, төлөөлөгч ирээгүйгээс үүсэх үр дагаврын талаар үзүүлбэл.

Хэргийн оролцогч	Хуулийн зүйл, заалт	Үүсэх үр дагавар
Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч	1.ЗХХШТХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2, 69.3 2.ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.2, 100.4	1.хэргийг тэдний оролцоогүйгээр хянан шийдвэрлэнэ. <ul style="list-style-type: none"> • шүүх хуралдааныг хойшлуулна. • нэхэмжлэлийг буцаана. 2. мөн хэргийг тэдний оролцоогүйгээр хянан шийдвэрлэнэ. -нэхэмжлэлийг буцаана.
Хариуцагч түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч	Зөвхөн ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.3, 100.4-т зааснаар зохицуулжээ.	Хэргийг тэдний оролцоогүйгээр шийдвэрлэнэ.

1.3.1 Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч шүүх хуралдаанд ирээгүйгээс гарах холбогдлын талаар ЗХХШТХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.1-д ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.2, 100.4-т зааснаар зохицуулахаар заасан атлаа ЗХХШТХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.2, 69.3-т энэ талаар тусгайлан заасан нь ямар учиртай болох, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тохиолдолд аль хуулийг нь хэрэглэх, эдгээрийн ялгаа юу вэ гэсэн асуулт зүй ёсоор гарч байна.

Агуулгынх нь хувьд үзвэл аль аль зохицуулалт нь гарах холбогдлын талаар ижил байна.

Харин ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.2-т нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч хүрэлцэн ирээгүй нь “хүндэтгэн үзэх шалтгаангүй байх” талаар тодорхой заасан бол ЗХХШТХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.2-т хүрэлцэн ирээгүй шалтгааны талаар тодорхой зохицуулалт байхгүй.

Мөн ЗХХШТХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.2-т зааснаар шүүх тэдгээрийг заавал байлцуулах шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдааныг хойшлуулах тухай заасан бол ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.2,100.4-т ийм боломж алга байна.

ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.2-т тухайн тохиолдолд шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцэх эсэх талаар хариуцагчийн гаргасан хүсэлтээр шийдвэрлэдэг бол хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2-т зааснаар ийм хүсэлт шаардлагагүй.

ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.4-т дээрх хүсэлт гаргаагүй байлаа ч шүүх хэргийг шийдвэрлэж болохоор зохицуулсан нь хуулийн 69 дүгээр 69.2, 69.3-тай адил зохицуулалттай байна.

Гэвч нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй тохиолдолд шүүх хуралдаан хийх эсэхийг ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.2, 100.4-т зааснаар, харин шалтгаан нь тодорхой бус бол ЗХХШТХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.2, 69.3-т зааснаар тус тус зохицуулна гэж ойлгож хэрэгжүүлж үл болно.

Учир нь нэхэмжлэгч, түүний төлөөлөгч өмгөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй нь хүндэтгэн үзэх шалтгаантай бөгөөд өөрөө хуралдаанд оролцох хүсэлтэй болж болно.

Түүнчлэн хүндэтгэн үзэх шалтгаантай гэдэг нь шүүх хуралдааныг заавал хойшлуул гэсэн үг биш гэдгийг мөн анхаарвал зохино.

Үүнийг ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.4, ЗХХШТХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.2,69.3-т зааснаас харж болно.

Ер нь шүүх хуралдаанд нэхэмжлэгч түүний төлөөлөгч, өмгөөлөгч хүрэлцэн ирээгүйгээс шүүх хуралдааныг хойшлуулах, эсхүл хийх тухай асуудал нь шүүх өөрийн эрх мэдлийн хэмжээнд шийдвэрлэх асуудал болох нь дээр дурьдсан хуулиудаас тодорхой байна.

Шүүх хуралдааныг нэхэмжлэгч, түүний өмгөөлөгч, төлөөлөгчийн оролцоогүйгээр хийхэд дараах нөхцөл байдлыг харгалзан үзвэл зохино. Үүнд:

- Хуралдаанд хүрэлцэн ирээгүй шалтгааныг тогтоох, энэ нь хүндэтгэн үзэх шалтгаан бус байх
- Мөн хэргийн талаар хангалттай нотлох баримт бүрдсэн байх явдал.

“Хүндэтгэн үзэх шалтгаан” гэдэг нь хуулийн ойлголт бөгөөд үүнд ямар ямар тохиолдлуудыг ойлгож болохыг хуульд тухайлан нэрлэн заах боломжгүй, зөвхөн шүүх нөхцөл байдлыг харгалзан өөрөө тогтоох ёстой юм.

Энэ талаар ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн дэлгэрэнгүй тайлбарт дурьдсанаар шүүх хуралдааны товыг нэхэмжлэгчид мэдэгдсэн байхад тэрээр үл ялиг шалтгаанаар, эсхүл шалтгаанаа шүүхэд мэдэгдэхгүйгээр шүүх хуралдаанд ирэхгүй байх, үл ялих гэдэгт жишээлбэл, тухайн өдөр цас, бороотой тул ирж чадахгүй гэж мэдэгдсэн, эсхүл энэ өдөр түүний хувьд зурхайн гарлагаар муу өдөр гэж үзсэн г.м. байж болно.¹⁰³ гэж тайлбарлажээ.

Эндээс үзэхэд үл ялих шалтгаан болгон хүндэтгэн үзэх шалтгаан болохгүй гэдгийг анхаарвал зохино.

Нэхэмжлэгч түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй тохиолдолд:

- хариуцагчийн хүсэлтээр шүүх хэргийн нотлох баримт болон бусад нөхцөл байдлыг харгалзан түүний эзгүйд хэргийг хянан шийдвэрлэх
- эсхүл нэхэмжлэлийг буцаах гэсэн үр дагавар үүснэ.

Үүнээс шүүх аль нэгийг сонгон шийдвэрлэнэ.

ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.4, ЗХХШТХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.2-т зааснаар нэхэмжлэгч түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нь шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй тохиолдолд “хэргийн нөхцөл байдлыг харгалзан, нотлох баримт хангалттай бүрдсэн гэж үзвэл хэргийг тэдний оролцоогүйгээр хянан шийдвэрлэх эрхийг шүүхэд олгосон ижил агуулга бүхий заалт байна.

Мөн дээр дурьдсан тайлбарт “Нэхэмжлэлийг буцаах талаар хариуцагчийн хүсэлт шаардлагатай эсэхэд шүүх анхаарвал зохино. Нэхэмжлэлийг буцааснаар нэхэмжлэгч дахин нэхэмжлэл гаргах эрхтэй үлдэж байгаа тул хариуцагч үүнийг хүсэхгүй байх магадлал ихтэй. Өөрөөр хэлбэл тэрээр нэхэмжлэгчийн оролцоогүйгээр өөрт ашигтай шийдвэр гаргуулж, энэ асуудлыг шүүхээр дахин хэлэлцүүлэхгүй байх зорилготой байна. Иймд хариуцагчийн хүсэлтгүйгээр нэхэмжлэлийг буцаасан шүүхийн захирамж, тогтоолыг буруутгах үндэсгүй болно” гэжээ.¹⁰⁴

“Иргэн хуулийн этгээдээс захиргааны актыг хууль бус гэж үзэж шүүхэд гаргасан нэхэмжлэлээр хэргийг шийдвэрлэж тэдний Үндсэн хуулиар олгогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” Захиргааны хэргийн шүүхийн үндсэн зорилттой нь холбож үзвэл шүүх хуралдаанд нэхэмжлэгч тал ирээгүй үндэслэлээр шууд нэхэмжлэлийг буцаахыг гол болгох нь зохимжтой бус.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа этгээдүүд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэгш эрхтэйгээр оролцох боловч тэдний эрх зүйн байдал нь тэгш бус өөрөөр хэлбэл нэг талаас иргэн хуулийн этгээд нөгөө талаас тэдний эрхийг нь хохироосон гэх захиргааны байгууллага, албан тушаалтан оролцож байгаа онцлогтой нь холбоотойгоор шүүх хуралдаанд нэхэмжлэгч хүрэлцэн ирээгүй тохиолдолд

¹⁰³ ИХШХШТХ-ийн дэлгэрэнгүй тайлбар, УБ 2007, 100 дугаар зүйл

¹⁰⁴ ИХШХШТХ-ийн дэлгэрэнгүй тайлбар 100 дугаар зүйл

хэдийгээр хариуцагч хүсэлт гаргасан ч аль болох нэхэмжлэгчийг оролцуулах боломжийг хангаж байх нь зүйтэй.

ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.2, ЗХХШТХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.2-т зааснаар нэхэмжлэлийг буцаах гол үндэслэл ялгаа нь юунд байна гэдэг асуулт зүй ёсоор гарч байна.

ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.2 дахь хэсэгт зааснаар нэхэмжлэгч шүүх хуралдаанд ирээгүйгээс нэхэмжлэлийг буцаах талаар зохицуулсан бол захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч нь ирээгүй үед түүнийг заавал байлцуулах шаардлагатай гэж шүүх үзвэл нэг удаа шүүх хуралдааныг хойшлуулах, 2 дахь удаагаа ирээгүй бол буцаахаар байна.

Дээр дурдсан бүгдийг нэгтгэн дүгнэвэл нэхэмжлэгч түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нь шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй тохиолдолд гарах холбогдлын асуудлыг илүү нарийвчилсан зохицуулалт бүхий ЗХХШТХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.2-т зааснаар шийдвэрлэж байх нь зөв юм.

Түүнчлэн хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсэгт анхаарлаа хандуулбал зохино.

Захиргааны хэргийн шүүх эрх нь зөрчигдсөн иргэн, хуулийн этгээдийн нэхэмжлэлээр хэрэг үүсгэж, шүүхээс гаргасан шийдвэр нь зөвхөн тухайн нэхэмжлэгч этгээдийн биш нийтийн эрх ашигт нийцдэг үр дагаварт хүргэдэг учраас нэхэмжлэгч шүүх хуралдаанд ирээгүй явдал нь зөвхөн шүүх хуралдааныг хойшлуулах, нэхэмжлэлийг буцаах үндэслэл болохгүй, нийтийн эрх ашгийн үүднээс хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэх үр дагаварт хүргэж болно.

Гэхдээ хэргийн талаар нотлох баримт хангалттай бүрдсэн байх нь чухал гэдгийг анхаарвал зохино.

Шүүхэд урьдаас хөдөлбөргүй тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй. /ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.3/

Иймд шүүх хуралдааныг нэхэмжлэгчийн оролцоогүйгээр нийтийн эрх ашгийн үүднээс хийнэ гэдэг нь нэхэмжлэгч талд ашигтай шийдвэр гаргана гэсэн үг биш бөгөөд шүүхийн шийдвэр нь нэхэмжлэгч талд ашигтай, ашиггүй гарах талаар шүүх урьдчилан шийдвэрлэх боломжгүй бөгөөд хамгийн гол нь нэхэмжлэгч шүүх хуралдаанд ирээгүй байсан ч шүүх хуралдааныг нийтийн эрх ашгийн үүднээс хийх, шүүхийн шийдвэр нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх нь гол гэдгийг шүүх анхаарвал зохино.

Нийтийн ашиг сонирхлоос, ямар нэгэн нийтийн сайн сайхнаас урган гарсан шаардлага эсвэл нийтийн сайн сайхан байдалтай холбоотой зүйлүүд онцгой анхаарах тохиолдлууд байдаг. Нийтийн ашиг сонирхол нь бүгдэд хүртээмжтэй байх боломжтой. Тухайлбал Төрийн байгаль орчныг хамгаалах ашиг сонирхол нь нийт иргэдийн ашиг сонирхолд шууд нийцэж байна. Мөн хувь этгээдийн ашиг сонирхол нь өөрөө нийтийн эрх ашиг сонирхолтой агуулгын хувьд давхцаж болно.¹⁰⁵

Нэхэмжлэгчийн эзгүйд хариуцагчийн хүсэлтээр хэргийн нөхцөл байдлыг харгалзан шүүх хуралдааныг явуулах нь зүйтэй гэж үзсэн бол энэ талаар шүүх

¹⁰⁵ П.Одгэрэл "Захиргааны эрх зүйн ерөнхий анги УБ, 2004 , 19

хуралдааны тэмдэглэлд тусгаж, шүүх хуралдааныг ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар явуулна.

Нэхэмжлэгч шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүйгээс нэхэмжлэлийг буцаахдаа дараах зүйлүүдийг анхаарвал зохино. Үүнд:

- шүүх хуралдааны товыг түүнд мэдэгдсэн баримттай байх;
- шүүх хуралдаанд хүрэлцэн ирэхгүй байх талаар нэхэмжлэгч шүүхэд ямар нэг хүсэлтийг гаргаагүй;
- шүүхэд ирээгүй шалтгаан нь хүндэтгэн үзэх шалтгаан гэж шүүх үзэхээргүй байх зэрэг нөхцөл болно.

Нэхэмжлэлийг буцаахдаа шүүх бүрэлдэхүүнээс тогтоол, шүүгч дангаар хэргийг хянан шийдвэрлэж байгаа бол захирамж гаргах журмаар шийдвэрлэнэ.

Нэхэмжлэлийг буцаасан тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг хэрхэн зохицуулах вэ? гэдэг асуулт зүй ёсоор гарна.

Үүнд хуулийн 80, ИХШХШТХ-ийн 59 дүгээр зүйлийн 59.5-д зааснаар зохицуулна гэж ойлгоно.

Тухайлбал улсын тэмдэгтийн хураамжийг улсын орлого болгохоор тогтоол, захирамждаа дурьдана. Холбогдох хуулийн тайлбарыг үзнэ үү.

Үүнээс гадна нэхэмжлэлтэй хамт хавсаргаж ирүүлсэн нотлох баримтыг буцаах бөгөөд хэрэг үүсгэснээс хойш мөрдөн шалгах зарчмын дагуу шүүхээс болон хэргийн бусад оролцогчоос бүрдүүлсэн нотлох баримтыг нэхэмжлэгчид буцаах шаардлагагүй. Гэхдээ эдгээр баримтыг устгахгүйгээр архивт хадгална. Нэхэмжлэлийг буцаасан шүүгчийн захирамж буюу шүүхийн тогтоолд дурьдсан хаягт хэргийн оролцогч байхгүй бол материалыг холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн шүүхэд хадгална.

Нэхэмжлэлийг буцааснаар тухайн хугацаанд хэрэг үүсгэсэн захирамжийн үйлчлэл дуусгавар болно гэсэн үг.

Нэхэмжлэлийг буцааснаар нэхэмжлэгч шүүхэд дахин хандах эрхийг нь хязгаарлахгүй, тухайн маргаантай асуудлаар нэхэмжлэгч шүүхэд дахин хандах эрх нь нээлттэй.

Дахин нэхэмжлэл гаргасан тохиолдолд шүүх нэхэмжлэлийг ердийн журмаар хүлээн авч, хуульд зааснаар бүртгэж, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл үгүй бол захиргааны хэрэг шинээр үүсгэж, өмнө нь хадгалагдсан нотлох баримт шүүхэд байгаа бөгөөд тухайн баримт ач холбогдлоо алдаагүй бол түүнийг нь хавсаргаж хэргийг хянан шийдвэрлэнэ.

Улсын тэмдэгтийн хураамжийг шинээр дахин төлсөн байх учиртайг анхаарвал зохино.

1.3.2.Хариуцагч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүйгээс үүсэх үр дагаврын талаар ЗХХШТХ-д өөрөөр тусгайлан зохицуулаагүй бөгөөд ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.3, 100.4-т зааснаар зохицуулахаар ишлэл авчээ.

Дээрх тохиолдолд шүүх нэхэмжлэгчээс түүний саналыг сонсох бөгөөд нэхэмжлэгч нь хариуцагчийг эзгүйд хэргийг хянан шийдвэрлүүлэх талаар хүсэлт гаргаж болно.

Хэрэв ийм хүсэлт гаргавал шүүх нэхэмжлэгчээс гаргасан тайлбар болон бусад нотлох баримтыг үнэлэн хэргийг хянан шийдвэрлэнэ.

Гол нь өмнө нь хариуцагчаас бичгээр тайлбар авсан байх шаардлагатайгаас гадна хариуцагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй байх нөхцөл заавал бүрдсэн байна.

Хэргийг хариуцагчийн оролцоогүйгээр шийдвэрлэнэ гэдэг нь нэхэмжлэлийг шууд хангах үндэслэл болохгүй.

Шүүх нэхэмжлэгчээс гаргасан тайлбар болон бусад баримт нотолгоог үндэслэн хэргийг шийдвэрлэх тул шүүх хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий шийдвэр гаргах үүргээ гол зарчим болгоно.

Хариуцагчийг эзгүйд шүүх хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэх хүсэлтээс гадна хариуцагчийг албадан ирүүлэх, шүүх хуралдааныг хойшлуулах хүсэлтийг нэхэмжлэгч гаргаж болох юм.

Хүсэлт болгоны талаар шүүх зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэж, шийдвэрээ хэргийн оролцогчдод танилцуулна гэж ойлговол зохино.

Дээрх асуудлаар шүүхээс гарах шийдвэр ямар хэлбэртэй байх нь шүүхийн анхаарах асуудлын нэг юм.

Одоогийн шүүх таслах практикаас үзэхэд шүүх хуралдааны тэмдэглэлд тусгах замаар ам шийдвэр гаргах явдал олонтаа тохиолдож байна.

ЗХХШТХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.2, 79.3-т зааснаас үзвэл дээрх асуудлаар ам шийдвэр гаргаж байгаа нь буруу болно. Холбогдох зүйлийн тайлбараас тодорхой үзнэ үү.

1.3.3.Хуульд хэдийгээр тусгайлан зохицуулаагүй боловч шүүх хуралдаанд оролцох мэдэгдэл авсан хэргийн оролцогч болох гуравдагч этгээд, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, хэргийн бусад оролцогч болох гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, прокурор шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүйгээс үүдэн гарах үр дагаврын талаар авч үзэх нь зүйтэй.

Нэхэмжлэгч, хариуцагч, тэдний төлөөлөгч буюу өмгөөлөгчийн ирцийн хамт шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь шүүх хуралдааны мэдэгдлийг хүлээн авсан дээрх оролцогчдын ирцийг мөн мэдээлнэ.

1. Гуравдагч этгээд, түүний өмгөөлөгч буюу төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй. Шүүх хуралдааны мэдэгдлийг хүргүүлсэн талаар хуралдааны тэмдэглэлд тусгавал зохино. Мөн баримт нь байх ёстой.

Харин гуравдагч этгээд нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх хуралдаанд хүрэлцэн ирж чадахгүй болж, өөрөө оролцох хүсэлтээ шүүхэд гаргасан нөхцөлд шүүх түүнийг байлцуулах зайлшгүй шаардлагатай гэж үзвэл хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2-т зааснаар хуралдааныг хойшлуулж болно. Холбогдох зүйлийн тайлбарыг үзнэ үү.

2. Гэрч, шинжээч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд мэдэгдэл хүргүүлсэн тухай тэмдэглэлд тусган, баримтыг хэрэгт хавсаргаж, шүүх хуралдааныг тэдний оролцоогүйгээр явуулна.

Шүүх хуралдаанд гэрч, шинжээчийг заавал оролцуулж, мэдүүлгийг нь авах шаардлагатай гэж шүүх үзвэл хуралдааныг хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2-т зааснаар хойшлуулна.

Гэрч шүүхийн дуудсанаар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг албадан ирүүлэхийг цагдаагийн байгууллагад даалгаж болно. /ЗХХШТХ-ийн 58 дүгээр зүйлийн 58.6/ Холбогдох зүйлийн тайлбарыг үзнэ үү.

Энэ талаар шүүгч захирамж, шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргана.

Шинжээч дүгнэлт өгөхөөс татгалзвал түүнд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ./ЗХХШТХ-ийн 59.5/ Холбогдох зүйлийн тайлбарыг үзнэ үү.

3. Орчуулагч, хэлмэрч шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй нь хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

Гэхдээ монгол хэл мэддэггүй, хэлгүй, дүлий хэргийн оролцогчдын шүүх хуралдаанд мэтгэлцэх, өөрийгөө сонсгох зарчмыг хэрэгжүүлэх үүднээс шүүх аль болох орчуулагч хэлмэрчийг шүүх хуралдаанд оролцуулах шаардлагатай.

Шүүх хуралдаанд оролцож байгаа хэргийн оролцогч нь өөрөө хүсвэл орчуулагч, хэлмэрчийг байлцуулахгүйгээр шүүх хуралдааныг явуулах боломжтой.

Гэхдээ шүүх орчуулагч хэлмэрчийг оролцуулахгүйгээр шүүх хуралдааныг явуулахад хэргийн оролцогч нь шүүх хуралдааны ажиллагааг бүрэн хэмжээгээр ойлгох чадвар байгаа эсэхийг лавлаж тогтооход анхаарвал зохино.

Орчуулагч, хэлмэрчийг заавал оролцуулах шаардлагатай, тэдний оролцоогүйгээр шүүх хуралдааныг явуулах боломжгүй бол мөн л шүүх хуралдааныг дээр дурьдсан хуулийн дагуу хойшлуулна.

Орчуулагч, хэлмэрч нь орчуулга хийхээс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзвал тэдэнд хариуцлага хүлээлгэнэ /ЗХХШТХ-ийн 60 дугаар зүйлийн 60.5-ын тайлбарыг үзнэ үү/.

4. Иргэдийн төлөөлөгч Томилогдсон иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд заавал оролцох үүрэгтэй бөгөөд, шүүх хуралдаанд ирээгүй тохиолдолд хуралдааныг хойшлуулна. /ЗХХШТХуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-ын тайлбарыг үзнэ үү/ .

5. Прокурор шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй бол шүүх хэргийг түүний эзгүйд хянан шийдвэрлэнэ.

Харин хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ирээгүй бол шүүх хуралдааныг хойшлуулна.

Хэргийн оролцогчид, бусад оролцогчдыг бүртгэж, тэдний биеийн байцаалтыг шалгасны дараа шүүх хуралдааны дэгийг дээр дурьдсан дарааллын дагуу явуулах бөгөөд шүүх хуралдааны дэгийн талаар хуулийн 69 дүгээр зүйлд ИХШХШТХ-ийн 101-113 дугаар зүйлүүдэд заасан журмаар зохицуулагдахаар заажээ.

1.3.4 Хэргийн болон бусад оролцогч шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүйгээс гарах холбогдлын асуудлаар шүүх тухай бүр нь шүүх хуралдааныг завсарлуулж,

зөвлөлдөх тасалгаанд хүсэлтийг хэлэлцэж, шүүх бүрэлдэхүүнээс шүүхийн тогтоол, шүүгч хэргийг дангаар шийдвэрлэж байгаа бол шүүгчийн захирамж гаргаж шийдвэрлэнэ.

Шүүхээс гаргаж байгаа дээрх захирамж, тогтоолд гомдол гаргах эрхтэй эсэх уг гомдлыг ямар журмаар шийдвэрлэх асуудлаар эргэлзээ төрж болно.

Учир нь захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгддэг ИХШШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.2-100.4-т зааснаар гарсан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол ИХШШТХ-ийн 170 дугаар зүйлд заасан журмаар гомдол гаргахаар зохицуулсан бөгөөд харин уг 170 дугаар зүйлийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэхээр ишлэл авсан зүйл, заалт хуульд байхгүй байгааг анхаарвал зохино.

ЗХХШТХ-ийн 79, 90 дүгээр зүйлүүдэд зааснаас үзвэл захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргасан гомдлыг давж заалдах шатны шүүх хянан хэлэлцэхээр байхад ИХШШТХ-ийн 170 дугаар зүйлд энэ асуудлыг өөрөөр зохицуулсан байна.

Иймд илүү нарийвчилсан зохицуулалттай хуулийг хэрэглэж захирамж, тогтоолд гаргасан гомдлыг ЗХХШТХ-ийн 90 дүгээр зүйлд заасан журмаар шийдвэрлэж байх нь зөв юм.

1.3.5.Одоогийн практикт нэхэмжлэгч, хариуцагч нь өөрөө шүүх хуралдаанд хүрэлцэн ирсэн боловч, өмгөөлөгч нь ямар нэгэн шалтгаанаар ирээгүйгээс, мөн эсрэгээр өмгөөлөгч нь ирсэн байхад нэхэмжлэгч, хариуцагч ирээгүйгээс шүүх хуралдааныг хойшлуулах тухай хүсэлт гаргах нь олонтаа тохиолдож байна.

Дээрх тохиолдолд шүүх хуралдааныг хийх эсэх тухай асуудлыг шүүх хуульд нийцүүлэн шийдвэрлэх учиртай.

Харин хэргийн оролцогч итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж, итгэмжлэл олгосон атлаа заавал өөрийн биеэр оролцох тухай хүсэлт гаргах, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч нь төлөөлүүлж байгаа этгээдийг заавал оролцуулах хүсэлт гаргадаг тохиолдол мөн практикт их гарч байна.

Энэ тохиолдолд төлөөлөгч, төлөөлүүлэгч заавал хоёул байх шаардлагагүй, харин итгэмжлэгдсэн төлөөлөгч нь өөрөө оролцоход л хангалттай.

Энэ талаарх дэлгэрэнгүйг хуулийн 26, 27 дугаар зүйлүүдийн тайлбараас үзнэ үү.

1.4.Хэргийн оролцогчдыг бүртгэж дууссаны дараа шүүх хуралдаанд орчуулагч, хэлмэрч оролцож байгаа бол тэдэнд эрх, үүргийг нь тайлбарлаж өгнө.

Монгол хэл мэдэхгүй хэргийн оролцогч шүүх хуралдаанд оролцож байгаа тохиолдолд орчуулагч, хэлмэрчийн эрх үүргийг хамгийн эхэнд танилцуулж байгаагийн учир нь тэдгээр оролцогчийн шүүхэд мэтгэлцэх боломжийг хангаж байгаагийн илрэл юм.

Эдгээр оролцогчид нь шүүх хуралдааны болон бусад ажиллагаа, шүүхийн шийдвэрийн агуулгыг үнэн зөв, бүрэн орчуулж, хэлмэрчилж өгөх үүрэгтэй болон, санаатайгаар буруу орчуулсан, хэлмэрчилсэн, эсхүл орчуулга хийхээс татгалзвал

Эрүүгийн хуульд¹⁰⁶ заасан хариуцлага хүлээлгэхийг сануулж, хуралдааны тэмдэглэлд энэ талаар тусгаж, эрх үүргээ ойлгосон талаар гарын үсгийг нь тэмдэглэлд зуруулна.

Ингэхдээ Эрүүгийн хуульд зааснаар ямар хариуцлага хүлээлгэхийг маш тодорхой тайлбарлаж өгвөл зохино.

1.5. Шүүх хуралдаанд гэрч оролцож байгаа бол шүүх хуралдаан даргалагч гэрчийг шүүх хуралдааны танхимаас тусгаарлана. Олон гэрч оролцож байгаа тохиолдолд тэднийг хооронд нь харьцуулахгүй байх талаар шүүх хуралдаан даргалагч арга хэмжээ авна.

Гэрчүүдийг хооронд нь харилцуулахгүй байх арга хэмжээг авахад шүүхэд хүндрэл учирна. Гэхдээ энэ хуулийн шаардлагыг хангах нь шүүхийн үүрэг юм.

Шүүх хуралдааны бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий шүүхийн нарийн бичгийн дарга, тухайн шүүхийг харьяалсан тамгын хэлтэст энэ үүргийг хариуцуулж болох юм.

Энэ талаар Шүүхийн тухай хуулийн¹⁰⁷ 69 дүгээр зүйлийн 69.5-д “Шүүхийн тамгын газар, хэлтэс, алба нь дараах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ” мөн зүйлийн 69.5.1-д “шүүх хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангах үүрэгтэй” гэж заасан байна.

Мэдүүлгийг авахаас өмнө гэрчид хуульд Эрүүгийн хуульд заасан үүрэг, хүлээх хариуцлагыг сануулж, тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

1.6. Шүүх хуралдаан даргалагч нь шүүх бүрэлдэхүүнийг нэр, албан тушаалаар нь хуралдаанд оролцож байгаа шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, прокурор, шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх нарийн бичгийн даргыг нэрээр нь тус тус танилцуулж, хуульд заасан үндэслэлээр тэдгээрийг татгалзан гаргах эрхтэйг хэргийн зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нарт тайлбарлан өгнө.

ЗХХШТХ-ийн 69 дүгээр зүйлд шүүх бүрэлдэхүүнийг зарлах ба татгалзан гаргах эрхийн талаар тайлбарлах тухай ИХШХШТХ-ийн 103 дугаар зүйлийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөн хэрэглэхээр ишлэл заасан байгаа боловч шүүгч өөрөө татгалзан гарах үндэслэл, татгалзан гарах хүсэлт, татгалзан гарах, шүүгчийг татгалзан гаргасны үр дагаврын талаар ЗХХШТХ-ийн 64, 65, 66 дугаар зүйлд тодорхой тусгайлан зохицуулсан байх тул тухайн асуудлыг шийдвэрлэхдээ ЗХХШТХ-ийн дээрх зүйл, хэсгийг баримталж байвал зохино.

/Жич: Хуулийн 64, 65, 66 дугаар зүйлийн дэлгэрэнгүй тайлбарыг үзнэ үү/

Шүүх хуралдаанд оролцогчдоос татгалзан гаргах тухай хүсэлтийг шүүх хуралдаанаар хэрэг хянан хэлэлцэхээс өмнө эсхүл татгалзан гаргах үндэслэл шүүх хуралдааны явцад тогтоогдвол тухайн үед нь гаргана.

Татгалзан гаргах хүсэлт гаргавал хэргийн оролцогчдын санал, татгалзан гаргагдаж байгаа этгээд өөрөө хүсвэл түүний тайлбарыг сонссоны дараа уг хүсэлтийг хангах эсэх асуудлаар шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэж шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж гаргана.

Татгалзан гаргагдаж байгаа шүүгч татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэхэд оролцож болохгүй.

¹⁰⁶ Монгол Улсын Эрүүгийн хууль 254 дүгээр зүйлийг үз. ТМ, 2002, №5

¹⁰⁷ Шүүхийн тухай хууль, ТМ, 2002, №29

Хуульд заасан үндэслэл байхад татгалзан гараагүй, татгалзан гаргах хүсэлт гарсан боловч хууль бусаар хүлээж аваагүй бол хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг шийдвэрлэсэнтэй адилтгаж үзнэ¹⁰⁸.

Татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэсэн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид түүнийг гаргасан өдрөөс хойш 10 хоногийн дотор Улсын Дээд шүүхэд гомдол гаргах эрхтэй. Давж заалдах шатны журмаар гомдлыг хянан хэлэлцэх хүртэл хойшлогдоно гэсэн үг. Харин зарим шүүгчид ЗХХШТХ-ийн 48 дугаар зүйлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж байгаа нь буруу юм.

Шүүгч, шүүх бүрэлдэхүүн, иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах хүсэлтийг хэрхэн хэлэлцэх талаар тухайн зүйлийн дэлгэрэнгүй тайлбарт тодорхой тусгагдсан тул уг тайлбарыг үзнэ үү.

1.7.Хуралдаан даргалагч шүүх хуралдааны оролцогч нэг бүрт хуульд заасан эрх үүргийг нь тодорхой тайлбарлан өгөх бөгөөд энэ талаар шүүх хуралдааны тэмдэглэлд тусгагдсан байвал зохино.

Нэхэмжлэгчийн эрх үүрэг /хуулийн 19/, хариуцагчийн эрх үүрэг /хуулийн 20/, төлөөлөгчийн эрх /хуулийн 27/, прокурорын эрх үүрэг /хуулийн 55/, иргэдийн төлөөлөгчийн эрх үүрэг /хуулийн 56/, гэрчийн эрх үүрэг /58/, шинжээчийн эрх, үүрэг /59/ дүгээр зүйлүүдэд заасан байгаа тул энэ талаарх холбогдох зүйлийн тайлбарыг үзнэ үү.

1.8.Шүүх хэргийг хэлэлцэж эхлэхээс өмнө тухайн хэргийг хянан хэлэлцэхтэй холбогдуулан хэргийн оролцогчдоод нотлох баримт бүрдүүлэх болон тухайн хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон бусад асуудлаар ямар нэг хүсэлт байгаа эсэхийг заавал тодруулж асууна.

Жишээлбэл: Нотлох баримттай холбоотой бус өөр ямар нэг хүсэлт гэдэгт шүүх хуралдааныг хаалттай явуулах гэх мэт .

Хэрэв хүсэлт гарвал түүнийг даруй шийдвэрлэнэ. “Даруй” гэдгийг хүсэлт гаргасан тухай бүрд нь гэж ойлговол зохино.

Шүүгч, шүүх бүрэлдэхүүн хүсэлтийг шийдвэрлэж, үүнийг хангах эсэх тал талаар шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж гаргах талаар өмнө дурьдсан.

Уг шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид хуулийн 90 дүгээр зүйлд зааснаар гомдол гаргах эрхтэй.

ИХШХШТХ-ийн 105 дугаар зүйлийн 105.2-т зааснаар нотлох баримтыг шүүх хуралдааны үед гаргаж өгсөн нь хүндэтгэн үзэх шалтгаангүй бол түүнийг хүлээн авах боломжгүй байхаар зохицуулсан бол захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэх явцад хэргийн оролцогчоос гаргаж өгсөн хуульд заасан шаардлага хангасан нотлох баримтыг шүүх хүлээн авна.

Учир нь ЗХХШТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.1-д зааснаар нотлох баримтыг гаргахад хуульд өөрөөр заагаагүй бол ИХШХШТХ-ийн 37,40-45,47-49,51 дүгээр зүйлийг баримтлахаар ишлэл авч зохицуулсан байна.

Холбогдох зүйлийн тайлбарыг үзнэ үү.

¹⁰⁸ Улсын Дээд шүүхийн 2002 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл заалтын тайлбарлах тухай 263 дугаар тогтоолын 28

Гэхдээ ЗХХШТХ-ийн 69 дүгээр зүйлд зааснаас үзвэл ИХШХШТХ-ийн 105 дугаар зүйлийг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлахаар зохицуулсан байгааг мөн анхаарах ёстой.

ЗХХШТХ-ийн 74 дүгээр зүйлийн 74.2-т нэмэлт нотлох баримт шаардлагатай бол шүүх хуралдааныг хойшлуулах, мөн хуулийн 85 дугаар зүйлийн 85.6-д давж заалдах журмаар хэрэг хянан хэлэлцсэн захиргааны хэргийн шүүх шинээр цуглуулсан хуулийн шаардлага хангасан, эргэлзээгүй нотлох баримтыг үнэлж, дүгнэх, үндэслэл болгох эрхтэй гэж тус тус зааснаас үзвэл захиргааны хэрэг хянан шийдвэрлэх явцад талууд нотлох баримтыг хэдийд ч гаргаж өгөх эрхтэй гэж ойлгогдоно.

Энэ нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөрдөн шалгах зарчимтай холбоотой, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас ялгаатай зохицуулалт юм.

Харин хяналтын шатны шүүх хуралдаанд нотлох баримт шинээр гаргаж өгөх боломжгүй бөгөөд энэ талаар хуулийн холбогдох тайлбараас үзнэ үү.

Шүүх хуралдааны үед шинээр гаргасан нотлох баримт нь хуулийн шаардлага хангасан, эргэлзээгүй тохиолдолд шүүх түүнийг хүлээн авч, эсрэг талд нь танилцуулж шийдвэр гаргахдаа үнэлж дүгнэнэ.

Харин хуулийн шаардлага хангаагүй, эргэлзээтэй нотлох баримт байвал шүүх түүнийг шалгахад шаардлагатай гэж үзвэл хуульд заасан журмаар хуралдааныг хойшлуулж болно.

1.9.Хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэсний дараа дэгийн дагуу хэргийг хэлэлцэж эхлэх ажиллагаанд орж, хуралдаан даргалагч нь хэргийн талаар танилцуулна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 98 дугаар зүйлийн 98.1.д зааснаар ямар хэрэг хянан шийдвэрлэх гэж байгааг товч танилцуулдаг бол ИХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.1-д зааснаар явагдах танилцуулга нь арай дэлгэрэнгүй байна.

Тухайлбал: *Нэхэмжлэгч “Д” Улсын Татварын ерөнхий газрын улсын байцаагчийн –ны –тоот актыг хүчингүй болгуулах тухай Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийг шүүх 2006 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүлээн авч, _____ - д холбогдуулан ----ны өдөр захиргааны хэргийг үүсгэсэн байна.*

Үүний дараа нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлагаа юуг үндэслэж байгааг товч танилцуулах юм.

Жишээ нь: *Манайх НӨАТ төлөгч биш байхад НӨАТ ногдуулсныг эс зөвшөөрч байна үндэслэл нь гэх мэтээр.*

Дээрх байдлаас үзвэл ИХШХШТХ-ийн 98 дугаар зүйлийн 98.1, 106 дугаар зүйлийн 106.1 нь утгын хувьд адил боловч мөн хуулийн 106 дугаар зүйлийн танилцуулга нилээд дэлгэрэнгүй байх нь харагдаж байна.

1.10.Шүүх хуралдаан даргалагч болон шүүгч нэхэмжлэлийн гол утгыг танилцуулсны дараа:

- Нэхэмжлэгч нэхэмжлэлээ дэмжиж байгаа эсэх
- Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрч байгаа эсэх
- Зохигч эвлэрэх хүсэлтэй байгаа эсэхийг заавал асууна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол зарчмын нэг болох диспозитив зарчмын хүрээнд дээрх нөхцөл байдал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд хэрэгжиж болно.

Хэрэв шүүх хуралдааны өмнө дээрх нөхцөл байдал илэрвэл хуулийн 41, 42, 43 дугаар зүйлийн аль тохирохоор нь шийдвэрлэх бөгөөд энэ үед улсын тэмдэгтийн хураамжийн тавин хувийг хөнгөлөх боломж хуульд байгааг шүүх хуралдааны оролцогчдод танилцуулах шаардлагатай.

Харин шүүх хуралдааны үед дээрх нөхцөл байдал бий болбол хуулийн 74 дүгээр зүйлд зааснаар шүүх бүрэлдэхүүн тогтоол, шүүгч захирамж гаргаж, хэргийг хэрэгсэхгүй болгоно.¹⁰⁹

Эдгээр ажиллагаа нь нэхэмжлэл анх шүүхэд ирсэн үеэс тухайн хэргийн хувьд шүүхээс эцсийн шийдвэр гарах хүртэлх хугацааны аль ч шатанд байж болох авч, шүүхийн шийдвэр гарахаас өмнө буюу шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө хийгдсэн байна.

Дээрх үндэслэлийн аль нэгээр хэргийг хянан шийдвэрлэхдээ шүүх тухайн татгалзал, зөвшөөрөл, эвлэрэл нь зохигчдын хүсэл зоригийн илрэл болж чадаж байгаа эсэх, бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхол хөндөгдөж байгаа эсэхийг хангалттай бүрэн шалгаж, хянах үүрэгтэй.

Ялангуяа эрх зүйн бүрэн чадамжгүй хүмүүсийн эрх ашиг хэрхэн хөндөгдөж байгааг онцгой анхаарах нь чухал.

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг сайн дураар биелүүлсэн бол биелэлтийг нэхэмжлэгч хүлээн зөвшөөрсөн эсэхийг шүүх шалгах үүрэгтэй ба энэ талаарх баримтыг хэрэгт заавал хавсаргана.

Шүүх мөн энэ зүйлд зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийг ИХШХШТХ-ийн 59 дүгээр зүйлийн 59.4-т заасны дагуу шийдвэрлэнэ. Шүүх хуралдааны үед дээрх нөхцөл байдал тогтоогдвол тэмдэгтийн хураамжийг буцааж олгохгүй.

Энэ талаар хуулийн 41, 42, 43, 74 дүгээр зүйлийн тайлбараас үзнэ үү.

1.11.Нэхэмжлэгч нь нэхэмжлэлээсээ татгалзаагүй, хэргийн оролцогчид эвлэрэх хүсэлгүй байгаа бол хэрэг хянан хэлэлцэх ажиллагаа цааш үргэлжилнэ.

Шүүх хуралдаанд хэргийн оролцогчдын тайлбарыг сонсох нь шүүхэд өөрийгөө сонсгох зарчмын бодит баталгаа, хэрэгжилт нь юм.

ИХШХШТХ-ийн 107 дугаар зүйлийн 107.1-д зааснаар шүүх хуралдаан даргалагч хэргийн зохигчдод эрх үүргийг нь шүүх хуралдаанд дахин тайлбарлаж өгөхийн зэрэгцээ тэднийг үнэн зөв тайлбар өгөх үүрэгтэй болохыг сануулна.

Эхлээд нэхэмжлэгч тал нэхэмжлэлийн шаардлагын талаар тайлбар өгч, үндэслэлээ хэрэгт авагдсан нотлох баримтад тулгуурлан ярина.

Дараа нь хариуцагч тал нэхэмжлэлийн шаардлагын талаар өөрийн байр суурийг илэрхийлж, нэхэмжлэлийг татгалзаж байгаа үндэслэлээ хэрэгт авагдсан нотлох баримтыг үндэслэн ярина.

Хэрэв гуравдагч этгээд оролцож байгаа бол хариуцагчийн дараа өөрийн тайлбарыг танилцуулна.

¹⁰⁹ ЗХХШТХ-ийн 74 дүгээр зүйлийн 74.1, ИХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.5-н дэлгэрэнгүй тайлбарыг үзнэ үү

Шүүх хуралдаанд хэргийн оролцогчдын хэн нэг нь ирээгүй бол тэдний гаргасан тайлбарыг шүүх бүрэлдэхүүнд оролцож байгаа шүүгчдийн хэн нэг нь уншиж танилцуулна.

ИХШХШТХ-ийн 107 дугаар зүйлийн 107.4-д заасан бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа этгээд мөн тайлбараа шүүх хуралдаанд гаргана.¹¹⁰

1.12. Шүүх хэргийн оролцогчдын мэдүүлгийг сонссоны дараа гэрч, шинжээчээс мэдүүлэг авах, хэрэгт цугларсан бичмэл болон эд мөрийн баримтыг судлах, үзлэг хийх, бусад нотлох баримтыг шинжлэн судлах дарааллыг тогтооно.

Дээрх нотлох баримтуудыг шинжлэн судлах арга нь тухайн хэргийн онцлогоос шалтгаалан өөр өөр байж болно.

Нотлох баримтыг шинжлэх нь ИХШХШТХ-ийн 109-113 дугаар зүйлүүдэд заасан дараалал, журмын дагуу явагдана.

Нотлох баримтыг шинжлэн судлахдаа хэргийн оролцогчдоос шүүх бүрэлдэхүүн, шүүгч тодруулах асуултыг тавихаас гадна хурал даргалагчийн зөвшөөрлөөр хэргийн оролцогчид харилцан асуулт асууж, хариулт авч болно.

Шүүх хуралдаан даргалагч нотлох баримт шинжлэн судлахдаа мэтгэлцэх зарчмыг тууштай хэрэгжүүлж, уг ажиллагааг ямар арга хэлбэрээр хэрэгжүүлэх вэ? гэдэг талаар анхаарвал зохино.

Нотлох баримтыг шинжлэн судлах ажиллагааны нэг хэлбэр нь тухайн баримтыг шинжлэн судлахтай холбогдон асуулт тавих явдал юм.

Асуулт тавих дарааллыг хуулиар тогтоосон байх тул шүүх хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэхдээ дараах дарааллаар асуулт тавих нь зүйтэй.

Үүнд: а. Шүүх хуралдаан даргалагч

б. Шүүгч, иргэдийн төлөөлөгч

в. Нотлох баримт гаргаж буй этгээд

г. Нотлох баримтыг эсэргүүцэж буй этгээд

Нотлох баримтыг эсэргүүцэж байгаа этгээд нь заавал хариуцагч байх албагүй, нэхэмжлэгч, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд байж болно.

1.13. ИХШХШТХ-ийн 109 дүгээр зүйлд зааснаар шүүх эхлээд гэрчийн мэдүүлгийг сонсоно.

Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх явцад шүүх хуралдаанаар тогтсон дарааллын дагуу гэрчийг танхимд оруулж Эрүүгийн хуулийн 254-р зүйлд заасны дагуу үүрэг, хүлээх хариуцлагыг сануулж шүүх хуралдааны тэмдэглэлд энэ талаар ойлгосны баталгаа болгож гарын үсгийг нь зуруулах талаар дээр дурьдсан.

¹¹⁰ - Прокурор (ЗХХШТХ-ийн 55 дугаар зүйл)

- Эцэг, эх (ИХШХШТХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.3.)

- Асран хамгаалагч (ИХШХШТХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.2.)

- Эд хөрөнгө эрхлэн хамгаалагч (ИХШХШТХ-ийн 33 дугаар зүйлийн 33.2.)

- Өвлөгдөх эд хөрөнгийг эрхлэгч, хамгаалагч (ИХШХШТХ-ийн 33 дугаар зүйлийн 33.3.) нар байна.

Эдгээр субъектийн талаар холбогдох хуулийн зүйл, заалтын тайлбараас үзнэ үү.

Түүний биеийн байцаалтыг шүүх хуралдаан эхлэхийн өмнө авч, шүүх хуралдааны танхимаас гаргаж тусад нь байлгана. (ИХШХШТХ-ийн 102 дугаар зүйлийн тайлбараас үзнэ үү)

Шүүх хуралдаанд оролцож байгаа гэрчид эдлэх эрх байхгүй зөвхөн үүрэг хүлээдгээрээ онцлог.

Гэрч шүүх хуралдаанд юуны талаар гэрчлэх гэж ирснийг тайлбарлаж мэдүүлгээ өгнө.

Гэрчийн мэдүүлэгтэй холбогдуулж ИХШХШТХ-ийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсэгт заасан дараалмаар асуулт тавина.

Нэг хэрэгт хоёроос дээш хэд хэдэн гэрч оролцож болно. Шүүх тэднийг тус тусад нь асууна.

Мэдүүлэг өгсөн гэрчийг хурал даргалагч явахыг зөвшөөрч болно. Гэхдээ олон гэрч ирсэн тохиолдолд гадаа байгаа гэрчтэй мэдүүлэг өгсөн гэрч уулзах магадлал их учраас гэрчийг танхимаас гаргахгүйгээр шүүх хуралдааныг дуустал танхимд байлгах нь илүү зохимжтой.

Насанд хүрээгүй гэрчээс мэдүүлэг авахдаа түүний эцэг эх, харгалзан дэмжигч, эсхүл сурган хүмүүжүүлэгч заавал байлцуулна .

Гэхдээ тэднийг үнэн зөв мэдүүлэг өгөхөд нь нөлөөлж болохоор оролцогчийг шүүх хуралдааны танхимаас түр тусгаарлаж болно.

Энэ нь түр тусгаарлагдаж байгаа этгээдийн насанд хүрээгүй гэрчээс асуулт асуух эрхийг нь хязгаарлахгүй бөгөөд түүнийг буцаж орж ирсний дараа асуулт асуух боломжийг олгоно.

Насанд хүрээгүй гэрчээс мэдүүлэг авсны дараа түүнийг хуралдааны танхимаас гаргана.

Шүүх хуралдаанаар нотлох баримтыг шинжлэн судлах дараалал тогтоохдоо гэрчийн мэдүүлгийг бичмэл нотлох баримт судлахаас өмнө авч болох бөгөөд нотлох баримт шинжлэн судалсны дараа гэрчээс тодруулах асуулт гарвал түүнээс дахин асуулт асууж болно.

1.14.Гэрчээс мэдүүлэг авсны дараа ИХШХШТХ-ийн 110 дугаар зүйлийн дагуу бичмэл болон эд мөрийн баримтыг шинжлэн судлах ажиллагаанд орно.

Хэрэгт авагдсан нотлох баримтуудыг шүүх хуралдаан дээр шинжлэн судална.

Бичмэл нотлох баримт болон эд мөрийн баримтыг:

Нэгдүгээрт: Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой, шаардлагатай гэж үзсэн нотлох баримтыг шүүгч сонгосноор

Хоёрдугаарт: Зохигчдын хүсэлтээр

Гуравдугаарт: Гэрч, шинжээчийн хүсэлтээр тус тус уншиж танилцуулж болно.

Эд мөрийн баримтыг танилцуулахдаа хэрэгт ач холбогдолтой талаас нь танилцуулах нь зөв.

Төр, байгууллагатай холбоотой эсхүл хувь хүний нууцтай холбоотой нотлох баримтыг шүүх хуралдаанд уншиж, сонсгож, танилцуулахыг хуулиар хоригложээ.¹¹¹

Төр, байгууллагатай холбоотой нууц бичиг баримтад улсын нууцын жагсаалтад хамаарагдах баримт бичгийг хамааруулан ойлгоно.

¹¹¹ ИХШХШТХ-ийн 110 дугаар зүйлийн 110.2

Харин хувь хүний нууцтай холбоотой асуудал бол тухайн хүн нууц гэж үзсэн нууц бичиг баримтад хамаарагдах онцлогтой.

Хувийн захидал бичгийг зөвхөн эзэмшигчийнх зөвшөөрөлтэйгөөр уншин сонсгож болно. Зөвшөөрлөө өгсөн нь шүүх хуралдааны тэмдэглэлд тусгагдсан байвал зохино.

Шүүх хуралдааны үед хэрэгт авагдсан бичмэл нотлох баримт хуурамч болох талаар хэргийн оролцогчоос шүүх бүрэлдэхүүнд мэдэгдэж болох бөгөөд ийнхүү мэдэгдэж байгаа этгээд үүнийгээ хуурамч гэдгийг нотлох үүрэгтэй ба хуурамч баримтыг нотлох баримтаас хасах хүсэлт гаргаж болно.

Бичмэл нотлох баримт хуурамч гэдгийг хүсэлт гаргагч тал хөдөлбөргүй нотолсон тохиолдолд уг баримтыг нотлох баримтаас хасах тухай шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж гаргана. Уг тогтоол, захирамжид гомдол гаргаж болно. Энэ талаар хуулийн 90 дүгээр зүйлийн тайлбараас үзнэ үү.

Шүүх хуурамч болох тухай мэдээллийг өөрийн эрх хэмжээнд шалгана. Ингэж шалгах ажиллагаа шинжилгээ хийлгэх буюу бусад нотлох баримтыг шаардан авах хэлбэрээр хийгдэнэ.

Үүнийг шүүх хуралдаан дээр шууд шалгаж хийх боломж тэр бүр байхгүй тул хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2-т зааснаар шүүх хуралдааныг хойшлуулж болно.

Жишээ нь: Шүүх хуралдаанаар нотлох баримт шинжлэн судлах явцад хариуцагч хэрэгт ач холбогдол бүхий бичмэл нотлох баримтад зурсан гарын үсгийг “би зураагүй”, эсхүл бичмэл нотлох баримтын нотариатаар гэрчлүүлсэн хувь нь эх баримттайгаа зөрж байгаа гэх зэргээр маргаан гарвал шүүх хэрэгт авагдсан бусад нотлох баримтад зурагдсан гарын үсэгтэй харьцуулан үзэх, уг хуурамч гэх гарын үсэг зурсан баримтыг шүүхэд гаргаж өгсөн этгээдийг шүүх хуралдаан дээр асуух боломжтой бол асууж тодруулах, эх хувьтайгаа тохирохгүй байгаа баримтын талаар хэргийн оролцогчоос тодруулах зэрэг ажиллагааг гүйцэтгэж, хэрэв шүүх хуралдааны явцад энэ бүгдийг шалгаж тогтоох боломжтой бол эдгээр баримтуудыг нотлох баримтаас хасаж, харин шүүх хуралдаанаар тогтоох боломжгүй бол шүүх хуралдааныг хойшлуулж, шинжээч томилж болно.

Бичмэл нотлох баримт хуурамч болох нь тогтоогдсон нөхцөлд хэргийн оролцогч шаардлагатай гэж үзвэл хуурамч баримтыг шалгуулж, арга хэмжээ авахуулахаар эрх бүхий байгууллагад хандана.

Шүүх хуралдаанд хэрэгт эд мөрийн баримтаар хураагдан ирсэн зүйлийн талаар танилцуулж, хуралдааны тэмдэглэлд тусгана.

Шүүх хуралдаанд авчрах боломжгүй эд мөрийн баримтыг байгаа газарт нь очиж үзэх, хэргийн оролцогчдыг байлцуулан хийсэн үзлэгийн тэмдэглэл, бусад нотолгооны хэрэгслээр бэхжүүлсэн дүрс, дуу бичлэгийг хуралдаан дээр уншиж сонсгох зэргээр шинжлэн судалж болно.

1.15. Бичмэл болон эд мөрийн баримтыг шинжлэн судалсны дараа хэрэв тухайн хэрэгт шинжээч оролцож байгаа бол түүний дүгнэлтийг сонсоно. Хэрэв шинжээч шүүх хуралдаанд оролцоогүй бол түүний гаргасан дүгнэлтийг шүүх уншиж сонсоно.

Шинжээч дүгнэлтээ сонсгосны дараа түүнд асуулт тавьж болно. Асуултыг ИХШХШТХ-ийн 108 дугаар зүйлд заасан дарааллын дагуу тавина.

Шүүх дараах тохиолдолд тухайн шинжээчийн дүгнэлт гаргасан асуудлаар дахин өөр шинжээч томилж дүгнэлт гаргуулж болно. Үүнд:

- дүгнэлт эргэлзээтэй
- тодорхой бус үндэслэлгүй
- шинжээч зөрүүтэй дүгнэлт гаргасан. Энэ талаар шүүх тогтоол, шүүгч

захирамж гарган шийдвэрлэх бөгөөд шүүх хуралдааныг тодорхой хугацаагаар хойшлуулна гэсэн үг.

1.16. Шүүх хуралдааны даргалагч хуулийн 62 дугаар зүйлд зааснаар үүргийнхээ дагуу хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн дүүрэн, бодитойгоор тогтоох зорилгоор өмнө нь тодруулаагүй, эсхүл нэмж тодруулах шаардлагатай зүйлийг асууж тодруулах, хэргийн оролцогчдод энэ талаар нэмж тодруулж ярих зүйл байгаа эсэхийг иргэдийн төлөөлөгчид дүгнэлт гарахаас өмнө заавал асууна.

Энэ үе нь шийдвэр гаргахад шаардлагатай бүх нөхцөл байдлыг “нөхөж” тодруулах шат гэж үзэж болно.

1.17. Нотлох баримтыг шинжлэн судалж шүүх шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орохын өмнө иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлтийг сонсоно.

Иргэдийн төлөөлөгч нь дүгнэлтийг бичгийн хэлбэрээр гаргах бөгөөд дүгнэлтэд:

- Хэргийн оролцогчдын хооронд гарсан маргааны үйл баримт
- Тэдний гэм буруугийн талаар тусгагдсан байх ёстой.

Иргэдийн төлөөлөгчдийн бичгээр гаргасан дүгнэлтийг хэрэгт хавсаргана.

Иргэдийн төлөөлөгчид дүгнэлтэд гарын үсгээ зурсан байна.

Иргэдийн төлөөлөгч эрүүл мэнд болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас бичгээр гаргах боломжгүй бол дүгнэлтийг амаар гаргаж болно.

Энэ талаар шүүх хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх нь зүйтэй.

1.18. Иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлтийг сонссоны дараа шүүх хуралдаан даргалагч нь шүүх хуралдааныг завсарласныг мэдэгдэж, шүүх бүрэлдэхүүн шийдвэрээ гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орно.

Зөвлөлдөх тасалгаанд шийдвэр гаргах, санал хураах журмын талаар хуулийн 67 дугаар зүйлийн тайлбараас дэлгэрэнгүй үзнэ үү.

1.19. Шүүхийн шийдвэр сонсгохоор шүүгч, шүүх бүрэлдэхүүн танхимд орж ирэхэд оролцогчид суудлаасаа боссон байна. Шүүх хуралдаан даргалагч шүүхээс гарсан шийдвэрийн /шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийдвэрийн/ тогтоох хэсгийн агуулгыг сонсгон тайлбарлаж, шүүх хуралдаан хаасныг мэдэгдэнэ.

- 70 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, түүнийг гаргах
- 70.1. Захиргааны хэргийн шүүх шийдвэрээ Монгол Улсын нэрийн өмнөөс гаргана.
- 70.2. Анхан шатны шүүхээс захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:
- 70.2.1. маргаан бүхий захиргааны акт хууль бус болох нь тогтоогдвол түүнийг хүчингүй болгох;
 - 70.2.2. эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоож хүлээн зөвшөөрөх;
 - 70.2.3. захиргааны байгууллагаас гаргасан акт нь илт хүчин төгөлдөр бус болохыг нь хүлээн зөвшөөрөх;
 - 70.2.4. захиргааны актыг гаргахгүй байгаа явдал болон эс үйлдэхүй нь хууль бус гэж тогтоогдсон бол шаардагдах захиргааны актыг гаргахыг тухайн захиргааны байгууллага, албан тушаалтанд даалгах;
 - 70.2.5. төлбөр тогтоосон захиргааны актын төлбөрийн хэмжээг багасгах;
 - 70.2.6. захиргааны байгууллага, албан тушаалтнаас иргэнд учруулсан хохирлыг гаргуулах, хохирлын хэмжээг өөрчлөх, хасах;
 - 70.2.7. хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай гэж үзвэл захиргааны байгууллага, албан тушаалтнаас дахин шинэ акт гартал захиргааны уг актыг түдгэлзүүлэх;
 - 70.2.8. нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг хэрэгсэхгүй болгох;
 - 70.2.9. нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох.
- 70.3. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр нь хэрэгт авагдсан бөгөөд шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримт болон хуульд үндэслэсэн байна.
- 70.4. Захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны улмаас нэхэмжлэгчид хохирол учирсан нь тогтоогдвол нөхөн төлүүлэх ба хохирлын хэмжээний талаар маргаан гарсан бол иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлнэ.

ТАЙЛБАР

Дээрх зүйлд шүүх захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцээд ямар агуулгатай шийдвэр гаргах, шүүхийн шийдвэрт тавигдах шаардлагын талаар зохицуулжээ.

Иргэн хуулийн этгээдээс захиргааны актыг хууль бус хэмээн үзэж, шүүхэд гаргасан нэхэмжлэлийг хүлээн авч, хуульд заасан процессын ажиллагааг хийж

гүйцэтгэн, улмаар хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, эцсийн шийд гаргаснаар тухайн маргааныг хянан хэлэлцэх анхан шатны үйл ажиллагаа дуусна.

Үүний эцсийн үр дүн нь шүүхийн шийдвэр юм.

Шүүхийн шийдвэрийг :

1. Аймаг, нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхээс

2. Улсын Дээд шүүх захиргааны хэргийг анхан шатны журмаар хэлэлцээд тус тус гаргана.

Захиргааны хэргийн шүүхээс гаргадаг бусад баримт бичгээс /шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол гэх мэт/ захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн ялгагдах гол онцлог нь тухайн маргааныг эцэслэн шийдвэрлээд гаргасан эрх зүйн акт юм.

“Шүүхийн шийдвэр нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч эрх бүхий төрийн байгууллагаас гаргадаг, эрх зүйн харилцааг тодорхойлох, түүнийг зохицуулсан хэм хэмжээг хэрэглэх хэлбэрээр тухайн хэрэг маргаанд хамааралтай этгээдэд хуулиар тодорхойлогдсон төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг акт” мөн гэж шүүхийн шийдвэрийг Улсын Дээд шүүх тогтоолдоо¹¹² тодорхойлжээ.

Түүнчлэн шүүхийн шийдвэрийн зорилго нь зөрчигдсөн буюу маргаантай эрхийг сэргээх, түүнийг зохих ёсоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхээс гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болон нийт иргэдэд хүмүүжлийн үр нөлөө үзүүлэх явдал гэж мөн тогтоолд дурьдсан байна.¹¹³

1. Хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх зохицуулалтаас үзэхэд шүүхийн шийдвэр нь “Монгол Улсын нэрийн өмнөөс” гэсэн гарчигтай байна.

Нэгэнт хуульчлагдсан учраас энэ нь хуулиар тогтоосон гарчиг бөгөөд шүүх эрх мэдлийг Үндсэн хуулиар эрх нь олгогдсон төрийн байгууллага-шүүх хэрэгжүүлдэг үүднээс шүүхийн шийдвэр “Монгол Улсын нэрийн өмнөөс” гардаг болно.

Энэ талаар ИХШХШТХ-ийн 116 дугаар зүйлийн тайлбараас дэлгэрэнгүй үзэж болно.

2. Хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т шүүхээс ямар агуулгатай шийдвэр гаргахыг тоочих замаар зохицуулжээ. Үүнд 9 төрлийн шийдвэр байна.

Шүүхийн шийдвэрийн агуулга нь нэхэмжлэлийн шаардлагаас шууд хамаарна.

Нэхэмжлэл ямар агуулгатай байх талаар 32 дугаар зүйлийн 32.5-д тодорхой заасан тул хуулийн холбогдох зүйлийн дэлгэрэнгүй тайлбарыг үзэх хэрэгтэй.

Шүүх нэхэмжлэлийн шаардлагаас хамааран 70 дугаар зүйлд заасан шийдвэрийн аль тохирохыг гаргана.

Үүнийг үзүүлбэл:

¹¹² Улсын дээд шүүхийн тогтоол, 2006 оны 4 сарын 24, дугаар 21

¹¹³ Улсын дээд шүүхийн тогтоол, 2006 оны 4 сарын 24, дугаар 21

Нэхэмжлэлийн төрлүүд /ЗХХШТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.5/	Шүүхээс гаргах шийдвэрийн агуулга / ЗХХШТХ-ийн 70 дугаар зүйл /
1.Захиргааны байгууллагаас гаргасан акт нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол тухайн актыг хүчингүй болгуулах	Маргаан бүхий захиргааны акт хууль бус болох нь тогтоогдвол түүнийг 70 дугаар зүйлийн 70.2.1-д зааснаар хүчингүй болгох
2.Захиргааны байгууллагаас гаргасан актыг илт хууль бус гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх	Мөн зүйлийн 70.2.3-т зааснаар захиргааны байгууллагаас гаргасан акт нь илт хүчин төгөлдөр бус болохыг хүлээн зөвшөөрөх
3.Маргаан бүхий захиргааны акт нь нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн болон түүнээс үүдэн гарах хохирлыг арилгуулах тухай	Мөн зүйлийн 70.2.5, 70.2.6-д зааснаар шийдвэр гаргана. 70.2.2-т зааснаар шийдвэр гарч болно
4.Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус эс үйлдэхүй, нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хэрхэн зөрчсөн, түүний үр дагаврыг арилгах тухай зааж, зөрчигдсэн эрхээ сэргээлгэх тухай	Хуулийн 70 дугаар зүйлийн 70.2

Дээр дурдсанаас гадна дараах агуулгатай шийдвэр гаргаж болно. Үүнд:

- Хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай гэж үзвэл захиргааны байгууллага албан тушаалтнаас дахин шинэ акт гартал захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх /хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.7/

- Нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангах / 70.2.1-70.2.6/
- Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг нь хэрэгсэхгүй болгох /70.2.8/
- Нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох /70.2.9/

Шүүх ямар төрлийн шийдвэр гаргах нь нэхэмжлэлийн шаардлагаас шууд хамааралтай байх талаар дээр дурьдсан ч шүүхэд зөрчигдсэн эрхээ хамгаалуулахаар хандаж байгаа этгээдийн хууль зүйн мэдлэгийн түвшингээс хамаарч, нэхэмжлэлийн шаардлага нь тэр бүр тодорхой бус байх нь шүүхийн практикт элбэг тохиолддог.

Ийм тохиолдолд шүүх үндэслэл бүхий шийдвэр гаргахын тулд нэхэмжлэлийн шаардлагыг сайтар тодруулах зайлшгүй шаардлагатай.

Жишээ: Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд газар ашиглуулах тухай шийдвэр гаргасан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолыг хууль бус гэж үзэж хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргажээ.

Нэхэмжлэгч нь уг актыг хууль бус гэж буй үндэслэлээ Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1-д “Засаг даргын өргөн мэдүүлсэн хотын ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл болон Нийслэлийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг дүүрэг бүрийн хуваарьтайгаар хэлэлцэн батлах” гэж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийг, харин 21.2.2-т “батлагдсан төлөвлөгөөний дагуу тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах, газрын байршил, зориулалт, хэмжээг тогтоох”, 21.2.3-т “...төлөвлөгдсөн газруудад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэнэ...” гэж Нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийг тус тус зохицуулсан

байгаагаас үзвэл иргэд, хуулийн этгээдэд газар, эзэмшүүлэх ашиглуулах эрх нь зөвхөн Нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд хамаарах асуудал байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1-д "...газрыг Монгол Улсын газрын тухай хууль тогтоомжид заасан болзол, журмын дагуу төлбөртэйгөөр гэрээний үндсэн дээр ашиглана" гэж заасан бөгөөд мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 1 болон 2 дахь хэсгүүдэд зааснаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Тэргүүлэгчид нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдтэй Монголын талын өмчлөгч газар ашиглуулах гэрээг байгуулахад зөвшөөрөл өгөх эрхтэй байна.

Иймд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид нь Газрын тухай хуулиар өөрт нь олгоогүй эрхийг эдэлж, хууль зөрчиж, бидний хууль ёсоор эзэмшиж буй газарт дээрх хуулийн этгээдэд газар олгосон шийдвэр гаргаж эрхийг хохироож байна гэж зааж.¹¹⁴ Уг тогтоолыг хүчингүй болгуулах шаардлага гаргажээ.

Харин дээрх үндэслэлээр маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгуулахаар /хуулийн 70.2.1/ нэхэмжилж байгаа нь буруу бөгөөд энэ нь хуульд заасан "захиргааны актыг илт хууль бус гэж тооцох" /хуулийн 9.1.3/ үндэслэл болно.

Гэтэл нэхэмжлэгч, түүний өмгөөлөгч нар нарийн ялгааг нь ойлгоогүй байна.

Дээрхээс үзэхэд нэхэмжлэгч жирийн иргэд төдийгүй тэдний эрхийг нь хамгаалан шүүхэд төлөөлж байгаа өмгөөлөгч нар ч үүний нарийн ялгааг ойлгохгүй байх нь элбэг тохиолдог.

Ийм тохиолдолд үндэслэл бүхий шийдвэр гаргах зорилгоор шүүх энэ талаар тайлбарлаж, нэхэмжлэлийн шаардлагыг тодруулж байвал зохих талаар дээр дурьдсан.

Дээрх хоёр шаардлагын ялгаа, үр дагавар нь ямар талаар дараагийн зүйлд тодорхой тайлбарлана.

Шүүхээс гаргах шийдвэр тус бүрийн талаар тусгайлан авч үзье.

Өмнө дурьдсанаар өнөөгийн шүүхийн практикт ажиглагдаж байгаа зүйл бол нэхэмжлэгч нь маргаан бүхий захиргааны актыг хууль бус гэж үзэж, түүнийг хүчингүй болгох, /70.2.1, 10 дугаар зүйл/ болон Захиргааны байгууллагаас гаргасан акт нь илт хүчин төгөлдөр бус болохыг нь хүлээн зөвшөөрөх /70.2.3 болон 9 дүгээр зүйл/ шаардлага гаргаж байгаагийн учир холбогдол үр дагаврыг тэр бүр ялгадаггүй, /тэдний эцсийн зорилго нь хүчингүй болгох/, шүүх ч үүнийг нарийн шалгаж тодруулахгүйгээр, нэхэмжлэлдээ маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгуулах тухай шаардлага тавьсан атлаа нэхэмжлэлийн агуулга, шүүх хуралдаан дээр гаргаж байгаа тайлбараас нь үзэхэд илт хүчин төгөлдөр актын талаар яригдаж байхад энэ талаар тодруулахгүйгээр шууд "маргаан бүхий акт" гэж үзэж шийдвэрлэж байгаа буруу практик тогтжээ.

Дээрх хоёр өөр шаардлага бүхий нэхэмжлэлийн талаар шүүхээс 2 өөр шийдвэр гарах юм. /Хуулийн 70.2.1, 70.2.3 /

Иймд эдгээр шийдвэрийн ялгаа, үр дагаврыг харьцуулан үзэх зорилгоор хамтад нь тайлбарлах нь илүү ойлгомжтой байна.

2.1 /хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.1,70.2.3/ Шүүх хуулийн 70.2.1-д заасан агуулга бүхий шийдвэр гаргахын тулд юуны өмнө маргаан бүхий захиргааны акт гэж

¹¹⁴ Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн 2006 оны 10 сарын 25-ны өдрийн 165 дугаар шийдвэртэй хэргээс

юуг ойлгох, уг актыг ямар нөхцөлд хууль бус гэж тооцох талаар сайтар ойлгосон байх шаардлагатай.

Маргаан бүхий захиргааны акт гэдэг нь захиргааны актад байгаа алдаа нь уг актыг илт хууль бусад тооцох үндэслэлд хамаарахгүй боловч иргэн хуулийн этгээд эрх, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчсөнд тооцож, гомдол гаргасан тухайн акт юм.

Нэгэнт хууль бус болох нь тогтоогдсон бол тухайн актын үйлчлэлийг бүрмөсөн зогсоох шаардлагатай болно.

Маргаан бүхий захиргааны актын талаар хуулийн 10, Илт хүчин төгөлдөр бус актад ямар актыг тооцох талаар хуулийн 9 дүгээр зүйлийн тайлбарт тус тус тодорхой заасан байгааг үзэх хэрэгтэй.

Маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгох шаардлага бүхий нэхэмжлэлийн төрөлд дараах жишээг нэрлэж болно:

Үүнд:

- Төрийн захиргааны албан хаагчийг ажлаас халах тухай Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан үндэслэл тогтоогдоогүй байхад ажлаас нь халсан,
- Бусдын хууль ёсоор эзэмшиж байгаа газрыг өөр этгээдэд өмчлүүлэн газрыг давхцуулан олгож Газрын тухай хуулийг зөрчсөн,
- Ашигт малтмалын тухай хуульд заасан үндэслэлээр лиценз эзэмших эрхийг цуцлахдаа /лицензийн төлбөрийг төлөөгүй/ энэ талаар лиценз эзэмшигчид мэдэгдэлгүйгээр хууль зөрчсөн гэх мэт

Юуны өмнө шүүх нэхэмжлэлийн шаардлагад гол анхаарлаа хандуулах шаардлагатай.

“Маргаан бүхий актыг хүчингүй болгуулах” тухай нэхэмжлэл гаргасан байхад шүүх өөрийн санаачилгаар нэхэмжлэлийн шаардлагыг өөрчилж, “илт хүчин төгөлдөр бус акт” гэж тооцож, шийдвэр гаргаж байгаа нь хуулиар нэхэмжлэлийн шаардлагыг өөрчилж, нэмэгдүүлэхээр зөвхөн нэхэмжлэгчид олгогдсон эрхийг зөрчиж байгаа мэт ойлгогдож байна.

Шүүгч нэхэмжлэлийг хүлээн аваад дараах шалгуураар илт хууль бус гэдгийг шалгаж тогтоож болох юм. Үүнд:

- хэн ч харсан илт алдаатай,
- ноцтой байх

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхэн үед тухайн захиргааны акт нь илт хууль бус эсхүл маргаан бүхий эсэх нь тодорхой бус байж болно.

Иргэний хувьд маргаан бүхий акт, илт хууль бус актыг ялгахад маш хүндрэлтэй.

Энэ нь эрх зүйн хамгаалал хүссэн иргэдэд сөрөг нөлөө үзүүлэх ёсгүй бөгөөд шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж болохгүй.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн захиргааны акт илт хууль бус болох нь эсхүл маргаан бүхий, хууль бус болох нь тогтоогдвол нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх замаар, түүнчлэн шүүх үүнд нь тусалж хэргийг зөв чигт оруулж шийдвэрлэх ёстой юм.

Хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар захиргааны акт “илт хууль бус” шинжийг агуулаагүй тохиолдолд түүнийг маргаан бүхий акт гэж үзнэ.

Өөрөөр хэлбэл хуулийн 9 дүгээр зүйлд заасан үндэслэлээс өөр бусад үндэслэлээр иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж байгаа захиргааны акт болгон маргаан бүхий акт болно гэдгийг өмнө нь дурьдсан.

Илт хууль бус захиргааны акт нь гарсан цагаасаа ямар ч эрх зүйн нөлөөлөлгүй байдаг. Өөрөө хэлбэл уг захиргааны актыг иргэд биелүүлэх, захиргааны байгууллага хэрэгжүүлнэ гэх шаардлагагүй.

Эрх зүйт төрийн үед алдаатай, илт хууль бус акт хүчин төгөлдөр байх боломжгүй.

Иймээс ч онолын хувьд иргэд илт хууль бус захиргааны актын талаар гомдлыг хуульд заасан гомдол гаргах хугацааг баримтлалгүйгээр хэдийд ч гаргаж болно гэж ойлгоно.

Харин маргаан бүхий захиргааны актын үр дагавар нь түүнийг хүчингүйд тооцсоноор илэрнэ.¹¹⁵ “ЗХХШТХ-ийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” Улсын Дээд шүүхийн 2006 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 37 дугаар тогтоолын 4; 5; 6; 18; 19 дүгээр заалтад илт хууль бус болон маргаан бүхий захиргааны актын талаар тайлбарласныг үзнэ үү.

2.2. Ямар тохиолдолд эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоох /хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2/ агуулга бүхий шийдвэр гаргаж болох вэ? гэдэг асуулт зүй ёсоор гарна. Одоогоор шүүхийн практикт ийм төрлийн шийдвэр гараагүй байна.

Энэ нэхэмжлэл нь захиргааны эрх зүйн харилцаа байгаа болон байхгүй фактыг тогтоолгох, шаардлагыг агуулдаг.

Эрх зүйн харилцаа гэдэг ойлголтыг хийсвэр харилцаан дээр бус тодорхой эрх зүйн харилцаан дээр авч үздэг. Үүнд:

- тодорхой нөхцөл байдлаас үүсэн гарсан
- хувь хүн болон хуулийн этгээд хоорондын эсхүл 2 хуулийн этгээдийн хооронд буюу тэдгээрийн эд хөрөнгөтэй холбоотой
- нийтийн эрх зүйн харилцаа

Шүүх эрх зүйн харилцаа үүсэхгүй байх тохиолдол, харилцаа үүсэх тохиолдол нь аль вэ гэдгийг ялгах нь чухал

Эрх зүйн харилцаа үүсэхгүй тохиолдол:

- нэхэмжлэл нь хууль, түүний зүйл заалтыг тайлбарлуулах зорилготой
- эрх зүйн маргаан бус зөвхөн нөхцөл байдлыг шүүхээр тогтоолгох зорилготой бол

Жишээ:

иргэн “А” газрын тухай хуулийн тодорхой хэм хэмжээг хэрхэн ойлгох талаар мэдэхийг хүсэж байгаа бол

- тухайн дүүрэгт хүүхдийн хувийн цэцэрлэг ажиллуулж болох эсэх талаар хийсвэр маргаан

Иргэн “Б” нь зан чанарын хувьд төрийн албан хаагч байж болох эсэхийг шүүхээр тогтоолгох

Иргэн Т өөрийн хүнсний дэлгүүртээ согтууруулах ундааны зүйл зарахын тулд тусгай зөвшөөрөл авах эсэх талаарх маргаан

¹¹⁵ П.Одгэрэл “Захиргааны эрх зүйн ерөнхий анги УБ, 2004 , 129-130

Эдгээр тохиолдолд шүүхэд эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгох тухай нэхэмжлэл гаргах боломжгүй. Учир нь эрх зүйн хийсвэр хэм хэмжээг тайлбарлуулах шаардлага тавьжээ.

- Харьяалалгүй хүнийг цэргийн албанд татахаар зарлан дуудах хуудас хүргүүлсэн бол;
- Иргэн тухайн засаг захиргааны нэгжид байнга оршин суугч гэдгээ тогтоолгох бол;
- Иргэний сонгуульд оролцох эрхтэй эсэх асуудлаар маргаан гарах зэрэг тохиолдлуудад дээрх төрлийн нэхэмжлэлийг гаргаж болох юм.

Дээрх шаардлага бүхий нэхэмжлэлийг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу зөвхөн нэхэмжлэгчийн хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа тохиолдолд л гаргана.

Жишээ нь: цэргийн хугацаат албыг хаах шаардлага тухайн иргэнд байхгүй бол эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгох тухай нэхэмжлэл хууль, өөрөөр хэлбэл тухайн захиргааны актын улмаас түүний эрх хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөөгүй байна гэж үзнэ.

Мөн иргэн Монгол Улсын иргэн мөн эсэх асуудлаар маргаан гарчээ.

70.2.2 -т зааснаар нэхэмжлэл гаргах эрхтэй юу гэдэг асуулт гарна.

Энэ үндэслэлээр нэхэмжлэл гаргасан тохиолдолд шүүхээс давхар шалгах шаардлагатай нэг зүйл бол үнэхээр энэ байдлыг тогтоолгох шаардлага нэхэмжлэгчид байсан эсэхийг тогтоох.

Өөрөөр хэлбэл үүний цаана нэхэмжлэгчийн ямар эрх ашиг, сонирхол зөрчигдөж байна гэдгийг анхаарах нь чухал юм.

2.3./хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.4/ Эс үйлдэхүйтэй холбоотой нэхэмжлэл нь даалгах нэхэмжлэл болно

Шүүх шийдвэр гаргахдаа:

- “эс үйлдэхүй”¹¹⁶ байсан эсэх
- энэ нь хууль бус эсэх
- үүнээс нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн эсэхийг шалгана

Дээрх байдлууд тогтоогдвол зөрчигдөж байгаа эрхийг сэргээж, зохих захиргааны актыг гаргахыг захиргааны байгууллага, албан тушаалтанд даалгах шийдвэр гаргана.

Анхаарах зүйл: Шүүх хуулийн хүрээнд холбогдох захиргааны актыг гаргах талаар даалгасан шийдвэр гаргах болохоос нэхэмжлэгчийн хүсэж байгаа шаардлагыг шууд биелүүлсэн шийдвэр гаргаж болохгүй.

Үүнийг дараах жишээн дээр тайлбарлъя.

Иргэн барилга барих зөвшөөрөл хүсэж холбогдох байгууллагад ханджээ.

Тухайн захиргааны байгууллага зөвшөөрөл олгохоос татгалзсан байна.

Энд тухайн захиргааны байгууллага иргэний хүсэлтэд ямар ч байсан хариу өгсөн учир татгалзсан хариуг эс үйлдэхүй гэж үзэхгүй. Иймээс иргэн “зөвшөөрөл олгуулах”-аар өөрийн хүссэн үр дүнд хүрэх зорилгоор хуулийн 70 дугаар зүйлийн

¹¹⁶ Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-н тайлбарыг үзнэ үү

70.2.4-т зааснаар нэхэмжлэл гаргаж болохгүй. Нэхэмжлэл гаргасан бол шүүх түүнийг хүлээн авахаас татгалзаж болохгүй.

Харин шүүх хуралдаанаар хэлэлцэж хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.4-т зааснаар шийдвэр гаргах үндэслэлгүй тул энэ үндэслэлээр нь “захиргааны актыг гаргасан байна. Эс үйлдэхүй байхгүй” гэж хуулийн 70.2.9-д зааснаар нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгоно гэсэн үг.

Гэхдээ нэхэмжлэгчид өөрийн хүссэн үр дүнд хүрэх боломж байна. Энэ нь нэхэмжлэлийн шаардлагыг өөрчилж, өөрийн хүссэн үр дүнд хүрэх /зөвшөөрөл авах боломжтой/ эсэхийг шүүхээр шийдүүлэх.

Өөрөөр хэлбэл захиргааны байгууллагын зөвшөөрөл өгөхөөс татгалзсан ба уг хариу нь хуульд нийцээгүй гэж түүнийг хүчингүй болгуулах /70.2.1/ эсхүл илт хүчин төгөлдөр бусад тооцуулах /70.2.3/-аар нэхэмжлэл гаргах юм.

Тэгвэл дээрх жишээн дээр иргэн шүүхэд ямар байдлаар хандаж болох, шүүхээс хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.4-т зааснаар ямар шийдвэр гарч болох талаар авч үзье.

Иргэн шүүхэд “хуулийн дагуу зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг шийдвэрлэж, захиргааны акт гаргахыг тухайн эрх бүхий байгууллага албан тушаалтанд даалгах” тухай шийдвэр гаргуулахаар нэхэмжлэл гаргана.

Харин “зөвшөөрөл олго” гэсэн талаар шийдвэр гаргуулах тухай нэхэмжлэл гаргах эрхгүй.

Шүүх “хууль бус эс үйлдэхүй байна” гэж үзвэл хуулийн 70.2.4-т зааснаар “хуульд заасан журмын дагуу захиргааны акт гаргахыг даалгасугай” гэсэн шийдвэр гаргахаас бус зөвшөөрөл олгох үндэслэл байгаа эсэхийг шалгаж олгох, эсхүл олгохгүй байх тухай шийдвэр гаргаж болохгүй.

Энэ нь захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож, түүний өмнөөс захиргааны акт гаргаж байгаа хэлбэр гэж үзнэ.

2.4 /Хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.5/ Нэхэмжлэгч нь захиргааны актаар төлбөр тогтоосныг зөвшөөрч байгаа боловч түүний хэмжээг зөвшөөрөөгүй буюу багасгах тухай нэхэмжлэл гаргах тохиолдолд хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.5-д зааснаар шийдвэрлэнэ.

Төлбөр гэдэгт төрийн өмчийг /иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц зэрэг/ ашиглуулсны төлөө иргэн аж ахуйн нэгж байгууллагаас авч, улс, орон нутгийн төсөв, тусгай зориулалтын санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ.¹¹⁷

Захиргааны хэргийн шүүх тогтоосон төлбөрийн хэмжээг хуульд заасан хэмжээгээр багасгах, захиргааны байгууллага төлбөрийн хэмжээг дахин нэмэхгүй байх, эсхүл илүү төлсөн төлбөрийн хэмжээг буцаан олгох гэсэн утгаар энэ заалтыг хэрэглэж болно.

Мөн энэхүү заалтыг захиргааны хэргийн шүүх өөрийн үзэмжээр захиргааны актын төлбөрийн хэмжээг тогтоох эрхтэй гэсэн утгаар ч мөн ойлгож болно.¹¹⁸

¹¹⁷Татварын ерөнхий хууль. ТМ, 2006 он, №30 /459/

¹¹⁸ “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хэлбэр, агуулга” ХБНГУ-ын Байротын их сургуулийн профессор, доктор Даниель-Эразмус Каан – Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа- Шүүгчдэд зориулсан гарын авлаг номоос УБ хот, 2004 он, 160 дугаар тал

Жишээ:

- Ашигт малтмалын тухай хуулиар¹¹⁹ /хуулийн 32 дугаар зүйлийн 32.3/-т Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон уурхайн талбайн гектар тутамд 15 ам. доллар байх бөгөөд харин нүүрс болон түгээмэл тархацтай ашигт малтмалын хувьд гектар тутамд 5 ам. доллар байна гэж заажээ.

Гэтэл захиргааны байгууллага түгээмэл тархацтай ашигт малтмал гэж заасныг анхааралгүйгээр 15 ам. доллараар тогтоожээ.

Үүний эсрэг төлбөр тогтоосныг хуулийн дагуу төлөх ёстой гэж зөвшөөрч байгаа боловч төлбөрийг багасгаж хуульд нийцүүлэн шийдвэрлэж өгөхийг хүсэж нэхэмжлэл гаргаж болох юм.

- Олон Улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авах төлбөрийн хэмжээг Засгийн газрын тогтоолоор¹²⁰ хөнгөн тэргэнд ачааны авто машинд даац тонноос шалтгаалж 3,5 тн. Хүртэл бол 800, 3,6-12,0 тн бол 1000 төгрөг гэх мэт тогтоожээ.

Сэлэнгэ аймгаас Улаанбаатар хотод ачаа тээвэрлэж байсан жолоочоос замын постод 1000 төгрөг төлөхийг шаарджээ.

Тэрээр төлбөр төлөхөө зөвшөөрсөн боловч машины даацаас шалтгаалж үүнээс бага хэмжээний төлбөр төлөх ёстой гэж шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

Дээрх тохиолдлуудад шүүх нэхэмжлэлийг хүлээн авч зохих шалгалтыг хийж, төлбөр нь гаргасан зөрчилд нь тохирч байгаа эсэхэд дүгнэлт хийнэ. Шүүхээс шалгалтыг ямар хязгаарт явуулах, ямар шийдвэр гаргаж болох талаар дор дурьдах жишээн дээр дэлгэрэнгүй тайлбарлана.

Харин төлбөр тогтоосон актыг зөвшөөрөхгүй өөрөөр хэлбэл төлбөр төлөх үндэслэлгүй гэж үзвэл хууль бус актыг хүчингүй болгуулах, эсхүл илт хүчин төгөлдөр бусад тооцуулах нэхэмжлэлийн шаардлагын аль нэгийг гаргана .

Хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.5-д заасан төлбөр гэдэгт торгууль, хураамж, татвар хамрагдах уу гэдэг асуулт гарч болно.

Татварын ерөнхий хуульд¹²¹

Хууль тогтоомжийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлого, эд хөрөнгө, бараа, ажил үйлчилгээнд тодорхой хугацаанд, тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгийг албан татвар гэнэ.

Хууль тогтоомжийн дагуу төрийн зохих байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилгээ үзүүлсний төлөө тэднээс тухай бүр авч, улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгийг хураамж гэнэ. гэж тус тус заажээ.

Эндээс үзвэл төлбөр, хураамж, татварын хэмжээг аль алийг нь хуулиар тогтоох бөгөөд хуульд заасан хэмжээг буруу тогтоож иргэн, хуулийн этгээдийн эрхийг зөрчсөн тохиолдолд захиргааны хэргийн шүүхэд хандах бөгөөд шүүх төлбөр, хураамж, татвар, торгууль аль алины хэмжээг багасгах шийдвэр гаргаж болно гэж ойлгогдож байна.

¹¹⁹ Ашигт малтмалын тухай хууль ТМ, 2006 он, №30 /459/

¹²⁰ Засгийн газрын тогтоол, 2002 оны 9 дүгээр сарын 4, №177, уг тогтоолын 2 дугаар хавсралт

¹²¹ Татварын ерөнхий хууль. ТМ, 2006 он, №30/459/

Өөр нэг тохиолдол: Хуулиар захиргааны байгууллага тухайн этгээдийн гаргасан зөрчилд 20-40 мянган төгрөгийн торгууль ногдуулах эрхтэй байхаар зохицуулсан гэж бодъё.

Хэдийгээр торгуулийн дээд хэмжээг 40000 төгрөг гэж заасан боловч ялимгүй зөрчилд дээд хэмжээгээр буюу 40000 төгрөгийн торгууль ногдуулсныг эс зөвшөөрч иргэн, хуулийн этгээдээс шүүхэд хандвал шүүх энэ асуудлыг хүлээн авч шалгах ёстой энэ нь хуулийн бодолгод нийцнэ.

Харин шалгалт ямар хэмжээнд явагдах вэ гэдэг нарийн асуудал.

Учир нь энэ шалгалт захиргааны байгууллагын дотоод үйл ажиллагаа руу хандах аюултай тул шүүх маш болгоомжтой хандах ёстой.

Хууль тогтоогчоос торгууль дээд доод хэмжээг зааж байгаа нь энэ хүрээнд дур зоргоороо бай гэдгийг зөвшөөрсөн хэрэг огт биш. Ийм ч учраас тодорхой нэг хяналт байх ёстой бөгөөд энэ хяналтын үүргийг захиргааны хэргийн шүүх хэрэгжүүлнэ гэж ойлгогдож байна.

Энэ төрлийн маргаан шүүхэд ирвэл шүүх захиргааны байгууллагаас хамгийн түрүүн яагаад энэ зөрчилд ийм хүнд арга хэмжээ авав гэдгийг асуух шаардлагатай.

Шалгалтыг явуулсны эцэст шүүхээс торгуулийн хэмжээг багасгаж шууд 20, 30 мянга гэх мэт зааж шийдвэр гаргаж болохгүй. Харин 40000 төгрөгөөр торгосон нь буруу гэдгийг тогтоогоод зөрчилд тохирсон арга хэмжээ авахыг даалгаж буцааж болох юм.

Энд захиргааны байгууллага, захиргааны хэргийн шүүхийн торгон зааг оршино. 40000 төгрөгөөр торгосон захиргааны акт буруу гэдгийг шүүх тогтооно, харин хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ дотор дахин захиргааны акт гаргаж, арга хэмжээ авах нь захиргааны байгууллагын дотоод асуудал болно.

Түүнчлэн хуулийн мэдлэг муу, хайнга байдлаасаа болж, захиргааны байгууллагын төлбөр тогтоосон актыг тухайн үед зөвшөөрч төлбөр төлсний дараа хуульд заасан хэмжээнээс илүү төлбөр төлснөө мэдэж, илүү төлсөн төлбөрөө буцаан нэхэмжлэх тохиолдолд мөн дээрх хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.5-д зааснаар шийдвэр гаргах тохиолдол гарч болно.

Эдгээрийг нэгтгэж дүгнэвэл хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.5-т зааснаар нэхэмжлэгч нь зөвхөн төлбөр тогтоосон захиргааны актыг зөвшөөрсөн боловч хэмжээг нь зөвшөөрөхгүй тохиолдолд нэхэмжлэл гаргана .

Харин актыг огт зөвшөөрөхгүй бол хуулийн 70.2.1, 70.2.3-тай холбоотой нэхэмжлэл гэдгийг анхаарвал зохино.

2.5./Хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.6, Мөн 70 дугаар зүйлийн 70.4/ Дээрх 2 зүйлийн аль аль нь захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг нэхэмжилсэн тохиолдолд шүүхээс гаргах шийдвэрийн талаар зохицуулжээ.

Иймд эдгээрийн ялгааг гаргах үүднээс дээрх 2 зүйлийг хамтад нь авч үзэх нь зүйтэй гэж үзэв.

Эдгээр зүйлүүдээр бие даасан нэхэмжлэлийн шаардлага гаргаж болох уу, ялангуяа хуулийн 70.4-т зааснаар бие даасан шаардлага гаргаж болох эсэх, шүүх

ямар тохиолдолд 70 дугаар зүйлийн 70.2.6-д зааснаар, ямар тохиолдолд 70.4-т зааснаар тус тус шийдвэр гаргах талаар авч үзье.

Хуулийн 70 дугаар зүйлд заасан шүүхээс гарах шийдвэрийн нэг төрөл болгон зааснаас үзвэл хуулийн 70.2.6-д зааснаар бие даасан нэхэмжлэлийн шаардлага гаргаж болно.

Энэ заалтад “захиргааны акт” гэж тусгайлан заагаагүй байна. Захиргааны акт гаргаагүй мөртлөө үйл ажиллагааны улмаас хохирол учрах тохиолдол байж болно. Үйл ажиллагаа болгон захиргааны акт байхгүй. Тухайлбал замын доогуурх трубаг солих шаардлага гарчээ. Захиргааны байгууллага нэгэн компаниар энэ ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн боловч яг хаана уг шугамыг аль хэсэгт нь солихыг тодорхой зааж өгөөгүй байсан гэж бодъё. Үүнээс болж гүйцэтгэгч өөр газарт газар ухсанаас замын эсрэг талын дэлгүүрийн орох зам хаагдаж хохирол учирснаас гомдол гарах тохиолдол гарна.

Эндээс үзвэл хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.6-с бусад бүх заалтуудаар нэхэмжлэл гаргах үндэслэл нь захиргааны хууль бус акт байдаг бол энэ заалт нь ийм нөхцөлийг шаардахгүй.

Өөрөөр хэлбэл захиргааны акт байж ч болно, байхгүй байж ч болно. Түүгээр зогсохгүй уг акт нь хууль бус, эсхүл хууль ёсны эсэхээс үл хамаардаг байна.

Гол нь захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанаас хохирол учирсан байх нь гол нөхцөл.

Жишээ нь: хууль бус барилгыг нураах шийдвэр. Энэ нь хууль ёсны шийдвэр. Гэтэл нураах явцад хэн нэг этгээдэд учирсан хохирлын асуудлаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж болох юм.

Түүнчлэн хуулийн дагуу гаргасан захиргааны актын улмаас нөхөн олговор аваагүйгээс нэхэмжлэл гарч болно. Жишээ. Бүх нийтээрээ тарилгад хамрагдах хамрагдаагүй бол албадан тариа хийх шийдвэр гарсан байна. Гэтэл тухайн тариа нь хэн нэг иргэнд сөрөг нөлөө үзүүлж биед нь өөрчлөлт өгснөөс нөхөн төлбөр нэхэх тохиолдол байж болно.

Хуульд зөвхөн “иргэнд учирсан хохирол” гэж заасан нь учир дутагдалтай байна.

Захиргааны байгууллагын хууль бус захиргааны актын улмаас зөвхөн иргэний төдийгүй, хуулийн этгээдэд хохирол учрах нь олонтаа.

Тийм ч учраас иргэн, хуулийн этгээдээс захиргааны актыг хууль бус гэж үзэж, зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийн шүүхэд хэргийг хянан хэлэлцдэг.

Иймд хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.6-д зааснаар захиргааны хууль бус актын улмаас зөвхөн иргэнд төдийгүй хуулийн этгээдэд учирсан хохирлыг нэхэмжлэлийн дагуу шийдвэрлэх нь зүйтэй юм.

Тухайлбал: Мэргэжлийн хяналтын газраас шалгалт хийж “Х” ХХК-ийн дэлгүүрийг бусдын эрүүл мэндэд хортой бүтээгдэхүүн зарсан гэдгээр үйл ажиллагааг нь зогсоох шийдвэр гаргаж энэ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлжээ.

Дэлгүүрийг хааснаас тухайн үед дэлгүүрт байсан хүнсний бүтээгдэхүүн, мах ялзарч муудсан байна.

Улсын байцаагчийн энэ актыг хууль бус гэж үзэж тухайн компани шүүхэд хандсаны дагуу шүүх шийдвэрлэж, байцаагчийн актыг хууль бус гэж үзжээ.

Энэ тохиолдолд нэхэмжлэгч нь өөрт хохирол учирсан гэж үзэж хохирлыг дараах байдлаар нэхэмжилсэн байна.

- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлснээс тухайн дэлгүүрийн нэр хүндэд муугаар нөлөөлж, үйлчлүүлэгч бараг байхгүй болсон тул нэр хүндээ сэргээлгэх, /хохирлоо мөнгөөр нэхэмжилж болох/
- Муудсан хүнсний бүтээгдэхүүний тооцоог гаргаж, төлүүлэхээр нэхэмжлэх эрхтэй байна.

Захиргааны хэргийн шүүх нэхэмжлэгчийн шаардлагын дагуу хохирлыг:

- бүхэлд нь нэхэмжлэлийн дагуу гаргуулах,
- хохирлын хэмжээг өөрчлөх,
- хасах шийдвэрийг шүүх гаргаж болно.

А.Тухайн хохирлын тооцоог гаргаж шүүхэд нэхэмжлэх эрхтэй ба хариуцагч хохирлын хэмжээний талаар маргаагүй, нэхэмжилж байгаа хохирол нь нотлох баримтаар нотлогдож тогтоогдсон бол шүүх нэхэмжлэлд заасан хэмжээгээр өөрөөр хэлбэл учирсан хохирлыг нэхэмжилсний дагуу бүгдийг нь гаргуулахаар нэхэмжлэлийг бүхэлд нь хангана гэсэн үг.

Б.“Хохирлын хэмжээг өөрчлөх”, “Хохирлын хэмжээг хасах” эдгээр ойлголтыг бүхэлд нь адилтгаж ойлгож болохгүй.

“Өөрчлөх” гэдэг нь өөртөө нэмэгдүүлэх, хасах аль алиныг нь багтаана гэж ойлгож болно.

Гэвч хохирлын хэмжээг шүүх багасна гэдэг нь өөрчлөх гэдэгтэй утга нэг мэт боловч, захиргааны хэргийн шүүхийн нотлох үүрэгтэй холбоотойгоор хохирлын хэмжээ нэмэгдэж болно.

Нэмэгдсэн тохиолдлыг мөн хохирлын хэмжээг шүүх өөрчлөн тогтоох гэдгээр ойлгоно.

Шүүх зөвхөн нэхэмжлэгчээс гаргасан шаардлагын хэмжээнд /диспозитив зарчим/ хэргийг хянан шийдвэрлэх ёстой бөгөөд шалгалтаар хохирлын хэмжээ нэмэгдэхээр байгааг нэхэмжлэгч өөрөө зөвшөөрч түүнийг гаргуулахаар нэхэмжлэх тохиолдолд шүүх нэмэгдүүлэн өөрчилж болох бөгөөд нэхэмжлэгч үүнийг хүсээгүй анхны нэхэмжлэлээр шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргавал шүүх үүнийг нэмэгдүүлэх эрхгүй гэж ойлгоно.

Хохирлын хэмжээг шалгаад нэхэмжилсэн хэмжээнээс илүү болох нь тогтоогдвол энэ талаар хэргийн оролцогч ялангуяа нэхэмжлэгчид мэдэгдэхдээ болгоомжтой хандах шүүх хэн нэг талд нь илт илүү байдлаар хандаж байна гэсэн сэтгэгдэл төрүүлэхгүйгээр ажиллах шаардлага гарна.

Ямар ч тохиолдолд шүүх нэхэмжлэлийн хүрээнд асуудлыг шийдвэрлэнэ гэдэг ерөнхий зарчмаасаа ухрах эрхгүй, талуудад эрх, тэгш хандах зарчмыг анхаарах ёстой.

Хуулийн агуулгаас үзвэл 70 дугаар зүйлийн 70.2-д шүүхээс 9 төрлийн шийдвэр гарахыг хуульчилсан байх бөгөөд хуулийн 70 дугаар зүйлийн 70.4 нь нэхэмжлэлийн шаардлагатай холбоотой, шүүхийн шийдвэрийн төрөл биш бөгөөд зөвхөн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны улмаас хохирол учирсан нь тогтоогдож, үүнийг нөхөн төлүүлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.6-д заасан

агуулга бүхий хэрэв хохирлын хэмжээний талаар маргаан гарвал иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлэхийг зохицуулсан заалт гэж ойлгогдоно.

Практикт нэхэмжлэлийн шаардлагын дагуу шүүх захиргааны акт хууль бус гэж үзэж, түүний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүх шийдвэрлэх тохиолдол олонтаа гардаг. Өөрөөр хэлбэл хэд хэдэн нэхэмжлэлийн шаардлага гаргаж байгаа тохиолдолд дээрх шийдвэр гарах юм.

Ийнхүү шийдвэр гаргахдаа хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.1-70.2.4 дэх хэсгийн аль тохирохыг 70.2.6 дахь зүйлтэй давхар баримтална.

Харин хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.6-д зааснаар бие даасан нэхэмжлэл гаргасан бол хуулийг давхар баримтлах шаардлагагүй, зөвхөн хуулийн 70.2.6 дахь заалт дангаар хэрэглэгдэнэ. .

Захиргааны акт хууль бус гэдгийг зөвшөөрсөн боловч, /эсхүл зөвшөөрөөгүй байж ч болно/ хохирлын хэмжээний талаар маргаан гаргавал хуулийн 70 дугаар зүйлийн 70.4-т зааснаар хохирлын талаарх нэхэмжлэлийг тусгаарлан иргэний хэргийн шүүхэд шилжүүлнэ гэсэн үг.

Ингэхдээ шүүх тусгаарлах талаар тусад нь ямар нэг эрхийн акт гаргах шаардлагагүй бөгөөд энэ талаар шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт дурьдана.

Энэ асуудлаар ИХШХШТХ-д заасан журмын дагуу ердийн журмаар нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлнэ гэсэн үг юм.

2.6./Хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.7/ Энэ зохицуулалт нь захиргааны байгууллагын үйл ажиллагаанд шүүх аль болохоор хөндлөнгөөс оролцохгүй байхын нэг баталгаа гэж хэлж болно.

“Хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай” гэдгийг шүүх өөрийн санаачилгаар тогтоохгүй бөгөөд захиргааны байгууллага энэ талаар өөрөө санаачилж, шалгах хүсэлтээ шүүхэд гаргасан байх нөхцөл байдлыг ойлгоно.

Улсын Дээд шүүхийн 2006 оны 37 дугаар тогтоолд: “Хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.7-д заасан “...хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай гэж үзвэл захиргааны байгууллага, албан тушаалтнаас дахин шинэ акт гартал захиргааны уг актыг түдгэлзүүлэх” ажиглагаар хариуцан өөрөө маргаан бүхий захиргааны актыг алдаатай гарсныг хүлээн зөвшөөрч, нөхцөл байдлыг шалган тогтоож, шинээр захиргааны акт гаргах боломжтой гэж үзсэн тохиолдолд шүүх маргаан бүхий захиргааны актын хэрэгжилтийг түдгэлзүүлэх бөгөөд захиргааны байгууллага албан тушаалтнаас шинээр гаргасан захиргааны актад хуульд заасан ердийн журмаар гомдол гаргаж болно” гэж заажээ.

Практикт шүүх өөрөө хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай гэж тогтоож байгаа нь буруу бөгөөд захиргааны байгууллагаас гаргасан акт нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн тохиолдолд уг актыг гаргахдаа нөхцөл байдлыг тодруулж шалгах ажиглагаа дутуу байна гэж захиргааны байгууллага, албан тушаалтан өөрөө хүлээн зөвшөөрөөгүй бол уг актыг хууль бус гэж үзэх үндэслэл болох юм.

Харин энэ талаар шалгах нь зүйтэй гэдгээ захиргааны байгууллага өөрөө хүсвэл шүүх хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.7-д зааснаар шийдвэр гаргаж болох юм. Уг шийдвэр нь тухайн хэргийн хувьд эцсийн шийдвэр болно.

Энэ нь хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн гэсэн үг биш бөгөөд захиргааны байгууллага, албан тушаалтан нь өөрийн гаргасан захиргааны актын үндэслэлийг тодруулж, шалгах шаардлагатай гэж үзэж байгаа гэсэн үг юм.

Нөхцөл байдлыг дахин шалгаад өмнөх захиргааны акт нь тухайн захиргааны байгууллага албан тушаалтан өөрчлөх шаардлагагүй гэсэн нь иргэн хуулийн этгээдээс шүүхэд уг асуудлаар дахин нэхэмжлэл гаргахад саад болохгүй гэдгийг анхаарвал зохино. Энэ тохиолдолд нэхэмжлэлийг ердийн журмаар гаргана.

Дахин шинэ акт гарган захиргааны уг актыг түдгэлзүүлэх нь эрх зүйн түр хамгаалалтын нэг болох захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхээс огт өөр шийдвэр юм.

Жишээ: 1.Нэхэмжлэгч Б нэхэмжлэлдээ: “Бид Гааль болон Онцгой татварын хууль судлан “ачааны” автомашинд онцгой татвар төлөхгүйг мэдэн Солонгос улсаас “....” маркийн бага оврын ачааны автомашиныг Монголд оруулж иртэл гаалийн улсын байцаагч нар “суудлын автомашин” гэж үзэн онцгой албан татвар төлөхийг шаардаж бидний машиныг өгөхгүй бидний эрхийг зөрчиж байна. Гаалийн улсын байцаагч нарын үйл ажиллагаа хууль бусад тооцож өгнө үү гэжээ.

Хариуцагч нь “...Монгол улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенци, холбогдох хууль эрхийн акт болон гадаад улсын гааль, худалдааны байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох, Монгол Улсын Гаалийн ерөнхий газарт бараа судлал, барааны ангиллын талаар мэргэшин ажилладаг алба, мэргэжилтэнүүдээс зарим зүйлийг тодруулах шаардлагатай.

Дээрх нөхцөл байдлыг тодруулан Онцгой албан татварыг нөхөн төлүүлэх эсэх тухай асуудлыг нягтлан шалгах шаардлагатай байна.” гэжээ.

2. Мөн “... Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2002 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 75 дугаар тушаалаар орон сууцны зориулалтыг өөрчилж, хүнсний барааны дэлгүүр ажиллуулах зөвшөөрлийг иргэн Ш-д олгожээ.

Дүүргийн Засаг даргын захирамжаар уг газрыг албадан чөлөөлөх тухай шийдвэр гаргажээ.

Шүүхэд маргаан ирсний дараа хариуцагч нь иргэн Ш нь газар эзэмших эрхтэй эсэхийг нягтлан шалгах шаардлагатай байна гэсэн тайлбарыг ирүүлж болох юм. Дээрх тохиолдлуудад мөн хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.7-д заасан шийдвэрийг гаргаж болох юм.

2.7./хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.8/ Энэ нь хэд хэдэн шаардлага бүхий нэхэмжлэл гаргасан тохиолдолд, шүүх тэдгээрийг бүхэлд нь хангах боломжгүй гэж үзвэл гаргах шийдвэр юм.

Шүүхээс нэхэмжлэлийн шаардлагад хязгаар тогтоох боломжгүй бөгөөд нэхэмжлэлийн шаардлага болгоныг тухайлбал, хангах үндэслэл бий эсэхийг шалгах шаардлагатай.

Шүүх шийдвэрээ гаргахдаа нэхэмжлэлийг хангаж байгаа шаардлагатай холбоотой хуулийг 70 дугаар зүйлийн 70.2.8-тай давхар баримтлах нь зөв юм.

Жишээ нь: “Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын 2006 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 15, 16, 17 дугаар захирамжуудыг хүчингүй болгож, урьд эрхэлж байсан ажилдаа эргүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах”

тухай Ч-н нэхэмжлэлийн дагуу шүүх 15, 16-р захирамжийг хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзэх;

Р нь төрийн алба хаасан хугацааны зохих нэмэгдэл, зэрэг дэв цалингийн зөрүү гаргуулах, ТЗ-6 зэрэглэлээр цалинжуулахыг Сумын засаг даргын тамгын газарт даалгах, цалингийн зөрүүг гаргуулах нэхэмжлэл гэх мэт хэд хэдэн шаардлага бүхий нэхэмжлэлийн заримыг нь хэрэгсэхгүй болгох тохиолдол юм.

2.8./Хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.9/ Захиргааны акт үндэслэлтэй, нэхэмжлэгчийн ямар ч эрх зөрчигдөөгүй тохиолдолд хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.9-д зааснаар шийдвэр гарна.

Дээрх зүйлээр нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох нь ганц шаардлага бүхий болон хэд хэдэн шаардлага бүхий нэхэмжлэлийн аль аль тохиолдолд байж болно.

2.9.Цаашид иргэн, хуулийн этгээд эрх зүйн хамгаалалт авахын хэрэгцээ, шаардлага хүрээгээ тэлэхийн хэрээр нэхэмжлэлийн өөр бусад төрөл байж болох талаар зарим судлаачдын бүтээлд дурьдсан байна¹²².

Ямар ч тохиолдолд шүүх нэхэмжлэлийн хүрээнээс хальж огт болохгүй. Нэхэмжлэлийн шаардлагаас өөр байдал тогтоогдвол шүүх яах ёстой вэ гэдэг асуулт гарна.

Юуны өмнө нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх эрхтэй талаар шүүх нэхэмжлэгчид ИХШШТХ-ийн 104 дүгээр зүйлд заасан эрх, үүргийг нь тодорхой тайлбарлаж өгнө.

Нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн төрлүүдийг мэдэхгүй байж болно. Энэ байдлаасаа болж нэхэмжлэгч хохирох ёсгүй. Шүүх үүнд туслах ёстой гэдэг талаар өмнө нь дурьдсан.

Анхан шатны шүүх хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.1-70.2.9, 70.4-т зааснаар шийдвэр гаргахдаа шийдвэртээ үндэслэлээ маш тодорхой зааж өгөх нь зүйтэй. Энэ талаар доор дэлгэрэнгүй тайлбарля.

3./Хуулийн 70 дугаар зүйлийн 70.3/ Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт эрүү, иргэний шүүхийн шийдвэрт тавигддаг хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх үндсэн шаардлага болон найруулга зүй, баримт бичгийн стандартын шаардлага нэг адил тавигдана.

Шүүхийн шийдвэрт тавигдах үндсэн шаардлагын талаар Улсын Дээд шүүх албан ёсны тайлбар гаргасан байна¹²³.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Шүүхийн тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ”.

Мөн зүйлийн 2.2-т “Захиргааны хэргийн шүүх маргааныг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль болон Монгол Улсын олон улсын гэрээг баримтална” гэж тус тус заасан байна. /холбогдох зүйлийн тайлбарыг үз/

Шүүх шийдвэрээ гаргахдаа зөвхөн хуульд захирагдана.

¹²² А.Эрдэнэцогт, Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй, 2006, 234

¹²³ Улсын Дээд шүүхийн тогтоол 2006 оны 21 дүгээр тогтоол

Иймд хэрэг, маргааны талаар материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээг тэдгээрийн агуулга, зорилгод нийцүүлэн, шүүхээс оновчтой, зөв хэрэглэсэн тохиолдолд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хууль ёсны байх шаардлага хангагдана.

Хэрэг, маргааныг шийдвэрлэж буй шүүх Үндсэн хуулиас бусад хуулийн талаарх Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбарыг хуулийн зүйл, заалтыг оновчтой зөв тайлбарлан хэрэглэхэд ашиглах ба харин тэрхүү тайлбарыг хэрэг, маргааны талаар шийдвэр гаргах үндэслэл болгож баримтлахгүй талаар ИХШХШТХ-ийн дэлгэрэнгүй тайлбарт дурьджээ.

Тухайн харилцааг зохицуулсан хуулийн зүйл, заалт хоорондоо зөрчилтэй байвал шүүх нарийвчилсан зохицуулалттай хэм хэмжээг хэрэглэнэ. Нарийвчилсан зохицуулалт гэдэг нь хэлэлцэж буй тухайн асуудлын ерөнхий зарчим, онцлог, ухагдахууныг тодорхойлсон хэм хэмжээг хэлэх ба энэхүү зохицуулалтын үйлчлэл нь тухайн асуудалтай холбоотой тохиолдол бүрт хамаарна.

Захиргааны эрх зүйн маргаантай харилцааг зохицуулсан хууль байхгүй бол шүүх төсөөтэй харилцааг зохицуулж байгаа хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ.

Иргэний болон захиргааны эрх зүйн маргаантай харилцааг зохицуулсан хууль байхгүй бол шүүх төсөөтэй харилцааг зохицуулж байгаа хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ.

Хуулийг оновчтой зөв хэрэглэх нь шүүгчийн үр чадвараас ихээхэн шалтгаална.

Хуулийг оновчтой зөв хэрэглэж чадаагүйгээс шүүхийн шийдвэр зорилгодоо хүрч чадахгүй бөгөөд, шүүхийн шийдвэрийн үр дагавар хэргийн оролцогч төдийгүй нийтийн эрх ашигт сөргөөр тусах, уг шийдвэр нь хууль ёсны байх хуулийн шаардлага хангаагүй нь давах болон хяналтын шатны шүүхээс тухай шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болдог байна.

Тухайн маргаантай харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ байхгүй, эсхүл байгаа нь тодорхой бус, түүнчлэн хуулийн зүйл, заалт хоорондоо зөрчилтэй, шударга ёсонд нийцэхгүй байна гэсэн үндэслэлээр шүүх хуулийн хэм хэмжээг хэрэглэхээс, хэргийг хянан шийдвэрлэхээс татгалзаж болохгүй.

Одоогийн практикт зарим шүүх захиргааны хэргийг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хуулийг баримталж хэргийг шийдвэрлэж байгаа нь буруу юм.

Шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх хуулийн шаардлага гэдэгт юуг ойлгох вэ? Юуны өмнө хуулийн 70 дугаар зүйлийн 70.3 дахь хэсгийн тодорхойлолтоос үзэхэд энэ нь нотлох баримттай холбож яригдах асуудал гэдэг нь тодорхой байна. Тухайлбал “шүүх шийдвэрээ хэрэгт авагдсан, шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтыг үндэслэн гаргана” гэж уг зүйлд тодорхойлжээ.

Иймд нотлох баримтад тавигдах хуулийн шаардлагын талаар дурьдахгүй өнгөрч болохгүй.

Энэ талаар хуулийн 30 дугаар зүйлийн тайлбараас тодорхой үзэх хэрэгтэй.

Шүүх хэрэгт хамааралтай бөгөөд хуульд заасан арга хэрэгслээр олж авсан, хэрэгт авагдсан ба шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, шүүхээр судлан шинжлэгдсэн нотлох баримтаар хэрэгт ач холбогдол бүхий бүх нөхцөл байдал тогтоогдсон хийгээд эдгээр нөхцөл байдлын талаар шүүхийн бүрэн, бодитой дүгнэлтийг агуулсан шийдвэр үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангана.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл болж буй нотлох баримтууд нь тухайн хэрэгт хамааралтай байх гэдэг нь нэхэмжлэлийн шаардлага болон түүнийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа татгалзлыг тогтооход ач холбогдолтой бөгөөд шалтгаант холбоотой байх шинжийг илэрхийлнэ.

Хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтууд нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасны дагуу хуулиар зөвшөөрөгдсөн арга хэрэгсэл, хэлбэрээр гаргасан, цугларсан, бүрдсэн тохиолдолд шүүхийн шийдвэрийн үндэслэл болох боломжтой болно.

Хуулиар зөвшөөрөгдөөгүй арга хэрэгслээр олж авсан, хуульд заасан хэлбэрээр бэхжүүлэгдээгүй, гэрчлэгдээгүй баримтыг шүүх нотлох баримт гэж үзэж, шийдвэрийн үндэслэл болгож болохгүй. Улсын Дээд шүүхийн 2006 оны 37 дугаар тогтоолд: 1. Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4-т "...хуульд заасан журмыг зөрчиж авсан нотлох баримт..." гэдгийг ИХШХШТХ-ийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" Улсын Дээд шүүхийн 2002 оны 263 дугаар тогтоолын 11 дэх заалтын дагуу ойлгоно. Мөн зүйлийн 31.8-д заасан "...хуулиар зөвшөөрөгдөөгүй баримт..." гэдэгт ИХШХШТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.2-т тодорхойлон зааснаас бусад баримт, сэлтийг хэлнэ.

Хуулиар зөвшөөрөгдөөгүй нотлох баримтыг шүүх шаардан гаргуулж болохгүй бөгөөд хэргийн оролцогчдоос уг баримтыг бүрдүүлж ирүүлсэн тохиолдолд шүүгч захирамж гаргаж тэдгээрийг нотлох баримтаас хасна" гэж заасныг анхаарна уу.

Дахин нотлох шаардлагагүй баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болж болно. Энэ нь "шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тооцогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй" гэсэн зарчимд харшлахгүй.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4-т зааснаар нийтэд илэрхий үйл баримт хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй. Нийтэд илэрхий үйл баримт гэдэг нь шүүхэд болон хэргийн оролцогчдод илэрхий байхаас гадна тухайн үйл баримтын талаар мэдээлэлтэй байх боломжтой тодорхой хүрээний хүмүүст илэрхий байхыг хэлнэ.

Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон үйл баримтыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4-т зааснаар өөр хэрэгт дахин нотлох шаардлагагүй.

Иргэний болон захиргааны хэргийн талаар гаргасан хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон үйл баримтыг захиргааны өөр хэргийг шийдвэрлэхэд нотлогдсон гэж тооцно.

Гэхдээ эдгээр үйл баримт нь түрүүчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон этгээдийн хувьд өөр хэрэгт хэргийн оролцогчоор орж байгаа тохиолдолд нотлогдсон гэж үзнэ.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй этгээдийн хувьд хүчин төгөлдөр шийдвэрээр нотлогдсон үйл баримтын талаар өөр хэрэгт маргах эрх нь нээлттэй ба шүүх тухайн хэрэгт цугларсан баримтыг хянан хэлэлцэж, шийдвэр гаргана.

- Арбитрын хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт нотлогдсон үйл баримтыг тухайн этгээдүүдийн оролцоотой захиргааны хэрэг хянан хянан шийдвэрлэх ажиллагаанд дахин нотлохгүй.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримт нь хуульд заасан журмын дагуу бэхжигдэж, гэрчлэгдсэн байхаас гадна хуулиар зөвшөөрөгдсөн хэлбэрээр хэрэгт авагдсан байна.

Хэрэгт авагдаагүй нотлох баримтад үндэслэгдсэн шийдвэр үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангахгүй гэж үзнэ.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл болж буй нотлох баримт шүүх хуралдаанаар заавал хянан хэлэлцэгдсэн байна. Хэрэгт авагдсан боловч шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдээгүй нотлох баримт шийдвэрийн үндэслэл болсон байвал шүүх хуралдааныг шууд явуулах шүүн таслах ажиллагааны үндсэн зарчмын нэг зөрчигдсөнд тооцно.

Хууль ёсны бөгөөд үндэслэлтэй байна гэдэг нь 2 өөр ойлголт боловч салшгүй холбоотой. Үндэслэлгүй шийдвэр ямагт хууль бус байдаг бол хууль бус шийдвэр түүнийг үндэслэлгүй болгодогос холбоог нь ойлгож болно.

Үүнээс гадна шийдвэрт дурьдсан дүгнэлт нь хэргийн бодит байдалтай нийцсэн байх ёстой гэдгээр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлага хангагдана.

Зарим тохиолдолд шийдвэр үндэслэлтэй боловч хууль ёсны байх шаардлагыг хангаагүй тохиолдол байна.

Энэ нь шүүхийн шийдвэрт шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурахгүй байх, шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцуулахгүй хийх, шүүх бүрэлдэхүүнд орж байгаа шүүгчийн нэрийг шийдвэрт буруу бичих гэх мэт.

Шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаагүй нь давж заалдах болон хяналтын шатны шүүхээс түүнийг хүчингүй болгох үндэслэл болно.

71 дүгээр зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хэл

- 71.1. Захиргааны хэргийн шүүх шийдвэрээ монгол хэлээр, тус улсад албан хэргийг хөтөлж байгаа бичгээр гаргана.
- 71.2. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт шүүх бүрэлдэхүүн /шүүгч/ гарын үсэг зурах ба шүүгч гарын үсгээ зурахаас татгалзах эрхгүй.

ТАЙЛБАР

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 1-д “Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн” гэж хуульчилсан байна.

“Монгол Улсын нэрийн өмнөөс” гаргаж байгаа шүүхийн шийдвэр /шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол бусад эрхийн акт мөн адил/ төрийн албан ёсны хэл болох монгол хэлээр, тус улсад албан хэргийг хөтөлж байгаа бичиг буюу кирилл бичгээр гарна.

Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зүйлийн 2-т зааснаар энэ хуулийн 1 дэх заалт нь хүн амын үндэсний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө гэж заасан байна.

2. Зөвлөлдөх тасалгаанд шүүх бүрэлдэхүүн /шүүгч/ зөвлөлдөж шийдвэрээ гаргах бөгөөд шүүхийн шийдвэрийг хэргийг уншиж илтгэсэн шүүгч бичиж боловсруулж шүүх бүрэлдэхүүн гарын үсгээ зурна.

Шүүгч нь зөвлөлдөх тасалгаанд санал өгөхгүй байх эрхгүйтэй адил шүүхийн шийдвэрт гарын үсэг зурахгүй байх эрхгүй юм. Өөрөөр хэлбэл шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр байхын баталгаа нь түүнд шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурснаар илэрнэ.

Гарын үсгээ шүүгчид зөвхөн өөрийн гараар бичих шаардлагатай.

Шүүх бүрэлдэхүүн гарын үсгээ зураагүй, эсвэл шүүх бүрэлдэхүүнд оролцоогүй шүүгч гарын үсгээ зурах нь шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно.

72 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн агуулга

- 72.1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр нь удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсгээс бүрдэнэ.
- 72.2. Удиртгал хэсэгт захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хэзээ, хаана, ямар шүүх гаргаж байгаа, шүүх бүрэлдэхүүн болон шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, захиргааны хэргийн болон шүүх хуралдааны оролцогчийг нэрлэн заана.
- 72.3. Тодорхойлох хэсэгт нэхэмжлэлийн шаардлагын агуулга, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, прокурорын болон иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг тусгана.
- 72.4. Үндэслэх хэсэгт захиргааны хэрэгт байгаа болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг хянан шийдвэрлэхэд үндэс болсон нотлох баримтыг үнэлж дүгнэсэн байдал, захиргааны актын хууль зүйн үндэслэлийг тусгана.

72.5. Тогтоох хэсэгт захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд баримталсан хуулийн нэр, зүйл, хэсэг, заалтыг тодорхой зааж, шүүхэд гаргасан нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэлийг хангасан, эсхүл зарим хэсгийг хангаж, заримыг хэрэгсэхгүй болгосон, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон, түүнчлэн шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийг хуваарилсан байдал, эд мөрийн баримтыг хэрхэх, захиргааны хэрэгт хэд хэдэн нэхэмжлэгч, хариуцагч оролцсон бол нэхэмжлэгч, хариуцагч тус бүр ямар эрх эдэлж, үүрэг хүлээхийг тусгана. Шаардлагатай бол шийдвэр гүйцэтгүүлэх арга, журам, хугацаа, шийдвэрийг давж заалдах журам, хугацааг заана.

72.6. Энэ хуулийн 72.5-д заасан тогтоох хэсэг нь захиран тушаах хэлбэртэй байна.

ТАЙЛБАР

1. Захиргааны процесс нь иргэний процессоос ялгаатай тул гарах шийдвэр нь ч гэсэн өөрийн өвөрмөц онцлогтой байх ёстой.

Хуулийн 70 дугаар зүйлд захиргааны хэргийг анхан шатны шүүх хуралдаанаар хэлэлцээд гаргах шүүхийн шийдвэрийн төрлүүдийн талаар зохицуулсан бол энэ зүйлд дээрх шийдвэр нь ямар бүтэцтэй болохыг тодорхойлжээ.

Шүүхийн шийдвэрийн бүтэц, агуулгад тавигдах шаардлага нь шүүхийн шийдвэрийн зорилгоор тодорхойлогддог. Энэ нь шүүхийн шийдвэр хэргийн оролцогчдоо ойлгомжтой тэдний зүгээс хүлээн зөвшөөрхүйц байдлаар томъёологдсон байхыг шаардана.

Шийдвэр хэр сайн томъёологдсоноос хэргийн оролцогчид давж заалдах эсхүл хяналтын журмаар гомдол гаргах эсэх нь хамааралтай байдаг.

Хуулийн 72 дугаар зүйлд шүүхийн шийдвэрийн удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсэгт заах зүйлийг тодорхой заажээ.

Шүүхийн шийдвэрийг боловсруулахдаа түүнд эдгээр зүйлийг хуульд заасан дарааллын дагуу тусгасан байвал зохино.

/Шүүхийн шийдвэрийн агуулгын тухай Улсын Дээд шүүхийн 2006 оны 21 дүгээр тогтоолд тодорхой заасныг үзэх /

2. Аливаа шүүхийн шийдвэр нь тухайн шүүхээс ямар эрхийн акт гаргаж байгаа тэр нэрээр нэрлэгдсэн байна. /шийдвэр, шийтгэх тогтоол, шүүхийн захирамж... гэх мэт/

Шүүхийн шийдвэрийн удиртгал хэсэг нь “Монгол Улсын нэрийн өмнөөс” гэсэн гарчгаас эхэлнэ.

Энэ нь хуулиар тогтоосон гарчиг гэдгийг 70 дугаар зүйлийн тайлбарт дурьдсан байгаа.

Удиртгал хэсэгт дурьдах зүйлийг дарааллын дагуу дараах байдлаар заана. Үүнд:

- гарчиг
- шүүхийн шийдвэрийн гарсан он сар өдөр
- шийдвэрийн дугаар

- шийдвэрийг хаана гаргаж байгаа
- шийдвэр гаргаж байгаа аймаг, хотын нэр
- шийдвэр гаргаж байгаа шүүхийн нэр
- шийдвэр гаргаж байгаа шүүх бүрэлдэхүүн болон шүүгчийн нэр /шүүх хуралдааныг бүрэлдэхүүнтэй хийж байгаа бол шүүх хуралдаан даргалагч болон бүрэлдэхүүнд орж байгаа шүүгчийн овгийн эхний үсэг, нэрийг бүтнээр нь/
- шүүх хуралдааны нарийн бичгийн даргын овгийн эхний үсэг, мөн нэрийг нь бүтнээр
- шүүх хуралдаанд хэргийн болон шүүх хуралдааны оролцогч /хэргийн болон бусад оролцогч/-ийн овог, нэр, оршин суугаа газар эсхүл ажил, албан тушаалыг тодорхой бичих /шүүх хуралдаанд оролцогчийн талаарх хуулийн 16 зүйлийн тайлбарыг үзэх/

Үүнийг дэлгэрэнгүй авч үзье.

Шүүх хуралдааны шийдвэр хэдийд ёсчлогдон бэлэн болох эсэхээс үл хамаарч огноо нь хуралдаан болсон өдрөөр шүүхийн шийдвэрт тусгагдах ёстой.

Тухайлбал шүүх хуралдаан 2007 оны 01 дүгээр сарын 10-нд болж, шийдвэрийг 01 дүгээр сарын 17-ны өдөр бэлэн болгосон гэж үзвэл шүүхийн шийдвэр гарсан огноо нь 01 дүгээр сарын 10-н болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар тухайн шүүхийн хувьд нэгдсэн байна. Нарийн бичгийн даргын дансанд бүртгэгдсэн эрэмбээр шийдвэрийг дугаарлана.

Шүүхийн шийдвэрийн дугаар, шүүх хуралдааны тэмдэглэлийн дугаартай адил байна.

Шүүхийн шийдвэрийг хэрхэн дугаарлах, уг дугаарын бүртгэлийг ямар албан тушаалтан хариуцаж бүртгэх, хөтлөх, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс шүүхийн шийдвэр хүчингүй болж, хэргийг дахин хянан шийдвэрлэх тохиолдолд шүүхийн шийдвэрийг хэрхэн дугаарлах зэрэг асуудлыг тухайн шүүх дотооддоо журам боловсруулан мөрдөж ажиллах нь зүйтэй.

Шүүхийн шийдвэрийг дугаарлах нь шүүхийн ажлын үзүүлэлт болох статистик мэдээ гаргахад чухал ач холбогдолтой юм.

Удиртгал хэсэгт тухайн шийдвэрийг аль шүүх гаргасан нь тодорхой байх үүднээс шүүхийг заах нь хэргийн харьяалал, нутаг дэвсгэрийн харьяаллын хувьд зөв эсэхийг шалгахад ач холбогдолтой.

Шүүгч болон бүрэлдэхүүнийг заах нь шүүх хэргийг дангаар эсхүл бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн эсэхийг шалгахад тустай.

Хэргийн оролцогчийн талаар эргэлзээ гаргахгүй үүднээс тэднийг маш тодорхой өөрөөр хэлбэл тухайн шийдвэр хэнд хамааралтай болохыг тодорхой заах.

Түүнчлэн удиртгал хэсэгт хуульд зааснаас гадна хэнд холбогдох ямар төрлийн маргаантай хэргийг шийдвэрлэх гэж байгааг зааснаар удиртгал хэсэгт заах зүйлүүд дуусгавар болно.

Шийдвэрийг хаана гаргаж байгаа гэдэгт тухайн шүүх хуралдааныг хийсэн байр, танхимыг заахыг ойлгоно. Тухайлбал “шүүх хуралдааны танхимд”, “...сургуулийн хурлын танхимд” гэх мэт.

ЗХХШТХ-ийн 16 дугаар зүйлд заасан оролцогчдын төлөөлөгчдийг удиртгал хэсэгт ямар байдлаар зааж өгөх ёстой вэ? гэдэг асуулт зүй ёсоор гарна.

Тухайлбал удиртгал хэсэгт төлөөлөгчдийг заахдаа тэд албан ёсны итгэмжлэлтэй эсэх нь чухал биш учраас хэргийн оролцогчдын хүсэлтээр өөрсдийнх нь нэрлэснээр заах учиртай.

Төлөөлөх эрхтэй этгээд оролцсон эсэх тухай асуудлыг шүүх хэргийг хянан хэлэлцэх явцад шалгах учиртай.

Эндээс хуулийн 34.1.5-д заасан үр дагавар үүснэ гэдгийг анхаарах шаардлагатай.

Өнөөгийн шүүхийн практикт захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн удиртгал хэсгийг дараах байдлаар томъёолж байгаа нь хуульд нийцэж байна:

Тохиолдол:

“Газар чөлөөлөх тухай Баянзүрх дүүргийн газрын албаны шаардлага болон газар өмчлөх эрхийг хүчингүйд тооцсон Нийслэлийн Засаг даргын 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 354 дүгээр захирамжийн хавсралтад заасан Д-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах” тухай нэхэмжлэлийг иргэн Д Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхэд гаргажээ.

Энэ тохиолдлоор шүүхийн шийдвэрийн удиртгал хэсгийг томъёолбол:

Монгол Улсын нэрийн өмнөөс

2007 оны 01 сарын 1-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шүүх хуралдааны даргалагч Б, шүүгч Ж,Э нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн шүүх хуралдааны танхимд хийсэн шүүх хуралдаанаар

нэхэмжлэгч Баянзүрх дүүргийн 6 дугаар хороо, 1 дүгээр хороолол, 30 дугаар байр, 15 тоотод суух, эмэгтэй Д овогтой С-ийн нэхэмжлэлтэй

хариуцагч Баянзүрх дүүргийн Засаг дарга болон Нийслэлийн Засаг даргад холбогдох /хэргийн оролцогчид/

“Газар чөлөөлөх тухай Баянзүрх дүүргийн газрын албаны шаардлага болон газар өмчлөх эрхийг хүчингүйд тооцсон Нийслэлийн Засаг даргын 2006 оны 7 сарын 20-ны өдрийн 354 дүгээр захирамжийн хавсралтад заасан Д-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай хэргийг хянан хэлэлцэв.

Шүүх хуралдаанд:

Нэхэмжлэгч /түүний төлөөлөгч, өмгөөлөгч/

Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч түүний өмгөөлөгч

Гуравдагч этгээд /түүний төлөөлөгч, өмгөөлөгч/

Прокурор

Иргэдийн төлөөлөгч

Шинжээч

Гэрч

Нарийн бичгийн дарга ... нар оролцов.

Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгч Э даргалж тус шүүхийн шүүх хуралдааны танхимд хийсэн шүүх хуралдаанаар

Нэхэмжлэгч: Баянзүрх дүүргийн 6 дугаар хороо 10 дугаар хороолол 6-57 тоотод суух, эрэгтэй, Б овогтой С-н нэхэмжлэлтэй

Хариуцагч: Баянгол дүүргийн Засаг даргад холбогдох

Гуравдагч этгээд: Баянгол дүүргийн 8 дугаар хороо 3 дугаар хороолол 10-17 тоотод суух, эмэгтэй, Ц овогтой Д-гийн бие даасан шаардлагатай

"Газар өмчлөх эрхийг хүчингүй болгосон Баянгол дүүргийн Засаг даргын 2006 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн захирамжийг хүчингүй болгуулах тухай маргаантай хэргийг хянан хэлэлцэв.

Шүүх хуралдаанд: нэхэмжлэгч Б.С; хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Г; бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд Ц.Д; гэрч Л.А; нарийн бичгийн даргаар С.О нар оролцов.

Шийдвэрийн Тодорхойлох хэсэг нь шийдвэрийн хоёр дахь үндсэн хэсгийг бүрдүүлнэ.

Энэ хэсэгт нэг талаас нэхэмжлэлийн шаардлага, шаардлагын талаар нэхэмжлэгч болон түүний төлөөлөгчийн шүүх хуралдаанд гаргасан тайлбар, нөгөө талаас хариуцагчийн татгалзал, татгалзлын талаар хариуцагч болон түүний төлөөлөгчийн гаргасан тайлбар, гуравдагч этгээдийн тайлбарыг шүүх анхааралтай судалсны эцэст тэдгээрийн агуулгыг шийдвэрт тусгана.

Гэхдээ хэргийн оролцогчдын тайлбарыг оновчтой тусгах нь чухал юм.

Шүүх хуралдаанд оролцоогүй хэргийн оролцогчийн тайлбарыг тодорхойлох хэсэгт тусгахдаа өмнө шүүхэд гаргаж байсан тайлбараас авна.

Шаардлага, татгалзал, тайлбаруудад дурьдагдаагүй зүйлийг шийдвэрт нэмж бичих, тэдгээрийн агуулгыг зөв тодорхойлохгүй байх нь шүүхийн алдаанд тооцогдоно.

Талууд маргаж байгаа болон маргахгүй байгаа баримт гэж байдаг. Энэ ялгааг шийдвэрт тодорхой гаргаж өгөх хэрэгтэй.

Тодорхойлох хэсгийн гол зорилго нь нэхэмжлэгчийн хүссэн зүйл, талуудын маргаж байгаа зүйл болон талууд шаардлагынхаа үндэслэлд нотолгоо болгож, ямар нотлох баримт гаргасан зэрэг нь хэргийн оролцогчид төдийгүй хөндлөнгийн хэн бүхэнд төдийгүй давж заалдах хяналтын шатны шүүхэд ч ойлгомжтой байхад оршино.

Тодорхойлох хэсэгт үйл баримтуудыг ямар нэг чимэггүйгээр объектив байдлаар харуулсан байх шаардлагатай.

Энд ямар ч эрх зүйн үнэлэлтийг оруулж болохгүй.

Нэхэмжлэгчийн шаардлагыг зөв тусгаж чадсан тохиолдолд нэхэмжлэгч нь чухам ямар шаардлага гаргаж, юу хүсэж байгааг шүүх ойлгосон эсэх нь харагдана.

Тодорхойлох хэсэг нь шүүх шийдвэрийнхээ үндэслэх хэсгийн үндэслэлээ гаргах үндэс суурь нь болно.

Тодорхойлох хэсэгт бичигдсэн тайлбарыг шийдвэрийн үндэслэх хэсэгт эрх зүйн хувьд шалгасан байх ёстой.

Хэргийн оролцогчийн шүүхэд мэдүүлэх, шүүх хуралдааны ажиллагаанд биеэр оролцох эрх хангагдсан нь тодорхойлох хэсэгт бичигдсэн зүйлээс маш ойлгомжтой харагдах ёстой.

Түүнчлэн Захиргааны хэргийн шүүхийн өөрийгөө сонсгох зарчим энд тодорхой байх ёстой. Тодорхойлох хэсгийг тодорхой бичээгүй тохиолдолд талуудаа “шүүх миний ярьсныг хүлээн авсангүй, ойлгосонгүй” гэж ойлгоход хүргэж болзошгүй гэдгийг анхаарах ёстой.

Энэ бүгдээс дүгнэвэл: тодорхойлох хэсэгт:

- нэхэмжлэлийн шаардлагын агуулга
- нэхэмжлэгч нь шаардлагаа үндэслэж байгаа нотлох баримтыг болон аль нотлох баримтыг шүүх хэрэглэсэн болохыг тодорхой харуулах
- хариуцагчийн тайлбар, өөрийгөө хамгаалж байгаа үндэслэл,

Процесс ажиллагаа хэрхэн явагдсаныг харуулах зорилготой учраас энэ бүгдийг тодорхой тусгасан байх шаардлагатай.

Үүнээс гадна иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт нэхэмжлэлийн шаардлага, нэхэмжлэлийн тайлбар, хариуцагчийн татгалзал, тайлбар, зохигчийн төлөөлөгч буюу гуравдагч этгээдийн тайлбарын агуулгыг тусгадаг бол Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт эдгээрээс гадна өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, прокурорын болон иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг тусгажээ. /Хуулийн 72 дугаар зүйлийн 72.3/

3.1.Нэхэмжлэлийн шаардлагын агуулга гэдэгт: нэхэмжлэгчийн шүүхэд гаргасан нэхэмжлэл, түүний үндэслэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөн бол өөрчлөгдсөн агуулгыг нь шийдвэрийн тодорхойлох хэсэгт тусгана. Энэ бүгдийн агуулгыг шүүгч зөв тодорхойлж, ойлгомжтой бичих шаардлагатай.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалтад нэхэмжлэлийн шаардлага, нэхэмжлэгчийн тайлбар гэж ИХШХШТХуульд зохицуулсан шиг тусад нь бичихээр заагаагүй байна. Гэвч Захиргааны хэргийн шүүх хуралдаанд нэхэмжлэгч болон түүний төлөөлөгч өөрийн биеэр оролцож байгаа тохиолдолд шийдвэрийн тодорхойлох хэсэгт тэдний шүүх хуралдаанд гаргасан тайлбарыг зайлшгүй тусгаж байх нь зөв юм.

3.2.“Хариуцагчийн тайлбар” гэдэгт шүүх хуралдаанд хариуцагчаас гаргаж байгаа тайлбарын агуулгыг тусгана. Хариуцагч шүүх хуралдаанд оролцоогүй гэдэг үндэслэлээр түүний тайлбарыг шийдвэрийн тодорхойлох хэсэгт дурьдахгүй өнгөрч болохгүй. Шүүх хуралдаанаас өмнө шүүхэд гаргасан тайлбарын агуулгыг тусгана.

3.3.Гуравдагч этгээдийн тайлбар гэдэгт захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн тогтоосноор эрх ашиг нь хөндөгдөж болзошгүй гэж үзсэн этгээдийн тайлбарын агуулгыг ойлгоно.

3.4.Хуулийн 72 дугаар зүйлийн 72.3-т “нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн тайлбар” гэж заасан бөгөөд эдгээр нэрлэгдсэн этгээдүүдийн тайлбар бүрийг шүүхийн шийдвэрт тусгах эсэх тухай асуулт гарна.

Өнөөгийн шүүхийн практикт ажиглагдаж байгаа зүйл бол хэргийн оролцогч нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд нь процессын ажиллагаанд өөрийгөө

төлөөлүүлэхээр хэн нэгэн этгээдэд итгэмжлэл олгосон атлаа төлөөлүүлэгч, төлөөлөл хоёр хоёулаа зэрэгцэн оролцож байгаа буруу практик тогтжээ.

Нэгэнт төлөөлөгч томилогдсон тохиолдолд тухайн томилогдсон төлөөлөгч нь процессын ажиллагаанд оролцох ёстой.

Иймд шүүх хуралдаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч аль аль нь хүрэлцэн ирсэн тохиолдолд шүүгч төлөөлүүлэгч болон төлөөлөгчийн хэн нь албан ёсоор шүүх хуралдаанд тайлбараа гаргах талаар тодруулан асууж, тайлбараа гаргасан этгээдийн тайлбарыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт тусгах нь зөв. Тайлбар гаргаагүй этгээдээс шүүх бүрэлдэхүүн шаардлагатай тодруулах зүйлийг асууж, тодруулж болох бөгөөд энэ нь шүүх хуралдааны тэмдэглэлд тусгагдах учиртай.

3.5.Хуульд нэгэнт "...төлөөлөгчийн буюу өмгөөлөгчийн тайлбар..." гэж заасан учир эдгээрийн хэн нэгнийх нь тайлбарыг тодорхойлох хэсэгт тусгана гэж ойлгоно.

3.6.Тодорхойлох хэсэгт гэрчийн мэдүүлгийг заавал тусгахаар заажээ. Шүүх хуралдаанд гэрч оролцож оролцож байгаа тохиолдолд түүний шүүх хуралдаанд өгсөн мэдүүлгийг тодорхойлох хэсэгт тусгана. Тухайн хэрэгт олон гэрч мэдүүлэг өгсөн байж болно. Энэ бүгдийг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт тусгах шаардлагатай эсэх тухай асуулт гарна.

Нэгэнт хуульчлагдсан учир тусгах нь зөв боловч шүүхийн шийдвэрийн агуулгыг ойлгомжгүй нүсэр болгохоос болгоомжилж шүүх зарим гэрчийн мэдүүлгийн агуулгыг шийдвэрийн тодорхойлох хэсэгт дурьдаж, бусдыг нь шүүх хуралдаанаар хэлэлцсэн талаар тэмдэглэх нь зүйтэй юм.

3.7.Шүүх хуралдаанд прокурор оролцсон бол түүний дүгнэлтийн агуулгыг тодорхойлох хэсэгт товч тусгана.

3.8.Иргэдийн төлөөлөгчид шүүх хуралдаанд оролцсон бол мөн дүгнэлтийн агуулгыг товч тодорхой, ойлгомжтой байдлаар шийдвэрийн тодорхойлох хэсэгт тусгах нь зөв юм.

4. "Үндэслэх" хэсэг нь чухал ач холбогдолтой хэсэг. Энэ хэсэгт хамгийн гол их зүйл бичигддэг.

Шүүхийн шийдвэр нь болж өнгөрсөн үйл явдалд дүгнэлт өгөхөөс гадна ирээдүйд болох үйл явдалд нөлөөлөх үр дагавар бий болгодог тул үндэслэх хэсэг маш чухал юм.

Шүүгч бүр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүрсэн үр дүнгээ энгийн хялбар өгүүлбэрээр логикийн хувьд зөв дараалалтай, ойлгомжтой байдлаар илэрхийлэх нь чухал.

Энэ бүхэн шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгтэй хамааралтай. Үндэслэх хэсэгт шүүхийн шийдвэрийн үндэслэл болж буй нотлох баримтуудын хууль зүйн болон бодит үндэслэлийг зааж, тэдгээрийн талаар шүүхийн хийж буй дүгнэлтийг тусгана.

Шийдвэрийн үндэслэх хэсэг нь шүүхээр хэлэлцэгдэж буй эрх зүйн маргааны талаар шүүх ямар дүгнэлт гаргаж байгаа, энэхүү дүгнэлт нь ямар бодит нөхцөл байдалд тулгуурлаж, хуулийн ямар зүйл, заалтад үндэслэсэн гэдгийг илэрхийлдэг тул чухал ач холбогдолтой юм.

Шүүх шийдвэрийн үндэслэх хэсэгт нэхэмжлэлийн шаардлага тус бүрийн талаар дүгнэлт өгөх үүрэгтэй ба хариуцагчаас гарсан шаардлагыг сөрөг нэхэмжлэл гэж үзсэн тохиолдолд түүний талаар мөн дүгнэсэн байвал зохино.

Шүүхэд гаргаагүй шаардлага, үндэслэлийн талаар шүүх дүгнэлт хийх эрхгүйн зэрэгцээ шаардлагын үндэслэл, зүйлээс өөр үндэслэл, зүйлийг шийдвэрлэх, шаардлагын хэмжээнээс илүү хэмжээгээр шийдвэр гаргах эрх шүүхэд байхгүй.

Шүүхийн дүгнэлт нь зөвхөн хуулиар зөвшөөрөгдсөн, хэрэгт хамааралтай, шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн нотлох баримтад тулгуурласан байх учиртай бөгөөд нотлох баримтаар тогтоогдоогүй үйл баримтыг шүүх тогтоогдсон гэж үзэх, хэрэгт цугларсан баримтаар хангалттай бүрэн тогтоогдсон үйл баримтыг тогтоогдоогүй гэж үзэх нь шийдвэрийн үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг зөрчиж буй явдал мөн.

Захиргааны хэргийн шүүх ямар шийдвэр гаргаж байгаа нь шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсгээс тодорхой харагдах ёстой.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэгт дараах зүйлүүдийг заавал тусгана.

Үүнд:

- шийдвэр гаргахдаа үндэслэл болгосон хууль тогтоомжийн нэр
- хуулийн зүйл, заалт, хэсэг
- оролцогчийн тайлбарт өгсөн дүгнэлт
- нотлох баримт үүнийг үнэлж дүгнэсэн байдал
- захиргааны актын хууль зүйн үндэслэл

Шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсгийг дараах 2 аргын аль нэгээр боловсруулж болно. Энэхүү аргачлалыг хуулиар нарийвчлан тодорхойлох боломжгүй боловч одоогийн шүүхийн практикаас тодорхойлж байгаа болно.

Үүнд:

1. шийдвэр гаргах
2. дүгнэлт гаргах аргаар гэж 2 ангилна.

Дээрх 2 аргыг дэлгэрүүлэн авч үзвэл:

Шийдвэр гаргах аргаар шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсгийг боловсруулахдаа эхлээд шууд ямар шийдвэр гаргах гэж байгаагаа бичиж, дараа нь ийм шийдэлд хүрсэн үндэслэлээ тоочих замаар бичдэг байна.

Доорх жишээн дээр авч үзвэл:

ҮНДЭСЛЭХ НЬ :

Захиргааны хэргийн шүүх хэрэгт цугларсан нотлох баримтыг тал бүрээс нь дүгнэн үзээд “Газар чөлөөлөх тухай Баянзүрх дүүргийн газрын албаны шаардлага болон газар өмчлөх эрхийг хүчингүйд тооцсон Нийслэлийн Засаг даргын 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 354 дүгээр захирамжийн хавсралтад заасан Д-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах үндэслэлтэй тул нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэв. Гэж дүгнээд дараа нь ийм шийдвэрт хүрсэн үндэслэлээ тодорхойлж бичнэ.

Тухайлбал

- нэхэмжлэл нь шүүхэд харъяалагдах
- тухайн шүүхэд харъяалагдах
- Урьдчилан шийдвэрлүүлэх журам зөрчсөн эсэх зэргээр нэхэмжлэл нь хуульд заасан шаардлага хангасан эсэх талаар дүгнэж бичээд дараа нь талуудаас ирүүлсэн нотлох баримт, шүүх өөрийн санаачилгаар бүрдүүлсэн нотлох баримтуудад үнэлэлт өгнө.

Нотлох баримтыг дүгнэсэн байдлыг тусгахдаа тухайн нэхэмжлэлийг хангах үндэслэл нь ямар баримтаар тогтоогдож байгааг эсхүл ямар баримтаар үгүйсгэгдэж байгаа зэрэгт үнэлэлт өгөх ёстой.

Түүнчлэн захиргааны актад тавигдах шаардлага хангагдсан эсэхэд анхаарлаа хандуулбал зохино.

2 дахь аргаар шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсгийг үйлдэх тохиолдолд дээрхээс эсрэгээр өөрөөр хэлбэл эхлээд бүх дүгнэлтээ бичиж, дээрх дүгнэлтээс нэхэмжлэлийг хангах, эсхүл хэрэгсэхгүй болгож байгаагаа бичдэг. Манайд энэ арга нь илүү өргөн хэрэглэгддэг байна.

5. Шүүхийн шийдвэр нь хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэж буй шүүх эрх мэдлийн акт учир түүний тогтоох хэсэгт шийдвэрийн үндэслэх хэсэгт дурьдсан дүгнэлтийн үр дагаврыг тусгахаас гадна шүүхийн шийдвэр ойлгомжтой, тодорхой, биелэгдэх боломжтой байх бүх нөхцөлийг заасан байвал зохино.

Захиргааны хэргийн талаар гаргасан шийдвэрийн тогтоох хэсэгт тусгагдах асуудлын хүрээг хуульд тодорхой заажээ.

Шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг, сөрөг нэхэмжлэл гаргасан бол сөрөг шаардлагыг шүүх хэрхэн шийдвэрлэсэн, хэн ямар үйлдлийг хэнд ашигтайгаар гүйцэтгэх үүрэгтэйг, мөн маргаантай байсан эрхийг хэн эдлэх талаар шийдвэрийн тогтоох хэсэгт тодорхой тусгасан байна.

Шүүх эдгээр болон хуульд заасан бусад асуудлыг шийдвэрийн тогтоох хэсэгт тусгахдаа тухайн шийдвэрийг биелүүлэхэд ямар нэгэн хүндрэл учруулахгүй байхад онцгой анхаарвал зохино.

Хэргийн оролцогчдын шаардлагыг бүхэлд нь эсхүл заримыг нь хэрэгсэхгүй болгож байгаа бол шүүх хэнд хамааралтай, хэний, ямар шаардлагыг хэрэгсэхгүй болгож байгааг тодорхой заахаас гадна хуулийн холбогдох зүйл, заалтыг баримтална.

Шийдвэрийн тогтох хэсэг нь шийдвэр гүйцэтгэхэд чухал. Учир нь тухайн шийдвэр эрх зүйн ямар үр дагавартай болох нь тогтоох хэсгээс шууд эргэлзээгүй харагдаж байх ёстой.

Хуулийн 72 дугаар зүйлийн 72.5-д “шаардлагатай бол шийдвэр гүйцэтгүүлэх арга, журам, хугацаа...”-г тогтоох хэрэгт заахаар заасан байгаа боловч хуулийн 78 дугаар зүйлийн 78.2-т “...шийдвэрээ биелүүлэх арга журмыг гаргасан шийдвэртээ тодорхойлно” гэж заасанд анхаарлаа хандуулах нь чухал

Өөрөөр хэлбэл энэ тухай заахыг хуулийн 78.2-т зааснаар шүүхэд үүрэг болгожээ.

/холбогдох зүйлийн тайлбараас дэлгэрэнгүй үзнэ үү/

Мөн зүйлд /хуулийн 72 дугаар зүйлийн 72.5/ шаардлагатай бол давж заалдах журам, хугацааг шүүхийн шийдвэрт заана гэснийг энэ талаар шүүхийн шийдвэрт заавал тусгана гэж ойлгож хэрэгжүүлэх хэрэгтэй.

73 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг
уншиж сонсгох, хүргүүлэх

73.1. Шүүх хуралдаан даргалагч шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг хуралдаанд оролцогчдод уншиж сонсоно.

- 73.2. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг уншиж сонсгосноос хойш 7 хоногийн дотор хувийг хэргийн оролцогчдод хүргүүлнэ.
- 73.3. Нэхэмжлэгч, эсхүл хариуцагчийн оролцоогүйгээр гаргасан шийдвэрийг тэдэнд энэ хуулийн 73.2-т заасан хугацаанд хүргүүлнэ.

ТАЙЛБАР

1. Зөвлөлдөх тасалгаанд шүүхийн шийдвэрийн гол үндэслэл, шүүхээс шийдвэрлэвэл зохих асуудлыг хэлэлцэн олонхын саналаар шийдвэрлэж, шүүх бүрэлдэхүүн шийдвэрээ гаргаж, шүүгч /шүүх бүрэлдэхүүн/ гарын үсгээ зурж баталгаажуулна.

Зөвлөлдөх тасалгаанд шүүхийн шийдвэрийг тэр бүр бүрэн хэмжээгээр нь боловсруулах боломж байдаггүй.

Бүрэн хэмжээгээр боловсруулагдаагүй шүүхийн шийдвэрийг шүүх хуралдаанд оролцогчдод сонсгох зорилгоор гарын үсгээ зурах шаардлага байгаа эсэх талаар ойлгомжгүй санал гарч болох авч ямар ч тохиолдолд гарын үсэг зурсан байх ёстой. .

Энэ нь шийдвэрийг зөвлөлдөх тасалгаанд гаргахтай холбоотой. Жинхэнэ утгаар нь ёсчлон гаргах асуудал бол өөр. Дараагийн хэсгийн тайлбарт энэ талаар тусгасан.

Шүүх хуралдаан даргалагч шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хэрхэн шийдвэрлэснийг шийдвэрийн тогтоох хэсэгт тусгагдсанаар тайлбарлана.

Хуульд нэгэнт "...тогтоох хэсгийн агуулгыг уншиж сонсоно" гэж хуульчилсан учраас шүүхийн шийдвэрийг бүхэлд нь үг үсэггүй уншиж сонсгох шаардлагагүй.

Шүүхийн шийдвэрийг ёсчлохдоо түүний тогтоох хэсгийн агуулгыг хэргийн болон шүүх хуралдааны оролцогчдод сонсгож, тайлбарласнаас өөр утга, агуулгаар шийдвэрт тусгаж болохгүй.

Шүүх хуралдаан даргалагчийн сонсгосон дээрх танилцуулга, тайлбарыг шүүх хуралдааны тэмдэглэлд тодорхой тусгавал зохино.

2. Шүүх шийдвэрээ бүрэн эхээр нь бэлэн болгож, ёсчлон хэргийн оролцогчдод хүргүүлэх нь түүнийг уншиж сонгосноос хойш 7 хоногийн хугацаанд багтах талаар хуулиар зохицуулжээ.

Иймд дээрх хугацаанд шийдвэрийг бэлэн болгож, хүргүүлсэн байх шаардлагатай.

Шүүгч болон шүүх бүрэлдэхүүн түүнд гарын үсэг зурж, шүүхийн тамга дарагдсанаар шийдвэр ёсчлогдоно.

Зөвхөн ёсчлогдсон шийдвэрийг зохигчдод хүргүүлнэ.

Хүргүүлэх ажиллагааг олон хэлбэрээр гүйцэтгэж болно.

- зохигч өөрийн биеэр шүүхэд хүрэлцэн ирж, шүүгч, шүүгчийн туслах, нарийн бичгийн даргаас гардан авах.
- шүүхийн бичиг хүргэгчээр зохигчдод хүргүүлэх
- баталгаат шуудангаар хүргүүлэх
- итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хүргүүлэх

Шүүх шийдвэрийг аль болох хуульд заасан хугацааны дотор хэргийн оролцогчдод гардуулан өгөх бүх боломжтой арга хэмжээг авах шаардлагатай.

Үүнд шүүхийн Тамгын хэлтэс чухал үүрэгтэй.

Шүүх шийдвэрийг гардуулан өгсөн талаар баримт заавал үйлдэж хэрэгт хавсаргах бөгөөд уг баримтад шүүхийн шийдвэрийг хэргийн ямар оролцогчид, хэдийд /он, сар, өдөр, цаг, минут/ хэн гардуулж өгсөн талаар маш тодорхой заах шаардлагатай. Энэ талаар баримтад тодорхой заагаагүйгээс шүүхийн шийдвэрийг

гардаж, аваагүй, болон давж заалдах хяналтын журмаар гомдол гаргах хугацааны хувьд маргаан гардгийг анхаарвал зохино.

Шийдвэрийг зөвхөн хэргийн оролцогчдод гардуулах ёстой бөгөөд хэн нэгэн ах, дүү, төрөл садан, албан тушаалтны хувьд хамт ажилладаг хүнд нь гэх мэтээр дамжуулан гардуулж өгөхөөр өөр этгээдэд гардуулж болохгүй. Үүнд итгэмжлэгдсэн төлөөлөгч хамааралгүй болно.

Шийдвэрийг гардан авсан этгээдийн гарын үсгийг тодорхой бичүүлж авна.

Зохигчид шүүхээс гарсан шийдвэрийг мэдсэн атлаа зориуд түүнийг хүлээн авахгүй, улмаар шийдвэрийг биелүүлэхгүй, цаг хожих зорилготой зайлсхийдэг явдал гардаг. Шүүхийн шийдвэрт давж заалдах болон хяналтын гомдол гаргах эрх шийдвэрийг гардан авсан үеэс эхлэн тоологддог учир тэд шийдвэрийг аль болох урт хугацаанд авахгүй байхыг эрмэлздэг. Энэ байдлыг гаргахгүй, таслан зогсоох, шүүхийн шийдвэрийг шуурхай биелүүлэхийн тулд шүүх шийдвэрийг цаг хугацаанд нь гаргаж, түүнийг гардуулах, хүргүүлэх ажиллагааг хуульд заасан оновчтой хэлбэрээр гүйцэтгэж, энэ талаар хийсэн өөрийн бүхий л ажиллагааг баримтжуулан, баталгаажуулсан байвал зохино.

3.Хэргийн оролцогчгүйгээр гарсан шүүхийн шийдвэрийг гардуулах журам хугацаа дээрх зүйлийн нэг адил журмаар зохицуулагдана.

Зохигч хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх хуралдаанд оролцоогүй учир тэрээр шүүхийн шийдвэр гарсан эсэх, гарсан бол ямар шийдвэр гарсныг мэдэхгүй байгаа тул түүний эрхийг хангах зорилгоор хуульд тусгайлсан зохицуулалт хийжээ.

Шийдвэрийг шуудангаар, бичиг хүргэгчээр хүргүүлэх боломжтойгоос гадна хэргийн оролцогч өөрөө хүрэлцэн ирвэл түүнд гардуулж өгнө.

74 дүгээр зүйл. Захиргааны хэргийн шүүхээс гаргах бусад шийдвэр

- 74.1. Захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх явцад энэ хуулийн 41, 42, 43 дугаар зүйлд заасан үндэслэл, нөхцөл байдал илэрвэл шүүх бүрэлдэхүүн тогтоол, шүүгч захирамж гаргаж хэргийг хэрэгсэхгүй болгоно.
- 74.2. Захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх явцад нэмэлт нотлох баримт цуглуулах, гэрчийн мэдүүлэг авах, шинжээч томилох, ирээгүй оролцогчийг шүүх хуралдаанд зайлшгүй оролцуулах шаардлагатай гэж үзвэл шүүх бүрэлдэхүүн тогтоол, шүүгч захирамж гарган шүүх хуралдааныг 14 хүртэл хоногоор хойшлуулж, дараагийн шүүх хуралдааны товыг тогтооно.

ТАЙЛБАР

Захиргааны хэргийг анхан шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд, шүүх хуралдаанаас шийдвэр гаргалгүйгээр шүүгч захирамж, шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргах тохиолдлуудын талаар энэ зүйлд зохицуулжээ.

1. Тухайлбал Хуулийн 41, 42, 43-д заасан үндэслэл тогтоогдвол шүүх шийдвэр гаргахгүйгээр шүүгч захирамж, шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргана.

Нэхэмжлэгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзах, хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, нэхэмжлэгч хариуцагч нар нь эвлэрэх боломжтой байна.

Яагаад шүүхээс шийдвэр гарахгүй захирамж, тогтоол гаргаж байна вэ? гэдэг асуулт гарна.

Үүний хариулт нь нэхэмжлэлээр үүссэн захиргааны хэргийг хэргийн оролцогчдын хүсэлтээр шүүгч, шүүхээс хамаарах шалтгаангүйгээр зөвхөн хэргийн оролцогчийн хүсэл зоригоос хамаарч эцэслэн шийдвэрлээгүй тул тухайн хэргийг хэрэгсэхгүй болгож байгаа хэрэг юм.

Дээрх зүйлээр хэргийг хэрэгсэхгүй болгож байгаа тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг ИХШХШТХ-ийн 59 дүгээр зүйлд заасан журмаар зохицуулна.

Хуулийн 41, 42, 43 дугаар зүйлд зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгохын үр дагавар юу вэ?

43 дугаар зүйлд заанаар нэхэмжлэгч хариуцагч нар эвлэрвэл шүүх тухайн хэргийг дахин авч хэлэлцэхгүй. Энэ талаар хуульд тодорхой зохицуулжээ.

Харин 41, 42 дугаар зүйлүүдэд заасан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд шүүх дахин авч хэлэлцэх эсэх талаар тодорхой зохицуулалт хуульд байхгүй тул дахин авч хэлэлцэнэ гэж ойлгож болно.

Мөн дээрх захирамж, тогтоолын талаар гаргасан гомдлыг дээд шатны шүүх давж заалдах журмаар хянаж болно. Өөрөөр хэлбэл захирамж гомдол давж заалдах журмаар хэргийн оролцогчид гомдол гаргах эрхтэй.

Уг гомдлоор хэргийг тухайн шүүх биш Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим давж заалдах журмаар хуулийн 90 дүгээр зүйлд зааснаар хянан хэлэлцэнэ.

Хуулийн 41; 42; 43 дугаар зүйлийн тайлбарыг үзнэ үү.

2. ЗХХШТХ-д зааснаар шүүх хуралдааныг хойшлуулах 2 үндэслэл байна.

Үүнд:

- Хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2, ИХШХШТХ-ийн 105 дугаар зүйлийн 105.2
- Хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2

Эдгээр зүйлүүдийн үндэслэл юу вэ? ямар тохиолдолд аль зүйлийг баримтлах вэ гэдэг асуулт гарна.

Хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д "...101-113 дугаар зүйлд заасан журмаар зохицуулагдана" гэж ишлэл хийсэн заалт байгаа бөгөөд ИХШХШТХ-ийн 105 дугаар зүйл нь "хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэх" гэсэн гарчигтай байна.

Нэгэнт хуулиар дээрх зүйлийг ишлэл хийж, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэхээр зохицуулсан байгаагаас үзвэл захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх явцад хэргийн оролцогчдоос нэмэлт тайлбар, нотлох баримттай холбоотой, хүсэлт гаргаж, түүнийг зайлшгүй шаардлагатай гэж үзвэл шүүх, шүүх хуралдааныг уг зүйлд заасан журмаар хойшлуулах эрхтэй байна. Тухайлбал

“хэргийн оролцогчдын хүсэлтээр нотлох баримт шинээр шаардлагатай гэж үзвэл энэ зүйлийг баримталж шийдвэрлэнэ гэсэн үг.

Харин Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нотлох үүргийн зарчимтай холбоотойгоор шүүх өөрийн санаачилгаар /хэргийн оролцогч хүсэлт гаргаагүй байх/ шинээр нотлох баримт шаардлагатай, эсхүл хуралдаанд ирээгүй оролцогчийг байлгах шаардлагатай гэж үзвэл хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2-т заасан журмыг баримталж шүүх хуралдааныг хойшлуулна.

Шүүгчийн тогтоол, захирамжид хойшлуулж буй үндэслэл, ямар хугацаагаар хойшлуулсан хугацаа, дараагийн шүүх хуралдааны товыг тодорхой заана.

Ийм тохиолдолд шүүгч захирамж, шүүхээс тогтоол гаргах, уг шүүгчийн захирамж, тогтоолд гомдол гарах эрхтэй бөгөөд гомдлыг 90 дүгээр зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

75 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт засвар оруулах

- 75.1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт хэргийн бодит байдлыг илт буруу илэрхийлсэн, санамсаргүй тооны алдаа гаргасан, зарим зүйлийг ойлгомжгүй илэрхийлсэн байвал шүүх өөрийн санаачилгаар буюу оролцогчийн хүсэлтээр шийдвэрийн агуулгыг өөрчлөхгүйгээр засвар оруулж болно.
- 75.2. Хэргийн оролцогч захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор тухайн шийдвэрт засвар оруулах хүсэлт гаргах эрхтэй.
- 75.3. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт засвар оруулсан тухай шүүх бүрэлдэхүүн тогтоол, шүүгч захирамж гаргана.
- 75.4. Захиргааны хэргийн шүүх шийдвэртээ засвар оруулахдаа урьд нь хэргийн оролцогчид гардуулсан шийдвэрийг буцаан авч түүнд өөрчлөлт оруулж дахин бичиж гаргана.
- 75.5. Хэргийн оролцогчид засварласан шийдвэрийг нэн даруй хүргүүлнэ.

ТАЙЛБАР

Захиргааны хэргийн шүүх нь анхан шатны шүүх хуралдаанаас гаргасан шийдвэртээ засвар, нэмэлт оруулах эрхтэй байна. Энэ иргэний хэргийн шүүхээс ялгагдах онцлогийн нэг юм.

1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт засвар оруулах үндэслэлүүд:

- Хэргийн бодит байдлыг илт буруу илэрхийлсэн
- Санамсаргүй тооны алдаа гаргасан

- Зарим зүйлийг ойлгомжгүй илэрхийлсэн
- Засвар оруулах тухай:

1. хэргийн оролцогч

2. эсхүл шүүх өөрийн санаачилгаар хийгдэх ажиллагаа юм.

Шүүхийн шийдвэрт оруулах засвар нь шийдвэрийн агуулгыг өөрчилж болохгүй. Тухайлбал өмнө нь гарсан шүүхийн шийдвэрийн агуулгад ямар нэг өөрчлөлт хийж болохгүй.

Шүүхийн шийдвэрт засвар оруулах тухай асуудал нь зөвхөн шийдвэрийг гаргасан шүүгч, шүүх бүрэлдэхүүний бүрэн эрхийн асуудал байна.

Шүүхийн шийдвэрт засвар оруулж зөвтгөөгүй асуудал нь уг алдаатай шийдвэр тэр чигээрээ хүчин төгөлдөр болно гэсэн үг биш, шийдвэрт байгаа ямар ч алдааг дээд шатны шүүхээр зөвтгүүлэх боломж хэргийн оролцогчдод байна гэж ойлгоно.

Зөвхөн хуульд заасан боломжтой засварыг хийж өөрийн алдааг зөвтгөх эрхийг хуулиар олгосон тохиолдолд шүүх энэ эрхээ эдэлж, хуулийн заалтыг зөв хэрэгжүүлэх нь зүйтэй.

2. Шүүхийн шийдвэрт ямар хугацаанд засвар оруулж болох хугацааны талаар зохицуулжээ.

Хэргийн оролцогч шийдвэрийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор тухайн шийдвэрт засвар оруулах хүсэлтээ шүүхэд гаргахаар зохицуулсан боловч шүүх гаргасан шийдвэртээ ямар хугацааны дотор өөрчлөлт оруулах эрхтэй талаар хуульд тусгайлан зохицуулалт алга байна.

Дээрх хугацааг дараах байдлаар ойлгож хэрэгжүүлнэ.

Шүүхийн шийдвэрийг уншиж сонсгосноос хойш 7 хоног дотор гардуулж өгөх ёстой. /хуулийн 73 дугаар зүйлийн 73.2/. Хэргийн оролцогч шийдвэрийг хүлээн авснаас хойш 10 хоног дотор шийдвэрт засвар оруулах тухай хүсэлтээ гаргана гэж үзвэл хамгийн цаад хугацаа 17 хоног болно.

Тухайлбал: шүүхийн шийдвэр 2005 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр гарсан гэж бодъё. 2005 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр хэргийн оролцогчдод шүүхийн шийдвэрийг гардуулжээ.

Тэгвэл 2005 оны 01 дүгээр сарын 05-наас 15-ны дотор хэргийн оролцогч нь шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах хүсэлтээ гаргах эрхтэй.

Харин шүүхийн хувьд шүүхийн шийдвэрийг гарсан өдрөөс хойш /шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогчдод шийдвэрийг гардуулснаас хойш түүнд засвар оруулах талаар хуулиар олгогдсон хугацааг оруулаад дээрх жишээн дээрээс үзэхэд 2005 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 01 дүгээр сарын 15-ны дотор шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах эрхтэй гэж ойлгогдоно.

Хугацаа тоолох тухай журмын талаар Иргэний хуулийн 72 дугаар зүйлийг анхаарч холбогдох тайлбарыг үзнэ үү.

Шүүх хэргийн оролцогчдод засвар оруулаагүй шийдвэрийг ёсчлохоос /гардуулахаас/ өмнө засвар оруулах шаардлагатай нөхцөлд хэргийн оролцогчдод зайлшгүй мэдэгдэх шаардлагатай эсэх асуулт зүй ёсоор гарна

Энэ тохиолдолд шийдвэрт оруулсан засвар нь шийдвэрийн агуулгыг өөрчлөх учиргүй учраас энэ талаар хэргийн оролцогчдод зайлшгүй мэдэгдэх шаардлагагүй.

Шүүхийн шийдвэрт засварыг зөвхөн 1 удаа оруулж болно гэж ойлгоно.

Хуульд заасан хугацаанд хүсэлтээ гаргаагүй, шүүх өөрийн санаачилгаар засвар оруулаагүй бол үүний давж заалдах, хяналтын шатны шүүх зөвтгөх юм.

3.Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт засвар оруулах талаар шүүх бүрэлдэхүүн тогтоол, шүүгч захирамж гаргана.

Ингэхдээ шүүх хуралдаан хийх шаардлагагүй.

Засварыг зөвхөн анхны шийдвэр гаргасан шүүгч, шүүх бүрэлдэхүүн оруулна.

Засвар оруулсан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид хэргийн оролцогчид гомдол гаргах эрхтэй бөгөөд гомдлыг хуулийн 90 дүгээр зүйд заасан журмаар хянана.

Шүүхийн шийдвэрт оруулсан засвар нь шийдвэрийн агуулгыг өөрчлөх учиргүй тул хуульд заасан үндэслэлээр зөв засвар оруулсан бол хэргийн оролцогчдоос гомдол гарах үндэслэл тэр бүр байхгүй.

Захирамж нь зөвхөн шүүхийн шийдвэрт засвар оруулах тухай байна. Өөрөөр хэлбэл эхлээд шүүхийн Шийдвэрт засвар оруулах тухай захирамж гаргаад дараа нь уг захирамжийг үндэслээд шийдвэрээ шинээр боловсруулан гаргах гэж ойлгоно.

Хүсэлтийг хүлээн авч ямар хугацаанд шүүх шийдвэрт засвар оруулах хугацааг хуульчлаагүй боловч аль болох түргэн хугацаанд тухайлбал хүсэлт гаргамагц энэ асуудлыг шийдвэрлэнэ гэж ойлгоно.

4.Шүүхийн шийдвэрт засвар оруулах үндэслэл байна гэж шүүх үзвэл урьд нь хэргийн оролцогчдод гардуулсан шийдвэрийг буцаан авна. Энэ талаар өмнө нь шүүхийн шийдвэрийг гардуулсан баримтад тэмдэглэл үйлдэж баримтжуулах хэрэгтэй.

Шүүхийн шийдвэрт засвар оруулах тухай захирамж, тогтоолыг үндэслэн шүүхийн шийдвэрийг дахин бичиж гаргана.

Харин өмнөх шийдвэртэй нь засвар оруулсан тухай шийдвэрийг хамт хавсаргана гэсэн үг биш болно.

“Шийдвэрт засвар оруулах тухай” хүсэлтийг шүүх хүлээн авах үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай шүүгч захирамж гаргана.

5.Засварласан шийдвэр гэдэг нь засвар оруулж шинээр гаргасан шийдвэрийг хэлж байна.

“Нэн” даруй гэдгийг засвар оруулсан тухай шийдвэр гармагц түүнийг хэргийн оролцогчдод хүргүүлнэ гэж ойлгоно.

Шүүхийн шийдвэрт засвар оруулах тухай захирамж, тогтоолын загвар:

ШҮҮХИЙН ТОГТООЛ

200.. оны ...сарын ...өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Шүүхийн шийдвэрт засвар оруулах тухай

1. Удиртгал хэсэг

2. Тодорхойлох хэсэгт: шүүхийн шийдвэрт ямар үндэслэлээр ямар засвар оруулах гэж байгааг дурьдана

3. үндэслэх хэсэгт: оруулах гэж байгаа засвар нь хуулийн 75 дугаар зүйлийн 75.1-д заасан үндэслэл болж чадаж байгаа эсэх талаар дүгнэнэ

4. тогтоох хэсэг: ЗХХШТХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.1-д заасныг удирдлага болон ТОГТООХ НЬ:

1.....Шийдвэрт тогтох хэсгийн 1 дүгээр заалтыг 15000 төгрөг гэсний 150000 төгрөг гэж засварласугай.

2. Захирамжийг үндэслэн шүүхийн шийдвэрийг өөрчлөлт оруулан ахин үйлдэж, засварласан шийдвэрийг хэргийн оролцогчдод нэн даруй хүргүүлсүгэй.

Захирамжид 10 хоног дотор Улсын Дээд шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ШҮҮГЧ.....

Энэ захирамжийн үндэслэл шийдвэрийг дахин үйлдэнэ гэж ойлгоно.

76 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт нэмэлт оруулах

76.1. Шүүхийн шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор захиргааны хэргийн шүүх өөрийн санаачилгаар буюу хэргийн оролцогчийн хүсэлтээр дараах тохиолдолд шийдвэртээ нэмэлт оруулна:

76.1.1. нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийн талаар шийдвэр гаргалгүй орхигдуулсан;

76.1.2. захиргааны хэргийн шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамж, эд мөрийн баримтын асуудлыг шийдвэрлээгүй.

76.2. Нэмэлт шийдвэр гаргах, шүүх хуралдаан хийхэд энэ хуульд заасан журмыг баримтална.

ТАЙЛБАР

Шүүх өөрийн гаргасан шийдвэрт хуульд заасан үндэслэлээр засвар оруулж болохоос гадна нэмэлт оруулах эрхтэй байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт нэмэлт оруулах нь засвар оруулахтай нэг адил

- шүүх өөрийн санаачилгаар
- хэргийн оролцогчийн хүсэлтээр хийгдэх ажиллагаа юм.

Харин шүүхийн шийдвэрт засвар оруулах болон нэмэлт оруулах талаар хуульд заасан үндэслэл өөр өөр. Энэ талаар хуулийн дээрх зүйлээр зохицуулжээ.

1.Хуульд зааснаар засвар оруулах тухай хүсэлтийг хэргийн оролцогч нь шүүхийн шийдвэрийг гардаж авснаас хойш 10 хоног дотор хүсэлтээ гаргах эрхтэй байдаг бол шийдвэрт нэмэлт оруулахад шүүхийн шийдвэр гарснаас хойш 10 хоног дотор хэргийн оролцогч болон шүүх өөрийн санаачилгаар нэмэлт оруулж болохоор хуульчилжээ.

Үүний учир нь нэмэлт оруулах үндэслэлтэй холбоотой байж болно.

Шийдвэрт нэмэлт оруулах үндэслэл:

- Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийн талаар шийдвэр гаргалгүй орхигдуулсан
- захиргааны хэргийн шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамж, эд мөрийн баримтын асуудлыг шийдвэрлээгүй орхигдуулсан тохиолдол болно.

Хуульд энэ 2 үндэслэлийг заасан байгаа тул өөр үндэслэлээр шүүхийн шийдвэрт нэмэлт оруулахыг хориглоно.

Эхний үндэслэлийн тухайд хэд хэдэн шаардлага бүхий нэхэмжлэлтэй хэргийг хянан шийдвэрлэхдээ шүүх нэхэмжлэлийн аль нэг шаардлагын талаар огт шийдвэрлээгүй, энэ талаар хэлэлцээгүй, ямар нэг дүгнэлтэд хүрээгүй, шаардагдах нотлох баримтыг цуглуулаагүй бол тухайн шаардлагыг шийдвэрлэж нэмэлт оруулж болохгүй.

Харин орхигдсон шаардлагын талаар шүүх хуралдаанаар нотлох баримтын үндсэн дээр хянан хэлэлцсэн, энэ талаар үндэслэх хэсэгт ямар нэг дүгнэлт хийсэн боловч тогтоох хэсэгт шийдлийг орхигдуулсан байвал дээрх үндэслэлээр нэмэлт оруулж болно.

Хоёр дахь үндэслэлийн тухайд мөн л орхигдуулсан асуудлын талаар хэрэгт нотлох баримт зайлшгүй авагдсан байх шаардлагатай.

2.Шүүхийн шийдвэрт нэмэлт оруулах нь анхан шатны шүүх хуралдаанаас шийдвэр гаргах үед огт шийдвэрлээгүй орхигдуулсан асуудлыг “нөхөж” нэмж гаргаж байгаа учраас нэмэлт шийдвэр гаргах нь анхан шатны шүүх хуралдаанаас шийдвэр гаргахтай адил журмаар шийдвэрлэгдэнэ.

Гэхдээ шүүх хуралдаан нь анх тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх хуралдааныг бодвол товч байдлаар явагдах бөгөөд зөвхөн шийдвэрлээгүй орхигдуулсан асуудлын хүрээнд асуудлыг шийдвэрлэж шийдвэр гаргах ёстой.

Шүүхийн шийдвэрт нэмэлт оруулахад шүүхийн шийдвэрийн агуулга тухайлбал хэргийг хэлэлцээд гаргасан шийдвэр өөрчлөгдөх учиргүй гэж ойлгох хэрэгтэй.

Мөн шүүхийн шийдвэрт нэмэлт оруулахад зөвхөн анх шийдвэр гаргасан шүүгч, шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэнэ гэсэн үг болно.

Шүүх, шүүхийн шийдвэрт нэмэлт оруулах тухай хэргийн оролцогчийн хүсэлт мөн өөрийн санаачилгаар нэмэлт оруулах талаар эхлээд шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолоор шийдвэрлэнэ. Үүний үндсэн дээр өмнөх шүүхийн шийдвэрт нэмэлт оруулсан шийдвэрийг шинээр боловсруулан гаргана.

Энэ нэмэлт оруулсан шийдвэрээ хэргийн оролцогчдод нэн даруй хүргүүлнэ.

Хэргийн оролцогчдоос гаргасан шүүхийн шийдвэрт нэмэлт оруулах тухай хүсэлтийг хангах боломжгүй гэж үзвэл шүүх энэ тухай шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолоор шийдвэрлэнэ.

77 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох

- 77.1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр уншиж сонсгосноор хуулийн хүчин төгөлдөр болно.
- 77.2. Нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор давж заалдах, хяналтын журмаар хянуулах бол 30 хоногийн дотор гомдол гаргах буюу прокурор давж заалдах эсэргүүцэл бичиж болно.
- 77.3. Анхан шатны шүүхийн шийдвэрт нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргах эсэхээ сонгон гомдлоо захиргааны хэргийг шийдвэрлэсэн тухайн шүүхэд ирүүлнэ.
- 77.4. Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад уг асуудлаар өөр шүүхэд хандахыг хориглоно.
- 77.5. Хяналтын журмаар анхан шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдлыг шийдвэрлээд гаргасан шүүхийн тогтоолд давж заалдах гомдол гаргах эрхгүй.

ТАЙЛБАР

1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хэдий үеэс хүчин төгөлдөр болох тухай асуудал дээр нэлээд маргадаг.

Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичигт зааснаас үзвэл хүчин төгөлдөр болох нь гэдэг нь хүчинтэй болох гэдэг үгтэй нэг адил ойлгогдохоор тайлбарлажээ.¹²⁴ Гэвч хүчин төгөлдөр болох, хүчинтэй байх гэдэг нь үгийн өөр өөр утгыг илэрхийлэх талаар үзэл баримтал мөн байдаг.¹²⁵

Тэгвэл хуулийн дээрх заалтаас шүүхийн шийдвэр уншиж сонсгосноор хүчин төгөлдөр болно. Тухайлбал анхан шатны журмаар шүүх хэргийг хянан хэлэлцээд хуульд заасан журмын дагуу зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэж шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарын үсгээ зурж сонсгосноор шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болно.

Үүнийг аливаа шүүхийн шийдвэр нь заавал биелэгдэх ерөнхий шинжтэй нь ч мөн холбон тайлбарлаж болно.

Хуулийн дээрх заалт нь Монгол улсын Үндсэн хуулиар олгосон шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг нь хязгаарлахгүй.

Энэхүү хүчинтэй шийдвэрт хэргийн оролцогчид дээд шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй бөгөөд ийнхүү гомдол гаргаагүй бол шийдвэр хүчин төгөлдөр мөрдөгдөж шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаа явагдах эрх нь нээгдэнэ гэсэн үг.

Гомдол гарснаар уг шийдвэрийн хүчин төгөлдөр байх шинж алдагдаж байна гэж үзэж болохгүй. Харин дээд шатны шүүхийн шийдвэр гартал түүний үйлчлэл түр хугацаагаар тасалдана гэсэн үг юм.

Хэрвээ хуульд энэ талаар тусгайлан заагаагүй бол анхан шатны шүүх хуралдаанаас гаргасан шийдвэр нь ямар ч хууль зүйн үр дагаваргүй, ач холбогдолгүй, түүнийг биелүүлэх боломжгүй шийдвэр гэж ойлгогдохоор байна.

Иймд шүүхийн шийдвэр нь уншиж сонсгосон үеэсээ л хүчин төгөлдөр болно. Хуульд хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө гэж заагаагүй нь цаашид тухайн шийдвэрт гомдол гаргах тохиолдлыг нээлттэй орхисон гэж ойлгоно.

Шүүхийн шийдвэр уншиж сонсгосноор хүчин төгөлдөр болно. Харин хэзээ эрх зүйн үйлчлэл үзүүлж эхлэх гэдэг асуудал тусдаа ойлголт юм. Онолын хувьд гагцхүү эцсийн шийдвэр гарсан цаг хугацаанаас эрх зүйн үйлчлэл үзүүлнэ.¹²⁶

2.Хуулийн дээрх зүйлд шүүхийн шийдвэрт нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд, гомдол гаргах хугацаа, гомдлыг аль шатны шүүхэд гаргах талаар зохицуулжээ.

Хуульд зааснаар:

- нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч,
- хариуцагч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч
- гуравдагч этгээд зэрэг этгээдүүд шүүхийн шийдвэрт гомдол гаргаж болохоор заажээ.

Гуравдагч этгээдийн өмгөөлөгч, төлөөлөгчийн талаар хуульд заагаагүй боловч, тэд төлөөлөгч, өмгөөлөгчөөр дамжуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон бол төлөөлөгч, өмгөөлөгчийг нь гомдол гаргах эрхгүй гэж үзэх боломжгүй

^{125 29}И. Дамбажав, Д.Алтан –Од, Д.Солонго “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг”, УБ хот, 2006 он, 651, 724 дүгээр тал

¹²⁶ Д.Оросоо “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт шийдвэр гүйцэтгэх арга журмыг тодорхойлох асуудал” МТЭЗсэтгүүл 25 дугаар тал

билээ. Иймд гуравдагч этгээдийг төлөөлөгч буюу өмгөөлөгч мөн давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй гэж ойлговол зохино.

Хэргийн дээрх оролцогчид нь шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш давж заалдах журмаар бол 14 хоног, хяналтын журмаар бол 30 хоногийн дотор гомдлоо гаргах эрхтэй байна.

Гомдлыг хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүх хүлээн авч, дээд шатны шүүхэд хүргүүлэх бөгөөд гомдлыг хүлээн авч байгаа шүүх гомдлыг гаргаж байгаа этгээд нь энэ хуульд заасан гомдол гаргах эрхтэй этгээд мөн эсэх, гомдлыг хуульд заасан хугацааны дотор гаргаж байгаа болон гомдол нь хуульд заасан шаардлага бүрдүүлбэрийг хангасан эсэхийг сайтар шалгаж байх нь зүйтэй.¹²⁷

Анхан шатны шүүхийн шийдвэрт талуудын аль нэг нь давж заалдах гомдол гаргасан нь эсрэг талын хяналтын журмаар гомдол гаргах эрхийг үл хязгаарлана.¹²⁸

Хэргийн оролцогчдын аль нэг нь давж заалдах гомдол, нөгөө нь хяналтын журмаар гомдол гаргасан бол хэргийг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэх бөгөөд энэ тохиолдолд хэргийг бүхэлд нь хянана. Энэ нь хяналтын гомдлоор хэргийг хянуулах тухай хүсэлт гаргасан этгээдийн эрхийг хохироож байгаа асуудал биш юм.¹²⁹

Гомдол гаргах эрхтэй этгээд мөн эсэхийг биеийн байцаалт, холбогдох бичиг баримтыг нь үндэслэн тогтооно.

Гомдлыг хуульд заасан хугацааны дотор гаргасан эсэхийг шалгахад шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогчдоод гардуулсан баримтыг үндэслэж тооцно.

Хугацаа тоолоход Иргэний хуулийн хугацааг тодорхойлох, тоолох талаар зохицуулсан 8 дугаар бүлгийн 71, 72, 73 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

Хугацааг маш зөв тооцохын тулд шүүхийн шийдвэрийг гардуулсан баримтад шийдвэрийг гардуулсан он, сар, өдөр, цаг, минутыг нэг бүрчлэн тэмдэглэсэн байвал зохино.

Гомдол гаргах хугацааг тоолохдоо шүүхийн шийдвэрийг тухайн этгээд хэзээ гардан авсан, мөн гардан авсанд тооцох үндэслэлтэй үеэс эхэлж тооцно. Гомдол гаргах эрхтэй этгээдийн төлөөлөгч, өмгөөлөгч шийдвэрийг гардан авсан бол тэдгээрээр төлөөлүүлсэн этгээдийг гардаж авсан гэж үзнэ.

Шүүхийн шийдвэрийг шүүх хуралдаанд оролцоогүй этгээдэд хуульд заасан журмын дагуу хүргүүлсэн бол түүнийг хүлээн авсан гэж үзнэ.

Шүүхийн шийдвэрийг хүлээж аваагүй болохоо эсхүл хожимдуулж хүлээн авснаа тухайн этгээд нотолбол түүний хүсэлтээр анхан шатны шүүх гомдол гаргах эрхийн хугацааг Иргэний хуулийн 82 дугаар зүйлийн 82.4-т заасныг төсөөтэй хэрэглэж, сэргээж болно.

Ийм гомдлыг хүлээн авсан шүүх гомдол гаргах хугацааг хэтрүүлснээс хэргийн оролцогч сэргээлгэх тухай хүсэлт гаргавал нотлох баримтыг үндэслэл дээрх хугацааг сэргээх эсэх тухай асуудлыг шийдвэрлэж, сэргээсэн тохиолдолд нь дээд шатны шүүхэд ирүүлнэ.

¹²⁷ ЗХХШТхуулийн 81 дүгээр зүйлийн тайлбарыг үзнэ үү

¹²⁸ Мөн тайлбар

¹²⁹ Мөн тайлбар

Ингэхдээ хугацаа сэргээх тухай асуудлыг шүүгчийн захирамжаар шийдвэрлэх бөгөөд уг захирамжид гомдол гаргах эрхтэй ба гомдлыг хуулийн 90 дүгээр зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

Хэрвээ хууль заасан хугацааг хэтрүүлж гомдол гаргасан этгээд энэ талаар ямар нэг тайлбар гаргахгүйгээр, хугацааг сэргээлгэх тухай хүсэлт гаргаагүй бол шүүх энэ талаар тайлбар хийж, гомдлыг буцаана.

Энэ тохиолдолд мөн шүүгчийн захирамж гаргах бөгөөд гомдол гаргах эрхтэй, гомдлыг мөн 90 дүгээр зүйлд заасан журмаар хянана.

Хэргийн оролцогчдоос гадна шүүх хуралдааны бусад оролцогчийн нэг болох прокурор давж заалдах эсэргүүцэл бичиж болохоор хуульчилжээ.

Хуулийн энэ заалттай үзвэл хэргийн оролцогчид шүүхийн шийдвэрт давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй байхад прокурор зөвхөн давж заалдах журмаар эсэргүүцэл бичих эрхтэй байхаар зохицуулжээ.

Прокурор эсэргүүцэл бичих хугацаа, журам, түүнийг хүлээн авах, шүүх хуралдаанаар хэлэлцэх ажиллагаа нь дээр дурьдсан хэргийн оролцогчийнхтой адил байна.

Давж заалдах болон хяналтын журмаар гаргаж байгаа гомдолд хэрэгт авагдсан болон авагдаагүй нотлох баримтыг хавсаргаж ирүүлэх нь олонтаа тул түүнийг хүлээн авч байгаа шүүх гомдолд ямар ямар хэдэн хуудас баримт хавсаргасан талаар баримт үйлдэх, гомдол гаргаж буй этгээд энэ талаар гомдолдоо дурьдсан байвал, дурьдсан баримтууд нь хавсаргагдсан эсэхийг заавал нягталж, шалгаж байх нь зүйтэй. Шаардлагатай бол энэ талаар баримт үйлдэж байвал зохино.

3. Анхан шатны шүүхийн шийдвэрт аль шатны шүүхэд тухайлбал: давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргахад сонгох нь хэргийн оролцогчийн хуулиар олгогдсон эрх байна.

Шүүх энэ талаар сонголт хийхэд нь туслах, зөвлөх эрхгүй бөгөөд зөвхөн хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлийг заасан хуулийн зүйлийг л тайлбарлаж өгөх эрхтэй.

Гомдлыг захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн тухайн шүүхэд ирүүлнэ.

Хэрэв давж, заалдах болон хяналтын шатны шүүхэд гомдлыг ирүүлбэл түүнийг хүлээн авсан шүүх хуульд заасан журмыг тайлбарлаж гомдлыг харъяалах шүүхэд нь биш, гомдол гаргагчид буцаана .

Давж заалдах болон хяналтын гомдлыг хүлээн авах журмын талаар ЗХХШТХ-ийн 81, ИХШХШТХ-ийн 173 дугаар зүйлд зохицуулсан тул дээрх хуулийн тайлбараас тодорхой үзнэ үү.

4. Захиргааны хэргийн шүүхэд хэргийг хянан шийдвэрлэх явцад хэргийн оролцогч нь тухайн маргаантай асуудлаар өөр шүүхэд хандах эрхгүй. Үүнийг хуулиар хоригложээ.

Хуулиар хориглосон үйлдэл хийснийхээ хариуцлага үр дагаврыг тухайн хэргийн оролцогч өөрөө хүлээх ёстой.

Гэхдээ энэ нь санаатайгаар мэдсээр байж өөр шүүхэд тухайн асуудлаар хандсан хэргийн оролцогчийн хувьд яригдана.

Харин хэргийн оролцогч захиргааны актыг маргаантай гэж үзэж, шүүхэд нэхэмжлэл гаргаж, шүүх захиргааны хэргийг үүсгэж хэргийг шалгаж байх үед энэ талаар маргаан шүүхэд шалгагдаж байгаа эрх ашиг нь хөндөгдөж болзошгүй гуравдагч этгээд өөр шүүхэд тухайн захиргааны актын талаар маргаан гаргасан байж болох тохиолдол гарч болно.

Энэ тохиолдолд шүүх ямар арга хэмжээ авах вэ?

Шүүхийн шийдвэрийн улмаас эрх ашиг нь хөндөгдөж болох гуравдагч этгээд болон өөр бусад этгээдэд хэрэг үүсгэсэн талаар шүүх аль болох түргэн хугацаанд мэдэгдэх ёстой.

Энэ тохиолдол нэхэмжлэлийн шаардлагыг нэгтгэх талаар хуулийн 44 дүгээр зүйлийн дагуу шийдвэрлэж болно.

Энэ нь хуулийн 34.1.6-с өөр зохицуулалт юм.

Хуулийн 34.1.6-д зааснаар нэхэмжлэлд дурьдсан үйл баримт маргааны талаар хуулийн хүчин төгөлдөр болсон тухайн шүүхэд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болдог байна.

Тэгвэл дээрх хуулиар шүүх хэргийг эцэслэн шийдвэрлээгүй, шүүхийн шийдвэр гаргаагүй үеийн асуудлыг хөнджээ.

5.Хэрэг маргааныг хянан шийдвэрлээд гаргасан гомдлыг хянан хэлэлцэх хуулиар тогтоосон хамгийн дээд шат нь хяналтын шатны шүүх хуралдаан болно.

Иймд анхан шатны шүүхийн шийдвэрийг хяналтын шатны журмаар хянаад гаргасан тогтоолд давж заалдах гомдол гаргах эрхгүй.

Давж заалдах гомдлыг зөвхөн анхан шатны шүүхийн шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд л гаргана.

Хяналтын шатны шүүхээс гаргасан тогтоол нь тухайн хэргийн хувьд эцсийн шийдвэр болно.

Харин хяналтын шатны шүүх хууль зөрчсөн үндэслэлээр хэргийн оролцогч нь Улсын Дээд шүүхэд ганц удаа гомдол гаргах эрхтэй талаар ИХШХШТХ-ийн 176 дугаар зүйлд заасан тул энэ хуулийн тайлбарыг үзнэ үү.

78 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх

78.1. Хэргийн оролцогчид захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн биелүүлэх үүрэгтэй.

78.2. Захиргааны хэргийн шүүх шийдвэрээ биелүүлэх арга, журмыг гаргасан шийдвэртээ тодорхойлно.

ТАЙЛБАР

1.Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаар Монгол улсын иргэн Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх үүрэгтэй байна.

Үндсэн хуулийн дээрх үзэл баримтлал Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгалаа олсны нэг илрэл нь ЗХХШТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2, 78 дугаар зүйлийн 78.1 дэх заалт юм. ЗХХШТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2-т Захиргааны хэргийн шүүхийн хүчин төгөлдөр актыг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа холбогдох бүх байгууллага, албан тушаалтан, иргэн заавал биелүүлнэ” гэж заасныг тайлбарласан хуулийн холбогдох тайлбарыг үзнэ үү.

Шүүхийн шийдвэр ямар хугацаанаас хүчин төгөлдөр болох талаар хуулийн 77 дугаар зүйлийн тайлбарт тодорхой тайлбарласан.

Анхан шатны шүүхийн шийдвэр шүүхийн шийдвэрийг уншиж сонгосноор хүчин төгөлдөр болно.¹³⁰

Хэрэв тухайн шийдвэрийг эс зөвшөөрч хэргийн оролцогч нь давж заалдах эсхүл хяналтын шатны шүүхэд давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргасан бол анхан шатны шүүхээс гаргасан хүчин төгөлдөр бүхий шүүхийн шийдвэрийн үйлчлэл дээд шатны шүүхийн шийдвэр гартал түр зогсоно гэсэн үг.

Шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч хэргийн оролцогч нь гомдол гаргаж байгаа нь тухайн шүүхийн шийдвэр биелэгдэх утыг алдагдуулахгүй болно.

Нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүх хэвээр үлдээж, мөн хяналтын шатны шүүх ч хэвээр үлдээжээ гэж бодъё.

Тэгвэл анхан шатны шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр дээд шатны шүүхийн шийдвэр гарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх ёстой бөгөөд энэ үеэс биелэгдэх учиртай юм.

Дээд шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилсөн тохиолдолд тухайн өөрчилсөн шийдвэр нь анхан шатны шүүхийн хүчин төгөлдөр шинжийг зогсоох бөгөөд өөрчлөлт оруулсан шийдвэр нь хүчин төгөлдөр болж мөрдөгдөж, биелэгдэх учиртай болно.

Харин дээд шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдолд тухайн шүүхийн шийдвэрийг биелүүлэх гэсэн ойлголт үгүй болно.

Шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогч биелүүлэх үүрэгтэй. Нэгэнт хуулиар үүнийг “үүрэг” болгон хуульчилсан тул үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох учиртай бөгөөд тодорхой үр дагаварт хүргэнэ гэсэн үг юм.

Шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүйгээс дараах үр дагавар үүснэ.

- Захиргааны хэргийн шүүхийн хүчин төгөлдөр болсон шийдвэр /шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж/-ийг сайн дураар биелүүлэх үүрэгтэй бөгөөд ингэж сайн дураар биелүүлээгүй бол ИХШХШТХ-ийн 183-188 дугаар зүйл, ШШГТХ-д зааснаар албадан биелүүлэх шаардлагатай болно.¹³¹

Шүүхийн шийдвэрийг дараах тохиолдолд албадан биелүүлэхээр шүүгч захирамж гаргана. /ИХШХШТХ-ийн 185 дугаар зүйл 185.1/

¹³⁰ ЗХХШТХуулийн 77 дугаар зүйлийн 77.1 Хууль “ Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны дугаарт нийтлэгджээ

¹³¹ ИХШХШТХ “ Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны дугаарт нийтлэгджээ.

- Төлбөр авагч шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргасан
- Шүүхийн шийдвэрийг даруй биелүүлэх шаардлагатай гэж шүүгч үзсэн¹³²
- Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг тогтоосон хугацаанд

үл биелүүлбэл захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр холбогдох эрх бүхий албан тушаалтанд хандана. Холбогдох хуулийн тайлбарыг үзнэ үү.

Одоо захиргааны хариуцлагын тухай хууль болон Эрүүгийн хуульд энэ талаар ямар зохицуулалт байгааг авч үзье

¹³² Мөн хууль

Захиргааны хариуцлагын тухай хуулийн¹³³

30 дугаар зүйл. Шүүхийг үл хүндэтгэх

3. Шүүхийн шийдвэр, шаардлагыг тогтоосон хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй буюу биелүүлэхэд саад учруулсан бол 500-10.000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

30/4/ дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албан ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх

1. Шийдвэр гүйцэтгэлийн албанд дуудагдсан этгээд хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, хүрэлцэн ирэхэд нь саад учруулсан бол 200-5000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.
2. Албан үүргээ биелүүлэхэд нь санаатайгаар саад учруулсан, эсэргүүцсэн, албан үүрэгтэй нь холбогдуулан доромжилсон, гүтгэсэн, заналхийлсэн, хүч хэрэглэсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 500-25000 төгрөгөөр торгох, эсхүл 7-14 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
3. Шийдвэр биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн, хуурамч гэрээ хийж, эд хөрөнгөө бусдад шилжүүлсэн, нуусан, битүүмжилсэн, эд хөрөнгийг санаатайгаар үрэгдүүлсэн бол 5000-10000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.
4. Төлбөр төлөгчийн цалин орлогоос суутгал хийгээгүй, дутуу суутгасан суутгасан мөнгийг хуульд заасан хугацаанд олгоогүй буюу шилжүүлээгүй, төлбөр, тэтгэлэг, төлөгчийг ажлаас халагдсаныг мэдэгдээгүй бол 100-15000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

Монгол улсын Эрүүгийн хуулийн 258 дугаар зүйл.¹³⁴

Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх

- 258.1. Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд нь зориуд саад учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, нэгээс

¹³³ Хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэл 1992 оны 5 дугаар

¹³⁴ Хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэл 2002 оны 5-дугаарт

гурван сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

- 258.2. Шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийх зорилгоор хөрөнгийн мэдүүлгээ санаатай буруу гаргасан, эсхүл эд хөрөнгөө нуун дарагдуулсан, бусдад шилжүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэлх хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос дээш дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 258.3. Энэ хэргийг гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

ТАЙЛБАР

Энэ зүйлд заасан гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон, ялагдагчаар татагдсан, ял шийтгэгдсэн этгээд шүүхийн шийдвэрийг биелүүлсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө. Гэж тус тус заасан байна.

Мөн Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль, Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуульд шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүйгээс үүдэн гарах үр дагаврын талаар зохицуулалт байгааг анхаарах хэрэгтэй.

Захиргааны хэргийн шүүх шийдвэрээ биелүүлэх арга, журмыг гаргасан шийдвэртээ тодорхойлох талаар тухайн зүйлд зохицуулжээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаас үзвэл шүүх шаардлагатай бол шийдвэр гүйцэтгүүлэх арга журам, хугацааг, шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт заахаар тусгажээ. Эндээс үзэхэд энэ хуулиар шүүхийн шийдвэр бүрт энэ талаар заах шаардлагагүй бөгөөд зөвхөн шаардлагатай бол заахаар зохицуулсан байна.

Тэгвэл захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дээрх зүйлд шүүх гаргасан шийдвэртээ шийдвэрээ биелүүлэх арга журмыг “тодорхойлно” гэж зааснаас биш, “шаардлагатай бол” “тодорхойлж болно” гэх мэт нэр томъёо хэрэглээгүй учраас шүүх шийдвэр бүрт энэ талаар заавал заана гэсэн утга агуулагдаж байна гэж ойлгогдоно.

Гэвч өнөөгийн шүүн таслах ажиллагааны практикаас үзэхэд хуулийн энэ заалт тэр бүр хэрэгжихгүй байгаа болно.

Шүүхийн шийдвэрт шүүх шийдвэрээ биелүүлэх арга журмын тодорхойлно гэдгийг практикт зарим шүүхүүд буруу тайлбарлан хэрэглэж, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хэт хөндлөнгөөс оролцсон шийдвэр гаргаж байна.

Шүүхийн шийдвэр биелүүлэх үйл ажиллагаа нь уг шийдвэрт хэрэв шийдвэр биелүүлэх арга журмыг заасан бол тухайн заасан арга журмын дагуу л явагдах учиртай.

Улсын Дээд шүүхийн 2006 оны 37 дугаар тогтоол: Хуулийн 78 дугаар зүйлийн 78.2-т заасан “захиргааны хэргийн шүүх шийдвэрээ биелүүлж арга, журмыг гаргасан шийдвэртээ тодорхойлно гэдэгт Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр /шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шийдвэр, магадлал/-ийн зөвхөн тогтоох заалтыг хэн, хэзээ, яаж биелүүлэх болон биелэлтийг нь хэрхэн тооцох талаар шийдвэрийн тогтоох хэсэгт тодорхой тусгахыг ойлгоно” гэж заажээ.

Захиргааны хэргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр /шийдвэр, магадлал, тогтоол, шүүгчийн захирамж/-ийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183-188 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу албадан биелүүлнэ гэж зааснаас үзвэл Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь иргэний шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийн ажиллагаатай нэг адил явагдана гэсэн үг. Эндээс шүүх шийдвэрийн тогтоох хэсэгтээ арга, журмаас гадна хугацааг мөн зааж өгөх нь чухал.

Хугацааг заах гэдэг нь шүүхийн шийдвэрийг сайн дураар эсхүл албадан гүйцэтгэж эхлэх хугацааг заана гэсэн үг.

Энэ бүгдийг шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт тодорхойлж заах юм.

Нэхэмжлэлийн шаардлага болон захиргааны хэргийн шүүхээс гаргаж байгаа шийдвэрийн төрлөөс хамаарч шийдвэр биелүүлэх гүйцэтгэх арга, журам, хугацаа нь өөр өөр байж болно.

Тухайлбал: Маргаан бүхий захиргааны акт хууль бус болох нь тогтоогдвол түүний хүчингүй болгосон, захиргааны байгууллагаас гаргасан акт нь илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрсөн зэрэг актыг албадан гүйцэтгэх шаардлага тун бага.

Өөрөө аяндаа биелэгдэх шинж чанартай тул албадан биелүүлэх журмаар биш сайн дураар тухайлбал өөрөө дагаж мөрдөх замаар биелэгдэнэ гэсэн үг.

Захиргааны хэргийн шүүх нийтээр дагаж мөрдөх захиргааны актыг хүчингүй болгосон бол энэ талаараа хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхийг захиргааны байгууллага албан тушаалтанд үүрэг болгож болно.

Захиргааны байгууллага албан тушаалтнаас бусдад учруулсан хохирлыг гаргуулах, хохирлын хэмжээг өөрчлөх, захиргааны актыг гаргахгүй байгаа эс үйлдэхүй нь хууль бус болсон бол шаардагдах захиргааны актыг гаргах тухайн байгууллага, албан тушаалтанд даалгаж, шийдвэрийг сайн дураар биелүүлэх журам хугацааг зааж өгч болно.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргасан тохиолдолд шүүхийн шийдвэрийг түдгэлзүүлэх тухай ИХШХШТХ-ийн 122 дугаар зүйл шиг зохицуулалт байхгүй боловч онолын хувьд энэ нь гомдол гарсан нөхцөлд шүүхийн шийдвэр биелэгдэх ямар ч боломжгүй болно.

Хуульд тусгайлсан зохицуулалт үгүй боловч шүүх хуулийн дээрх зүйлд зааснаар шийдвэрийн тогтоох хэсэгт энэ талаар заах эрхтэй юм.

Гэвч иргэний зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нэн даруй сэргээх үүднээс шүүхийн шийдвэрийг нэн даруй биелүүлэх шаардлагатай гэж шүүх үзвэл давж заалдах, хяналтын журмаар гомдол гарсан эсэхээс үл хамааран шүүхийн шийдвэр шууд биелүүлэх талаар шийдвэртээ зааж өгөх эрхтэй.

Захиргааны шүүхэд хуулиар олгогдсон энэ эрхтэй нь холбоотойгоор хуульд ИХШХШТХ-ийн заалттай адил заалт үгүй байна гэж ойлгож болно.

79 дүгээр зүйл. Захиргааны хэргийн шүүхийн тогтоол,
шүүгчийн захирамж

- 79.1. Энэ хуулийн 73 дугаар зүйлд зааснаар шийдвэр гаргахаас бусад тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар захиргааны хэргийн шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.
- 79.2. Захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг бичгээр гаргана.
- 79.3. Хуульд тусгайлан заасан бол захиргааны хэргийн шүүхийн тогтоол буюу шүүгчийн захирамжийг тэмдэглэлд тусгах замаар гаргаж болно.
- 79.4. Захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж нь гармагц хүчин төгөлдөр болно.

ТАЙЛБАР

1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед шүүхийн шийдвэр гарахаас бусад тохиолдолд шүүхээс шийдвэрлэж байгаа асуудлаар ямар нэг эрхийн акт гаргах нь зайлшгүй.

Анхан шатны шүүхийн шийдвэрээс бусад шүүх бүрэлдэхүүнээс гаргасан шийдвэрийг шүүхийн тогтоол, шүүгч дангаар гаргасан шийдвэрийг захирамж гэж нэрлэнэ.¹³⁵

“Шүүх бүрэлдэхүүн” гэдэгт хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, ИХШХШТХуулийн 81 дүгээр зүйлийн 81.1-д зааснаас үзвэл анхан шатны шүүхийн хувьд 3 шүүгч байх ёстой тул ямар ч тохиолдолд шүүхийн тогтоол нь 3 шүүгчийн хамтын шийдвэр юм. Харин шүүх бүрэлдэхүүнд байгаа шүүгчийн татгалзан гаргах тухай асуудлыг хэлэлцээд гаргасан шүүхийн тогтоол үүнд хамаарахгүй. / хуулийн 65 дугаар зүйл /

Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шийдвэрлэж байгаа тодорхой нэг асуудлын талаар гардаг тухайлбал захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх, шинжээч томилох, шүүх хуралдааныг хойшуулах гэх. мэт.

¹³⁵ ЗХХШТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.11, 3.1.12

Шүүхийн тогтоолыг зөвхөн шүүх хуралдааны үед хэргийг бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэж байгаа үед гаргана.

Харин хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхээс бусад бүх тохиолдолд болон хэргийг шүүгч дангаар шийдвэрлэж байгаа тохиолдолд шүүгчийн захирамж гарна .

Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж нь шүүхийн шийдвэрийн нэг адил удиртгал, тодорхойлох, үндэслэх /хянах/ тогтоох /захирамжлах/, хэсгээс бүрдэнэ.

Захирамж тогтоолд шийдвэрлэж буй асуудлыг аль болох товч, тодорхой, хуулийн үг хэллэгээр боловч хэргийн оролцогчдоод ойлгомжтой, байхаар тусгах ёстой.

Шүүгч тухайн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг боловсруулахдаа юуны түрүүнд тухайн актыг гаргах болсон үндэслэл, шалтгаанаа сайтар тодорхойлох нь чухал. Тухайлбал: Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай шүүгчийн захирамж гаргах шаардлага болмоо гэж бодъё.

Эхлээд захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гарахаас өмнө захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх зайлшгүй шаардлага бий болсон эсэхийг тогтооно.

Дараа нь хууль зүйн үндэслэл байгаа эсэхийг тогтооно. Өөрөөр хэлбэл ЗХХШТХ-ийн 45, 46 дугаар зүйлүүдийг судалж, захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хуульд заасан үндэслэл бий эсэхийг шалгана.

Өнөөгийн практикт шүүгчийн ажлыг хөнгөвчлөх, цагийг хэмнэх зорилгоор анхан шатны шүүхийн шийдвэр гаргахаас бусад асуудлаар акт гаргахдаа хэвлэмэл маягыг ашиглаж байна. Энэ нь буруу биш болно. Гагцхүү ийм хэвлэмэл маягт нь захиргааны актад тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна бэлэн болгосон маягыг асуулт нэг бүрээр бөглөж, гаргаж байгаа эрхийн актынхаа үндэслэлийг зөв тодорхойлсон байх шаардлагатай.

2.Шүүхээс гарч байгаа дээрх шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь бичгээр гарна.

Бичгээр гарсан дээрх шийдвэрт шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурж, тамга дарагдсанаар ёсчлогдоно.

3.Шүүх ихэнх тохиолдолд тогтоол, захирамжийг бичгээр гаргах ёстойгоос гадна тэмдэглэлд тусгах замаар амаар гаргаж болох талаар хуульчилжээ.

Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг амаар гаргахад 3 шаардлага тавигдаж байна гэж ойлгох нь зүйтэй. Үүнд:

- Энэ талаар хууль тусгайлан засан байх шаардлагатай
- Зөвхөн шүүх хуралдаанаас гаргах
- Шүүх хуралдааны тэмдэглэлд заавал тусгагдсан байх гэсэн 3 шаардлага болно.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд энэ талаар тусгайлан заасан зүйл байхгүй боловч хуулиар нэгэнт зөвшөөрөгдсөн тул шүүх хуралдааны явцад шийдвэрлэгдэж байгаа зарим асуудлаар захирамж тогтоолыг амаар гаргаж болохоор байна Үүнд: хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь заалтыг нэрлэж болно. “Шүүх

хуралдааны журам зөрчсөн этгээдэд эхний удаа хуралдаан даргалагч урьдчилан сануулна. Гэж заасан бөгөөд энэ сануулах эрхээ хэрэгжүүлэхдээ заавал бичгээр захирамж гаргах шаардлагагүй харин ам захирамж, тогтоол гаргаж болох бөгөөд энэ талаар шүүх хуралдааны тэмдэглэлд зайлшгүй тусгагдсан байх ёстой байна.

Мөн 63 дугаар зүйлийн 6-д заасан асуудлаар ч мөн ийм ам акт гарч болно.

Амаар гаргасан захирамж нь шууд хүчин төгөлдөр биелэгдэх учиртай бөгөөд уг захирамжид гомдол гаргах эрхгүй байна.

Шүүх хуралдаанд хэргийн оролцогчид оролцож байгаа тохиолдолд шүүх бүрэлдэхүүнээс шийдвэрлэсэн асуудлын талаар тогтоол гаргахад хуралдааны тэмдэглэл заавал хөтөлсөн байх шаардлагатай.

4. Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж хэдий үеэс хүчин төгөлдөр болох талаар хуулийн энэ зүйлд зохицуулжээ.

Шүүхийн шийдвэр нь уншиж сонсгосноор хүчин төгөлдөр болдог бол шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь гармагц хүчин төгөлдөр болно.

Нэгэнт хүчин төгөлдөр болж байгаа учраас гармагц биелэгдэнэ гэсэн үг.

Харин хүчин төгөлдөр захирамж тогтоолын үйлчлэл нь гомдол гарсан тохиолдолд зогсож болно.

Захиргааны хэргийн шүүхээс гаргасан хүчин төгөлдөр болсон ямар ямар захирамж тогтоолд гомдол гаргаж болох болохгүй талаар ИХШХШТХ-ийн адил зохицуулалт байхгүй байна. Иймд Хуулийн 90 дүгээр зүйлд зааснаар захиргааны хэрэг үүсгэхээс бусад бүх захирамж, тогтоолд гомдол гаргаж болно гэж ойлгоно. Цаашид хуульд өөрчлөлт орвол өөрөөр зохицуулагдаж болох юм.

Захиргааны хэрэг үүсгэж байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлж буй явдал бөгөөд цаашид үргэлжлүүлэн явуулах үндэс суурь нь болдог. Энэ нь зөвхөн дотоод харилцаанд хамааралтай, уг захирамжийн талаар хэргийн оролцогчдод заавал мэдэгдэх шаардлагагүй,

Шүүх шүүхийн тогтоол, захирамжид хаана, ямар хугацаанд гомдол гаргах эрхтэйг болон хугацааг заавал зааж байх нь чухал.

Гомдол гаргах эрх бүхий захирамжийн талаар хэргийн оролцогчдод заавал мэдэгдэх шаардлагатай.

Гомдлыг хуулийн 90 дүгээр зүйлд заасан журмын дагуу хянах учир хуулийн энэ зүйлийн тайлбарыг үзнэ үү.

80 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн зардал,
улсын тэмдэгтийн хураамж

80.1. Захиргааны хэргийн шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийн асуудлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52-60 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэнэ.

ТАЙЛБАР

1. Захиргааны хэргийн шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийн асуудлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52-60 дугаар зүйлд заасан үндэслэл журмын дагуу шийдвэрлэхээр ишлэл татаж хуульчилжээ.

Иймд эдгээр зүйлийн дэлгэрэнгүй тайлбарыг үзнэ үү.

Захиргааны хэрийн шүүхийн онцлогт тохируулан дээрх зүйлүүдийг товч тайлбарлах нь зүйтэй байна.

ИХШХШТХ-ийн 52 дугаар зүйл. Шүүхийн зардал

- 52.1. Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг шүүхийн зардал гэнэ.
- 52.2. Шүүхийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

ТАЙЛБАР

1. ИХШХШТХ-ийн 52 дугаар зүйлийн 52.1-д зааснаас үзвэл шүүхийн зардал нь:

а. Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой гарна.

б. Уг ажиллагаатай холбоотой зайлшгүй гарах зардал байна.

Өргөн утгаар нь авч үзвэл шүүхийн хэвийн үйл ажиллагааг хангахад зориулагдсан бүх зардал нь шүүхийн зардалд тооцогдох талаар ИХШХШТХ-ийн холбогдох зүйлийн тайлбарт дурьдагджээ.

Үүний дотор захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулагдах зардал мөн багтана.

Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдон гарах зардал гэдэг нь зохигч хэргийн оролцогчдын ашиг сонирхлын үүднээс эхлээд шүүхээс төлж дараа нь тэднээс нөхөн авдаг зардал юм.

Шүүхийн зардал нь хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотойгоор гарах зайлшгүй зардал байх талаар дээр дурьдсан.

Тухайн хэрэг маргааныг үндэслэлтэй зөв шийдвэрлэхэд үнэхээр гарах байсан зардал л “зайлшгүй зардалд”-д тооцогдоно.

Түүнээс биш шүүх заавал бүрдүүлэх шаардлагагүй нотлох баримтыг бүрдүүлсэнтэй холбогдон гарсан зардал нь зайлшгүй зардалд тооцогдохгүй.

Нотлох баримтыг заавал бүрдүүлэх шаардлагатай байсан эсэхийг тогтоох гол шалгуур нь тухайн нотлох баримт нь шүүхийн шийдвэр гарахад гол үндэслэл нь болж чадсан эсэх асуудал юм.

2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой зайлшгүй гарах зардлыг эхлээд төрөөс санхүүжүүлэх талаар хуулийн 52 дугаар зүйлийн 52.2-т зохицуулжээ. Энэ зардлын тодорхой хэсгийг зохигчоор нөхөн төлүүлнэ. Хуулийн энэ зохицуулалт нь гэрч, шинжээч, орчуулагч нар зардлаа нөхөн төлүүлэх найдвартай баталгааг бий болгож байна.

53 дугаар зүйл. Нөхөн төлүүлэх шүүхийн зардал

53.1. Шүүхээс гаргасан дараах зардлыг зохигчоор нөхөн төлүүлнэ:

53.1.1. шинжээч, орчуулагч, хэлмэрчийн тээвэр, байр, хоолны зардал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар гүйцэтгэсэн ажил үүрэгт ажилд нь хамаарахгүй бол ажлын хөлс;

53.1.2. гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, цалин, хөдөлмөрийн хөлс;

53.1.3. үзлэг хийх, туршилт явуулах, таньж олуулах ажиллагаа явуулахад гарсан зардал;

53.1.4. эд мөрийн баримт хадгалах зардал;

53.1.5. 5.гэрчийн мэдүүлгийг очиж авсан зардал.

ТАЙЛБАР

1.Хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон гарсан зардал болгоныг бүгдийг нь зохигчдоор нөхөн төлүүлэхгүй бөгөөд зөвхөн энэ хуульд заасан 5 төрлийн зардлыг л захиргааны хэргийн оролцогч, зохигчдоор нөхөн төлүүлэх учиртай.

Орчуулагч, хэлмэрч болон шинжээчийн үйлчилгээ нь төлбөртэй байдаг бөгөөд энэ зардлыг талууд нөхөн төлдөг боловч тэргүүн ээлжид шүүхээс гаргана.

Хуульд хэдийгээр дээрх байдлаар зохицуулсан ч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн практикаас үзэхэд хэргийн зохигчдын аль нэг нь ялангуяа орчуулагч, хэлмэрчийн зардлыг өөрөө хариуцахаар тэдэнтэй тохиролцон үүрэг хүлээж байна. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүх өөрийн санаачилгаар нотлох баримтыг бүрдүүлэх эрхгүй бөгөөд ийм тохиолдолд шинжээч томилуулахаар хүсэлт гаргасан этгээд мөн зардлыг шүүхийн оролцоогүйгээр өөрөө хариуцах үүрэг хүлээх тохиолдол ч байна.

Тэгвэл захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох үүргийг талууд биш шүүх өөрөө хүлээдэг онцлогтой тул дээрх зардлыг ихэвчлэн хуульд зааснаар эхлээд шүүх, дараа нь зохигчдоор нөхөн төлүүлэх журмаар гаргуулж байна.

Шүүхээс гаргасан зардлыг зохигчоор нөхөн төлүүлэхдээ шүүхийн шийдвэрээр бүрэн эсвэл заримыг нь гаргуулна.

2.Гэрч, үзлэг, туршилт хийх, эд мөрийн баримт хадгалахтай холбогдсон шүүхийн зардлыг дээрх журмаар нөхөн төлүүлнэ.

3.Шүүхээс урьдчилан төлөх зардал, нөхөн төлүүлэх зардлын талаарх баримт хэрэгт зайлшгүй хавсаргагдсан байх шаардлагатай.

Шүүх тухайн зардлын талаарх нотлох баримтад тусгагдсан тооцоог нягтлан шалгаж, уг зардлыг эхлээд төрийн сангаас, дараа нь хэргийн аль оролцогчоос нь гаргуулах талаар шүүхийн шийдвэрт тодорхой зааж өгөх нь зүйтэй юм.

54 дүгээр зүйл. Нөхөн төлүүлэх шүүхийн зардлын хэмжээг
Тодорхойлох

54.1. Нөхөн төлүүлэх шүүхийн зардлыг дараах журмаар тодорхойлно:

- 54.1.1. шинжээч, орчуулагч, хэлмэрч, гэрчид олгох тээвэр, байр, хоолны зардлыг улсын төсвөөс санхүүждэг байгууллагад мөрдөгдөж буй албан томилолтын зардлын хэмжээгээр;
 - 54.1.2. шинжээч, орчуулагч, хэлмэрчийн ажлын хөлсийг шүүхээс төлсөн хэмжээгээр;
 - 54.1.3. мэдүүлэг өгөхөөр шүүхэд дуудагдсан хугацаанд гэрч цалин, хөдөлмөрийн хөлсөөр хохирсон бол энэ хугацааны цалин, хөдөлмөрийн хөлсний дунджаар;
 - 54.1.4. бусад зардлыг гүйцэтгэлийн баримтад заасан хэмжээгээр.
- 54.2. Зардлыг шүүхээс заасан улсын төсвийн дансанд тушаана.

ТАЙЛБАР

1. Нөхөн төлүүлэх зардлын хэмжээг шүүх өөрөө дур мэдэн тодорхойлж болохгүй бөгөөд хэрэгт авагдсан тооцооны баримтыг үндэслэн хуульд заасан журмаар хэмжээг нь тодорхойлж төлүүлнэ. Шүүх хуульд заасан хэмжээнээс илүү хэмжээгээр нөхөн төлүүлэхийг шаардах мөн зардлыг төлүүлэхгүй байх эрхгүй болно.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүхийн практикаас үзэхэд зардал авах эрх бүхий этгээд өөрөө хүсэлтээ гаргахгүй л бол шүүх зардлыг тэр бүр шийдвэрлэхгүй байгаа нь буруу юм.

Нотлох үүргийг өөрөө хүлээдэг Захиргааны хэргийн шүүхийн хувьд хүсэлт гаргасан эсэхээс үл хамааран дээрх зардлын асуудлыг зайлшгүй шийдвэрлэж байх нь чухал гэдгийг анхаарвал зохино.

1.1 Шинжээч, орчуулагч, хэлмэрч, гэрчид олгох тээвэр, байр, хоолны зардлыг Улсын төсвөөс санхүүждэг байгууллагад мөрдөгдөж байгаа албан томилолтын зардлын хэмжээгээр тодорхойлох бөгөөд албан томилолтын зардлын хэмжээг Засгийн газраас тогтооно.

Тухайлбал: Монгол Улсын Сангийн сайдын 2006 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 64 дүгээр тушаалаар 2006 оны 4 дүгээр сарын 01-ээс эхлэн төрийн болон төрийн захиргааны албан хаагчийн албан томилолтын зам хоног, байрны зардлын хэмжээг аймагт 15.500 төгрөгөөр, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 23.500 төгрөгөөр, төрийн тусгай болон төрийн үйлчилгээний албан хаагчийн хувьд зам хоногийн зардлыг аймаг, нийслэлд 6500 төгрөгөөр, аймгийн төвөөс сумдад ажиллах төрийн албан хаагчийн албан томилолтын зам хоногийн зардлыг 4500 төгрөгөөр тус тус тогтоож олгохоор заажээ.

Дээрх хэмжээ нь бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ, тарифын өсөлттэй уялдан өөрчлөгдөж болох тул нөхөн төлөх зардлыг төлүүлэх үеийн тогтоосон хэмжээг баримталж байх нь зүйтэй.

1.2. Шинжээч, орчуулагч, хэлмэрчийн ажлын хөлсийг шүүхээс төлсөн хэмжээгээр тодорхойлохын тулд шүүх зардлыг тооцоходоо ямар шалгуур баримтлах вэ гэдэг чухал.

Өнөөгийн шүүхийн практикт ихэвчлэн эдгээр этгээдийн өөрсдийнх нь тодорхойлж, нэхэмжилсэн хэмжээгээр шүүх зардлыг төлж байна.

Хэдийгээр зардлыг хэргийн зохигчдын хэн нэг нь нөхөн төлөх учиртай ч зардлыг шүүх аль болох бодитой тогтоохыг эрмэлзэх учиртай.

Үүний тулд Иргэний хуулийн 344 дүгээр зүйлд заасан "Ажил гүйцэтгэгчид төлөх хөлс"-ний талаарх зохицуулалтыг анхаарвал зохино.

Дээрх зардлыг шүүх өөрийн санаачилгаар эхэлж тогтоох нь зохимжгүй.

Ажлын хөлсний талаарх баримтаа орчуулагч, хэлмэрч, шинжээч нь өөрсдөө тодорхойлж шүүхэд баримтаа гаргаж өгөх, шүүх үүнийг нягтлан шалгана.

Шүүх хөлсний хэмжээг бодит байдалд нийцүүлэн өөрчлөх эрхтэй байна.

1.3. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн санаачилгаар мэдүүлэг өгөхөөр шүүхэд гэрчээр дуудагдсан этгээдийн энэ хугацаанд цалин, хөдөлмөрийн хөлсөөр хохирсон бол баримтыг үндэслэж шүүх дээрх зардлыг хариуцан төлж, үүнийг зохигчдоор нөхөн төлүүлнэ. Нөхөн төлүүлэхдээ шүүхийн санаачилгаар

дуудагдсан гэрчийн зардлыг нэхэмжлэгч, хариуцагч нарын аль алианаар нь хуваан нөхөн төлүүлж болно.

Харин хэргийн оролцогчийн хэн нэг нь гэрч асуулгах хүсэлт гаргасан бол шүүх тухайн этгээдээр зардлыг нөхөн төлүүлнэ. Энэ талаар хүсэлт гаргасан этгээдэд урьдчилан тайлбарлаж, ойлгуулах юм.

1.4.Бусад зардал гэдэгт үзлэг хийх, туршилт явуулах, таньж олуулах, эд мөрийн баримт хадгалах, гэрчийн мэдүүлгийг газар дээр нь очиж авсан зардал хамаарна.

Уг зардлыг гүйцэтгэлийн баримтад заасан хэмжээгээр нөхөн төлүүлнэ гэдгийг дээрх ажиллагааг явуулахад гарсан зардлын хэмжээгээр гэж ойлгох бөгөөд энэ нь нотлох баримтаар тогтоогдсон байх шаардлагатай.

2.Зардлыг шүүхээс заасан улсын төсвийн дансанд тушаана гэдгийг шүүх шийдвэртээ зардлыг тушаах дансыг заавал заах шаардлагатай гэж ойлгох бөгөөд бүх зардал улсын төсөвт төвлөрч байгаа учир шүүх шийдвэртээ “төрийн сангийн орлогод” гэж зааж байгаа нь буруу биш юм.

55 дугаар зүйл. Шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх

55.1. Зохигч төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар болон бусад нотлох баримтаар тогтоогдсон, эсхүл хуульд заасан бусад үндэслэл байвал зохигчийг шүүхийн зардал нөхөн төлөхөөс шүүгчийн захирамжаар чөлөөлж болно.

55.2. Шүүх тухайн этгээдийн эд хөрөнгийн болон бусад байдлыг харгалзан шүүхийн зардлыг нөхөн төлөх хэмжээг багасгах буюу хугацааг хойшлуулах, эсхүл хэсэгчлэн төлүүлж болно.

ТАЙЛБАР

1.Шүүхийн шийдвэрээр зохигчийг шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс чөлөөлж болно.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед зохигчийг шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх тухай асуудлыг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны адил зөвхөн зохигчийн хүсэлтээр чөлөөлөх юм.

Ийнхүү чөлөөлөх үндэслэл нь зохигч төлбөрийн чадваргүй байх. Энэ нь түүний тайлбар, нотлох баримтаар тогтоогдсон байх ёстой.

Хуульд заасан бусад үндэслэл байж болно.

Шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс чөлөөлүүлэх тухай хүсэлт гаргагч нь ямар учраас зардлыг нөхөн төлөх боломжгүй талаар хүсэлтээ тодорхой бичиж, холбогдох баримтыг хавсаргасан байна.

Тухайлбал: Төлбөрийн чадваргүй талаар засаг захиргааны байгууллагын тодорхойлолт, орлогын мэдүүлэг гэх мэт байж болно.

Шүүх зохигчоос гаргасан хүсэлт нь үндэслэл бүхий байна гэсэн дүгнэлтэд хүрвэл шүүгчийн захирамжаар түүнийг шүүхийн зардлыг нөхөн төлөхөөс бүр мөсөн чөлөөлж болно.

2.Шүүх төлбөрийн чадваргүй үндэслэлээр бүрэн чөлөөлөх шаардлагагүй гэж үзвэл

а.нөхөн төлөх зардлын хэмжээг багасгах

б.төлөх хугацааг хойшлуулах

в. Хэсэгчлэн төлүүлэх арга хэмжээ авна.

Энэ талаар шүүгчийн захирамжаар шийдвэрлэнэ.

Шүүгчийн захирамжид зардлын хэмжээг багасгаж байгаа бол хэмжээг, хугацааг хойшлуулах бол ямар хугацаагаар хойшлуулж байгаа, хэдийд төлөх, хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэж байгаа бол ямар хэмжээгээр төлөхийг тодорхой заана.

Мөн хэмжээг багасгах, хугацааг хойшлуулах, хэсэгчлэн төлүүлэх болсон үндэслэл, шалтгааныг тодорхой заавал зохино.

56 дугаар зүйл.Нөхөн төлүүлэх шүүхийн зардлыг хуваарилах

- 56.1. Шүүхийн зардлыг нэхэмжлэл бүрэн хангагдсан тохиолдолд хариуцагчаар, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд нэхэмжлэгчээр нөхөн төлүүлнэ.
- 56.2. Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан бол шүүхийн зардлыг тэр хэмжээгээр хариуцагч буюу нэхэмжлэгчид хуваарилан хариуцуулна.
- 56.3. Хяналтын шатны болон давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилбөл шүүхийн зардлын хуваарилалтыг нэгэн адил өөрчлөн шийдвэрлэнэ.
- 56.4. Зохигч эвлэрэхдээ шүүхийн зардлыг өөрөөр хуваарилахаар тохиролцоогүй бол шүүх энэ зүйлд заасан журмаар шийдвэрлэнэ.
- 56.5. Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзвал хариуцагч шүүхийн зардлыг нөхөн төлөхгүй. Харин хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг сайн дураар хүлээн зөвшөөрч биелүүлсэн шалтгаанаар нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан бол хариуцагчийн төлөх шүүхийн зардлыг тавин хувиар хөнгөлнө.

ТАЙЛБАР

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөхөн төлүүлэх шүүхийн зардлыг хуваарилах журам нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал хуваарилахтай адил журмаар зохицуулагдах тул ИХШХШТХ-ийн 56 дугаар зүйлийн тайлбарыг үзнэ үү.

57 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамж

- 57.1. Шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлсний төлөө зохигчоос төлж байгаа мөнгөн хөрөнгийг улсын тэмдэгтийн хураамж гэнэ. Улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан нэхэмжлэгчээр төлүүлж нэхэмжлэл

хангагдсан тохиолдолд хариуцагчаар төлүүлэн нэхэмжлэгчид буцаан олгоно. Улсын тэмдэгтийн хураамжийг энэ хуульд заасны дагуу төлнө.

- 57.2. Хэрэг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдуулж төлөх улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг Тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар зохицуулна.
- 57.3. Хураамжийг буцаан олгох, нөхөн төлүүлэх, чөлөөлөх тухай асуудлыг Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн холбогдох заалт болон энэ хуулийн 58, 59 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

ТАЙЛБАР

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай ойлголт, түүнийг төлүүлэх хувь хэмжээний талаар ИХШШТХ-ийн 57 дугаар зүйлийн тайлбарт дэлгэрэнгүй байгаа тул энд зөвхөн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд улсын тэмдэгтийн хураамж хэрхэн төлөгдөж байгаа онцлогийн талаар тайлбарлах нь зүйтэй гэж үзэв.

1. ИХШШТХ-ийн 62 дугаар “нэхэмжлэлийн бүрдүүлбэр” гэсэн зүйлийн 62.2-т “нэхэмжлэлд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, эсхүл уг хураамжаас чөлөөлөх тухай хүсэлт, ...хавсаргана”

Мөн хуулийн “нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах” тухай 65 дугаар зүйлийн 65.1.11-д “энэ хуулийн 62 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй байвал” гэж нэхэмжлэгч нь шүүхэд нэхэмжлэл гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжийг заавал төлсөн байх, төлөөгүй тохиолдолд түүнийг нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй гэж үзэж нэхэмжлэлийг нь хүлээн авахаас татгалзах тухай тодорхой зохицуулжээ.

Гэтэл ЗХХШТХ-д ийм тодорхой заасан зохицуулалт байхгүй байна.

Тухайлбал хуулийн 32; 33; 34 дүгээр зүйлээс энэ талаар тодорхой харж болно.

Гэвч энэ нь Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргахад улсын тэмдэгтийн хураамжийг заавал төлүүлэх, энэ талаарх баримтыг шүүхэд нэхэмжлэл гаргахдаа хавсаргах шаардлагагүй гэсэн ойлголт огт биш гэдгийг ойлговол зохино.

Эрх зүйн маргааныг шийдвэрлэхийн тулд төрийн байгууллагын-шүүхийн үйлчилгээг авсныхаа төлөө улсын тэмдэгтийн хураамжийг төлөх нь нэхэмжлэгчийн үүрэг юм.

Дээр дурьдсан ЗХХШТХ-ийн холбогдох зүйлд энэ талаар тодорхой заагаагүй боловч хуульд ИХШШТХ-ийн 57 дугаар зүйлд зааснаар улсын тэмдэгтийн хураамжийг зохицуулахаар ишлэл авсан байгааг анхаарна уу.

ИХШШТХ-ийн 57 дугаар зүйлд “...улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан нэхэмжлэгчээр төлүүлж, нэхэмжлэл хангагдсан тохиолдолд хариуцагчаар төлүүлж, нэхэмжлэгчид буцаан олгоно...” гэж заасан нь нэхэмжлэгч шүүхэд нэхэмжлэл гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжийг заавал төлсөн байхыг үүрэг болгосон заалт гэж ойлгогдоно.

Иймд Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан этгээд нь улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлөөгүй тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзалгүйгээр хуулийн 33 дугаар зүйлд заасан журмаар түүнийг төлүүлэхээр хугацаа тогтооно. Харин шүүхээс тогтоосон хугацаанд улсын тэмдэгтийн хураамжийг төлөөгүй тохиолдолд нэхэмжлэлийг буцаах юм. Хугацааг тогтоох, буцаах журмын талаар хуулийн 37 дугаар зүйлийн тайлбараас тодорхой үзнэ үү.

2.Шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхэд хураах хураамжийн хэмжээг Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлжээ.

Дээрх хуульд заасан хувь хэмжээ захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэр бүр бүрэн хэрэгждэггүй.

Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргагч нь дээрх хуулийн 2 дугаар зүйлд “эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлж болохгүй нэхэмжлэлд 250 төгрөг” гэж заасны дагуу “захиргааны акттай” холбоотой маргаан гэдгээр шат шатны шүүхэд ердөө л 250 төгрөг төлж байна.

Өөрөөр хэлбэл “Захиргаан акт” гэдгээр анхнаасаа 250 төгрөг төлүүлж байгаа буруу практик тогтжээ.

Тэгвэл захиргааны акт болгон үнэлгээтэй байгаа. Жишээ нь: Татварт улсын байцаагч “10.000.000” төгрөг төлүүлэхээр акт тогтоосон байна гэж үзвэл энэ 10.000.000 төгрөг нь нэхэмжлэлийн үнэ болох юм. Иймд энэ үнэлгээнээс тооцож улсын тэмдэгтийн хураамжийг төлүүлж байх нь зөв.

Мөн Замын цагдаа 10.000 төгрөгийн торгуулийн хуудас бичиж гэж бодоход мөн энэ хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамжийг төлж болох юм.

Захиргааны актад дурьдсан үнэлгээгээр нэхэмжлэлийн үнийг тодорхойлж болох талаар цаашид холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлага зүй ёсоор гарч байгаа нь дээр дурьдсанаас тодорхой байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд улсын тэмдэгтийн хураамжийг нөхөн төлүүлэх, хураамжаас чөлөөлөх, буцаах, хуваарилах асуудал нь ИХШХШТХ-ийн 58, 59, 60 дугаар зүйлд заасан журмаар зохицуулагдах тул эдгээр зүйлийн тайлбарыг үзнэ үү.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан
шийдвэрлэх ажиллагаа

81 дүгээр зүйл. Давж заалдах гомдол гаргах, гомдлыг

хүлээн авах

- 81.1. Анхан шатны журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлээд гаргасан захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, эсхүл тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гардуулсан буюу энэ хуулийн 72.3-т заасны дагуу хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор давж заалдах гомдлоо Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимд гаргах эрхтэй.
- 81.2. Энэ хуулийн 81.1-д заасан этгээд хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд оролцоогүй бол захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор давж заалдах гомдол гаргах эрхтэй.

- 81.3. Анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдлыг талуудын аль нэг нь гаргасан явдал эсрэг талын хяналтын журмаар гомдол гаргах эрхийг үл хязгаарлана.
- 81.4. Нэхэмжлэгч, хариуцагч талын аль нэг, эсхүл хамтран нэхэмжлэгч болон хамтран хариуцагчийн аль нэг нь давж заалдах, нөгөө нь хяналтын журмаар гомдол гаргасан бол давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд хэргийг бүхэлд нь хянана.
- 81.5. Давж заалдах гомдлыг тухайн шийдвэрийг гаргасан захиргааны хэргийн шүүхээр дамжуулан гаргана.
- 81.6. Давж заалдах гомдлыг тухайн захиргааны хэргийг шийдвэрлэсэн шүүгч буюу шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хүлээн авч, уг гомдол болон түүнд хавсаргасан баримт бичгийг эсрэг талд, шаардлагатай бол гуравдагч этгээдэд танилцуулах бөгөөд, тэдгээрийн тайлбарыг авч, хэрэгт хавсаргаж болно.
- 81.7. Энэ хуулийн 81.5.-д заасан шүүх давж заалдах гомдолд хариуцагч, гуравдагч этгээдээс гаргасан тайлбарыг хавсарган хэргийн хамт уг гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ.

ТАЙЛБАР

Энэ зүйлд захиргааны хэргийн оролцогчийн давж заалдах гомдол гаргах эрхийг хэрэгжүүлэх арга журмыг тодорхойлсон байна. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хууль ёсны ба үндэслэл /иргэн хуулийн этгээдийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхол анхан шатны захиргааны хэргийн шүүхээр хамгаалагдаж чадаагүй байх тохиолдол бий/ бүхий байх, захиргааны хэргийг зөв шийдвэрлэх асуудал захиргааны шүүн таслах ажиллагааны цөм ойлголт. Анхан шатны шүүхийн тодорхой хэрэг хянан шийдвэрлэсэн ажиллагаа, түүний шийдвэр алдаатай байх тохиолдол байдаг.

Иймд нэг талаас иргэн хүн дээд шатны Шүүхээр эрхээ хамгаалуулах, нөгөө талаас дээд шатны шүүх анхан шатны шүүхийн алдааг засах, шүүхийн шийдвэрт шүүмжлэлтэй хандах асуудал зайлшгүй тавигдана.

Дээд шатны шүүхийн эрх зүйн хамгаалалт зайлшгүй шаардлагатай болсон нөхцөлд анхан шатны захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт гомдол гаргах бөгөөд гомдол нь үндэслэл бүхий байж тодорхой үр дүнд хүрнэ.

Шүүхийн шийдвэрт давж заалдах, эсхүл хяналтын гомдол заавал гаргаж байх ёстой биш.

Энэ зүйлийн 81.1-д заасан этгээдээс давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах эрхийг аливаа хэлбэрээр хязгаарлаж болохгүй.

Захиргааны хэргийн оролцогч шүүхийн анхан шатанд эрх ашиг сонирхлоо бүрэн хамгаалуулж чадсан гэж үзвэл тухайн шийдвэрт давж заалдах гомдол гаргах хэрэгцээ, шаардлага байхгүй болно.

Давж заалдах эрхээр хангах нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах баталгааны чухал хэсэг.

Захиргааны хэргийн оролцогчоос давж заалдах эрхээ хэрхэн хэрэгжүүлэх нь өөрсдөөс нь шууд хамааралтай юм.

Захиргааны хэргийн нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд давж заалдах гомдол гаргах эрхээ өөрөө биечлэн эсхүл төлөөлөгч, өмгөөлөгчөөрөө дамжуулан давж заалдах шатанд хандаж гомдол гаргаж хэрэгжүүлнэ.

Давж заалдах гомдол гаргах процессын эрхийг иргэн, хуулийн этгээд чөлөөтэй эдлэх эрхтэй.

Давж заалдах эрхээ хэрхэн ашиглах нь хэргийн оролцогчийн өөрийн үзэмжийн асуудал бөгөөд шүүх хуралдаанд оролцоогүй байсан ч захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрхээ бодитойгоор эдэлнэ.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 100 дугаар зүйлийн 100.2, 100.3, 100.4-д заасан журмын дагуу хэргийн аль нэг оролцогчийн эзгүйд захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх хуралдаанд оролцоогүй оролцогч давж заалдах гомдол гаргах эрхтэй байна.

Шүүх хуралдаанд эзгүй байсан этгээдэд шүүхийн шийдвэрийн хувийг гаргуулах, давж заалдах гомдлыг хүлээж авах зэрэг асуудал шүүх хуралдаанд оролцсон этгээдийнхтэй адил байна.

Захиргааны хэргийн оролцогчид өөрөө эсхүл тэд төлөөлөгч, өмгөөлөгчөөрөө дамжуулан давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргах эрхээ сонгож хэрэгжүүлэхэд хэн ч тэднийг давж заалдах буюу хяналтын журмаар гаргах эсэхийг хөндлөнгөөс албадах, тулган шаардах ёсгүй.

Иргэн хүн өмгөөлөгчөөс эрх зүйн туслалцаа авч давж заалдах эсхүл хяналтын журмаар гомдол гаргах эсэхээ сонгож буй явдлыг хөндлөнгийн шахалт дарамт гэж үзэхгүй.

Давж заалдах гомдол гаргах эрх энэ хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-т заасан хугацааны дотор хэрэгжих тул уг хугацаа дуусгавар болсноор давж заалдах гомдол гаргах боломжгүй болно.

Хэрэв давж заалдах гомдол гаргах эрх бүхий субъектүүд /Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1/ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр давж заалдах гомдол гаргах хуулийн хугацааг хэтрүүлбэл уг эрхээ алдана.

Шүүхийн практикт хугацаа хожих, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хойшлуулах зэрэг хувийн шалтгаанаар давж заалдах эрхээ буруугаар ашиглах тохиолдол цөөнгүй гардаг.

1. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргаснаар шүүхийн шийдвэрийг дахин хянах шүүхийн алдааг засах үндэслэл бий болох ба давж заалдах шатны ажиглагаа эхэлнэ.

Хуулийн энэ зүйлд давж заалдах гомдол гаргах үндэслэлийг нарийвчлан тусгаагүй. Өөрөөр хэлбэл энэ хуульд ямар нөхцөлд давж заалдах гомдол гаргаж болох үндэслэлийг тодорхойлж заагаагүй.

Энэ хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1-т заасан “шийдвэр” гэдэгт Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.1-70.2.9-д заасны дагуу

гаргасан аймаг, нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрүүд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 76 дугаар зүйлд заасны дагуу гаргасан нэмэлт шийдвэр мөн адил хамаарна. Өөрөөр хэлбэл эдгээр шийдвэрт гомдол гаргана гэж ойлгоно.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хянаж үзэх зүйл нь анхан шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгож захиргааны хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр байна. Гомдол гаргах эрх бүхий субъект нь тухайн захиргааны хэргийн оролцогч байна.

2.Тухайн захиргааны хэргийн нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд анхан шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд оролцсон эсэхээс үл хамааран давж заалдах гомдол гаргах эрхийг эдэлнэ.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч гомдол гаргаснаар эрх зүйн тодорхой үр дагаврууд үүсдэг. Үүнийг эрх зүйн хэрэгсэл гэж нэрлэдэг байна.

- Давж заалдах гомдол гаргаснаар захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаа зогсох бөгөөд захиргааны хэргийг давж заалдах шатаар эцэслэн шийдвэрлэхээс өмнө тухайн захиргааны хэргийн шийдвэрийн үйлчлэл үүсэхгүй.
- Давж заалдах гомдол гаргаснаар захиргааны хэрэг дээд шатны шүүхэд шилжинэ ингэснээр тухайн хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал өөрчлөгдөнө.

Хуулиар эрх олгогдсон этгээд давж заалдах журмаар гомдол гаргаж захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүхээр хянуулах нь хэргийн оролцогчдод зөрчигдсөн эрх ашиг сонирхлоо дээд шатны шүүхээр хамгаалуулах өргөн боломж олгодог ба хяналтын журмаар хянуулахаас давуу талтай.

3.Давж заалдах гомдлыг хүлээн авч байгаа анхан шатны шүүхийн шүүгч эсхүл нарийн бичгийн дарга нь тухайн гомдол гаргагчид дээд шатны шүүхийн эрх зүйн хамгаалалт шаардлагатай эсэхийг урьдчилан тогтоох боломжгүй тул энэ хуульд заасан журмын дагуу гомдлыг тухайн захиргааны хэргийн хамт давж заалдах шатны шүүхэд хүргүүлэх үүрэгтэй.

4.Энэ зүйлд шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах этгээдийг нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч гэж тодорхой нэрлэн заасан тул хэргийн талаар ямар нэг сонирхолгүй этгээд болох гэрч, шинжээч нь шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхгүй байна.

Харин нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн төлөөлөгч, өмгөөлөгч нь итгэмжлэлд тусгайлан заасан /Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-ийн тайлбарыг үз/ тохиолдолд итгэмжлэгчийн нэрийн өмнөөс давж заалдах гомдол гаргах эрх эдэлнэ.

5.Энэ зүйлийн 81.1-т заасан "... давж заалдах гомдол ..." гэдгийг анхан шатны захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг буруу гэж үзэж дээд шатны шүүхээр дахин хянуулахаар хэргийн талаар сонирхол бүхий этгээдээс хуульд заасан хугацааны дотор гаргасан гомдол гэж ойлгоно.

6.Энэ зүйлийн "шийдвэрийг гардуулсан" гэдгийг шүүхийн эрх бүхий албан тушаалтнаас ёсчилсон шүүхийн шийдвэрийн хувийг хэргийн оролцогч, гуравдагч этгээдэд өөрт нь биечлэн өгснийг ойлгоно.

Итгэмжлэлд хэргийн оролцогчийн нэрийн өмнөөс шүүхийн шийдвэрийг гардан авах тухай заагаагүй бол шүүх хуралдаанд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчид хүчинтэй шүүхийн шийдвэрийн хувийг гардуулсныг захиргааны хэргийн оролцогч /Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1/-д гардуулсан гэж үзэхгүй.

Шүүх хуралдаанд оролцсон эсэхээс нь үл хамааран шүүхийн шийдвэрийн хувийг хэргийн оролцогчдод хүргүүлсэн, эсхүл гардуулсан байх нь шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхийг нь бодиттойгоор эдлүүлэх урьдчилсан нөхцөл болно.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч эсхүл өмгөөлөгчид шийдвэрийн хувийг гардуулсан явдал нь нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдэд шүүхийн шийдвэрийг хүргүүлэх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

7.Хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсгийн "захиргааны хэргийн шийдвэрийг хүлээн авсан" гэдгийг хэргийн оролцогч алслагдмал газар оршин суудаг буюу оршин байрладаг нөхцөл байдалаас шалтгаалан шүүхийн шийдвэрийг гардуулан өгөх боломжгүйгээс шуудан, факс зэргээр дамжуулан тухайн шийдвэрийг гардан авбал зохих этгээдэд нь хүргүүлснийг ойлгоно.

Энэ тохиолдолд шүүхийн шийдвэрийг хүргэж өгөх албан үүрэг бүхий этгээд /шуудангийн ажилтан/ шүүхийн шийдвэрийг хүлээлгэн өгсөн он, сар, өдрийг тэмдэглэж, хүлээн авсан этгээдээр гарын үсэг зуруулсан байх шаардлага тавигдана.

Хэрэв маргаан гарвал хүлээн авсан хугацааг шүүхийн шийдвэр хүргэж өгөх үүрэг бүхий шуудан холбооны ажилтны албан бичиг баримтыг хүлээлгэн өгсөн бүртгэлийг үндэслэн давж заалдах гомдол гаргах хугацааг хэтрүүлсэн эсэхийг тодорхойлно.

8.Энэ зүйлийн 81 дүгээр зүйлийн 81.3-т заасан "талуудын аль нэг" гэснийг нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн аль нэг гэж, "эсрэг тал" гэдгийг давж заалдах гомдол гаргаагүй энэ зүйлийн 81 дүгээр зүйлийн 81.1-т нэрлэн заасан этгээдийн аль нэг нь байна гэж ойлгоно.

Гомдол гаргагч /нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд/ шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуулийн хугацаанд давж заалдах гомдлоо гаргаж чадаагүй болох нь тогтоогдвол шүүх гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацааг сэргээж давж заалдах гомдол гаргах эрхийг эдлүүлэх боломжийг хангана.

Гомдол гаргагч этгээдийн хүсэлтээр хөөн хэлэлцэх хугацааг сэргээх эсэх асуудлыг анхан шатны шүүх шийдвэрлэнэ.

Шүүхийн шийдвэрийг гардан авсан буюу хүлээн авсан этгээд нь давж заалдах гомдол гаргах хугацааг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтрүүлснийг нотолсон баримтаа өөрөө гаргах бөгөөд шүүх хүсэлтийн дагуу үндэслэлийг нь шалгаж, давж заалдах гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацааг сэргээх эсэх асуудлыг хянан үзэж шийдвэрлэнэ.

Хүндэтгэн үзэх шалтгаанд тухайлбал: гомдол гаргагч хүндээр өвчилсөн, хорио цээрийн дэглэм тогтоосон, гал усны аюул учирсан зэрэг гомдол гаргагчийн хүсэл зоригоос үл хамаарах шалтгаанууд хамаарна.

Давж заалдах гомдол гаргах хугацааг сэргээснээр хэргийн оролцогч давж заалдах гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх боломжтой болно.

82 дугаар зүйл. Давж заалдах гомдлын хэлбэр, агуулга

- 82.1. Давж заалдах гомдлын хэлбэр, агуулга нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 162.1-162. 3-т нийцсэн байна.
- 82.2. Давж заалдах гомдол гаргагч нь уг гомдлыг давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцэхэд өөрөө, эсхүл төлөөлөгч /өмгөөлөгч/-өө оролцуулахаа тодорхой бичсэн байна.

162 дугаар зүйл. Давж заалдах гомдлын хэлбэр, агуулга

- 162.1. Давж заалдах гомдлыг бичгээр гаргана.
- 162.2. Давж заалдах гомдолд дараах зүйлийг заана:
- 162.3. гомдлыг ямар шүүхэд гаргаж байгаа;
- 162.4. гомдол гаргаж буй этгээдийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, эсхүл албан тушаал, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар;
- 162.5. аль шүүхийн, ямар шийдвэрийг давж заалдаж байгаа;
- 162.6. шийдвэрийн чухам аль нотлох баримтыг зөвшөөрөхгүй байгаа, түүний үндэслэл;
- 162.7. гомдол гаргаж буй этгээдийн хүсэлт.
- 162.8. Давж заалдах гомдолд түүнийг гаргасан этгээд гарын үсгээ зурна.

ТАЙЛБАР

Аймаг, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогч /Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1/, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч эс зөвшөөрвөл давж заалдах гомдол гаргах эрхтэй.

Энэ зүйлийг тайлбарлахын тулд давж заалдах гомдол гаргах эрхийн тухай тодруулж дурьдах нь зүйтэй гэж үзэж байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн шийдвэрийг хэргийн нөхцөл байдал буюу үйл баримт талаас эсхүл зөвхөн хууль хэрэглэсэн талаас дахин хянуулах эсэхээс хамааран эрх бүхий этгээдээс гаргаж буй гомдлыг давж заалдах гомдол, хяналтын гомдол гэж ялгаж үзнэ.

Энэ хуульд давж заалдах гомдол гаргаж болох нөхцөлүүдийг урьдчилан заагаагүй бөгөөд ямар нэг хязгаарлалт хийгээгүй байна. Иймээс эрх бүхий этгээдээс гаргаж буй давж заалдах гомдол бүр дээд шатны шүүхээр хянан хэлэлцэгддэг.

Давж заалдах гомдол гаргах эрх бүхий этгээд гомдлоо тухайн захиргааны хэргийг шийдвэрлэсэн анхан шатны шүүхээр дамжуулан Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимд хандаж гаргах бөгөөд энэ хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5 –д заасан шаардлагыг зөрчиж гаргасан гомдлыг давж заалдах шатны шүүх хүлээж авахгүй.

Харин эрх бүхий этгээд давж заалдах гомдлоо Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд шуудангаар ирүүлсэн бол тухайн захиргааны хэргийг шийдвэрлэсэн анхан шатны шүүхэд нь шилжүүлэх ба түүнийг хүлээн авсан шүүх нь гомдол гаргах эрх бүхий этгээдийн давж заалдах эрхийг хангахтай холбогдсон ажиллагааг энэ хуулийн 81 дүгээр зүйлийн 81.6, 81.7-д зааснаар гүйцэтгэнэ.

Шүүх, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд өөрөө эсхүл төлөөлөгч, өмгөөлөгчөөрөө дамжуулан давж заалдах гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй.

Үүнтэй холбоотойгоор хоорондоо харилцан уялдаа бүхий хэд хэдэн үүргийг шүүх хүлээнэ. Энэ нь анхан шатны журмаар захиргааны хэргийг шийдвэрлээд гаргасан шийдвэрийг нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдэд гардуулах, давж заалдах гомдлыг хүлээн авах, давж заалдах гомдол болон хэргийг давж заалдах шатны шүүхэд хүргүүлэх зэргээр хэргийн оролцогчдоос эрхээ бодиттойгоор хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэх урьдчилсан ажиллагааг анхан шатны захиргааны хэргийн шүүх хуульд заасан журмаар гүйцэтгэнэ.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг уншиж сонсгосны дараа шүүх хуралдаан даргалагчаас шүүхийн шийдвэрийн хувийг гардуулах журам, хугацаа, давж заалдах гомдлыг тухайн шийдвэрийг гаргасан анхан шатны захиргааны хэргийн шүүхээр дамжуулан гаргах журамтай болохыг тодотгож тайлбарлаж байх нь иргэнийг аливаа хэлбэрээр чирэгдүүлж гомдоохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Шүүх хуралдаанд биечлэн оролцоогүй давж заалдах гомдол гаргах эрх бүхий этгээдэд шүүхийн шийдвэрийг гардуулах үедээ шүүхийн шийдвэрийг давж заалдах журмыг тайлбарлан өгч, тэднээс давж заалдах эрхээ хэрэгжүүлэхэд шүүх туслах үүрэгтэй.

Анхан шатны захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт хуулиар давж заалдах гомдол гаргах эрх олгогдсон этгээд давж заалдах эсвэл хяналтын журмаар гомдол гаргах эсэх асуудалтай холбогдуулан шүүгч шүүхийн шийдвэрийг уншиж сонсгосны

дараа эдгээр шатны зааг, ялгаа, гомдлыг хянаж үзэх хязгаарыг тайлбарлаж байх нь тэднээс гомдол гаргах эрхээ зөв хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг бүх шатны шүүхээр хянуулах зорилгоор гомдол гаргаж болохгүй бөгөөд давж заалдах гомдол үндэслэл бүхий байж, гомдол гаргагч дээд шатны шүүхээс эрх зүйн хамгаалалт авч чадах болно.

1. Анхан шатны журмаар захиргааны хэргийг хянан шийдвэрлээд гаргасан шүүхийн шийдвэрт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, давж заалдах гомдлыг заавал бичгийн хэлбэрээр гаргана.

2. Аймаг, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан Давж заалдах гомдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиас ишлэл татсан 162 дугаар зүйлийн 162.2 дахь хэсэгт дурьдсантай адил нөхцөлүүдийг тусгах бөгөөд харин шүүх энэ зүйлд заасан нөхцөлийг бүрэн тусгаагүй, мөн улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй гэсэн үндэслэлээр давж заалдах гомдлыг хүлээн авахаас татгалзаж болохгүй.

3. Давж заалдах гомдлыг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэгт заасан хугацаанд шүүхэд гаргах бөгөөд давж заалдах гомдлыг биеэр эсхүл шуудан, харилцаа холбооны байгууллагаар дамжуулан анхан шатны шүүхэд хүргүүлж болно.

Давж заалдах гомдол гаргах “14 хоногийн дотор” гэсэн хугацааг Иргэний хуулийн 72 дугаар зүйлд заасан журмыг баримтлан тоолно.

3. Хуулийн 162.2 –т заасан доорх зүйлийг тухайлбал:

Ямар шүүхэд гаргаж байгаа” гэдгийг шүүхийн хувьд Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимыг ойлгоно.

- “Гомдол гаргаж буй этгээд” нь давж заалдах гомдол гаргаж буй захиргааны хэргийн оролцогч Монгол Улсын, гадаал улсын, харьяалалгүй иргэний овог, эцгийн нэр, нэр, хаяг
- “Албан тушаал” гэдэгт хуулийн этгээдийг төлөөлж байгаа этгээдийн албан тушаал гэж ойлгоно.
- “Хуулийн этгээд бол” гэдгийг гомдол гаргаж байгаа хэргийн оролцогч нь хуулийн этгээд байвал гэж ойлгоно.
- “Оноосон нэр” гэдэгт хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд дурьдсан нэрийг хэлнэ.
- “Аль шүүхийн” гэдгийг захиргааны хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэсэн шүүхийн нутаг дэвсгэрийн харьяаллыг ойлгоно.
- “Ямар шийдвэрийг” гэдэгт давж заалдах гомдол гаргаж буй этгээд хэргийн оролцогчоор оролцсон захиргааны хэргийн талаар гарсан аймаг, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг ойлгоно.

Давж заалдах гомдолд дээрх зүйлийг заавал тусгана. Түүнчлэн давж заалдах гомдол гаргах эрх бүхий этгээд гомдлоо:

- Анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч байгаа үндэслэл болон давж заалдах шатны шүүхэд гаргаж байгаа хүсэлт,
- Шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон буюу хэрэгт хамааралтай аль нотлох баримтыг ямар үндэслэлээр зөвшөөрөхгүй байгаа,
- Давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцох эсэх болон шинэ нотлох баримтын талаарх хүсэлтийг тусгасан байх шаардлагатай.

4. Гомдол гаргасан этгээд давж заалдах гомдлыг өөрийн хүсэл зоригоор гаргах бөгөөд гомдолд өөрөө гарын үсэг зурсан байна.

Давж заалдах гомдол гаргах эрх бүхий этгээд гомдолд гарын үсэг зураагүй, итгэмжлэлээр давж заалдах гомдол гаргах эрх олгоогүй бол шүүх тухай этгээдийн гомдлыг хүлээж авахгүй.

83 дугаар зүйл. Давж заалдах гомдлоос татгалзах

- 83.1. Давж заалдах гомдол гаргасан этгээд шүүх бүрэлдэхүүн, шүүгч зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө хэрэг шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд давж заалдах гомдлоосоо татгалзах эрхтэй.
- 83.2. Давж заалдсан этгээд давж заалдах шатны шүүх хуралдаан эхлэхээс өмнө гомдлоосоо татгалзвал түүнийг давж заалдах гомдол гаргаагүйд тооцох ба харин шүүх хуралдааны явцад татгалзвал захиргааны хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг хэрэгсэхгүй болгох тухай шүүхийн магадлал гаргана.

ТАЙЛБАР

1. Энэ зүйлийн 83.1-ийн “давж заалдах гомдол гаргасан этгээд” гэдгийг анхан шатны Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр буруу болсон гэж үзэж, дээд шатны шүүхээс эрх зүйн хамгаалалт авахыг хүсч байгаа хэргийн оролцогч тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гэж, мөн хэсгийн “шүүх бүрэлдэхүүн” гэдгийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.3-д заасан “3 шүүгчийн бүрэлдэхүүн” гэж тус тус ойлгоно.

Давж заалдах гомдол гаргасан тухайн хэргийн оролцогчийн хувьд “гомдлоос татгалзах” нь өөрийнх нь хүсэл зоригийн илэрхийлэл байна. Харин гомдол гаргасан бусад этгээдийн хувьд уг татгалзал нь ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй, өөрөөр хэлбэл эрх зүйн үр дагавар үүсэхгүй харин давж заалдах гомдлоос татгалзсан этгээдийн хувьд гомдол гаргаагүйд тооцогдох үр дагавартай.

Дээд шатны шүүхэд давж заалдах гомдол гаргах эрх бүхий бусад этгээдийн гомдлыг үндэслэн хэргийг хянан хэлэлцэхэд давж заалдах гомдлоос татгалзсан этгээдийн “татгалзал” саад болохгүй.

2. Энэ хэсэгт заасан “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шат” гэдгийг давж заалдах гомдлыг анхан шатны шүүх хүлээж авсан үеэс давж заалдах шатны шүүх хуралдаан завсарлахыг мэдэгдэх хүртэлх үеийг хамааруулна. Түүнчлэн хэргийн оролцогчдын гомдлоос татгалзах эрх нь хяналтын шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ч хэрэгжүүлнэ.

Хуулийн 83 дугаар зүйлд давж заалдах гомдлоосоо татгалзаж үл болох тохиолдлыг зохицуулсан заалт байхгүй байна.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим давж заалдах шатны шүүхийн үүргийг давхар хэрэгжүүлдгээс хамааран тухайн захиргааны хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэсэн аймгийн Захиргааны хэргийн шүүх давж заалдах гомдлыг хүлээн авсны дараа гомдол гаргаагүй талд танилцуулж хэргийг 3 хоногийн дотор Улсын Дээд шүүхэд хүргүүлнэ.

Энэ зүйлийн 83.2-т заасан “магадлал” гэснийг “шүүхийн тогтоол”-ын адил утгаар ойлгоно. Гомдол гаргасан этгээд давж заалдах шатны шүүх хуралдаан эхлэхээс өмнө гомдлоосоо татгалзвал түүнийг давж заалдах гомдол гаргаагүйд тооцож захирамж гаргана. Харин шүүх хуралдааны явцад татгалзвал шүүх бүрэлдэхүүн захиргааны хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг хэрэгсэхгүй болгох тухай магадлал (шүүхийн тогтоол гэсэн үг) гаргана.

84 дүгээр зүйл. Шүүх хуралдаанд оролцох

84.1. Хэргийн оролцогч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд, прокурор давж заалдах шатны шүүх хуралдаанд биеэр оролцохыг хүсвэл шүүх тэдгээрт тухайн шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг мэдэгдэж, шүүх хуралдаанд биеэр оролцох эрхийг нь хангана.

84.2. Энэ зүйлийн 84.1-д заасан этгээд шүүх хуралдаанд ирээгүй явдал давж заалдах журмаар захиргааны хэргийг шийдвэрлэхэд саад болохгүй.

ТАЙЛБАР

Энэ хэсгийн 84 дүгээр зүйлийн 84.1-д заасан субъект болох хэргийн оролцогч түүний төлөөлөгч өмгөөлөгч, гуравдагч этгээдийн хэн аль нь давж заалдах гомдол гаргасан бол шүүх хуралдаанд оролцох тухай хүсэлтээ давж заалдах гомдолдоо заавал бичсэн байна.

Давж заалдах гомдол гаргаагүй хэргийн оролцогч шүүх хуралдаанд биеэр оролцох хүсэлтээ амаар, бичгээр, телефон утас, факс зэрэг ямар ч хэлбэрээр илэрхийлж болно.

1. Давж заалдах шатанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд /түүний төлөөлөгч, өмгөөлөгч/-ийн хуулиар олгогдсон шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах гол үндэслэл нь давж заалдах шатны шүүх хуралдааны товыг мэдэгдэх явдал.

Шүүх хуралдааны товыг хуульд заасан журмын дагуу мэдэгдэх үүргийг шүүхийн захиргаа хариуцна.

Давж заалдах шүүх хуралдаан явуулах бэлтгэлийг хангах явцад хуралдааны товыг мэдэгдэх үүргийг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ.

2. Давж заалдах шатны шүүх хуралдааны товыг гомдол гаргасан этгээдээр хязгаарлахгүй тухайн хэргийн давж заалдах гомдол гаргаагүй хэргийн бусад оролцогчид мэдэгдэж болно. Энэ нь давж заалдах шатанд мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангахад чухал ач холбогдолтой.

3. Захиргааны хэргийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэдэг ба давж заалдах шатны шүүх шинээр цуглуулсан, хуулийн шаардлага хангасан эргэлзээгүй нотлох баримтыг үнэлж, дүгнэх үндэслэл болгох эрхтэй тул давж заалдах шүүх шаардлагатай гэж үзвэл биечлэн оролцох хүсэлт гаргасан эсэхээс үл хамааран өөрийн санаачлагаар хэргийн оролцогчдыг шүүх хуралдаанд оролцуулж болно. Энэ тохиолдолд шүүх хуралдааны товыг хуульд заасан журмын дагуу нэгэн адил мэдэгдэнэ.

4. Энэ хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д давж заалдах шатны шүүх хуралдаанд биечлэн оролцох эрх бүхий этгээдийг нэрлэн заасан байна.

Нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцох хүсэлтийг нэгэн адил гаргах эрхтэй.

Давж заалдах шатны шүүх хуралдаанд хэргийн оролцогч өөрөө биечлэн оролцох хүсэлт гаргасан тохиолдолд анхан шатны шүүх хуралдаанд оролцсон төлөөлөгчид шүүх хуралдааны товыг мэдэгдэх шаардлагагүй болно.

Шүүх хуралдаанд биечлэн оролцох хүсэлтээ давж заалдах гомдолдоо илэрхийлсэн этгээдэд захиргааны хэргийг хянаж хэлэлцэх өдөр, цагийг тодорхой мэдэгдэх ёстой.

5. Энэ зүйлд давж заалдах шатны шүүх хуралдааны товыг ямар хэлбэрээр мэдэгдэхийг заагаагүй боловч зарчмын хувьд энэ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-т заасан журам нэгэн адил хэрэглэгдэнэ.

Давж заалдах шатны шүүхийн хувьд хэргийн оролцогч бүрд мэдэгдэх хуудсаар шүүх хуралдааны товыг хүргэх асуудал хүндрэлтэй байдаг.

Давж заалдах шатны шүүх хуралдааны товыг харилцах утас, факсаар эсхүл аймгийн Захиргааны хэргийн шүүхээр дамжуулан мэдэгдэж болох бөгөөд энэ тухай шүүх хуралдааны нарийн бичгийн дарга тодорхой тэмдэглэл хийж хэрэгт хавсаргасан байх шаардлага тавигдана.

Ийм байдлаар давж заалдах шатны шүүх хуралдааны товыг мэдэгдсэн бол хуулиар тогтоосон журам зөрчсөн гэж үзэхгүй.

Энэ тухай зохицуулалтыг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шинээр оруулах шаардлагатай гэж үзнэ.

6. Давж заалдах шатны шүүх хуралдаан хаана, хэзээ болохыг хүсэлт гаргасан этгээдэд /бусад оролцогчид/ боломжтой хугацааны өмнө мэдэгдэнэ.

Өөрөөр хэлбэл давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцох эрхийг хангах үүднээс төвөөс алслагдсан байдал, нийтийн тээвэр, онгоцны нислэгийн хуваарь зэргийг харгалзан шүүх хуралдаан болох өдөр, цагаас өмнө хүрэлцэн ирж чадах хамгийн богино хугацаанаас өмнө давж заалдах шатны шүүх хуралдаанд хүсэлт гаргасан буюу хүсэлт гаргаагүй этгээдэд шүүх хуралдаан мэдэгдсэн байхыг ойлгоно.

85 дугаар зүйл. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх

- 85.1. Давж заалдах гомдол гарсан хэргийг Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхим хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ.
- 85.2. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг шүүгчдийн зөвлөгөөнөөс томилогдсон шүүгч даргална.
- 85.3. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж байгаа захиргааны хэргийн шүүх давж заалдах гомдолд заасан үндэслэлээр хязгаарлахгүй захиргааны хэргийг бүхэлд нь хянан үзэх үүрэгтэй.
- 85.4. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд аль нэг шүүгч нь захиргааны хэргийн талаар илтгэж танилцуулна.
- 85.5. Илтгэгч нэхэмжлэлийн шаардлага, хариуцагчийн тайлбар, анхан шатны шүүхийн дүгнэлт, шийдвэрийн агуулга, давж заалдах гомдлын үндэслэл, хэрэгт авагдсан нотлох баримтын талаар танилцуулж, улмаар шүүх бүрэлдэхүүн илтгэгчид асуулт тавьж, нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн тайлбарыг сонсож, шаардлагатай зарим зүйлийг тэднээс асууж тодотгосны дараа шүүх хуралдаан завсарлан, шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орно.
- 85.6. Давж заалдах журмаар хэрэг хянан хэлэлцсэн захиргааны хэргийн шүүх шинээр цуглуулсан, хуулийн шаардлага хангасан, эргэлзээгүй нотлох баримтыг үнэлж дүгнэх, үндэслэл болгох эрхтэй.

ТАЙЛБАР

1. Давж заалдах шатны шүүх захиргааны хэргийг заавал бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ. Давж заалдах шатны журмаар хэрэг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн буюу шүүгчийн тоог энэ хуулийн 52 дугаар зүйлийн 52.3-т "... 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй..." байхаар заасан байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхим болно. Энэ нь Монголын дагнасан шүүхийн тогтолцооны онцлог юм.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд ирүүлсэн хэргийг танхимын шүүгчдийн зөвлөлгөөнөөс тогтоосон журмын дагуу шүүгчдэд тойргийн журмаар хуваарилна.

2. Энэ зүйлийн 85 дугаар зүйлийн 85.1-д заасан "30 хоногийн хугацаа"-г хуваарийн дагуу шүүгч захиргааны хэрэг хүлээн авсан өдрөөс бус Захиргааны хэргийн

танхим хэргийг хүлээн авч бүртгэсэн өдрөөс Иргэний хуулийн 72 дугаар зүйлд заасан журмын дагуу тоолно.

3. Давж заалдах шатны шүүх хуралдаан даргалагч нь энэ хуулийн 62 дугаар зүйлийн 62.2-т заасан эрх, үүргийг эдэлж хэрэгжүүлнэ.

Энэ хуулийн 85 дугаар зүйлийн 85.4-т заасан "...аль нэг шүүгч...", 85 дугаар зүйлийн 85.5-д заасан "...илтгэгч..." гэдгийг шүүгчдийн зөвлөлгөөнөөс тогтоосон хуваарийн дагуу хэрэг хүлээж авсан шүүгчийг ойлгоно.

Давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүнд энэ хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1-д заасан татгалзан гарах үндэслэлүүд нэгэн адил хамаарах ба шүүх бүрэлдэхүүнийг хуульд заагаагүй үндэслэлээр өөрчилж болохгүй. /Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 64 дүгээр зүйлийн тайлбарыг үз/

Шүүх бүрэлдэхүүний аль нэг нь татгалзан гарахаас өөр хүндэтгэн үзэх шалтгааны улмаас давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцох боломжгүй тохиолдол гарвал шүүгчийг сольж өөрчлөх, хэргийг шүүгчдийн зөвлөлгөөнөөс тогтоосон журмын дагуу дахин хуваарилах асуудал гарч болно.

4. Энэ зүйлийн 85.5-д заасан дэгийн дагуу захиргааны хэргийг давж заалдах шатны журмаар хянан хэлэлцэх ба давж заалдах шатны шүүх хуралдааныг нээх, шүүх бүрэлдэхүүнийг татгалзах, шүүгчийг татгалзан гаргах, хэргийн оролцогчдын ирцийг бүртгэх, эрх, үүрэг тайлбарлах гэх мэт асуудалд анхан шатны шүүх хуралдааны дэгийг энэ хуулийн зохицуулсан заалтууд нэгэн адил мөрдөгдөнө.

5. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх энэ зүйлийн 85.3-т зааснаар гомдолд заасан үндэслэлээр хязгаарлахгүй захиргааны хэргийг бүхэлд нь хянан үзнэ.

Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийн хууль ёсны ба үндэслэлтэй эсэхийг хянан шалгаж тогтоохын тулд давж заалдах гомдолд дурьдсан үндэслэлээр хязгаарлахгүй хэргийг бүхэлд нь хянах үүрэгтэй.

Энэ зүйлийн 85.3-т заасан "...захиргааны хэргийг бүхэлд нь хянан үзэх..." гэдгийг давж заалдах гомдлын үндэслэл, шүүхийн шийдвэрийн ямар хэсэгт гомдол гаргасан эсэхээс үл хамааран анхан шатны шүүх тухайн захиргааны хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн шалгаж тогтоосон эсэх, шүүхийн шийдвэрт дурьдсан дүгнэлт нь нотлох баримтад үндэслэсэн эсэх, шүүхийн цуглуулж бүрдүүлсэн нотлох баримт нь хуулийн шаардлага хангасан эсэх, тухайн хэрэгт хамааралтай болох төдийгүй хуулийн хэм хэмжээг зөв хэрэглэсэн эсэх, хуулиар тогтоосон журмыг хангасан эсэхийг хянан шалгахад чиглэсэн цогц ажиллагаа гэж ойлгож болно.

Давж заалдах гомдол гаргах эрх бүхий этгээд захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн зарим хэсэгт гомдол гаргасан ч давж заалдах гомдол гаргаагүй хэсэг хүчин төгөлдөр болох тухай ойлголт байдаггүй бөгөөд шийдвэр бүхэлдээ хянагддаг.

Давж заалдах гомдол гаргаагүй этгээдэд холбогдох эсэхийг ч давж заалдах шатны шүүх хянан үзнэ.

6. Энэ хуулийн 85 дугаар зүйлийн 85.6-гийн "шинээр цуглуулсан хуулийн шаардлага хангасан эргэлзээгүй нотлох баримтыг үндэслэн дүгнэх, үндэслэл болох

эрхтэй” гэсэн заалтыг захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх өөрийн санаачлагаар шинэ нотлох баримт цуглуулах үүрэгтэй тухай заалт гэж ойлгож болохгүй. Нөгөө талаар захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх шинэ нотлох баримт гаргах талаар хэргийн оролцогчдоос шаардахгүй.

Харин давж заалдах гомдолд хавсаргасан эсхүл шүүх хуралдааны явцад гаргасан шинэ нотлох баримт нь тухайн захиргааны хэрэгт хамааралтай эсэх, хуулийн шаардлага хангасан, эргэлзээгүй нотлох баримт болж чадах эсэхийг шүүх бүрэлдэхүүн нягтлан шалгах болно.

Хуулийн энэ заалт анхан шатны шүүхийн дутуу бүрдүүлсэн нотлох баримтыг түүний өмнөөс нөхөн цуглуулахыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд үүрэг болгосон заалт биш болно.

Хэргийн оролцогчдоос тухайн захиргааны хэрэг маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой байж болох шинэ нотлох баримтыг давж заалдах шатанд ирүүлсэн нөхцөлд давж заалдах шатны шүүх хуралдаанд илтгэгч шүүгч шүүх бүрэлдэхүүнд танилцуулна. Давж заалдах шатны шүүх хуралдаанд шинэ нотлох баримт гаргавал гомдол гаргаагүй талыг тухайн нотлох баримттай танилцах, тайлбар гаргах боломжоор хангана.

Уг нотлох баримт нь тухайн хэрэгт хамааралтай эсэх, нотлох баримт хуулийн шаардлага хангасан эсэх, эргэлзээгүй нотлох баримт мөн эсэх, анхан шатны шүүхийн шийдвэр гарахад нөлөөлж болох байсан эсэхийг үнэлж, дүгнэх нь давж заалдах шатны шүүхийн бүрэн эрхэд хамаарах бөгөөд ямар хүрээнд хэрэгжүүлэх нь маргаантай асуудлын нэг.

Хэргийн оролцогчид давж заалдах гомдол гаргахдаа шинэ нотлох баримт хавсаргасан байвал анхан шатны шүүх давж заалдах гомдол гаргаагүй талд гомдлын хамт танилцуулж байх шаардлагатай.

Анхан шатны Захиргааны хэргийн шүүх тухайн хэрэгт шаардлагатай нотлох баримтыг дутуу бүрдүүлсэн хэргийн нөхцөл байдлыг тогтоож чадаагүй явдал нь шүүхийн шийдвэрийг хүчингүй болох үндэслэл болно. Анхан шатны шүүх энэ үүргээ хангалттай гүйцэтгэж чадсан эсэх, шүүхийн шийдвэр нотлох баримтад үндэслэсэн эсэхийг давж заалдах шатны шүүх үнэлж, дүгнэх, өөрөөр хэлбэл шалгадаг тул давж заалдах шатны шүүх шинэ нотлох баримт цуглуулахгүй үүрэггүй.

86 дугаар зүйл. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан хэлэлцсэн захиргааны хэргийн шүүхийн магадлал

- 86.1. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан хэлэлцсэн захиргааны хэргийн шүүхийн магадлалд нэхэмжлэлийн шаардлага, хариуцагчийн тайлбар, анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн болон давж заалдах гомдлын агуулга, давж заалдах шатны шүүхээс гаргаж байгаа шийдвэр, түүний үндэслэл тусгагдсан байна.
- 86.2. Давж заалдах журмаар хэрэг хянан хэлэлцсэн захиргааны хэргийн шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх, өөрчлөх, хүчингүй болгох шийдвэрийн аль нэгийг заавал гаргана.

- 86.3. Магадлал уншин сонсгомогц хуулийн хүчин төгөлдөр болно.
- 86.4. Магадлалыг гарснаас хойш 7 хоногийн дотор нэхэмжлэгч, хариуцагчид хүргүүлнэ.
- 86.5. Давж заалдах шатны шүүх магадлал гаргахдаа хуульд заасан захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн гэж талууд, эсхүл гуравдагч этгээд үзвэл энэ хуулийн 77.2.-т заасан хугацаанд хяналтын журмаар гомдол гаргаж болно.

ТАЙЛБАР


Давж заалдах шатны шүүхийн магадлал гарснаар давж заалдах журмаар хэрэг хянан хэлэлцэх ажиллагаа дуусгавар болдог.

Магадлал бол давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэртэй захиргааны хэргийг хянан хэлэлцээд гаргасан эрх зүйн акт юм.

1. Энэ зүйлийн 86.1-д давж заалдах шатны шүүхийн магадлалын бүтцийг тодорхойлсон байна. Магадлал гаргахын өмнө шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орж анхан шатны шүүх хэргийн нөхцөл байдлыг зөв тогтоосон эсэх, тухайн захиргааны акттай холбогдох маргаан хэрэгт цугларсан нотлох баримтаар нотлогдсон эсэх, материаллаг хуулийг зөв хэрэглэсэн эсэх, шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх процессын хуулийн шаардлагыг хангасан эсэх талаар зөвлөлдөн “магадлал” хэмээх эрх зүйн актыг гаргана.

Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийн хуулийн үндэслэл болон хэргийн бодит нөхцөл байдлыг хянаж үздэг.

2. Энэ зүйлийн 86.2-т давж заалдах шатны шүүхээс гарах магадлалыг агуулгаар нь доорх байдлаар ангилжээ.



3. Мөн зүйлийн 86.4-ийн “Магадлалыг гарснаас хойш 7 хоногийн дотор ...” гэснийг магадлалыг ёсчилсноос хойш 7 хоногийн дотор гардуулна гэж ойлгож хэрэгжүүлнэ.

87 дугаар зүйл. Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөх

- 87.1. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан хэлэлцсэн захиргааны хэргийн шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хууль зүйн үндэслэлтэй гэж үзвэл уг шийдвэрийг хэвээр үлдээнэ.
- 87.2. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан хэлэлцсэн захиргааны хэргийн шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг зөв гэж үзсэн хууль зүйн үндэслэлээ магадлалдаа заах үүрэгтэй.
- 87.3. Анхан шатны шүүх нотлох баримтыг буруу үнэлсэн, эсхүл хууль буруу хэрэглэсэн бол давж заалдах шатны журмаар захиргааны хэрэг хянан хэлэлцсэн шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь өөрчлөх эрхтэй.

ТАЙЛБАР

1. Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх. Давж заалдах гомдол гаргасан этгээдийн гомдол үндэслэлгүй, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр хууль ёсны ба үндэслэлтэй гэсэн дүгнэлтэд давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүн хүрсэн нөхцөлд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж магадлал гаргана.

Энэ зүйлийн 87.1-ийн заалтыг нөгөө талаас нь үзвэл давж заалдах гомдол үндэслэлгүй байвал анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх нөхцөл бүрдэнэ.

Давж заалдах шатны шүүх юуны өмнө давж заалдах гомдлыг хүлээж авах үндэслэл байгаа эсэхийг хянан үзнэ. Давж заалдах гомдлыг хүлээж авах үндэслэлгүй гэж үзэх хэд хэдэн тохиолдол байж болно. Тухайлбал:

- Давж заалдах гомдол гаргах эрхгүй этгээд гомдол гаргасан
- Давж заалдах гомдол гаргах хуульд заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн ... гэх мэт

Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хууль ёсны ба үндэслэлтэй гэж үзэж давж заалдах гомдлыг хангаагүй үндэслэлээ магадлалдаа тодорхой заах шаардлагатай.

2. Анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчлөх. Анхан шатны шүүхийн шийдвэрийн алдааг илрүүлж засах, шийдвэрийг өөрчлөх эрхийг давж заалдах шатны шүүхэд хуулиар олгосон.

- Анхан шатны шүүх нотлох баримтыг бүрэн цуглуулсан боловч буруу үнэлсэн байх
- Захиргааны акттай холбоотой маргааныг шийдвэрлэхдээ хууль буруу хэрэглэсэн зэрэг нь анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчлөх хуулийн үндэслэлд хамаарна.

Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрт 2 хэлбэрээр өөрчлөлт оруулж болно.

1. Хэсэгчлэн өөрчлөх

2. Бүхэлд нь өөрчлөх

Хэсэгчлэн өөрчлөх гэдэгт: Анхан шатны шүүхийн шийдвэрийн зарим заалтыг өөрчлөх, нэмэлт заалт оруулах байдлаар өөрчлөлт оруулахын аль аль нь хамаарна.

Шүүхийн практикаас үзэхэд шүүх Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.1-д заасны дагуу нотлох баримтыг бүрэн хангалттай цуглуулсан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан журмын дагуу явагдсан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчөөгүй, анхан шатны шүүх захиргааны хэрэг маргааныг үндсэнд нь зөв шийдвэрлэсэн боловч шийдвэр гаргахдаа нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг шийдвэрлээгүй орхисон, захиргааны акттай холбогдох маргааныг буруу зүйлчилсэн зэрэг зөрчил гаргасан нь анхан шатны шүүхийн шийдвэрт нэмэлт эсхүл хэсэгчилсэн өөрчлөлт оруулах үндэслэл болно. Түүнчлэн нэхэмжлэлийн шаардлагатай уялдуулан анхан шатны шүүхийн шийдвэрийн заалтуудыг нэгтгэх байдлаар бүхэлд нь өөрчилнө.

Давж заалдах шатны шүүх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт нэмэлт өөрчлөлт эсхүл өөрчлөлт оруулахдаа гомдолд дурьдсан үндэслэлээр төдийгүй гомдолд дурьдаагүй үндэслэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Энэ нь хэргийг бүхэлд нь хянан үзэх зарчимтай холбоотой. Анхан шатны шүүх захиргааны хэргийг хэлэлцэж шийдвэрлэхэд хангалттай нотлох баримт цуглуулсан, шүүх хуралдааны болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа процессын хуулийн дагуу явагдсан байсан ч анхан шатны захиргааны хэргийн шүүх нотлох баримтыг буруу үнэлэх, хуулийг буруу хэрэглэх байдлаар алдаа гаргаж хэргийн бодит нөхцөл байдлаас эсрэг шийдэл гаргасан байвал шүүхийн шийдвэрийг өөрчлөх бус шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж болох урьдчилсан нөхцөлд:

1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасны дагуу шүүхээс нотлох баримтыг бүрэн цуглуулж бүрдүүлсэн байх

2. Энэ хуулийн 88 дугаар зүйлд заасан үндэслэл байхгүй байх шаардлага хамаарна.

Анхан шатны шүүхийн шийдвэрт нөлөөлөхөөргүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алдаа зөрчил нь шүүхийн шийдвэрийг өөрчлөх үндэслэл болохгүй.

88 дугаар зүйл. Анхан шатны шүүхийн шийдвэрийг
хүчингүй болгох

88.1. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох тохиолдолд дор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргана:

- 88.1.1. Нэхэмжлэлийг хангасан анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгох;
 - 88.1.2. Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг буюу бүгдийг хангах;
 - 88.1.3. Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг харъяалагдах шүүхэд шилжүүлэх буюу нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах;
 - 88.1.4. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой дутагдал илэрсэн, эсхүл шийдвэрт нөлөөлж болохуйц шинэ нотлох баримт илэрсэн бол захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаах.
- 88.2. Захиргааны хэргийг хянан хэлэлцэхэд хангалттай нотлох баримт цугларсан, шүүх хуралдаан болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуулийн дагуу явагдсан боловч захиргааны хэргийн шүүх нотлох баримтыг буруу үнэлсэн, хуулийг буруу хэрэглэсэн байвал давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүх энэ хуулийн 88.1.1, 88.1.2-т заасан шийдвэрийн аль нэгийг гаргана.
- 88.3. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүх дараах үндэслэл илэрвэл энэ хуулийн 88.1.4-т заасан шийдвэрийг гаргана:
- 88.3.1. Анхан шатны шүүх хэргийн оролцогч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгчийг шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг нь хангалгүй захиргааны хэргийг шийдвэрлэсэн;
 - 88.3.2. Хууль бус бүрэлдэхүүнээр захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн;
 - 88.3.3. Анхан шатны шүүх энэ хуулийг зөрчсөн нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гаргахад нөлөөлөхөөр байвал;
 - 88.3.4. Шүүх шаардлагатай нотлох баримтыг дутуу бүрдүүлсэн, эсхүл хуулийн шаардлага хангаагүй нотлох баримтыг захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн үндэслэл болгосон;
 - 88.3.5. Шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй;
 - 88.3.6. Шүүхийн шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан.

ТАЙЛБАР

Анхан шатны захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгоно. Шүүхийн шийдвэрийг ямар үндэслэлээр хүчингүй болгож байгаагаас хамааран үр дагавар нь өөр өөр байдлаар шийдвэрлэгдэнэ.

Жишээ нь: Хэргийн оролцогчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангалгүй захиргааны хэргийг шийдвэрлэсэн үндэслэл тогтоогдвол анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаах,

Захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус маргааныг хүлээн авч шийдвэрлэсэн нь тогтоогдвол шийдвэрийг хүчингүй болгож хэргийг харьяалагдах шүүхэд нь шилжүүлэх, нэхэмжлэлийг хүлээн авах татгалзах гэх мэт.

Энэ зүйлийн 88.1.1, 88.1.2, 88.1.3, 88.1.4-д давж заалдах шатны шүүхээс гаргах магадлалын ангилал буюу үр дагаврыг заасан байна. Анхан шатны захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, тухайн хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаах ерөнхий нөхцөл нь:

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой дутагдал илэрсэн байх
- Анхан шатны шүүхийн шийдвэрт нөлөөлж болохуйц шинэ нотлох баримт илэрсэн байх
- Тухайн захиргааны хэргийг давж заалдах шатны шүүх хуралдаанаар шууд шийдвэрлэх боломжгүй байх явдал юм.

Давж заалдах шатны шүүх “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой дутагдал илэрсэн” гэдэг үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгохдоо хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн зөрчил нь “ноцтой”-д тооцогдох зөрчил эсэх, шүүхийн шийдвэр гарахад нөлөөлсөн байдалд хийсэн дүгнэлт, үндэслэлээ магадлалд тодорхой заасан байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дутагдал /хуульд бичсэнээр/ нь “ноцтой” шинжтэй болохын тулд шүүхийн шийдвэрт нөлөөлсөн байх шаардлага зайлшгүй тавигдана.

Давж заалдах гомдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “ноцтой” зөрчлийн талаар тодорхой дурьдаагүй ч хэрэг хянан хэлэлцэх явцад хэргийн оролцогчдын эрх, хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн байдал тогтоогдвол давж заалдах шатны шүүх шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болгоно.

Энэ зүйлийн 88.1.4-д заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой дутагдал гэдэгт энэ зүйлийн 88.3.1, 88.3.2, 88.3.3, 88.3.4, 88.3.5, 88.3.6-д заасан үндэслэлүүд хамаарна. /Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн тайлбарыг үз/

89 дүгээр зүйл. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн заалтыг заавал биелүүлэх

89.1. Захиргааны хэргийн шүүхийн магадлалд дурдсан заалтыг хэргийг дахин хэлэлцэж байгаа шүүх заавал биелүүлнэ.

89.2. Давж заалдах шатны журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрт заагдаагүй буюу түүгээр няцаагдсан байдлыг өөрөө тогтоох буюу нотлогдсон гэж үзэх, түүнчлэн уг хэргийг дахин хэлэлцээд ямар шийдвэр гаргавал зохихыг анхан шатны шүүхэд зааж өгөх эрхгүй.

ТАЙЛБАР

1. Давж заалдах шатны шүүхийн магадлалын заалт заавал биелэгдэх хүчинтэй бөгөөд анхан шатны шүүх биелүүлэх үүрэгтэй.

Давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээ энэ зүйлийн 89.2-т зааснаар хязгаарлагдана.

2. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх тодорхой захиргааны хэргийг шийдвэрлэх талаар анхан шатны шүүхэд өгөх заалтыг хязгаартайгаар хуульчилсан явдал нь шүүгчийн хэний ч нөлөөнд үл автах зарчмыг хангах баталгааны нэг.

3. Захиргааны хэргийг дахин хэлэлцэж байгаа анхан шатны захиргааны хэргийн шүүх нэмэлт нотлох баримт цуглуулах, хэрэгт авагдсан нотлох баримтад хуулийн шаардлага хангуулах, хэргийн нөхцөл байдлыг дахин шалгах, захиргааны тухайн хэргийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн этгээдийг бие даасан шаардлагатайгаар гуравдагч этгээдээр татан оролцуулах, хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэх... зэрэг давж заалдах шатны шүүхийн магадлалын заалтыг заавал биелүүлэх үүрэгтэй.

4. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх материаллаг эрх зүйн ямар хэм хэмжээг хэрэглэж, тухайн захиргааны акттай холбогдох маргааныг хэрхэн шийдвэрлэх болон процессийг зааж өгөх эрхгүй. Харин магадлалд анхан шатны шүүх материаллаг эрх зүйн хэм хэмжээг яаж зөрчсөн талаар үнэлэлт, дүгнэлт өгсөн явдал энэ зүйлийн 89.2-т хамаарахгүй.

90 дүгээр зүйл. Захиргааны хэргийн шүүхийн тогтоол,
шүүгчийн захирамжид гомдол гаргах

90.1. Хэргийн оролцогч нь захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах, хойшлуулах, түдгэлзүүлэх талаар гарсан захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор Улсын дээд шүүхэд гомдол гаргаж болно.

90.2. Үг гомдлыг энэ хуулийн 85 дугаар зүйлд заасан журмаар хэлэлцэж дараах байдлаар шийдвэрлэнэ:

90.1.1. Захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхих;

90.1.2. Захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаах;

90.1.3. Захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хүчингүй болгож, асуудлыг өөрийн магадлалаар шийдвэрлэх.

ТАЙЛБАР

Хэргийн оролцогч тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч анхан шатны шүүхийн шийдвэрээс гадна захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхтэй.

1.Энэ хуулиар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүхийн ямар захирамж, шүүхийн тогтоолд хэргийн оролцогчид гомдол гаргаж тухайн анхан шатны шүүхэд гомдол гаргаж болох нөхцөлийн талаар зохицуулалт байхгүй.

Захиргааны хэргийн шүүх захиргааны хэрэг үүсгэснээс хойш явуулсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол хэргийн оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхол, хуулиар тогтоосон журам зөрчсөн захирамж, тогтоол хамаарахаар байна.

2.Энэ зүйлийн 90.1-д заасан Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргах "... гарсан өдрөөс хойш 10 хоног ..." гэсэн хугацааг Иргэний хуулийн 72 дугаар зүйлд заасан журмын дагуу тоолно.

3.Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргах нь анхан шатны захиргааны хэргийн шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан алдаа, зөрчлийг илрүүлж засуулах, захиргааны процессын хуулиар тогтоосон журмыг нэг мөр ойлгож, хэрэглэх явдалд тус дөхөм үзүүлэх ач холбогдолтой. Хэргийн оролцогчид шүүхийн эцсийн шийдвэр гарахыг хүлээлгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхээ хэрэгжүүлнэ.

4.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны захирамж, тогтоолд гомдол гаргах боломжийг зөвхөн хэргийн оролцогчдод олгосон байна.

5.Хэргийн оролцогчийн төлөөлөгч буюу өмгөөлөгч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасны дагуу тусгайлан зааж итгэмжлэл олгосон нөхцөлд шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргах боломжтой.

6.Гомдлыг бичгийн хэлбэрээр гаргана.

7.Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид холбогдуулан гаргасан гомдлыг хэлэлцэх хуралдааны дэг давж заалдах шатны шүүх хуралдааны дэгтэй адил байна.

Гомдлыг хэлэлцэж шийдвэрлэх хугацааг энэ хуулиар тогтоогоогүй. Хуулийн 85 дугаар зүйлийн 85.1-д заасан хугацаанд хянан шийдвэрлэнэ гэж ойлгох боловч захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, хөдөлгөөнд саад болохгүйгээр аль болохоор шуурхай хянан үзэж шийдвэрлэх шаардлагатай.

Давж заалдах шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан тогтоол, захирамжид гомдол гаргасан явдал нь хэргийг эцэслэн шийдвэрлэх анхан шатны шүүх хуралдааныг хойшуулах үндэслэлд хүргэдэг.

8. Гомдол гаргах хугацаа хэтрүүлсэн бол давж заалдах шатны шүүх гомдлыг авч хэлэлцэхээс татгалзах тухай тогтоолыг энэ хуулийн 79 дүгээр зүйлд заасны дагуу гаргана.

9. Энэ зүйлийн 90.2.3-т заасан "... өөрийн магадлалаар шийдвэрлэх ..." гэдгийг анхан шатны шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийн үндэслэл тухайн нөхцөл байдалтай нийцээгүй, гомдлыг дахин хэлэлцүүлэхээр буцаах шаардлагагүй гэж үзвэл давж заалдах шатны шүүх шууд тухайн бодит нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч асуудлыг шинээр шийдвэрлэж шүүхийн эрхийн акт гаргаж байгаа ажиллагаа юм.

Энэ зүйлийн 90.2-т заасны дагуу гомдлыг хэлэлцэхээр давж заалдах шатны шүүхээс магадлал хэмээх эрх зүйн актыг гаргах бөгөөд бүтцийн хувьд энэ хуулийн 86.1-д заасан шаардлагыг хангасан байна.

10. Давж заалдах гомдол гаргаж болох шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид иргэн, хуулийн этгээдийн эрх ашиг сонирхлыг шууд хөндсөн агуулга бүхий шүүхийн эрх зүйн актууд орно. Анхан шатны шүүхээс гаргасан тогтоол, захирамж бүрт гомдол гаргана гэж ойлгож болохгүй. Зарчмын хувьд иргэн, хуулийн этгээдийн субъектив эрхийг хөндөөгүй шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй гэж үзэж болно.

11. Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид холбогдуулан гаргасан болон гомдлыг хэлэлцээд гаргасан давж заалдах шатны шүүхийн магадлал /хуульд томьёолсноор/-д хэргийн оролцогчид тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч хяналтын журмаар гомдол гаргахгүй.

/Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 91.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172.1-ийн тайлбарыг үз/

Энэ хуулиар шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хүчингүй болгож, гомдлыг өөрийн магадлалаар шийдвэрлэх эрхийг давж заалдах шатны шүүхэд олгосон нь гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэх, иргэнийг чирэгдүүлэхгүй байх шаардлагатай холбоотой.

АРАВДУГААР БҮЛЭГ

Хяналтын журмаар захиргааны хэрэг хянан
шийдвэрлэх ажиллагаа

91 дүгээр зүйл. Хяналтын журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх

91.1. Хяналтын журмаар гомдол гаргах, түүнийг шийдвэрлэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172-178 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

ТАЙЛБАР

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "... эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно."

гэж заасны дагуу Улсын Их Хурлын 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар аймаг, нийслэлийн Захиргааны хэргийн дагнасан шүүхийг байгуулсан билээ.

Мөн Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

Хуулиар харъяалуулсан эрүүгийн хэрэг, эрх зүйн маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

2. Давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;

Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Улсын Дээд шүүх нь Монгол Улсын шүүхийн дээд байгууллага бөгөөд хяналтын шатны шүүх мөн”;

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим захиргааны хэргийг дараах журмаар хянан шийдвэрлэнэ:

15.2.1. Аймаг, нийслэлийн Захиргааны хэргийн шүүх анхан шатны журмаар шийдвэрлэсэн хэргийг давж заалдах шатны;

15.2.2. Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн болон анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэртэй хэргийг хяналтын шатны.” гэж тус тус заажээ.

Дээрх хуулиудын заалтын дагуу Улсын Дээд шүүхийн 2004 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Улсын Дээд шүүхэд Захиргааны хэргийн танхим байгуулагдаж, хяналтын журмаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172-178 дугаар зүйлийн заалтуудыг дагнасан шүүхийн онцлогт тохируулан хэрэглэж байна.

IV ХЭСЭГ

ИРГЭНИЙ ХЭРГИЙГ ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хяналтын журмаар хэрэг
хянан шийдвэрлэх ажиллагаа

- 172.1. Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 167 дугаар зүйлд заасан магадлалд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.
- 172.2. Хяналтын журмаар дараах үндэслэлээр гомдол гаргана:
- 172.1.1. шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн;
- 172.1.2. шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн.
- 172.3. Хяналтын журмаар гомдол гаргасан этгээд хяналтын шатны шүүх хуралдаанаас өмнө гомдлоосоо татгалзвал түүнийг гомдол гаргаагүйд тооцож, улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгох тухай шүүгч захирамж гаргана.

ТАЙЛБАР

1.Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн дагуу гарсан анхан шатны шүүхийн шийдвэр, мөн хуулийн 86 дугаар зүйлд зааснаар давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан хэлэлцсэн магадлалд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 86 дугаар зүйлийн 86.5-д заасны дагуу нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь шийдвэр, магадлалыг гардан авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хяналтын журмаар гомдлоо гаргана.

Хэргийн оролцогчид тэдгээрийн төлөөлөгч болон өмгөөлөгчийн давж заалдах болон хяналтын журмаар гаргасан гомдлыг хэрхэн шийдвэрлэх тухай мөн хуулийн 81 дүгээр зүйлийн 81.3-д “Анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдлыг талуудын аль нэг нь гаргасан явдал эсрэг талын хяналтын журмаар гомдол гаргах эрхийг үл

хязгаарлана”, 81.4-т “Нэхэмжлэгч, хариуцагч талын аль нэг, эсхүл хамтран нэхэмжлэгч болон хамтран хариуцагчийн аль нэг нь давж заалдах, нөгөө нь хяналтын журмаар гомдол гаргасан бол давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд хэргийг бүхэлд нь хянана” гэж заасан байна.

Гэвч нотлох баримтыг шалгуулан шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах зэрэг Монгол Улсын Үндсэн хуулиар иргэдэд олгогдсон эрхийг баталгаатай эдлүүлж, талуудын гомдлын дагуу тухайн хэргийг давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсний дараа магадлалыг эс зөвшөөрвөл хяналтын журмаар гомдол гаргах эрх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын 2007 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар баталгаажсан билээ.

Улсын Их Хуралд өргөн баригдсан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд ч дээрх зохицуулалт тусгагдсан болно.

Энэ нь давж заалдах болон хяналтын шатны шүүх хэргийг талуудын гаргасан гомдлын дагуу хуульд заасан өөр өөр үндэслэлүүдээр хянан шийдвэрлэдэгтэй холбоотой юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Иргэний эрх зүйн чадамж бүхий иргэн мэргэжлийн хувьд шаардлагатай гэж үзвэл хяналтын шатны шүүхэд захиргааны хэргийг хянан хэлэлцэхэд төлөөлөгчөө оролцуулна” гэж заасны дагуу хэргийн оролцогчид нь анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан хэлэлцэхэд оролцож байгаагүй төлөөлөгчийг итгэмжлэл олгон хяналтын шатны шүүх хуралдаанд оролцуулж болно.

Хуулийн дээрх заалт нь хэргийн оролцогчдод зөрчигдсөн эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах өргөн боломжийг олгосон зохицуулалт юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-д “Хугацааг тоолох, тодорхойлоход Иргэний хуульд заасан журмыг баримтална” гэж заасны дагуу Иргэний хуулийн 82 дугаар зүйлийн 82.4 дэх хэсгийн “Шүүх ... хөөн хэлэлцэх хугацаа өнгөрснийг хүндэтгэн үзэх шалтгаантай гэж үзвэл уг хугацааг сэргээж, зөрчигдсөн эрхийг хамгаалж болно” гэсэн заалтыг хэрэглэж, хяналтын журмаар гомдол гаргах эрх бүхий этгээд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуульд заасан 30 хоногийн хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хүндэтгэн үзэх шалтгаан байсан эсэхийг нотолсон бичмэл баримтуудыг үндэслэн тухайн этгээдийн хүсэлтийн дагуу хяналтын журмаар гомдол гаргах хугацааг сэргээж болно.

Тухайн этгээд гомдол гаргах хугацаа сэргээлгэх тухай хүсэлтдээ холбогдох баримтуудыг хавсарган, хяналтын журмаар гаргаж байгаа гомдлын хамт хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүхэд гаргана.

Уг хүсэлтийг хүлээн авсан шүүгч хугацааг сэргээх эсэх асуудлыг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д “Энэ хуулийн 73 дугаар зүйлд зааснаар шийдвэр гаргахаас бусад тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар захиргааны хэргийн шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.”,

79.2-т “Захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг бичгээр гаргана” гэж заасны дагуу захирамж гаргаж шийдвэрлэнэ.

2.Хяналтын гомдлыг бичгээр гаргах бөгөөд түүнд дараах зүйлийг заавал тусгана:

- Гомдлыг ямар шүүхэд гаргаж байгаа;
- Гомдол гаргагч нь тухайн хэргийн оролцогч мөн эсэх, хэрэв төлөөлөгч, өмгөөлөгч бол итгэмжлэлтэй эсэх;
- Гомдол гаргаж буй хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч болон өмгөөлөгчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр,хаяг, оршин байгаа газар;
- Гомдлыг хуульд заасан үндэслэлийн дагуу гаргасан эсэх;
- Аль шүүхийн ямар шийдвэр, магадлал, тогтоолыг эс зөвшөөрч байгаа;
- Шийдвэр, магадлал, тогтоолыг хуульд заасан ямар үндэслэлээр зөвшөөрөхгүй байгаа;
- Хяналтын шатны шүүхээс юу хүсэж байгаа;
- Хяналтын шатны шүүх хуралдаанд оролцох эсэх;
- Гомдол гаргаж буй этгээдийн гарын үсэг, хуулийн этгээдийн тамга, тэмдэг.
- Улсын тэмдэгтийн хураамж төлсөн эсэх;
- Гомдол гаргах хугацааг хэтэрсэн эсэх, хэрэв хугацааг хэтэрсэн бол хөөн хэлэлцэх хугацааг сэргээлгэх хүсэлт, түүнд хавсаргасан баримт нь шаардлага хангасан эсэх;

Хяналтын гомдлыг:

а. Хууль буруу хэрэглэсэн

б.Хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн гэсэн үндэслэлээр гаргана.

2.1.Хууль буруу хэрэглэсэн гэдэгт :

- Хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй;
- Хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн;
- Хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн;
- Төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн гэдэг үндэслэлүүд хамаарна.

Шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй гэдэг нь хэргийн оролцогчдын хооронд үүссэн эрх зүйн маргааныг нарийвчлан зохицуулсан хууль байхад шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ уг хуулийн холбогдох заалтыг хэрэглэлгүйгээр, харин түүнтэй ойролцоо төрлийн харилцааг зохицуулсан ерөнхий зохицуулалттай хуулийг хэрэглэсэн эсхүл холбогдох хуулийн заалтыг огт хэрэглээгүйг;

Шүүх хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн гэдэг нь шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ тэдгээрийн хооронд үүссэн эрх зүйн маргаанд хэрэглэгдэх хуулийг буруу тодорхойлж, тухайн маргаанд хамааралгүй өөр хуулийг хэрэглэсэн, эсхүл хүчингүй болсон буюу хүчин төгөлдөр болоогүй хууль баримталсныг;

Хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн гэдэг нь шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ тухайн эрх зүйн маргааныг зохицуулсан хуулийн зүйл, заалтын утга, агуулгыг буруу ойлгон хэрэглэснийг;

Төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн гэдэг нь хэргийн оролцогчдын хооронд үүссэн эрх зүйн маргааныг зохицуулсан хууль байхгүй нөхцөлд төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг шүүх буруу сонгож хэрэглэснийг тус тус хамааруулж үзнэ.

2.2.Хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн гэдэгт:

- Шүүх хуралдаанд хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч зайлшгүй биечлэн оролцох хэрэгт тэднийг оролцуулаагүй;
- Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн;
- Хэргийн оролцогчийн эрхийг ноцтой зөрчсөн үндэслэлүүд хамаарна.

Шүүх хуралдаанд хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч зайлшгүй биечлэн оролцох хэрэгт тэднийг оролцуулаагүй гэдэг нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2, 84 дүгээр зүйлийн 84.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 175 дугаар зүйлийн 175.1-д зааснаар нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нарт шүүх хуралдааны товыг мэдэгдээгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тэдгээрийг хэрэг хянан хэлэлцэхэд оролцуулалгүйгээр хуулиар олгогдсон эрхийг нь хязгаарласан явдал юм.

Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн гэдэгт Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.3, 52.4-д зааснаар бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэх хэргийг шүүх дангаар болон бүрэн бус бүрэлдэхүүнээр хэлэлцсэн, эсхүл Шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийн “Анхан болон давж заалдах, хяналтын шатны журмаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд урьд нь оролцсон шүүгч уг хэрэг, маргааныг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй” гэсэн заалтыг зөрчсөн, мөн тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний шийдвэрийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх

бүрэлдэхүүн болон шүүх хуралдаан даргалагчийг томилох хуваарийг зөрчиж, хэргийг өөр шүүгч, шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэсэн, шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолд шүүгч буюу шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зураагүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан зэрэг нөхцөл байдлууд хамаарна.

Мөн шүүгчийн албан тушаалд томилсон тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гараагүй болон шүүгчийн бүрэн эрхийг нь эрх бүхий албан тушаалтан, байгууллагаас түдгэлзүүлсэн этгээд хэрэг хянан шийдвэрлэхэд оролцсоныг хууль бус бүрэлдэхүүн гэж үзнэ.

Түүнчлэн хууль зөрчиж, шүүх хуралдаанд оролцсон иргэдийн төлөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын аль нэгийг татгалзан гаргах хуульд заасан үндэслэл байхад тэд татгалзан гараагүй, гаргасан боловч хууль бусаар хүлээн аваагүй бол хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэнтэй адилтган үзэх үндэслэлтэй.

Хэргийн оролцогчийн эрхийг ноцтой зөрчсөн гэдэг нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.1, 21, 27, 29 дүгээр зүйлүүд болон бусад хуульд зааснаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нарын эрхийг ноцтой зөрчсөн, хууль бусаар хязгаарласан, эрхээ эдлэх боломжийг олгоогүй байх явдал юм.

3. Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг эс зөвшөөрч гомдол гаргасан нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар хяналтын шатны шүүх хуралдаан болохоос өмнө гомдлоосоо татгалзвал Улсын Дээд шүүхийн шүүгч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасны дагуу захирамж гарган, түүнийг гомдол гаргаагүйд тооцох бөгөөд хяналтын шатны шүүхэд гомдол гаргасан этгээдээс төрийн санд болон орон нутгийн төсвийн орлогод төлсөн улсын тэмдэгтийн хураамжийн мөнгийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2-т зааснаар буцаан олгоно.

173 дугаар зүйл. Хяналтын журмаар гаргасан гомдол хүлээж авах

- 173.1. Хяналтын журмаар гаргасан гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх хүлээж авах бөгөөд энэ хуулийн 163.1-д заасан ажиллагааг гүйцэтгэнэ. Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч гомдлын талаар тайлбараа гаргах эрхтэй.
- 173.2. Гомдол хүлээж авсан шүүх хэрэгт улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, зохигчийн гомдлыг хавсарган гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш нийслэлд 3 хоногийн дотор, хөдөө орон нутагт 14 хоногийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

- 173.3. Хяналтын журмаар гомдол гаргаж байгаа этгээдээс энэ хуулийн 57.1, 57.4-т заасны дагуу улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлүүлнэ.
- 173.4. Хяналтын журмаар гомдол гаргахад энэ хуульд заасан журмыг баримтлаагүй бол шүүх гомдлыг хүлээн авахгүй бөгөөд энэ тухай шүүгч захирамж гаргана.

ТАЙЛБАР

1.Хяналтын журмаар гаргасан гомдлыг тухайн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүгч буюу нарийн бичгийн дарга хүлээн авна.

Хяналтын гомдлыг хүлээн авахдаа хуульд заасан журмыг хангасан эсэхийг нягтлан үзнэ. Үүнд:

- Гомдол гаргагч нь хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй этгээд мөн эсэх;
- Хяналтын журмаар гомдол гаргах хугацаа;
- Хуульд заасан үндэслэлийг тусгасан эсэх;
- Хяналтын шатны хуралдаанд оролцох эсэх;
- Улсын тэмдэгтийн хураамж төлсөн эсэх.

Хяналтын журмаар гомдол гаргасан талаар шүүхээс мэдэгдсэний дараа хэргийн бусад оролцогч тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар хяналтын гомдолтой танилцаж, тайлбар гаргах эрхтэй бөгөөд уг тайлбараа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 173 дугаар зүйлийн 173.2-д заасан хугацаанаас өмнө гаргах бол хэргийг шийдвэрлэсэн анхан шатны шүүхэд, уг хугацаанаас хойш гаргаж байгаа бол хяналтын шатны шүүх хуралдаанаас өмнө Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд шууд хүргүүлнэ.

Тайлбарт аль шүүхийн ямар шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан хэний гомдолд тайлбар гаргаж байгаа талаар, уг гомдлыг няцааж байгаа хууль зүйн үндэслэл, хяналтын шатны шүүх хуралдаанд оролцох эсэхээ тусгаж, гарын үсгээ зурсан байна.

2.Хяналтын журмаар гаргасан гомдлыг тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүх хүлээн авч, улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг тухайн хэрэгт хавсарган, хяналтын журмаар гаргасан гомдлыг хүлээж авсан өдрөөс хойш Нийслэлд 3 хоногийн дотор, хөдөө орон нутагт 14 хоногийн дотор Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хэргийг хүргүүлнэ.

Хяналтын журмаар гаргасан гомдлыг хүлээж авсан шүүхийн нарийн бичгийн дарга энэ талаар хэргийн бусад оролцогчдод заавал мэдэгдэж, хяналтын журмаар гаргасан гомдолтой танилцах, түүнд тайлбар гаргах эрхтэйг тайлбарлаж өгнө.

Харин хэргийн бусад оролцогчдын тайлбарыг хэрэгт заавал хавсаргах шаардлагагүй бөгөөд хэргийг Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хүргүүлэхээс өмнө бичгээр тайлбар ирүүлбэл хэрэгт хавсаргана.

3.Хяналтын журмаар гомдол гаргаж буй этгээд улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлдөг тул Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлд зааснаар улсын тэмдэгтийн хураамжийг заавал төлүүлнэ. Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг Тэмдэгтийн хураамжийн хуулийн 6, 18 дугаар зүйлд зааснаар зохицуулна.

Хяналтын шатны шүүх хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг үндэслэлтэй гэж үзэж, анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон буюу өөрчилсөн тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3-т заасны дагуу гомдол гаргагчаас төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг Төрийн сан, холбогдох байгууллагын данснаас буцаан олгох тухай захирамжийг шүүгч гаргана.

Хяналтын журмаар гомдол гаргасан этгээд шүүх хуралдаанаас өмнө гомдлоосоо татгалзвал Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.3-т заасны дагуу түүнийг гомдол гаргаагүйд тооцож, шүүгч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 79 дүгээр зүйлд зааснаар гомдол гаргахдаа төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгох захирамж гаргана.

4.Хэргийн оролцогчид тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нараас хяналтын журмаар гаргасан гомдол нь хуульд заасан журмыг баримтлаагүй, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 163 дугаар зүйлд заасан ажиллагааг гүйцэтгээгүй, мөн хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1, 172.2.2-т заасан үндэслэлээр гаргаагүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хугацаа хэтрүүлсэн бол тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шүүгч гомдлыг хүлээн авахаас татгалзаж, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 79 дүгээр зүйлийн дагуу захирамж гаргана.

174 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа

174.1. Хэргийг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.

ТАЙЛБАР

1.Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим хяналтын журмаар гаргасан гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан хэргийг хянан шийдвэрлэнэ.

Энэ хугацааг Захиргааны хэргийн танхим хэргийг хүлээн авч, холбогдох дансанд бүртгэсэн өдрөөс хойш тоолно. Хэргийг Танхимын шүүгч нарын зөвлөгөөний шийдвэрийг үндэслэн цагаан толгойн үсгийн дарааллаар Шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийн заалтад нийцүүлэн, Танхимын тэргүүн болон шүүгч нарт хуваарилна.

Хэрэв хуульд заасан дээрх хугацаанд хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх боломжгүй бол Шүүхийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.4.1, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-т заасны дагуу Танхимын шүүгчдийн зөвлөгөөнөөс хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

175 дугаар зүйл. Хэргийн оролцогчид мэдэгдэх

- 175.1. Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч хяналтын шүүх хуралдаанд оролцохыг бичгээр хүсвэл шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг мэдэгдэнэ.
- 175.2. Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй явдал хэргийг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

ТАЙЛБАР

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд “Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэнэ”, Шүүхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд “Шүүх хуралдааныг нээлттэй явуулна” Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна” гэж тус тус заажээ.

Шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчим нь захиргааны хэргийн хяналтын шатны шүүх хуралдаанд нэгэн адил хамаарна.

Хэргийн болон бусад оролцогч шүүх хуралдаанд оролцох тухай хүсэлтээ бичгээр гаргасан бол шүүх хуралдаан хэзээ, хаана, хэдэн цагт болохыг шүүгчийн туслах 7 хоногийн өмнө тэдгээрт заавал мэдэгдэж, тэмдэглэл үйлдэнэ.

Шүүх хуралдааны товыг Танхимын тэргүүн, түүний эзгүйд орлож буй шүүгч тогтооно.

“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” Улсын Дээд шүүхийн 2002 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 263 дугаар тогтоолын 33-т “... Гомдлыг хүлээн авсан шүүгч буюу нарийн бичгийн дарга зохигч, түүний өмгөөлөгч, төлөөлөгчид танилцуулж, тайлбар гаргах эсэхийг тодруулж гарын үсэг зуруулах ба улсын тэмдэгтийн хураамж төлүүлнэ” гэж заажээ.

Үүний дагуу шүүх хяналтын журмаар гаргасан гомдлыг хэргийн бусад оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид танилцуулж тайлбар гаргах эсэхийг тодруулна. Энэ нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 4, 6 дугаар зүйлүүдэд тодорхойлон заасан талуудын мэтгэлцэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэгш эрхтэй оролцох зарчмуудыг хэрэгжүүлж байгаа хэлбэр юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Захиргааны хэргийн шүүх захиргааны хэрэг хянан шийдвэрлэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 4-11 дүгээр зүйлд заасан зарчмыг баримтална” гэж заасан бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг мэтгэлцэх үндсэн

дээр хэрэгжүүлэх, мэтгэлцэх зарчим нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд хэрэгжих талаар Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлон заасан байна.

Монгол Улсын эрх зүйн зохицуулалтаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь орчин үеийн эрх зүйт төрийн мэтгэлцэх зарчмыг мөрддөг бөгөөд энэ нь үндсэндээ Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрсөн заалтуудад зарчмын хувьд тулгуурласан байдаг.

Хяналтын шатны шүүхэд талуудын мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талуудын тэнцвэрт байдлыг хангаж, шүүх хуралдааны оролцогчдын хуульд заасан эрхийг бүрэн утгаар нь эдлүүлэх явдал юм.

Мэтгэлцэх зарчмыг шүүн таслах ажиллагааны бүх шатанд хэрэгжүүлэхдээ анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн онцлогоос шалтгаалан өөр өөр байна.

Хяналтын шатны шүүх нь хэргийн оролцогчдоос хуулийг буруу хэрэглэсэн болон хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн гэх үндэслэлээр гаргасан гомдлыг үндэслэн хэргийг хянан шийдвэрлэхдээ болсон хэргийн үйл баримтын талаар талуудыг мэтгэлцүүлэх биш харин хууль хэрэглээний асуудлаар мэтгэлцээнийг өрнүүлж, эцсийн шийдвэрээ гаргана.

Анхан болон давж заалдах шатны шүүхтэй адилхан шинээр нотлох баримт гаргуулах, түүнийг нотлох баримтын хэмжээнд үнэлж, дүгнэх үзлэг, туршилт хийх, шинжээч томилох зэрэг ажиллагаа явуулдаггүй билээ.

2.Хяналтын шатны шүүх хуралдаанд оролцохыг хүссэн этгээдэд шүүх хуралдааны товыг мэдэгдсэн боловч тухайн этгээд хяналтын шатны шүүх хуралдаанд ирээгүй явдал нь тухайн шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй бөгөөд шүүх хуралдааныг ердийн журмаар явуулж, хэргийг хянан шийдвэрлэнэ.

Харин энэ талаар шүүх хуралдааны тэмдэглэлд тодорхой тусгах шаардлагатай юм.

176 дугаар зүйл.Хяналтын шатны шүүх хуралдаан

- 176.1. Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэнэ.
- 176.2. Шүүх хяналтын журмаар хэргийг дараах байдлаар хянан шийдвэрлэж тогтоол гаргана:
 - 176.2.1. шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхих;
 - 176.2.2. шийдвэр, магадлалд нэмэлт, өөрчлөлт оруулах;
 - 176.2.3. магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөх;

- 176.2.4. шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох;
- 176.2.5. шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан болон давж заалдах шатны шүүхэд буцаах.
- 176.3. Тогтоолд шүүх хуралдаан даргалагч, илтгэсэн шүүгч гарын үсэг зурна. Тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, хяналтын гомдлын болон гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тус тус тусгана.

ТАЙЛБАР

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавинхоёрдугаар зүйлийн 1-д “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ”, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1-д “Хяналтын журмаар гомдол гаргах, түүнийг шийдвэрлэхэд Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 172-178 дугаар зүйлд заасан журмыг баримтална” гэж тус тус заасан бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176 дугаар зүйлийн заалтуудтай адил зохицуулалтыг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.4, 52.5 дахь хэсэгт тусгасан байна.

Мөн Шүүхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Дагнасан шүүх нь шүүн таслах ажлын төрлөөр байгуулагдсан шүүх мөн” гэжээ.

Ардчилсан эрх зүйт төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмуудын хэрэгжилт, хүний эрх, эрх чөлөөг хуульд нийцүүлэн баталгаатай хангахад захиргааны хэргийн дагнасан шүүхийн тогтолцоо оновчтой, эрх мэдэл хүрэлцэхүйц байх ёстой.

Гэтэл өнөөдрийн байдлаар Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын 6 шүүгч давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүн таслах ажиллагааг давхар хэрэгжүүлж байгаа нь практикт хүндрэлтэй төдийгүй дагнасан шүүхийн тогтолцоо төгөлдөр биш байгааг харуулж байна.

Энэ талаар Хууль зүйн үндэсний төвөөс Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төлөвшил” судалгааны тайланд тодорхой тусгагджээ.

Давж заалдах журмаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн танхимын 3 шүүгч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.4 дэх хэсгийн “анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэх болсон” гэсэн заалтын дагуу өөрөө татгалзан гаргах үүрэгтэй бөгөөд Шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийн “Анхан болон давж заалдах, хяналтын шатны журмаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд урьд нь оролцсон шүүгч уг хэрэг, маргааныг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд

оролцож болохгүй” гэсэн заалтын дагуу хяналтын шатны шүүх бүрэлдэхүүнд оролцож, захиргааны хэргийг хянан шийдвэрлэх боломжгүй юм.

Энэ нь тухайн хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн, шүүгчид нь уг хэргийн талаар урьдчилсан тодорхой ойлголт, итгэл, үнэмшил төрөөгүй байх нь шүүх шударга шийдвэр гаргах гол үндэслэл хэмээн үзэж, тодорхой хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгч дахин оролцохыг хуульчлан хориглодог нь олон улсын хэмжээнд хэвшиж тогтсон нийтлэг зарчим болно.

Өөрөөр хэлбэл “нэг хэрэгт нэг шүүгч нэг удаа оролцох” гэсэн нийтлэг зарчим үйлчилж байгаа талаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн 1 дүгээр тогтоол гарсан билээ.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим мэргэшсэн байдлаа хадгалж, танхимын шүүгч нар бүрэн бүрэлдэхүүнээрээ хяналтын шатны шүүх хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэх боломжгүй байгаа өнөөгийн нөхцөлд Шүүхийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.4.1 дэх хэсгийн заалтыг үндэслэн Улсын Дээд шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөнөөр хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн болон шүүх хуралдаан даргалагчийг томилох хуваарийг тогтоосны дагуу эрүүгийн болон иргэний танхимын шүүгч нараас захиргааны хэргийн хяналтын шатны шүүх хуралдаанд оролцуулж байна.

Хяналтын шатны шүүх хуралдааныг Захиргааны хэргийн танхимын тэргүүн, түүний эзгүйд бусад Танхимын тэргүүн даргалж, Танхимын тэргүүн оролцоогүй бол тухайн танхимын томилогдсон шүүгч даргална.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд хяналтын шатны шүүх хуралдааныг явуулах дэг, дарааллын талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй билээ.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим давж заалдах журмаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа, хуралдааны дэгийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 85 дугаар зүйлийн заалтуудаар зохицуулсан тул үүнийг адилтган хэрэглэж, түүнд заасан нийтлэг журмын дагуу шүүх хуралдааныг явуулна.

Хуралдаан даргалагч нь шүүх хуралдааныг нээж, ямар хэрэг хянан хэлэлцэх гэж буйг танилцуулна. Шүүх хуралдаанд оролцогчдын ирцийг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга илтгэнэ.

Хуралдаан даргалагч хэргийн оролцогчдод эрх, үүргийг тайлбарлан өгч, шүүх бүрэлдэхүүн, нарийн бичгийн даргыг танилцуулж, хуульд заасан үндэслэлээр тэдгээрийг татгалзан гаргах эсэхийг асууна.

Шүүх хуралдааны оролцогчдоос шүүх хуралдаанд гаргах хүсэлт байгаа эсэхийг хуралдаан даргалагч тодруулж, хүсэлт гаргасан тохиолдолд түүний талаар бусад оролцогчдын саналыг сонсож, шүүх бүрэлдэхүүн даруй шийдвэрлэнэ.

Хэргийг илтгэгч шүүгч нь нэхэмжлэлийн шаардлага, хариуцагч, гуравдагч этгээдийн тайлбар, анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалын агуулга, хэрэгт авагдсан нотлох баримтууд, хяналтын журмаар гаргасан гомдлыг танилцуулна. Шүүх бүрэлдэхүүн нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нарын хяналтын гомдлын үндэслэл, тайлбарыг сонсож, шаардлагатай зарим зүйлүүдийг тэднээс асууж, тодруулсны дараа хуралдаан даргалагч шүүх хуралдаан завсарласныг мэдэгдэж, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсгийн “Бүх шатны захиргааны хэргийн шүүх шийдвэрээ зөвлөлдөх тасалгаанд гаргана” гэсэн заалтын дагуу шүүх бүрэлдэхүүн шийдвэрээ гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орно.

Зөвлөлдөх тасалгаанд хэргийг шийдвэрлэх талаар гаргасан шүүгчийн санал нууц байна.

Шүүх бүрэлдэхүүн асуудал бүрийг олонхын саналаар шийдвэрлэнэ. Хуралдаан даргалагч өөрийн саналыг бусад шүүгчийн дараа гаргана. Асуудал шийдвэрлэхэд шүүгч саналаа өгөхөөс татгалзах, түдгэлзэх эрхгүй.

Шүүх хуралдаанаас гарсан тогтоолын агуулгыг хуралдаан даргалагч, шүүх хуралдааны оролцогчдод танилцуулж, уг тогтоолыг эс зөвшөөрвөл гомдол гаргагч этгээд хяналтын шатны шүүхийн тогтоолыг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хууль зөрчсөн үндэслэлээр Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаж болохыг тайлбарлаж, шүүх хуралдаан дууссаныг мэдэгдэнэ.

Хуралдаан даргалагч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу явуулах, хэргийн байдлыг тал бүрээс нь бодитойгоор тогтоох, хэргийн оролцогч эрх, үүргээ хэрэгжүүлэх, мэтгэлцэх зарчмыг хангах, шүүх хуралдааны дэгийг сахиулах үүргийг хүлээнэ.

Хяналтын шатны шүүх хуралдаанд оролцох нарийн бичгийн дарга нь шүүгчийн туслах байна. Шүүгчийн туслах нь:

- тухайн өдрийн хуралдааны бэлтгэлийг хангах;
- хуралдааны зарыг гаргах;
- хэргийн оролцогчдод зарыг мэдэгдэх;
- шүүх бүрэлдэхүүн болон даргалагчийг томилуулах;
- томилогдсон шүүх бүрэлдэхүүнд тухайн хэргийн шийдвэр, магадлалын хуулбарыг хувилж тараах

зэрэг ажиллагааг хийх бөгөөд хэргийн оролцогч шүүх хуралдаанд оролцож байгаа үед шүүх хуралдааны тэмдэглэл хөтөлнө.

Хяналтын шатны шүүх хуралдааны тэмдэглэлд :

- Шүүх хуралдааныг хэзээ, хаана хийсэн;

- Шүүх хуралдаан эхэлсэн, дууссан цаг;
- Шүүх бүрэлдэхүүн;
- Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын нэр;
- Шүүх хуралдаанд оролцогч нарын ирц /овог, нэр, хаяг/;
- Шүүх хуралдаанд оролцогчдоод хуульд заасан эрх, үүргийг тайлбарласан байдал;
- Шүүх хуралдаанд оролцогчдоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэсэн тухай;
- Шүүх хуралдаанд оролцогч нарын гаргасан гомдол, хариу тайлбар;
- Тогтоолын агуулга, хэргийг шийдвэрлэсэн талаар;
- Шүүх хуралдаан даргалагч, тэмдэглэл хөтөлсөн нарийн бичгийн даргын гарын үсэг;
- Тогтоолыг эс зөвшөөрвөл 30 хоногийн дотор хууль зөрчсөн үндэслэлээр Улсын Дээд шүүхэд /Ерөнхий шүүгчид/ гомдол гаргаж болохыг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид тайлбарлан өгсөн тухай тусгана. Тэмдэглэлд хуралдаан даргалагч, нарийн бичгийн дарга нар гарын үсгээ зурж, баталгаажуулна.

2.Хяналтын журмаар хэргийг хянан хэлэлцсэн шүүх тогтоол гаргана. Уг тогтоолд хуралдаан даргалагч болон хэргийг илтгэсэн шүүгч гарын үсэг зурна.

Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолыг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-д заасны дагуу 7 хоногийн дотор бичгээр үйлдэн, Улсын Дээд шүүхийн тамгыг дарж баталгаажуулна.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоолын бүтэц, агуулгын талаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой зохицуулалт байхгүй ч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлд заасан шийдвэрийн бүтэц, агуулгын дагуу хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолыг үйлдэнэ.

Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол нь:

- Удиртгал
- Тодорхойлох
- Үндэслэх
- Тогтоох хэсгээс бүрдэнэ.

Удиртгал хэсэгт:

- Тогтоолыг хэзээ, хаана, ямар шүүх гаргасан;
- Шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, хэргийн болон шүүх хуралдааны оролцогчдын овог, нэр, хаяг;
- Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалын огноо, дугаар;
- Хэний гомдлоор хэргийг хянан хэлэлцэж байгааг тус тус бичнэ.

Тодорхойлох хэсэгт:

- Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн агуулга;
- Хяналтын журмаар гаргасан гомдлын агуулга;
- Хяналтын журмаар гаргасан гомдолд өгсөн тайлбар зэргийг тусгана.

Үндэслэх хэсэгт:

- Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалын хууль зүйн үндэслэл;
- Шүүхээс хуулийг хэрхэн тайлбарлаж хэрэглэсэн, хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн эсэх;
- Хяналтын гомдол хуулийн үндэслэлтэй эсэхэд өгсөн дүгнэлтийг тус тус заана.

Тогтоох хэсэгт:

- Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээсэн, өөрчилсөн, хүчингүй болгосон хяналтын журмаар гаргасан гомдлыг хангасан эсэх;
- Улсын тэмдэгтийн хураамжийг хэрхэн шийдвэрлэсэн;
- Уг тогтоолыг эс зөвшөөрвөл Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргах эрхтэй болохыг тус тус дурьдана.

Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолыг уншиж сонсгосноос хойш 7 хоногийн дотор хэргийн оролцогчдод гардуулж, баримт үйлдэж, хэрэгт хавсаргана.

Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолд хэргийн оролцогч тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нарын гомдол гаргах хугацаа дууссан, эсхүл тогтоолд гомдол гаргасан боловч түүнийг Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч үндэслэлгүй гэж үзэж, хариу өгснөөр уг тогтоол хуулийн хүчин төгөлдөр болно.

2.1. Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхих:

Анхан болон давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн, хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчөөгүй бол хяналтын шатны шүүх шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, хэргийн оролцогчдоос гаргасан хяналтын гомдлыг хангахгүй орхино.

2.2. Шийдвэр, магадлалд нэмэлт, өөрчлөлт оруулах:

Анхан болон давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ нотлох баримтыг бүрэн бүрдүүлсэн боловч тэдгээрт дүгнэлт хийхдээ хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл хяналтын шатны шүүх шийдвэр, магадлалыг зөвтгөж, өөрчлөлт оруулна.

Харин анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөв хэрэглэсэн боловч нэхэмжлэлийн шаардлагыг дутуу шийдвэрлэсэн, эсхүл зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай асуудлыг орхигдуулсныг хяналтын шатны шүүх засах боломжтой гэж үзвэл шүүхийн шийдвэр, магадлалд нэмэлт оруулна.

2.3. Магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөх:

Анхан шатны шүүх шийдвэр гаргахдаа хуулийг зөв хэрэглэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчөөгүй, нотлох баримтыг бүрэн цуглуулж, үндэслэлтэй дүгнэлт хийсэн байхад давж заалдах шатны шүүх хууль буруу хэрэглэж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон нь тогтоогдвол магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээнэ.

Харин анхан шатны шүүх шийдвэр гаргахдаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчөөгүй, нотлох баримтыг бүрэн бүрдүүлсэн атлаа, түүнд дүгнэлт хийхдээ хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн байхад давж заалдах шатны шүүх шийдвэрт өөрчлөлт оруулалгүй, хүчингүй болгож шийдвэрлэсэн бол магадлалыг хүчингүй болгож, шийдвэрт өөрчлөлт оруулна.

2.4. Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох:

Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь буюу заримыг хангаж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр буюу түүнийг хэвээр үлдээсэн магадлалыг гаргахдаа анхан болон давж заалдах шатны шүүх хууль буруу хэрэглэсэн, хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь тогтоогдвол шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгоно.

Харин хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх үед Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйл болон 41, 42, 43 дугаар зүйлд заасан үндэслэл илэрвэл шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгоно.

2.5. Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан болон давж заалдах шатны шүүхэд буцаах:

Анхан шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ нотлох баримтыг дутуу бүрдүүлсэн, буруу үнэлсэн, эсхүл хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн байхад давж заалдах шатны шүүх шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн бол хяналтын шатны шүүхээс шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхээр хэргийг дахин хянан шийдвэрлүүлэхээр буцаана.

Харин давж заалдах шатны шүүх магадлал гаргахдаа хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн байвал магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг дахин хянан хэлэлцүүлэхээр давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ.

176¹ дугаар зүйл. Улсын дээд шүүхийн нийт
шүүгчдийн хуралдаан

- 176¹.1. Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 176.2-т заасан тогтоолыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хууль зөрчсөн үндэслэлээр Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаж болно.
- 176¹.2. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл энэ хуулийн 174.1-д заасан хугацаанд дүгнэлт гаргаж, уг хэргийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлнэ. Ерөнхий шүүгчийн дүгнэлтэд хэрэг шийдвэрлэсэн байдал, гомдлын болон хууль зөрчсөн үндэслэлийг тусгасан байна.
- 176¹.3. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг үндэслэлгүй гэж үзвэл энэ хуулийн 174.1-д заасан хугацаанд хууль тогтоомжид заасны дагуу гомдол гаргагчид бичгээр хариу өгнө.
- 176¹.4. Улсын дээд шүүхийн хуралдаан Улсын дээд шүүхийн нийт шүүгчдээс бүрдэнэ. Энэхүү хуралдаанаас энэ хуулийн 178.1-д заасан тогтоол гаргана.
- 176¹.5. Танхимын шүүх хуралдааны тогтоолд гаргасан гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх хүлээн авч энэ хуулийн 163.1, 173.1-д заасан журмын дагуу хэргийн хамт Улсын дээд шүүхэд хүргүүлнэ. Энэ хуулийн 176¹.1-д заасны дагуу гомдол гаргасан этгээдэд энэ хуулийн 57.1, 57.4-т заасан журам хамаарахгүй.

ТАЙЛБАР

1. Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолыг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар эс зөвшөөрвөл уг тогтоолыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хууль зөрчсөн үндэслэлээр Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргана.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гаргасан гомдлыг тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүгч хүлээн авч, холбогдох материалыг бүрдүүлэн, Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимд хүргүүлнэ.

Энэ тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 173 дугаар зүйлийн 173.1, 173.2-т заасан журмыг баримтлах тул уг заалтын тайлбарыг үзнэ үү.

Захиргааны хэргийн танхимын тэргүүний туслах уг хэргийг бүртгэлд авч, Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлнэ.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч хэргийг 30 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.

2. Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл дүгнэлт гаргана.

Ерөнхий шүүгчийн дүгнэлтэд уг хяналтын гомдлын үндэслэл, хэрэг хянан шийдвэрлэсэн анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэрүүдийн агуулга, хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолыг ямар учраас хууль зөрчсөн гэж үзсэн үндэслэл, шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар тодорхой тусгасан байна.

Ерөнхий шүүгч дүгнэлт гаргасан бол уг хэргийг 30 хоногийн дотор Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хянан хэлэлцэнэ. Нийт шүүгчдийн хуралдааны товыг Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч буюу түүний эзгүйд орлож буй Танхимын тэргүүн захирамж гарган, товыг зарлаж хуралдуулна.

Захирамжид хуралдаан болох газар, огноо, цаг, хэлэлцэх асуудал түүний илтгэгч, урилгаар оролцогчдыг тодорхойлно.

Уг хуралдаанд хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч оролцохыг хүсвэл хуралдааны товыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 175.1-д заасны дагуу мэдэгдэнэ.

Улсын Дээд шүүхийн хуралдаанд нийт шүүгчдийн хуралдаанд Улсын Дээд шүүхийн бүх шүүгчид оролцоно.

3. Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч хэргийг хянаад гомдлыг үндэслэлгүй гэж үзвэл гомдол гаргасан этгээдэд Ерөнхий шүүгчийн ажлын албаны дарга албан бичгээр хариу өгнө.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолыг хууль зөрчөөгүй, дүгнэлт гаргах үндэслэлгүй гэж үзсэн талаар Ерөнхий шүүгчийн ажлын албаны дарга албан бичгээр хяналтын гомдолд хариу өгснөөр тухайн хэрэг, маргааны хувьд Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол нь эцсийн шийдвэр болно.

Хэрэв Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргасан этгээд Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаас өмнө гомдлоосоо татгалзвал Ерөнхий шүүгч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.3-т заасны дагуу түүнийг гомдол гаргаагүйд тооцож, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 79 дүгээр зүйлд зааснаар захирамж гаргана.

Харин нэхэмжлэгч, нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, нэхэмжлэгч, хариуцагч эвлэрсэн зэрэг нь бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй бол мөн хуулийн 79 дүгээр зүйлд зааснаар Ерөнхий шүүгч захирамж гаргаж, хэргийг хэрэгсэхгүй болгоно.

4. Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан нь Дээд шүүхийн 17 шүүгчээс бүрдэх бөгөөд нийт шүүгчдийн хуралдаанд бүх шүүгчдийн гуравны хоёроос доошгүй нь хүрэлцэн ирснээр хуралдаан хүчинтэйд тооцогдох бөгөөд хэрэг, маргааныг хуралдаанд оролцсон шүүгчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

Хуульд өөрөөр заагаагүй бол анхан болон давж заалдах шатны журмаар тухайн хэрэг, маргааныг хянан хэлэлцэхэд оролцсон Улсын Дээд шүүхийн шүүгч уг хэрэг, маргааныг Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаан болон нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэхэд оролцож болохгүй.

Тогтоолд нийт шүүгчдийн хуралдаан даргалагч, хэргийг илтгэсэн танхимын тэргүүн болон шүүгч гарын үсэг зурна.

Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаас тогтоол гарна. Энэ тогтоол нь тухайн хэрэг, маргааны хувьд эцсийн шийдвэр байна.

5. Захиргааны хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолд хэргийн оролцогч тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар хууль зөрчсөн үндэслэлээр гомдол гаргасан тохиолдолд гомдлыг хүлээн авах, тайлбар гаргуулах, хэргийг Улсын Дээд шүүхэд хүргүүлэх зэрэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 173 дугаар зүйлд хийсэн тайлбарын холбогдох заалтуудаар зохицуулах бөгөөд харин танхимын шүүх хуралдаанаас гаргасан тогтоолыг эс зөвшөөрч Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаж буй этгээд улсын тэмдэгтийн хураамж төлөхгүй.

177 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх

- 177.1. Улсын дээд шүүх энэ хуулийн 176¹ дугаар зүйлд заасны дагуу Улсын дээд шүүхийн хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэж байгаа тохиолдолд шүүгчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 177.2. Энэ хуулийн 177.1-д заасан шүүх бүрэлдэхүүний санал тэнцвэл дүгнэлтийг хүлээн аваагүйд тооцно.

ТАЙЛБАР

1. Улсын Дээд шүүхийн Нийт шүүгчдийн хуралдаанаар хэргийг хянан хэлэлцэж байгаа тохиолдолд Ерөнхий шүүгчийн дүгнэлтийг хүлээж авах эсэх талаар хуралдаанд оролцож буй шүүгчдийн саналыг хурааж, “олонхын санал авсан” бол дүгнэлтэд заасан үндэслэлийн дагуу тухайн хэргийг шийдвэрлэнэ.

“Олонхын санал авсан” гэдэг нь хуралдаанд оролцож буй шүүгчдийн 51 буюу түүнээс дээш хувийн санал авсаныг хэлнэ.

Хуралдаанд оролцож буй шүүгчид саналаа илээр гаргана.

Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанд хэргийг Танхимын тэргүүн, эсхүл Ерөнхий шүүгчийн томилсон шүүгч илтгэж хэлэлцүүлнэ.

2.Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанд оролцсон шүүх бүрэлдэхүүний /шүүгчдийн/ санал тэнцвэл Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн гаргасан -дүгнэлтийг хүлээн аваагүйд тооцох бөгөөд энэ тохиолдолд Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаас гаргасан тогтоол хэвээр үлдэнэ.

178 дугаар зүйл.Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэсэн тогтоол

178.1. Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэргийг дараах байдлаар хянан шийдвэрлэж тогтоол гаргана:

178.1.1. шийдвэр, магадлал, тогтоолыг хэвээр үлдээж, энэ хуулийн 176^{1.2}-т заасан дүгнэлтийг хангахгүй орхих;

178.1.2. шийдвэр, магадлал, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах;

178.1.3. магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөх;

178.1.4. тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, магадлал, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөх;

178.1.5. шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох;

178.1.6. шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхэд буцаах.

178.2. Энэ хуулийн 178.1-д заасан шүүхийн тогтоол танилцуулан сонсгомогц хуулийн хүчин төгөлдөр болно.

178.3. Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол эцсийнх байна.

ТАЙЛБАР

Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан нь Үндсэн хуульд заасан шүүхийн дээд байгууллага болох Улсын Дээд шүүхийн үйл ажиллагааг хуульд нийцүүлэн явуулах, хэрэг, эрх зүйн маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж, олонхын саналаар эцэслэн шийдвэрлэх үндсэн хэлбэр юм.

Мөн эрх зүйт төрийг төлөвшүүлэх, Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуулийг дээдлэн, хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх, шүүн таслах ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжилтийг хангах, шүүх эрх мэдлийг бэхжүүлэн хөгжүүлэхэд нийт шүүгчдийн хуралдааны ач холбогдол оршино.

1.1. Шийдвэр, магадлал, тогтоолыг хэвээр үлдээж, энэ хуулийн 176¹.2-т заасан дүгнэлтийг хангахгүй орхих:

Тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлээд гаргасан анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоол хууль зөрчөөгүй нь Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэх үед тогтоогдож, хуралдаанд оролцсон шүүгчдийн олонхи нь Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн гаргасан дүгнэлтийг хүлээж аваагүй бол шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг хэвээр үлдээж, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн гаргасан дүгнэлтийг хангахгүй орхино.

1.2. Шийдвэр, магадлал, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах:

Шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол хууль зөрчсөн учир нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн гаргасан дүгнэлтийг нийт шүүгчдийн хуралдаанд оролцсон шүүгчдийн олонхи нь хүлээж авсан бол шийдвэр, магадлал, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулна.

1.3. Магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөх:

Анхан шатны шүүхийн шийдвэр хуулийн үндэслэлтэй гарсан байхад түүнийг хүчингүй болгосон буюу өөрчилсөн давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээсэн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол хууль зөрчсөн гэж үзэж Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн гаргасан дүгнэлтийг хуралдаанд оролцсон шүүгчдийн олонхи хүлээн авбал магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөлт оруулна.

1.4. Тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, магадлал, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөх;

Анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал хууль зүйн үндэслэлтэй байхад түүнийг хүчингүй болгосон буюу өөрчилсөн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолыг хууль зөрчсөн гэж үзэж Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн гаргасан дүгнэлтийг хуралдаанд оролцсон шүүгчдийн олонхи нь хүлээн авбал

тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээх буюу өөрчилнө.

1.5. Шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох:

Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэр, түүнийг хэвээр үлдээсэн давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол хууль зөрчсөн гэж үзсэн Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн дүгнэлтийг Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанд оролцсон шүүгчдийн олонхи хүлээн авбал шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгоно.

Нийт шүүгчдийн хуралдаанаар хэрэг хянан шийдвэрлэх үед Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйл болон 41, 42, 43 дугаар зүйлүүдэд заасан нөхцөл байдал илэрвэл шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгон, хэргийг хэрэгсэхгүй болгож шүүхийн тогтоол гаргана.

1.6. Шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхэд буцаах:

Анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолыг хууль зөрчсөн гэж үзэж Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн гаргасан дүгнэлтийг нийт шүүгчдийн хуралдаанд оролцсон шүүгчдийн олонхи хүлээн авбал шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхээр дахин хянан шийдвэрлүүлэхээр буцаана.

Харин давж заалдах болон хяналтын шатны шүүх магадлал, тогтоол гаргахдаа хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр гаргасан Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн дүгнэлтийг хуралдаанд оролцсон шүүгчдийн олонхи хүлээн авбал магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг ердийн журмаар дахин хянан хэлэлцүүлэхээр давж заалдах болон хяналтын шатны шүүхэд буцаана.

2.1. Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолыг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар эс зөвшөөрч хууль зөрчсөн үндэслэлээр Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргасныг Ерөнхий шүүгч хүлээн авч, уг гомдол үндэслэлтэй гэж үзэж дүгнэлт гарган Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан тогтоолыг танилцуулан сонсгосноор хуулийн хүчин төгөлдөр болох бөгөөд тухайн хэргийнхээ хувьд уг тогтоол эцсийн шийдвэр болно.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг дахин хянах

92 дугаар зүйл. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлэх

92.1. Хуулийн хүчин төгөлдөр болсон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179-182 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

179 дүгээр зүйл. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах үндэслэл

179.1. Хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр /анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоол/-ийг дараах үндэслэл байвал шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж болно:

179.1.1. шүүхийн шийдвэр гарах үед хэргийн оролцогчид мэдэгдээгүй буюу мэдэгдэх боломжгүй байсан нотлох баримт илэрвэл;

179.1.2. шүүхийн шийдвэр гаргах үндэслэл болсон нотлох баримт хуурамч, эсхүл шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, хэргийн оролцогчийн уг хэргийг хянан шийдвэрлэх үед гаргасан үйлдэл /эс үйлдэхүй/ эрүүгийн гэмт хэрэг болох нь шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон;

179.1.3. шүүхийн шийдвэр гарах үндэслэл болсон шүүхийн шийтгэх тогтоол буюу шийдвэр, эсхүл төр, захиргааны болон бусад байгууллагын шийдвэр нь хууль бус байсны улмаас хүчингүй болсон .

ТАЙЛБАР

1. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах ажиллагаа нь шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг сахин биелүүлэх, иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрх, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн баталгааны нэг хэсэг мөн.

Шүүхийн шийдвэрийг дахин хянах ажиллагааны нэг төрөл нь хүчин төгөлдөр болсон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянах ажиллагаа юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлийн 179.1.1, 179.1.2, 179.3-т заасантай адил үндэслэл байвал захиргааны хэргийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлаар хянан үзнэ.

Хуулийн хүчин төгөлдөр болсон Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлтэд үндэслэн уг ажиллагаа явагддаг бөгөөд тухайн хүсэлтийг эрх зүйн хэрэгсэл гэж нэрлэдэг. Энэхүү эрх зүйн хэрэгсэл нь нэгэнт явагдаад өнгөрсөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зөвхөн хуульд заасан үндэслэлээр дахин шинээр явуулснаар хууль зүйн үндэслэлтэй шийдвэр гаргах нөхцлийг бүрдүүлнэ.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлт нь шүүхийн шийдвэрт гаргах гомдлын бие даасан төрөл юм.

Эрх зүй судлаачид нэгэнт хүчин төгөлдөр үйлчилж байгаа шүүхийн шийдвэр магадлал, тогтоолыг хүчингүй болгоход шууд хүргэхүйц хуульд заасан нөхцөл байдлыг шинээр илэрсэн нөхцөл байдал гэж тодорхойлжээ.

Шинэ нөхцөл байдал гэж үзэхийн тулд дорхи шаардлага хангагдсан байх ёстой.

- Шинээр илэрсэн нотлох баримт нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болохуйц баримт байх ба захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гарах үед уг шинэ нотлох баримт хэргийн оролцогчид болон шүүхэд мэдэгдээгүй байх,
- Захиргааны хэргийн шүүхээс Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 –д заасны дагуу нотлох баримт бүрдүүлэх, цуглуулах үүргээ хангалтгүй биелүүлсэн буруутай үйл ажиллагаатай ямар нэг байдлаар холбоотой байх,
- Шинээр илэрсэн нотлох баримт нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гарах үед мэдэгдэх боломжгүй байсан болох нь тогтоогдсон байх шаардлагатай.
- Хэргийн оролцогчдоос шинээр гаргасан нотлох баримт нь тухайн захиргааны хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой төдийгүй, анхан шатны журмаар уг хэргийг дахин хянан хэлэлцэхэд зайлшгүй хүргэх шинж бүхий байна.

2.Энэ зүйлийн “шүүхийн шийдвэр” гэдэгт захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоолын аль аль нь хамаарна.

3.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлтийг тухайн захиргааны хэргийн нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэднээс итгэмжлэл олгосны дагуу тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч гаргах эрхтэй. Мөн тухайн шийдвэрийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь шууд холбогдож байгаа бусад этгээд шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлтийг гаргаж болох юм.

4.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлт гаргаж байгаа хэргийн оролцогчоос улсын тэмдэгтийн хураамж төлөхийг шаардахгүй бөгөөд улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй явдал нь хүсэлтийг шүүх хүлээж авахаас татгалзах үндэслэл болохгүй.

5.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах үндэслэл нь давж заалдах болон хяналтын шатны журмаар шүүхийн шийдвэрийг хянах үндэслэлээс ялгаатай.

Хуулийн 179 дүгээр зүйлийн 179.1.1-д заасан "...хэргийн оролцогчид мэдэгдээгүй буюу мэдэгдэх боломжгүй байсан нотлох баримт илэрвэл" гэдгийг шүүхийн шийдвэр гарах үед илрээгүй байх төдийгүй хэргийн оролцогч мэдэгдээгүй, мэдэгдэх боломжгүй байснаас шүүхэд гаргаж өгөөгүй, захиргааны хэргийн шүүхээс нотлох баримт цуглуулах, бүрдүүлэх үед мэдэгдээгүй буюу илэрч тогтоогдох боломжгүй байсан нотлох баримт захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа илэрсэн байх явдал гэж ойлгож болох юм.

Захиргааны хэргийн шүүхийн хувьд шинэ нотлох баримт шүүхэд гаргаж өгөөгүй асуудлыг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.1.3, 20.2.1 –д заасан эрх үүргийн хүрээнд авч үзэх ёстой.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлийн 179.1.1-д заасантай адил үндэслэлээр Захиргааны хэргийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, магадлал, тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хэргийн оролцогчдын хүсэлтийг шүүх хүлээн авч шийдвэрлэхдээ хүсэлтэд дурьдсан төдийгүй хавсаргасан шинэ нотлох баримт хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг дахин хянах хангалттай үндэслэл болж чадах эсэхийг сайтар анхаарах шаардлагатай.

Мэдэгдээгүй буюу мэдэгдэх боломжгүй байсан нотлох баримт нь хуульд заасан журмын дагуу илэрсэн, тухайн хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой, анхан шатны журмаар зайлшгүй дахин хянан хэлэлцэхэд хүргэхээр шинжтэй байсан нь сая шинэ нөхцөл байдалд тооцогдоно.

Харин захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримт нь төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой, өөр улс орон нутагт байгаагаас шалтгаалан захиргааны хэргийн нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлсэн, хууль буруу хэрэглэсэн нь шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах үндэслэл болохгүй тул аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.1 –д заасан ажиллагааг гүйцэтгэхдээ анхааралтай хандаж байвал зохино.

Хэргийн оролцогч болон тухайн шийдвэрийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдээс ирүүлж байгаа шинэ нотлох баримт нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн үндэслэлийг өөрчлөх буюу уг баримтаар тодорхойлогдох нөхцөл байдал өөрчлөгдөх хэмжээнд хүрсэн нөхцөлд л шинэ баримтад тооцогдох бөгөөд давах, хяналтын шатанд гаргаж байсан баримт шинэ нотлох баримтад хамаарахгүй.

Шүүхийн шийдвэр гарах үндэслэл болсон нотлох баримт хуурамч байсан нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа илэрч тогтоогдсон байх ба "хуурамч,, болохыг эрх бүхий байгууллагаар зохих журмын дагуу шалгагдан тогтоогдож гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийтгэх тогтоол гарч хүчин төгөлдөр болсон байхыг шаардана.

Нотлох баримт хуурамч байж магадгүй гэх сэжиг таамаг, "хуурамч,, болохыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах" байгууллага шалгаж байгаа нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлт гаргах үндэслэл болж чадахгүй.

Харин энэ шалтгаан нь хэргийн оролцогчоос шинээр ирүүлж байгаа нотлох баримт нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн үндэслэлийг өөрчлөх буюу уг баримтаар тодорхойлогдох нөхцөл байдал өөрчлөгдөх хэмжээнд хүрэлцэхүйц байсан ч өмнө нь хэргийн оролцогчдоод мэдэгдэж байсан бол шинэ нөхцөл байдалд хамаарахгүй шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг ердийн журмаар дахин хэлэлцүүлэх үндэслэл болж чадахгүй юм.

Харин Шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримт хуурамч болох нь зохих журмын дагуу тогтоогдсон боловч хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн, өршөөлд хамаарсан зэргээс гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн тогтоол гаргаагүй явдал нь шинэ нөхцөл байдалд үүсгэж шүүхийн шийдвэрийг хүчингүй болгон тухайн захиргааны хэргийг ердийн журмаар хэлэлцүүлэхэд саад болохгүй.

Харин хэргийн оролцогчдоос хожим нь өөр шинжээчээр шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон шинжээчийн өмнөх дүгнэлтийг өөрчлүүлэн шинээр дахин гаргуулсан дүгнэлт, өмнөх мэдүүлгээсээ буцсан тухайд гэрчийн тодорхойлолт зэрэг бичмэл баримт нь шинээр илэрсэн нөхцөл байдлыг үүсгэхгүй.

180 дугаар зүйл. Шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гаргах

- 180.1. Шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг тийнхүү хянах үндэслэл байгааг мэдсэнээс хойш 30 хоногийн дотор зохигч, гуравдагч этгээд болон тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч уг шийдвэрт давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргаагүй бол анхан шатны, гомдол гаргасан бол тухайн шатны шүүхэд гаргана.
- 180.2. Хүсэлтийг бичгээр гаргаж түүнд шинээр илэрсэн нөхцөл байдлын талаарх баримтыг хавсаргана.
- 180.3. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гаргасан этгээд шүүх хуралдаанаас өмнө хүсэлтээсээ татгалзвал түүнийг хүсэлт ирүүлээгүйд тооцно.

ТАЙЛБАР

1.Хуулийн хүчин төгөлдөр болсон Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, хяналтын шатны тогтоолын аль алиныг нь шинээр илэрсэн нөхцөл байдлаар дахин хянуулж болно.

Тухайн захиргааны хэргийн шийдвэр дээд шатны шүүхээр хянагдаагүй байвал шинэ нөхцөл байдлаар дахин хянуулах тухай хүсэлтээ тухайн шийдвэрийг гаргасан анхан шатны шүүхэд гаргана.

Захиргааны хэргийн давж заалдах шатны магадлалыг дахин хянуулах шаардлагатай бол Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд, хяналтын шатны захиргааны хэргийн тогтоолыг дахин хянуулах бол Улсын дээд шүүхэд хандан хүсэлтээ

гаргах бөгөөд анхан шатны шүүх хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт хүлээн авна.

2. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлтийг бичгийн хэлбэрээр гаргахыг хуульд заасан боловч хүсэлтийн агуулгын талаар шаардлага тавигдаагүй байна.

Хуулийн хүчин төгөлдөр болсон Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтэд юуны өмнө захиргааны хэргийн аль шатны шүүхийн ямар шийдвэр /магадлал, тогтоол/-ийг дахин хянуулах гэж байгаа, шинээр илэрсэн нөхцөл байдал нь ямар нотлох баримтуудаар тогтоогдож байгааг заасан байна.

Мөн хүсэлтэд шүүхийн шийдвэрийг дахин хянах үндэслэл болсон шинэ нөхцөл байдал хүсэлт гаргагчид хэдийд илэрч мэдэгдсэн хугацааг тодорхой заасан байх ёстой бөгөөд энэ нь хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн эсэхийг тогтооход чухал ач холбогдолтой.

3. Хүчин төгөлдөр болсон захиргааны хэргийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлтийг тухайн захиргааны хэргийн оролцогч, тэдний эрх олгосноор төлөөлөгч, өмгөөлөгч нь гаргах эрхтэй.

Хүсэлт гаргах эрх бүхий этгээд хуульд заасан мэдснээс хойш 30 хоногийн дотор хүсэлтээ гаргаагүй бол, захиргааны хэргийн шийдвэрийг шинэ нөхцөл байдлын улмаас дахин хянуулах хүсэлт гаргах эрхээ алдах бөгөөд шинэ нөхцөл илэрсэн ч шүүх хүсэлтийг хэрэгсэхгүй болгох үндэслэл болно.

Хэрэв хүсэлт гаргах хугацааг хэтрүүлсэн нь хүндэтгэн үзэх шалтгаантай байвал эрх бүхий этгээдийн хүсэлтээр хөөн хэлэлцэх хугацааг анхан шатны шүүх сэргээнэ

Ишлэл хийсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 180 дугаар зүйлийн 180.1-д заасан "...30 хоногийн дотор..." гэсэн хугацааг захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах үндэслэл байгааг мэдсэн үеэс Иргэний хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-д заасан журмын дагуу тоолно.

Давж заалдах эсхүл хяналтын гомдлоос татгалзсан үндэслэлээр гомдол гаргаагүйд тооцож давж заалдах болон хяналтын шатны захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгсэхгүй болгож магадлал, тогтоол, гарсныг дээд шатны шүүхийн шийдвэртэй гэж үзэхгүй бөгөөд энэ тохиолдолд шинэ нөхцөл байдлаар гаргах хүсэлтийг анхан шатны шүүхийн шийдвэрт холбогдуулан гаргана.

4. Хүчин төгөлдөр болсон Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах тухай хүсэлтэд хавсаргасан шинэ нотлох баримт нь хуулийн шаардлага хангасан байна.

5. Магадлал, тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлт гаргасан бол анхан шатны шүүх хүсэлтийг хүлээж авсан өдрөөс хойш Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.7-д заасан хугацааг нэгэн адил баримтлан хүсэлтийг хэргийн хамт давах буюу хяналтын шатны шүүхэд хүргүүлнэ.

Хүсэлтийг хүлээн авсан анхан шатны шүүх хүчин төгөлдөр болсон захиргааны хэргийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлт, түүнд хавсаргасан шинэ нотлох баримтыг хүсэлт гаргаагүй тал буюу хэргийн бусад оролцогчдод танилцуулж, тайлбар гаргах боломж олгох ёстой. Хүсэлт гаргаагүй хэргийн оролцогчид шинэ нөхцөл байдалтай холбогдуулан тайлбар гаргаагүй явдал нь хэргийг тухайн дээд шатны шүүхэд хүргүүлэхэд саад болохгүй.

6.Хүчин төгөлдөр болсон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг шүүгчдийн зөвлөлгөөнөөс тогтоосон хэрэг хуваарилах журмын нэгэн адил баримталж хуваарилна.

181 дүгээр зүйл.Хүсэлтийг шийдвэрлэх

- 181.1. Шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг энэ хуульд заасан журмын дагуу тухайн шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.
- 181.2. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянахад анхан шатны шүүхийн шийдвэр гаргасан шүүгч буюу шүүх бүрэлдэхүүн дахин оролцохгүй.
- 181.3. Хүсэлт гаргасан этгээд шүүх хуралдаанд оролцохыг хүсвэл түүнд мэдэгдэх ба ийнхүү хүсэлт гаргасан этгээд хүрэлцэн ирээгүй явдал хүсэлтийг шийдвэрлэхэд саад болохгүй.
- 181.4. Шүүх хуралдаанаар шинээр илэрсэн нөхцөл байдлыг баталж байгаа шинэ нотлох баримтыг үндэслэн шинээр илэрсэн нөхцөл байдлыг тогтоох, уг нөхцөл байдал нь шийдвэрийг гаргахад хэрхэн нөлөөлсөн, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянан шийдвэрлэх хууль ёсны үндэслэл байгаа эсэхийг шийдвэрлэнэ.
- 181.5. Шүүх хүсэлтийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлээд түүнийг хангах, эсхүл хангахаас татгалзах тухай тогтоол гаргана.
- 181.6. Шүүх шинээр илэрсэн нөхцөл байдлыг тогтоосон нөхцөлд шүүхийн урьд гаргасан шийдвэрийг хүчингүй болгож хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

ТАЙЛБАР

1.Тухайн захиргааны хэргийн талаар эцсийн шийдвэр гаргасан шүүх шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ. Шүүх хуралдаан хуульд заасан тухайн шатны шүүх хуралдааны дэгийн дагуу явагдана.

Шүүх хуралдаанаар шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлт, түүнд хавсаргасан шинэ баримтын талаар хэлэлцэх бөгөөд тухайн хүчин төгөлдөр болсон захиргааны хэргийн шүүхийн шийдвэртэй хэргийн талаар хэлэлцэхгүй.

Өөрөөр хэлбэл шинэ нөхцөл байдлаар хянуулах гэж байгаа шүүхийн шийдвэр хууль ёсны ба үндэслэлтэй эсэх, хэрэг маргааныг шүүх зөв шийдвэрлэсэн эсэх, тухайн захиргааны хэрэгт авагдсан нотлох баримт хуулийн шаардлага хангасан эсэх гэх мэтээр аливаа дүгнэлт хийхгүй зөвхөн хэргийн оролцогчоос гаргасан хүсэлт, шүүхэд ирүүлсэн шинэ нотлох баримт нь шинээр илэрсэн нөхцөл байдлыг тогтоох үндэслэл болж чадах эсэх, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас тухайн хэргийг дахин хянан үзэж шийдвэрлэх хууль ёсны үндэслэл байгаа эсэхийг үнэлж дүгнэж шийдвэрлэнэ гэсэн үг.

2.Тухайн шатны шүүх хуралдааны товыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлт гаргасан этгээдэд болон бусад оролцогчдод хуульд заасан журмын дагуу мэдэгдэх үүрэгтэй ба тэднийг хүрэлцэн ирээгүй явдал нь хүсэлтийг хэлэлцэж шийдвэрлэхэд саад болохгүй.

3.Тухайн шатны шүүх шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас захиргааны хэргийг дахин хянан шийдвэрлэх хууль ёсны үндэслэл байгаа гэж үзвэл хүсэлтийг хангаж шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхээр ердийн журмаар хянан хэлэлцүүлэхээр шийдвэрлэнэ.

Харин тухайн шатны шүүх шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас захиргааны хэргийн шийдвэр /магадлал, тогтоол/-ийг хянуулах хүсэлтийг хангах хууль ёсны үндэслэл байхгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн бол хүсэлтийг хангахаас татгалзсан тогтоол гаргах ба хэргийг анхан шатны шүүхэд нь буцаана. Өөрөөр хэлбэл дахин хянуулах хүсэлтэд холбогдох шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолын хуулийн хүчин төгөлдөр байдал хэвээр хадгалагдан үлдэнэ.

4.Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг хянан шийдвэрлэх хугацааг хуулиар тусгайлан зохицуулаагүй байна.

Тухайн шатны шүүх шинэ нөхцөл байдлаар хянуулах хүсэлтийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 85 дугаар зүйлийн 85.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 174 дүгээр зүйлийн 174.1-д заасан хугацааны дотор хянан хэлэлцэж шийдвэрлэнэ гэж ойлгоно.

182 дугаар зүйл.Биелэгдсэн шийдвэрийг цуцлах

182.1. Биелэгдсэн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянан шийдвэрлэсэн шүүх хүчингүй болгож байгаа бол биелэгдсэн шийдвэрийг цуцлах тухай асуудлыг тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхээр шийдвэрлүүлэхээр шилжүүлэх үүрэгтэй.

ТАЙЛБАР

1. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гаргасан явдал нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3/ болно. Тухайн шатны шүүх хүсэлтийг хангах хууль зүйн үндэслэлгүй гэж дүгнэж хүсэлтийг хангахаас татгалзаж тогтоол гаргаснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл арилсанд тооцогдох ба төлбөр авагчийн буюу шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээнэ.

2. Тухайн шатны шүүх шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас захиргааны хэргийн шүүхийн шийдвэр /магадлал, тогтоол/-ийг хүчингүй болгосон бол биелэгдсэн шийдвэрийг цуцлах тухай асуудал тавигдана.

Биелэгдсэн шийдвэрийг цуцлах тухай асуудлыг тухайн захиргааны хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн Захиргааны хэргийн шүүх хүлээн авч шийдвэрлэнэ.

Харин дээд шатны шүүхээр хүсэлтийг хэлэлцэх явцад биелэгдсэн шийдвэрийг цуцлах хүсэлт тавигдсан бөгөөд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлт хангагдсан бол биелэгдсэн шийдвэрийг цуцлах асуудлыг анхан шатны тухайн захиргааны хэргийн шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлнэ.

3. Хуулийн 182 дугаар зүйлийн 182.1-т заасан “биелэгдсэн шийдвэр” гэдэгт шинээр илэрсэн нөхцөл байдлаар хянагдаж хүчингүй болсон шийдвэрийн дагуу захиргааны акттай холбогдох шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа бүрэн буюу хагас биелэгдсэн байх тохиолдлын аль алиныг хамааруулж үзнэ.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

93 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх

93.1. Захиргааны хэргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр /шийдвэр, магадлал, тогтоол, шүүгчийн захирамж/-ийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183-188 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу албадан биелүүлнэ.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар бүлгийн 93 дугаар зүйлийн дагуу захиргааны хэргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр буюу шийдвэр, магадлал, тогтоол, шүүгчийн захирамжийг биелүүлэх асуудлыг зохицуулж байна. Дээр дурдсан зүйлийн дагуу нэхэмжлэгч буюу иргэн, хуулийн этгээд түүнчлэн хариуцагч захиргааны байгууллага, албан тушаалтан захиргааны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийг сайн дураараа биелүүлэх үүрэгтэй билээ.

Тухайлбал энэ тухай Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.2.2 -т нэхэмжлэгч нь болон 20.2.3-т хариуцагч нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй хэмээн хуульчилжээ.

Харин шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183-188 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу албадан биелүүлэхээр заасан байна. Өөрөөр хэлбэл захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа иргэний хэргийн талаар шүүхээс гаргасан шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны нэгэн адил журмаар гүйцэтгэнэ.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, шүүхийн шийдвэр заавал биелүүлэх зэрэг нийтлэг зарчмыг баримтална.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжлэл бөгөөд шүүхийн шийдвэр биелэгдсэн, эсхүл хуульд заасан бусад тохиолдолд дээр дурдсан ажиллагаа дуусгавар болсонд тооцогдоно.

Захиргааны хэргийн хариуцагч болох нийтийн эрх зүйн субъект нь /Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийг үз/ захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэйг хуульчилж өгсөн юм.

Тухайлбал, хэргийн оролцогчид захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн биелүүлэх үүрэгтэй гэж Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заажээ.

Хэрэв хариуцагч захиргааны хэргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр, магадлал, тогтоол, шүүгчийн захирамжийг сайн дураараа биелүүлээгүй тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183-188 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу албадан биелүүлнэ.

Тухайлбал Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дээр дурдсан зүйлийн дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл болсон гүйцэтгэх хуудас, түүний агуулга, гүйцэтгэх хуудсыг үрэгдүүлсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаархи асуудлыг зохицуулж байгаа болно.

Түүнчлэн дээр дурдсан хуулийн 185 дугаар зүйлд заасанчлан шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг албадан гүйцэтгүүлэх болон шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудсыг шийдвэр гүйцэтгэх албанд шууд гардуулах тохиолдлыг тус тус хуульчилжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн үзэл баримтлалын дагуу захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дор дурдсан үе шаттайгаар авч үзэж болно.

Нэгдүгээрт, ахлах шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авч хуульд заасан шаардлага хангшасан эсэхийг нягтлан үзнэ. Тухайлбал: дээр дурдсан хуулийн дагуу гүйцэтгэх хуудсанд дараах зүйлийг тусгасан байна.

- Гүйцэтгэх хуудас олгосон шүүхийн нэр,
- Шийдвэр гаргасан огноо, шийдвэрийн дугаар,
- ямар хэргийн шийдвэрийг үндэслэж, гүйцэтгэх хуудас олгосон,
- гүйцэтгэх хуудас бичсэн шүүгчийн нэр, түүнийг олгосон огноо,
- хариуцагч болох нийтийн эрх зүйн субъектын нэр, оноосон нэр, үйл ажиллагаа явуулж байгаа газрын хаяг, нэхэмжлэгчийн овог, эцгийн нэр, нэр,

- ажлын болон гэрийн хаяг, утасны дугаар /хуулийн этгээд бол түүний нэр, оноосон нэр, үйл ажиллагаа явуулж байгаа газрын хаяг/
- шаардлагтай бол хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар, иргэн бол иргэний үнэмлэх, регистрийн дугаар,
 - шүүхээс гаргасан шийдвэрийн хүчин төгөлдөр болох хугацаа

Хэрэв гүйцэтгэх хуудас хуульд заасан шаардлага хангасан бол гүйцэтгэх хуудсыг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор гүйцэтгэх ажиллагаа үүсгэх тухай тогтоол гарган хувийн хэрэг нээж холбогдох шийдвэр гүйцэтгэгчид хуваарилна.

Харин гүйцэтгэх хуудас шаардлага хангаагүй бол ахлах шийдвэр гүйцэтгэгч хуудсыг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор шүүхэд буцаах тухай тогтоол гаргаж, түүнд буцаасан шалтгаан, үндэслэлийг зааж өгнө.

Хууль зүйн шинжлэх ухаанд нийтийн эрх зүйн байгууллага шүүх эрх мэдөийн байгууллагаас гаргасан шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй хэмээн үздэг байна. Гэхдээ ийнхүү шүүхээс гаргасан тогтоол, шийдвэрийг захиргааны байгууллага, албан тушаалтнаас биелүүлэхгүй байвал албадан гүйцэтгэх боломжтойг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлалын дагуу тогтоосон юм.

Харин захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гагцхүү гүйцэтгүүлэх боломжтой нөхцөлтэйгээр гарсан тохиолдолд л түүнийг албадан биелүүлэх шаардлага гарна. Тэгвэл эрх зүйн харилцааг тогтоох, өөрчлөх, хүчингүй болгоход чиглэсэн, эсхүл эрх зүйн тодорхой харилцаа байгаа эсэхийг тогтоосон шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх шаардлагагүй юм. Тухайлбал, захиргааны хэргийн шүүх хуулийн 70.2.1-д маргаан бүхий захиргааны акт хууль бус болох нь тогтоогдвол түүнийг хүчингүй болгох, 70.2.2-т эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоож, хүлэн зөвшөөрөх, 70.2.3-т захиргааны байгууллагаас гаргасан акт нь илт хүчин төгөлдөр бус болохыг нь хүлээн зөвшөөрөх гэх мэт үйл явдлыг тогтоосон бол энэхүү шүүхийн шийдвэр нь шууд л мөрдөгдөнө. Үүнийг англи хэл дээр “self-executing” гэж нэрлэх бөгөөд шийдвэр нь өөрөө биелэгдэх зарчим болно. Иймд энэ тохиолдолд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх гэсэн ойлголт анхнаасаа шаардлагагүй болж байгаа билээ.

Харин захиргааны азтыг гаргахгүй байгаа явдал болон эс үйлдэхүй нь хууль бус гэж тогтоогдсон бол шаардагдах захиргааны актыг гаргахыг тухайн захиргааны байгууллага, албан тушаалтанд даалгах зэрэг үүрэг болгосон нэхэмжлэл болон үйлдлийг зогсоолгох, эсхүл гүйцэтгүүлэх нэхэмжлэлтэй холбогдуулан шүүхээс гаргаж байгаа шийдвэр нь зарчмын хувьд захиргааны байгууллагыг тухайн нэхэмжлэлд дурдсан үйл ажиллагаа явуулах, эсхүл түүнийг явуулахаас татгалзуулахад чиглэгдэнэ. Иймд дээр дурдсан агуулгатай шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтнаар гүйцэтгүүлэх шаардлага гардаг байна. Харин захиргааны байгууллага, албан тушаалтан энэ үүргээ биелүүлэхгүй байгаа бол шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх арга хэмжээ авна.

Тус улсад захиргааны хэргийн шүүх байгуулагдсанаас буюу 2004 оноос хойш нийслэлийн захиргааны хэргийн шүүхээс 280 гаруй хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Үүнээс 39-д нь шийдвэр гүйцэтгүүлэх хүсэлт гаргасны дагуу гүйцэтгэх хуудас бичигджээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан шүүхийн шийдвэрийн хувьд дараах төрлийн маргаан зонхилж байгаа талаар судалгаанаас харагдаж байна.

- Газрын маргаан
- Тарийн албан хаагчийг ажлаас үндэслэлгүй халсан, ажилд эгүүлэн тогтоосон,
- Захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэр,
- Захиргааны актыг хүчингүй болгосон шийдвэр
- Эс үйлдэхүйн үр дагаварыг арилгах тухай шийдвэр.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2-т “Захиргааны хэргийн шүүх шийдвэрээ биелүүлэх арга, журмыг гаргасан шийдвэртээ тодорхойлно” хэмээн заажээ. Хуулийн энэ заалттай холбогдуулан Улсын Дээд шүүхээс Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай 37 дугаар тогтоолыг 2006 оны 7 дугаар сард гаргаж, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр /шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шийдвэр, магадлал/-ийн зөвхөн тогтоох хэсгийн заалтыг хэн, хэзээ, яаж биелүүлэх болон биелэлтийг нь хэрхэн тооцох талаар шийдвэрийн тогтоох хэсэгт тодорхой тусгахыг ойлгоно гэж тодруулан тайлбарлав.

Нөгөө нэг нь шүүхийн шийдвэрийг сайн дураараа биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцооны асуудал практик дээр анхаарал татаж байгаа билээ.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т Захиргааны хэргийн шүүхийн акийг биелүүлээгүй этгээдэд энэ хууль, Эрүүгийн хууль¹³⁶ болон хууль тогтоомжийн бусад актад заасан хариуцлага хүлээлгэнэ хэмэн хуульчилжээ. Түүнчлэн Эрүүгийн хуулийн 258 дугаар зүйлийн 258.1-д хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд зориуд саад учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байдаг. Гэвч практик дээр эрүүгийн хэрэг үүсгэж, хариуцлага ногдуулсан тохиолдол байхгүй байна.

Харин шүүгч нар Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30.3-т шүүхийн шийдвэр, шаардлагыг тогтоосон хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүй буюу биелүүлэхэд саад учруулсан бол 500-10000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна гэж заасны дагуу торгох шийтгэл ногдуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын санаачлан боловсруулж 2006 оны 9 дүгээр сард Улсын Их хуралд өргөн мэдүүлж одоо хэлэлцүүлэгийн шатанд байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэлийн нэг нь иргэний болон захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр байхаар заасан байна.

94 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

94.1.Энэ хуулийг 2004 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

¹³⁶ Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай

(Шоллер/Харбих)

Оршил

Бүгд Найрамдах Монгол ард улсын Ардын Их Хурлаас 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн Хуулиар засаглал хуваах буюу эрх мэдэл хуваарилалтын зарчмыг хүлээн зөвшөөрснөөр хууль дээдлэх ёсыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгосон ардчилсан эрх зүйн тогтолцоотой болсон билээ. (Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйл) Иргэний болон эрүүгийн эрх зүйн маргааныг шүүх уламжлалт шүүхийн хэлбэрүүдээс гадна захиргааны шүүх (administrative courts) байдгийг Үндсэн хуулийн 48 дугаар зүйлд заасан байна.

Монголын Үндсэн Хуулийн дагуу иргэний шүүх тэгш эрхтэй талуудын эрхийн асуудлыг шийдэх үүрэгтэй байхад эрүүгийн шүүх нь хохирогчийн эрхийг хамгаалдаг. Үндсэн хуульд тусган захиргааны шүүхийг нэвтрүүлэх нь Монголын хувьд нэгэн бодлын шинэ зүйл байсан. Ерөнхийд нь авч үзэхэд тэдгээр нь Хүний эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлөх¹³⁷ гэсэн үүрэгтэй.

Мэдээж энэ нь бусад шүүхийн хэлбэрүүдтэй, жишээлбэл нэг талаас хүний эрхийг хамгаалдаг Үндсэн хуулийн цэц, нөгөө талаас хохирол үүссэн тохиолдолд нөхөн төлөх асуудлыг шийдэх иргэний шүүхтэй огтолцож байгаа л даа. Монгол улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг төлөвлөж боловсруулахад туслалцаа үзүүлсэн гавъяат хуульч профессор Бираагийн Чимэдэд гүнээ талархаж байгаагаа илэрхийлэх нь зүйд нийцнэ.

2004 оны 6 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон ба тэр цагаас эхлэн уг хуулийг нэн түрүүнд монголын шүүхүүд хэрэглэх болсон.

Монгол Улс нь нэг намын засаглалтай захиргааны төрөөс ардчилсан эрх зүйт төрийн хэлбэрт шилжсэн нь нийгэмд бүхэлд нь нэн ялангуяа шүүгчдийн хувьд хувьсгал болсон гэж хэлж болно. Төрийн аппаратын гэнэтийн өөрчлөлт нь оролцогч болгонд ер бусын өндөр шаардлага тавина гэдгийг төр, улс төрийн хариуцлагатай хүн болгон ойлгож байлаа. Өмнөх системийн үеийг бодвол нийгэм болон төрийг шинээр нээлттэй болгосон захиргааны шүүхийн нийгмийн ач холбогдол нь захиргааны шүүхийн төсөл бүрэлдэх тусам улам тодорхой болно.

1995 оноос хойш Ханнс-Зайделийн сан монголын хуулийн шилжилтийн явцтай хамт байсан бөгөөд 10 жилийн дараа хөгжлийн хамтын ажиллагааны 10 жилийн ойг Улаанбаатар хотод тэмдэглэхэд шинэ хууль үйлчилж эхлээд 1 жил өнгөрснөөс гадна ойн баярыг тохиолдуулан монгол, герман, америкийн талуудын хийсэн Захиргааны хэргийн дагнасан шүүхийн түүхийн хөгжил болон хэлбэрүүдийн талаарх судалгааг гардуулсан юм.

¹³⁷ Chimid, Das Wesen der Verwaltungsgerichtsbarkeit in der Mongolei, deren gesellschaftliche und rechtliche Bedeutung, in: HSS, Reformen in der Mongolei und Weltpraxis, Ulaanbaatar, 2004.

Энэ явдлаас өмнө нь Ханнс-Зайделийн сан Азийн Хөгжлийн Банкнаас 138 зарласан залуу шүүгчдэд захиргааны хэргийн шүүхийн үүргийг таниулах төслийн ажлыг авсан байсан. Сангийн зүгээс зөвхөн германы загварыг¹³⁹ биш мөн франц, америкийн загварыг танилцуулж тайлбарлах дээр үргэлж анхаарч ирсэн. Учир нь монголын мэргэжилтнүүд өөрсдийн туршлага болон бусад загварыг судалсны үндсэн дээр боловсруулсан хууль болох ёстой байсан. 2007 оны 3 дугаар сард ХБНГУ-ын Мюнхен дэх сангийн төв дээр болсон семинарын үед Монгол улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын 5 шүүгч болон германы онол дадлагын 3 мэргэжилтэнтэй Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлсэн эхний 3 жилд гарсан үр дүн болон тулгамдсан асуудлын талаар хэлэлцсэн. Тухайн хуулийн гол асуудлаар тавьсан олон илтгэлийн дагуу эрчимтэй бөгөөд нээлттэй хэлэлцсэн болохоор оролцогчид семинарыг амжилттай болсон гэж үзсэн.

Мэдээж үүний ард өнгөрсөн хугацаанд илэрсэн хуулийн сул талуудыг тус бүрчлэн тайлбарлах эсвэл нэмэлт, өөрчлөлт оруулснаар арилгаж болох тухай асуудал тавигдаж байлаа. Тийм учраас Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимийн шүүгчид ЗХХШТХ-ийг тайлбарлахаар шийдсэн.

Үүнтэй зэрэгцээд бид нараас мөн өөрийн зүгээс дараа нь монгол хэл рүү орчуулагдах тайлбар бичихийг хүссэн. Герман хэл дээрх эх хувь зүгээр нэг материал биш харин ном болон хэвлэгдэх ёстой гэдэгт зохиогчид ихээхэн ач холбогдол өгсөн.

Ингэсэн тохиолдолд л цаашид тулгарах асуудал болон хуулийн хийдлийн талаар хэлэлцэх нь утга учиртай болох юм. Түүнчлэн зохиогчдоос аль болох товчоор тодруулга хийж, тулгамдсан асуудалд тайлбар өгөхийг хүссэн. Тиймээс санаатайгаар товч бичсэн тайлбараас бүрэн дүүрэн мэдээлэл авна гэж хүлээж болохгүй.

Герман болон Европын бусад эрх зүйт орнуудтай харьцуулахад захиргааны шүүхийн үүргийг Монголын олон нийт арай илүү өргөн цар хүрээтэй хүлээн авдаг. Манай тивийхэн нийгмийн болон санхүүгийн асуудал шийдвэрлэх шүүхтэй зэрэгцэн байх захиргааны ерөнхий шүүхийг ердөө л нэг хуулийн шүүх бүрэлдэхүүн гэж үздэг бол харин монголын олон нийт үүнийг улс төрийн болон соёлын чухал хэрэгсэл гэж үздэг.

Энэ нь 2 замаар үйлчилдэг: нэг талаар урьдчилан сэргийлэх, нөгөө талаар “халамж”. Ялангуяа Монгол шиг шилжилтийн шатанд яваа улсын хувьд урьдчилан сэргийлэх гэдэг нь захиргааны шүүх нэг удаагийн тохиолдлын шударга байдлыг бий болгоод зогсохгүй ерөнхий утгаараа шударга бус явдлыг гаргуулахгүй байх үүрэгтэй гэсэн үг юм.

Тиймээс монголын ЗХХШТХ нь удаан эргэлзэлгүй хуульд хамаарах эрх зүйн тогтоомжуудыг шүүхээр хүчингүй болгосон. Захиргааны актыг захиргааны хэрэг хянан шүүхэд гол зангилаа болдог гэдэг ч ялангуяа гарч болзошгүй хуулийн зөрчлийг урьдчилан сэргийлэхэд уг хуульд хамаарах хэм хэмжээ ч мөн ижил ач холбогдолтой. Сайн хэм хэмжээ нь захиргааны сайн актаас илүү эрчимтэй урьдчилан сэргийлэх үйлчилгээг үзүүлдэг. Монголын захиргааны шүүхийг “халамжийн” үйлчилгээтэй гэдэг нь ХБНГУ байгуулагдсаны дараа нэвтрүүлсэн захиргааны шүүхийн туршлагатай яг тохирч

¹³⁸ Developing Mongolia's Legal Framework A Needs Analysis, Hrsg. Asian Development Bank, 1995.

¹³⁹ Scholler, Die Kontrolle der Verwaltung durch die Verwaltungsgerichtsbarkeit, in: „Ergebnisse“ (=Hintergrund), Ausgabe No. 3, Ulaan Bataar 1998, S. 35-42 (in mongolischer Sprache)

байна. Учир нь энд ч гэсэн захиргааны шүүх хүний нэр хүнд болон амь нас үндсэн хуулиар хамгаалагдсан байдаг тулгуурлан төрөөс нийгмийн халамжийн эрхийг бий болгосон байна.

Тэгэхлээр Монголын хараат бус шүүгчид шинэ ЗХХШТХ-ийн үндсэн дээр урьдчилан сэргийлэх болон ялан шийтгэх аргаар хүний эрхийг хамгаалах хэрэгт хүчин зүтгэж, шинэ эрх зүйн соёлыг бий болгоно гэдэгт итгэж байна.

Доктор/jur./, доктор/h.c./, проф.Хайнрих Шоллер

Доктор/jur./, доктор/h.c./ Юрген Харбих

Мюнхен хот, 2007 оны 5 дугаар сар

МОНГОЛ УЛСЫН ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТАЙЛБАР¹⁴⁰

Доктор /jur./, доктор /h.c./, проф. Хайнрих Шолер

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

- 1.1. Энэ хуулийн зорилт нь иргэн, хуулийн этгээдээс захиргааны актыг хууль бус гэж үзэж, зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар гаргасан гомдол, нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх болон уул захиргааны хэргийг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

I. Ерөнхий үндэслэл

Нэгдүгээр хэсэгт “Ерөнхий үндэслэл” гэсний дор бусад хуультай нэгэн адилаар нийт хууль буюу ЗХХШТХ-д нийтэд нь үйлчлэх журам оржээ. Зарим хэсгээрээ энд шийдвэр, шүүхийн шийдвэр, шинжээчийн дүгнэлт, түүнчлэн эрх үүрэг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан буюу албан үүрэг хэрэгжүүлэгч г.м. бусад этгээдийн хуулийн тодорхойлолтуудыг тусгажээ.

Гэвч нөгөө хэсгээр, тухайлбал цар хэмжээний хувьд захиргааны ерөнхий эрх зүйд хамаарах захиргааны актын тухай ойлголтыг тодорхойлохдоо ЗХХШТХ-ийн хүрээнээс илүү өргөн хүрээтэй зохицуулжээ. Хуулийн зорилтыг тодорхойлох гэдэг нь ЗХХШТХ-ийн хувьд хуулийн системчлэлийн түүхийг төдийгүй, тухайн хууль бүхэлдээ болон зохицуулалт бүрийн чиглэж байгаа зорилго, зорилтыг авч үзнэ гэсэн үг юм.

Уг хуулийн агуулга нь захиргааны зүгээс хэрэгжүүлсэн үйлдлийг шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааны арга замаар зохицуулах явдал юм. Өөрөөр хэлбэл шүүхийн формаль маягийн хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх замаар захиргааны материаллаг эрх зүйн арга хэмжээг хянан гэсэн үг.

II. Бусад зүйл

Захиргааны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах эрх бүхий этгээдэд иргэд, түүн дотор гадаадын этгээд, харъяалалгүй хүмүүс түүнчлэн хуулийн этгээд багтдаг. Хуулийн этгээд гэдэг нь эрх зүйн хувьд эрх үүрэг бүхий хувь хүмүүсийн хоорондын буюу хувь хүмүүс, эд хөрөнгийн нэгдэл байдаг.

Гэхдээ энэ нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд (баг, хороо г.м.) эсвэл иргэний эрхэд хамаарах хуулийн этгээд байж болдог. Үүнд иргэний эрх зүйн дор холбоо, сангууд, бусад байгууллагууд багтана.

Арилжааны эрх зүйн хувьд энэ ойлголтод захиргааны шүүхийн өмнө шаардах эрхээ хэрэгжүүлэх эрхтэй буюу тэдний эсрэг чиглэсэн шаардах эрхээ хэрэгжүүлэхээр

¹⁴⁰ Төрийн мэдээлэл, Nr. 3., 2003.

бусдын зүгээс шаардсаныг хүлээн зөвшөөрөх үүрэг бүхий хувьцаат компаниуд зэрэг хуулийн этгээдийн бусад төрлүүд багтаж байдаг. Албан журмаар бус гагцхүү эрх бүхий этгээдийн зүгээс нэхэмжлэл, гомдол гарснаар хэрэгжиж эхэлдэг захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаа нь захиргааны хууль бус актаас хамгаалахад оршино.

Захиргааны актын тодорхойлтыг хуульд нарийвчилж тусгажээ. Захиргааны акт нь хэлбэрийн буюу материалаг алдаатай бол түүнийг хууль бус гэж үздэг, жишээлбэл: захиргааны акт нь харъяалмын хувьд хуульд заасныг зөрчсөн эсвэл бодит нөхцөл байдлаараа захиргааны өөр байгууллагаас гарсан, иргэдийн эрхийг илт ихээр хязгаарласан бол түүнийг хууль бус гэж үздэг.

Харин зүгээр л хууль бус акттай зэрэгцээд захиргааны эрх зүйд хүчин төгөлдөр бус актын тухай ойлголт байдаг. Алдаатай байдал (хууль бус шинж) нь илэрхий байгаа актыг хүчин төгөлдөр бус гэж тодорхойлдог. Илт алдаа зөрчилтэй ийм акт анхнаасаа үйлчилдэггүй боловч хуульд нийцэх мэт шинжийг нь бүрмөсөн арилгах зорилгоор түүнийг хүчингүй болгуулахаар шаардах боломжтой байдаг. Учир нь гагцхүү алдаатай, хууль бус актууд нь шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргах хугацаа дуусмагц хуулийн бүрэн хүчин чадалтай болдог.

2 дугаар зүйл. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомж,
түүнийг хэрэглэх

- 2.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль¹, Шүүхийн тухай², Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай³, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
- 2.2. Захиргааны хэргийн шүүх маргааныг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль болон Монгол Улсын олон улсын гэрээг баримтална.

I. Ерөнхий зүйл

Энэ зохицуулалт нь Монгол улсын захиргааны шүүхүүдээс дагаж мөрдвөл зохих хуулийн хүрээг тодорхойлж өгчээ. Үүнд: Монгол улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болоод бусад зохицуулалт багтсан байх агаад зөвхөн зарим талаараа хууль тухай бүрийн ач холбогдолд хөтөлгөдөн жагсаажээ. Өөрөөр хэлбэл, нэн тэргүүнд баримтлах хуулиар Үндсэн хуулийг тусгажээ.

Харин түүний дараагаар жагсаалтад тусгагдсан хуулиуд нь ач холбогдлын хувьд ЗХХШТХ-тай ижил, тэдгээрийг гагцхүү ЗХХШТХ-д өөр зохицуулалт хэрэглэхээр заасан, зохицуулалт байхгүй бол хэрэглэхээр байна. “Энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас” гэснээс үзвэл, өөр бусад хууль хэрэглэхэд

¹ Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

² Шүүхийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 29 дүгээрт нийтлэгдсэн.

³ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн

тэдгээр нь ямар нэгэн байдлаар бодит нөхцөл байдлын холбоотой байх шаардлагатай гэж үзэх боломжтой байна.

Үүнээс үзвэл, энэ зохицуулалт нь бусад хуулийг хэрэглэхийг шууд зааж байгаа бөгөөд улмаар ЗХХШТХ-д өөр хууль хэрэглэхээр тусгайлан заасан байх эсвэл энэ хуульд зохих зохицуулалт байхгүй болохыг анхаарах зайлшгүй шаардлага байхгүй гэсэн дүгнэлтийг ч хийх боломжтой байна.

II. Үндсэн зарчмууд

Дээрх зохицуулалтад ач холбогдол бүхий үндсэн хоёр зарчмыг баримтжуулсан байгааг тэмдэглэх шаардлагатай.

Нэг. Үндсэн хуулийн давуу эрх буюу захиргаа болон захиргааны хэргийн шүүх нь Үндсэн хуульд захирагдах ёстойг тусгасан байх бөгөөд дараагаар нь шүүх эрх мэдэл хууль ёсны байх ёстойг заажээ. Захиргааны хэргийн шүүгч нь шийдвэрээ гагцхүү хуульд нийцүүлэн, өөрөөр хэлбэл шүүхийн шийдвэр, бусад шийдвэрийг гаргахдаа парламентаас батлан гаргасан хуулийн шинжгүй албаны дотоод журам, бусдын заавар зэрэгт үндэслэж болохгүй.

Хоёр. Олон улсын гэрээг тусгасан нь гагцхүү парламентаас акт (нэгдэн орох) гарган баталснаар улс хоорондын шинжтэй хууль эрх зүйн харилцаа үүссэн бол хамаарна.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- 3.1.1. "захиргааны байгууллага" гэж нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага, түүнчлэн Засгийн газрын байгууллагын зарим үүргийг төлөөлөн гүйцэтгэдэг Засгийн газрын бус байгууллага, хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр бусдыг захирамжилсан шийдвэр гаргаж, нийтлэг үйлчилгээ үзүүлдэг сургууль, эмнэлэг, холбоо, харилцаа, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны болон шашны байгууллага зэрэг нийтийн эрх зүйн субъект болох байгууллагыг;
- 3.1.2. "захиргааны албан тушаалтан" гэж энэ хуулийн 3.1.1-д заасан байгууллагын нийтийн эрх зүйн хүрээнд захирамжлах, зохион байгуулах бүрэн эрхийг бие даан хэрэгжүүлдэг төрийн жинхэнэ албан хаагч, түүнчлэн нийтийн эрх зүйн холбогдолтой асуудлаар бусдыг захирамжилсан шийдвэр гаргадаг төрийн бус албан тушаалтныг;
- 3.1.3. "иргэн" гэж Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харъяалалгүй хүнийг;
- 3.1.4. "захиргааны акт" гэж нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар захиргааны байгууллага, албан тушаалтнаас амаар буюу бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон эрх зүйн үр дагавар шууд бий болгодог нэг удаагийн захирамжилсан бусад арга

- хэмжээ (үйлдэл, эс үйлдэхүй)-г; энэ хуулиар захиргааны байгууллагын хэм хэмжээ тогтоосон шийдвэр (зарлиг, тогтоол, дүрэм, заавар, журам)-ийг захиргааны актад хамааруулна;
- 3.1.5. "үйл ажиллагаа" гэж үйлдэл, эс үйлдэхүйг;
- 3.1.6. "эс үйлдэхүй" гэж иргэн, хуулийн этгээдээс эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хэрэгжүүлэх, хамгаалуулахаар гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх үүргээ захиргааны байгууллага, албан тушаалтнаас хуульд заасан хугацаанд биелүүлээгүй буюу шийдвэрлэхгүй орхигдуулсныг;
- 3.1.7. "нэхэмжлэл" гэж иргэн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус актын улмаас зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны хэргийн шүүхэд хандаж гаргасан өргөдлийг;
- 3.1.8. "гомдол" гэж захиргааны хууль бус актын талаар тухайн байгууллагын удирдах дээд шатны нь байгууллага, албан тушаалтанд болон шүүхэд хандаж гаргасан нэхэмжлэлээс бусад өргөдлийг;
- 3.1.9. "шүүхийн шийдвэр" гэж анхан шатны шүүхээс захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд гаргасан баримт бичгийг;
- 3.1.10. "шүүхийн тогтоол" гэж захиргааны хэрэг хянан шийдвэрлэх аливаа ажиллагааны талаар шүүх бүрэлдэхүүнээс гаргасан анхан шатны шүүхийн хуралдааныхаас бусад баримт бичиг, мөн Улсын дээд шүүхийн хуралдаанаар хяналтын журмаар захиргааны хэргийг хянан хэлэлцээд гаргасан баримт бичгийг;
- 3.1.11. "шүүхийн магадлал" гэж давж заалдах шатны шүүхээс захиргааны хэргийг хянан хэлэлцээд гаргасан баримт бичгийг;
- 3.1.12. "шүүгчийн захирамж" гэж захиргааны хэрэг хянан шийдвэрлэх аливаа ажиллагааны талаар шүүгчээс дангаараа гаргасан баримт бичгийг;
- 3.1.13. "энгийн магадлал" гэж захиргааны байгууллага, албан тушаалтнаас хууль зөрчсөн үйл ажиллагааны шалтгаан, нөхцлийг арилгуулахаар тэдгээр байгууллага, албан тушаалтанд шаардаж захиргааны хэргийн шүүхээс гаргасан баримт бичгийг.

I. Томъёолол

Захиргааны байгууллага гэдэг нь төв, орон нутгийн нийтийн гүйцэтгэх засаглалын байгууллага буюу өөрөөр хэлбэл төрийн засаглалын эрх мэдлийг нийтийн эрх ашигт нийцүүлэн хэрэгжүүлж буй газар юм. Захиргааны байгууллагын тухай ойлголтыг харин нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс ялгаж авч үзэх шаардлагатай. Түүнээс гадна төрөөс үүрэг хүлээж зарим талаараа нийтийн эрх зүйн үйл ажиллагаа хэрэгжүүлж буй (захиргааны байгууллагаас "зээлдэх" гэж бас нэрлэдэг) засгийн газрын бус байгууллагын захиргааны ажилтнуудыг нэрлэж болох юм.

Харин энэ жагсаалтад эдгээр засгийн газрын бус байгууллагын хажуугаар угаасаа захиргааны байгууллагад хамаарах сургууль гэх зэргийн нийтийн эрх зүйн субъектуудыг нэрлэсэн байх юм. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь зөвхөн төрөөс түүнд шилжүүлсэн бус өөрийн бие даасан нийтийн засаглалын эрх үүргийг хэрэгжүүлдэг тул тэдгээрийг гуравдахь ангилалд хамааруулах нь зүйтэй болов уу.

Харин “шашны байгууллага” гэснийг германы Үндсэн хуулийн ойлголттой нэгэн адилаар буюу төвийг сахисан байдлаар “шашны нэгдэл” гэж ойлгох хэрэгтэй байх. Учир нь “сүм хийд” гэснийг европын хувьд гагцхүү христийн сүмийн холбоо гэж ойлгодог.

II. Захиргааны албан тушаалтны тухай ойлголт

Захиргааны байгууллага, төрийн бус албан тушаалтны дараагаар захиргааны албан тушаалтны тухай ойлголтыг тодорхойлжээ. Энд зааснаар дээрх ойлголтод түшмэдийн эрх зүйн зохицуулалтад хамаарах этгээдүүд бус харин гүйцэтгэж буй ажил үүргийнхээ хувьд нийтийн эрх зүйн ажил үүргийг дээр заасан байгууллагын буюу албан тушаалтны өмнөөс бие даан гүйцэтгэж байгаа этгээдүүд хамаарч байна. Энд ч гэсэн нийтийн эрх зүйн холбогдолтой асуудлаар бусдыг захирамжилсан шийдвэр гаргадаг төрийн бус албан тушаалтныг төрийн жинхэнэ албан тушаалтантай адил эрх хэмжээтэй байхаар зохицуулжээ.

III. Захиргааны актын тухай ойлголт

3.1.4.-т зааснаар захиргааны актын тухай ойлголтыг хуулийг хэрэглэхтэй холбоотойгоор тодорхойлжээ. Энэ тодорхойлолт нь захиргааны актын мөн чанарт холбогдог хоцроод байгаа ерөнхий сургаалд үндэслэжээ.

Энэ сургаалаар захиргааны актыг хувь хүнд чиглэсэн шинжтэй зохицуулалт буюу амьдралын тодорхой нөхцөл байдлыг (тодорхой шинж) аман, бичгэн хэлбэртэй, тодорхой буюу тодорхойлох боломжтой тооны хүмүүст чиглэсэн (индивидуал шинж) тусгайлсан зохицуулалт гэж үздэг.

Харин тодорхойгүй тооны хүмүүст хамаарах зохицуулалтыг германы хуулиар захиргааны акт гэж үздэггүй. Ийм зохицуулалтыг хуулийн доод талын түвшинд дүрэм, захирамжид хамааруулдаг. Харин монголын хуульд зааснаар дээр дурдсан дүрэм, захирамжийг бүхэлд нь захиргааны актад тооцож, захиргааны актын нэгэн адил хэмжээний хяналтад байхаар тусгажээ.

Германы хууль тогтоомжид зааснаар дүрэм, захирамжийн хэм хэмжээний хяналтыг гагцхүү Захиргааны дээд шүүхээс хэрэгжүүлдэг (ГЗШТХ-ийн 47 дугаар зүйл). Учир нь германы шүүх захиргааны акттай хамт гарсан, түүнийг хэрэгжүүлэх журам, эрх зүйн үр дагавар бүхий бусад заалтыг захиргааны актад тооцдог. Энд хуулиуд хамаарахгүй байгаа бололтой хэдий ч дээр дурдсан дүрэм, захирамж хуулийн хүрээнд багтдаг билээ.

Иймээс захиргааны шүүхүүдийн хяналтын эрх мэдлийн хүрээ хэт өргөжиж болох юм. Гэхдээ нөгөө талаар төвлөрсөн шинжтэй, хяналт сул байгаа захиргааг нэгдмэл байдалд оруулах нь зорилтоо хэрэгжүүлэхэд дөхөм байж болох юм.

IV. Нэхэмжлэл ба нэхэмжлэл гаргах эрх

Иргэний эрх зүйн байдлыг бэхжүүлэх үүднээс захиргааны байгууллагаас үүргээ хэрэгжүүлэх ёстой боловч хэрэгжүүлээгүй тохиолдолд түүнийг нь үйлдэх ёстой гэсэнтэй ижил тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл захиргааны үйлдлийг эсэргүүцэж захиргааны шийдвэрийг хүчин төгөлдөр бус болгуулахаар, эс үйлдлийн эсрэг чиглэсэн, үүрэг болгосон нэхэмжлэл зэргийг шүүхээс шийдвэр гаргуулж захиргааны байгууллагыг

албадлагын журмаар захиргааны акт гаргуулж ямар нэгэн үйлдэл хэрэгжүүлэх тохиолдолд нэрлэсэн байна.

Энэ зохицуулалт нь нэг талаас иргэний эрх, нөгөө талаас иргэний хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг ялгаж үзсэн байна. Эдгээр шаардах эрхүүдийн (иргэний эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол) хоорондын ялгааг тодорхойлох нь захиргааны материаллаг эрхийн асуудал агаад тодохойлолт нь Монгол улсын Үндсэн хуульд заасан үндсэн эрхүүдийг нарийн харгалзсан байх шаардлагатай. Хуулиар хамгаалагдсан болоод хууль ёсны ашиг сонирхлын хооронд ялгаа байхгүй болов уу.

Нэхэмжлэл гэдэг нь зөвхөн захиргааны хууль зөрчсөн актын (хүчингүй болгох боломжтой эсвэл хүчин төгөлдөр бус) улмаас эрх нь буюу хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн шалтгаанаар захиргааны шүүхэд хандаж буй иргэний үйлдэл мөн. Харин дээрх зорилгыг хэрэгжүүлэх зорилго агуулаагүй бусад бүх өргөдлийг гомдол гэнэ.

V. Шүүхийн шийдвэр: Шийдвэр ба магадлал

Шүүхээс гаргаж буй шийдвэрийн хувьд хуульд зааснаар анхан шатны шүүхээс гаргасан шийдвэр, түүнчлэн анхан шат, дээд шатны шүүхүүдийн алинд нь ч үл хамаарах шүүхэд хамаарахгүй шийдвэр гэж хувааж авч үзсэн байна.

Харин шүүхийн тогтоол гэдэгт захиргааны хэрэг хянан шийдвэрлэх аливаа ажиллагааны талаар шүүх бүрэлдэхүүнээс гаргасан баримт бичиг, мөн Улсын Дээд шүүхийн хуралдаанаар хяналтын журмаар захиргааны хэргийг хянан хэлэлцээд гаргасан баримт бичгийг хамааруулсан байна. Ямар шалтгаанаар ингэж ялгаатай авч үзсэн болох нь энд тодорхой бус байна.

Дараагийн заалтаас үзвэл “шүүхийн магадлал” гэдэгт дээд шатны шүүхээс давж заалдах шатны журмаар захиргааны хэргийг хянан хэлэлцээд гаргасан баримт бичиг хамаарах ажээ(3.1.11).

“Энгийн магадлал” гэснийг үүрэг хүлээлгэсэн нэхэмжлэлийн зэрэгцээ өргөн утгаар нь тодорхойлох нэхэмжлэл гаргасан тохиолдолд үйлдлүүдийг нь хууль бус гэж тогтоогоогүй ч захиргааны байгууллагад тодорхой үйлдэл хэрэгжүүлэх үүрэг хүлээлгэх, эсхүл захиргааны үйл ажиллагааны журам тогтоохтой холбогдож гаргадаг шүүхийн шийдвэрийг хамааруулж хуульчилжээ.

Хуульд шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсны эцэст түүний шийдвэрийг агуулсан баримт бичиг гаргана гэдэг нь амаар явуулсан шүүх хуралдааныг тасалдуулж, эсхүл хойшлуулж болохгүй гэсэн үг биш юм. Тиймээс эцсийн шийдвэрийг тухайн хэрэг маргаантай холбоотой шүүх хуралдааныг дахин шинээр явуулсны эцэст гаргах шаардлагатай болж байна (20.1.4, 31.7 дугаар хэсгүүдтэй харьцуулах).

4 дүгээр зүйл. Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаан

4.1. Захиргааны хэргийн шүүх энэ хуулийн 3.1.1., 3.1.2.-т заасны дагуу дараах байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны хууль бус актад холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ:

4.1.1. Монгол Улсын Засгийн газар;

4.1.2. Монгол Улсын Засгийн газрын гишүүн (Ерөнхий сайд, сайд);

- 4.1.3. Монгол Улсын яам;
- 4.1.4. Монгол Улсын Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг;
- 4.1.5. Төрийн албаны Зөвлөл, түүний салбар байгууллага;
- 4.1.6. Сонгуулийн Ерөнхий хороо;
- 4.1.7. Монгол банк;
- 4.1.8. Үнэт цаасны хороо;
- 4.1.9. яамны харъяа болон харъяа бус захиргааны акт гаргадаг бие даасан агентлаг, түүнтэй адилтгах газар, зөвлөл, товчоо, төв, сан зэрэг байгууллага;
- 4.1.10. аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга;
- 4.1.11. аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг (хэлтэс, газар);
- 4.1.12. улсын хяналт шалгалтын болон захиргааны хяналтын байгууллага, тэдгээрийн хянан шалгагч, байцаагч, цагдаагийн, тагнуулын, хилийн цэргийн байгууллага, түүний захиргааны таслан зогсоох болон шийтгэлийн арга хэмжээ авах эрх бүхий бүх албан тушаалтан;
- 4.1.13. аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн нийтийн Хурал, тэдгээрийн Тэргүүлэгчид;
- 4.1.14. төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг болон холбоо, харилцаа, эрчим хүчний системийн захиргаа зэрэг үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг байгууллага;
- 4.1.15. сүм хийдийн захиргаа;
- 4.1.16. шийдвэр, үйл ажиллагааг нь захиргааны хэргийн шүүхэд давж гомдол гаргаж байхаар хуульд тусгайлан заасан нийтийн эрх зүйн субъект болох бусад байгууллага, албан тушаалтан.

Энэ хуулийн 4.1-д заасан байгууллагын зөвхөн гадагш (бусдаас) дагаж мөрдөх буюу заавал биелүүлэх захиргааны акт нь захиргааны хэргийн шүүхэд хамаарна.

Шүүх, прокурорын байгууллага, түүнчлэн эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын байцаан шийтгэх, эсхүл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай⁴ хуулийн дагуу явуулсан үйл ажиллагааны талаар иргэн, хуулийн этгээдээс шүүхэд гаргасан гомдлыг эрүүгийн болон иргэний хэргийн шүүх хянан шийдвэрлэнэ.

I. Ерөнхий зүйл

4 дүгээр зүйлд нийтийн эрх зүйн маргаан нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гаргахаар захиргааны шүүхэд харъяалагдах бүх байгууллагыг жагсаажээ. Ингэснээр ЗХХШТХ нь захиргааны шүүхийн енумерацийн (нэрлэж тоолох) зарчмыг баримталж буй нь тодорхой байна. Энэ зарчмын дагуу иргэн, нийтийн эрх зүйн байгууллагын хооронд, нийтийн эрх зүйн байгууллага хоорондын зөвхөн тодорхой, хуульд заасан маргааныг шүүхээр шийдвэрлүүлэх боломжтой байхыг хэлнэ.

⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль “Төрийн мэдээдлэл” эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн

Гагцхүү хуулиар захиргааны шүүхийн харъяаллыг тодорхойлсон үед тухайн хэрэг маргааныг шийдвэрлэх эрх олгогдоно. Төрийн зарим акт “шүүхээс гадуур байх” ёстой гэж үздэг байсан тул энэ зарчим өмнө үед германы хувьд үйлчилдэг байсан юм. Харин 1960 оны германы захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 1-д ерөнхий нөхцлийг хүлээн зөвшөөрөхөөр шийдэж захиргааны шүүхийн орчин үеийн тогтолцооны үндэс болгожээ. Үүний дагуу үндсэн хуулийн эрх зүйн шинжтэй маргаанаас бусад нийтийн эрх зүйн бүх хэрэг маргаан захиргааны шүүхийн харъяалалд багтаж, иргэн, нийтийн эрхийн байгууллагын хооронд гарсан хэрэг маргааныг нэг бүрчлэн тоочин жагсаах шаардлагагүй болсон юм.

Харин германы хуульд зааснаар үндсэн хуулийн маргаан энд хамаарахгүй бөгөөд үүнийг холбооны түвшинд Холбооны үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу Холбооны үндсэн хуулийн шүүхэд харъяалагдахаар хуульчилж тогтоосон байдаг.

(Харин үндсэн хуулийн маргаанд Холбооны үндсэн хуулийн шүүхийн харъяаллын хувьд енумерацийн зарчим үйлчилдэг. Үүний шалтгаан нь Холбооны үндсэн хуулийн шүүхэд хууль тогтоогчоос зөвхөн онцгойлон харъяалуулсан хэргийг шийдэхээр заалт орсон байдаг оршино.)

II. Ерөнхий нөхцөл эсвэл енумерацийн зарчим

ЗХХШТХ-ийн 3 дугаар зүйлд өргөн хэмжээний жагсаалтыг оруулсныг үзэхэд Монголын хууль нь ерөнхий нөхцлийг хүлээн зөвшөөрч, гагцхүү Ерөнхийлөгчийг үүнд хамааруулахгүй байх зорилготой гэж үзэж болохоор байна. Яагаад гэвэл улсын Ерөнхийлөгчид захирагдах бараг бүхий л захиргааны байгууллагуудыг дурдсан байна.

Нөгөө талаас төрийн захиргаатай холбоотой үндсэн хуулийн бус маргааныг бүгдийг бус, зөвхөн тодорхой нэр бүхий захиргааны байгууллагыг жагсаалтад оруулсанаас үзэхэд енумерацийн зарчмыг баримталж байна гэж үзэж болохоор.

Гуравдугаар тайлбар болох, хэдийгээр ЗХХШТХ-ийн 4 дүгээр зүйлээс үзэхэд енумерацийн зарчмыг баримталж буй ч, өргөн хүрээг хамарсан жагсаалтыг тусгаснаар уг зарчмыг аль болох эрчимтэй байдлаар хэрэгжүүлэх эрмэлзэл харагдаж байна гэснийг арай илүүд үзүүштэй юм. Мөн түүнчлэн орон нутгийн байгууллагууд, захиргааны байгууллагуудыг нэг бүрчлэн зааж, тэдгээртэй холбоотой хэрэг маргааныг захиргааны шүүхэд харъяалуулсан байх юм. Жишээлбэл, 4.1.10-т зааснаар аймаг, нийслэлийн ... засаг дарга нарыг заасан байна.

Түүнээс гадна аймаг, нийслэлийн засаг даргын дэргэдэх тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагуудыг ч дурджээ. Улсын хяналт шалгалтын болон захиргааны хяналтын байгууллага, тэдгээрийн хянан шалгагч, байцаагч, цагдаагийн, тагнуулын, хилийн цэргийн байгууллагаас гадна аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн нийтийн Хурал, тэдгээрийн Тэргүүлэгчдийг заасан байх авч эдгээрийг орон нутгийн гүйцэтгэх засаглалын байгууллагуудын ард шууд жагсаагаагүй нь хачирхалтай. 4.1.15-д заасан “сүм хийд” гэснийг итгэлтэйгээр шашны нэгдэл гэж ойлгох нь зүйтэй болов уу.

4.1.16-д шийдвэр, үйл ажиллагааг нь захиргааны хэргийн шүүхэд давж гомдол гаргаж байхаар хуульд тусгайлан заасан нийтийн эрх зүйн субъект болох бусад байгууллага, албан тушаалтанг заасан нь харин нилээд ач холбогдолтой байна. Учир

нь энд зааснаас бусад захиргааны үйл ажиллагаа хэрэгжүүлж буй албан тушаалтны актыг шүүхэд бусад хуульд тусгайлан заасан бол эсэргүүцэх боломжийг хангаж байна. 2005 оны 3 дугаар сарын 31-нд Монгол улсын Үндсэн хуулийн цэцээс гаргасан дүгнэлт, түүний дараа батлагдсан хуулиар энэ хуулийн 4.1.1, 4.1.6-д заасан Засгийн газар, Сонгуулийн ерөнхий хороо зэргийг хүчингүй болгосон билээ. Энэ нь үндсэн хуулийн маргаанд хамаарна.

III. Хуулийн байгууллагын шийдвэр

Энэ хуулийн 4.2-т заасан шийдвэрүүд нь захиргааны шүүхийн харъяалалд багтахгүй зургаан янзын байгууллагыг заасан байна. Эдгээр нь голдуу шүүх, прокурор, хэрэг бүртгэх зэрэг байгууллагууд байна.

Харин аливаа хяналтыг хийдэлгүй хэрэгжүүлэх боломжийг хангах зорилгоор албан ёсоор нэрлэсэн эдгээр зургаан байгууллагаас гаргасан шийдвэрийг ердийн шүүхэд иргэдийн нэхэмжлэлд үндэслэж хянахаар заажээ.

IV. Монгол Улсын Захиргааны шүүхийн акт

Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн шийдвэрээр улс төрийн функц бүхий байгууллагаас, түүнчлэн сонгуулийн ерөнхий хорооноос (4.1.6) гаргасан шийдвэрт зөвхөн Үндсэн Хуулийн Цэц л халдах эрхтэй. (2005 оны 03 дугаар сарын 31- ны өдрийн Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн магадлал Nr. 2/02).

5 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн акт, түүнийг заавал биелүүлэх

- 5.1. Захиргааны хэргийн шүүхийн акт нь шийдвэр, тогтоол, магадлал, энгийн магадлал, шүүгчийн захирамж гэсэн хэлбэртэй байна.
- 5.2. Захиргааны хэргийн шүүхийн хүчин төгөлдөр актыг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа холбогдох бүх байгууллага, албан тушаалтан, иргэн заавал биелүүлнэ.
- 5.3. Захиргааны хэргийн шүүхийн актыг биелүүлээгүй этгээдэд энэ хууль, Эрүүгийн хууль⁵ болон хууль тогтоомжийн бусад актад заасан хариуцлага хүлээлгэнэ.

I. Ерөнхий зүйл

Эхний хэсэгт шүүхийн шийдвэрийн хэлбэрийг тодорхойлжээ. Шийдвэрийг энэ зүйлд заасан таван өөр гадаад хэлбэрээр гаргах боломжтой ажээ. 5.2-т захиргааны хэргийн шүүхийн хүчин төгөлдөр актыг Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа холбогдох бүх байгууллага, албан тушаалтан, иргэн заавал биелүүлэхээр заажээ.

Германы хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль тогтоомжид заавал биелүүлэх шинжтэй үүрэг болгосон заалт байдаггүй. Учир нь энд гагцхүү хариуцагчдад (төр, нийтийн эрх зүйн бусад этгээд, баг хороод г.м.) шийдвэрийг заавал биелүүлэх үүрэг оногдуулдаг. Төр ч гэсэн тодорхой тохиолдолд заавал биелүүлэх үүрэг хүлээдэг ч энэ нь зөвхөн нэхэмжлэгчийн хувьд үйлчилдэг. Ингэж өргөн хүрээтэй зохицуулсан нь Монголын ЗХХШТХ-ийн үйлчлэлийн хүрээнд дүрэм буюу эрх зүйн хэм хэмжээ

⁵ Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн

захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зүйл болох боломжтой байдагтай холбоотой байж болох юм. Эдгээрийг хүчингүй болгох, эсхүл түүнийг эсэргүүцэж гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь ерөнхийдөө бүх этгээдэд заавал биелүүлэх үр дагавар үүсгэх нь гарцаагүй.

Ер нь тодорхой бус тооны хүмүүсийн эсрэг чиглэсэн зохицуулалт зэрэгцээд тодорхой бус бус тооны хэрэг маргааныг шийдвэрлэхэд үйлчилдэг нь хэм хэмжээний мөн чанар билээ.

II. Хуулийн хүчин төгөлдөр байдал

Шүүхийн шийдвэр нь түүнийг ямар нэгэн аргаар буюу давж заалдах, хяналтын шатанд эсэргүүцэх боломжгүй болсноор хуулийн хүчин төгөлдөр болдог. Шийдвэрийг эсэргүүцэх боломжит хугацаа тоологдож дуусахад хууль хүчин төгөлдөр болдог. Харин Монгол улсын үндсэн хуулийн шүүхэд хандах боломж үүссэн тохиолдолд захиргааны шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болдоггүй байна. 5.3-т шүүхийн шийдвэрийг дагаж биелүүлээгүй бол Монголын Эрүүгийн болоод бусад хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхийг заасан байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа,
шүүхэд нэхэмжлэл гаргах эрх

Гомдлын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

6 дугаар зүйл. Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд
гомдол гаргах

- 6.1. Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээд захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны хууль бус акт нь түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хүлээн авснаас, эсхүл мэдсэнээс хойш 30 хоногийн дотор тухайн байгууллага, албан тушаалтныг шууд харъяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдлоо гаргана.
- 6.2. Гомдол нь иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай 6 хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 6.3. Энэ хуулийн 6.1.-д заасан хөөн хэлэлцэх хугацаа зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтэрсэн нь тогтоогдвол захиргааны байгууллага, албан тушаалтан уг хугацааг хэтэрснээс хойшхи гурван сарын дотор нөхөн сэргээж болно. Хугацаа сэргээхтэй холбогдсон гомдлыг шүүхэд гаргана.

⁶ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн

6.4. Энэ хуулийн 6.1.-д заасан байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хүлээн авч хуульд өөрөөр заагаагүй бол 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж хариу өгнө. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор сунгаж болно. Хугацаа сунгасан тухай гомдол гаргасан иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэнэ.

I. Ерөнхий зүйл

6 дугаар зүйлд иргэн нь захиргааны акт гарсны улмаас түүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл дээд шатных нь захиргааны байгууллагад хандах боломжийг заажээ. Тиймээс гомдол гаргах ажиллагаа нь хоёр давхар зорилготой болох нь харагдаж байна.

Энэ нь нэг талаас иргэнд эрхээ хамгаалах илүү боломж олгож, нөгөө талаас захиргааны дээд шатны байгууллагад шийдвэрээ засварлах боломж олгосноор захиргааны шүүхүүдийг хэт ачаалмаас хамгаалж байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд иргэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийг баримтлах тухай заасан нь иргэний хувьд бэрхшээлтэй санагдаж байна. Энэ хугацаа нь амаар гаргасан шийдвэрт нэгэн адил хамаарах тул тухайн шийдвэр чиглэж буй этгээдийн хувьд нэг сарын хугацааг заасан нь оновчтой биш байна. Харин хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаа хэтэрсэн болох нь тогтоогдвол захиргааны байгууллага уг хугацааг гурван сарын дотор сунгаж болохыг заажээ.

Хугацаа хэтэрсэн гомдлыг (хугацааг нөхөн сэргээхийг эсэргүүцсэн гомдол болов уу) захиргааны хэргийн шүүхэд гаргах эрхийг иргэнд олгосон байна. Гомдлын талаарх шийдвэрийг түүнийг гаргаснаас хойш 30 хоногт багтаан гаргах бөгөөд энэ хугацааг сунгах боломжийг хангасан байна.

Гомдлын талаар шийдвэр гаргах хугацаа ийм богино байгаа нь газар нутгийн холоос шалтгаалж нотлох баримт, нотолгоог хангах, эсхүл хэргийн нөхцөл байдалтай бүрэн хэмжээнд танилцахад хангалтгүй байж, улмаар иргэн, захиргааны байгууллагыг хэт их ачаалалд учруулах магадлалтай юм.

II. Гомдлын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Гомдлын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн үед хэрэгжүүлдэг. Хууль ёсны ашиг сонирхол гэдэгт захиргааны шийдвэр гаргах үед эрх хэмжээний алдаа гаргахгүй байхыг шаардах эрхийг хамааруулан ойлгоно.

Өөрөөр хэлбэл энэ нь захиргааны байгууллага хуульд заасны дагуу эрх хэмжээнийхээ хүрээнд зөвшөөрсөн болоод заавал биелүүлэх шинжтэй заалт гаргахдаа дээд шатны байгууллага нь доод шатныхаа байгууллагын үйлдэл эрх хэмжээний хувьд буруугаар ашигласан, эсхүл хэтрүүлэн хэрэглэсэн эсэхэд хяналт тавина.

Эрх хэмжээг буруугаар хэрэглэх гэдэг нь хуульд заагаагүй зорилгыг хэрэгжүүлэхээр эрмэлзэх явдал юм. Жишээлбэл, зөвшөөрөл олгохгүй байх шалтгаан нь захиргааны байгууллага өргөдөл гаргагчтай маргаантай байгаа, хувийн өс хонзонтой, эсхүл тааламжит бус шашны бүлэглэлд хамаардагтай холбоотой гэх мэт. Эрх хэмжээ хэтрүүлнэ гэдэг нь захиргааны байгууллага хэд хэдэн шийдлээс нэгийг нь сонгох боломжтой гэж ташаа ойлгосныг хэлнэ, жишээлбэл, малын өвчин гарах үед нэг бол малыг вакцинжуулах, эсхүл бүгдийг нь хаших шийдвэр гаргах боломжтой байдал хамаарна. Бодит байдал дээр харин ганцхан арга хэмжээ боломжтой. Энэ нь вакцинжуулах арга хэмжээ юм.

Харин монголын хуульд гомдлыг анхны захиргааны байгууллагад гаргах тухай заагаагүй байгаагаараа германы хуулиас ялгаатай байна. Өөрөөр хэлбэл захиргааны анхны байгууллагад өөрийн алдааг засах боломжийг тусгаагүй байна. Гэвч хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэрлэх нийт хугацааг “хэт сунжруулахгүй” гэсэн үндэслэл бүхий шалтгаан байгаа гэдэгт итгэлтэй байна.

7 дугаар зүйл. Хэргийг урьдчилан шийдвэрлэх журам

- 7.1. Захиргааны байгууллага, албан тушаалтан гомдлыг урьдчилан шийдвэрлэх талаар дараахь ажиллагаа явуулна:
 - 7.1.1. захиргааны акт хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгах;
 - 7.1.2. гомдол гаргагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч, шаардлагатай бол эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн гуравдагч этгээдэд хэрэг шийдвэрлэх он, сар, өдөр, газрыг мэдэгдэж, уг ажиллагаанд хүсэлтээр нь байлцуулах.
- 7.2. Энэ хуулийн 7.1.2.-т заасан этгээд хүрэлцэн ирээгүй бол тэдгээрийн оролцоогүйгээр хэргийг урьдчилан шийдвэрлэж болно.
- 7.3. Шаардлагатай гэж үзвэл шинжээч томилон дүгнэлт гаргуулна.
- 7.4. Урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцын талаар тэмдэглэл хөтөлнө. Уг тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:
 - 7.4.1. шийдвэр гаргаж байгаа байгууллагын нэр, хаяг, албан тушаалтны овог, эцгийн болон өөрийн нэр;
 - 7.4.2. шийдвэр гаргасан, хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулсан он, сар, өдөр, газар;
 - 7.4.3. гомдол гаргагч, хариуцагч, бусад оролцогчын овог, эцгийн болон өөрийн нэр;
 - 7.4.4. гомдлын агуулга, шаардлага;
 - 7.4.5. шинжээчийн дүгнэлт, гэрчийн мэдүүлэг бусад нотлох баримт;
 - 7.4.6. тэмдэглэл хөтөлсөн болон гомдлыг шийдвэрлэсэн албан тушаалтан, захиргааны байгууллагын эрх баригчийн гарын үсэг.
- 7.5. Хамтын удирдлага бүхий захиргааны байгууллага гомдлыг хэлэлцсэн бол асуудал шийдвэрлэх ердийн олонхийн журмыг баримтлан шийдвэр гаргана.

7.6. Гомдлыг хүлээж авсан байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 45, 46 дугаар зүйлд заасан журмын дагуу маргаантай захиргааны актын биелэлтийг гомдол бүхий хэргийг хянан шийдвэрлэх хүртэл түдгэлзүүлж болно.

I. Ерөнхий зүйл

7.1 дүгээр зүйлд гомдлыг захиргааны байгууллагын захиргааны актын хууль ёсны байдлыг хянах үүргийг маш товчоор харъяалуулжээ. Гэхдээ үүнээс энэ шатанд гагцхүү материаллаг эрхийн зөрчлийг хянана гэж ойлгож болохгүй. Түүнээс гадна энэхүү хяналт нь эрх хэмжээний зөрчилгүй шийдвэр гаргуулах эрхийг хамаарна (эрх хэмжээгээ хэтрүүлээгүй, буруугаар ашиглаагүй байх).

Гэхдээ дээрх томъёомоос үзэхэд эсэргүүцсэн шийдвэр зорилгодоо нийцэх эсэхэд цэвэр хяналт тавих боломжгүй байгаа нь тодорхой. Өөрөөр хэлбэл захиргааны шүүхэд хандахаас хянан шийдвэрлэх урьдчилсан шатанд тухайн шийдвэр нь оновчтой бөгөөд төрийн зорилгод нийцэж байсан эсэхийг захиргааны дээд шатны байгууллагаас шалгах боломжгүй байна.

Энэ утгаараа шүүхээс өмнөх шатны хянан шийдвэрлэх ажиллагаа нь шийдвэр зорилгодоо нийцсэн эсэхийг хянадаг захиргааны байгууллагын хянан шийдвэрлэх ердийн дотоод ажиллагаанаас ялгаатай байна. Захиргааны дээд шатны байгууллага асуудлыг шийдвэрлэж чадаагүй бол шүүхээс өмнөх шатны ажиллагааг явуулж, шүүхийн хяналтыг хэрэгжүүлэх зорилготой тул ингэж хязгаарласан нь хянан шийдвэрлэх ажиллагааг түргэсгэх нөлөөтэй.

II. Хянан шийдвэрлэх ажиллагааны алхмууд

Хянан шийдвэрлэх ажиллагааны эхний алхам нь гомдол гаргагч, өмгөөлөгч, зарим тохиолдолд гуравдагч этгээдэд мэдээлэл олгох үүрэг хамаарна. Мэдээлэлд шийдвэр гаргах газар, цагаас гадна хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох тухай зохих өргөдөл, хүсэлтийг гаргасан бол ийнхүү оролцох боломжийн талаарх мэдээлэл агуулагдана. Үүнээс үзэхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхийг хангасан байна.

Хянан шийдвэрлэх хоёр дахь шат нь протокол хөтлөх үүрэг юм. Энд зохицуулсан арга хэмжээнүүд нь үндсэндээ захиргааны хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах бөгөөд захиргааны байгууллагаас дундын шийдвэр гаргаж байгаа бол олонхийн саналаар шийдэх талаар тусгажээ.

Гомдол гаргах нь эсэргүүцсэн тухайн захиргааны шийдвэрийн (захиргааны актын) гүйцэтгэлийг түдгэлзүүлэх шууд үр дагавар үүсгэдэггүй. Харин хуулийн 45, 46 дугаар зүйлд зааснаар гомдол гаргасан захиргааны актыг гүйцэтгэхийг хойшлуулж болох тухай заажээ. Германы хуульд зааснаар гомдлын журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэх нь зарчмын хувьд түдгэлзүүлэх үйлчлэлтэй байдаг бөгөөд харин

Германы ЗХХШТХ-ийн 80 дугаар зүйлд зааснаар захиргааны байгууллага нь гомдол гаргасан захиргааны актыг гүйцэтгүүлэхээр захирамжлах эрхтэй байдаг. Германы хуулийн зохицуулалт нь хэдийгээр иргэдийн хувьд эрх зүйн баталгаат орчинг илүүтэй хангасан байж болох авч, Монголын хуулийн 45, 46 зүйлүүдийн шийдвэр

гаргахыг хойшлуулах тухай зохицуулалтыг хариуцлагатайгаар хэрэглэсэн тохиолдолд шийдвэр гаргах явцыг түргэсэх нь гарцаагүй.

8 дугаар зүйл. Захиргааны байгууллага, албан тушаалтан гомдлыг хянан үзээд гаргах шийдвэр

- 8.1. Энэ хуулийн 6.1.-д заасан захиргааны байгууллага, албан тушаалтан гомдлын дагуу хэргийг хянан үзээд дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:
- 8.1.1. захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх;
 - 8.1.2. маргаан бүхий захиргааны акт нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг захиргааны актыг бүхэлд нь, эсвэл холбогдох хэсгийг хүчингүй болгох;
 - 8.1.3. захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус эс үйлдэхүй нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол захиргааны зохих акт гаргахыг тухайн захиргааны байгууллага, албан тушаалтанд даалгах.
- 8.2. Энэ хуулийн 8.1.-д заасан захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэрийг холбогдох захиргааны байгууллага, албан тушаалтан заавал биелүүлнэ.

I. Ерөнхий зүйл

Хуулийн 8 дугаар зүйлд захиргааны байгууллагаас гомдлыг хянаад гаргах шийдвэрийн агуулгыг тодорхойлжээ. Олон төрлийн шийдвэрийн агуулгын жагсаалтаас үзэхэд хуульд гомдлын шийдвэр нь тодорхойлох, хойшлуулах аль ч тохиолдолд гагцхүү захиргааны акт хэвээр байхаар заасан байна. Харин гомдлын журмаар хуульчилсан акт (дүрэм, захирамж буюу хуулийн хэм хэмжээ тогтоосон бусад хуультай адилгаж болох акт) өөрчлөхөөр байгаа бол энэ журам үйлчилдэггүй байна.

Учир нь захирамж гаргах, түүнийг хүчингүй болгох нь хэдийгээр хууль тогтоосон негатив акт нь тодорхойгүй тооны хүмүүст чиглэсэн тодорхойгүй олон тооны тохиолдолд үйлчлэх хууль тогтоосон акт хэвээр байдаг.

II. Гомдлын журмаар гаргасан шийдвэрийн агуулга

8.1 дугаар зүйлээс үзэхэд захиргааны актын илт хууль бус байдлыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр захиргааны акт нь илт алдаатайн улмаас хүчин төгөлдөр бус болохыг онцгойлон зохицуулжээ. 8.1.2-т маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгох, өөрчлөх тухай гомдол гарсан бол хүчингүй болгох тухай заажээ.

Харин 8.1.3-т захиргааны актыг анх гаргасан буюу гаргаагүй байгууллагад зохих актыг гаргахыг үүрэг болгох тухай заасан байна. Германы хуульд үүрэг болгох гомдол, өргөдөл гаргах тухай зохицуулалт үйлчилдэг.

9 дүгээр зүйл. Захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргах

- 9.1. Захиргааны байгууллага, албан тушаалтан дараахь тохиолдолд захиргааны актыг илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргана:
- 9.1.1. захиргааны акт утга агуулгын илэрхий алдаатай;
 - 9.1.2. бичгийн хэлбэрээр гаргасан захиргааны актыг батлан гаргасан байгууллага, албан тушаалтан нь тодорхойгүй;
 - 9.1.3. захиргааны акт гаргах эрх хэмжээгүй захиргааны байгууллага, албан тушаалтан гаргасан;
 - 9.1.4. захиргааны актыг гүйцэтгэх субъект тодорхой бус;
 - 9.1.5. хууль бус үйлдэл, эс үйлдэхүйг гүйцэтгэхийг шаардсан;
 - 9.1.6. нийтийн ёс зүйн хэм хэмжээг илт зөрчсөн;
 - 9.1.7. захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй;
 - 9.1.8. захиргааны акт гаргах хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн;
 - 9.1.9. захиргааны акт өөр бусад байдлаар холбогдох хууль зөрчсөн.
- 9.2. Захиргааны актын аль нэг заалт илт хууль бус бөгөөд тухайн заалтгүйгээр захиргааны актын агуулга ойлгомжгүй болоход хүрвэл захиргааны актыг бүхэлд нь илт хууль бус гэж тооцно.

I. Ерөнхий зүйл

Энэхүү зохицуулалт нь илтэд хууль бус захиргааны актыг тусгайлан зохицуулсан байна. 9.1.1, 9.1.2-т зохицуулсан тохиолдол нь германы хуулийн зохицуулалттай нэгэн адилаар захиргааны актын алдаа нь илт, онц хүнд хэлбэртэй байх буюу хүчин төгөлдөр бус байдлын сонгодог тохиолдлууд юм. Харин 9.1.3-т зохицуулсан тохиолдол нь зарчмын хувьд захиргааны актыг илт хүчин төгөлдөр гэж үзэхэд бэрхшээлтэй байдаг. Учир нь захиргааны тухайн актад гарын үсгээ зурсан албан тушаалтан харъяалмын дагуу үйл ажиллагаа хэрэгжүүлсэн эсэхийг тогтооход хүндрэл учирдаг. 9.1.4, 9.1.5 дахь хэсгийн хувьд ч нэгэн адил. Учир нь, захиргааны актын гүйцэтгэх ажиллагаа тодорхойгүй байх, хуульд заасан журам зөрчсөн зэрэг нь илт байдаггүй.

Германы хуульд эдгээр тохиолдолд алдаа илт байхад голлон үндэслэдэг. Өөрөөр хэлбэл алдааг “гараар баригддаг байх” шаардлага тавина. Зарим тохиолдолд алдаа нь илэрхий бөгөөд ноцтой байх, “духан дээр нь бичээстэй” байх ёстой тухай бичдэг.

Харин 9.1.6-д алдаа илэрхий байх хүчин зүйлийг онцгойлон заасан хэдий ч нийтийн ёс зүйн хэм хэмжээ, нөгөө талаас нийтийн биш хэм хэмжээ зэргийг хооронд нь ялгаж тодорхойлох нь бэрхшээлтэй байдаг. Захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй (9.1.7), захиргааны акт гаргах хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн (9.1.8) зэрэг нь хуулийн ердийн зөрчил буюу захиргааны байгууллага хууль ёсны байх зарчмыг зөрчсөн тохиолдлууд мөн.

Эдгээр зөрчил нь илт, илэрхий биш бол үр дагавар нь гагцхүү захиргааны шийдвэрийг тодорхой заасан хугацаанд хүчингүй болгуулахаар шаардах эрхийг нээхээс бус шууд хүчин төгөлдөр болох үр дагавар гарахгүй. Энэ санаанууд нь зарим хэм хэмжээнүүдийн “илэрхий” байх хүчин зүйл нь үндсэн ач холбогдолтой бөгөөд үүний улмаас түүнийг зарим нэг тохиолдолд орхигдуулж болохгүй гэсэнд үндэслэж байгаа юм.

Энэ хуулийн 9 дүгээр зүйл дэх бусад хуулийн заалтыг зөрчсөн тохиолдолд актыг хүчин төгөлдөр бус байх үр дагаврыг тусгасан тохиолдлуудад хамаарна.

Хэдийгээр зохицуулалтуудад “илт алдаатай” гэсэн тодорхойлолт шууд гарахгүй байгаа боловч алдаатай байгаа нь илт бол захиргааны хэргийн шүүхүүд нь хэрэгжүүлж буй шүүх засаглалын ажиллагааныхаа явцад хуулийн энэ зүйлийн 10 тохиолдлыг тайлбарын системчилсэн болоод тетеологийн аргуудыг ашиглан тухайн актыг хүчин төгөлдөр бус гэж тооцох нөхцөл байдлыг хэрэглэх боломжтой юм.

II. Хүчин төгөлдөр бус байх (хууль бус)

Энэ зүйлийн 2 дугаар хэсэгт захиргааны актын аль нэг заалт илт хууль бус бөгөөд тухайн заалтгүйгээр захиргааны актын агуулга ойлгомжгүй болоход хүрвэл захиргааны актыг бүхэлд нь илт хууль бус гэж тооцно. Тэгвэл эсрэгээрээ захиргааны актын тухайн заалтгүйгээр захиргааны акт ойлгомжтой байвал түүнийг тэр хэсгээр нь илт хууль бус гэж үзэхгүй гэж дүгнэх боломжтой байна.

10 дугаар зүйл. Маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгох

- 10.1. Маргаан бүхий захиргааны акт иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн нь тогтоогдсон бол энэ хуулийн 6.1.-д заасан захиргааны байгууллага, албан тушаалтан уг актыг хүчин төгөлдөр үйлчилж байгаа, эсхүл ирээдүйд хүчин төгөлдөр болох эсэхээс үл хамааран бүхэлд нь буюу холбогдох хэсгийг хүчингүй болгосон шийдвэр гаргана.

Иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн нь тогтоогдсон тул захиргааны акт хууль бус болохыг (хүчин төгөлдөр бус буюу хүчингүйд тооцох боломжтой) захиргааны байгууллага 6 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон бол актыг хүчингүй болгохоор заажээ.

Өөрөөр хэлбэл, монголын хуулиар хоёр алхамыг нэгэн зэрэг хэрэгжүүлэхээр байна. Үүнд: актыг хууль бус болохыг тогтоож, дараагаар нь хүчингүй болгохоор байна.

Германы хуульд хууль бус захиргааны актыг цуцлана гэж хэлдэг. Хүчин төгөлдөр бус актыг ч хүчингүй болгож, улмаар хүчинтэй байгаа мэт шинж байдлыг нь арилгах боломжтой. Зөвхөн нэгэнт хүчин төгөлдөр болчихсон актын хувьд бус ирээдүйд хүчин төгөлдөр болох актын хувьд ч хүчингүй болгох үр дагаврыг зохицуулжээ.

11 дүгээр зүйл. Захиргааны акт гаргахыг даалгах

- 11.1. Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан дараахь тохиолдолд захиргааны зохих акт гаргахыг тухайн захиргааны байгууллага, албан тушаалтанд даалгана:
 - 11.1.1. захиргааны акт гаргахаас үндэслэлгүйгээр татгалзсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгож, захиргааны акт гаргах;
 - 11.1.2. захиргааны байгууллага, албан тушаалтны эс үйлдэхүйн улмаас иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн нь тогтоогдсон.

11.2. Захиргааны байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 11.1.-д зааснаас бусад үйлдэл хийж гүйцэтгэхийг даалгасан шийдвэр гаргаж болно.

10 дугаар зүйл нь захиргааны актыг анх гаргасан байгууллага тухайн актыг өөрөө арилгах зарчимд үндэслэж байгаа тул 11 дүгээр зүйлд зааснаар зохих захиргааны байгууллагад даалгах шаардлага гарч байна. Учир нь захиргааны анхны байгууллага гомдол хянан шийдвэрлэдэггүй, гомдлыг шууд харъяалагдах дээд шатны байгууллагад нь гаргахаар монголын хуульд зааснаараа германы хуулиас ялгагдаж байна.

Үүний улмаас захиргааны анхны актыг гаргасан байгууллага шийдвэр гаргах эрхээ алдсан бөгөөд дээд шатны байгууллага хэргийг дахин шилжүүлэхээс хамаарч байна. 11.1 дүгээр зүйлд заасан нь үндэслэлгүйгээр татгалзсан акт гаргахыг үүрэг болгох (Германы хуульд захиргааны анхны актыг гаргасан байгууллагад үүрэг болгох гэж нэрлэдэг) үр дагавар үүсгэж байна. Энэ журам нь гаргахыг шаардсан актыг гаргахгүй байх эс үйлдлийг шаардсан үед нэгэн адил үйлчилнэ.

12 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх

12.1. Иргэн, хуулийн этгээд дараахь тохиолдолд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй:

12.1.1. хуульд тусгайлан заасан;

12.1.2. дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтнаас энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан журмын дагуу гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн;

12.1.3. захиргааны байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан журмын дагуу гаргасан шийдвэрийг биелүүлээгүй;

12.1.4. шууд харъяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан гомдлыг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлээгүй.

12.2. Харъяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан байхгүй бол иргэн, хуулийн этгээд нь зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар энэ хуулийн 6.1.-д заасан хугацаанд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргана.

Германы захиргааны шүүхийн процесст нэхэмжлэх эрх гэж нэрлэгдсэн зохицуулалтыг агуулжээ (ЗШХХШТХ 42.2), 12.1.2 дугаар заалт нь Германы хуулийн 8 дугаар зүйлд заасан дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрийг иргэн эс зөвшөөрвөөс нэхэмжлэл гаргах эрхтэй гэсэн зохицуулалттай нийцэж байна.

Энэ зохицуулалтыг тайлбарлахдаа шүүхэд нэхэмжлэл гаргахад дан ганц гомдол гаргах иргэний хүсэл үндэслэл болохгүй харин тухайн иргэн нь өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзсэн байх шаардлагатай. 12.1.3, 12.1.4-д зааснаар иргэний эрх нь захиргааны байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан журмын дагуу гаргасан шийдвэрийг биелүүлээгүй, эсхүл шууд харъяалах дээд

шатны захиргааны байгууллага, албан тушаалтан гаргасан гомдлыг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлээгүй үед зөрчигдсөн байна.

Үүнээс үзэхэд 12.1.2-т заасан тохиолдолд ч мөн адил иргэний эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол зөрчигдсэн байх шаардлагатайг заажээ. Иймээс гагцхүү шийдвэрийг эс зөвшөөрөх нь дангаараа хангалтгүй, иргэний эрх зөрчигдсэн байх шаардлагатай.

Хугацааг 6 дугаар зүйлд зааснаар зохицуулахаар заажээ. 12.1.1-д зааснаас үзэхэд энэ зүйлд зааснаар бусад, хуульд заасан тохиолдолд иргэн захиргааны шүүхэд хандах боломжтой байхаар заасан нь ач холбогдолтой.

13 дугаар зүйл. Шүүхээс захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим

13.1. Захиргааны хэргийн шүүх захиргааны хэрэг хянан шийдвэрлэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 4-11 дүгээр зүйлд заасан зарчмыг баримтлана.

Захиргааны хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарчмын хувьд ИХШХШТХ-ийн 4-11 дугаар зүйлүүд үйлчлэхээр заажээ.

Үүний үр дүнд хянан шийдвэрлэх ажиллагаануудыг захиргааны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогоос шалтгаалан тодорхой хэмжээнд ижилсүүлэх боломж үүсч байгаа нь таатай хэрэг юм. Ингэж адилтгах, ойртуулах нь зөв.

ИХШХШТХ-ийн 4-11 дүгээр зүйлүүд нь арай өмнө үед гарсан бөгөөд тэдгээрийг хэрхэн хэрэглэх туршлага хуримтлагдсан гэж үзсэн тул нарийвчлан судлах шаардлагагүй болов уу.

Германы хуулийн хувьд ч мөн адил Иргэний процессийн хуулийн заалтыг хэрэглэхээр заасан байдаг.

14 дүгээр зүйл. Захиргааны хэргийн нутаг дэвсгэрийн харьяалал

14.1. Нэхэмжлэлийг тухайн шийдвэр гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтны оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүхэд гаргана.

Энэ зүйлд захиргааны хэрэг маргааныг шийдвэрлэхтэй холбоотой захиргааны шүүхийн харьяаллын асуудлыг зохицуулжээ. Харьяалал нь тухайн захиргааны (актыг гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтны) үйлдэл хэрэгжсэн газраар тодорхойлогдох ажээ. Өөрөөр хэлбэл газар харьяаллыг ерөнхийд нь зохицуулжээ.

Энэ нь Шүүхийн тухай хуулийн зохицуулалтаар Монгол Улсын газар нутаг захиргааны шүүхүүдийн харьяалалд буйг заажээ.

15 дугаар зүйл. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал

15.1. Аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх энэ хуульд заасны дагуу үүсгэсэн захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

- 15.2. Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхим захиргааны хэргийг дараахь журмаар хянан шийдвэрлэнэ:
- 15.2.1. аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх анхан шатны журмаар шийдвэрлэсэн хэргийг давж заалдах шатны;
- 15.2.2. Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхим давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн болон анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэртэй хэргийг хяналтын шатны.
- 15.3. Монгол Улсын дээд шүүх шаардлагатай гэж үзвэл ямар ч хэргийг татан авч анхан шатны журмаар хянан шийдвэрлэх эрхтэй.

I. Ерөнхий зүйл

Захиргааны хэргийн шүүхийн нутаг дэвсгэрийн харъяаллын тухай зохицуулалт дээр 15 дугаар зүйл нэмэлт хэлбэртэйгээр орсон байна. Энэ зохицуулалт аймаг, нийслэлийн захиргааны шүүхүүдийн анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд захиргааны ямар хэргийг шийдвэрлэхийг заажээ. Хүлээн авах хэрэг гэдэг нь германы хуулиар бол хуульд зааснаар шүүхийн харъяалалд шилжүүлсэн хэрэг гэж ойлгодог.

Түүнээс гадна дээр дурдсан шүүхүүдэд анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх харъяаллыг шилжүүлсэн бол энд функциональ харъяаллын зохицуулалтыг тодорхойлдог. Хэрэв анхан шатны журмаар хэргийг аймаг буюу нийслэлийн шүүх шийдвэрлэхээр байгаа бол дээд шүүх давж заалдах журмаар шийдвэрлэнэ.

Давж заалдах журмаар хэрэг шийдвэрлэхэд хуулийг зөв хэрэглэсэн эсэхийг, түүнчлэн хэргийн нөхцөл байдлыг дахин судалдаг.

II. Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог

Дээд шүүхийн захиргааны хэргийн танхим нь давж заалдах шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэхээс гадна хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх буюу хуулийг яаж хэрэглэсэн байдлыг хянах эрхтэй байна. Ингэхдээ нэг талаас Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн хэрэг, нөгөө талаас аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэртэй хэргийг хянах харъяаллыг түүнд оногдуулжээ.

Сүүлд дурдсан зохицуулалт нь нилээд өвөрмөц санагдсан бөгөөд энэ нь шийдвэрийг нь давж заалдах, хяналтын журмаар эсэргүүцэх боломжгүй тохиолдолд аймаг нийслэлийн шүүхийн шийдвэрүүд нь хуулийн хүчин төгөлдөр болдогт оршино. Шийдвэрийг эсэргүүцэх боломжтой бол хуулийн хүчин төгөлдөр биш гэсэн үг.

Германы процессийн хуульд үндэслэн үүнийг судлахад үүний хариулт нь 15 дугаар зүйлийн сүүлийн хэсгээс олж болох юм. Энд Улсын дээд шүүхэд Кассацийн эрхийг олгожээ. Улсын дээд шүүх нь хэргийг татан авч, анхан шатны журмаар шийдэх эрхтэй байна. Германы процессийн хуулинд бусад улс орнуудтай харьцуулахад хянан шийдвэрлэх ердийн ажиллагаанаас (гомдол, давж заалдах, хяналтын шат г.м.) гадуур орших кассацийн журам байдаггүй.

Доктор/jur./, доктор/h.c./ Юрген Харбихийн тайлбар

Гуравдугаар бүлэг “хэргийн оролцогч” /16-29 дүгээр зүйлүүд/

16 дугаар зүйл. Хэргийн оролцогчдын бүрэлдэхүүн

- 16.1. Нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийг хэргийн оролцогч гэнэ.
- 16.2. Нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь захиргааны хэргийн бие даасан оролцогч бус зөвхөн төлөөлүүлж буюу өмгөөлүүлж байгаа этгээдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалж буй этгээд мөн.

1.Ердийн тохиолдолд захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үед нэг талаас иргэн буюу хувь хүн нэхэмжлэгчээр, нөгөө талаас нийтийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч этгээд оролцдог.

Нэхэмжлэгч: нэхэмжлэгч нь бодгаль этгээд, хувь хүн байх зайлшгүй шаардлагагүй байдаг. 1.1-д зааснаас үзвэл хуулийн этгээд нэгэн адил нэхэмжлэгч байх боломжтой.

Харин энэ тохиолдолд ЗХХШТХ-д ингэж заахдаа бүртгэгдсэн буюу хуулийн этгээдийн эрхтэй нийгэмлэг, хувьцаат компани зэрэг иргэний эрхийн хуулийн этгээдийг зааж байгаа болов уу.

Иргэн нь өөрийн наснаас үл шалтгаалан нэхэмжлэгч байж болох бөгөөд хэрвээ газрын өмчлөгч мөн бол нярай хүүхэд, түүнчлэн бусдын адилаар эрх эдэлж үүрэг хүлээж буй сэтгэцийн согогтой этгээд ч мөн адил нэхэмжлэгч байж болно.

Хариуцагч: Хариуцагч гэдэг нь нийтийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байдаг. Жишээлбэл, төрийн олон төрлийн албан байгууллага, эсхүл нийтийн эрхийн хуулийн этгээд болох аймаг г.м..

Нэхэмжлэгч, хариуцагч нар нь маргаан бүхий эрх зүйн харилцааг шийдвэрлэх захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тогтмол оролцогчид мөн. Үүнээс гадна бусад этгээд буюу 21 дүгээр зүйлд заасан гуравдагч этгээдүүд нь хэргийн оролцогч байж болдог. Ингэснээр тухайн хэрэг маргааны оролцогчдыг нэг мөр тодорхойлжээ.

Үүнээс гадна 54 дүгээр зүйлийг дурдах хэрэгтэй. Үүний дагуу иргэдийн төлөөлөгч, өмгөөлөгч, шинжээч, орчуулагч гэх бусад хүмүүс оролцогчийн хүрээнд багтаж байна. Гэхдээ эдгээр хүмүүст 16 дугаар зүйлийн заалтуудыг жишээлбэл 25 дугаар зүйл шиг хэрэглэж болохгүй.

Ингэх нь утгагүй. 54.1 дүгээр хэсгийг буруу томъёолсон юм шиг санагдаж байна. 16 дугаар зүйлд заасан “оролцогчдоос” 54.2-т заасан “бусад оролцогчдыг” ялган салгах нь зүйд нийцэх байлаа; энэхүү “бусад оролцогчдыг” шүүх хуралдаанд хамтран оролцогч хүмүүс гэж тодорхойлж болно.

2.Хянан шийдвэрлэх ажиллагаанд биеэр оролцож байгаа шүүгч, прокурор, өмгөөлөгч, шинжээч болон бусад этгээд нь 16 дугаар зүйлийн болоод ЗХХШТХ-д заасан оролцогчын бусад эрхийг эдэлдэггүй. 16.2-т зааснаар нэг талаас оролцогчид /нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд/ шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийгөө төлөөлүүлэх эрхтэй боловч, нөгөө талаас тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчид энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан оролцогчид биш болохыг тодруулж өгдөг.

Эдгээр нь нэхэмжлэгч, хариуцагчдын хоорондын эрх зүйн харилцаанд оролцдоггүй бөгөөд харин тэдний төлөө буюу оролцогчдын эрхийг өмнөөс нь хэрэгжүүлдэг.

17 дугаар зүйл. Хэргийн оролцогчийн иргэний эрх зүйн чадвар

17.1. Захиргааны хэргийг захиргааны хэргийн шүүхэд хянан шийдвэрлэхэд иргэн, хуулийн этгээд оролцох эрхтэй.

17.2. Хуулийн этгээдийн эрхгүй боловч тухайн захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай холбоо, сан зэрэг нэгтгэлийг шүүгч захирамж гаргаж уг захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулж болно.

17.1.Иргэд болон хуулийн этгээдүүд шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож асуулт тавих, хүсэлт тайлбар гаргах замаар эрхээ хэрэгжүүлэхдээ эрх зүйт төрийн зарчимд нийцүүлэх ёстой.

Германы Үндсэн хуульд зааснаар /103 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэг/ хэн боловч шүүхэд хандах эрхтэй байдаг. Өөрөөр хэлбэл шүүх нь хянан шийдвэрлэх ажиллагааг оролцогчидгүйгээр хэрэгжүүлэхийг хориглодог. Монголын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-д зааснаар Монгол улсын иргэн шударга шүүхээр шүүлгэх эрхтэй байдаг.

Хянан шийдвэрлэх ажиллагааг шударгаар явуулахад түүнд оролцогч нь өөрийн эрхийг идэвхтэйгээр тусгаж авах боломжтой байх ёстой. Хэрвээ шүүхийн зүгээс оролцогчын энэхүү эрхийг тусгаж авахад саад хийвэл хянан шийдвэрлэх ажиллагааны алдаа гэж үзнэ. /88.1.4-р зүйлтэй харьцуул/.

17.2.-т заасан нэгтгэлүүдийг 16.1, 21-д заасан гуравдагч этгээд гэж үзэж болохгүй.

Гуравдагч этгээдийн оролцох эрхийг энэ хуулийн 21, Иргэний хуулийн 29 дүгээр зүйлүүдэд зохицуулсан байна. 17.2-т заасан нэгтгэлүүдийг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мэдлэг нь шаардлагатай гэж шүүхээс үзсэн байгууллагууд гэж ойлгох хэрэгтэй. Шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж буй нэгтгэлүүдийн эрх энэ тохиолдолд зөрчигдсөн байх шаардлагагүй. Өөрөөр хэлбэл шүүгчээс захирамж гаргах замаар тухайн нэгтгэлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахаар гаргасан шийдвэрүүдийг эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэр гэж үзнэ.

Хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогч нь ийм захирамж гаргах тухай саналыг шүүгчид гаргаж болох ч шүүгчийн хувьд үүнийг заавал биелүүлэх үр дагавар үүсэхгүй.

18 дугаар зүйл. Хэргийн оролцогчийн иргэний эрх зүйн чадамж

- 18.1. Шүүхэд захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр заагдсан эрхээ өөрөө хэрэгжүүлж үүргээ биелүүлэх, хариуцлага хүлээх буюу төлөөлөгчөөрөө гүйцэтгүүлэх чадварыг иргэний эрх зүйн бүрэн чадамжтай этгээд эдэлнэ.
- 18.2. Иргэний эрх зүйн зарим чадамжтай, эсхүл сэтгэцийн өвчний, мансууруулах бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч төлөөлөн хамгаална.
- 18.3. 16-18 хүртэлх насны иргэн өөрөө хүсвэл түүний эцэг, эх, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр захиргааны хэргийн шүүхэд биечлэн оролцох эрхтэй.

Эрх зүйн чадамж гэдэг нь хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлдэл хэрэгжүүлэх чадамж буюу эрх зүйн үр дагавар бүхий процессийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх чадвар юм. Хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн чадварыг иргэний хууль дахь иргэний эрх зүйн чадамжтай адилтгаж болох бөгөөд нэхэмжлэгчийн хувьд хууль зүйн үндэслэл бүхий нэхэмжлэл гаргах нөхцөл болдог.

Эрх зүйн чадамжгүй этгээдийн өмнөөс иргэний эрхэд заасантай нэгэн адилаар түүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно. 16-18 насны оролцогчдын хувьд тэдгээрийн эцэг, эх буюу тэдгээрийн эрх бүхий асран хамгаалагчдын зөвшөөрснөөр хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжтой байдаг.

Энэ насны оролцогч этгээд нь зарчмын хувьд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох чадвартай байдаг тул шүүхийн зүгээс тухайн этгээдийн эцэг эх, асран хамгаалагч нар нь насанд хүрээгүй этгээдийн хүслийг харгалзахыг санал болгох нь зүйтэй.

19 дүгээр зүйл. Нэхэмжлэгчийн эрх, үүрэг

- 19.1. Нэхэмжлэгч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараах эрх эдэлнэ:
 - 19.1.1. нэхэмжлэлээ өөрчлөх, түүний шаардлагын хэмжээг ихэсгэх буюу багасгах, нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагчтай эвлэрэх;
 - 19.1.2. захиргааны хэргийн шүүхийн болон эсрэг талын шаардлага, тайлбар, нотлох баримт, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл, хуулбар хийх, тэдгээрт тайлбар өгөх, шүүх хуралдаанд оролцох;

- 19.1.3. нотлох баримт гаргаж өгөх, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, бусад нотлох баримт цуглуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах;
 - 19.1.4. шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, прокурор, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг хуульд заасан үндэслэлээр татгалзан гаргахыг шаардах;
 - 19.1.5. шүүх хуралдааны бусад оролцогчид асуулт тавих;
 - 19.1.6. захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргах;
 - 19.1.7. хуульд заасан бусад эрх.
- 19.2. Нэхэмжлэгч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараахь үүрэг хүлээнэ:
- 19.2.1. захиргааны хэргийн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх;
 - 19.2.2. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих;
 - 19.2.3. захиргааны хэргийн шүүхийн тавьсан шаардлага, шийдвэрийг биелүүлэх.
- 19.1.1. Нэхэмжлэгчийн үндсэн эрхийг жагсаасан байна.**
- 19.1.2. дахь хэсгийн зохицуулалтыг энэ хуулийн 31, 62.2 дугаар зүйлүүдэд зааснаар захиргааны процессыг тодорхойлодог мөрдөн шалгах зарчимтай холбож үзэх шаардлагатай.**
- Шүүхэд танилцуулсан бүхий л баримтыг үзэж танилцах боломж нэхэмжлэгчид байх ёстой. Энэ нь шүүхийн зүгээс захиргааны байгууллагуудаас шаардан гаргуулж авсан акт эсхүл "эсрэг тал" буюу хариуцагчийн зүгээс шүүхэд танилцуулсан бусад акт байж болно. Өөрөөр хэлбэл шүүх болоод бусад оролцогчид актын агуулгын хувьд нэхэмжлэгчээс "илүү их мэдлэг"-тэй байж болохгүй. Энэ нь эсрэгээрээ мөн адил үйлчилнэ.**
- Энэ нь шүүхийн зүгээс нэхэмжлэгчийг дан объект мэтээр үзэхээс татгалзсан эрх зүйт төрийн үндсэн зарчмын илрэл юм. Нэхэмжлэгч нь шүүх хуралдаанд оролцож хянан шийдвэрлэх ажиллагааны явцын талаар өөрийн зүгээс тайлбар гаргах эрхийг эдлэх нь эрх зүйт төрийн зарчимд үндэслэсэн хянан шийдвэрлэх ажиллагаанд мөн адил нийцнэ.**
- 19.1.3. 31.2-т зааснаар шүүх өөрийн зүгээс нотлох баримтыг цуглуулах буюу нотлох баримт гаргаж өгөхийг шаардах үүрэгтэй байсан тохиолдолд нэхэмжлэгч нь тухайн нөхцөл байдлыг тодруулах тухай санал гаргаж нотлох баримт цуглуулах тухай хүсэлтээ гаргах эрхтэй /31.3 дугаар зүйл/. Нотлох баримт гаргуулах тухай хүсэлтийг шүүх шууд хэрэгжүүлэх үүрэг хүлээхгүй бөгөөд гагцхүү тухайн нөхцөл байдлыг тодруулахад шаардлагатай нотлох баримтыг шаардана /31.8 дугаар хэсэг/. Хэрвээ нотлох баримтын талаар гаргасан нэхэмжлэгчийн хүсэлтийг хангаагүй бол энэ талаарх тайлбарыг гаргана.**
- 19.1.4. Татгалзан гаргах зохицуулалтыг 65.1, 64.1 дүгээр хэсгүүдтэй холбож үзэх шаардлагатай.**

19.1.5. Бусад оролцогчдоод асуулт тавих эрх нь хэргийн нөхцөл байдлыг тодруулахад чиглэгдсэн байна.

19.1.6. Энэ нь нэхэмжлэгчийн эдлэх бусад ердийн эрхийн жагсаалт гэж үзнэ /81, 91 дүгээр зүйлүүдийн тайлбарыг үз/.

19.1.7.-д зааснаар нэхэмжлэгчийн хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх эрхийг ЗХХШТХ-д нэг мөр зохицуулаагүй болохыг заажээ. Өөрөөр хэлбэл нэхэмжлэгч нь захиргааны хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусад хуульд заасан эрхийг эдлэхээр шаардаж болно.

19.2 Нэхэмжлэгчийн үүрэг

Шүүхээс дуудсан хугацаанд хүрэлцэн ирэх. Нэхэмжлэгчийн үүргийг шүүхээс дуудах бүрт биеэр хүрэлцэн ирэх гэж ойлгож болохгүй. 29.2-т зааснаар нэхэмжлэгч нь энэ тохиолдолд хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд өмгөөлөгчийн туслалцаа авах эрхтэй. Хэрвээ нэхэмжлэгч нь өөрийн ашиг сонирхлоо өмгөөлөгчөөр төлөөлүүлж хэрэгжүүлэхээр үүрэг болгосон бол нэхэмжлэгчийн үүргийг өмгөөлөгч биелүүлэхэд хангалттай. Өөрөөр хэлбэл шүүхээс товолсон хугацаанд өмгөөлөгч байлцаж болно.

Германы захиргааны процессын эрхийн дагуу нэхэмжлэгч нь шүүх хурал буюу шүүхээс товолсон бусад хугацаанд /газар дээр нь очиж танилцах/ биечлэн оролцох үүргийг зарчмын хувьд хүлээдэггүй. Гэхдээ германы захиргааны хэргийн шүүхийн зүгээс оролцогчыг биечлэн оролцохыг захирамжлах /Германы захиргааны хянан шийдвэрлэх хуулийн 95.1.1 дүгээр зүйл/ боломжтой. Хэдийгээр захиргааны хянан шийдвэрлэх тухай монголын хуульд нэхэмжлэгч “биеэр оролцох” тухай тодорхой заагаагүй ч 19.2.3-т зааснаас үзэхэд шүүх нь нэхэмжлэгчийг биечлэн хүрэлцэн ирэхийг шаардах эрхтэй болохыг харж болно.

Ийнхүү биечлэн оролцох нь хянан шийдвэрлэх ажиллагааг түргэвчлэх, аливаа нөхцөл байдлыг тодруулах, эсвэл тухайн хэрэг маргааныг эвлэрлийн замаар шийдвэрлэхэд чиглэсэн байж болно.

19.2.2. Нэхэмжлэгчийн ердийн үүргийг тодорхойлжээ.

19.2.3. Энэ заалтыг ямар нэгэн бэрхшээлгүйгээр хэрэглэх боломжтой. Жишээлбэл: нэхэмжлэгч захиргааны шүүхийн зүгээс түүнд нотлох баримт гаргах тухай шаардлагыг биелүүлэх үүрэгтэй /31.2. дугаар зүйлийг үз/. Нэхэмжлэгчийг биечлэн байлцуулахаар захирамжлах талаар 19.2.1 дэх хэсгийн тайлбарыг үз.

20 дугаар зүйл. Хариуцагчийн эрх, үүрэг

20.1. Хариуцагч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараах эрх эдэлнэ:

20.1.1. захиргааны хэргийн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх;

20.1.2. нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх, эсхүл татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах, нэхэмжлэгчтэй эвлэрэх;

- 20.1.3. захиргааны хэргийн шүүхийн болон эсрэг талын шаардлага, тайлбар, нотлох баримт, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл, хуулбар хийх;
 - 20.1.4. гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, нэмэлт нотлох баримт цуглуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах;
 - 20.1.5. энэ хуулийн 19.1.4.-19.1.7.-д заасан эрх.
- 20.2. Хариуцагч захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараах үүрэг хүлээнэ:
- 20.2.1. нэхэмжлэлийн талаар бичгээр тайлбар гаргах, захиргааны хэргийн шүүхээс шаардсан нотлох баримтыг гаргаж өгөх;
 - 20.2.2. захиргааны хэргийн шүүхээс тавьсан шаардлага, шийдвэрийг биелүүлэх, шүүх хуралдаанд оролцох;
 - 20.2.3. захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх.

20.1 Хариуцагчийн эрх.

Хариуцагчийн эрхийн тухай зохицуулалтын хувьд онц бэрхшээл үгүй байна.

20.2 Хариуцагчийн үүрэг.

Хариуцагчийн үүргийн талаарх заалтууд мөн адил онцгой бэрхшээл учруулахгүй байна. Харин нэхэмжлэгч нь 20.2.1-д зааснаар нэхэмжлэлд хариу тайлбарыг бичгээр гаргах үүрэгтэй байгааг онцгойлон заах шаардлагатай. Энэ нь шүүх хуралдааны үеэр хариуцагч шүүх болоод нэхэмжлэгчийн эсрэг гэнэтийн тайлбар гаргахаас зайлсхийх зорилготой.

Нөгөө талаас хариуцагчийн бичгэн тайлбар шүүх хурлын үеэр тухайн хэргийн оролцогчидтой мэтгэлцэх боломжийг шүүхээс хангах нөхцлийг нэмэгдүүлдэг. Хариуцагч нь 20.2.2-т зааснаар шүүх хуралд оролцох үүрэгтэйг онцгойлон анхаарах нь зүйтэй.

21 дүгээр зүйл. Гуравдагч этгээд, түүнийг татан оролцуулах

- 21.1. Захиргааны тухайн хэргийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн бөгөөд бие даасан шаардлагатайгаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах нь зүйтэй гэж захиргааны хэргийн шүүх шийдвэрлэсэн иргэн, хуулийн этгээдийг гуравдагч этгээд гэнэ.
- 21.2. Тухайн захиргааны хэрэгт татан оролцуулахаар захиргааны хэргийн шүүх шийдвэрлэсэн гуравдагч этгээд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Захиргааны акт зөвхөн нэг бус хэд хэдэн этгээдийн эрхэд хамаарах нь олон тохиолддог. Жишээлбэл: газрын нэг хэсэг хоёр хүний өмчлөлд хамаарах бөгөөд тухайн

газрыг захиргааны байгууллагаас /жишээ нь зам барих зорилгоор/ акт гарган хураан авсан бол ийнхүү хураан авснаар өмчлөгч этгээдүүдийн хоёулангийнх нь эрх хөндөгдөнө.

Хэрвээ энэ тохиолдолд өмчлөгч этгээдүүдийн зөвхөн нэг нь хөрөнгө хураасан тухай захиргааны актыг захиргааны хэргийн шүүхийн өмнө эсэргүүцсэн бол шүүх нь өмчлөгч нөгөө этгээдийг тухайн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах шаардлагатай гэж үзнэ. Захиргааны шүүхээс гаргасан шийдвэрээр нэхэмжлэл гаргаагүй өмчлөгч этгээд нь гуравдагч этгээдийн эрхийг эдэлдэг.

Гуравдагч этгээд нь энэ тохиолдолд зохигч талын эрх, үүргийг хүлээдэг /энэ хуулийн 21.2, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлүүд/. Ямарваа этгээд гуравдагч этгээдийн эрх зүйн байдлыг олж авахын тулд түүний эрх буюу хууль ёсны ашиг сонирхол тухайн захиргааны актын улмаас хөндөгдсөн байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл бусад этгээдийн үзэл бодлын, эсхүл эдийн засгийн ашиг сонирхол хөндөгдөх нь хангалтгүй юм. Жишээлбэл: Ямар нэг иргэн өөрт нь барилга байгууламж барих эрхийг олгохоос татгалзсан захиргааны актыг эсэргүүцэж шүүхэд хандсан бол тухайн барилга байгууламжийг барих үүргийг хүлээсэн архитекторчийн хувьд гуравдагч этгээдийн эрх зүйн байр суурийг эзлэхгүй.

Учир нь энэ тохиолдолд барилга байгууламж барих эрх олгохоос татгалзсан шийдвэр гарснаар архитекторчийн өөрийн эрх бус, гагцхүү эдийн засгийн эрх нь хөндөгдсөн байна.

Хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдийг оролцуулах нь хянан шийдвэрлэх ажиллагааг цомхон болгох зорилготой. Өөрөөр хэлбэл тухайн зүйлээр хэд хэдэн хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж харилцан зөрчилдсөн шүүхийн шийдвэр гарахаас татгалзаж байна.

22 дугаар зүйл. Нэхэмжлэлийг хэд хэдэн этгээд хамтран гаргах

- 22.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгэн адил шаардлага бүхий нэхэмжлэлийг хэд хэдэн нэхэмжлэгч хамтран гаргаж болно.
- 22.2. Энэ хуулийн 22.1.-д заасан тохиолдолд нэхэмжлэгчид дундаасаа төлөөлөгч томилон итгэмжлэл буюу бүрэн эрх олгож, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрсдийгөө төлөөлүүлэн оролцуулах эрхтэй.
- 22.3. Нэхэмжлэлийг 20 буюу түүнээс дээш этгээд хамтран гаргасан тохиолдолд шүүгч тэдэнд төлөөлөгчөө энэ хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу захиргааны хэрэг үүсгэснээс хойш 14 хоногийн дотор томилон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахыг санал болгоно.
- 22.4. Энэ хуулийн 22.3.-т заасан хугацаанд нэхэмжлэгчид төлөөлөгчөө томилоогүй бол шүүгч тэдний дундаас төлөөлөгчийг нь томилно.

22.5. Төлөөлөгчийн тоо 3-аас илүүгүй байх ба энэ тохиолдолд шүүгч төлөөлөгчийн бүрэн эрхийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2-т зааснаар хязгаарлаж болохгүй.

22.1 Хянан шийдвэрлэх ажиллагааг цомхотгох зорилгоор хэд хэдэн этгээд шүүхэд нэг нэхэмжлэл гаргах боломжийг олгодог.

Жишээ: а. Нэг газрын хэд хэдэн өмчлөгч газрын татвар оногдуулах тухай шийдвэрийг эсэргүүцэж нэг нэхэмжлэл гаргаж болдог.

б. Насанд хүрээгүй сурагчийг сургуулиас хассан тохиолдолд тухайн сурагч болон түүний эцэг, эх дундаа нэг нэхэмжлэл гаргаж сургуулиас хассаныг эсэргүүцэж болно.

в. Нэг газрын хэд хэдэн өмчлөгч хамтран нэг нэхэмжлэл гаргаж тэдгээрийн хөршид олгосон барилга байгууламж барих зөвшөөрлийн талаарх шийдвэрийг эсэргүүцэж нэхэмжлэл гаргаж болно.

г. Зам төлөвлөлтийг хариуцсан эрх бүхий байгууллага цаашид барих замын чиглэлийн талаар шийдвэр гаргаж энэ нь хэд хэдэн газрын өмчлөгчдийн эрх ашгийг хөндсөн бол тухайн өмчлөгч этгээдүүд хамтран нэхэмжлэл гаргаж захиргааны тухайн актыг эсэргүүцэж болно.

22.2-22.5 дахь хэсгүүд нь олон тооны хүмүүсийг хамарсан хянан шийдвэрлэх ажиллагааг буюу олон тооны нэхэмжлэгчийг хамарсан хянан шийдвэрлэх ажиллагааг шийдвэрлэхийг хялбарчилах зорилготой. Энэ тохиолдолд нэхэмжлэгч этгээдүүд нь дундаасаа хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрсдийгөө төлөөлөх нэг төлөөлөгчийг томилох шаардлагатай. 20 буюу түүнээс олон тооны этгээд хамтран нэхэмжлэл гаргасан бөгөөд дундаасаа хамтын төлөөлөгчийг томилоогүй бол санаачлага шүүхэд шилжиж 1-3 төлөөлөгчийг томилуулах санал тавина.

Нэхэмжлэгчид цаашид төлөөлөгчөө томилоогүй бол түүнийг шүүхээс томилно. Төлөөлөгчийн бүрэн эрхийг нэхэмжлэгчийн зүгээс хязгаарлах эрхтэй болохыг анхаарах нь зүйтэй /энэ хуулийн 22.5, ИХШХШТХ-ийн 36.2 /.

23 дугаар зүйл. Хамтран хариуцагч

23.1. Нэг нэхэмжлэлд хэд хэдэн хариуцагч байж болох ба тэдгээр нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даан оролцох эрхтэй.

23.2. Хамтран хариуцагчид нь ашиг сонирхлын зөрчилгүй, уг хэргийг хянан шийдвэрлэхэд бүгд оролцох шаардлагагүй, түүнчлэн хэргийн шийдвэрт сөргөөр нөлөөлөхгүй гэж үзвэл хэн нэгийгээ томилон өөрсдийгөө төлөөлүүлэн оролцуулж болно.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хэд хэдэн хариуцагчид холбогдох нэг нэхэмжлэл гаргах боломжийг олгож байна. Тиймээс хариуцагч тус бүр нь тухайн шүүх хуралд оролцохыг зөвшөөрнө /23.1 дүгээр хэсэг/. Түүнээс гадна хамтран хариуцагч нар нь тэднийг төлөөлөх нэг төлөөлөгчийг сонгох эрхийг олгосон байна.

Харин төлөөлөх этгээдийг сонгох асуудал нь гагцхүү тэдний харьяалалд байх бөгөөд шүүх үүнд нөлөөлөх боломж үгүй /23.2 дугаар хэсэг: "...үзвэл ..." гэжээ/. Шүүхийн зүгээс хариуцагчдын тоог хязгаарлах боломжгүй.

24 дүгээр зүйл. Хариуцагчийг солих

- 24.1. Хариуцагчаар татагдсан этгээд уг нэхэмжлэлийн жинхэнэ хариуцагч биш болох нь нотлох баримтаар тогтоогдвол түүнийг шүүгч нэхэмжлэгчийн зөвшөөрснөөр жинхэнэ хариуцагчаар солино.
- 24.2. Хариуцагчийг солихыг нэхэмжлэгч зөвшөөрөөгүй бол уг этгээдийг шүүгч хамтран хариуцагчаар татан оролцуулна.
- 24.3. Хариуцагчийг нотлох баримт цуглуулахаас өмнө солих бөгөөд хэрэв тийнхүү цуглуулсны дараа солиход хүрвэл шинээр тогтоогдсон хариуцагч буюу хамтран хариуцагч уг хэргийн нотлох баримтыг шинээр цуглуулж үнэлүүлэхийг шаардах эрхтэй.

Хэрвээ нэхэмжлэгч нь тухайн хэрэгт холбогдох этгээдийн эсрэг чиглэсэн нэхэмжлэл гаргаагүй буюу жинхэнэ биш хариуцагчийг татсан бол хянан шийдвэрлэх ажиллагааг цаашид үргэлжлүүлэн явуулах нь түүний хувьд ач холбогдолгүй юм.

24.1.Хариуцагчийг солих нь шүүгчийн эрх мэдэлд харьяалагдана. Энэ нь шүүгчийн эрх хэмжээний асуудал бөгөөд харин нэхэмжлэгчийн зөвшөөрлийг авсан байна. Хэрвээ нэхэмжлэгч нь хариуцагчийг солихыг хүссэн боловч шүүгч ийнхүү солихыг зөвшөөрөөгүй бөгөөд нэхэмжлэгч нь жинхэнэ биш хариуцагчийн эсрэг маргаанаа үргэлжлүүлэхийг хүсээгүй бол уг этгээдийн эсрэг гаргасан нэхэмжлэлээсээ татгалзахаас өөр арга зам үгүй. /41.1 дүгээр зүйл/.

24.2.Хариуцагчийг солих тухай шүүгчийн шийдвэрийг нэхэмжлэгч зөвшөөрөөгүй бол "шинэ" этгээдийг тухайн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд хамтран хариуцагчаар оролцуулна. Харин нэхэмжлэгчийн анхны нэхэмжлэлдээ дурдсан этгээд нь хариуцагч хэвээр үлдэнэ. Өөрөөр хэлбэл нэхэмжлэгчийн зүгээс хариуцагчаар татсан этгээдийг шүүгч санаачлагаараа хянан шийдвэрлэх ажиллагаанаас хасах эрх байдаггүй. Шүүгч нь нэхэмжлэгчийн хүсэл зоригт хөндлөнгөөс нөлөөлөх эрхгүй. Энэ заалт нь эрх зүйт төрийн зарчимд үндэслэсэн байдаг билээ. Өөрийн зүгээс ямар нэгэн нөлөө үзүүлэх боломжгүй байсан нотлох баримт цуглуулах ажиллагааны үр дүн шинэ хариуцагчийн хувьд ач холбогдолгүй байх ёстой.

24.3.Шинэ хариуцагчийг оролцуулсан тохиолдолд нотлох баримт цуглуулах ажиллагаа өөрөөр явагдах боломжтой байсантай энэ нь холбоотой. Иймээс 24.3-т зааснаар шинээр хариуцагчаар татагдсан этгээдэд нотлох баримтыг цуглуулах ажиллагааг дахин явуулахаар шаардах эрхийг олгох нь зүйтэй юм. Түүнээс гадна хамтран хариуцагчийн хувьд дээр заасан эрхийг нэгэн адил эдэлнэ. Харин шинэ

хариуцагч буюу хамтран хариуцагч нь нэгэнт явагдсан нотлох баримт цуглуулах ажиллагаа буюу гэрчийн мэдүүлэг авсан эсхүл газар дээр нь үзэж танилцсан зэргийг хүлээн зөвшөөрсөн бол нотлох баримтыг дахин цуглуулахгүй.

25 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлан авах

25.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн эрхийг залгамжлахад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

Оролцогч этгээд нь ямар нэг шалтгааны улмаас хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжгүй болсон /жишээлбэл нас барсан/ бол зарчмын хувьд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох нь ач холбогдолгүй байдаг.

Харин тухайн этгээдийн эрхийг залгамжлагчид шилжүүлдэг. Үүнийг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан журмыг баримтлан зохицуулдаг.

26 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг төлөөлөх

26.1. Иргэний эрх зүйн чадамж бүхий иргэн мэргэжлийн хувьд шаардлагатай гэж үзвэл хяналтын шатны шүүхэд захиргааны хэргийг хянан хэлэлцэхэд төлөөлөгчөө оролцуулна.

26.2. Хууль, эрх зүйн бусад акт болон үүсгэн байгуулах баримт бичгийн дагуу олгогдсон эрх хэмжээний хүрээнд байгууллагын эрх баригч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлнө.

26.3. Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийн төлөөлөгчөөр оролцох байгууллагын эрх баригч нь өөрийн албан тушаал, эрх хэмжээгээ гэрчилсэн баримт бичиг, бусад ажилтан олгогдсон итгэмжлэлээ захиргааны хэргийн шүүхэд үзүүлнэ.

26.4. Итгэмжлэл нь Иргэний хуулийн 64.2-т заасан шаардлагыг хангасан байна.

26.1. Шүүх хуралд төлөөлүүлэх эсэхээ иргэн гагцхүү өөрөө шийднэ. Ихэнх иргэд хууль эрх зүйн мэдлэггүйн улмаас мэргэжлийн туслалцаа дэмжлэг авалгүй шүүхэд хандахаар хуульд заах боломжгүй болохыг энэ хэсгээр зохицуулжээ. Мэргэжлийн зохих мэдлэгтэй этгээд /өмгөөлөгч гэх мэт/-ээр иргэний байр суурийг бэхжүүлж, хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах нөхцлийг шүүхийн хувьд ялангуяа хууль эрх зүйн асуудал яригдах үед хялбаршуулдаг.

Өнөөгийн туршлагаас үзэхэд хууль эрх зүйн мэдлэггүй этгээд нь шүүх хуралдааны үед хууль эрх зүйн сэдэвт мэтгэлцээнд оролцох чадваргүй байдаг нь нотлогддог.

26.1-д хяналтын шатны шүүхэд л төлөөлөгч оролцох тухай бичсэн нь хууль тогтоогчийн хэвлэлийн алдаа байх; нэхэмжлэгчийн хувьд өөрийгөө төлөөлүүлэх эрх захиргааны хэргийн нэг, хоёрдугаар шатны шүүхийн алинд нь ч гарцаагүй олгогдох ёстой. /29.2-г үз./

26.2, 26.3 дахь хэсгийн хувьд бэрхшээлтэй зүйлгүй байна.

26.4 дэхь хэсгийн хувьд иргэний хуулийн 64.2-ыг хэрэглэхээр заасан байх бөгөөд энэ нь хэрэглэхэд бэрхшээлгүй санагдана.

§ 26.2., § 26.3., § 26.4. -----

27 дугаар зүйл. Төлөөлөгчийн бүрэн эрх

27.1. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулна.

27.2. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлд тусгайлан заасан тохиолдолд дараахь эрх эдэлнэ:

27.2.1. нэхэмжлэлийн өргөдөлд гарын үсэг зурах;

27.2.2. нэхэмжлэлийг хүлээн авах;

27.2.3. нэхэмжлэлийн шаардлагаас бүрэн буюу хэсэгчлэн татгалзах;

27.2.4. нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх;

27.2.5. эвлэрэх;

27.2.6. захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргах;

27.2.7. төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлийг бусдад шилжүүлэх;

27.2.8. захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах.

27.1.Энэ заалт нь төлөөлүүлсэн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах төлөөлөгчийн ерөнхий үүргийг тодорхойлжээ. Тиймээс төлөөлөгчийн үүрэг нь гагцхүү төлөөлүүлсэн этгээдийн ашиг сонирхолд чиглэгдсэн байдаг бөгөөд төлөөлөгч нь бусад оролцогчын эрх, ашиг сонирхолд анхаарал тавих шаардлагагүй. 27 дугаар зүйл нь төлөөлөгчийн ерөнхий үүрэг буюу хариуцагч, нэхэмжлэгчийн төлөөлөгчийн хувьд нэгэн адил үйлчилдэг байна.

27.2.27.1-д заасан төлөөлөгчийн ерөнхий үүргээс гадна 27.2.-т гагцхүү итгэмжлэлд тусгайлан заасан тохиолдолд эдлэх зарим онцгой эрхийг дурджээ. Энэ тохиолдолд итгэмжлэгч этгээд нь төлөөлөгчид 27.2.-т заасан бүх эрхийг олгох, эсвэл заримыг нь олгох, эсхүл аль ч эрхийг олгохгүй байх эрхтэй. Төлөөлөгчийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх боломжийг хязгаарлахгүйн тулд төлөөлүүлэгч этгээд нь хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцохооргүй бол төлөөлөгчийн бүрэн эрхийг нилээд өргөн хэмжээтэй байхаар тодорхойлох нь зүйтэй. Ялангуяа туршлага бүхий өмгөөлөгчийн

хувьд өргөн хүрээг хамарсан бүрэн эрх олгогдсон байх шаардлагатай. 27.2 дахь хэсгийн бусад зохицуулалтыг нарийвчлан авч үзэх шаардлагагүй.

Харин төлөөлөгчид энэ хуулийн 90 дүгээр зүйлд заасан гомдол гаргах бүрэн эрхийг олгосон байх шаардлагатай болов уу. Энэ журам 6 дугаар зүйлд заасан гомдлын хувьд нэгэн адил хүчин төгөлдөр үйлчлэх нь зүйтэй болов уу. Учир нь хянан шийдвэрлэх энэ төрлийн ажиллагаанд өөрийгөө төлөөлүүлэх эрхгүй байх үндэслэл тодорхой бус байна.

28 дугаар зүйл. Төлөөлөн оролцож болохгүй байдал

- 28.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг 18 насанд хүрээгүй болон эрх зүйн зарим буюу бүрэн чадамжгүй этгээд төлөөлөн оролцож болохгүй.
- 28.2. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар, эсхүл ажиллаж байгаа байгууллагаа төлөөлөн тухайн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаагаас бусад тохиолдолд шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч.

28.1.Энд зааснаар гагцхүү эрх зүйн бүрэн чадамжтай этгээд бусдыг төлөөлөх эрхтэй. Хууль тогтоогч нь энэ тохиолдолд гагцхүү өөрөө эрх зүйн бүрэн чадамжтай этгээд бусдын өмнөөс хариуцлагатайгаар үйл ажиллагаа хэрэгжүүлэх боломжтой гэж үзжээ.

28.2.Шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын хувьд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ерөнхийдөө бусдыг төлөөлөх эрхгүй ажээ. Эрх зүйт төрийн зарчим нь энэ төрлийн зохицуулалтыг шаарддаггүй. Ердийн шүүх, эрүүгийн хэрэг мөрдөн шалгах явцад төрийн үүргийг хэрэгжүүлдэг мэргэжлийн тодорхой хэсгүүдийг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахаас татгалзах үзэл баримтлал, сэтгэл зүйн зарим хандлага ажиглагддаг. Гэхдээ энд бүр мөсөн татгалзаагүй байна. Гагцхүү хувийн эсхүл ажил мэргэжлийн үүрэгтэй холбоогүй тохиолдолд дээр заасан мэргэжлийн этгээд төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэх боломжтой байгаа нь нөхцөл байдлын хувьд нийцэж байна.

29 дүгээр зүйл. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох

- 29.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч гэрээний үндсэн дээр аль нэг талыг төлөөлөн оролцож болно.
- 29.2. Талууд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд өмгөөлөгчийн туслалцаа авч болно.

- 29.3. Тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн бүрэн эрх нь хууль зүйн туслалцаа авч байгаа талын хүсэлтээр тодорхойлогдоно.
- 29.4. Өмгөөлөгч нь захиргааны хэрэг хянан хэлэлцэхэд гэрээгээр оролцохдоо Өмгөөллийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

29 дүгээр зүйл нь ойлгомжтой байна. Талуудыг хууль эрх зүйн мэдлэг бүхий бусад этгээд буюу их, дээд сургуулийн багш, профессорууд төлөөлж болно. Гагцхүү гэрээ байгуулж үүрэг хүлээсэн тохиолдолд тухайн талыг төлөөлнө. /29.1./ Төлөөлөгч нь гагцхүү нэг талын ашиг сонирхлыг төлөөлөх тул тухайн талыг төсөөлвөл хүсэлтийг удиртгал болгох ёстой. Өөрөөр хэлбэл тухайн талын хүсэл зориг нь төлөөлөгч этгээдийн хувьд эрх зүйн үр дагавар бүхий үүрэг байдаг /29.3./.

29.2.-т талууд нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд өмгөөлөгчийн туслалцаа авч болохоор заасан нь талууд өөрсдөө хууль эрх зүйн зохих мэдлэг эзэмшсэн байх боломжийг харгалзан үзжээ.

29.4. Төлөөлөгч нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд өмгөөлөгчийн эрх үүрэгтэй оролцоно. Ингэж зохицуулснаар шүүх болоод оролцогчдын хувьд нэг талаас өмгөөлөгч нөгөө талаас төлөөлж буй бусад этгээдийн эрх, үүргийг ялгах шаардлагагүй болно.

Талууд гэсэн томъёоллын хувьд: Германы хууль эрх зүйд “тал” гэсэн томъёоллыг зарчмын хувьд иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэдэг.

Германы захиргааны хянан шийдвэрлэх эрхэд “талууд” гэсэн ойлголтыг хэрэглэдэггүй бөгөөд оролцогч гэсэн томъёолол байдаг. 29 дүгээр зүйлд “тал” гэснийг нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, хамтран хариуцагч зэрэг нь аль ч үед өмгөөлөгчийн туслалцааг авч болно гэж ойлгоно. Өөрөөр тайлбарлах нь дур зоргийн буюу хууль бус үр дүнд хүргэх магадлалтай.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

“Нотлох баримт” /30-31 дүгээр зүйлүүд/

30 дугаар зүйл. Нотлох баримт

- 30.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нотлох баримтыг ойлгох, гаргаж өгөх, цуглуулах, үнэлэхдээ энэ хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37, 40-45, 47-49, 51 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

Шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаа нь ихэнх хэргийн хувьд төсөөтэй байх тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгэнт үйлчилж байгаа, батлагдсан зохицуулалтыг хэрэглэхээр заасан нь тустай санагдаж байна. Харин ЗХХШТХ-д ИХШХШТХ-иас бусад зарчим үйлчлэхээр байгаа бол энэ тухай иш татаж заасан байдаг.

Нөгөө талаас 30 дугаар зүйлд “энэ хуульд өөрөөр заагаагүй бол” гэснийг анхаарах шаардлагатай. Өөрөөр хэлбэл ИХШХШТХ-ийн заалтыг “сохроор” дагахгүй болохыг заасан байна /31 дугаар зүйлийн тайлбарыг үз/.

Тэнд бичсэнээс үзэхэд захиргааны хэргийг шүүхэд иргэний хуулийг заах шардлагагүй болгохын тулд зарим нэгэн зохицуулалт шаардлагатай байна. Хуулийн тодорхой бус заалтуудыг хүчин төгөлдөр эрх зүйн үүднээс тайлбар хийснээр тодруулах хэрэгтэй.

Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхээс өөр зарчмаар захиргааны хэргийг шүүдэг тул, ЗХХШХ өөр дүрэмтэй. Үүнээс үүдэн 30 дугаар зүйлийн заалт “энэ хуульд өөрөөр заагаагүй бол” гэсэн нөхцөлтэйгээр явна. Өөрөөр хэлбэл ИХШХШТ Хуулийн зохицуулалтыг шууд “харанхуйгаар” захиргааны хэргийн шүүхэд ашиглаж болохгүй гэсэн үг юм. (31.1-ийг үз).

Нотлох баримтуудыг цуглуулахаасаа өмнө шүүх шийдвэрт ач холбогдол бүхий хэргийн нөхцөл байдлын талаар тодруулах шаардлагатай. Ингэхдээ шүүх оролцогчдийн тайлбарт найдаж болохгүй, тэд заримдаа – ямар ч шалтгаанаар бай – ач холбогдолгүй фактуудыг мэдүүлдэг. Шүүх ийнхүү бодол санааны бэлтгэл ажлаа хангасаны дараа зохих нотлох баримтуудыг цуглуулж мөрдөн шалгах зарчмыг эхлүүлнэ.

Нотлох баримт хууль ёсных байх

30.1 дүгээр хэсэгт ИХШХШТХ-ийн 37 дугаар зүйлийг хэрэглэхээр заасан байх бөгөөд 2 дугаар хэсэгт нь хууль ёсны баримтын тодорхойлолтыг тусгажээ. Захиргааны процессын үед түгээмэл хэрэглэгддэг хэргийн газар дээр үзлэг хийх тухай 37.2 -т тодорхой заагаагүй байна. Тиймээс үүнийг ИХШХШТХ-ийн 37.2-т заасан эд мөрийн баримт гэсэнд хамааруулан ойлгож хууль ёсны нотлох баримт гэх нь зүйтэй болов уу. /ИХШХШТХ-ийн 45.2 дугаар хэсэгтэй харьцуулна уу/ Ялангуяа газар, барилга байгууламж, зам харилцаатай холбоотой асуудлын хувьд хэргийн газар дээр очиж танилцах нь элбэг тохиолдоно.

31 дүгээр зүйл. Захиргааны хэргийг нотлох үүрэг

- 31.1. Захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэнэ.
- 31.2. Захиргааны хэргийн шүүх хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг байгууллага, албан тушаалтан, иргэнээс гаргаж өгөхийг шаардах эрхтэй бөгөөд холбогдох этгээд уг шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 31.3. Оролцогч, түүний өмгөөлөгч, төлөөлөгч нотлох баримт гаргаж өгөх, үнэлэхийг захиргааны хэргийн шүүхээс шаардах эрхтэй.
- 31.4. Нотлох баримт гаргах, цуглуулах талаар хуульд заасан журмыг зөрчиж олж авсан нотлох баримт нотлох чадвараа алдах бөгөөд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.

- 31.5. Энэ хуулийн 31.2.-т заасан шаардлагыг биелүүлээгүй гэм буруутай этгээдэд Захиргааны хариуцлагын тухай¹⁴¹ хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 31.6. Төрийн байгууллага, хуулийн этгээд, хувь хүний гаргаж өгсөн бичмэл нотлох баримтыг уг хэргийн талаар захиргааны хэргийн шүүхээс гаргасан шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа анх гаргаж өгсөн этгээдийн хүсэлтээр буцааж өгч болох бөгөөд шаардлагатай гэж үзвэл хуулбарыг хэрэгт хавсаргана.
- 31.7. Шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт зайлшгүй шаардагдвал хуралдааныг нэг удаа хойшлуулна. Энэ тохиолдолд шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.
- 31.8. Захиргааны хэргийн шүүх хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасах бөгөөд тийм баримтыг шаардан гаргуулж болохгүй.

31.1.Хэргийн нөхцөл байдлыг тогтоох, нотлох баримтыг авч үзэх арга барил, байдлын хувьд иргэний, захиргааны процессын хооронд ихээхэн ялгаа ажиглагддаг. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд маргааны зүйл нь хувь хүн, иргэдийн хооронд байдаг. Зохигч талууд нь голдуу хувь хүмүүс байх бөгөөд өөр хоорондоо тэгш эрхтэй байдаг.

Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд зохигчид хэргийн нөхцөл байдлыг илтгэж, нотлох баримт, баримт бичгийг гаргаж, танилцуулдаг. Жишээ нь нотлох баримтыг /гэрчийн мэдүүлэг авах/ гаргахаар урьдчилж хүсэлтээ гаргадаг. Захиргааны процессын хувьд маргааны зүйл нь нийтийн эрх зүйн шинжтэй байдаг.

Өөрөөр хэлбэл иргэний субъектив нийтийн эрх, түүний эрх чөлөө, өмчлөлийн зүйл нь маргааны зүйл болдог. Захиргааны акт гарснаар иргэн энэ эрхээ зөрчигдсөн гэж үзвэл захиргааны шүүхэд ханддаг. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч талууд үндсэндээ нэг талаас тухайн актыг эсэргүүцэж иргэн нь нэхэмжлэгч, нөгөө талаас нийтийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч этгээд буюу төр хариуцагч болж оролцдог.

Хянан шийдвэрлэх ажиллагааны талууд нь процессоос гадуур бол захирах, захирагдах байдалтай байдаг /төр-иргэн/. Харин шүүхийн өмнө хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо тэгш эрхтэй байна. Иргэний, захиргааны хянан шийдвэрлэх ажиллагаануудын үндсэн ялгаа нь процессын явцад илэрдэг.

Захиргааны хэргийн шүүх нь хэргийн нөхцөл байдлыг албаны журмаар судалж тогтоодог. Өөрөөр хэлбэл хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа талуудын зүгээс нотлох баримтын талаар гаргасан хүсэлт, өргөдөл шүүхийн хувьд заавал биелүүлэх шинжтэй байдаггүй. Энэ нь герман, монголын захиргааны хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйд зарчмын хувьд ижил зохицуулжээ. /ЗХХШТХ-ийн 31.1, Германы хуулийн 86.1/. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанаас гол нь маргааны зүйл ялгаатай байдагтай холбоотой.

¹⁴¹ Захиргааны хариуцлагын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 4-5 дугаарт нийтлэгдсэн.

Иргэний хянан шийдвэрлэх ажиллагааны зүйл нь тэгш эрх бүхий зохигчдын хувийн шаардлагыг шийдвэрлэдэг. Иргэний хэргийн шүүгч нь энэ тохиолдолд иргэний хянан шийдвэрлэх шударга ажиллагааг хангаж, зохигч талууд өөрсдийн тайлбарыг гаргах боломжийг бүрдүүлэх үүрэг хүлээдэг. Талууд шаардаагүй бол шүүгч санаачлагаараа тухайн нөхцөл байдлыг тогтоохыг хориглодог. Нөгөө талаас захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд нийтийн ашиг сонирхол буюу төрийн өмнөх иргэний эрх ашиг хөндөгддөг.

Иргэний эрхийг үнэлж байгаа төрийн байр суурийг олон нийт мэдэх эрхтэй. Төр өөрийн аппарат, хувь хүний талаарх акт, мэдээлэл олж авах боломжтой тул иргэнээс илүү хүч чадалтай бөгөөд үүнийг тэнцүүлэх шаардлага гарч ирдэг. Иймээс шүүхийн зүгээс хэргийн нөхцөл байдлыг албан журмаар тогтоох үүрэг ноогддог. Өөрөөр хэлбэл нотлох баримтыг цуглуулах үүргийг шүүх хүлээнэ.

Нотлох баримт цуглуулах энэхүү үүргийг мөн “формаль нотлох үүрэг” гэж нэрлэдэг. Нотлох баримт цуглуулах үүрэг нь мөрдөн шалгах зарчмаас эхтэй боловч энэ нь процессыг эхлэхэд чухал байсан баримтыг нотлохгүй байх нь шүүхэд сөрөг үр дагаварыг авчирна гэсэн үг биш. Нотлох үүрэг хэргийн аль нэг оролцогчид ногдоно; материалаг нотлох үүргийн тухай 31.1 дэхь тайлбарыг үзнэ үү.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхээс хөтлөн явуулах нь зарим үед иргэн, зарим үед хариуцагч болж оролцож байгаа төрийн талд үйлчлэх үр дагавартай байдаг. Тухайн хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад чухам аль талын ашиг сонирхолд нийцэж шийдэгдэх нь шүүхийн хувьд ялгаагүй байна. Учир нь шүүх энэ тохиолдолд төвийг сахиж үр дүнг анхаарахгүй байх шаардлагатай. Захиргааны хэргийн шүүхийн гол үүрэг нь объектив талаараа зөв зүйтэй бүрэн дүүрэн нөхцөл байдлыг судалж тогтоох явдал юм.

Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь мөрдөх шалгах зарчимд үндэслэдэг. Иймээс ЗХХШТХ-ийн 30.1 дүгээр зүйлд ИХШХШТХ-ийн 43.2-ыг хэрэглэхээр заасныг энэ зарчмын дагуу шууд хэрэглэх боломжгүй юм.

Учир нь ИХШХШТХ-ийн 43.2-т иргэний хэргийн шүүх гэрчийг гагцхүү оролцогчдын зүгээс хүсэлт гаргасан тохиолдолд оролцуулахаар заасан байдаг. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед хүсэлт гаргах бололцоотой боловч мөрдөн шалгах зарчмын дагуу зайлшгүй шаардлагатай биш юм.

30.1-д ИХШХШТХ-ийн 40.5-ыг заасан нь захиргааны хэргийн шүүхийн давж заалдах болон хяналтын шатанд ямар ач холбогдолтой байгаа нь тодорхойгүй байна. Учир нь захиргааны хэргийн шүүхэд нотлох баримтыг танилцуулах шаардлагагүй байдаг; учир нь захиргааны хэргийн шүүх ямар ч аргаар байсан тохирох нотлох баримтын талаар мэдсэн л бол оролцогчид танилцуулаагүй ч тухайн нотлох баримтыг цуглуулах шаардлагатай болно.

Үүнээс гадна захиргааны хэргийн шүүхэд огт мэдэгдээгүй нотлох баримтууд байж болох бөгөөд угаас нарийн нямбай үйл ажиллагаатай захиргааны хэргийн шүүх тэдгээрийг хэрэгт холбоогүй болохыг тогтоох нь олонтаа байдаг. Ийм тохиолдолд шүүх мөрдөн шалгалтаас үл хамааран хэргийн нөхцөл байдлыг тодруулахаар аливаа арга

хэмжээг авахгүй байж болно. Харин нэхэмжлэгч эсвэл хариуцагч ийм нотлох баримтыг мэдэж байвал захиргааны хэргийн шүүх хуралд энэ тухай мэдэгдэхийг шаардана.

Гэрчийг дараа шатны шүүхэд “нөөцөлж” шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд давж заалдах болон хяналтын шатанд иргэний хуулийн 40 дүгээр зүйлийн дагуу тэднээс мэдүүлэг авахаас татгалзаж болно. Энэ утгаараа ямар ч тохиолдолд иргэний хуулийн 40.5-ыг захиргааны хэргийн шүүхэд хэрэглэж болно.

Нотлох баримтыг цуглуулах материаллаг үүргийн хувьд:

Хянан шийдвэрлэх тухайн ажиллагааны эцсийн шийдвэрт ач холбогдолтой аливаа нөхцөл байдлыг шүүх, оролцогчдын хүчин чармайлтын үр дүнд тогтоох боломжгүй тохиолдолд гарч болох үр дагавар. Энэ тохиолдолд шүүх эцсийн шийдвэрийг гаргах шаардлагатай болдог. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд “in dubio pro reo” буюу “эргэлзээтэй үед шүүгдэгчид ашигтайгаар” гэсэн зарчим үйлчилдэг.

Өөрөөр хэлбэл эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдохгүй бол хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгана. Харин захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед аливаа нөхцөл байдал тогтоогдоогүй бол тухайн нөхцөл байдалд тогтоогдсон тохиолдолд ашигтай нөхцөл байдалд үүсэх байсан талын эсрэг шийдэгддэг.

Дараах үндсэн зарчим үйлчилнэ:

Захиргааны актыг хүчингүй болгох тухай нэхэмжлэл гаргасан тохиолдолд тухайн хэргийн нөхцөл байдал буюу тухайн акт гаргаснаар гарах үр дүн тогтоогдохгүй бол захиргааны байгууллагын эсрэг талд шийдвэр гарна.

Захиргааны актыг гаргуулах эсхүл захиргааны байгууллагаас бусад үйлчилгээ үзүүлэхийг шаардсан нэхэмжлэл гаргасан тохиолдолд тухайн шаардах эрх оршин тогтнож байгаа талаар урьдчилсан нөхцөл байдлыг шүүхээс тогтоогоогүй бол нэхэмжлэгчийн эсрэг талд шийдвэр гарна.

Нотлох баримт цуглуулах материаллаг үүрэг аль талд ноогдохыг хянан шийдвэрлэх ажиллагааны бус материаллаг эрхэд зааснаар шийдвэрлэнэ.

31.2.Нотлох баримт гаргуулахаар шүүхээс шаардах эрх нь мөрдөн шалгах зарчмын үр дагавар мөн. Тухайн хэргийн нөхцөл байдлыг тогтооход ач холбогдолтой гэж үзсэн нотлох баримтыг шүүх өөрийн санаачилгаар шаардах ёстой. Оролцогчид зохих хүсэлтийг гаргах боломжтой боловч зайлшгүй шаардлага байхгүй /16 дугаар зүйл/. Энэ тохиолдолд тухайн субъектүүд шүүхийн шаардлагыг биелүүлэх нь эрх зүйт төрийн зарчимд нийцдэг /31.2/; "Иргэн" гэсэн ойлголтыг 19.3-ын тайлбартай харьцуулж үз.

Шүүхээс захиргааны аливаа актыг шаардсан бол захиргааны байгууллага нь тухайн актыг бүрэн хэмжээгээр гаргаж өгнө. Захиргааны байгууллага нь актын өөрт тааламжгүй агуулгатай хэсгийг гаргаж өгөхгүй байж болохгүй. Захиргааны актыг “цэвэрлэхийг” хориглоно.

31.3.Тухайн нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай нотлох баримтын талаар эхний ээлжинд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй этгээдүүд хамгийн зөв ойлголттой байдаг. Тиймээс оролцогчид хэргийн нөхцөл байдлыг тогтооход оролцдог.

Оролцогчид нь нотлох баримт санал болгох, нотлох баримтыг шаардах эсхүл цуглуулахаар шүүхэд хүсэлтээ гаргах эрхтэй /19.1.3-тай харьцуул/. Хэргийн

оролцогчдын энэхүү оролцоо нь шүүхэд мэдүүлэх зарчимд үндэслэдэг /19.1.3, 20.1.4-ийг үз/. Гэхдээ хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нь өөрийн бөгөөд нийтийн ашиг сонирхолд нийцсэн үүргийг үндэслэдэг. Тухайн нотлох баримтыг анхан шатны шүүхэд санал болгоогүй тохиолдолд түүнийг давж заалдах болон хяналтын шатанд дахин гаргахгүй. /30.1, ИХШХШТХ-ийн 40.5/.

31.4. Эрх зүйт төрийн зарчмын дагуу хууль бусаар олж авсан нотлох баримтыг үнэлэхийг хориглоно. Жишээлбэл, германы, магадгүй монголын хуулиар ярилцлагыг нууцаар буюу ярилцагч нөгөө талд мэдэгдэлгүйгээр бичлэг хийхийг хориглодог. 30.1, ИХШХШТХ-ийн 37.2-т зааснаар дуу бичлэг нь зарчмын хувьд хууль ёсны нотлох баримт болдог. Гэхдээ тухайн яриаг хууль бусаар бичиж авсан бол захиргааны шүүхийн шийдвэрийн үндэс болдоггүй.

31.5. Нотлох баримт гаргуулахаар шүүхээс шаардсныг тухайн субъект биелүүлээгүй тохиолдолд шаардлагаа албадан хэрэгжүүлэх боломж хангагдсан байх нь чухал ач холбогдолтой. Ийм боломж байхгүй тохиолдолд 31.2 хэрэгжихгүй.

31.6. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсны дараагаар бичмэл нотлох баримтыг шаардан авсан газарт нь буцаан олгож болно. Гэхдээ шүүхээс нотлох баримтыг өөрийн санаачлагаар бус, тухайн субъект зохих хүсэлтээ гаргавал буцаан олгоно. Харин шүүхээс шаардлагатай үед тухайн актын хуулбарыг үйлдсэн бол шүүхээс уг актыг буцаан олгох үүрэг үүсэх үндэслэлтэй. Энэ тохиолдолд актыг буцаан олгохгүй байх үндэслэл үүсэхгүй байна.

31.7. Захиргааны хэргийн шүүхээс шийдвэрлэх нөхцөл байдал нилээд нарийн төвөгтэй байх нь олон тохиолдоно. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх явцад өмнө төлөвлөөгүй нотлох баримт цуглуулах зайлшгүй шаардлага гарах боломжтой. Энэ тохиолдолд хянан шийдвэрлэх ажиллагааг нэг удаа хойшлуулна. Харин шинээр гарч ирсэн нотлох баримтыг үндэслэж, хэд хэдэн удаа хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулахыг зөвшөөрөхгүй.

31.8. Шүүх нь нотлох баримтыг үнэлэх үүргийг хүлээдэг тул тухайн хэрэг маргаанд холбогдолгүй нотлох баримтыг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр авч хэлэлцэхгүй /31.1 дүгээр зүйл, ИХШХШТХ-ийн 40.1 дүгээр зүйл/. Учир нь зарим тохиолдолд хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид нь процессыг удаашруулах зорилгоор тухайн хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолгүй нотлох баримтыг санал болгох нь тохиолддог. 31.8 дахь хэсэг нь оролцогчдын зүгээс хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах боломжийг хязгаарлах хэрэгслийг олгодог.

Нотлох баримтыг үнэлэх, 30.1 дэхь хэсэг, ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйл.

Шүүх нь нотлох баримтыг өөрийн итгэл үнэмшлийн дагуу үнэлнэ. Гэрчийн мэдүүлгүүд өөр хоорондоо тохирсон тохиолдолд тэдгээрийг шүүхээс үнэн зөв гэж үзэх дундад зууны үеийн Герман болоод бусад орны хууль зүйн тогтолцоон дахь нотлох баримтын зохицуулалт үйлчлэхгүй. Хэд хэдэн гэрчийн мэдүүлэг тохирсныг шүүхээс

баримтлахгүй. Харин шийдвэрийнхээ үндэслэлд тухайн гэрчийн мэдүүлгийг тусгана. Түүнээс гадна хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын зүгээс гаргасан хэргийн нөхцөл байдлын талаарх тайлбарыг шүүх заавал баримтлах шаардлагагүй. Түүнчлэн захиргааны байгууллагаас нөхцөл байдлыг тодорхойлсныг шүүх үндэслэл болгох шаардлага гарахгүй.

Учир нь захиргааны байгууллагын тайлбарыг бодит нөхцөл байдал болоод эрх зүйн үүднээс хянах нь шүүхийн бодит үүрэг даалгавар юм. Энд ч бас ямар шалтгаанаар шүүх захиргааны хэргийн шүүхээс өөр хэргийн нөхцөл байдлыг тогтоосноо шийдвэртээ тайлбар оруулах ёстой.

ТАВДУГААР БҮЛЭГ

Нэхэмжлэл гаргах, түүнийг хүлээн авах **/32-48 дугаар зүйлүүд/**

32 дугаар зүйл. Нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн хэлбэр, бүрдүүлбэр, агуулга

- 32.1. Нэхэмжлэлийг хариуцагчийн оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүхэд бичгээр гаргах бөгөөд нэхэмжлэгч, эсхүл түүнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлж буй этгээд гарын үсэг зурсан байна. Энэ хуулийн 4.1.1-4.1.3-т заасан тохиолдолд нэхэмжлэлийг Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимд гаргана.
- 32.2. Нэхэмжлэлд дараахь зүйлийг тусгана:
 - 32.2.1. нэхэмжлэлийг захиргааны хэргийн ямар шүүхэд гаргаж байгаа;
 - 32.2.2. нэхэмжлэгч, хариуцагчийн овог, эцгийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, оршин байгаа газрын хаяг;
 - 32.2.3. нэхэмжлэлийн шаардлагын агуулга;
 - 32.2.4. хавсаргасан баримт бичгийн жагсаалт.
- 32.3. Нэхэмжлэлийг төлөөлөгч гаргасан бол итгэмжлэл буюу гэрээг хавсаргана.
- 32.4. Нэхэмжлэлд нэхэмжлэгч, эсхүл төлөөлөгч гарын үсэг зурж, нэхэмжлэл болон түүнд хавсаргасан баримт бичгийг хариуцагчийн тоогоор хувилж өгнө.
- 32.5. Энэ хуулийн 32.2.3-т заасан нэхэмжлэлийн шаардлагын агуулга гэдэгт дараахь зүйлийн аль нэг багтана:
 - 32.5.1. захиргааны байгууллагаас гаргасан захиргааны акт нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөнийг нотолж чадах бол тухайн актыг хүчингүй болгуулах;
 - 32.5.2. захиргааны байгууллагаас гаргасан захиргааны акт илт хууль бус гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх;
 - 32.5.3. маргаан бүхий захиргааны акт нэхэмжлэгчийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн болон түүнээс үүдэн гарах хохирлын тухай;
 - 32.5.4. захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус эс үйлдэхүй нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хэрхэн зөрчсөн, түүний үр дагаврыг арилгах тухай зааж, зөрчигдсэн эрхээ хэрхэн сэргээлгэхийг хүсч байгаа.

32.1, 1 дүгээр өгүүлбэр.

Нэхэмжлэлийг шүүхэд орон нутгийн харьяалалаар гаргах зарчмыг Германы хуульд нэгэн адил заасан байдаг.

32.1.1 дүгээр өгүүлбэрт “оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүх” гэжээ. Зарчмын хувьд хариуцагч нь нийтийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч этгээд, жишээлбэл төрийн байгууллага байдаг. Тиймээс “оршин байгаа газар” гэснийг тухайн байгууллагын захиргаа орших газар гэж ойлгоно. Өөрөөр хэлбэл байгууллагын захиргаа гэдэг нь захиргааны байгууллагын удирдлага орших газар байна.

32.1, 2 дугаар өгүүлбэр. Энэ хуулийн 4.1.1-д заасан Монгол Улсын Засгийн газар, 4.1.6-д заасан Сонгуулийн ерөнхий хорооны эсрэг гаргах нэхэмжлэлийг Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 3 дугаар сарын 31-ний 2/02 тоот дүгнэлт түүнчлэн Улсын Их Хурлын зохих хуулийн дагуу захиргааны шүүхийн харъяаллаас хассан байна.

4.1.3-д зааснаар аливаа яамдын эсрэг нэхэмжлэлийг Улаанбаатарт орших Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимд гаргана.

32.2 Нэхэмжлэлийн шаардлагын агуулга.

Нэхэмжлэгчийн зүгээс хялбар хангах боломжтой нэхэмжлэлийн шаардлагын агуулгад тавигдах шаардлагыг тусгажээ. Үүнд: нэхэмжлэлийг гаргаж байгаа шүүхийг нэрлэнэ. Нэхэмжлэгч, хариуцагчийн бүтэн нэр, хаяг нь нэхэмжлэгчийн хэн болох, түүнд шүүхээс бичиг баримт хүргүүлэхтэй холбоотойгоор шаардсан байна. Шүүхээс нэхэмжлэлийг болоод бусад баримтыг хүргүүлэх зорилгоор хариуцагчийн бүтэн нэр, хаягийг заах шаардлагатай байна. /38.1 дэхь хэсэг/.

Нэхэмжлэлийн шаардлагыг нэхэмжлэгч тодорхой заана. Нэхэмжлэлийн шаардлагыг тодорхойлоогүй тохиолдолд шүүх нь хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж эцсийн шийдвэр гаргах боломжгүй юм. Ирүүлсэн баримт материал бүрэн эсэхийг шүүхээс хянах боломжийг хангах зорилгоор 32.2.4-д, эсхүл 33.2-т заасан журмыг баримтлах эсэхийг шийдвэрлэхээр заажээ.

32.3.Нэхэмжлэлийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд гаргахаас зайлсхийсэн зохицуулалт.

32.4.Нэхэмжлэлд гарын үсэг зурснаар нэхэмжлэл гаргах хүсэл зоригийн илэрхийлэл хангагдана. Өөрөөр хэлбэл гагцхүү гарын үсэг нь нэхэмжлэлийг бүрэн бүтэн буюу жирийн баримт бичгийг нэхэмжлэл болгодог.

Нэхэмжлэл түүнд хавсаргасан баримт бичгийн хуулбарыг хариуцагчийн тоогоор үйлдсэн байна.

Ихэнхи тохиолдолд нэхэмжлэл нь нэг хариуцагчийн эсрэг хандсан байдаг тул нэхэмжлэлд доод тал нь нэг нэг хуулбар үйлдсэн байх шаардлагатай байдаг. Энэ нь шүүхийг нэхэмжлэлийн хуулбар үйлдэж цаг алдахаас зайлсхийх зорилготой.

32.5.Энэ зохицуулалт нь нэхэмжлэлийн шаардлагын боломжит агуулгыг нарийвчлан тодорхойлсон байна.

32.5.1.Захиргааны тухайн акт нь түүний эрхийг зөрчсөн тохиолдолд нэхэмжлэгч нь тухайн актыг хүчингүй болгуулахыг шаарддаг. Германы хуульд захиргааны актыг хүчин төгөлдөр бусад тооцуулах гэсэн томъёолмыг хэрэглэдэг/ЗХХШТХ-ийн 42 дугаар зүйл/. Өөрөөр хэлбэл нэхэмжлэгчийн үзэж буйгаар эрхийг нь зөрчиж байгаа хууль бус акт гарсан бөгөөд шүүхээс тухайн актыг хүчингүй болгуулахаар шаардсан байна.

32.5.2.Захиргааны илтэд хууль бус актыг хүчин төгөлдөр бус захиргааны акт гэж нэрлэдэг. Энэ тохиолдолд захиргааны тухайн актыг захиргааны хэргийн шүүх илтэд хууль бус /хүчин төгөлдөр бус байдал/ болохыг тогтооход нэхэмжлэл чиглэдэг /70.2.3-ыг

үз/. Энэ зохицуулалтыг германы хуулиас авсан байх. Германы ЗХХШТХ-ийн 44.1-ийн дагуу “ноцтой алдаатай бөгөөд энэ нь нөхцөл байдлыг дүгнэхэд ил тодорхой байх” тохиолдолд захиргааны актыг хүчин төгөлдөр бус гэж үздэг. Тэгэхээр германы хуулиар захиргааны актыг хүчин төгөлдөр бус гэж үзэх 2 тодорхойлолт байна: ноцтой алдаа бөгөөд түүний илт байдал.

Харин ЗХХШТХ-ийн 32.5.2-ийн дагуу монголын хуулиар илт хуулийн зөрчил дангаараа захиргааны актыг хүчин төгөлдөр бус болгоход хүргэдэг байна; учир нь захиргааны актыг хүчингүй болгоход шүүх хүчингүй гэдгийг тогтоох нь хангалттай /32.5.2, 70.2.3/; хүчин төгөлдөр бус захиргааны актыг заавал хүчингүй болгох шаардлагагүй.

Монголын хууль тогтоогчдийн хувьд хүчин төгөлдөр бус захиргааны актын томъёоллыг /мөн захиргааны ерөнхий хуулийн бусад олон асуултыг/ өөрийн гэсэн хуульд–ЗХХШТХ–нэгтгэн зохицуулах асуудалд тулгарч байна. Энэ хуульд илт хууль бус шинж нь дангаараа захиргааны актыг хүчингүй болгох чанар мөн эсэх эсвэл монголын хууль тогтоогчид германы хуулийг /ЗХХШТХ-ийн 44 дүгээр зүйл/ баримтлах эсэхийг тодорхойлох шаардлагатай болно.

Одоо үйлчилж байгаа монголын хуулиар илт хууль бус шинжтэй захиргааны актыг хүчингүй акт гэдэг бололтой. Ийм захиргааны актын эсрэг гаргасан нэхэмжлэл нь захиргааны хэргийн шүүх захиргааны актын илт хууль бус шинж /=хүчингүй/-ийг тогтоох зорилготой /70.2.3-ийг үз/. Германы ЗХХШТХ-ийн 43 дугаар зүйлд ийм тохиолдолд “захиргааны актын хүчингүй болохыг тогтоох нэхэмжлэл” гэсэн зохицуулалт байдаг.

32.5.3.Нэхэмжлэлд нэхэмжлэгчийн чухам ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол тухайн маргаан бүхий захиргааны акт гарснаар зөрчигдөж, үүний улмаас ямар үр дагавар гарахыг заасан байна. Жишээлбэл: нэхэмжлэгчийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхийг хурааснаар тээврийн хэрэгсэл жолоодох эрх чөлөө зөрчигджээ. Тухайн этгээд жолоочоор ажилладаг тул энэ нь нэхэмжлэгч ажлын байраа алдах үр дагавар үүсгэж болох юм. Энэ зохицуулалт нь хянан шийдвэрлэх ажиллагаа чухам ямар зорилгоор хэрэгжихийг тодорхой болгох зорилготой. Хариуцагч нь нэхэмжлэгчийн шаардлагад хариу тайлбар өгнө /38.3-ыг үз/.

32.5.4.Энэ тохиолдолд нэхэмжлэгч нь захиргааны байгууллагын хууль бус эс үйлдлийг нэхэмжлэлдээ тусгасан байдаг. Энэ нь германы ЗХХШТХ-ийн 42 дугаарын зүйлийн “үүрэг болгосон нэхэмжлэл”-тэй тохирч байна. Нэхэмжлэгч нь захиргааны байгууллагын эс үйлдэхүйн улмаас зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тодорхой нэрлэх ёстой. Дээр дурдсан эс үйлдэхүйн улмаас үүссэн үр дагавар, тухайлбал түүнд учирсан хохирлыг нөхөн төлөх, зөрчигдсэн эрхээ сэргээхийг нэхэмжлэгч шаардаж болно.

Нэхэмжлэгчээс шаардсан үйлдлийг захиргааны байгууллага хэрэгжүүлснээр эрхийг сэргээж болно. Энэ нь эрх олгосон захиргааны акт гарах замаар хэрэгжих боломжтой.

Жишээ: захиргааны байгууллага нь зорчих хэсэгт сандал, ширээ нэмж тавих тухай цайны газрын эзний хүсэлтийг хууль бусаар татгалзжээ. Ийнхүү татгалзсанаа цайны газрын эзэн саяхан тээврийн хэрэгсэл жолоодож явахдаа хурд хэтрүүлж шийтгэл хүлээсэн гэж тайлбарлажээ. Энэ тайлбар нь хууль бус болно, учир нь энэхүү шийтгэл болон зорчих хэсэгт сандал, ширээ нэмж тавих тухай хүсэлт хоёрын хооронд ямар ч

холбоо байхгүй. Үүний улмаас цайны газрын эзэнд тоогоор илэрхийлж болохуйц хохирол учирчээ.

Энэ тохиолдолд цайны газрын эзэн нь нэхэмжлэлдээ зорчих хэсэгт сандал, ширээ нэмж тавих зөвшөөрөл, түүнчлэн олох байсан ашиг орлогыг нөхөн төлөхийг шаардаж болно.

33 дугаар зүйл. Нэхэмжлэл хүлээн авах

- 33.1. Нэхэмжлэлийг тухайн захиргааны хэргийн шүүхийн нарийн бичгийн дарга хүлээн авч, ийнхүү хүлээн авсан нэхэмжлэл, хавсаргасан материалын хуудасны тоо, огноо, цаг, минутыг нэхэмжлэлд тэмдэглэн, нэхэмжлэл бүртгэх дэвтэрт бүртгэж баримтжуулна.
- 33.2. Нэхэмжлэл нь энэ хуулийн 32.2-т заасан бүрдүүлбэр хангаагүй бол хүлээн авсан шүүгч 7-14 хоногийн хугацаа тогтоон нэхэмжлэгчид уг шаардлагыг хангах боломж олгоно.
- 33.3. Нэхэмжлэгч шүүгчийн тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй бол уг нэхэмжлэлийг буцаана.

33.1.Энд тухайн захиргааны хэргийн шүүхийн тамгын хэлтсийн ажилтан нэхэмжлэлийг хүлээн авахдаа баримтлах журмыг заажээ. Хуульд захиргааны “тухайн” шүүх гэж заасан боловч үүнийг “түүнд хандсан” захиргааны шүүх гэж ойлгох ёстой. Учир нь нэхэмжлэл нь уг шүүхэд харьяалагдах эсэхийг эхний ээлжинд шүүхээс хянаж, харьяалагдаагүй тохиолдолд 35 дугаар зүйлд заасан журмыг баримтлана.

Нарийн бичгийн дарга нь нэхэмжлэлийг хүлээж авсан огноог тодорхой тэмдэглэх нь чухал ач холбогдолтой. Нэхэмжлэлийг хуульд заасан хугацаанд багтааж гаргасан эсэхийг тогтоох нь үүнээс хамаарна. 32 дугаар зүйлийн зохицуулалт, түүнчлэн энэ хуулийн бусад зүйлд нэхэмжлэл гаргах хугацааг заагаагүй байна.

Гэхдээ энэ нь нэхэмжлэгч нь хугацаа харгалзалгүй нэхэмжлэл гаргаж болно гэж дүгнэж болохгүй. Захиргааны эрх зөрчсөн актыг эсэргүүцэх зорилгоор иргэн буюу хуулийн этгээд нь хугацаа харгалзалгүй нэхэмжлэл гаргах боломжгүй. 6.1-д зааснаар гомдлыг тодорхой цаг хугацаанаас эхлүүлэн 30 хоногт багтааж гаргахаар заажээ. Өөрөөр хэлбэл энд заасан хугацаа дуусмагц гомдол гаргах нь хууль бус юм. Энэ тохиолдолд хуульд иргэн буюу хуулийн этгээд нь захиргааны актыг гагцхүү тодорхой хугацааны дотор эсэргүүцэх боломжтой болохыг илэрхийлжээ. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.2 дугаар хэсэгт иргэн нь захиргааны хэргийн шүүхэд 6.1 дүгээр хэсэгт заасан хугацаа буюу 30 хоногийн дотор нэхэмжлэл гаргах боломжтой байхаар тусгажээ. 81.1-д зааснаар давж заалдах шатны шүүхэд гомдол гаргахдаа тодорхой хугацаа баримтлахаар заасан байна.

Гомдол, нэхэмжлэл гаргах, давж заалдах шатанд хандах тухай эдгээр зохицуулалтаас үзэхэд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эрх зөрчсөн захиргааны актыг хугацаагүйгээр эсэргүүцэх боломжийг хориглох зорилго агуулагдаж байгаа нь харагдаж байна. 12.2 дахь хэсгийн зохицуулалтыг төсөөтэй хэрэглэвэл

нэхэмжлэгч нь гомдлын шийдвэрийг хүлээн авснаас гагцхүү 30 хоногийн дотор эсэргүүцэх боломжтой байна. Үүнээс хойш гаргасан нэхэмжлэлийг хууль бус гэж үзнэ. Нөгөө талаас иргэн нь өөрт олгогдсон эрх зүйн боломжийг ашиглан захиргааны акт эсэргүүцээгүй бол тодорхой хугацаа өнгөрмөгц хүчин төгөлдөрт тооцох нийтийн сонирхол оршдог.

Германы хуульд захиргааны актыг хуулийн хүчин төгөлдөр болох тухай ойлголт байдаг. Өөрөөр хэлбэл захиргааны акт хэдийгээр хууль бус боловч түүнийг гарснаар тодорхой хугацаа өнгөрөхөд бий болсон эрх зүйн байдалд итгэх боломж эрх зүйт төрийн хувьд оролцогчдоод олгогдсон байх ёстой. Эрх зүйн баталгаат орчин удаан хугацаагаар үүсэхгүй байх нь эрх зүйт төрд нийцэхгүй.

33.2.Нэхэмжлэлийн шаардлага агуулгын хувьд бүрэн бус бол шүүгч нь нэхэмжлэгчид нэхэмжлэлийн шаардлагаа нөхөн хангах боломжийг олгоно. Хугацааг 7-14 хоногоор тогтоосон бөгөөд шүүх үзэмжээрээ хугацааг тогтооно. Хугацааг нэхэмжлэлийн шаардлагын бүрдүүлбэрийг харгалзан тогтооно. Германы хууль зүйн байр сууринаас үзэхэд 14 хоногийн хугацаа ч гэсэн богино байна.

33.3.Нэхэмжлэгч нь түүнд тавьсан шаардлагыг шүүхээс тогтоосон хугацаанд хангаагүй бол нэхэмжлэлийг буцаана. Шүүхэд өөр боломж олгогдоогүй бөгөөд энэ нь нэхэмжлэгчийн хувьд нилээд хатуу үр дагавар үүсгэх учраас шүүх нь 33.2-т заасан хугацааг тогтоохдоо анхааралтай хандах нь зүйтэй болов уу.

34 дүгээр зүйл. Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах

34.1. Шүүгч дараахь тохиолдолд нэхэмжлэл хүлээн авахаас татгалзана:

- 34.1.1. захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус;
- 34.1.2. тухайн захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус ;
- 34.1.3. захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг биелүүлээгүй ба энэ журмыг хэрэглэх боломжтой;
- 34.1.4. нэхэмжлэгч нь эрх зүйн бүрэн чадамжгүй бөгөөд түүнийг төлөөлсөн этгээд байхгүй;
- 34.1.5. нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан;
- 34.1.6. нэхэмжлэлд дурдсан үйл баримт, хариуцагчийн гэм буруугийн талаар, эсхүл уг нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, түүнчлэн хэргийг хэрэгсэхгүй болгосон хуулийн хүчин төгөлдөр захиргааны хэргийн шүүхийн шийдвэр буюу шүүгчийн захирамж байгаа;
- 34.1.7. нэхэмжлэгч болох иргэн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан боловч эрх, үүрэг нь эрх залгамжлагчид шилжээгүй;
- 34.1.8. захиргааны акт нь Үндсэн хууль зөрчсөн нь тогтоогдсон бөгөөд Үндсэн хуулийн цэцийн харьяаллын маргаан бол;
- 34.1.9. захиргааны акт нь эрүүгийн эрх зүйн маргаан бол;
- 34.1.10. захиргааны акт нь иргэний эрх зүйн маргаан бол.

34.2. Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахдаа захиргааны хэргийн шүүх тогтоол, шүүгч захирамж гарган татгалзсан шалтгааныг зааж, нэхэмжлэлийг энэ хуулийн

34.1.3.-34.1.6.-д заасан тохиолдолд нэхэмжлэгчид буцаах бөгөөд бусад тохиолдолд холбогдох байгууллагад нь шилжүүлнэ.

34.1.Захиргааны хэргийн шүүх нь нэхэмжлэл гаргасан тохиолдолд гагцхүү хуульд заасан тохиолдолд түүнийг хүлээн авна. 34.1-д нэхэмжлэлийг хүлээн авах боломжгүй хэд хэдэн үндэслэлийг заажээ. Дараахь тохиолдолд шүүгч нь нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.

34.1.1.Захиргааны хэргийн шүүхийн харьяалалд гагцхүү 4.1, 4.2-т заасан хэрэг маргаан хамаарна. Бусад нэхэмжлэлийг шүүх хүлээн авах боломжгүй бөгөөд 34.2, 35 дугаар зүйлүүдэд заасан журмыг баримтлана.

34.1.2.Энд зарчмын хувьд захиргааны хэргийн шүүхийн харьяалалд багтах хэрэг маргааныг тусгажээ. Захиргааны хэргийн шүүх нь 14 дүгээр зүйлд зааснаар орон нутгийн харьяалалгүй нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж 35.1-д зааснаар харьяалмынх нь захиргааны шүүхэд шилжүүлнэ.

34.1.3.Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан захиргааны журмаар урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар тухайн хэрэг маргааныг шийдвэрлэх шаардлагатай бөгөөд 12.2-т бусад тохиолдлыг зохицуулжээ. Урьдчилан шийдвэрлэх шаардлагыг нэхэмжлэгч заавал биелүүлэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл нэхэмжлэгч нь эрхээ захиргааны журмаар урьдчилан шийдвэрлэх журмаар хамгаалуулахыг оролдоогүй бол түүний нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана. Хуульд заасан журмыг хангаагүй нэхэмжлэлийг хүлээн авахгүй.

34.1.4.Эрх зүйн чадамжгүй нэхэмжлэгч хянан шийдвэрлэх ажиллагааны чадамжгүй байна. Өмнөөс нь төлөөлөгч оролцохооргүй бол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.

34.1.5.Нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд гаргасан бол шүүхээс 33.2-т заасан хугацаанд итгэмжлэлээ гаргахыг шаардана. Гагцхүү энэ хугацаанд итгэмжлэлээ шүүхэд гаргаагүй бол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана /33.3, 34.1.5/.

34.1.6.Тухайн хэрэг маргааны талаар хуулийн хүчин төгөлдөр шийдвэр гарсан тохиолдолд хэрэг, маргаан буюу маргааны тухайн зүйлээр эрх зүйн маргаан дахин явуулах боломжгүй. Бусад тохиолдолд хуулийн хүчин төгөлдөр болох нь учир холбогдолгүй юм. Энэ утгаараа уг нөхцөл байдлын талаар дахин нэхэмжлэл гаргавал түүнийг хүлээн авахаас татгалзана.

34.1.7.Иргэн нас барсан эсвэл хуулийн этгээд татан буугдсан бөгөөд түүний эрх, үүрэг бусад этгээдэд шилжээгүй бол тухай этгээдийн эрх, үүргийн талаар маргах нь утга алдах бөгөөд энэ тохиолдолд энэ талаар гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.

Жишээ: Улсын Их сургуулиас оюутныг шалгалтанд оруулахаас татгалзсан бөгөөд уг оюутан нь нэхэмжлэл гаргасныхаа дараагаар нас барсан тохиолдолд шалгалтанд оруулахыг татгалзсаныг эсэргүүцсэн нэхэмжлэл хуульд нийцэхгүй. Учир нь энэ тохиолдолд нэхэмжлэлийн зүйл нь гагцхүү тухайн оюутанд хамаарах хувь хүний шинжтэй үл залгамжлагдах эрх, үүрэг юм. Уг хэргийг үргэлжлүүлэх талаарх өөр хүний сонирхолыг хэрэгсэхгүй.

34.1.8. Үндсэн хуулийн цэцийн харьяалалд хамаарах эрх зүйн маргаан нь захиргааны хэргийн шүүхийн маргааны зүйл болохгүй. Тиймээс холбогдох нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, 35.1-д заасны дагуу Үндсэн хуулийн цэцэд шилжүүлнэ.

34.1.9. Захиргааны хэргийн шүүхийн харьяалалд эрүүгийн эрх зүйн маргаан хамаарахгүй /4.3 дугаар зүйлийг үз/ бөгөөд энэ тохиолдолд хэрэг маргааныг прокурорт шилжүүлнэ /35.1 дүгээр зүйл/.

Жишээ: иргэн гэмт хэрэг үйлдсний улмаас баривчлагдсан тохиолдолд түүнийг баривчилсан нь хууль ёсны эсэхэд захиргааны хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй.

34.1.10. Иргэний хэрэг маргаан нь захиргааны хэргийн шүүхийн харьяалалд нэгэн адил хамаарахгүй. Тиймээс иргэний хэрэг маргааны зүйл бүхий нэхэмжлэлийг иргэний шүүхэд шилжүүлнэ /35.1/.

34.2. Энд 34.1-д заасан хэрэг маргааны хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулжээ. Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан эсхүл харьяаллын газарт шилжүүлснээс үл шалтгаалан шүүгч нь нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсныг үндэслэх үүрэгтэй. Энэхүү үндэслэлээс түүний нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсныг эсэргүүцэж дээд шатны байгууллагад хандах эсэхээ нэхэмжлэгч шийднэ.

35 дугаар зүйл. Нэхэмжлэлийг өөр шүүхэд шилжүүлэх

35.1. Энэ хуулийн 34.1.1., 34.1.2., 34.1.8., 34.1.10.-т заасан үндэслэл байвал нэхэмжлэлийг харьяалагдах шүүхэд буюу Үндсэн хуулийн цэцэд, мөн хуулийн 34.1.9.-д заасан үндэслэл байвал прокурорт тус тус шилжүүлнэ.

35.2. Нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж хүчин төгөлдөр болсны дараа шилжүүлнэ.

35.3. Тухайн хэргийн шүүхийн харьяаллын талаар гарсан шүүх хоорондын маргааныг Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын тэргүүн шийдвэрлэнэ.

35.1. Энэ заалтыг 34.1 дүгээр хэсэгтэй холбон тайлбарласан билээ.

35.2. Тухайн нэхэмжлэлийг гагцхүү түүнийг шилжүүлэх тухай шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсны дараагаар шилжүүлэх нь зүйтэй юм.

35.3. Захиргааны хэргийн шүүхээс нэхэмжлэлийг шилжүүлсэн шүүх нь тухайн хэргийг өөрийн харьяаллын бус гэж үзвэл үүнтэй холбогдсон маргааныг Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын тэргүүн шүүгч шийдвэрлэнэ. Хэргийн харьяаллын талаар гарсан маргааныг дээд шатны байгууллага өндөр түвшинд шийдвэрлэж байгаа нь зөв зүйтэй хэрэг гэж үзэж байна. Тухайн шийдвэр нь танхимын тэргүүний үзэмжээр бус хуульд заасны дагуу буюу тухайн хэрэг маргааны зүйлийн дагуу тодорхойлогдоно.

Тухайн хэрэг маргаан нь жишээлбэл: иргэний эсхүл захиргааны хэргийн шүүхийн харьяалалд багтаж байгаа нь ихээхэн ач холбогдолтой байдаг. Учир нь иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны үед зохигчдын нотлох үүрэг хуулиар тогтоогддог бол

захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд энэ үүргийг шүүх хүлээдэг. Үүнээс гадна тухайн нэхэмжлэлийг чухам аль шүүхийн харьяалалд хамаарахыг түргэн шуурхай тогтоох нь ач холбогдолтой.

36 дугаар зүйл. Захиргааны хэрэг үүсгэх

36.1. Шүүгч энэ хуулийн 34.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор захиргааны хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

36.1. 34.1-д заасан үндэслэл байхгүй бол нэхэмжлэлийг хүлээн авна. Нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх тухай захирамж гаргана. Германы нөхцөлтэй харьцуулбал энэ хугацаа маш богино юм. Учир нь 34.1-д заасан нэхэмжлэлийг хүлээн авах эсэхийг хянах ажиллагаа нь зарим тохиолдолд нарийн төвөгтэй байдаг.

37 дугаар зүйл. Захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа

- 37.1. Нэхэмжлэл хүлээн авч, хэрэг үүсгэсэн шүүгч дараахь ажиллагаа явуулна:
- 37.1.1. хариуцагчийг дуудан ирүүлж, нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримт бичгийн хувийг гардуулж, энэ тухайгаа баталгаажуулах;
 - 37.1.2. хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, гэрчийг дуудаж мэдүүлэг авах, шинжээч, орчуулагч, хэлмэрч томилох болон шаардлагатай бусад ажиллагаа явуулах;
 - 37.1.3. хэргийн оролцогчид эрх, үүргийг нь амаар тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд бичиж, гарын үсэг зуруулах;
 - 37.1.4. шаардлагатай бол холбогдох шүүхэд шүүхийн даалгавар явуулах;
 - 37.1.5. талуудыг эвлэрүүлэх арга хэмжээ авах;
 - 37.1.6. нэхэмжлэлийн үнэ, захиргааны хэргийн шүүхийн зардлын тухай шийдвэрлэх.

Нэхэмжлэлийг хүлээн авч, хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлсний дараагаар шүүгчээс чухам ямар үйл ажиллагааг хэрэгжүүлж, захирамжлах журмыг нэг бүрчлэн заажээ.

37.1.2. Энэ заалтад заасан шүүгчийн үүрэг нь мөрдөн шалгах зарчмын илрэл бөгөөд шүүхийн зүгээс хэргийн нөхцөл байдлыг албаны журмаар буюу өөрийн зүгээс судалж тогтоохыг тусгажээ.

37.1.5. Тухайн хэрэг маргааныг эвлэрлийн журмаар шийдвэрлэх арга хэмжээ авах шүүгчийн үүрэг нь нилээд ач холбогдолтой /эвлэрэл, 43 дугаар зүйлийн тайлбарыг үз/. Тухайн нэхэмжлэлийн зүйлд илэрсэн бодит болоод эрх зүйн асуудлыг судалж шүүх хуралдааныг явуулах үр чадварыг шүүгчээс шаарддаг.

38 дугаар зүйл. Нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах

- 38.1. Хэрэг үүсгэсэн өдрөөс хойш нийслэлд 7, орон нутагт 14 хоногийн дотор шүүгч нэхэмжлэлийг хариуцагчид гардуулна.
- 38.2. Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор, эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөх эсэх тухайгаа шүүхэд бичгээр мэдэгдэх үүрэгтэй.
- 38.3. Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй бол тайлбартаа үндэслэлийг зааж, нотлох баримтаа хамтад нь гаргаж ирүүлнэ.
- 38.4. Энэ хуулийн 38.2., 38.3.-т заасан хугацаа болон шаардлагын дагуу тайлбараа гаргаж өгөөгүй гэм буруутай албан тушаалтанд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

38.1-д зааснаар 37.1.1 дэх хэсгийн дагуу шүүхэд дуудагдсан хариуцагчид нэхэмжлэлийг шаардлагыг гардуулна. Нийслэл, хөдөө орон нутаг дахь ялгавартай нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр хугацаа заажээ.

38.2, 38.3, 38.4

Нэхэмжлэлийн шаардлагад хариуцагчийн зүгээс тайлбараа гаргах хугацааг хатуу тогтоосонгүй. 14 хоногийн хугацаанаас өөр хугацаа тогтоох эрх мэдэл шүүхэд олгогдсон байна. Хугацааг 14 хоногоос бага буюу уртаар тогтоож болно. Бодит амьдрал дээр шүүх нь хуульд зааснаас өөр хугацааг заахаар бол түүнийг уртасгах хандлагатай байдаг. 14 хоногийн хугацаа нилээд богино юм. Ялангуяа хариуцагч буюу төр нь нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхөөр бол захиргааны байгууллагын хэмжээнд ярилцах шаардлага гарна.

Харин хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагыг ихэнхдээ эсэргүүцдэг тул энэ тохиолдолд тайлбарын үндэслэлийг гаргах шаардлагатай болдог. Энэ тохиолдолд мөн адил 14 хоногоос урт хугацаа шаардагдана. Шүүх өөрийн эрх хэмжээний хүрээнд хугацаа тогтоохдоо захиргааны тухайн ажилтан нь үүргээ өөрийн буруугаас баримталж чадаагүй бол шийтгэл хүлээдгийг анхааруулах шаардлагатай. Хариуцагчийн хүсэлтээр шүүгч нь өөрийн тогтоосон хугацааг сунгах нь хуульд харшлахгүй гэдгийг анхаарах шаардлагатай.

39 дүгээр зүйл. Сөрөг нэхэмжлэл

- 39.1. Хариуцагч нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх явцад үндсэн нэхэмжлэлтэй хамруулан хянан шийдвэрлүүлэхийн тулд шүүх хуралдаанаар хэлэлцэхийн өмнө сөрөг нэхэмжлэл гаргах эрхтэй.
- 39.2. Сөрөг нэхэмжлэл гаргахдаа нэхэмжлэл гаргах нийтлэг журмыг баримтална.
- 39.3. Маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгуулах болон захиргааны акт гаргуулах тухай нэхэмжлэлтэй холбогдуулан сөрөг нэхэмжлэл гаргахыг хориглоно.

39.1.Энэ заалтын зорилго нь хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчид бус гагцхүү хариуцагчид хянан шийдвэрлэх ажиллагааг хялбаршуулах зорилгоор нэхэмжлэгчийн эсрэг бие даасан сөрөг шаардах эрхийг хэрэгжүүлэх зорилготой. Анхны нэхэмжлэлийг шийдвэрлэхэд сөрөг нэхэмжлэлийг шийдэх тул анхны нэхэмжлэлтэй холбоотой байх шаардлагатай. Ялангуяа нэхэмжлэгчийн шаардах эрх нь сөрөг нэхэмжлэлийн шаардлагатай нэгэн адил эрх зүйн харилцаанаас үүсэж байгаа бол дээр дурдсан холбоог оршиж байна гэж үзнэ.

Сөрөг нэхэмжлэлийн тухай зохицуулалт нь ер нь захиргааны хэргийн шүүхийн агуулга юу байх вэ гэдгийг сайтар бодоход хүргэж байна. “Хуулийн зорилт” гэсэн гарчигтай 1 дүгээр зүйлийг хууль тогтоогчид хууль бус захиргааны актаас хамгаалах зорилгоор захиргааны хэргийн шүүхийг Үндсэн хуулинд захирагдахаар хийсэн гэж ойлгож болохоор байна. Нэхэмжлэлийн шаардлагын агуулга 32.5-д ч мөн захиргааны акт анхаарлын төвд байна, 70.2 ч мөн адил.

Төр эсвэл олон нийтийн эрх зүйн өөр хуулийн этгээд нэхэмжлэгчийн хэлснээр хууль зөрчсөн хүндрэл учруулсан захиргааны акт гаргасан эсвэл дэмжсэн захиргааны актыг үйлдээгүй гэсэн таамаглал дээр дурдагдсан эрх зүйн хэм хэмжээний суурь нь болж байгаа юм. Гэхдээ 39 дүгээр зүйлээс харахад хариуцагч ч гэсэн—энэ нь ихэнхи тохиолдолд төр буюу аливаа төрийн эрх баригч байдаг—нэхэмжлэгчийн эсрэг, жишээлбэл бодит хүний эсрэг эрхээ эдлэх эрхтэй. Энэ нь заавал захиргааны акттай холбоотой маргаан байх шаардлагагүй, учир нь нэхэмжлэгч нь төрийн эсрэг эсвэл аливаа өөр төрийн эрх баригчийн эсрэг төрийн дээд эрх мэдэлгүйн учраас захиргааны акт гаргаж чадахгүй юм байна.

Тэгэхлээр сөрөг нэхэмжлэлийн хүрээнд хариуцагч төрийн эрх баригчийн нэхэмжлэгчийн эсрэг эдлэх, олон нийтийн эрх зүйн үндэслэлтэй эрхийн тухай яригдана.

Төгсгөлд нь 70.2.2-т захиргааны хэрэг хянан шийдвэрлэх явцад нэхэмжлэлийн агуулга нь заавал захиргааны акт байх шаардлагагүй, учир нь энэ заалтаар бол нэхэмжлэлийн агуулга нь нэхэмжлэгч болон төрийн хоорондын эсвэл аливаа өөр төрийн эрх баригчийн хоорондын олон нийтийн эрх зүйн харьцаа байгаа эсэх асуулт юм. Ийм тохиолдолд захиргааны акт шүүх хуралдааны агуулга болохгүй.

Эдгээр таамаглалууд нь дараах дүгнэлтэнд хүргэж байна: монголын захиргааны хэргийг хянан шийдвэрлэх явцад зөвхөн захиргааны акт нэхэмжлэлийн агуулга болох биш харин хэдэн жилийн өмнөөс хэрэгжүүлсэн захиргааны шүүхийн харъяалал нь олон нийтийн эрх зүйн болон захиргааны эрх зүйн маргааны шийдвэрлэхэд үйлчилдэг байна.

Ингэснээр монголын захиргааны хэргийн шүүхийн харъяалал нь германы ЗХХШТХ-ийн 40 дүгээр зүйлд заасанчлан, өөр шүүхийн төрөлд харъяалагдах тухай хуулиар батлаагүй тохиолдолд, үндсэн хуулийн эрх зүйн шинж бус нийтийн эрх зүйн маргааныг хамаардаг захиргааны хэргийн шүүхийн харъяалалтай нилээд төстэй болсон байна,

Тэгэхлээр захиргааны актаас гадна эрх зүйн харьцаа болон нийтийн эрх зүйн шаардлага зэрэг нь хувь хүн болон төрийн эрх баригчийн нэхэмжлэлийн агуулга байж болох нь.

Доорхи жишээнд /ажлаасаа халагдсан/ албан хаагч – нэхэмжлэгч – захиргааны акт гаргуулах гэж нэхэмжлэл гаргаагүй, учир нь ажлын байрны тодорхойлт гаргах нь

тухайн тохиолдлын “шийдвэр” биш юм /3.1.4-ийг үз/ буюу захиргааны акт биш, харин захиргааны бусад арга хэмжээний нэг юм. Доорх жишээнд нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэлийн агуулга нь нийтийн эрх зүйн шинжтэй шаардлага юм.

Жишээ: нэг талаас захиргааны ажилтанг ажлаас халах үед ажлын байрны тодорхойлолт гаргаж өгөхийг нэхэмжлэлдээ шаардсан бөгөөд нөгөө талаас хариуцагч сөрөг нэхэмжлэлдээ тухайн ажилтан буюу нэхэмжлэгчид ашиглахаар олгосон, эзэмшилд нь байгаа мэргэжлийн номыг гаргаж өгөхийг шаарджээ. Энэ тохиолдолд шаардах эрхүүд ажил үүргийн харилцаа холбоотой байна.

Сөрөг нэхэмжлэлийг шүүх хуралдаан болохоос өмнө гаргах шаардлагатай байгаа нь германы захиргааны хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйгээс ялгаатай байна. Энэ нь монголын ЗХХШТХ-д тухайн хянан шийдвэрлэх ажиллагааг тодорхой хугацаанд эцэслэн шийдвэрлэхийг заасантай холбоотой.

Германы захиргааны хэргийг шүүх тухай хуультай харьцуулахад сөрөг нэхэмжлэлийг шүүх хуралдаан эхлэхээс өмнө гарсан байх ёстойг анхаарах хэрэгтэй; энэ нь тодорхой хугацаанд шүүх хуралдааныг дуусгах гэсэн монголын ЗХХШТХ-ийн гол зарчимтай холбоотой.

39.2 Энэ зохицуулалтад сөрөг нэхэмжлэлийн хувьд 32 дугаар зүйл нэгэн адил үйлчлэхийг заажээ. Сөрөг нэхэмжлэлд аливаа хөнгөлөлт үйлчилдэггүй байна.

39.3. Харин зарим тохиолдолд анхны нэхэмжлэл гаргах үед сөрөг нэхэмжлэл гаргахыг хориглодог нь германы захиргааны процессын эрх зүйтэй нийцэж байна /Германы ЗПХ-ийн 89.2 дугаар зүйлтэй харьцуул/.

Германы хууль тогтоогч нь 50 орчим жилийн өмнө захиргааны процессын тухай хуулийг батлахдаа нэг талаас захиргааны байгууллага, нөгөө талаас иргэн хоорондын захирах, захирагдах харилцаа сөрөг нэхэмжлэл гаргахад хамаарахгүй гэж үзэж байжээ.

Германы захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагааны хувьд сөрөг нэхэмжлэл ач холбогдол багатай.

40 дүгээр зүйл. Иргэн, албан тушаалтныг захиргааны хэргийн шүүхэд дуудан ирүүлэх

40.1. Шүүгч хэргийн оролцогч, гэрчийг шүүхийн мэдэгдэх хуудсаар захиргааны хэргийн шүүх болон шүүх хуралдаанд дуудан ирүүлнэ.

40.2. Шүүхийн мэдэгдэх хуудсыг бичих, түүнийг хүргэх, гардуулах болон хариуцлага хүлээлгэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 77.2-77.9-д заасныг баримтална.

40.1, 40.2. Хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид, гэрчүүдийг зарлан дуудах нь шүүхийн үүрэг мөн. 40 дүгээр зүйлд хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн үйлчилж байгаа зохицуулалтыг хэрэглэхээр заасан нь зөв зүйтэй юм.

41 дүгээр зүйл. Нэхэмжлэлээс татгалзах

- 41.1. Нэхэмжлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд нэхэмжлэлээсээ татгалзах эрхтэй.
- 41.2. Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсанаа бичгээр илэрхийлэх бөгөөд шүүх хуралдааны явцад нэхэмжлэлээсээ татгалзвал хуралдааны ажиллагааг дуусгаж, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаж, гарын үсэг зуруулна.
- 41.3. Нэхэмжлэлээсээ татгалзсан этгээд уг асуудлаар дахин нэхэмжлэл гаргах эрхээ алдах бөгөөд энэ нь бусад этгээд уг асуудлаар бие даасан нэхэмжлэл гаргахад саад болохгүй.
- 41.4. Шүүгч нэхэмжлэгчийн нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж хэргийг хэрэгсэхгүй болгох тухай захирамж гаргаж, захиргааны хэргийн шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийн асуудлыг шийдвэрлэнэ.

Ерөнхий зүйл

Нэхэмжлэгч, хариуцагч этгээдүүд нь нэхэмжлэлээс гэрээ байгуулах замаар татгалзаж болно. Нэхэмжлэгч дангаараа нэхэмжлэлээсээ татгалзаж болно. Нэхэмжлэлээс татгалзах гэдэг нь шаардах эрхээ шүүхэд хандах замаар хэрэгжүүлэхээс татгалзахыг хэлнэ. Нэхэмжлэлээс татгалзсныг материаллаг эрх зүйн шаардах эрхээс татгалзсанаас ялгаж авч үзэх хэрэгтэй. Учир нь нэгэнт шаардах эрх устаж алга болох тул материаллаг эрх зүйн татгалзал нь нэхэмжлэлийг үндэслэлгүй болгох үр дагавартай.

41.1.Нэхэмжлэлээс шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд татгалзаж болно. Нэхэмжлэгч нь нэхэмжлэлээ гаргахаас өмнө тухайн шаардах эрхээсээ татгалзсан атлаа нэхэмжлэл дахин гаргавал хүлээн авахаас татгалзана.

41.2.Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нилээд ач холбогдолтой тул түүнийг бичгээр илэрхийлнэ (1-р өгүүлбэр). Шүүх хуралдааны протоколд гарын үсэг зурсныг бичгэн хэлбэртэй нэгэн адил хүчинтэй гэж үзнэ.

41.3.Нэхэмжлэлээс татгалзсан тохиолдолд тухайн этгээд уг асуудлаар цаашид шаардах эрхээ алдах бөгөөд хянан шийдвэрлэх ажиллагааны үед түүнийг хэрэгжүүлэх эрхийг үгүйсгэнэ. Энэ нь шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болсноор тухайн асуудлаар дахин нэхэмжлэл гаргах боломжоо алдана /41.2/. Тухайн хэрэг маргаанаар дахин нэхэмжлэл гаргавал хүлээн авахаас татгалзана. Нэхэмжлэгчийн эрхийг эдлэх тул ийнхүү татгалзах нь нэхэмжлэгчийн эрх залгамжлагчийн хувьд нэгэн адил үйлчилнэ. Харин нэхэмжлэлээсээ татгалзах нь бусад этгээд тухайн хэрэг маргаанаар бие дааж нэхэмжлэл гаргахад саад болохгүй.

Германы жишээ: Хэрвээ эцэг эхийн буруугаас насанд хүрээгүй сургуулийн насны хүүхдээ сургуульд явуулаагүй бол эрх бүхий захиргааны байгууллагаас хоёуланд нь торгууль ногдуулж болно. Энэ тохиолдолд эх нь шаардах эрхээсээ татгалзах нь эцгийн эрх зүйн байдалд нөлөөлөхгүй бөгөөд дангаараа захиргааны хэргийн шүүхэд торгууль ногдуулсныг эсэргүүцэж нэхэмжлэл гаргах эрхтэй.

41.4.Нэхэмжлэлийг гаргасны дараагаар нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан тохиолдолд хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан заалт юм.

42 дугаар зүйл. Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх

- 42.1. Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хэмжээгээр хүлээн зөвшөөрч, энэ нь бусад этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхөөргүй, хуульд харшлаагүй байвал шүүгч хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай захирамж гаргана.
- 42.2. Шүүгч захирамж гаргахдаа захиргааны хэргийн шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийн асуудлыг шийдвэрлэнэ.
- 42.3. Энэ хуулийн 42.1-д заасан захирамжийг захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн нэгэн адил журмаар биелүүлнэ.

42.1.Нэхэмжлэлийг гаргасны дараагаар тухайн шаардлага үнэн зөв болохыг хариуцагч ойлговол түүнийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Нэг талаас хянан шийдвэрлэх шаардлагагүй ажиллагаанаас татгалзаж нөгөө талаас хариуцагчийн хувьд нэхэмжлэлийн шаардлагыг шууд хүлээн зөвшөөрснөөр нэгэнт яагдах нь ойлгомжтой хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах боломжтой болдог. Хүлээн зөвшөөрөх нь бусдын эрх ашигт харшлах ёсгүй. Нэхэмжлэлийн шаардлагыг хууль бусаар хүлээн зөвшөөрөхгүй байхыг шүүхээс хянах шаардлагатай. Гагцхүү энд дурдсан нөхцөл байдал хангагдсан тохиолдолд шүүгч нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагчаас хүлээн зөвшөөрснийг захирамжилж хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгоно.

42.2.Нэхэмжлэлээс татгалзсантай нэгэн адилаар захирамжинд шүүхийн зардал тэмдэгтийн хураамжийн асуудлыг зохицуулна.

43 дугаар зүйл. Нэхэмжлэгч, хариуцагч эвлэрэх

- 43.1. Нэхэмжлэгч, хариуцагч харилцан буулт хийж, нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх, шаардлагыг биелүүлэх арга замаа тодорхойлох зэргээр хоорондоо тохиролцож эвлэрлийн гэрээ байгуулж, маргаанаа дуусгавар болгож болно.

- 43.2. Нэхэмжлэгч, хариуцагч нар нь эвлэрсэн тохиролцоогоо бичгээр илэрхийлж, гарын үсгээ зурсан байна. Шүүх хуралдааны явцад эвлэрвэл хуралдааны тэмдэглэлд тусгаж, гарын үсэг зуруулна.
- 43.3. Нэхэмжлэгч, хариуцагч хоёрын эвлэрсэн нь хуульд харшлаагүй, эсхүл бусад этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй нь тогтоогдвол шүүгч эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай захирамж гаргаж, захиргааны хэргийн шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийн тухай асуудлыг шийдвэрлэнэ.
- 43.4. Энэ хуулийн 43.1.-д заасны дагуу эвлэрсэн бол уг маргааныг захиргааны шүүх дахин авч хэлэлцэхгүй.

43.1. 37.1.5-ийн дагуу шүүгч эрх зүйн маргааныг эвлэрлийн журмаар шийдвэрлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

Эвлэрлийн журмаар маргааны хэсгийг нь эсвэл маргааныг бүхэлд нь шийдвэрлэдэг. Оролцогчид асуудлыг шийдэж чадсан тохиолдолд эвлэрэлд хүрч болно. Төрийн эрх баригчдийн хувьд энд хязгаарлалт байгаа. Нийтийн эрх зүйн хууль тогтоомж эсвэл ерөнхий заалтуудыг эвлэрэлийг зохицуулахгүй. Олон нийтийн захиргааны зангилаа болсон тэгш эрхийн зарчим энд гол үүргийг гүйцэтгэнэ.

Жишээ: Нийтийн татвар тал дээр эрх зүйн маргаан гарсан бол төрийн байгууллага эвлэрэх зорилгоор төлөх хугацааг хойшлуулах эсвэл хэсэгчлэн төлөхийг зөвшөөрч болно. Барилга байгууламжийг зайлуулах тухай эрх зүйн маргаан гарсан бол албан байгууллага нь нэхэмжлэгчтэй эвлэрэхийн тулд жишээлбэл хүчингүй болгосон захирамжинд анх заасан байсан барилга байгууламжийг зайлуулах хугацаанаас илүү урт хугацааг олгосон.

Татварын хэмжээний тал дээр шүүхэд маргасан бол хариуцагч албан байгууллага татварын хэмжээг бууруулахдаа болгоомжтой байх хэрэгтэй, учир нь энд үүний эсрэг тэгш эрхийн зарчим байгаас гадна тухайн албан байгууллага захиргааны дотоод шалгалтаар хүнд байдалд орж болзошгүй.

43.2. Шүүх хуралдаанаас гадуур эсвэл шүүх хуралдааны явцад эвлэрэлд хүрч болно. Эвлэрсэн тохиролцоог бичгээр илэрхийлсэн байх тухай хуульд заасан байна; Мэдээж эвлэрсэн тохиролцоог тусгасан шүүх хуралдааны тэмдэглэлд гарын үсэг зурсанаар бичгээр илэрхийлэх тухай заалтыг хангаж байгаа юм. Эвлэрлийн гэрээ байгуулах тухай санаачлагыг оролцогчид эсвэл шүүхийн зүгээс гаргаж болно. 37.1.5-д зааснаас үзвэл ихэнхи тохиолдолд эвлэрэх санааг шүүх гаргадаг юм байна.

43.3. Эвлэрэл нь хууль зөрчих ёсгүй бөгөөд мэдээж бусдын эрхэнд халдах ёсгүй. Нэхэмжлэл гаргаснаас хойш байгуулсан эвлэрэлийн тохиролцоонд давхар шинжийг агуулна: энэ нь оролцогчдын эрх үүргийг зохицуулсан нийтийн эрх зүйн гэрээ, өөрөөр хэлбэл шүүх хуралдааныг зогсоох үйлчилгээтэй. Нэхэмжлэлээс татгалзахтай /41.4/ адил

мөн хариуцагч нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөхтэй /42.2/ адил шүүгч хуралдааныг зогсоож шүүх хурлын зардал болон бусад асуудлыг шийднэ. Шүүгч ингэхдээ эвлэрэлийг ямар ч эрх зүйн зөрчилгүй болохыг тогтоосон байна.

43.4.Эвлэрэлд хүрснээр нэхэмжлэгч хариуцагч нарын хоорондын маргаантай эрх зүйн харьцаа нь нэг мөсөн шийдэгдэнэ. Үүний үр дүнд захиргааны шүүх эвлэрлээр шийдэгдсэн маргааныг дахин авч хэлэлцэхгүй.

44 дүгээр зүйл. Нэхэмжлэлийн шаардлагыг нэгтгэх, тусгаарлах

44.1. Аль нэг захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд тухайн маргаантай хэрэг байгаа, эсхүл нэг нэхэмжлэгчээс өөр өөр хариуцагчид гаргасан нэхэмжлэлтэй хэд хэдэн хэргийг захиргааны хэргийн шүүх нэг ажиллагаагаар нэгтгэн хэлэлцэж болно.

44.2. Нэгтгэн гаргасан, эсхүл хэд хэдэн нэхэмжлэгч гаргасан буюу хэд хэдэн хариуцагчид холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн шаардлагатай нэг буюу хэд хэдэн хэргийг шүүгчийн захирамжаар тусгаарлаж болно.

44.1, 44.2.Нэхэмжлэлийн шаардлагыг нэгтгэх ба тусгаарлах нь шүүх хуралдааны ажлыг хялбарчлах үүднээс боломжтой юм. Нэхэмжлэлийн шаардлагыг нэгтгэх ба тусгаарлахыг зөвхөн шүүх шийдэх нь уг зорилгод нийцнэ. Нэхэмжлэлийн шаардлагыг нэгтгэх ба тусгаарлах талаар оролцогчид санал гаргах боломжтой ч зайлшгүй шаардлагатай биш бөгөөд энэ нь шүүхийн хувьд чухал биш.

45 дугаар зүйл. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх

45.1. Энэ хуулийн 46 дугаар зүйлд болон өөр хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүгч захирамж гаргаж, маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ.

45.2. Хэм хэмжээ тогтоосон захиргааны актыг зөвхөн хуульд зааснаар түдгэлзүүлж болно.

Ерөнхий зүйл:

45.1-ийн гол тулгуур санаа нь маргаан бүхий захиргааны акт, өөрөөр хэлбэл иргэнд үүрэг хүлээлгэсэн /жишээлбэл татвар төлөхийг шаардсан/ эсвэл ямар нэгэн аргаар иргэний эрхэнд халдсан захиргааны акт /тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нь хураах/.

Захиргааны актыг гаргаснаар тухайн байгууллага тодорхой зорилго мөрдөж байгаа юм, гэхдээ захиргааны акт биелсэн тохиолдолд л зорилгодоо хүрнэ.

Жишээ: үйлдвэрийг хаах, сурагчийг сургуулиас хасах, эзэмшлийн газрыг булаах.

Маргаан бүхий захиргааны актаас үүдэлтэй захиргааны хэргийн захиргааны актын биелэлтийг яаж зогсоох вэ гэсэн асуулт гарч ирж байна. Захиргааны хэргийн шүүх маргаан бүхий захиргааны актыг шүүж эхлэхээс өмнө захиргааны байгууллага

дуусгавар болгоогүй, эргэлтгүй нөхцөл байдлыг бий болгох дээр хууль тогтоогч санаа тавих хэрэгтэй.

45.1.46 дугаар зүйлийн нөхцөл үүсээгүй бөгөөд бусад өөр хууль тогтоомжоор хориглоогүй бол шүүгч маргаан бүхий захиргааны актыг гүйцэтгэх захирамж гаргана. Хариуцагч актыг биелүүлж, харин захиргааны актыг хууль зөрчсөнийг шүүх хуралдаанаар шүүгч тогтоож хүчингүй болгосноор /70.2.1/ шүүх хуралдаан дууссан тохиолдолд хууль бус актыг гүйцэтгэсний үр дагаварыг хариуцагч хариуцна /70.2.6/.

45.2.Эрх зүйн маргаан хэм хэмжээний хүчинтэй буюу хүчингүй тухай гарсан бол тухайн хэм хэмжээ нь зөвхөн нэхэмжлэгчийг хамаараад зогсохгүй ихэнхи тохиолдолд тодорхой бус тооны хүмүүсийг хамаарна. Нэг хүний нэхэмжлэл нь хэм хэмжээг шууд хүчингүй болгоно гэсэн үг биш юм. Хэм хэмжээг зохицуулахын тулд хуулийн тусгай зохицуулалт хэрэг болдог.

46 дугаар зүйл. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нөхцөл
46.1. Захиргааны актын биелэлтийг дараахь тохиолдолд түдгэлзүүлж болохгүй;

46.2. захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь бусдын амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, хуулийн этгээдэд илт хохирол учруулахаар бол;

46.3. иргэн, хуулийн этгээдээс албан татвар, төлбөр, хураамж гаргуулах тухай акт бол;

46.3. захиргааны журам зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэсэн болон уг зөрчлийг таслан зогсоох тухай захиргааны хяналтын байгууллага, албан тушаалтны шийдвэр бол;

46.4. хууль тогтоомжид заасан тохиолдолд үл маргалдах журмаар биелүүлэх бол.

Ерөнхий зүйл:

Захиргааны хэргийн шүүх хуралдаанаар захиргааны актын хүчин төгөлдөр эсэхийг шалгах аас өмнө захиргааны акт биелэгдэх ёстойг хууль тогтоогчид анхаарах ёстой. Тиймээс тодорхой нөхцлүүдэд шүүгч захиргааны актыг түтгэлзүүлдэг.

46.1.4.Захиргааны актын биелэлтийг түтгэлзүүлэхэд хуульд харшлах эсэхийг эхлээд тогтоох хэрэгтэй. Германы хуулиар жишээлбэл энэ бол дараах тохиолдлууд: цэргийн алба хаах зарлан дуудах хуудас /Цэргийн албаны хуулийн 33 дугаар зүйлийн 2 дугаар өгүүлбэрийн 35.1/ эсвэл аюулыг зайлуулах, жишээлбэл Амьтны тахлын тухай хуулийн 80 дугаар зүйл.

Ерөнхийдөө хууль тогтоогч биелэлтийг түтгэлзүүлэхийг хориглосон тухайн хуулиуд аль ч улсад байдаг. Ганц нэг тохиолдлыг шүүхээр зохицуулах тухай асуудал энд байхгүй.

46.1.1. Чухал эрх зүйн үнэт зүйлсд учрах аюулыг зайлуулахаар Захиргааны байгууллагын гаргасан захиргааны акт ойрийн хугацаанд биелэх боломжгүй бол ихээхэн хохирол учирч болзошгүй.

Жишээ:1. Захиргааны байгууллага байшин эзэмшигчид захиргааны акт гарган нурах аюултай байшингаа хүн орохооргүй болгож бэхэлж хамгаалахыг шаардах.

2. Цайны газрын эзэн гал тогооны эрүүл ахуйн байдлыг сайжруулах удаа дараалан тавьсан шаардлагыг биелүүлээгүй учир захиргааны байгууллага уг цайны газрыг хаахыг шаардах.

46.1.2. Татвар, зардал төлөхийг шаардсан тохиолдолд шүүгч захиргааны актын биелэлтийг түтгэлзүүлэх эрхгүй. Энэ зохицуулалтаар шаардлагатай нийтийн үйл ажиллагааны санхүүжилтыг баталгаажуулсан байна.

§46.1.2. Нийтийн төсвийн сангийн орлогыг төлөвлөж болохоор байлгах хэрэгтэй. Үүнээс гадна захиргааны акт биелэгдсний дараа нь хууль зөрчсөн нь шүүхээр тогтоогдож хүчингүй болсон бол захиргааны байгууллагаар хохирлыг нөхөн төлүүлэх амархан; нэхэмжлэгчид засаж болохгүй хохирол учраагүй.

Харин бусад захиргааны актын хувьд биелэгдсний дараа хууль бус гэдэг нь тогтоогдсон бол, жишээлбэл барилга байгууламжийг зайлуулах зэрэгт харьцангуй том асуудал үүсдэг.

45.1.2. Татвар-(Германы хуулиар).

Нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд төрөөс зохих хууль журмын дагуу бүх байгууллага, хүнээс шаардан гаргуулдаг мөнгөн нэхэмжлэлийг татвар гэнэ.

Хураамж гэж нийтийн захиргааны үүргээ хэрэгжүүлэх зорилгоор нэг талаас оногдуулсан мөнгөн нэхэмжлэлийг хэлнэ. Жишээлбэл, гадаад паспорт гаргуулахад төлдөг хураамж.

Зарлага гэж аливаа захиргааны үйлдлийг гүйцэтгэхэд оролцогч талуудад ногдуулах бүхий л хураамж, зардлыг хэлнэ.

§46.1.3. Захиргааны дотоод хяналт болон захиргааны шийдвэрийн гүйцэтгэлийн хувьд өөр журам үйлчилнэ

47 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа

47.1. Хуулиар тусгайлан хугацаа тогтоогоогүй бол захиргааны хэргийн шүүх нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш аймгийн төвд 40, нийслэлд 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

47.2. Хэргийг давж заалдах болон хяналтын шатны захиргааны хэргийн шүүхээс дахин хэлэлцүүлэхээр буцаасан бол уг хэргийг тухайн захиргааны хэргийн шүүх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

47.3. Шаардлагатай тохиолдолд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хугацааг тухайн захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор, 15 хоногоор 2 дахь удаагаа сунгаж болно.

47.4. Хугацааг тоолох, тодорхойлоход Иргэний хуульд заасан журмыг баримтална.

47.5. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусад хугацааг энэ хуулийн 47.1.-д заасан хугацааны дотор шүүх тогтоож болно.

47.1. Уг заалт нь захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаа нь тодорхой хугацаанд явагдаж дуусах ёстой гэсэн Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль (ЗХХШТХ)-ийн зарчимд нийцэж байна.

Нэхэмжлэлийг хүлээж авснаас хойш 30 буюу 40 хоногийн дотор анхан шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэх ёстой нь нэлээд шахуу хугацаа юм. Энэхүү хугацааг тогтоосноор хэргийн оролцогчид (32.2, 38.2-ыг үз)-оос гадна мөн шүүх (36.1-ийг үз)-ийг цаг хугацаагаар шахаж, асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэхийг шаардаж байна.

Гуч ба дөч хоногоор хугацааг тогтоосноор нийслэлийн шүүх ба аймгийн шүүхүүдэд ялгаатай хандаж байна. Ингэж хандсаны шалтгаан нь хот болон аймагт бодитойгоор нөлөөлөхүйц газар зүйн орон зайны асуудал хэмээн ойлгогдож буй. Харин эрх зүй улс төрийн талаас нь авч үзвэл нийслэл хот, аймгуудын хоорондын энэхүү ялгаа нь бусад зүйл дээр, тухайлбал гомдол гаргах хугацаан дээр адил байх ёстой бишүү гэсэн асуудлыг төрүүлж байна (6.1.).

Германы ойлголтоор 47.1-д заасан хугацаа нь дэндүү богино юм. Германы анхан шатны шүүх хэргийг ойролцоогоор тав дахин илүү хугацаанд хянан шийдвэрлэдэг юм.

47.2. Энэхүү заалт 47.1-тэй төстэй утгатай юм.

47.3. Төвөгтэй асуудлыг хянан шийдвэрлэхэд 47.1., 47.2.-т заасан хугацааг баримтлах боломжгүй байж болох юм. Иймд холбогдох шүүхийн шүүгчдийн зөвлөгөөн хугацааг хоёр удаа сунгаж болох нь ээ. Шүүгчдийн зөвлөлгөөний энэхүү бүрэн эрх нь 47.1., 47.2-т дурдсан хэргүүдэд хамаарах юм байна хэмээн ойлгогдож байна. Хугацааг шүүгчдийн зөвлөлгөөн үзэмжээрээ шийдвэрлэх аж.

Энэхүү зохицуулалт нь ерөнхийдөө практикийн чухал ач холбогдолтой.

47.5. Хэргийг хянан шийдвэрлэх явцад гарч болохуйц онцгой тохиолдолд хэрхэх асуудалд уян хатан хандаж, үзэмжээрээ шийдвэрлэх нэлээд өргөн боломжийг энэхүү заалт шүүхэд олгож байна. Тодорхой хэргийг хянан шийдвэрлэхэд цаг хугацаа шаардлагатай тохиолдолд хатуу тогтоосон хугацаа тийм ч оновчтой биш байдаг.

48 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх

48.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 80 дугаар зүйлийг баримтална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Шүүх хуралдааныг товлон зарлах, түүнд бэлтгэх

49 дүгээр зүйл. Шүүх хуралдааныг товлон зарлах

- 49.1. Захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэхэд хангалттай нотлох баримт цугларсан гэж үзсэн, эсхүл энэ хуулийн 47.1.-д заасан хугацаа дууссан, түүнчлэн шаардлагатай бусад тохиолдолд шүүгч захирамж гаргаж, шүүх хуралдааныг хэзээ, хаана болохыг товлон зарлана.
- 49.2. Хэргийн болон шүүх хуралдааны оролцогчдод шүүх хуралдаан хэзээ, хаана болох товыг шүүхийн мэдэгдэх хуудсаар мэдэгдэнэ.

49.1.Энэ заалт нь нотлох үүргийг шүүх хариуцах ёстой гэсэн мөрдөн шалгах зарчимд үндэслэгдэж байна. Тийм учраас цугларсан нотлох баримт хангалттай эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

49.2.Шүүх хуралдаан болох цаг хугацаа, газрын ач холбогдлыг бодолцон оролцогч талуудад энэ тухай мэдээллийг бичгээр хүргэх нь чухал. Бичмэл материал мөн нотлох баримт болдог.

- 50 дугаар зүйл. Шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг томилох
- 50.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, түүнчлэн хэргийг шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэх бол шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлд заасны дагуу томилно.

51 дүгээр зүйл. Иргэдийн төлөөлөгчийг томилох

- 51.1. Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийг Шүүхийн тухай хуульд заасны дагуу оролцуулна.
- 51.2. Тухайн шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасны дагуу томилно.
- 51.3. Энэ хуулийн 51.2.-т заасны дагуу томилогдсон иргэдийн төлөөлөгч нь татгалзан гарах үндэслэл байхгүй бол шүүх хуралдаанд заавал оролцоно.

51.1.Захиргааны хэргийн шүүх хуралдаанаас гадна мөн иргэний болон эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчдийг оролцуулдаг тул тэднийг сонгон шалгаруулах журам нь адилхан байвал зохино.

51.2.Иргэний төлөөлөгчид шүүх хуралдааны процесст хүчтэй нөлөөлөх боломжтойг харгалзан (56-р зүйлд холбогдох тайлбарыг үз) тодорхой хэргийг хянан

шийдвэрлэх шүүх хуралдааны иргэдийн төлөөлөгчдийг сонгон шалгаруулахад гадны хууль бус нөлөөлөл байж болохоос сэргийлэх нь зүйтэй.

51.3.Иргэдийг иргэдийн төлөөлөгчөөр сонгон шалгаруулахад тэдний зөвшөөрөл шаардлагатай. Нэгэнт сонгогдсон иргэн нь үүргээ хууль журмын дагуу гүйцэтгэж, тодорхой шүүхийн үйл ажиллагаанд оролцохоос дур мэдэн татгалзахгүй байх нь эрх зүйт төрийн зарчимд нийцнэ. Иймд хүндэтгэн үзэх бодит шалтгаан баймааж (жишээлбэл өвчний шалтгаан) иргэдийн төлөөлөгч оногдсон үүргийнхээ дагуу (ЗХХШТХ-ийн 51.3., 51.2., ИХ-ийн 79.2., 78.2) оролцох ёстой шүүх хуралдаанд оролцохгүй байх үндэслэл бий болно. Ийм шалтгаан байхгүй тохиолдолд тухайн иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд заавал оролцох үүрэгтэй.

Германы эрх зүйд ч иргэдийн төлөөлөгчдийг захиргааны хэргийн шүүх ажиллагаанд оролцуулах асуудлыг зохицуулсан байдаг. Тэднийг орон тооны бус шүүгчид хэмээн нэрлэнэ. Асуудлыг ганц шүүгч шийдвэрлэхээс бусад тохиолдолд анхан шатны шүүхэд хэргийг мэргэжлийн гурав, орон тооны бус хоёр шүүгч хянан шийдвэрлэнэ(ЗХХШТХ-ийн 5.3.).

Харин хоёр дахь шатны шүүхэд иргэдийн төлөөлөгчдийг оролцуулах эсэх асуудлыг тухайн муж улс өөрөө шийдвэрлэнэ. Тухайлбал, Бавари муж улсад 2 дахь шатны шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчдийг оролцуулдаггүй.

Харин монголын иргэдийн төлөөлөгчид, германы орон тооны бус шүүгчдийн хооронд нэгэн томоохон ялгаа байна: Германы орон тооны бус шүүгчид шүүх хуралдааны аман хэлэцүүлэг явуулах, мөн шүүхийн шийдвэр гаргахад мэргэжлийн шүүгчдийн адил эрх эдэлнэ(ЗХХШТХ-ийн 19-р зүйл). Тэд гэрч шинжээчдэд асуулт тавьж, мэргэжлийн шүүгчдийн адил санал гаргах эрхийг эдэлнэ. Тэд мөн мэргэжлийн шүүгчдийн адил хараат бус байна. Орон тооны бус шүүгчдийг таван жилээр сонгож (ЗХХШТХ-ийн 25-р зүйл), тэд мөн дахин сонгогдох эрхийг эдэлнэ.

Доктор/jur./, доктор/h.c./, проф. Хайнрих Шоллерийн тайлбар
(Үргэлжлэл)

ДОЛДУГААР БҮЛЭГ

Шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогч, хуралдааны нийтлэг журам

52 дугаар зүйл. Шүүх бүрэлдэхүүн

- 52.1. Захиргааны хэргийн шүүх дараахь хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ:
 - 52.1.1. энэ хуулийн 4.1.1-4.1.3-т заасан байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны акттай холбоотой;
 - 52.1.2. аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан захиргааны акттай холбоотой;
 - 52.1.3. урьд нь шүүгч анхан шатны журмаар дангаараа шийдвэрлэж гаргасан шийдвэр нь давж заалдах, эсхүл хяналтын шатны шүүхээс хүчингүй болсон.
- 52.2. Энэ хуулийн 52.1-д зааснаас бусад хэргийг захиргааны хэргийн шүүхийн шүүгч дангаар шийдвэрлэнэ.
- 52.3. Давж заалдах шатны журмаар хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.
- 52.4. Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхим 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.
- 52.5. Хяналтын шатны шүүх хуралдаанаас тогтоол гаргана. Тогтоолд шүүх хуралдаан даргалагч, илтгэсэн шүүгч гарын үсэг зурна. Тогтоолд анхан шатны болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын агуулга, түүний үндэслэл, гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тусгана.
- 52.6. Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолыг гомдол гаргагч этгээд хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хууль зөрчсөн үндэслэлээр Улсын дээд шүүхэд гомдол гаргаж болно. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл дүгнэлт гаргаж уг хэргийг Улсын дээд шүүхийн хуралдаанаар хэлэлцүүлнэ.
- 52.7. Ерөнхий шүүгчийн дүгнэлтэд гомдлын үндэслэл, хэрэг шийдвэрлэсэн байдал, хууль зөрчсөн гэсэн үндэслэлийг тусгасан байна.

52.8. Улсын дээд шүүхийн хуралдаан Улсын дээд шүүхийн нийт шүүгчдээс бүрдэнэ. Энэхүү хуралдаанаас тогтоол гаргах бөгөөд энэ нь эцсийн шийдвэр болно.

Хуульд бүрэлдэхүүнтэй байх тохиолдлыг жагсааснаас үзвэл зөвхөн зарчмын хувьд л шүүх бүрэлдэхүүнийг гурван шүүгчтэй байхаар заасан бололтой. Ялангуяа шийдвэрийг аймаг, нийслэлийн засаг дарга гаргасан 4.1.1-4.1.3 дахь хэсгийг онцолж нэрлэсэн байх юм.

Дараагийн зохицуулалтад шүүгч дангаар шийдэх хэргийг заасан байх бөгөөд эндээс шүүгч ерөнхийд нь дангаар шийдэх журамтай болох нь харагдаж байна. Харин давж заалдах журмаар хэрэг шийдвэрлэхэд бодит бүрэлдэхүүн нь 3 шүүгч байна. Хяналтын шатны журмаар хэргийг 5 шүүгч шийдвэрлэхээр нэмэгдүүлжээ. Харин хяналтын шатны журмаар шийдвэр гаргах, гарын үсэг зурж тогтоол гаргах журмын талаар нэмэлт зохицуулалт тусгагджээ.

Түүнчлэн тодорхой хугацааны дотор нэхэмжлэгч хяналтын шатны шүүхээс гаргасан шийдвэрийг эсэргүүцэж дээд шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй байна. Ингэснээр шүүхийн шийдвэрийг давж заалдах өөр нэг хэрэгслийг тусгажээ.

Дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг шийдвэрлэх журмыг оруулжээ (52.6, 52.7). Нийт шүүгчдийн хуралдаанаас гарсан шийдвэрийг үндэслэн тогтоол гарах бөгөөд энэ нь эцсийн шийдвэр болно (91 дүгээр зүйл).

53 дугаар зүйл. Шүүгч буюу шүүх бүрэлдэхүүнийг солих

53.1. Шүүгч буюу шүүх бүрэлдэхүүнийг солиход Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 83 дугаар зүйлийг баримтална.

Шүүгч буюу шүүх бүрэлдэхүүнийг бүхэлд нь солиход ИХШХШТХ-ийн 83 дугаар зүйлийг баримтлахаар заажээ.

54 дүгээр зүйл. Шүүх хуралдаанд оролцогч

54.1. Шүүх хуралдаанд оролцогчийг энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хэргийн болон бусад оролцогч гэж ангилна.

54.2. Шүүх хуралдаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгч, прокурор, нэхэмжлэгчийн болон хариуцагчийн төлөөлөгч, өмгөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг бусад оролцогч гэнэ.

Оролцогчдын хүрээг хуулиар 16 дугаар зүйлийн дагуу тодорхойлжээ. Энд дурдсан бусад оролцогчдыг тодорхойлж, тоог ч нэг мөр жагсаажээ. Түүнээс гадна орчуулагч, шинжээч, нарийн бичгийн дарга, хэлмэрч зэргийг нэг бүрчлэн зааж өгчээ.

Оролцогчдыг энд нэрлэх болсон шалтгаан нь тэдгээрийн хүрээ хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тогтоогдох нь элбэгт оршиж байгаа болов уу.

55 дугаар зүйл. Шүүх хуралдаанд прокурор оролцох

- 55.1. Прокурор шүүх хуралдаанд төрийг төлөөлөн оролцох бөгөөд захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны хууль зүйн үндэслэлийн талаар дүгнэлт гаргана.
- 55.2. Прокурор захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Прокурор нь шүүх хуралдааны үеэр төрийг төлөөлж оролцдог. Прокурор бусад оролцогчдын нэгэн адилаар дүгнэлт гаргах эрхтэй байх агаад энэ нь захиргааны байгууллага албан тушаалтны арга хэмжээ, үйлдлийг хамаарна. Харин энэ зохицуулалт дахь албан тушаалтан гэснийг арай өргөн утгаар нь, хэрвээ 4 дүгээр зүйлд заасан байгууллагыг төлөөлж буй ажилтныг хамруулж үзнэ. Прокурорын хувьд захиргааны хянан шийдвэрлэх ажиллагааны үед ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлд заасан эрхийг эдэлнэ.

56 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгч, түүний эрх, үүрэг

- 56.1. Захиргааны хэргийг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд 3 хүртэл иргэдийн төлөөлөгч оролцуулна.
- 56.2. Иргэдийн төлөөлөгч нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:
- 56.2.1. шүүхийн байранд хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх;
 - 56.2.2. нотлох баримт шинжлэхэд оролцох;
 - 56.2.3. нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд, гэрч, шинжээчид асуулт тавих;
 - 56.2.4. нэмэлт нотлох баримт цуглуулах талаар хүсэлт гаргах;
 - 56.2.5. хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн гэм буруутай эсэхийн талаар дүгнэлт гаргах;
 - 56.2.6. өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлыг задруулахгүй байх;
 - 56.2.7. энэ хуульд заасан шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэх.
- 56.3. Энэ хуулийн 56.2.5-т зааснаар хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн гэм буруутай эсэхийн талаар гаргасан иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүх хуралдаанд уншиж сонсгоно.

Монголын захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны өөр нэг онцлог нь иргэдийн төлөөлөгчийн оролцоо юм. 56 дугаар зүйлд түүний эрх үүргийг тодорхойлсон байх бөгөөд хуулийн дагуу оролцох шаардлагатай тохиолдлуудыг зохицуулжээ.

Анхан шатан дахь шүүх бүрэлдэхүүн гэснийг хамтын буюу 52.1.1-3-т заасан 3 шүүгчийн бүрэлдэхүүн гэж ойлгох болов уу.

56.2-т иргэдийн төлөөлөгчдийн эрхийг нэгбүрчлэн нэрлэжээ. Иргэдийн төлөөлөгчдийг нотлох баримт шинжлэх, цуглуулахад мэдээлэл авах, оролцох, асуулт тавих зэрэгт түүний эдлэх эрхээс үзэхэд үнэхээр шүүгчидтэй нэгэн адил хэмжээтэйгээр хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжтой болох нь харагдаж байна. Шүүхийн шийдвэрээс тусдаа өөрийн гэсэн дүгнэлтийг гаргах эрхтэй бололтой. Гэхдээ энэ дүгнэлт гагцхүү маргааны зүйл хэргийн оролцогчдын гэм буруугаар хязгаарлагдаж байна.

Ийнхүү томъёолсон нь хоёр асуулт тавихад хүргэж байна: нэгт, маргааны зүйлтэй холбогдуулан дүгнэлт гаргана гэдэг нь холбогдох бүх асуудлыг судлахыг зөвшөөрнө гэж ойлгох, эсхүл маргаан бүхий зүйлийг хүлээн зөвшөөрөх эсвэл хүлээн зөвшөөрөх боломжгүйг зааглаж хязгаарлахад төвлөрнө гэж ойлгох уу? Маргааны зүйл гэсэн ойлголтын нэг хэсэг болох хэргийн оролцогчдын гэм бурууг тусад нь тусгасан байх тул түүнийг өргөн утгаар нь ойлгох шаардлагагүй гэж дүгнэх боломжтой байна.

Харин нөгөө талаас эрүүгийн шинж чанаргүй захиргааны маргааны үед гэм буруу гэсэн ойлголтыг хэрэглэх учир дутагдалтай мэт. Гэхдээ энэ төрлийн маргаанд албаны хариуцлага, түүнийг дагаад хохирол нөхөн төлөх асуудал зэргийг захиргааны шүүх шийдвэрлэх шаардлага гарч, санаатай, болгоомжгүй үйлдлүүд илэрдэг тул гэм буруугийн элементийг онцгойлон заах нь зүйтэй. Иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлтийг шүүх хуралдааны үеэр уншиж танилцуулдаг тул шүүх уг дүгнэлтэд агуулагдсан асуудлуудыг эрчимтэй судалж, дүгнэлтийг эцсийн шийдвэр гаргахдаа харгалзах шаардлагатай болно.

57 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга

57.1. Захиргааны хэргийн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь шүүх хуралдаан явуулах бэлтгэлийг хангаж, шүүх хуралдааны ирцийг бүртгэж, шүүгч, шүүх бүрэлдэхүүнд танилцуулах, хуралдааны ажиллагааг тэмдэглэл үйлдэн баталгаажуулах, шүүхийн шийдвэрийг хүргүүлэх, гүйцэтгэх хуудах олгох, хүргүүлэх, хэргийг цэгцэлж, үдэх, архивт шилжүүлэх ажиллагааг гүйцэтгэнэ.

58 дугаар зүйл. Гэрч

58.1. Захиргааны хэргийн шүүхээс маргааныг шударгаар шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байдлыг мэдэж байгаа этгээдийг гэрч гэнэ.

58.2. Гэрч захиргааны хэргийн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирж, хэргийн талаархи мэдээлэл, нөхцөл байдлыг мэдүүлэх үүрэгтэй.

- 58.3. Гэрч үнэн зөв мэдүүлэг өгч, шүүгч, хэргийн оролцогч болон хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчийн асуултад хариулна. Гэрчүүдийг нүүрэлдүүлэн мэдүүлэг авахдаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 43.6.-д заасан журмыг баримтална.
- 58.4. Санаатайгаар худал мэдүүлэг өгсөн, эсхүл мэдүүлэг өгөхөөс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан, зайлсхийсэн гэрчид Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 58.5. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүхийн дуудсанаар ирж чадахгүй гэрчээс байгаа газарт нь очиж мэдүүлэг авч болно.
- 58.6. Гэрч шүүхийн дуудсанаар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг албадан ирүүлэхийг шүүхээс цагдаагийн байгууллагад даалгаж, холбогдох зардлыг гэрчээр гаргуулахаар тогтоож болно.

I. Гэрчийн байдлын талаарх ерөнхий зүйл

Энэхүү зохицуулалт нь гэрчийг бусад оролцогчдоос ялгах зорилгоор нарийн тодорхойлсон байна. Гагцхүү тухайн маргааныг шударгаар шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, байдлыг мэдэж байгаа тохиолдолд гэрч байна. Өөрөөр хэлбэл түүний мэдэж буй зүйлс нь ач холбогдолгүй, гагцхүү сонирхол татахуйц, эсвэл шинж чанарын дүрслэл төдий байж болохгүй. Тухайн дүрслэл нь ач холбогдолтой бол шинжээч түүнийг үнэлж дүгнэлт гаргана.

II. Бусад зүйл

Ингээд үнэн зөв мэдүүлэг өгөх, шүүхэд хүрэлцэн ирэх, хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үнэн зөв хариулах гэрчийн бусад үүргийг нэрлэсэн байна. Гэрчүүдийг нүүрэлдүүлэн мэдүүлэг авахдаа ИХШШТХ-ийн 43.6.-д заасан журмыг баримтлахаар заасан нь зөв байна. Түүнчлэн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүхийн дуудсанаар ирж чадахгүй гэрчээс байгаа газарт нь очиж мэдүүлэг авч болохоор заажээ. Харин гэрч нь худал мэдүүлэг өгсөн, эсхүл түүнийг албадан ирүүлсэн бол Эрүүгийн хуулийг хэрэглэхээр тогтоож болохыг заажээ.

59 дүгээр зүйл. Шинжээч

- 59.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгайлан эзэмшсэн мэдлэгтэй, уг хэргийн талаар хувийн болон албаны сонирхолгүй, энэ хуульд заасны дагуу захиргааны хэргийн шүүхээс томилогдсон этгээдийг шинжээч гэнэ.

- 59.2. Нотлох баримтыг шинжлэх даалгавар авсан этгээд захиргааны хэргийн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирж, тавигдсан асуудлаар бодитой дүгнэлт өгнө.
- 59.3. Шинжлүүлэхээр өгсөн материал хангалтгүй, эсхүл оногдсон үүргийг биелүүлэхэд эзэмшсэн мэргэжил, мэдлэг нь шаардлага хангахгүй гэж үзвэл шинжээч дүгнэлт өгөхөөс татгалзаж болно.
- 59.4. Шинжээч нь дүгнэлт өгөхөд шаардлагатай гэж үзвэл хэргийн материалтай танилцах, асуулт тавих, нэмэлт материал гаргаж өгөх тухай хүсэлтээ шүүхэд гаргах эрхтэй.
- 59.5. Санаатайгаар худал дүгнэлт өгсөн, эсхүл дүгнэлт өгөхөөс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан шинжээчид Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 59.6. Шинжээч байгууллагаас томилогдсон бол тухайн байгууллагын нэрийн өмнөөс, бусад шинжээч өөрийн нэрийн өмнөөс дүгнэлтээ бичгээр гаргаж, түүний үнэн зөвийг хариуцна. Дүгнэлтэд ямар шинжилгээ хийсэн, түүний үндсэн дээр гарсан дүгнэлт, шүүгчээс тавьсан асуултад өгсөн үндэслэл бүхий хариултыг тодорхой бичнэ. Шинжээч хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдлыг олж тогтоовол энэ талаар шүүхээс асуулт тавигдаагүй ч гэсэн дүгнэлтээ оруулах эрхтэй.
- 59.7. Шаардлагатай тохиолдолд шүүгч хэд хэдэн этгээдийг шинжээчээр томилж болох бөгөөд тэдгээр нь санал нэгтэй байвал нэг дүгнэлт гаргаж, гарын үсгээ зурна. Харин аль нэг шинжээч бусад шинжээчийн дүгнэлттэй санал нийлэхгүй байвал дүгнэлтээ тусад нь гаргаж болно.
- 59.8. Дахин шинжээч томилох тохиолдолд өмнө нь уг хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргахад оролцсон этгээд оролцохгүй.

Шинжээчийг нарийн тодорхойлсны дараагаар шинжээчийн дүгнэлтийг гаргах талаар хуульд тайлбарыг тусгажээ. Шинжээчдийг шүүхээс шинжээчийн хувьд тодорхойлж буй нь ач холбогдолтой юм (59.1). Шинжээч захиргааны хэргийн шүүхээс дуудсанаар ирж бодитой, объектив дүгнэлт гаргах үүрэгтэй. Объектив гэснийг төвийг сахисан дүгнэлт гаргахыг ойлгоно. Өөрөөр хэлбэл шинжээч нь дүгнэлт гаргахдаа хэрэгт хамаарахгүй зүйлээр, аль нэг талыг баримталсан, гэр бүлийн холбоотой болоод объектив бусад хүчин зүйлийг удирдлага болгож болохгүй. 59.4-т зааснаар шинжээч нь нотлох материал хангалтгүй байна гэж үзвэл асуулт тавих, хэргийн баримттай танилцах, бусад хүсэлт тавих эрхтэй. Харин шинжлүүлэхээр өгсөн материал хангалтгүй, эсхүл хэргийн талаарх мэдлэг нь шаардлага хангахгүй гэж үзвэл шинжээч дүгнэлт өгөхөөс татгалзаж болно.

Энэ зохицуулалтад нэхэмжлэгч, түүний төлөөлөгч, эсхүл прокурор зэрэг бусад этгээдүүд нотлох баримт цуглуулахад оролцох, асуулт тавих эрхтэй эсэхийг заагаагүй байна. Харин дүгнэлтийн агуулгын шаардлагын талаар хуульд заажээ (59.6). Үүнээс гадна шинжээчийн хараат бус, төвийг сахисан байдлыг хангахад хуулиар анхаарчээ.

60 дугаар зүйл. Орчуулагч, хэлмэрч

- 60.1. Хэргийн оролцогч монгол хэл мэддэггүй, эсхүл хэлгүй, дүлий бол түүний хүсэлтээр орчуулагч, хэлмэрчийг захиргааны хэргийн шүүгч захирамж гарган томилно.
- 60.2. Орчуулагч, хэлмэрч захиргааны хэргийн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирж, тухайн этгээдийн нэхэмжлэлийн шаардлага, тайлбар, мэдүүлэг, татгалзал буюу оролцогчийн шаардлага, тайлбар, мэдүүлэг, татгалзал, шүүх хуралдааны болон бусад ажиллагаа, шүүхийн шийдвэрийн агуулгыг үнэн зөв, бүрэн орчуулж, хэлмэрчилж өгөх, хэргийн материалтай цаг хугацаанд нь танилцахад туслах үүрэгтэй.
- 60.3. Орчуулагч, хэлмэрч нь орчуулгыг тодруулахаар асуулт тавьж болно.
- 60.4. Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогч орчуулагч, хэлмэрчийн үүрэг гүйцэтгэхийг хориглоно.
- 60.5. Санаатайгаар буруу орчуулсан, хэлмэрчилсэн, эсхүл орчуулга хийхээс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан хэлмэрчид Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

60.5. Энд орчуулагч, хэлмэрч гагцхүү асуулт тавих эрхийг эдлэх юм байна. Үнэн зөв орчуулах, хэлмэрчлэх үүргээ зөрчих, эсхүл орчуулах, хэлмэрчлэх үүргээсээ татгалзсан тохиолдолд түүнд шинжээчийн нэгэн адил 59-р зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэх юм байна. Мөн энд ч эрүүгийн хуулийн тодорхой зүйл ангийг зааж өгөөгүй байна. Харин шинжээчдийг томилох журмаас ялгаатай нь орчуулагч, хэлмэрчдийг гагцхүү шүүхээс томилогдон зөвшөөрөгдсөн бүрэлдэхүүнээс авч ажлуулах тухай зохицуулалт үгүйлэгдэж байна. Тийм учраас орчуулагч, хэлмэрчийн мэргэжлийн ур чадварт тавигдах шаардлагын асуудал орхигдожээ. Үүнд мөн шинжээчдэд тавигдаг шаардлагын нэгэн адил заалт байх нь зүйтэй юм. Иймд орчуулагч, хэлмэрчдийг шүүхээс гаргасан нэрсийн жагсаалтын дагуу шүүх ажиллагаанд оролцуулах нь зөв болно.

61 дүгээр зүйл. Шүүх хуралдаан

- 61.1. Энэ хуулийн 42, 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд захиргааны хэргийг гагцхүү шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

I. Ерөнхий зүйл

Энэ зохицуулалт нь шинжээчийн тухай зохицуулалтаас ялгаатайгаар орчуулагч, хэлмэрчийг шүүхээс томилсон мэргэжилтэн шаардлагатай эсэхийг дурдаагүй байна. Тиймээс орчуулагч, хэлмэрчийн мэргэжлийн түвшинг хэрхэн тогтоох талаар зохицуулалт алга. Тиймээс шинжээчийг томилохтой холбоотой журмыг энд мөн адилаар хэрэглэх нь зөв болов уу. Орчуулагч, хэлмэрчийг шинжээчдийн нэгэн адилаар тодорхой жагсаалтаас сонгодог байх нь зөв.

II. Шүүх хуралдааныг амаар явуулах

Хуулиар захиргааны хянан шийдвэрлэх ажиллагааг мөн адил амаар явуулах зарчмаар тогтоожээ. Энэ зарчим нь “шүүх хуралдаан” гэсэн ойлголтоос урган гарч байна. 42, 43 дугаар зүйлүүдэд тодорхой заагаагүй бол хянан шийдвэрлэх ажиллагааг бичгээр явуулах боломжгүй. Гэхдээ эдгээр заалтуудыг хянан шийдвэрлэх ажиллагааг амаар явуулах үндсэн зарчмаас гадуур онцгой тохиолдол гэж үзэж болно. Харин “шүүх хуралдааныг” гэсэн ойлголт зарим тохиолдолд бэрхшээл учруулж болох юм.

Учир нь шүүх хуралдааныг нөхцөл байдал өөрчлөгдсөн бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол нэг л эхлүүлсэн бол тасалдуулж болохгүй, дуустал явуулна гэж ойлгогдож магадгүй (20.1.4).

62 дугаар зүйл. Шүүх хуралдаан даргалагч, түүний эрх, үүрэг

- 62.1. Захиргааны хэргийг шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байгаа бол тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс томилогдсон шүүгч, Ерөнхий шүүгч шүүх бүрэлдэхүүнд орж байгаа тохиолдолд Ерөнхий шүүгч, дангаар хэргийг хянан шийдвэрлэж байгаа бол шүүгч шүүх хуралдааныг тус тус даргална.
- 62.2. Шүүх хуралдаан даргалагч хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу явуулах, хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох, хэргийн оролцогч эрх, үүргээ хэрэгжүүлэх, мэтгэлцэх зарчмыг хангах, шүүх хуралдааны дэгийг сахиулах талаар шаардлагатай арга хэмжээ авна.

Энд шүүх хуралдааны үед буюу тодорхойлбол шүүх хуралдааны өмнө хойно бусад тодорхой ажиллагаа хэрэгждэг тул хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үеийн турш дахь шүүх хуралдааны даргалагчийн ажил үүргийг тодорхойлжээ. Ингэхдээ хуульд шүүхийн зөвлөгөөнөөс томилогдсон шүүх бүрэлдэхүүний даргалагчийг тодорхойлжээ.

Харин ерөнхий шүүгч шүүхийн бүрэлдэхүүнд орж байгаа бол шууд даргалагчийн үүргийг гүйцэтгэнэ. Харин хэргийг дангаар хянан шийдвэрлэж байгаа бол тухайн шүүгч даргална гэсэн нь илүү болов уу. ...Учир нь ИХ-д зааснаар дангаараа хэрэг шийдвэрлэж байгаа шүүгч хуралдааныг даргалж буй шүүгчийн эдэлдэг бүх эрх мэдлийг эдэлнэ (ИХ-ийн 90-р зүйл).

Шүүх хуралдаан даргалагч хянан шийдвэрлэх ажиллагааг зохих журмын дагуу явуулахад “шаардлагатай арга хэмжээ авах” гэдэг нь түүний гол үүрэг бололтой. Энэ тохиолдолд “шаардлагатай арга хэмжээ” гэдгийг тодруулах шаардлагатай. Учир нь тодорхой бус шүүх өөрийн үзэмжээр шийдвэрлэх боломжгүй эрх зүйн ойлголт бөгөөд

давж заалдах, хяналтын шатанд шалгаж болох юм. Цаашилбал бусад үүргийг жагсаасан байх агаад, мэтгэлцэх зарчим гэснийг яаж ойлгох тухай асуулт гарч ирж байна.

“Талуудын” зарчим нь ялангуяа Монголын ИХШХШТХ-д тусгалаа олж, эрх зүйт төр бүхий ихэнх орны иргэний процессийн хуулиудад үндсэн зарчим болж төлөвшсөн бөгөөд нэхэмжлэгч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч нь хянан шийдвэрлэх ажиллагааны явцад маргааны зүйлийг удирдана гэсэн ойлголт билээ. Тэрээр нэхэмжлэл гаргах, давж заалдах, нэхэмжлэлээ аль ч үед татан авах, өргөдөл хүсэлт гаргах, түүний шаардлагыг өөрчлөх, өргөжүүлэх, татан авах эрхтэй байдаг (19, 20 дугаар зүйл). Энэ эрхийг хариуцагч буюу энэ тохиолдолд төр, түүний эрх олгосон бусад байгууллага, нийслэлийн буюу аймгийн захиргаа мөн адил эдэлдэг. Харин эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагаанд эсрэгээрээ, инквизицийн буюу мөрдөн шалгах зарчим үйлчилдэг.

Энэ тохиолдолд хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх, явуулах, дуусгах санаачлага эрүүгийн шүүгчээс гардаг. Захиргааны шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаа нь Монголд бусад орчин үеийн эрх зүйт төрийн зарчимд нийцүүлэн дээрх зарчмаар явагддаг бөгөөд энэхүү зарчмыг Үндсэн хуулиндаа тусгасан байдаг.

Германы хувьд хэдийгээр талууд биш оролцогчид гэсэн ойлголтыг илүү хэрэглэдэг авч захиргааны хянан шийдвэрлэх ажиллагааг дээрх зарчимд тулгуурлан иргэний процесстай төстэй байдлаар хэрэгжүүлдэг.

Энэ хуульд тодорхой бус эрх зүйн гурван ойлголт тусгагдсан байна: шаардлагатай арга хэмжээ, бодитойгоор тогтоох, мэтгэлцэх зарчим.

Эдгээр ерөнхий ойлголт нь янз бүрийн утга агуулгатай байж болохоор хэдий боловч хууль тогтоогч түүнийг тайлбарлагүй байна. Эдгээр ойлголтууд нь янз бүрийн утга агуулгатай байж болох тул хэвшмэл хэллэг, түүний дотор эрх зүйн хэллэгэд үндэслэж үл болно.

Иймд тэдгээрийн тайлбарыг дараах баримт бичигт тусгах боломжтой мэт.

Үүнд: Дээд шүүхээс хянан шийдвэрлэсэн захиргааны, иргэний буюу эрүүгийн хэрэгт уг асуудлыг шийдвэрлэсэн эсэх. Хэрвээ тийм бол тухайн хэргийг урьд нь гаргасан шийдвэртэй шууд (автоматаар) холбож үзэх нь учир дутагдалтай. Учир нь одоогийн хэрэг нь түрүүчийн хэрэгтэй адил эсэхийг шалгах шаардлага гарна. ЗХХШТХ-ийн 88-р зүйлд зааснаар бол зөвхөн дээд шүүхээс урьд нь гаргасан шийдвэр, захирамжууд захиргааны хэргийн шүүхийн хувьд дагаж мөрдөх хүчинтэй байдаг байна. Энэхүү дагаж мөрдөх ёстой шийдвэр гараагүй болон хуульд энэ талаархи заалт үгүй бол тухайн хуулийн заалтын утга агуулгыг системчилсэн тайлбараар тодруулах шаардлагатай.

Системчилсэн тайлбар гэдэг нь захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн бүхий л хэм хэмжээнээс тодорхой бус эрх зүйн ойлголтын утга учрыг олж илрүүлэх гэсэн үг юм. Үүнд:

а) шаардлагатай арга хэмжээ:

хуульд тусгайлан заасан арга хэмжээг шаардлагатай арга хэмжээ гэнэ. Жишээлбэл, 63-р зүйлд заасны дагуу шүүх хуралдаанд оролцогчид шүүхийг хүндэтгэх, тогтоосон журмыг сахих, тухайлбал суудлаасаа босох үүрэгтэй. Энэхүү зорилтыг биелүүлэх үүднээс сануулах, журам зөрчсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зэрэг нь шаардлагатай арга хэмжээ байж болох юм. Шаардлагатай арга хэмжээ гэдэг нь

ялангуяа үнэн зөвийг олж тогтоохын тулд шүүх нэмэлт нотлох баримт цуглуулах зарчим буюу мөрдөн шалгах зарчимтай холбогдож гарна.

б) “байдлыг бодитойгоор тогтоох” буюу бодит үнэлгээ:

мөн энэ тохиолдолд хэвшсэн хэллэг гэхээсээ илүү хуульд энэ талаар хэрхэн тусгасныг авч үзэх нь зүйтэй. 85-р зүйлийн дагуу давж заалдах шатны хуралдаан дээр илтгэгчийн үүрэг гүйцэтгэж байгаа шүүгч нь оролцогч талуудаас анхан шатны шүүх дээр өгсөн мэдүүлгийг үнэн зөв танилцуулах, мөн үүний дараа шүүх бүрэлдэхүүн асуулт тавихдаа нэхэмжлэгч, хариуцагч нарт адил тэгш боломж олгох явдал нь хэргийн байдлыг бодитойгоор тогтоох тухай ойлголтод хамаарна.

Бодит байдлыг хангахын тулд оролцогч талуудад адил тэгш боломж олгогдсон байх ёстой (“адил зэвсгээр хангах”).

Талууд “адил зэвсэгтэй байна” гэдэг нь мэтгэлцэх зарчмын нэгэн шинж тэмдэг юм.

в) мэтгэлцэх зарчим: Дээр дурдсанчлан энэхүү зарчмын гол шинж тэмдэг нь нэхэмжлэгч, хариуцагч нарыг аль болохоор адил тэгш боломжоор хангах явдал юм. Тэгсэн хэдий боловч мэтгэлцэх зарчим нь энэхүү заалтын үндсэн дээр ямар ч хэмжээ хязгааргүй үйлчилнэ гэсэн үг биш гэдгийг анхаарах нь зүйтэй. Учир нь хууль өөрөө түүнийг хэд хэдэн заалтаар хязгаарлаж байна.

Үүнд тухайлбал нотлох баримт цуглуулахад мөрдөн шалгах зарчим үйлчлэх буюу нэг тал нь давж заалдах, нөгөө тал нь хяналтын журмаар гомдол гаргасан бол хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэх тухай 81-р зүйлийн заалт хамаарна. Ийм тохиолдолд хяналтын журмаар гаргасан гомдлыг авч хэлэлцэхгүй түүнийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ. Мөн 89.2-ын заалт ч мэтгэлцэх зарчмыг хязгаарласан байгаа бөгөөд энэ заалтын дагуу бол нотлох баримтын талаархи санал хүсэлтийг хугацаанаас хожимдуулж гаргавал түүнийг давж заалдах шатанд авч үзэхгүй.

Эдгээр хэм хэмжээ тогтоосон санаа бодлыг энэхүү хэмжээгээр хуулийн тайлбарт оруулах боломжгүй юм. Харин дараах байдлаар томъёолж болох талтай. Үүнд: мэтгэлцээний зарчимд үндэслэсэн процесс гэж оролцогч талууд нь хэргийн талаар диспозиц (эрхтэй)-той, өөрөөр хэлбэл нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлээс татгалзах эсхүл түүнийг өөрчлөх эрх эдлэхийг хэлнэ. Энэ зарчим нь ЗХХШТХ өөрөө энэхүү диспозицийн зарчимд хязгаарлалт тогтоох, жишээлбэл мөрдөн шалгах зарчмыг баримтлах буюу бусад зүйл ангид, тухайлбал ЗХХШТХ-ийн 81, 89-р зүйлд заасан хязгаарлалтыг хүртэл үйлчилнэ.

63 дугаар зүйл. Шүүх хуралдааны нийтлэг журам

63.1. Шүүх хуралдааны танхимд байгаа бүх хүн захиргааны хэргийн шүүхийг хүндэтгэх, хуралдааны танхимд тогтоосон журмыг сахих, хуралдаан даргалагчийн шийдвэрт захирагдах үүрэгтэй.

63.2. Шүүх хуралдаанд оролцогч тайлбар, мэдүүлэг өгөх, дүгнэлт гаргахдаа суудлаасаа босно.

- 63.3. Хуралдаанд оролцогч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас суудлаасаа босч чадахгүй бол хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр суугаагаараа үг хэлж болно.
- 63.4. Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч хуралдааны танхимд орж ирэх, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг уншиж сонсох үед танхимд байгаа бүх хүн суудлаасаа босно.
- 63.5. Шүүх хуралдааны журам зөрчсөн этгээдэд эхний удаа хуралдаан даргалагч урьдчилан сануулна. Дахин зөрчил гаргасан этгээдийг хуралдаан даргалагчийн захирамжаар шүүх хуралдааны танхимаас гаргаж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан журмаар торгууль ногдуулна.
- 63.6. Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, гэрч, шинжээчийг шүүх хуралдааны танхимаас гаргасан тохиолдолд хуралдаан даргалагчийн захирамжаар шүүх хуралдааныг тодорхой хугацаагаар хойшлуулах, эсхүл тэдгээрийн тайлбар, мэдүүлгийг сонсохгүйгээр захиргааны хэргийг хянан шийдвэрлэх боломжтой гэж үзвэл үргэлжлүүлэн явуулах бөгөөд хуралдаан даргалагч уг этгээдэд түүний байхгүйд хэлэлцсэн асуудлыг танилцуулна.

I. Ерөнхий зүйл

Энд шүүхийг хүндлэх ерөнхий үүргийн талаар заасны дараагаар оролцогчид шүүхийн арга хэмжээг босон сонсох, хүлээн авах тохиолдлуудыг нэг бүрчлэн заажээ. Үүнд шүүхийн өмнө тайлбар, мэдүүлэг өгөх, дүгнэлт гаргахдаа босохоор заажээ. Оролцогч нь удаан буюу богино хугацаагаар босч чадахгүй тохиолдолд баримтлах нэмэлтийг энэ зохицуулалтад нилээд хатуу оруулах нь зүйтэй болов уу. Гэвч онцгой тохиолдолд баримтлах зохицуулалт нэгэнт өгөгдсөн байх тул Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан хүний эрхийг зөрчсөн гэж үзэх нь үндэслэлгүй байна.

II. Шүүх хуралдаанаас гаргах

Шүүх хуралдааны журмыг дахин зөрчсөн тохиолдолд тухайн этгээдийг шүүх хуралдаанаас гаргана. Энэ журам гэрч, шинжээчийн хувьд нэгэн адил үйлчилнэ. Зөрчлийн улмаас ямар нэг этгээдийг шүүх хуралдааны танхимаас гаргасан тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулсан, эсхүл захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулсан бол хуралдаан даргалагч уг этгээдэд түүний байхгүйд хэлэлцсэн асуудлыг танилцуулах тухай заалт анхаарал татаж байна. Ингэхдээ мэдээж тухайн асуудлыг хэрхэн шийдсэн талаар мэдэгдэх ёстой.

Учир нь энэ зохицуулалт нь шүүх хуралдаанаас гаргасан этгээд, ялангуяа нэхэмжлэгч өөрийнх нь эзгүйд хэлэлцсэн асуудлыг зохих ёсоор танилцуулаагүй гэж үзвэл шийдвэрийг эсэргүүцэх (давж заалдах, хяналтын шат) боломж олгох зорилготой.

64 дүгээр зүйл. Шүүгч өөрөө татгалзан гарах үндэслэл

- 64.1. Дараах үндэслэл байвал шүүгч захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд үл оролцох ба өөрөө татгалзан гарах үүрэгтэй:
- 64.1.1. урьд нь уг захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгч, өмгөөлөгч, прокурор, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчээр оролцож байсан;
 - 64.1.2. уг захиргааны хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчийн төрөл садан, эсхүл шүүх бүрэлдэхүүнд хоорондоо төрөл, садангийн холбоотой хүмүүс орсон;
 - 64.1.3. хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, эсхүл уг захиргааны хэргийг шударгаар шийдвэрлэж чадах талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал;
 - 64.1.4. анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэх болсон.
- 64.2. Энэ хуулийн 64.1.4-т заасан журам нь Үлсын дээд шүүхэд хамаарахгүй.
- 64.3. Энэ хуулийн 64.1-д зааснаас бусад үндэслэлээр шүүгчийг татгалзаж үл болно.
- 64.4. Энэ хуулийн 64.1.1-64.1.3-т заасан заалт нь иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргад нэгэн адил хамаарна.
- 64.5. Шинжээч энэ хуулийн 64.1.1-64.1.3-т зааснаас гадна дараахь тохиолдолд дүгнэлт гаргахаас татгалзана:
- 65.1.1. албан тушаалын буюу бусад байдлаар хэргийн оролцогч нь шинжээчид нөлөөлж болох байвал;
 - 65.1.2. урьд нь түүний хийсэн шинжилгээний дүгнэлт уг захиргааны хэргийн үндэс болсон.
- 64.6. Энэ хуулийн 64.1-д заасан татгалзан гарах үндэслэл байвал шүүгч, иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга энэ тухайгаа шүүх хуралдаан эхлэхээс өмнө, эсхүл татгалзан гарах үндэслэл шүүх хуралдааны явцад илэрхий болсон бол тухайн үед мэдэгдэж татгалзан гарах үүрэгтэй.

Хуульд тухайн хэрэг маргаанд хувийн ашиг сонирхолтой байх тохиолдолд шүүгчийг албан үүргээ гүйцэтгэхээс татгалзах тухай зохицуулалтыг тусгасан байна. Энэ тохиолдолд шүүгч өөрөө татгалзаж, энэ тухайгаа шүүхийн захиргаа, ялангуяа шүүх хуралдааны даргалагчид хуульд заасан нөхцөл байдлыг үндэслэж мэдэгдэхийг үүрэг болгожээ. Татгалзан гарах үндэслэл нь шүүгч тухайн хэрэг маргаанд иргэний оролцогч болох орчуулагчаас шүүх хурлын нарийн бичгийн дарга хүртэлх олон төрлийн хэлбэрээр ажил үүрэг гүйцэтгэж байсан тохиолдолд болдог.

64.2-т зааснаар шүүгч нь төрөл садангийн холбоотой, бүр өөр шүүгчтэй ийм холбоотой бол энэ нь татгалзан гарах үндэслэл болдог байна. Харин төрөл садангийн холбооны зэрэглэлийг заагаагүй байх тул чухам хэдийд энэ зохицуулалт үйлчилж эхлэх нь тодорхой биш байна. Бүрэлдэхүүн дэх өөр шүүгчтэй төрөл садангийн холбоотой бол татгалзан гарах тухай заалт нилээд өвөрмөц байна. Энд мөн л төрөл садангийн холбооны зэрэглэлийг заагаагүй байх юм.

64.3 дугаар зүйлд заасан “хувийн харилцаа” гэснийг яаж ойлгох нь тодорхой биш байна. Энэ зохицуулалтыг ойлгохдоо шүүгч нь нэхэмжлэгчтэй хэт эерэг эсвэл хэт сөрөг харьцаатайн улмаас төвийг сахисан байр сууринд нь зүй ёсны эргэлзээ төрөхөөр бол татгалзан гарах үндэслэл болно гэх нь зүйтэй болов уу. Сөрөг харьцааг шүүгчийн татгалзан гарах үндэслэл гэж үзэх нь зөв болов уу. Харин 64.2-т шүүгч нь өөр шатанд тухайн хэргийг шийдэхэд оролцож байсан нь Улсын дээд шүүхэд хамаарахгүй гэжээ. Шүүгчдийн хүрэлцээ тааруу байх тул энэ төрлийн заалтыг тусгаж өгөх нь зүйтэй алхам болсон болов уу. Харин нөгөө талаас, тухайн хэрэг, маргааныг шийдвэрлэж байгаагүй шүүхээр хянан шийдвэрлүүлэх нэхэмжлэгчийн шаардах эрх зөрчигдөж байгаа эсэх нь эргэлзээ төрүүлэхээр байна.

Татгалзан гарах үндэслэлд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа албаны бусад этгээд болох иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, хэлмэрчийг мөн адил хамруулж байгаа нь анхаарал татаж байна. Харин орчуулагчдийг хамруулаагүй байгаа нь нилээд өвөрмөц шийдэл гэж үзэхээр байна.

65 дугаар зүйл. Татгалзан гаргах хүсэлт, татгалзан гарах

- 65.1. Энэ хуулийн 64.1-д заасан үндэслэлээр шүүгч, иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргахыг зохигч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч, прокурор, гуравдагч этгээд хүсч болох ба энэ тохиолдолд захиргааны хэргийн шүүх хэргийн оролцогчийн санал болон татгалзан гаргагдаж байгаа этгээд хүсвэл түүний тайлбарыг сонсоно.
- 65.2. Татгалзан гаргах тухай асуудлыг шүүх бүрэлдэхүүн тогтоол, шүүгч захирамж гаргаж шийдвэрлэнэ.
- 65.3. Шүүгчийг татгалзан гаргах тухай асуудлыг түүнийг байлцуулахгүйгээр бусад шүүгчид шийдвэрлэх ба санал тэнцвэл уг шүүгчийг татгалзан гаргасанд тооцно.
- 65.4. Хэд хэдэн буюу хэргийг дангаар шийдвэрлэх шүүгчийг, түүнчлэн шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлтийг тухайн захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч шийдвэрлэж, захирамж гаргана.
- 65.5. Иргэдийн төлөөлөгч, прокурор, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлтийг захиргааны хэргийг хэлэлцэж байгаа шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч шийдвэрлэнэ.

65.6. Ерөнхий шүүгч дангаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх явцад түүнийг татгалзсан буюу тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан бол шүүгчдийн зөвлөлгөөн олонхийн саналаар шийдвэрлэн тогтоол гаргана.

I. Ерөнхий зүйл

Энэ зүйлээр татгалзан гарах ажиллагаа, татгалзан гарах талаар гарах шийдвэрийг зохицуулжээ. Эхний ээлжинд татгалзан гарах болсон шүүгчийн хувьд түүнийг татгалзан гаргахаар шаардах эрх бүхий этгээдийг тодорхойлно. Харин эдгээр этгээдийн хүрээ өөрөө татгалзан гарах эрх бүхий этгээдтэй ижил биш хүмүүс байна. Энэ зүйлд тусгагдсан дараагийн зарчим бол татгалзан гаргах тухай хүсэлтийг бүрэлдэхүүний бусад шүүгчид татгалзан гаргах тухай асуудлыг тухайн шүүгчийн эзгүйд гаргадагт оршино. Харин хэд хэдэн буюу хэргийг дангаар шийдвэрлэх шүүгчийг, түүнчлэн шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах хүсэлтийг тухайн захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч захирамж гарган шийдвэрлэнэ (65.4). Ерөнхий шүүгчийг татгалзан гаргах тухай асуудлыг шүүгчдийн зөвлөгөөнөөр шийдвэрлэнэ.

II. Бусад зүйл

Шүүхээс гарах шийдвэрийн хэлбэрийн талаар зохицуулалт энэ зүйлд орсон байна (тогтоол, захирамж). Хүсэлт гаргах эрх бүхий этгээдийн хүрээг тодорхой заасан байна. Хянан шийдвэрлэх ажиллагааг шударгаар явуулах зорилгоор татгалзан гаргах тухай хүсэлт гаргасан хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын тайлбар, түүнчлэн татгалзан гаргахаар байгаа этгээдийн хүсэлтээр тайлбарыг нь сонсоно. Ингэснээр хянан шийдвэрлэх ажиллагааг чирэгдүүлэх, бүрхэгдүүлэхээс зайлсхийжээ.

66 дугаар зүйл. Шүүгчийг татгалзан гаргасны үр дагавар

- 66.1. Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг хангасан бол захиргааны хэргийг өөр бүрэлдэхүүн, шүүгч хянан шийдвэрлэнэ.
- 66.2. Тухайн захиргааны хэргийн шүүхийн бүх шүүгчийг татгалзан гаргасан, эсхүл бүх шүүгч уг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд урьд оролцож дахин оролцох боломжгүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд оролцох шүүгч хүрэлцэхгүй болсон тохиолдолд хэргийг ижил шатны өөр захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар дээд шатны шүүхэд шилжүүлнэ.
- 66.3. Энэ хуулийн 66.2-т зааснаар захиргааны хэрэг шилжиж ирсэн тохиолдолд дээд шатны захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч захирамж гарган зохих шатны өөр шүүхэд шилжүүлж, тухайн шүүхийн шүүгч зохих хуваарийн дагуу хүлээн авч хянан шийдвэрлэнэ.

Энд шүүгчийн татгалзан гаргах ажиллагаа, энэ талаар гарах шийдвэрийг зохицуулжээ. Эхний ээлжинд татгалзан гаргах тухай хүсэлт үндэслэлтэй эсэхийг хянана.

Үндэслэлтэй гэж үзсэн бол, тухайн хүсэлтийн агуулга буюу шүүгчийг татгалзан гаргах тухай асуудлыг шийдвэрлэнэ. Хүсэлтийг хүлээн авах үндэслэлтэй эсэхийг тухайн хүсэлтийг хүлээн авсан шүүгч буюу шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэж харин энэхүү хүсэлтийн талаарх эцсийн шийдвэрийг өөр бүрэлдэхүүн, шүүгч хянан шийдвэрлэнэ.

Гурван тохиолдолд уг асуудлыг тухайн хэргийг захиргааны хэргийн ерөнхий шүүгч захирамж гарган, зохих анхан шатны өөр шүүхэд асуудлыг шилжүүлнэ. Энэ тохиолдол нь бүх шүүгчийг татгалзан гаргасан, хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжгүй болсон эсхүл шүүх бүрэлдэхүүн бүрэн бус байгаа бол үүснэ. Сүүлийн зохицуулалтаас үзэхэд шүүх бүрэлдэхүүний нэг шүүгчийг татгалзан гаргасан тохиолдолд түүнийг орлуулах боломжгүй гэж үзэхээр байна. Харин шүүх хуралдаанд хуульд заасан бүрэлдэхүүнээс гадна дахиад өөр нэг шүүгч оролцсон тохиолдолд энэ асуудлыг шийдвэрлэх боломжтой санагдаж байна.

Ийм төрлийн зохион байгуулалтад шилжих боломжийг монголын шүүхийн практикаас судлах нь зөв болов уу. Хуульд заасан Дээд шатны шүүх гэдэг нь гагцхүү Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхим байх боломжтой.

Тиймээс анхан шатны өөр шүүхэд асуудлыг шилжүүлэхэд энэ нь агуулгын талаарх заавар буюу захирамжийн шинж чанарыг агуулаагүй байх шаардлагатай бөгөөд гагцхүү дээрх асуудлыг шийдвэрлэх шүүхийн сонгосон утгатай байна.

67 дугаар зүйл. Шийдвэрийг зөвлөлдөх тасалгаанд гаргах, санал хураах

- 67.1. Бүх шатны захиргааны хэргийн шүүх шийдвэрээ зөвлөлдөх тасалгаанд гаргана.
- 67.2. Зөвлөлдөх тасалгаанд захиргааны хэргийг шийдвэрлэх талаар шүүгчийн гаргасан санал нууц байна.
- 67.3. Шүүх бүрэлдэхүүн асуудал бүрийг олонхийн саналаар шийдвэрлэнэ /Энэ хэсэгт 2005 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/.
- 67.4. Хуралдаан даргалагч өөрийн саналыг бусад шүүгчийн дараа гаргана.
- 67.5. Асуудал шийдвэрлэхэд шүүгч саналаа өгөхөөс татгалзах эрхгүй.
- 67.6. Улсын дээд шүүхэд хяналтын шатны журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүх бүрэлдэхүүний санал тэнцвэл тухайн асуудлаар олонхийн санал аваагүйд тооцно.

Шүүх хуралдааны танхимд шүүгчид, иргэдийн төлөөлөгчид болон бусад хэргийн оролцогчид ил тодоор саналаа солилцох бололцоотой ч шийдвэрээ зөвлөлдөх тасалгаанд гаргахаар зохицуулсан байна. Гаргасан санал нь нууц байхаар заасан нь шүүхийг гадны нөлөөлөл, бусад сөрөг үр дагавраас хамгаалахад чиглэсэн байна. Түүнээс гадна асуудал бүрийг шийдвэрлэхээр заажээ.

Хянан шийдвэрлэх ажиллагааны сонгодог зарчмын дагуу шүүхийн арай залуу шүүгчдийн саналд нөлөөлөхгүйн тулд хуралдаан даргалагч нь саналаа бусад шүүгчдийн дараагаар гаргана. Харин санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргах журам нь энэ зүйлийн сүүлийн заалтаар хязгаарлагддаг. Учир нь хяналтын шатны шүүхэд санал тэнцсэнийг тухайн асуудлаар олонхийн санал аваагүйд тооцдог байна.

68 дугаар зүйл. Шүүх хуралдааны тэмдэглэл

- 68.1. Шүүх хуралдааны тэмдэглэлд хуралдааныг хэзээ, хаана хийсэн, эхэлсэн, дууссан цаг, шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, хэргийн ба шүүх хуралдааны оролцогчдын овог, эцгийн нэр, нэр, хаяг, тэдний ирц болон тэдэнд эрх, үүргийг тайлбарласан байдал, хэргийн болон шүүх хуралдааны оролцогчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, нотлох баримтыг шинжилсэн байдал, шүүх бүрэлдэхүүн, шүүгчээс захиргааны хэргийн талаар асууж тодруулсан байдал, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн агуулга, түүнд гомдол гаргах хугацаа, журмыг тайлбарласан байдлыг бичнэ.
- 68.2. Шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор тэмдэглэлийг бэлэн болгох ба түүнд шүүх хуралдаан даргалагч буюу шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.
- 68.3. Хэргийн оролцогчид нь шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж болно.
- 68.4. Тэмдэглэлтэй холбогдон гарсан саналын талаар шүүгч захирамж гаргана.
- 68.5. Шүүх хуралдааны тэмдэглэл алдаатай бичигдсэн тохиолдолд шүүгч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 96.3-т заасны дагуу засвар хийж баталгаажуулна.

Шүүх хуралдааны тэмдэглэлд заасан байхыг шаардсан жагсаалтыг тодорхой тусгажээ. Энэхүү заалтад эрх зүйт төрийн үүрэг даалгаврыг оногдуулсан байна. Энэ хуулийн 68.3-т хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдод тэмдэглэлтэй танилцах боломж олгосон нь эрх зүйт төрийн чухал баталгаа болж байна.

Харин хуулиар хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нь тэмдэглэлд дутуу буюу ташаа тусгагдсан зүйлийн талаар шүүх хуралдааны тэмдэглэлд нэмэлт өөрчлөлт оруулахаар хүсэлт гаргах тухай зохицуулалтыг тодорхой тусгаагүй байна.

Шүүхийн шийдвэрт нэмэлт, засвар оруулах тухай зохицуулалтыг шүүх хуралдааны тэмдэглэлийн хувьд мөн адил үйлчлэхээр зохицуулалт оруулах тухай бодож үзэх нь зүйтэй болов уу. Учир нь шүүх хуралдааны тэмдэглэлд даргалагч, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурснаар түүнийг шийдвэрийн адил хүчинтэй утгыг тусгаж өгч байгаа бөгөөд нөгөө талаар нэмэлт засвар оруулах тухай тусдаа зохицуулалт алга байна.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Анхан шатны шүүх хуралдааны дэг, анхан шатны шүүхийн шийдвэр

69 дүгээр зүйл. Шүүх хуралдааны дэг

- 69.1. Захиргааны хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдааны дэг нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 98, 99 дүгээр зүйл, 100.2-100.4, 101-113 дугаар зүйлд заасан журмаар зохицуулагдана.
- 69.2. Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй тохиолдолд захиргааны хэргийн шүүх хангалттай нотлох баримт цугларсан гэж үзвэл уг хэргийг хянан шийдвэрлэж болох бөгөөд тэдгээрийг заавал байлцуулах шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдааныг хойшлуулж дахин дуудах ба 2 дахь удаагаа ирээгүй бол нэхэмжлэлийг буцаана.
- 69.3. Нэхэмжлэгч ирээгүй тохиолдолд нийтийн ашиг сонирхлын үүднээс захиргааны хэргийн шүүх хэргийг түүний эзгүйд хянан шийдвэрлэж болно.

I. Ерөнхий зүйл

Шүүх хуралдааны дэг нь энд хэрэглэсэн утгаараа анхан шатны шүүхэд шүүх хуралдааныг аман хэлбэрээр явуулах журмыг хамарч байна.

Эхний ээлжинд ИХШХШТХ-ийн зохицуулалтыг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед нэгэн адилаар үйлчлэхээр заажээ. Нэг талаас иргэний, нөгөө талаас захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэгдлийг хангахаар, өөрөөр хэлбэл эрх зүйн нэгдмэл байдлыг үүсгэхээр эрмэлзсэн байна.

II. Онцгой зохицуулалт

Германы хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд нэхэмжлэгч буюу түүний төлөөлөгч ирээгүй бол “эзгүй байх” гэсэн ойлголтыг хэрэглэх агаад гарсан шийдвэрийг “эзгүйд гаргасан шийдвэр” гэж тодорхойлдог. Нотлох баримт хангалттай гэж үзсэн бол монголын хуулиар ч ингэж шийдвэр гаргахыг зөвшөөрдөг. Харин нэхэмжлэгч буюу түүний төлөөлөгчийг байлцуулах зайлшгүй шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдааныг дахин явуулах шаардлагатай болдог. /Герман текстийн орчуулга энд тийм ч тодорхой биш байна./ Харин энэ тохиолдолд нэг тал ирээгүй бол шүүх нь 69.2-т зааснаар нэхэмжлэлийг буцаахаар заажээ.

Харин олон нийтийн ашиг сонирхол хөндөгдөхөөр бол үүнээс өөрөөр шийдвэр гаргахаар 69.3-т заасан байна. Энэхүү заалт нь нэхэмжлэгч ирээгүй тохиолдолд хянан шийдвэрлэх эрхийг тухайн шүүхийн үзэмжийн хүрээнд үлдээсэн байна. Гэхдээ энэ нь гагцхүү шүүхэд ирээгүй эхний тохиолдлын хувьд хэмээн ойлгогдож байна. Хэрвээ энэ нь өөр утгатай бол үүний түрүүчийн өгүүлбэр нь “заавал” гэсэн утгатай биш харин “байж болно” гэсэн утгатай байх ёстой. Энэ нь нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч 2 дахь удаагаа ирээгүй бол шүүх нэхэмжлэлийг буцаах боловч хэргийн талаар шийдвэр гаргах эрхтэй гэсэн үг юм.

70 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, түүнийг гаргах

- 70.1. Захиргааны хэргийн шүүх шийдвэрээ Монгол Улсын нэрийн өмнөөс гаргана.
- 70.2. Анхан шатны шүүхээс захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:
- 70.2.1. маргаан бүхий захиргааны акт хууль бус болох нь тогтоогдвол түүнийг хүчингүй болгох;
 - 70.2.2. эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоож хүлээн зөвшөөрөх;
 - 70.2.3. захиргааны байгууллагаас гаргасан акт нь илт хүчин төгөлдөр бус болохыг нь хүлээн зөвшөөрөх;
 - 70.2.4. захиргааны актыг гаргахгүй байгаа явдал болон эс үйлдэхүй нь хууль бус гэж тогтоогдсон бол шаардагдах захиргааны актыг гаргахыг тухайн захиргааны байгууллага, албан тушаалтанд даалгах;
 - 70.2.5. төлбөр тогтоосон захиргааны актын төлбөрийн хэмжээг багасгах;
 - 70.2.6. захиргааны байгууллага, албан тушаалтнаас иргэнд учруулсан хохирлыг гаргуулах, хохирлын хэмжээг өөрчлөх, хасах;
 - 70.2.7. хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай гэж үзвэл захиргааны байгууллага, албан тушаалтнаас дахин шинэ акт гартал захиргааны уг актыг түдгэлзүүлэх;
 - 70.2.8. нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг хэрэгсэхгүй болгох;
 - 70.2.9. нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох.
- 70.3. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр нь хэрэгт авагдсан бөгөөд шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримт болон хуульд үндэслэсэн байна.
- 70.4. Захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны улмаас нэхэмжлэгчид хохирол учирсан нь тогтоогдвол нөхөн төлүүлэх ба хохирлын хэмжээний талаар маргаан гарсан бол иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлнэ.

I. Шийдвэрийн төрөл

70.2-т шийдвэрийн хэлбэр, төрлийг заажээ. Захиргааны актыг хүчингүй болгуулахаар гаргасан нэхэмжлэл нь германы хуулиар бол актын хэлбэрийг даалгах нэхэмжлэл гэж нэрлэдэг. Монголын хуульд зааснаар энэ тохиолдолд захиргааны акт хууль бус болохыг тогтоож, хүчингүй болгуулахаар заажээ. Энэ утгаараа шүүхийн шийдвэр нь тогтоох, даалгах гэсэн агуулгатай байна. Захиргааны хууль бус актыг хүчингүй болгуулах, үйлчлэлийг нь зогсоох гэдэг нь даалгах агуулгатай гэж үзэхээр байна(70.2.1).

70.2.2-т заасан шийдвэр нь эрх зүйн харилцаа үүссэнийг тогтоохоор байгаа тохиолдолд буюу жинхэнэ тогтоох нэхэмжлэлийн талаар яригдаж байгаа бол мөн адил тогтоох нэхэмжлэл гэж үзнэ. Хүлээн зөвшөөрөх нь тогтоох нэхэмжлэлийн дагуу гаргасан шийдвэрийн агуулгын нэг хэсэг, эсвэл хоёр дахь хэсэг байж болох юм.

70.2.3.-т захиргааны актыг илт хүчин төгөлдөр бус болохыг хүлээн зөвшөөрөх тухай буюу германы хуулиар бол захиргааны актын хүчин төгөлдөр бус болохыг тогтоосон шийдвэрийн тухай тусгажээ Илт хүчин төгөлдөр бус гэсэн нь үнэхээр захиргааны акт анхнаасаа хүчин төгөлдөр бус байсныг тогтоолгосон шийдвэр гаргуулах нэхэмжлэлийн тухай болохыг зааж байна.

70.2.4-т үүрэг болгосон буюу гаргаагүй буюу гаргахаас татгалзсан шийдвэрийг гаргуулах тухай шийдвэрийн талаар тусгасан байна. Захиргааны хүссэн актаа гаргуулах зорилготой тул уг нэхэмжлэл үүрэг болгосон нэхэмжлэл гэж үздэг. Энэ тохиолдолд захиргааны акт гаргуулах явдал хэвээрээ.

70.2.5, 70.2.6 дахь хэсэгт хохирол үүссэн, тухайн хэрэгт хохирол үүрэг гүйцэтгэж байгаа бол шүүхээс хохирлын хэмжээ, хохирол нөхөн төлүүлэхээр нэхэмжилж байгаа бол түүнийг хэмжээг бууруулах тухай асуудлыг шүүх өөрөө шийдвэрлэх эрхтэй. Энэ утгаараа Монголын шүүх Германы шүүхээс илүү эрх мэдэлтэй байна. Учир нь хохирлын асуудлыг Германы хувьд Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар ердийн шүүхүүд шийдвэрлэдэг.

Хэргийн нөхцөл байдлыг тодруулах шаардлагатай гэж захиргааны шүүхээс үзвэл эсэргүүцэл гаргасан актыг биелүүлэхийг хойшлуулах боломжтой. Монголын хуульд Германы хуулийн зохицуулалттай (ЗХШХШТХ-ийн 68, 80 дугаар зүйл) харьцуулахад захиргааны шүүхэд гаргасан гомдол нэхэмжлэл нь түдгэлзүүлэх үйлчлэл байдаггүй тул ийм боломж шүүхэд байх шаардлагатай(70.2.7).

70.2.8.-т нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, бусад хэсгийг хэрэгсэхгүй болгоход мөн чанар нь оршин буй хэсэгчилсэн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх талаар тусгасан байна. Гэхдээ энэ нь зарчмын хувьд 70.2.5, 70.2.6-д заасан шийдвэрүүдээс онц ялгагдахгүй юм.

70.2.9-т заасан нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох гэдэг нь герман хэлэнд тухайн гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахгүй байх тухай юм.

71 дүгээр зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хэл

71.1. Захиргааны хэргийн шүүх шийдвэрээ монгол хэлээр, тус улсад албан хэргийг хөтөлж байгаа бичгээр гаргана.

71.2. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт шүүх бүрэлдэхүүн /шүүгч/ гарын үсэг зурах ба шүүгч гарын үсгээ зурахаас татгалзах эрхгүй.

Үндсэн хууль, ерөнхий хуулиудад хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах үндэсний хэлний талаарх заалт орсон бол энд дахин дурдах шаардлагагүй байх. Гэхдээ энэ заалт нь шүүх хуралдааны дэгийг тодорхой байлгах үүрэгтэй. Шүүгчийн гарын үсэг зурах үүргийг тодорхойлсон байна.

72 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн агуулга

72.1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр нь удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсгээс бүрдэнэ.

- 72.2. Удиртгал хэсэгт захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хэзээ, хаана, ямар шүүх гаргаж байгаа, шүүх бүрэлдэхүүн болон шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, захиргааны хэргийн болон шүүх хуралдааны оролцогчийг нэрлэн заана.
- 72.3. Тодорхойлох хэсэгт нэхэмжлэлийн шаардлагын агуулга, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, прокурорын болон иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг тусгана.
- 72.4. Үндэслэх хэсэгт захиргааны хэрэгт байгаа болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг хянан шийдвэрлэхэд үндэс болсон нотлох баримтыг үнэлж дүгнэсэн байдал, захиргааны актын хууль зүйн үндэслэлийг тусгана.
- 72.5. Тогтоох хэсэгт захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд баримталсан хуулийн нэр, зүйл, хэсэг, заалтыг тодорхой зааж, шүүхэд гаргасан нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэлийг хангасан, эсхүл зарим хэсгийг хангаж, заримыг хэрэгсэхгүй болгосон, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон, түүнчлэн шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийг хуваарилсан байдал, эд мөрийн баримтыг хэрхэх, захиргааны хэрэгт хэд хэдэн нэхэмжлэгч, хариуцагч оролцсон бол нэхэмжлэгч, хариуцагч тус бүр ямар эрх эдэлж, үүрэг хүлээхийг тусгана. Шаардлагатай бол шийдвэр гүйцэтгүүлэх арга, журам, хугацаа, шийдвэрийг давж заалдах журам, хугацааг заана.
- 72.6. Энэ хуулийн 72.5-д заасан тогтоох хэсэг нь захиран тушаах хэлбэртэй байна.

Эхний хэсэгт 4 хэсгээс бүрдэх шийдвэрийн хэсэг бүрийг нарийвчлан заажээ. Тогтоох хэсгийг хамгийн сүүлд байхаар хуульчилсан байх бөгөөд Германы хуульд тенор гэж нэрлэх тогтоох хэсэг нь шийдвэрийн эхэнд байдаг. Харин энэ хуульд зааснаас үзвэл хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон бүхий л шатны шүүх, ялангуяа прокурорын болон иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлт, тайлбарыг тодорхойлох хэсэгт хамрагдсан байхад ихээхэн ач холбогдол өгдөг бололтой.

ЗХХШТХ-д зааснаар давж заалдах шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэхийн зэрэгцээ нотлох баримтыг дахин авч хэлэлцэлгүй хяналтын шатанд хэрэг шийдвэрлэх боломжийг олгодог тул энд заасан дөрвөн хүчин зүйлийг баримтлах нь ихээхэн ач холбогдолтой. Ер нь цаг хугацаа хэмнэх боломжийг хангаж байгаа энэ зохицуулалтыг гагцхүү хянан шийдвэрлэх ажиллагааг анхан шатанд хангалттай хэмжээнд тэмдэглэж, тайлбарласан тохиолдолд бүрэн ашиглах боломжтой.

Шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах хэл, шүүхийн шийдвэрт шүүгч гарын үсэг зурах тухай уг зүйлд тусгажээ. Шүүхийн шийдвэрийн бүтэц буюу удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсгээс бүрдсэн байхаар хуульчилж заасан нь практикт ихээхэн ач холбогдолтой. Тодорхойлох хэсэгт хэргийн маргаангүй нөхцөл байдал, хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тогтоогдсон нөхцөл байдал агуулагдана. Нотлох баримт цуглуулах, түүнийг танилцуулах журмыг энд тусгайлан заасан байна. Харин энэ

зохицуулалтад шүүхийн зардал, тэмдэгтийн хураамжийн талаар заасангүй (80 дугаар зүйлийг үзэх).

73 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг
уншиж сонсгох, хүргүүлэх

- 73.1. Шүүх хуралдаан даргалагч шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг хуралдаанд оролцогчдод уншиж сонсоно.
- 73.2. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг уншиж сонсгосноос хойш 7 хоногийн дотор хувийг хэргийн оролцогчдод хүргүүлнэ.
- 73.3. Нэхэмжлэгч, эсхүл хариуцагчийн оролцоогүйгээр гаргасан шийдвэрийг тэдэнд энэ хуулийн 73.2-т заасан хугацаанд хүргүүлнэ.

Шийдвэрийг бүхэлд нь бус, гагцхүү тогтоох хэсгийг оролцогчдод уншиж танилцуулна. Энэ нь Германы хуульд заасан шийдвэрийн хэсэгтэй дүйцдэг байна. Ийнхүү уншиж танилцуулснаар шийдвэр нь энэ хуулийн 77.1-д заасан журмаар хүчин төгөлдөр болох боловч эцсийн байдлаар хүчин төгөлдөр болдоггүй. Энэ нь шийдвэрийн хүчин төгөлдөр болох хугацааг тоологдож эхлэх хэдий ч гагцхүү давж заалдах боломжтой хугацаа дууссанаар бүрэн хэмжээгээр хууль зүйн хүчин чадалтай болно гэсэн үг. Хуулийн хүчин төгөлдөр болно гэдэг нь шийдвэрийг дахин өөрчлөх боломжгүй гэсэн үг билээ.

Шийдвэрийг давж заалдах, хяналтын шатны шүүхэд өргөдөл, гомдол гаргах замаар хүчингүй болгох, өөрчлөх боломжтой байдаг. Хүчин төгөлдөр байдлыг формаль, материаллаг гэж ангилдаг. Хуулиар давж заалдах боломжгүй болохыг Монголын хуулиар формаль хүчин төгөлдөр байдал гэж үздэг бол шүүхийн шийдвэр нэгэнт заавал биелэгдэх шинжтэй болж, түүнийг цаашид өөрчлөх боломжгүй болохыг материаллаг хүчин төгөлдөр байдал гэдэг.

74 дүгээр зүйл. Захиргааны хэргийн шүүхээс гаргах бусад шийдвэр

- 74.1. Захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх явцад энэ хуулийн 41, 42, 43 дугаар зүйлд заасан үндэслэл, нөхцөл байдал илэрвэл шүүх бүрэлдэхүүн тогтоол, шүүгч захирамж гаргаж хэргийг хэрэгсэхгүй болгоно.
- 74.2. Захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх явцад нэмэлт нотлох баримт цуглуулах, гэрчийн мэдүүлэг авах, шинжээч томилох, ирээгүй оролцогчийг шүүх хуралдаанд зайлшгүй оролцуулах шаардлагатай гэж үзвэл шүүх бүрэлдэхүүн тогтоол, шүүгч захирамж гарган шүүх хуралдааныг 14 хүртэл хоногоор хойшлуулж, дараагийн шүүх хуралдааны товыг тогтооно.

Дээрх зохицуулалт хоёр хэсгээс бүрдэж байна. Эхний хэсэгт 41-43 дугаар зүйлүүдэд зааснаар нэхэмжлэлээсээ татгалзсан, шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, эвлэрсэн тохиолдолд хянан шийдвэрлэх ажиллагааг захирамж буюу тогтоол гаргах замаар дуусгадаг. Энэ дарааллыг 41.4, 42.1 болоод 43.3-т заасан байна. Шүүх бүрэлдэхүүн тогтоол, шүүгч захирамж гаргана.

74.2-т нэмэлт нотлох баримт илэрсэн, цуглуулах шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдааныг хойшлуулахаар заажээ. Энэ журам шинжээч томилох, шүүх хуралдааны оролцогчдоос мэдүүлэг авахад нэгэн адил үйлчилнэ. Харин шүүхийн зүгээс дээрх шаардлага буй болсныг үндэслэхэд хангагдсан байх шаардлагатай нөхцөл байдал тодорхойгүй байна. Энэ асуудлыг шүүх эрх хэмжээнийхээ хүрээнд шийдэх боломжтой эсэх нь тодорхой бус байна.

75 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт
засвар оруулах

- 75.1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт хэргийн бодит байдлыг илт буруу илэрхийлсэн, санамсаргүй тооны алдаа гаргасан, зарим зүйлийг ойлгомжгүй илэрхийлсэн байвал шүүх өөрийн санаачилгаар буюу оролцогчийн хүсэлтээр шийдвэрийн агуулгыг өөрчлөхгүйгээр засвар оруулж болно.
- 75.2. Хэргийн оролцогч захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор тухайн шийдвэрт засвар оруулах хүсэлт гаргах эрхтэй.
- 75.3. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт засвар оруулсан тухай шүүх бүрэлдэхүүн тогтоол, шүүгч захирамж гаргана.
- 75.4. Захиргааны хэргийн шүүх шийдвэртээ засвар оруулахдаа урьд нь хэргийн оролцогчид гардуулсан шийдвэрийг буцаан авч түүнд өөрчлөлт оруулж дахин бичиж гаргана.
- 75.5. Хэргийн оролцогчид засварласан шийдвэрийг нэн даруй хүргүүлнэ.

I. Ерөнхий зүйл

Шийдвэрийн агуулга дахь илэрхий алдааг засварлах явдлыг нилээд хөнгөвчилсөн заалт байна. Өөрөөр хэлбэл давж заалдах буюу хяналтын шатны журмаар шийдвэрийг өөрчилж улмаар хэргийн болоод хууль эрх зүйн нөхцөл байдал бус, гагцхүү илэрхий алдааг засварлах боломжийг хангажээ.

75.1-д зааснаар хэргийн нөхцөл байдлыг илэрхий ташаа байдлаар тусгасан, болгоомжгүй байдлын улмаас тоо хэмжээг буруугаар тэмдэглэсэн тохиолдлыг тусгажээ. Шүүхийн зүгээс зарим зүйлийг ойлгомжгүй илэрхийлснийг энд тусгасан байх боловч үүнийг илт ташаа гэж үзэх нь эргэлзээтэй. Энэ тохиолдолд шүүх өөрийн санаачлагаар буюу оролцогчдын хүсэлтээр алдааг засварлах боломжтой.

II. 75.2-т зааснаар хэргийн оролцогчдод дээр дурдсан засвар оруулах эрхийг 10 хоногийн дотор хэрэгжүүлэхээр заажээ. Харин өөрийн санаачилгаар шийдвэрт засвар оруулахад хугацааны хязгаар тогтоогоогүй ажээ. Засвар оруулах тухай хүсэлт гаргасан бол энэ тухай шүүх бүрэлдэхүүн шүүхийн нэрийн өмнөөс тогтоол, шүүгч захирамж гаргана.

76 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт нэмэлт оруулах

76.1. Шүүхийн шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор захиргааны хэргийн шүүх өөрийн санаачилгаар буюу хэргийн оролцогчийн хүсэлтээр дараах тохиолдолд шийдвэртээ нэмэлт оруулна:

76.1.1. нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийн талаар шийдвэр гаргалгүй орхигдуулсан;

76.1.2. захиргааны хэргийн шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамж, эд мөрийн баримтын асуудлыг шийдвэрлээгүй.

76.2. Нэмэлт шийдвэр гаргах, шүүх хуралдаан хийхэд энэ хуульд заасан журмыг баримтална.

75 дугаар зүйлд заасан засварлах эрхээс үл хамаарч, 76 дугаар зүйлээр шүүхийн шийдвэрт нэмэлт оруулах эрхийг хангажээ. 76.1-д зааснаар нэхэмжлэлийн зарим хэсгийн талаар шийдвэр гаргалгүй орхигдуулсан, эсвэл 76.2-т зааснаар шүүхийн зардал тэмдэгтийн хураамж, нотлох баримтын асуудлыг шийдвэрлээгүй бол нэмэлт оруулахаар заажээ.

76.2-т хуулийн бусад зүйлийг баримтлахыг заасан байхад засвар оруулах тухай зүйлд хялбаршуулсан журмаар ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг олгожээ.

77 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох

77.1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр уншиж сонсгосноор хуулийн хүчин төгөлдөр болно.

77.2. Нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор давж заалдах, хяналтын журмаар хянуулах бол 30 хоногийн дотор гомдол гаргах буюу прокурор давж заалдах эсэргүүцэл бичиж болно.

77.3. Анхан шатны шүүхийн шийдвэрт нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргах эсэхээ сонгон гомдлоо захиргааны хэргийг шийдвэрлэсэн тухайн шүүхэд ирүүлнэ.

77.4. Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад уг асуудлаар өөр шүүхэд хандахыг хориглоно.

77.5. Хяналтын журмаар анхан шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдлыг шийдвэрлээд гаргасан шүүхийн тогтоолд давж заалдах гомдол гаргах эрхгүй.

I. Ерөнхий зүйл

77.1-д шийдвэрийг уншиж сонсгосноор хуулийн хүчин төгөлдөр болох тухай зарчмыг үндэслэжээ. Энд ч гэсэн дээр дурдсан гомдол, хүчин төгөлдөр бусад тооцуулахаар гаргасан нэхэмжлэлтэй адил зарчим буюу давж заалдах, хяналтын шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх нь түдгэлзүүлэх үйлчлэлгүй гэсэн үндсэн зарчим үйлчилнэ. Хэдийгээр давж заалдах, хяналтын шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэхүүлэхээр хандах боломж байгаа ч шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр байна.

II. Давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах

77.2-т зааснаар нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд тэдгээрийн өмгөөлөгч нарт давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргах эрхийг хангажээ. Хуульд энэ талаар хяналтын журмаар гомдол гаргах тухай заасан ч энэ нэхэмжлэл гаргахтай утга ижил байна. Давж заалдах болон хяналтын шатны ялгааны талаар есдүгээр бүлэгт илүү дэлгэрэнгүй авч үзэх болно. Прокурорын зүгээс энэ зүйлд зааснаар “давж заалдах эсэргүүцэл” бичиж болох бөгөөд үүнийг давж заалдах шатны журмаар гаргасан гомдлын эсрэг бичгэн тайлбар, хяналтын шатны журмаар гаргасан гомдлын эсрэг бичгэн тайлбар гэж ойлгох шаардлагатай.

77.3 нь зарчмын хувьд давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргах нь нэхэмжлэгчийн хувьд үндэслэлтэй болохыг тодорхойлж буй 77.1 дэхь хэсгийг давтаж байна. Давж заалдах, эсхүл хяналтын журмаар гомдол гаргахдаа тухайн шийдвэрийг гаргасан шүүхэд хандахаар заасанд энэ зохицуулалтын ач холбогдол орших байх. Сүүлийн хоёр заалтаар тухайн асуудлыг шийдвэрлээгүй байхад өөр шүүхэд уг асуудлаар хандахыг хориглосон байна. Энэхүү зохицуулалтаар өөр шүүхийн харьяалалд байгаа хэргийн тухай асуудлыг үндэслэжээ.

77.5-д хяналтын журмаар гарсан шийдвэрт давж заалдах журмаар гомдол гаргахыг хориглосон байна. Өөрөөр хэлбэл давж заалдах журмаар гарсан шийдвэрийг эсэргүүцэж хяналтын шатанд хандах боломжтой хэдий ч анхан шатны шүүхийн шийдвэрийг хяналтын журмаар эсэргүүцсэн бол давж заалдах шатны шүүхэд хандах эрхгүй. Хяналтын журмаар гомдол гаргахдаа нэхэмжлэгч анхан шатны шүүх хэргийн нөхцөл байдлыг зөвөөр үнэлж шийдвэр гаргасанд итгэлтэй байх шаардлагатай.

78 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх

78.1. Хэргийн оролцогчид захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн биелүүлэх үүрэгтэй.

78.2. Захиргааны хэргийн шүүх шийдвэрээ биелүүлэх арга, журмыг гаргасан шийдвэртээ тодорхойлно.

Шийдвэр биелүүлэх тухай заалтууд нь үүрэг хүлээсэн этгээдүүд нь аль мөчөөс эхлүүлэн шийдвэрийг биелүүлэх буюу хуулийн заалтад захирагдаж эхлэх ёстой болох тухай асуудлыг зохицуулж байна. Уншиж танилцуулснаар буюу шүүх хуралдааныг амаар явуулж дуусмагц шийдвэр хүчин төгөлдөр болох тул энэ мөчөөс шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаа эхлэх буюу гарсан шийдвэрийг баримтлах үүрэгтэй болно.

Давж заалдах, хяналтын журмаар шийдвэрийг эсэргүүцэх нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаа эхлэхэд саад болохгүй бөгөөд иргэний шийдвэр биелүүлэх үүргийг түдгэлзүүлэхгүй. Хуулиар захиргааны шүүхэд шийдвэрийг ямар арга замаар биелүүлэхийг шийдвэрлэх эрх мэдлийг олгожээ. Хуулийн зохицуулалт байхгүй буюу хангалтгүй байх тул энэ утгаараа шүүхэд үйл ажиллагаа явуулах ихээхэн эрх мэдлийг олгосон байна.

79 дүгээр зүйл. Захиргааны хэргийн шүүхийн тогтоол,
шүүгчийн захирамж

- 79.1. Энэ хуулийн 73 дугаар зүйлд зааснаар шийдвэр гаргахаас бусад тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар захиргааны хэргийн шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.
- 79.2. Захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг бичгээр гаргана.
- 79.3. Хуульд тусгайлан заасан бол захиргааны хэргийн шүүхийн тогтоол буюу шүүгчийн захирамжийг тэмдэглэлд тусгах замаар гаргаж болно.
- 79.4. Захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж нь гармагц хүчин төгөлдөр болно.

73 дугаар зүйлд заасан шүүхийн тухайн шатан дахь эцсийн шийдвэрийн зэрэгцээ хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад шийдвэрийг зохицуулж байгаа тул энэ заалт ач холбогдолтой. 73 дугаар зүйлд зааснаас бусад бүхий л арга хэмжээ нь шүүх бүрэлдэхүүнээс гаргасан тогтоол, шүүгчээс гаргасан захирамж байна. Харин шүүх хуралдааны даргалагч бие дааж захирамж гаргах боломжтой, гагцхүү хэргийг дангаар шийдвэрлэж байгаа шүүгчээр дээрх эрх мэдэл хязгаарлагдаж байгаа эсэхийг хуулиар зохицуулалгүй орхижээ. Дангаар хэрэг шийдвэрлэж байгаа шүүгчийн эрх мэдлийг ЗХХШТХ-иар бус шүүхийн тухай хуулиар зохицуулдаг.

Тогтоол, захирамжийг бичгээр гаргах тухай үндсэн зарчмаас 79.3-т зааснаар татгалзаж, тэмдэглэл хөтөлсөн байх нь хангалттай байхаар зохицуулжээ. Энэ тохиолдолд аман хэлбэрээр гаргаж болно. Гэхдээ аман хэлбэрээр гарсан тогтоол шийдвэрүүд нь бичгэн хэлбэртэйн нэгэн адилаар гарсан даруйдаа хүчин төгөлдөр болно.

80 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн зардал,
улсын тэмдэгтийн хураамж

80.1. Захиргааны хэргийн шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийн асуудлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52-60 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэнэ.

Шүүхийн зардал, Улсын тэмдэгтийн хураамжийн талаар ИХШХШТХ-ийн 52-60 дугаар зүйлүүдийг хэрэглэхээр заажээ. Харин нэмээд 36 дугаар зүйлийг баримтлахаар заасан байна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан
шийдвэрлэх ажиллагаа

81 дүгээр зүйл. Давж заалдах гомдол гаргах, гомдлыг
хүлээн авах

- 81.1. Анхан шатны журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлээд гаргасан захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, эсхүл тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гардуулсан буюу энэ хуулийн 72.3-т заасны дагуу хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор давж заалдах гомдлоо Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимд гаргах эрхтэй.
- 81.2. Энэ хуулийн 81.1-д заасан этгээд хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд оролцоогүй бол захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор давж заалдах гомдол гаргах эрхтэй.
- 81.3. Анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдлыг талуудын аль нэг нь гаргасан явдал эсрэг талын хяналтын журмаар гомдол гаргах эрхийг үл хязгаарлана.
- 81.4. Нэхэмжлэгч, хариуцагч талын аль нэг, эсхүл хамтран нэхэмжлэгч болон хамтран хариуцагчийн аль нэг нь давж заалдах, нөгөө нь хяналтын журмаар гомдол гаргасан бол давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд хэргийг бүхэлд нь хянана.
- 81.5. Давж заалдах гомдлыг тухайн шийдвэрийг гаргасан захиргааны хэргийн шүүхээр дамжуулан гаргана.

- 81.6. Давж заалдах гомдлыг тухайн захиргааны хэргийг шийдвэрлэсэн шүүгч буюу шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хүлээн авч, уг гомдол болон түүнд хавсаргасан баримт бичгийг эсрэг талд, шаардлагатай бол гуравдагч этгээдэд танилцуулах бөгөөд, тэдгээрийн тайлбарыг авч, хэрэгт хавсаргаж болно.
- 81.7. Энэ хуулийн 81.5.-д заасан шүүх давж заалдах гомдолд хариуцагч, гуравдагч этгээдээс гаргасан тайлбарыг хавсарган хэргийн хамт уг гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ.

I. Ерөнхий зүйл

Монголын хуульд захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг эсэргүүцэх 3 боломж байна: давж заалдах ба хянан шалгах (ЗХХШТХ-ийн 91 дүгээр зүйл) мөн гомдол гаргах (ЗХХШТХ-ийн 90 дүгээр зүйл). Давж заалдах, хяналтын журмаар шүүхийн шийдвэрийг эсэргүүцдэг бол, харин гомдол гаргаснаар шүүхийн тогтоолыг эсвэл дангаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг эсэргүүцэх эрхтэй.

Хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн эдгээр 3 журам нь хэргийн анхан шатны шүүхийн харъяалмыг дуусгавар болгож, дээд шатны шүүхийн шийдвэрийн харъяа болгодог. Гэхдээ эдгээр 3 эрх зүйн арга нь хянан шалгах агуулгынхаа цар хүрээгээрээ ялгаатай. Давж заалдах журмаар нөхцөл байдлыг болон хууль эрх зүйн асуудлыг дахин шалгаж үзэхэд хүргэдэг (ЗХХШТХ-ийн 85 дүгээр зүйл).

Нөхцөл байдлыг болон хууль эрх зүйн асуудлыг дахин шалгаж үзнэ гэдэг нь давж заалдах шүүх үндсэндээ нотлох баримт шинээр цуглуулах мөн мөрдөн шалгах явцад үүссэн нөхцөл байдлыг шинжлэхийг хэлнэ (ЗХХШТХ-ийн 85 дүгээр зүйл). Хянан шалгах хүрээнд зөвхөн захиргааны анхан шатны шүүх хуулийг зөв хэрэглэсэн эсэхийг л шалгадаг (ЗХХШТХ-ийн 91 дүгээр зүйл). 15.3-т заасан кассацийн журмыг хэрэглэж болохыг заасан байдаг.

Гэвч дээд шатны шүүх захиргааны шүүхийн харъяалалд ийм журмаар халдах нь шүүхийн хараат бус байх эрх зүйн баталгаай нийцэх эсэх нь эргэлцэээй байна. Ийм ч учраас Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхим өнөөг хүртэл ийм арга хэрэглэхээс зайлсхийсэн байх. Давж заалдахын тулд анхан шатны шүүх хуралдаанд заавал биеэр оролцох шаардлагагүй.

Хүндэтгэх шалтгаангүйгээр шүүх хуралд хүрэлцэн ирж чадаагүй оролцогчид ч давж заалдах эрхийг хуулиар олгосон байна.

II. Давж заалдах, хяналтын журмаар хэрэг шийдвэрлэх.

Энэхүү заалт нь зарим талаар давж заалдах шүүх хуралдааны нэгэн хэсгийг зохицуулж байгаа боловч тэр нь ЗХХШТХ-ийн 91-р зүйлээс улбаатай биш юм. 81.4-т зааснаар нэг тал нь давж заалдсан тохиолдолд нөгөө тал нь хэргийг хяналтын журмаар шийдвэрлүүлэх тухай гомдол гаргах эрхтэй байна.

Хэргийн нэг тал нь давж заалдах шатанд байгаа хэдий боловч хяналтын журмаар гомдол гаргах эрхийг мөн эдлэх ажээ. Иймд түүний эрх нь зөвхөн давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцохоор хязгаарлагдахгүй, харин үүнээс үл хамааран тэрбээр

хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй гэсэн үг юм. Чингэхдээ хяналтын шүүх нь гагцхүү хуулийг зөв хэрэглэсэн эсэхийг шалгаад, харин хэргийн бодит байдал, түүнийг шалгаж тогтоосон байдлыг хянахгүй гэсэн үг биш юм.

Хяналтын шатны шүүх асуудлыг зөвхөн процедурын талаас нь хянан шийдвэрлэнэ гэсэн утга уг заалтад агуулагдаагүй байна. Харин ч давж заалдах ба хяналтын гомдол давхардсан тохиолдолд асуудлыг давж заалдах утгаар авч үзэж хянан шийдвэрлэх юм байна.

Энэ нь хэргийн болон эрх зүйн нөхцөл байдлыг бүрэн хэмжээгээр хянан шалгаж шийдвэрлэх давж заалдах процесс явагдана гэсэн үг юм. Нэхэмжлэгч буюу хариуцагчийн тал нь хэд хэдэн хувь хүн буюу хуулийн этгээдээс бүрдэж байгаа бол тэдгээрийн хэн нь ч (аль нь ч) тус бүртээ хэргийг давж заалдах эсхүл хяналтын журмаар шийдвэрлүүлэх хувилбарыг сонгох эрхтэй байна. Тэгсэн хэдий боловч хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэх бөгөөд хэргийг бүрэн хэмжээгээр дахин хянан шалгах шаардлагатай болно. Хэргийг бүрэн гүйцэд хянан шалгаж шийдвэрлэх нь шаардлагатай бөгөөд энэ зөв шийдэл юм.

Учир нь хэд хэдэн субъектээс бүрдсэн нэхэмжлэгч буюу хариуцагч, эсхүл ганцхан нэхэмжлэгч буюу хариуцагчийн хувьд шүүхийн өөр өөр шийдвэр гарах ёсгүй билээ. Харин хэргийг хянан шалгасны үр дүнд оролцогч нэг талын хувьд өөр нөхцөл байдал тогтоогдсон байхад нөгөө талын хувьд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр нь үлдээх байвал шүүхийн шийдвэр адил биш байж болох юм.

III. Бусад зүйл

81.5-д захиргааны анхан шатны шүүх нь хянан шийдвэрлэх ажиллагааг Улсын дээд шүүхэд шилжүүлэхээр заажээ. Гэвч 81.1-д зааснаар давж заалдах журмаар Улсын дээд шүүхийн захиргааны танхимд гомдол гаргах тул энэ нь гагцхүү хэргийн баримтаар хязгаарлаж байгаа болов уу.

Дараагийн заалт буюу давж заалдах гомдлыг тухайн захиргааны хэргийг шийдвэрлэсэн шүүгч буюу шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хүлээн авч, үүний талаар бусад этгээдэд танилцуулах үүрэгтэй нь дээр дурдсан асуудалтай төстэй байна. Эдгээр баримтыг хэрэгт хавсаргаж болно гэжээ. Баримтыг хэргийн хамт 3 хоногт багтаан давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ гэжээ.

Энэхүү журам нь хэрэг маргааныг нэгэнт Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимд хүргүүлж байгаа нь бусад байдлаар нөлөөлөх боломжийг хязгаарласан явдал болов уу. Харин анхан шатны шүүх нь мэдээ, мэдээллийг цуглуулах, танилцуулах, олж авсан мэдээллийг давж заалдах шатны шүүхэд хүргүүлэх үүрэгтэй.

82 дугаар зүйл. Давж заалдах гомдлын хэлбэр, агуулга

82.1. Давж заалдах гомдлын хэлбэр, агуулга нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 162.1-162. 3-т нийцсэн байна.

82.2. Давж заалдах гомдол гаргагч нь уг гомдлыг давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцэхэд өөрөө, эсхүл төлөөлөгч /өмгөөлөгч/-өө оролцуулахаа тодорхой бичсэн байна.

Энд бичгээр гомдол гаргахдаа ИХШХШТХ-д заасан хэлбэрийг баримтлахаар зохицуулжээ. Давж заалдах журмаар гомдол гаргаж байгаа этгээд нь өөрөө эсвэл төлөөлөгчөө шүүх хуралдаанд оролцуулахыг заажээ.

83 дугаар зүйл. Давж заалдах гомдлоос татгалзах

83.1. Давж заалдах гомдол гаргасан этгээд шүүх бүрэлдэхүүн, шүүгч зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө хэрэг шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд давж заалдах гомдлоосоо татгалзах эрхтэй.

83.2. Давж заалдсан этгээд давж заалдах шатны шүүх хуралдаан эхлэхээс өмнө гомдлоосоо татгалзвал түүнийг давж заалдах гомдол гаргаагүйд тооцох ба харин шүүх хуралдааны явцад татгалзвал захиргааны хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг хэрэгсэхгүй болгох тухай шүүхийн магадлал гаргана.

Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчид иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны нэгэн адилаар нэхэмжлэлийн талаар, түүнээс татгалзахыг шийддэг.

Монголын хуульд нэхэмжлэлээсээ татгалзах эрхийг шүүх зөвлөлдөх хүртэл, өөрөөр хэлбэл шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орох хүртэл хангадаг нь хянан шийдвэрлэх ажиллагааны тухай бусад хуулиудаас нилээд илүү хөгжсөн болохыг илтгэж байна.

Германы хуулиар нэхэмжлэлийн талаар хариуцагчид мэдэгдсэнээс хойш нэхэмжлэлээс гагцхүү түүний зөвшөөрснөөр татгалзаж болдог. Учир нь тэр үед дахин хянан шийдвэрлэх ажиллагаа явагдахаас сэргийлж, хариуцагч хэрэг маргааныг шийдвэрлүүлэх сонирхолтой болсон байх нь тохиолддог. Шүүх хуралдааны явцад нэхэмжлэлээсээ татгалзсан бол тухайн хэрэг, маргаанаар давж заалдах журмаар гомдол гаргаагүй гэж үзэх хуулийн бодит бус байдал үүсдэг. Харин аман хэлбэрээр шүүх хуралдааны үед нэхэмжлэлээсээ татгалзвал захирамж гарч, улмаар хариуцагчийн хувьд тодорхой хэмжээний эрх зүйн баталгаат орчин үүсдэг.

Давж заалдах шатны шүүх хуралдаан эхлэхээс өмнө гомдлоосоо татгалзвал бодит нөхцөл байдлын явцыг үл харгалзан давж заалдах гомдол гаргаагүйд тооцох ба хуулийн хэллэгээр ийм нөхцөл байдлыг “фикци” гэж нэрлэдэг. Ийм тохиолдолд шүүх тухайн асуудлаар шийдвэр гаргахгүй, мөн шүүхийн зардлын асуудал ч гарах ёсгүй. Харин үүнээс хойш гомдлоосоо татгалзвал шүүх хянан хэлэлцэх ажиллагааг хэрэгсэхгүй болгох тухай магадлал гаргана.

Германы хууль тогтоомжоор бол хэргийг бүрэн гүйцэд хянан шийдвэрлэсэн гэж тооцож, шүүхийн шийдвэрийг гагцхүү шүүхийн зардал, хураамжийн талаар гаргаж болно

84 дүгээр зүйл. Шүүх хуралдаанд оролцох

- 84.1. Хэргийн оролцогч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд, прокурор давж заалдах шатны шүүх хуралдаанд биеэр оролцохыг хүсвэл шүүх тэдгээрт тухайн шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг мэдэгдэж, шүүх хуралдаанд биеэр оролцох эрхийг нь хангана.
- 84.2. Энэ зүйлийн 84.1-д заасан этгээд шүүх хуралдаанд ирээгүй явдал давж заалдах журмаар захиргааны хэргийг шийдвэрлэхэд саад болохгүй.

84 дүгээр зүйл нь давж заалдах журмаар шүүх хуралдааныг аман хэлбэрээр явуулах журмыг нарийн зохицуулжээ. Харин шүүх хуралдааныг бичгээр бус, амаар явуулахыг тодорхой заажээ. Шүүх хуралдааны оролцогчдын хүрээг нилээд өргөн байхаар зохицуулсан байна. Прокурор хүсэлт гаргавал шүүх хуралдаанд оролцох эрхийг мөн адил эдэлнэ.

Түүнчлэн гуравдагч этгээд, түүний төлөөлөгч, өмгөөлөгчид давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцох эрхийг олгожээ. Нөгөө талаас тухайн этгээдүүд шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргасан, оролцохыг нь зөвшөөрсөн эсэхээс үл шалтгаалан ирээгүй бол энэ нь шүүх хуралдааныг явуулахад саад болохгүй болохыг 84.2-т тодруулжээ.

**85 дугаар зүйл. Давж заалдах журмаар захиргааны
хэрэг хянан шийдвэрлэх**

- 85.1. Давж заалдах гомдол гарсан хэргийг Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхим хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ.
- 85.2. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг шүүгчдийн зөвлөгөөнөөс томилогдсон шүүгч даргална.
- 85.3. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж байгаа захиргааны хэргийн шүүх давж заалдах гомдолд заасан үндэслэлээр хязгаарлахгүй захиргааны хэргийг бүхэлд нь хянан үзэх үүрэгтэй.
- 85.4. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд аль нэг шүүгч нь захиргааны хэргийн талаар илтгэж танилцуулна.
- 85.5. Илтгэгч нэхэмжлэлийн шаардлага, хариуцагчийн тайлбар, анхан шатны шүүхийн дүгнэлт, шийдвэрийн агуулга, давж заалдах гомдлын үндэслэл, хэрэгт авагдсан нотлох баримтын талаар танилцуулж, улмаар шүүх бүрэлдэхүүн илтгэгчид асуулт тавьж, нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн тайлбарыг сонсож, шаардлагатай зарим зүйлийг тэднээс асууж тодотгосны дараа шүүх хуралдаан завсарлан, шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орно.
- 85.6. Давж заалдах журмаар хэрэг хянан хэлэлцсэн захиргааны хэргийн шүүх шинээр цуглуулсан, хуулийн шаардлага хангасан, эргэлзээгүй нотлох баримтыг үнэлж дүгнэх, үндэслэл болгох эрхтэй.

I. Ерөнхий зүйл

85.1-д давж заалдах гомдол гарсан хэргийг Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын харъяалалд байхаар заажээ. Үүнээс гадна шүүх хуралдааныг шүүгчдийн зөвлөлгөөнөөс томилогдсон шүүгч даргалахаар зохицуулсан байна. Даргалагч шүүгчийн үүрэг нь эцсийн шийдвэр гаргах ажиллагааг хамрах болов уу. Харин даргалагч шүүгчийг нилээд урт хугацааны өмнө хийсвэр хэлбэрээр, жишээлбэл нэрсийн дараалмаар томилсон байх шаардлагатай эсэх нь эргэлзээтэй. Хэрэг маргааныг захиргааны хэргийн танхимд хүлээн авсны дараагаар шүүгчдэд хуваарилах нь тэднийг аль нэг талыг баримталж байна гэж сэжиглэх үндэс болж болох юм.

Захиргааны хэргийн шүүх нь давж заалдах гомдолд заасан үндэслэлээр хязгаарлахгүй захиргааны хэргийг бүхэлд нь хянан үзэх үүрэгтэй байгаа нь хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээг тодорхойлох талаарх нэхэмжлэгчийн эрхийг хязгаарлаж байгаа хэрэг байж магадгүй. Германы хуулиар бол нэхэмжлэгч нь маргааны хүрээг тодорхойлдог. Маргааны зүйлийн энэ төрлийн хязгаарлалт нь нэхэмжлэлээсээ хэсгээр буюу бүхэлдээ татгалзах үндэслэл болох магадлалтай.

1. Шүүхийн зохион байгуулалтын тухай хууль (шүүхийн тухай хууль?)-ийн дагуу ЗХХШТХ-ийн 85-р зүйлд дурдсан шүүгчдийн зөвлөлгөөн нь шүүх хуралдааны даргалагчийг нэг жилээр томилдог байна. Ингэснээр хууль ёсны шүүгч байх шаардлагыг хангасан байна. Ийм журмаар Дээд шүүхийн давж заалдах шатны шүүхийн биш харин хяналтын шүүхийн даргыг томилдог гэсэн ойлголт төрж байна. (ИХХШТХ-ийн 184-р зүйл)

Хуулийн дагуу бол зөвхөн Дээд шүүхэд захиргааны хэргийн танхимтай хяналтын шатны шүүх байнгын даргатай байдаг хэмээн ойлгогдож байна. Харин захиргааны хэргийн танхим давж заалдах шатанд хэрэг хянан шийдвэрлэх тохиолдолд хяналтын шүүхийн дарга гагцхүү Шүүхийн тухай хуулиар эрх олгогдсон нөхцөлд уул шатны шүүх хуралдсаныг даргалах эрхтэй байна. Харин энэ тухай заалт хуулинд байхгүй юм шиг байна. Давж заалдах шатанд хэрэг хянан шийдвэрлэхдээ шүүгчдийн зөвлөлгөөн давж заалдах шатны шүүх хуралдааны даргалагч шүүгчийг нэг жилийн хугацаагаар томилох эсхүл хяналтын шүүхийн (танхимын) дарга энэ үүргийг өөр нэг шүүгчид ногдуулж болох юм. Илтгэгч шүүгчийг ээлжлүүлэн томилох явдал нь хууль ёсны шүүгч хараат бус байх зарчмыг зөрчинө.

2. 85 дугаар зүйлд мөн аль нэг шүүгч хэргийн талаар илтгэнэ гэжээ. Тэрбээр 85.5-д заасанчлан хэргийг танилцуулж, хариуцагчийн тайлбарыг сонсох үүрэгтэй юм байна. Мөн түүнийг ч гэсэн хийсвэрээр ойлговол томилох ёстой. Учир нь тэрбээр гарах шийдвэрт нөлөөлж болох юм. Мөн хуулийн заалтад шүүх бүрэлдэхүүн оролцогч талуудад асуулт тавина гэсэн байна. Харин асуултыг ямар дэс дараалмаар тавих журмыг хуульд зохицуулаагүй байна. Иймд энэ асуудлаар МУ-ын ИХ-ийн 170 дугаар заалтыг адил төстэйгөөр аналогоор хэрэглэвэл зохино. Гэвч энэхүү заалт нь анхан шатны захиргааны хэргийн шүүхэд хамаарах учир түүнийг зөвхөн аналогоор хэрэглэх боломжтой.

3. 85.3-т шүүх давж заалдах гомдолд заасан үндэслэлээр хязгаарлаж үл болох захиргааны хэргийг бүхэлд нь хянан үзэх үүрэгтэй гэжээ. Ингэснээр хэргийн талаархи нэхэмжлэгчийн эрх мэдэл (диспозицийн зарчим) хязгаарлагдаж байна. Энэхүү

хэлбэрийг эрх зүйн заалтын хатуу норм болгож хэрэглэвэл энэ нь давж заалдах гомдлын тодорхой хэсгээс татгалзах боломжийг хаах бөгөөд мөн л диспозицийн зарчим зөрчигдөх болно. Шүүх хуралдааныг даргалагч шүүгч өөрөө илтгэгчийн үүргийг гүйцэтгэх, эсхүл тодорхой хэрэг дээр түүнд энэхүү үүргийг урьдчилан ногдуулах боломж байх эсэх асуудал байна.

II. Илтгэгч, даргалагч шүүгч

Гэхдээ энэ тохиолдолд түүний ажлын ачаалал нэмэгдэхийг бодолцох хэрэгтэй. Илтгэгч шүүгч бол тухайн хэргийг материаллаг эрх зүй болон процессын эрх зүйн талаас нь судалсан байх ёстой. Үүний үндсэн дээр тэрбээр илтгэнэ. Шүүгчдийн бүрэлдэхүүн түүнд болон хэргийн оролцогчид, нэхэмжлэгч, хариуцагчид асуулт тавьж хариулт авснаар энэхүү илтгэлд нэмэлт болно.

Харин хэрэгт оролцогчдоод хэн тодруулах асуултуудыг тавих, хэн шүүх хуралдааныг завсарлуулж зөвлөлдөх тасалгаанд орох шийдвэр гаргах тухай асуудал бүрхэгдүү байна. Энэ үүргийг шүүх хуралдаан даргалагч гүйцэтгэх байх л даа. Хуулийн энэ заалтад илтгэгчийн үүргийг нарийвчлан тодорхойлж, түүнчлэн шүүх хуралдааныг даргалагч, илтгэгч, шүүхийн бусад бүрэлдэхүүний ажлын хуваарийг зааж өгсөн нь багаар ажиллах хамтын шийдэл гаргах зарчмын ач холбогдлыг онцгойлж байна.

85.6-д шинээр нотлох баримт цуглуулах, түүнийг үнэлж дүгнэх, гарах шийдвэрийн үндэслэл болгох талаархи давж заалдах шатны шүүхийн гол үүргийг тусгасан байна. Үүгээр хяналтын шатны шүүхээс ялгагдах ялгааг гаргаж тавьсан байна. Учир нь хяналтын шатны шүүх бол гагцхүү хуулийн хэрэглэтийг дахин хянадаг билээ.

86 дугаар зүйл. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан хэлэлцсэн захиргааны хэргийн шүүхийн магадлал

- 86.1. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан хэлэлцсэн захиргааны хэргийн шүүхийн магадлалд нэхэмжлэлийн шаардлага, хариуцагчийн тайлбар, анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн болон давж заалдах гомдлын агуулга, давж заалдах шатны шүүхээс гаргаж байгаа шийдвэр, түүний үндэслэл тусгагдсан байна.
- 86.2. Давж заалдах журмаар хэрэг хянан хэлэлцсэн захиргааны хэргийн шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх, өөрчлөх, хүчингүй болгох шийдвэрийн аль нэгийг заавал гаргана.
- 86.3. Магадлал уншин сонсгомогц хуулийн хүчин төгөлдөр болно.
- 86.4. Магадлалыг гарснаас хойш 7 хоногийн дотор нэхэмжлэгч, хариуцагчид хүргүүлнэ.
- 86.5. Давж заалдах шатны шүүх магадлал гаргахдаа хуульд заасан захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн гэж талууд, эсхүл гуравдагч этгээд үзвэл энэ хуулийн 77.2.-т заасан хугацаанд хяналтын журмаар гомдол гаргаж болно.

I. Ерөнхий зүйл

Энд давж заалдах журмаар шүүх нь шийдвэр бус харин магадлал гаргахаар заажээ. Шүүхийн шийдвэр, магадлал хоёрын хоорондын ялгаа нь тодорхой байна. Учир нь шийдвэрийг тодорхой, хуульд заасан хэлбэрээр гаргадаг бол магадлалд шүүхийн шийдвэртэй холбоотой саналыг агуулж байдаг. Магадлал нь шаардах эрх үүссэн байх, эсвэл үүсээгүй болохыг үндэслэсэн нөхцөл байдал буй эсэхийг хянасан хэлбэртэй байдаг. /Үүнтэй холбогдуулан: /Scholler, Besonderes Verwaltungsrecht, Fälle und Lösungen nach huchstrichterlichen Entscheidungen, C.F.Müller, 3. neubearb. Aufl., Heidelberg 1984 (zus. Mit S.Bross) mit Anhang Kurze Ableitung zur Abfassung von juristischen Gutachten und Gerichtsentscheidungen in mongolische Sprache übertragen, Ulaanbaatar 2003/.

Энд зааснаар магадлал нь анхан шатны болоод давж заалдах шатны хянан шийдвэрлэх ажиллагааг бүхэлд нь багтаасан хэргийн нөхцөл байдлыг тодорхойлох хэсэгтэй байх ёстой ажээ. 86.2 дугаар зүйлд зааснаас үзвэл магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх, өөрчлөх, буцаахыг шийднэ.

II. Эрх зүйн хэрэгсэл

86.4 дүгээрт давж заалдах журмаар гарсан шийдвэрийг харьцангуй богино хугацаанд буюу долоо хоногийн дотор оролцогчдоод хүргүүлэхээр заажээ. Тэд энэ шийдвэрийг эсэргүүцэж хяналтын шатны шүүхэд хандах эрхтэй. Ингэхдээ 86.2 дугаар зүйлд заасан буюу 7 хоногийн хугацаа олгосон байна. Ингэж заасан нь гагцхүү хоногийн тоог заах бөгөөд, харин давж заалдах журмаар гарсан шийдвэрийг зохигчдоод хүргүүлэх хугацааг заасан байх боломжгүй. Учир нь гагцхүү магадлалыг хүлээн авсныхаа дараагаар зохигчид шийдвэрийг хяналтын журмаар эсэргүүцэхээ шийднэ. Хуульд хяналтын журмаар гомдол гаргах тухай заасан ч энэ үнэндээ хяналтын журмаар өргөдөл гаргана гэсэн утгагтай. Хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл нь: захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам буюу хуулийг зөрчсөн байх. Хууль гэснийг захиргааны маргаан бүхий актыг гарахад баримталсан тусгай хуулийг бус /Барилга байгууламжийн тухай, Замын хөдөлгөөний тухай г.м./ энэ хуулийг бүхэлд нь ойлгох болов уу.

Энэ тохиолдолд өргөн утгаараа хуулийн ойлголтод хамаарах тул давж заалдах шатны шүүхээс ЗХШШТХ ташаа хэрэглэснийг хянах боломжтой болно.

Харин үндсэн хуулийг зөрчсөнийг энэ хүрээнд хянаж, зөрчсөн бол хяналтын журмаар гомдол гаргах боломжтой эсэх нь тодорхойгүй байна.

86.5-д давж заалдах шатны шүүхийн магадлалын талаар хяналтын журмаар гомдол гаргаж болно гэжээ. Энэхүү эрх нь уг хуулийн 91-р зүйл, мөн түүнд дурдсанаар ИХХШ-д тусгагдсан учир 86.5 байх шаардлагагүй юм. Тайлбар:дараах өгүүлбэр нь хуулийн герман орчуулга оновчтой биш байгаагаас улбаатай. Уг нь: "wenn sie der Meinung sind, dass das Gericht bei der Erstellung des Gutachtens die gesetzlich festgelegten prozessuellen Regeln verletzt oder Gesetze falsch angewandt hat," гэж орчуулах нь зөв байх байсан юм.)

Захиргааны хэргийн процессын журам гэдэг нь ЗХШШТХ-ийн анхан шатны шүүхэд хамарах заалтууд биш харин захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх журам гэж ойлгогдож байна. Үүнд мөн ЗХШШТХ-ийн 6 дугаар зүйлд зохицуулагдсан гомдол гаргах асуудал хамаарна. Хууль хэмээх ухагдахуунд анхан шатны шүүхээс тодорхой тохиолдолд мөрдөх ёстой хуульчилсан журам дүрэм хамаарна.

87 дугаар зүйл. Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөх

- 87.1. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан хэлэлцсэн захиргааны хэргийн шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хууль зүйн үндэслэлтэй гэж үзвэл уг шийдвэрийг хэвээр үлдээнэ.
- 87.2. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан хэлэлцсэн захиргааны хэргийн шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг зөв гэж үзсэн хууль зүйн үндэслэлээ магадлалдаа заах үүрэгтэй.

87.3. Анхан шатны шүүх нотлох баримтыг буруу үнэлсэн, эсхүл хууль буруу хэрэглэсэн бол давж заалдах шатны журмаар захиргааны хэрэг хянан хэлэлцсэн шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь өөрчлөх эрхтэй.

Энд зааснаар давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрийг зөв гэж үзвэл түүнийг хэвээр үлдээх буюу батлаад зогсохгүй үндэслэлтэй эсэхийг хянаж шийдвэрлэнэ. Ингэснээр шийдвэрийг зөв, буруу болохыг хүлээн зөвшөөрөөд зогсохгүй үндэслэлийг нь мөн адил хянах зорилготой. Харин шийдвэр нь зөв атлаа үндэслэл нь ташаа бол ямар арга хэмжээ авах талаар энд заагаагүй байна. Харин нотлох баримтыг буруу үнэлсэн, эсвэл хуулийг ташаа хэрэглэсэн бол шийдвэрийг давж заалдах шатны шүүхээс өөрчилж болно.

Харин гагцхүү шийдвэрийн үндэслэл буруу, нотлох баримтыг ташаа үнэлсэн байсан ч шийдвэрийг зөв гэж үзэх тохиолдолд шийдвэрийг өөрчлөх, хэвээр үлдээх дээр дурдсан эрх чөлөө ач холбогдлоо өгнө.

87.3 дугаар зүйлээс үзэхэд давж заалдах шатны шүүхээс ташаа үндэслэлийг засварлах шаардлагатай, эсхүл эцсийн шийдвэр нь зөв тул анхаарахгүй байх талаар тодорхой заагаагүй байна. Өөрөөр хэлбэл үндэслэл нь ташаа байсан ч шийдвэр зөв гарчээ.

88 дугаар зүйл. Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох

- 88.1. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох тохиолдолд дор дурдсан шийдвэрийн аль нэгийг гаргана:
- 88.1.1. Нэхэмжлэлийг хангасан анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгох;
- 88.1.2. Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг буюу бүгдийг хангах;
- 88.1.3. Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг харъяалагдах шүүхэд шилжүүлэх буюу нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах;
- 88.1.4. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой дутагдал илэрсэн, эсхүл шийдвэрт нөлөөлж болохуйц шинэ нотлох баримт илэрсэн бол

захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаах.

- 88.2. Захиргааны хэргийг хянан хэлэлцэхэд хангалттай нотлох баримт цугларсан, шүүх хуралдаан болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуулийн дагуу явагдсан боловч захиргааны хэргийн шүүх нотлох баримтыг буруу үнэлсэн, хуулийг буруу хэрэглэсэн байвал давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүх энэ хуулийн 88.1.1, 88.1.2-т заасан шийдвэрийн аль нэгийг гаргана.
- 88.3. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүх дараах үндэслэл илэрвэл энэ хуулийн 88.1.4-т заасан шийдвэрийг гаргана:
- 88.3.1. Анхан шатны шүүх хэргийн оролцогч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгчийг шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг нь хангалгүй захиргааны хэргийг шийдвэрлэсэн;
- 88.3.2. Хууль бус бүрэлдэхүүнээр захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн;
- 88.3.3. Анхан шатны шүүх энэ хуулийг зөрчсөн нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гаргахад нөлөөлөхөөр байвал;
- 88.3.4. Шүүх шаардлагатай нотлох баримтыг дутуу бүрдүүлсэн, эсхүл хуулийн шаардлага хангаагүй нотлох баримтыг захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн үндэслэл болгосон;
- 88.3.5. Шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй;
- 88.3.6. Шүүхийн шийдвэрт шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан.

I. Ерөнхий зүйл

Энд давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдолд үүсэх үр дагаврыг зохицуулжээ:

1 дүгээр хувилбар: нэхэмжлэлийг хангасан анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгох,

2 дугаар хувилбар: нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг буюу бүгдийг хангах,

3 дугаар хувилбар: анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг харъяалагдах шүүхэд шилжүүлэх буюу нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах,

4 дүгээр хувилбар: хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой дутагдал илэрсэн, эсхүл шийдвэрт нөлөөлж болохуйц шинэ нотлох баримт илэрсэн бол захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаах.

II. Хэргийн шийдвэрийг хүчингүй болгож, анхан шатны шүүхэд буцаах жагсаалт:
88.3.1-ээс 88.3.6-д зургаан тохиолдолд 88.1.4-т заасан шийдвэрийг гаргана. Энэ тохиолдолд нотлох баримтыг буруу үнэлж, хууль зөрчсөн бол анхан шатны шүүхийн

шийдвэрийг хүчингүй болгож, хэрэг маргааныг дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаана. Үүнд дараах тохиолдол хамаарна:

- эрх бүхий этгээдийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулаагүй /88.3.1/,
- хууль бус бүрэлдэхүүнээр захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн /88.3.2/,
- анхан шатны шүүх энэ хуулийг зөрчсөн нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гаргахад нөлөөлсөн буюу нөлөөлөхөөр байвал /88.3.3/,
- шүүхээс нотлох баримтыг дутуу бүрдүүлсэн /88.3.4/,
- анхан шатны шүүх хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн /88.3.5/,
- анхан шатны шүүхийн шийдвэрт шүүгч гарын үсэг зураагүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан.

Нилээд өргөн хүрээг хамрах энэхүү жагсаалт нь ялангуяа 88.3.5-д заасан хуулийг буруу тайлбарласан тохиолдолд анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох боломжийг хангасан нилээд ноцтой гэж хэлж болох зохицуулалтыг хангажээ. Буруу тайлбарлана гэснийг хуулийг хэрэглээгүй, буруу хэрэглэсэнтэй адилтган үзэж болохгүй. Энэ нь давж заалдах шатны шүүхэд анхан шатны бүх шүүх, захиргааны байгууллагын өмнө хууль тайлбарлах бүрэн эрхийг олгож байна гэсэн үг. Харин хүлээн зөвшөөрөгдсөн арга барилаар хууль тайлбарлах ажиллагааг гагцхүү дээд шатны шүүх хэрэгжүүлдэг.

Гэхдээ 88.3.5-д зааснаар давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчлөх боломжгүй бол энэ эрхийг эдлэх бөгөөд энэ нь нилээд түгээмэл тохиолддог. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хууль зүйн үйлчлэл нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааныхтай нэгэн адилаар гагцхүү зохигч талуудын хооронд үүссэн үед хуулийг буруугаар тайлбарлах боломж онолын хувьд гарахгүй. Харин хуулийг буруу хэрэглэсэн бол хэргийг давж заалдах, хяналтын журмаар шийдвэрлэх явцад шийдвэрийг хүчингүйд тооцож буцаах үр дагавар үүснэ.

Гэвч энэ үр дагавар нь хуулийг буруу тайлбарласан гэсэн үндэслэл гарахад үүсвэл доод шатны шүүхээс гарсан бүх шийдвэр нь дээд шатны шүүхээс хамаарна.

89 дүгээр зүйл. Давж заалдах журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн заалтыг заавал биелүүлэх

89.1. Захиргааны хэргийн шүүхийн магадлалд дурдсан заалтыг хэргийг дахин хэлэлцэж байгаа шүүх заавал биелүүлнэ.

89.2. Давж заалдах шатны журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэрт заагдаагүй буюу түүгээр няцаагдсан байдлыг өөрөө тогтоох буюу нотлогдсон гэж үзэх, түүнчлэн уг хэргийг дахин хэлэлцээд ямар шийдвэр гаргавал зохихыг анхан шатны шүүхэд зааж өгөх эрхгүй.

89.1-д анхан шатны шүүх нь давж заалдах шатны шүүхээс гарсан магадлалын заалтыг заавал биелүүлэхээр заасан байна. Өмнөх заалтад давж заалдах шатны шүүхээс гаргах шийдвэрийн төрлийг нэрлэсэн ч /анхан шатны шийдвэрийг хэвээр

үлдээх, өөрчлөх, хүчингүй болгох г.м./ заалт биелүүлэх тухай шууд буюу формаль маягаар өөрчлөх буцаах тухай агуулгыг тодорхой заагаагүй байна. Энэ төрлийн заалт буюу зааврыг давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүх хуулийг буруу тайлбарласан, хуулийг хэрэглээгүй буюу буруу хэрэглэсэн гэж шүүмжилсэн тохиолдолд зааварчилах эрхийг тодорхойлж болох юм.

Энэ тохиолдолд шийдвэрийг хэсгээр буюу бүхэлд нь хүчингүй болгосон, дахин шийдүүлэхээр буцаасан шийдвэр бүрт зааварчилга агуулагдаж байна гэж дүгнэх боломжтой. Зохицуулалтад магадлалын заалтын талаар дурдсан байх бөгөөд давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг баримтлах шаардлагатай талаар заагаагүй байна.

89.2-т нөгөө талаас анхан шатны шүүхээс тогтоогоогүй буюу үндэслэлгүй болохыг тогтоосон нөхцөл байдлыг давж заалдах шатны шүүхээс тодорхойлохоор өөрөө ажиллагаа явуулаагүй бол хязгаар тогтоожээ. Энэ утгаараа давж заалдах шатны шүүхийн ажиллагаа нилээд хязгаартай бөгөөд үндсэндээ хяналтын шатны шүүхийн үйл ажиллагаанд нилээд ойртсон байна. 89.2 нь давж заалдах шатны хянан шийдвэрлэх ажиллагааг хяналтын шатны хянан шийдвэрлэх ажиллагаанд ойртуулах зорилготой биш гэж бодож байна.

Хуулийн энэхүү заалт нь давж заалдах шатанд шинээр нотлох баримт гаргаж тавих асуудлыг гаргуулахгүй байх зорилготой юм бол анхан шатанд бүхий л нотлох баримтуудаа гаргаж тавихыг талуудаас шаардаж байгаа юм. Ингэснээр хянан шийдвэрлэх ажиллагааг нягтруулж байгаа юм.

Германд ч гэсэн давж заалдах шатанд ийм байдлыг үүсгэх шаардлагатай гэж үздэг бөгөөд харин энэ зорилгод хүрэхийн тулд өөр арга замыг сонгосон юм. Үүний тулд нотлох баримтуудаас татгалздаагүй, харин гагцхүү дор дурдсан нөхцөл хангагдсан тохиолдолд хэргийг давж заалдах шатанд шилжүүлдэг юм. Үүнд:

- Анхан шатны шүүхийн шийдвэр зөв зүйтэй гэдэг нь ихэд ноцтой эргэлзээ төрүүлж байвал
- Шийдэхэд онцгой хүндрэлтэй нөхцөл байдал ба эрх зүйн асуудал
- Хэргийн шийдэл зарчмын чухал ач холбогдолтой бол. Учир нь: тухайн шүүх гол асуудлаар дээд шатны шүүхээс өөр байр суурьтай тохиолдол
- Анхан шатны шүүх шийдвэр гаргахдаа процедурын алдаа гаргасан ба тэр нь түүний шийдвэрийн үндэслэл болсон бол.

Гагцхүү дээр дурдсан нөхцлүүдийн аль нэг нь хангагдсан байвал анхан шатны шүүх хэргийг давж заалдах шатанд шилжүүлэхийг зөвшөөрдөг. Анхан шатны шүүх татгалзсан тохиолдолд холбогдох тал дээд шатны шүүхэд гомдол гаргаж болно.

Германы энэхүү шийдэл нь хянан шийдвэрлэх ажиллагааг түргэтгэх ба эцсийн шийдвэрийн хүчин төгөлдөр болох хугацааг үндэслэлгүй хойшлуулахаас урьдчилан сэргийлэх зорилготой юм. Үүнээс гадна германы захиргааны процессын эрх зүйн нэгэн заалтыг дурдая. Энэ зарчим нь мөн монголын захиргааны процессын эрх зүйд тусгагдах нь зүйтэй хэмээн үзэж байна. Германы ЗХХШТХ-ийн 129 дугаар зүйлд зааснаар давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг нэхэмжлэгчийн хувьд хохиролтойгоор өөрчлөхийг хориглодог (reformation in reus хориг).

Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйт төрийн баталгаад үндэслэн дээр дурдсан зарчмыг монголын эрх зүйд Үндсэн хуулиар баталгаажуулах зохимжтой санагдана.

89.2.-ыг 88.1.4 ба 88.3-тай холбож үзэх ёстой тул мөн өөр хувилбар байж болох талтай. Үүний дагуу бол анхан шатны шүүх нотлох баримтыг буруу үнэлж, үнэлгээний процессыг буруу явуулсан тохиолдолд хэргийн талууд анхан шатны шүүхэд буцаах боломжтой. Энэхүү зөрчилтэй асуудлыг хэргийн талууд анхан шатны ажиллагааны үеэр гаргаж тавих боломжтой ба үүрэгтэй нотлох баримтуудыг 89.2-ын дагуу давж заалдах шатны хянан шийдвэрлэх ажиллагаанд хамааруулахгүйгээр шийдэж болох юм.

Энэ тохиолдолд нөхцөл байдлыг тогтооход хэргийн талуудыг зарим тохиолдолд оролцуулах шаардлага гарах тул мөрдөн шалгах зарчмыг тодорхой хэмжээгээр сулруулах явдал гарна. Давж заалдах шатны шүүх ямар шинэ нотлох баримтыг олж илрүүлэх талаар ЗХХШТХ-ийн 88-р зүйлд дэлгэрэнгүй тусгасан байна. (Тайлбар: 138-р хуудсанд төгсөв)

90 дүгээр зүйл. Захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргах

- 90.1. Хэргийн оролцогч нь захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах, хойшлуулах, түдгэлзүүлэх талаар гарсан захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор Улсын дээд шүүхэд гомдол гаргаж болно.
- 90.2. Уг гомдлыг энэ хуулийн 85 дугаар зүйлд заасан журмаар хэлэлцэж дараах байдлаар шийдвэрлэнэ:
 - 90.1.1. Захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхих;
 - 90.1.2. Захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаах;
 - 90.1.3. Захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хүчингүй болгож, асуудлыг өөрийн магадлалаар шийдвэрлэх.

Энэ зохицуулалтад эрх зүйн хамгаалалтын онцгой хэрэгсэл болох гомдлыг зохицуулжээ. Гомдлыг анхан шатны тодорхой шийдвэрийг эсэргүүцэж дээд шатны шүүхэд гаргах эрх олгожээ.

Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж гарсан бол тогтоол, захирамжийг эсэргүүцэж эрх бүхий этгээдүүдээс дээд шатны шүүхэд хандаж хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлсэн, хойшлуулсан, тасалдсаныг хянуулах боломжтой. Үүнтэй зэрэгцээд гомдлыг шийдвэрлэхдээ энэ хуулийн 85 дугаар зүйлийг хэрэглэж болохоор заажээ. 90.2-т зааснаар шүүх нь гомдлыг анхан шатны шүүхэд буцаах, тогтоолыг хүчингүй болгох боломжтой байна.

Харин 90.2.2, 90.2.3-т захирамж, тогтоолыг дээд шатны шүүх өөрөө шийдвэрлэх эрхтэй. Хуульд хэдийд хүчингүй болгох, буцаах, дээд шатны шүүх өөрөө шийдэхийг заагаагүй байна.

АРАВДУГААР БҮЛЭГ

Хяналтын журмаар захиргааны хэрэг хянан
шийдвэрлэх ажиллагаа

91 дүгээр зүйл. Хяналтын журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх

91.1. Хяналтын журмаар гомдол гаргах, түүнийг шийдвэрлэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172-178 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

Хяналтын журмаар буюу гагцхүү хуулийн биелэлтийг Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимаас хянах шатанд гомдол гаргах ажиллагааг ИХШХШТХ-д заасны дагуу зохицуулагдана.

Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан
шийдвэрлэх тухай хууль

16 ДУГААР БҮЛЭГ

Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

172 дугаар зүйл. Хяналтын журмаар гомдол гаргах

- 172.1. **Анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлээд гаргасан шүүхийн шийдвэр буюу энэ хуулийн 167 дугаар зүйлд заасан магадлалд зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй.**
- 172.2. Хяналтын журмаар дараах үндэслэлээр гомдол гаргана:
- 172.2.1. шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийг буруу хэрэглэсэн;
 - 172.2.2. хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн.
- 172.3. Дор дурдсан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн гэж үзнэ:
- 172.3.1. шүүх хуралдаанд оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч зайлшгүй биечлэн оролцох хэрэгт тэднийг оролцуулаагүй;
 - 172.3.2. хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн;
 - 172.3.2. хэргийн оролцогчийн эрхийг ноцтой зөрчсөн.

Хяналтын журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 91 дүгээр зүйлийн дагуу Монгол Улсын ИХ-ийн хяналтад хамаарах зүйл ангийг хэрэглэхээр

заажээ. (ИХ-ийн 172 дугаар зүйл болон бусад холбогдох зүйл ангиуд) 172.1-д мөн ИХ-ийн 167 дугаар зүйлд дурдсан шүүхийн шийдвэрүүдийн талаар хяналтын шатны шүүхэд хандах боломжуудыг тусгажээ. 172.2-т хяналтын шатны шүүхэд хандах шалтгаануудыг тоочжээ. Хууль зөрчсөн асуудлуудыг буруу хууль ба хуулийг буруу хэрэглэсэн гэж ялгаж салгаж байна. Ийм байдал хуулийг адил төстэй хэрэглэх явдлыг боломжгүй болгож байна.

Германд бол хуулийг адил төстэй хэрэглэхийг гагцхүү Эрүүгийн хуульд хориглодог. Хуулийг буруу ойлгох талаар дурдахад, хууль тогтоогч захиргааны байгууллагад үйлдэл хийх буюу үнэлгээ өгөхдөө үзэмжээрээ шийдвэрлэх эрх олгосон бол энэ нь шүүхэд хамаатай байж болох юм.

173 дугаар зүйл. Хяналтын журмаар гаргасан гомдол хүлээж авах

- 173.1. Хяналтын журмаар гаргасан гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх хүлээж авна.
- 173.2. Гомдол хүлээж авсан шүүх хэрэгт улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, зохигчийн гомдлыг хавсарган гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш нийслэлд 3 хоногийн дотор, хөдөө орон нутагт 14 хоногийн дотор Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.
- 173.4. Хяналтын журмаар гомдол гаргаж байгаа этгээдээс энэ хуулийн 57.1-д заасны дагуу улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлүүлнэ.

173 дугаар зүйл. Хяналтын журмаар гаргасан гомдол хүлээж авах.

173.3. Энэ заалт нь эрх хэмжээ тогтоосон норм хэм хэмжээ мөн бөгөөд тэр нь шийдвэр гаргасан анхан шатны шүүх нь хяналтын журмаар гаргасан гомдлыг хүлээж авах үүрэгтэй гэсэн үг.

173.2-ын дагуу Дээд шүүхэд хаягласан гомдол гаргах хугацаа нь хот, хөдөөгөөс хамааран өөр өөр байх юм байна.

174 дүгээр зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа

- 174.1. Хэргийг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.
- 174.2. Сонгуулийн холбогдолтой хэргийг хяналтын шатны шүүх хүлээн авснаас хойш 7 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ.

Хэрэг хянан шийдвэрлэх хугацаа.

Энд дурдсан хяналтын 30 хоногийн хугацаа нь хяналтын журмаар хэрэг шийдвэрлүүлэх гомдлыг гаргасан өдөр ба хяналтын шүүх хуралдаан эхэлсэн өдөр хоорондын хугацаа юм.

Иймд энэ нь хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлүүлэхтэй холбогдол бүхий давж заалдах гомдол гаргах хугацаа биш юм.

175 дугаар зүйл. Хэргийн оролцогчид мэдэгдэх

- 175.1. Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч хяналтын шүүх хуралдаанд оролцохыг хүсвэл шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг мэдэгдэнэ.
- 175.2. Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй явдал хэргийг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.
- 175.3. Зохигч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд гомдлын талаар тайлбараа гаргах эрхтэй.

175.1-ийн заалт нь хэргийн оролцогчид хүсэлт гаргасан нөхцөлд шүүх хуралдааны болох газар, цагийг мэдэгдэх үүргийг ногдуулж байна. Энэ нь өмгөөлөгчийг оролцуулсан процессын жинхэнэ шинж тэмдэг. Ийм нөхцөлд оролцогч талуудын төлөөлөгчид хянан шийдвэрлэх ажиллагааны зарим чухал асуудлыг хэлэлцэх журмыг чөлөөтэй тогтоодог. Хэргийн талуудад мэдээлэх явдал нь уг нь эрх зүйт төрийн чухал элемент мөн. Иймд энэ журмыг захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хэрэглэх нь эргэлзээтэй юм. ИХ-ийн 175 дугаар зүйлд дурдсан мэдээг хэргийн оролцогчдод нийгмийн ашиг сонирхлын үүднээс заавал хүргүүлэх ёстой хэмээн ойлгох нь зөв зүйтэй болно.

175.2-т оролцогч талууд шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй нөхцөлд хэрхэх асуудлыг зохицуулахдаа тэдний ирээгүй явдал нь шүүхийн үйл ажиллагаанд саад болохгүй хэмээсэн байна. Ийм хандлага бол цэвэр иргэний процессоос үүдэн гарч байгаа үр дагавар юм. Учир нь оролцогч талууд шүүх хуралдааны талаархи мэдээллийг авах эсэхээ өөрсдөө шийддэг. Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд ийм нөхцөл байдал байх ёсгүй гэж үзвэл нийтийн эрх зүйн шүүх ажиллагаанд оролцож байгаа талуудад ийм байдлаар хандахыг зөвшөөрч үл болно.

Энэ тохиолдолд нийтийн эрх ашиг хөндөгдөж байгаа учир түүнд хувийн ашиг сонирхлоос өөрөөр хандах ёстой.

176 дугаар зүйл. Хяналтын шатны шүүх хуралдаан

- 176.1. Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн иргэний хэргийн танхимын 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.
- 176.2. Танхимын шүүх хуралдаанаас тогтоол гаргана. Тогтоолд шүүх хуралдаан даргалагч, илтгэсэн шүүгч гарын үсэг зурна. Тогтоолд анхан шатны болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын агуулга, түүний үндэслэл, гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тусгана.
- 176.3. Танхимын шүүх хуралдааны тогтоолыг гомдол гаргагч этгээд хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хууль зөрчсөн үндэслэлээр Улсын дээд шүүхэд гомдол гаргаж болно. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл дүгнэлт гаргаж уг хэргийг Улсын дээд шүүхийн хуралдаанд хэлэлцүүлнэ.
- 176.4. Ерөнхий шүүгчийн дүгнэлтэд гомдлын үндэслэл, хэрэг шийдвэрлэсэн байдал, хууль зөрчсөн гэсэн үндэслэлийг тусгасан байна.
- 176.5. Улсын дээд шүүхийн хуралдаан Улсын дээд шүүхийн нийт шүүгчдээс бүрдэнэ. Энэхүү хуралдаанаас тогтоол гаргах бөгөөд энэ нь эцсийн шийдвэр болно.

176.6. Танхимын шүүх хуралдааны тогтоолд гаргасан гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх хүлээн авч хэргийн хамт Улсын дээд шүүхэд ирүүлнэ.

176.1-д дурдсан шүүгчдийн бүрэлдэхүүнийг томилох журам нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүгчдийн бүрэлдэхүүнийг томилох журамд үл нийцнэ. Учир нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх шүүгчдийн бүрэлдэхүүнийг иргэний танхим биш, харин захиргааны хэргийн танхим томилдог билээ. Бусад заалт нь Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын тогтоол, шийдвэрт хэрэглэж болох юм.

176.3-т гомдлыг 30 хоногийн дотор Дээд шүүхэд гаргаж болох тухай заажээ. Гомдол гаргах шалтгаан болсон шийдвэрийг гаргасан шүүх бүрэлдэхүүний тэн хагас нь иргэний танхимын шүүгчдээс бүрдэж байсан гэж энэхүү заалтаас ойлгогдож байна. Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч гомдлыг хэрхэх талаар шийддэг байна. Гомдлыг хүлээж авсан нөхцөлд түүнийг Улсын дээд шүүхийн бүрэн бүрэлдэхүүнээр хэлэлцдэг байна.

176.4-т Дүгнэлт (германаар “шийдвэр” гэж бичсэн байна)-ийн агуулгын талаар дурджээ.

176.5-д Улсын дээд шүүхийн хуралдааны шүүгчдийн бүрэлдэхүүнийг дахин тодотгосон байна. Улсын дээд шүүхээс гаргасан тогтоол нь эцсийн шийдвэр болдог байна. Энэ журам нь мөн захиргааны хэрэгт адил хамаарна.

176.6. Энэхүү онцгой ач холбогдол бүхий гомдол гаргах журамд нэмэлт тодруулга өгч байна.

177 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх.

177.1. нь Улсын дээд шүүхийн хуралдаанаар (176.5) асуудлыг олонхийн саналаар шийддэг тухай заалт юм. Асуудлыг шийдэхэд хуулиар тогтоосон шүүгчдийн тоо шийдвэрлэх үүрэг рольтой. Санал тэнцсэн тохиолдолд гомдлыг хүлээж аваагүйд тооцдог байна.

178 дугаар зүйл. Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн тогтоол.

178.1. Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүх дараахь байдлаар хэргийг хянан шийдвэрлэж тогтоол гаргана.

178.1.1. Шийдвэр магадлал, тогтоолдыг хэвээр үлдээж гомдлыг хангахгүй орхих.

178.1.2. Шийдвэр магадлал тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах.

178.1.3. Шийдвэр магадлал тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөх.

178.1.4. Шийдвэр магадлал тогтоолыг хүчингүй болгож хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох.

178.1.5. Шийдвэрийг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны болон давж заалдах шатны шүүхэд буцаах.

- 178.2. Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлсэх шүүхийн тогтоол гармагц хуулийнн хүчин төгөлдөр болно.
- 178.3. Улсын дээд шүүхийн хяналтын журмаар хянан шийдвэрлсэн тогтоол эцсийн шийдвэр болно.

176.3 ба 5-аар зохицуулагдаагүй Дээд шүүхийн бусад шийдвэрүүдийн талаар энэхүү зүйлд дэлгэрэнгүй тусгасан байна. Дээд шүүх гомдлын үндсэн дээр шийдвэр гаргах бөгөөд үүгээр гомдлын шалтгаан болсон тогтоолыг хэвээр үлдээх буюу өөрчилдөг байна.

178.1.3-ын дагуу шүүхийн шийдвэрийг (“тогтоол” гэсэн байна-орч.) бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгож болдог байна.

Ялангуяа 4, 5, 6-ийн заалтуудыг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хэрэглэх нь эргэлзээ төрүүлж байна. Учир нь тэнд анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох асуудлаас гадна захиргааны байгууллагуудын тогтоол, шийдвэр, захирамжуудын талаар гарсан гомдлуудыг авч хэлэлцдэг. Жишээлбэл шийдвэрийг хүчингүй болгох гэсэн томъёолыг гагцхүү шүүхийн шийдвэрийн хувьд хэрэглэж болохоос биш захиргааны акт буюу захиргааны бусад шийдвэрүүдэд хэрэглэж болохгүй. Хэргийг анхан шатны шүүх эсхүл давж заалдах шатны шүүхэд буцаах эсэх гэдэг нь тодорхой биш байна. (178.1, 5.) Энд мөн Улсын дээд шүүхийн хуралдааны шийдвэр нь эцсийнх байна гэжээ.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг дахин хянах

92 дугаар зүйл. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлэх

92.1. Хуулийн хүчин төгөлдөр болсон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179-182 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

92 дугаар зүйл. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлэх,

... Шинэ нөхцөл байдал илэрвэл анхан шатны захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг дахин хянуулах боломжтой юм (хянан шийдвэрлэх ажиллагааг дахин явуулах журмаар). Аймгийн ба нийслэлийн шүүхүүд энэхүү хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хүчин төгөлдөр болсон шийдвэрийн гүйцэтгэлийг түдгэлзүүлэх, хэргийн материалыг татаж авах эрхийг эдэлдэг байна (ИХШХШХ-ийн 179, 180 дугаар зүйл). Эдгээр шүүх нь мөн

хянан шийдвэрлэх ажиллагааг дахин явуулахыг шийддэг байж таарна. Уул шүүхүүдийн талаархи гомдлыг Улсын дээд шүүхэд гаргана (ИХШХШХ-ийн 181 дүгээр зүйл).

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

93 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх

- 93.1. Захиргааны хэргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр /шийдвэр, магадлал, тогтоол, шүүгчийн захирамж/-ийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183-188 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу албадан биелүүлнэ.

94 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

- 94.1.Энэ хуулийг 2004 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.**

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2005.03.31

Дугаар 2/02

Улаанбаатар хот

**Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт
Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүн Н.Жанцан, Ж.Амарсанаа, Ч.Дашням /илтгэгч/, Ц.Сарантуяа нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Хуралдаанд өргөдөл гаргагч Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч С.Магнайсүрэн, мөн дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугч Б.Энхбаяр, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэн нар хуралдаанд оролцлоо.

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.6-д Монгол Улсын Засгийн газар, Сонгуулийн ерөнхий хороог Захиргааны хэргийн шүүхийн хянан хэлэлцэх маргааны харъяалалд хамааруулан заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч, иргэн С.Магнайсүрэн, мөн дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Энхбаяр нар Үндсэн хуулийн цэцэд 2005 оны 3 дугаар сарын 11-ний өдөр ирүүлсэн байна.

Өргөдөл гаргагчид Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 16 дугаар зүйлийг тус тус үндэслэл болгон Үндсэн хуулийн цэцэд хандаж байгаагаа тэмдэглэсэн байна.

Уг өргөдөлд:

1.Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д Монгол Улсын Засгийн газраас гаргасан шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянан үзэхээр зааж, уг хуулийн 8.1.2-т заасны дагуу хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болохоор заасан нь Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1, 45 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн.

Учир нь, Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1-д: “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1-д: Засгийн газар нь “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах” бүрэн эрхтэй гэж заасан. Ийм ч учраас Монгол Улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд “1.Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх

ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна. 2.Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана”, 45 дугаар зүйлийн 2-т: “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэж хуульчилсан.

Энэ нь Улсын Их Хурал, Засгийн газар /бас Үндсэн хуулийн цэц/-аас өөр субъект Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгохгүй гэдгийг шууд тодорхойлсон хэрэг бөгөөд үүнтэй төсөөтэй харилцааг зохицуулсан Үндсэн хуулийн бусад зүйл, хэсгийн заалтаас ч харж болохоор байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлийн 2-т: “Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Ерөнхийлөгч өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэж заасан ба энэхүү үзэл баримтлалын дагуу Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаанд Ерөнхийлөгчийн баталсан шийдвэрийг хамааруулаагүй байна. Түүнчлэн Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2-т: “Хэрэв Улсын Дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын Дээд шүүх өөрөө хүчингүй болгоно” гэж заасан байна.

Эндээс үзэхэд Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Дээд шүүх гэсэн Үндсэн хуульд заагдсан эдгээр байгууллагуудын шийдвэрүүдийг хүчингүй болгохтой холбогдсон дээрх заалтууд нь угтаа хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн салаа мөчир тус бүрийн эрх мэдлийн харилцан зааг хязгаар, хариуцлагыг тогтооход чиглэгдсэн байна.

2.Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг захиргааны актад тооцож уг хуулийн 8.1.2-т заасны дагуу Захиргааны хэргийн шүүх хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болохоор заажээ. Энэ нь Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтыг зөрчсөн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1-д: “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж заасан. Сонгууль бол төлөөллийн ардчилал, улсын тусгаар тогтнол, төрийн бүрэн эрхт байдлын баталгаа, иргэний сонгох, сонгогдох эрхийн илэрхийлэл мөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад Үндсэн хуулийн цэцээс хянан шийдвэрлэх маргааны нэг төрөл болгон “ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх”-д Үндсэн хуулийн цэц хяналт тавихыг оруулж заасан нь нэг талаас, Монгол Улсын иргэний сонгуулийн /сонгох, сонгогдох/ буюу тус Улсын Үндсэн хуулиар олгосон улс төрийн эрхийг Үндсэн хуулийн эрх зүйн өндөр төвшинд хамгаалуулах боломжийг Монгол Улсын иргэдэд олгох; нөгөө талаас, Монгол Улсын төрийн эрх барих болон бусад дээд байгууллагыг сонгож байгуулах, түүний нийтийг засаглах дээд эрх мэдлийн хууль ёсны шинжийг хүлээн зөвшөөрүүлэхтэй холбоотой.

Сонгуулийг зохион явуулах үүргийг сонгуулийн байгууллагууд хариуцах ба сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах үүрэгтэй сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн үнэн зөв, эргэлзээгүй байдлаас хамаарч нийт сонгогчдын хүсэл зориг шударгаар илэрхийлэгдэж чадах эсэх нь тодорхойлогдох, сонгуульд оролцогч бусад этгээдийн эрх зүйн байдал /статус/-д өөрчлөлт ороход хүргэдэг, мөн сонгуулийн баталгаажсан үр дүнгээр засаг төрийн тогтвортой залгамж чанар хадгалагдах, үндэсний эв нэгдэл хангагдах, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагыг хууль ёсоор эмхлэн байгуулах зэрэг төрийн эрх мэдлийг Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд хэрэгжүүлэх үндэс болж байдаг. Ийм ч учраас Үндсэн хуулийн үзэл баримтлалд сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай маргааныг гагцхүү Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэж байхаар зааж өгсөн нь тодорхой байна.

Манай улсын хууль тогтоомжоор өдгөө сонгуулийн байгууллагууд захиргааны журмаар сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэж байгаагаас гадна сонгуулийн тодорхой зөрчилтэй буюу сонгуулийн өмнөх ухуулга сурталчилгааны журам зөрчсөн зэрэг хэргүүдийг захиргааны шийтгэл ногдуулах журмаар ердийн шүүхийн шүүгч хяналт тавьж хариуцлага хүлээлгэдэг, харин сонгогчдын нэрсийн жагсаалтын талаар гомдлоо хэсгийн хороонд гаргаад, гаргасан шийдвэрийг нь эс зөвшөөрвөл шууд ердийн шүүхэд хандаж, иргэний процессын журмаар шийдвэрлүүлдэг бол сонгуулийн төв байгууллагын шийдвэрийг Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тусгай журмаар хянан үзэх эрх зүйн журам үйлчилж байна.

Гэтэл Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтаар Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргааны хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг хамааруулснаар Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн харилцаанд оролцогч сонгуулийн төв байгууллага ба сонгогч, нэр дэвшигч, сонгуульд оролцохоо Сонгуулийн ерөнхий хороонд албан ёсоор илэрхийлж бүртгүүлсэн нам, эвсэл зэргийн хооронд үүсч болох нийтийн эрх зүйн аливаа маргааныг нь захиргааны хэргийн шүүхэд шийдвэрлэгдэж байх давуу боломжийг олгосон байна.

Энэ нь нэгд, сонгуулийн төв байгууллага ба сонгогч, нэр дэвшигч, нэр дэвшүүлсэн нам, эвслийн Үндсэн хуулийн эрх зүйн статусыг хөндсөн, хоёрт, сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хуульд нийцсэн байхад ч тодорхой нэгэн этгээдийн эрх ашигт нийцүүлж уул шийдвэрийг хүчингүй болгож байх бүрэн эрхийг захиргааны хэргийн шүүхэд олгосон, гуравт, сонгуулийн төв байгууллагын шийдвэрийг хянан үзэх талаарх халдашгүй байдлын хүрээг ийнхүү хумиснаар хэн боловч өөрийн эрх зөрчигдсөн нэрийдлээр сонгуулийн байгууллагын хууль ёсны шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлж зогсоох, сонгуульд оролцогчдын хоорондох зөрчилдөөнийг хурцатгах, сонгуулийн дараа ч гэсэн шүүхийн арга замаар ялах “горьдлого” төрүүлэх, шүүхийн процесст сонгуулийн байгууллагууд нэг нэгнийхээ эсрэг нотлох баримт гаргах, хэргийн аль нэг талд гэрчээр оролцох зэргээр “ажимлах”, мөн сонгуулийн байгууллагууд шат

шатандаа захиргааны урьдчилан шийдвэрлэх журмаас болж олон гомдол, өргөдөл дарагдаж сонгуулийг богино хугацаанд багтааж шийдвэрлэж чадахгүй байх, шийдвэрлэсэн ч шүүхээс түүнийг тухай бүр өөрчлөх, эсхүл сонгууль зохион явуулах үндсэн үүргээсээ хазайж хөрөнгө хүч, цагийг маргаан шийдвэрлэхэд зориулах, түүнчлэн шүүх олон нэхэмжлэлд дарагдаж, сонгуулийн маргаантай хэргүүдийг шийдвэрлэх явц хэт сунжрах, үүний улмаас сонгуулийн үр дүн хуульд заасан хугацаанд гарахгүй байх, сонгогчдын эрх хохирох байдалд хүрэхэд дээрх Үндсэн хуулийн бус заалтын сөрөг үр дагаврууд түлхэж байна.

Мөн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг үндэслэн Нийслэлийн захиргааны хэргийн шүүх Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг хянан үзэж байгаа нь ч хууль зүйн хяналтын статус, төвшний хувьд илтэд тохирохгүй байна. Ийм жишиг практик ч олон улсад байдаггүй. Хэрэв Үндсэн хуулийн цэцээс гадна бусад шүүх сонгуулийн төв байгууллагын шийдвэрийг хянаж байх ёстой гэж үзвэл Улсын Дээд шүүх сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн заримыг хууль зүйн агуулга, эрх зүйн маргааны шинж онцлогийн хувьд Үндсэн хуулийн эрх зүйн бус маргаан бол хуулиар нарийвчлан тодорхойлсон нөхцөлд хянаж шийдвэрлэж байх нь Үндсэн хуулийн хяналтаас тусгаарлах үндэслэл болох ёстой.

Үүнээс гадна захиргааны хэргийн шүүх сонгуулийн төв байгууллагын шийдвэрийг нэхэмжлэлийн дагуу хүлээн авч хянан үзэхдээ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмыг мөрдсөн байхыг Сонгуулийн ерөнхий хорооноос шаардахаар хуульд заагдсан байгаа. Гэтэл нөгөө талаар сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хуульд зааснаар Үндсэн хуулийн цэцэд хянагдах бол захиргааны хэрэг бус Үндсэн хуулийн маргаантай хэрэг болдог.

Өөрөөр хэлбэл, Сонгуулийн ерөнхий хороо заавал Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэх албагүй мэт. Тэгэхээр нэг бол сонгуулийн төв байгууллагын аливаа шийдвэрийн талаар Үндсэн хуулийн цэц, захиргааны хэргийн шүүхийн алинд нь ч нэхэмжлэл очихыг үл харгалзаж гарсан маргааныг Сонгуулийн ерөнхий хороо “захиргааны хэрэг” мэт үзэж сонгуулийн хуулиас гадна Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар урьдчилж шийдвэрлэж байх, эсхүл Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийн талаар гомдол гаргагч Үндсэн хуулийн цэцэд эхэлж “зарга” мэдүүлж, дараачаар нь Үндсэн хуулийн цэцийн харъяаллын маргаан бус байвал сая Захиргааны хэргийн шүүх шийдвэрлэж байх гэх мэт Үндсэн хуулийн цэц, захиргааны хэргийн шүүх хоорондын маргааны харъяалал, шалгуур журмыг тодотгож Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар тогтоож өгөөгүй нь Захиргааны хэргийн шүүхэд Үндсэн хуулийн маргаан мөн эсэхийг тодорхойлох боломжийг олгож байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн практикаас үзэхэд Сонгуулийн ерөнхий хорооны Улсын Их Хурлын гишүүнийг сонгох сонгуулийн үр дүнтэй холбогдуулан гаргасан шийдвэрийг Нийслэлийн захиргааны хэргийн шүүх хянан шийдвэр гаргаж байна. Жишээ нь, Улсын Их Хурлын сонгуулийн 24, 59 дүгээр тойргийн

сонгуулийн дүн, дахин санал хураалттай холбоотой маргааныг энд дурдаж болно. Хэрэв уг маргаан Үндсэн хуулийн цэцээр хянагдахгүй бол Сонгуулийн ерөнхий хорооны өөр ямар ч шийдвэр Үндсэн хуулийн цэцээр хянагдахгүй гэдэг нь тодорхой.

Сонгуулийн ерөнхий хорооны Улсын Их Хурлын гишүүнийг сонгох сонгуулийн үр дүнтэй холбогдуулан гаргасан шийдвэр хууль зүйн агуулгаараа ч тэр, Үндсэн хуулийн үндэслэлээр ч тэр Үндсэн хуулийн цэцийн хяналтын шууд объект болж чадна.

Сонгуулийн ерөнхий хорооны тухайн шийдвэр нь зөвхөн тодорхой нэгэн хувь этгээдийн эрх ашгийг хөндсөн, түүнд холбогдох асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн захиргааны байгууллагаас гаргасан нэг удаагийн чанартай захирамжилсэн акт төдий биш учраас Сонгуулийн ерөнхий хорооноос гаргаж буй шийдвэрүүд нь өргөн утгаараа сонгогчийн субъектив эрх, нэр дэвшигч болон түүнийг дэвшүүлсэн нам, эвслийн эрх ашиг, сонгуулийн объектив дэг журмыг хамгаалах нийтийн ашиг сонирхлын зүй ёсны шаардлага, үндэсний эв нэгдлийг хангах зэргийг бодолцож хууль ёс, зүй ёсны дагуу гарах ёстой шийдвэрүүд байдаг.

Чухамдаа эдгээр шийдвэрийг Үндсэн хуулийн заалт түүний үзэл санааны дагуу Цэц л авч үзэж залруулж, нийгэм-төрийн үйл ажиллагаанд ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш эрх, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх Үндсэн хуулийн зарчмыг чандлан сахиулах учиртай.

Эдгээрийг харгалзан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.6 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 2, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад нийцээгүй болохыг магадлан шийдвэрлэж өгөхийг хүсье” гэжээ.

Мөн өргөдөл гаргагч иргэн С.Магнайсүрэн, Б.Энхбаяр нар Үндсэн хуулийн цэцэд 2005 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн тайлбартай холбогдуулж нэмэлт тайлбар ирүүлсэн бөгөөд уг тайлбартаа: “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.2 дахь заалтын “Ерөнхий сайд” гэсэн нь мөн хуулийн 4.1.1 дэх заалтын адил Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт нийцээгүй байгаа тул уул асуудлыг өмнө гаргасан хүсэлтийн хүрээнд магадлан шийдвэрлэж өгөхийг хүсье. Учир нь Ерөнхий сайдын шийдвэр /захирамж/ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1, Дөчин нэгдүгээр зүйлийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ёсоор Засгийн газрын шийдвэрт хамаардаг юм. Гэтэл Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайдын шийдвэрт хамааруулсан нь Үндсэн хуулийн дээр дурдсан заалтуудад шууд харшилж байна” гэж нэмэлт шаардлага тавьсан байна.

Хоёр. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэнтэй холбогдуулж Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцохоор томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэн, С.Баярцогт нар уг маргаантай холбогдуулж Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

1.Захиргааны байгууллага, албан тушаалтан нь нийтийн ашиг сонирхлыг илэрхийлсэн хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр бусдыг

захирамжилсан, иргэн, хуулийн этгээдийн Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн олон тооны шийдвэр гаргаж байгаа боловч практикт захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, тэдний гаргасан захиргааны актын хууль зүйн үндэслэлийг хянах механизмыг оновчтой тогтоох зорилгоор Засгийн газраас 2001 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн бөгөөд энэ хуулийн төсөлд захиргааны хэргийн шүүх нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар, Засгийн газрын гишүүн /Ерөнхий сайд, сайд/, Монгол Улсын яам, Сонгуулийн ерөнхий хороо гэх мэт нийтийн эрх зүйн 17 субъекттэй холбогдсон маргааныг хянан шийдвэрлэхээр тусгасан байв.

Улсын Их Хурлын чуулганаар Ерөнхийлөгчөөс эрх зүйн үр дагавар шууд бий болгодог захирамжилсан шийдвэр гаргах явдал бараг тохиолдохгүй мөн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчсөн бол огцруулах асуудлыг нэгэнт Үндсэн хуулиар зохицуулсан учир хуулийн “Монгол Улсын Ерөнхийлөгч” гэсэн заалтыг хасч, харин гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага болсон Засгийн газрын шийдвэр нь шүүхийн журмаар хянагдаж байх нь зүйтэй гэж үзэж хуулийн төсөлд хэвээр үлдээжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2-ийн “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн заалт нь нэгдүгээрт, төрийн гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага болох Засгийн газарт гаргасан алдаагаа өөрөө засах боломж олгож байгаа; хоёрдугаарт, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлаас Засгийн газрын гаргасан алдааг залруулах явдлыг зохицуулсан зүйл гэж үзэж байна. Практикт дээр дурдсан журмаар Засгийн газрын тогтоол, захирамжийг хүчингүй болгосон явдал тохиолдохгүй байна.

Нөгөө талаас Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу иргэн, хуулийн этгээд нь захиргааны хууль бус гэж үзэж байгаа актын талаархи нэхэмжлэлээ захиргааны хэргийн шүүхэд гаргахын өмнө гомдлоо тухайн байгууллага, албан тушаалтныг харъяалах дээд шатны байгууллага, албан тушаалтнаар урьдчилан шийдвэрлүүлж байхаар хуульчилсан билээ. Улсын Их Хурал нь гомдол, маргаан хянан шийдвэрлэдэг байгууллага биш учраас иргэн, хуулийн этгээдийн гаргасан гомдлыг хянан барагдуулах боломжгүй юм.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12-т Монгол Улсын иргэн “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй”, мөн зүйлийн 14-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх... шударга шүүхээр шүүлгэх... эрхтэй” гэсэн заалтыг иш үндэс болгож, улмаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцийн, тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын “Үндсэн хууль бусад хуулиар олгосон эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй” гэсэн Наймдугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай

олон улсын Пактын “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаварлан гадуурхалтгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй...” гэсэн Хорин зургадугаар зүйлийн заалтуудыг баримтлан захиргааны хэргийн шүүхээс Монгол Улсын Засгийн газрын гаргасан захиргааны хууль бус актай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх тухай асуудлыг хуульчилсан.

Хэрэв Засгийн газрын шийдвэртэй холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх захиргааны хэргийн шүүхийн статус /эрх зүйн байдал, төвшин/ нь тохирохгүй байна гэж үзэж байгаа бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасныг баримтлан Улсын Дээд шүүх шаардлагатай гэж үзвэл ямар ч хэргийг татан авч анхан шатны журмаар хянан шийдвэрлэх эрхтэй билээ. Иймд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д Засгийн газраас гаргасан захиргааны хууль бус актыг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхээр заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна.

2.Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хороо нь Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийг улсын хэмжээгээр эрхлэн явуулах үүрэгтэй байнгын байгууллага бөгөөд бүрэлдэхүүнийг нь 5 жилийн хугацаагаар Улсын Их Хурлаас томилж, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга нь ажлын шаардлагыг харгалзан бүтэн буюу хагас /хавсарсан/ орон тоогоор ажиллаж байхаар Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд хуульчилжээ. Мөн Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлд Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны албан тушаал нь төрийн захиргааны албан тушаалд хамаарахаар заасан билээ.

Иймд Сонгуулийн ерөнхий хороо бол парламентаас байгуулагдаж, нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг, сонгууль бэлтгэн явуулах ажлыг төлөвлөж, зохион байгуулах, сонгуулийн хороодын үйл ажиллагааг нэгтгэн удирдах; сонгуулийн тойргийн хорооны шийдвэрийг давж заалдсан гомдол, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн маргаан бүхий бусад өргөдөл, гомдлыг харъяалмын дагуу хянан шийдвэрлэх зэргээр төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг нийтийн эрх зүйн байгууллага мөн.

Сонгуулийн ерөнхий хорооноос гаргаж буй шийдвэр нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан “захиргааны акт” гэсэн тодорхойлолтод бүрэн нийцэж байгаа юм. Өөрөөр хэлбэл Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр нь 1/захиргааны байгууллагаас гаргасан захирамжилсан шийдвэр, 2/нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн тодорхой нэг тохиолдлыг зохицуулсан, 3/эрх зүйн үр дагавар шууд бий болгосон, 4/ гадагшаа чиглэсэн зэрэг шинжээрээ захиргааны актад хамаарна. Харин өргөдөл гаргагч нарын тайлбарласан шиг Үндсэн хуулийн шинжтэй акт биш юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.8 дахь заалтын дагуу шүүгч захиргааны акт нь Үндсэн хууль зөрчсөн нь тогтоогдсон бөгөөд Үндсэн хуулийн цэцийн маргаан бол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, Үндсэн

хуулийн цэцэд шилжүүлэхээр хуульчилсан юм. Иймд өргөдөлд дурдсан “Үндсэн хуулийн бус эрх зүйн харилцааны хүрээнд захиргааны хэргийн шүүхэд шийдвэрлэгдэж байх давуу боломжийг захиргааны хэргийн шүүхэд олгосон байна” гэсэн саналыг зөвшөөрөх боломжгүй юм.

Мөн “сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай маргааныг гагцхүү Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэж байхаар зааж өгсөн нь тодорхой байна” гэж өргөдөлд дурдсаныг зөвшөөрөх боломжгүй. Учир нь: Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад “ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заасан билээ. Үүнээс үзэхэд аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагаас гаргасан шийдвэртэй холбогдсон маргаан Үндсэн хуулийн цэцэд хамаарахгүй бөгөөд энэ нь захиргааны хэргийн шүүхэд харьяалагдаж байна.

Сонгуулийн ерөнхий хороо нь төрийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэж байгаа нийтийн эрх зүйн субъектын хувьд тус улсад дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулна. Эдгээр хууль тогтоомжийн нэгийг зөрчсөн шийдвэр гаргасан тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд биш захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлүүлнэ.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан захиргааны хууль бус актыг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхээр заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна. “ гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “4.1.1. Монгол Улсын Засгийн газар” гэсэн заалт Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “4.1.6. Сонгуулийн ерөнхий хороо” гэсэн заалт Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2-ын 2 дахь заалтыг зөрчсөн болох нь дараахь үндэслэлээр тогтоогдож байна.

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн нь Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Засгийн газар төрийн гүйцэтгэх дээд байгууллага болохынх нь хувьд түүний шийдвэр хуульд нийцээгүй тохиолдолд хүчингүй болгох эрх бүхий субъектыг Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон байна. Улсын Их

Хурал, Засгийн газар Үндсэн хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд хандаж шийдвэрлүүлж болох нь нээлттэй байна.

Хууль тогтоогчоос Засгийн газрын шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянаж байхаар хуульчилсан нь Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон Засгийн газар, Улсын Их Хурлын эрх хэмжээнд халдсан гэх үндэслэл тогтоогдож байна.

Захиргааны хэргийн шүүхэд төрийн гүйцэтгэх дээд байгууллагын шийдвэрийг хянах эрх хэмжээ Үндсэн хуулиар олгогдоогүй байна.

2. Сонгуулийн ерөнхий хороо хуульд зааснаар ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийг улсын хэмжээнд зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй байгууллага бөгөөд Үндсэн хуульд заасан иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргадаг байна. Дэлхийн ардчилсан улсуудын Үндсэн хуулийн заалтаас үзэхэд энэ төрлийн маргааныг Үндсэн хуулийн шүүхтэй улсад Үндсэн хуулийн шүүх, Үндсэн хуулийн шүүхгүй улсад Дээд шүүх нь хянан шийдвэрлэдэг жишиг тогтсон байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2-т Сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн бол Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заажээ. Гэтэл Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр хуульд нийцээгүй тохиолдолд Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэж байхаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хуульчилсан нь Үндсэн хуулиар Үндсэн хуулийн цэцэд тусгайлан олгосон эрх хэмжээнд халдсан байна.

3. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4.1.2 заалтад “Ерөнхий сайд” гэж оруулсан нь Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1, Дөчин нэгдүгээр зүйлийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн асуудлаар Монгол Улсын иргэн С.Магнайсүрэн, Б.Энхбаяр нар өргөдөл гаргаагүй харин нэмэлт тайлбартаа дурдсан бөгөөд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгээгүй учир дүгнэлт гаргах боломжгүй гэж үзэв.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаан” гэсэн 4 дүгээр зүйлийн “...дараахь байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны хууль бус актад холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ” гэсэн 1 дэх хэсгийн 4.1.1-д “Монгол Улсын Засгийн газар” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн” Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн заалтуудыг, мөн 4.1.6-д “Сонгуулийн ерөнхий хороо” гэж заасан нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-ын ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан

шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргах тухай заалтыг тус тус зөрчсөн байна.

2.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы ажиллагаа эхэлсэн өдрөөс хойш 15 хоногт багтаан энэхүү дүгнэлтийг хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГА
ГИШҮҮД**

**Ж.БЯМБАДОРЖ
Н.ЖАНЦАН
Ж.АМАРСАНАА
Ч.ДАШНЯМ
Ц.САРАНТУЯА**

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

2006.01.25

Дугаар 2/01

Улаанбаатар хот

**Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт
Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүн Л.Рэнчин, П.Очирбат, Ж.Амарсанаа /илтгэгч/, Ч.Дашням нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяа нарыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч З.Энхболд, өргөдөл гаргагч иргэн Ц.Банзрагч, Б.Үнэнбат нар оролцлоо.

Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 12 дугаар хорооны оршин суугч, иргэн Ц.Банзрагч, Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Үнэнбат нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

“Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.2-ын “.../Ерөнхий сайд/...” гэсэн хэсэгт Монгол Улсын Засгийн газраас гаргасан захиргааны актыг Захиргааны хэргийн шүүх магадлан хянаад, тус хуулийн 8.1.2-т заасны дагуу хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болохоор заажээ. Энэ заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн” гэсэн 38 дугаар зүйлийн 1, “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн 45 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчиж байгаа үндэслэлийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

“Монгол Улсын төрийн байгуулал” гэсэн Үндсэн хуулийн Гуравдугаар бүлэгт төрийн эрх мэдлийг Улсын Их Хурал /хууль тогтоох/, Засгийн газар /гүйцэтгэх/, Шүүх эрх мэдэл гэсэн хуваарийн дагуу эрх мэдлийн салаа мөчир болгон тус тусад нь бүрэн эрхийг зааглан тодорхойлсон. Энэхүү хуваарилалт нь эрх мэдлийн салаа мөчир бүрт Үндсэн хуулиар хязгаарлал тогтоож буйн илэрхийлэл бөгөөд эрх мэдлүүд нь бие биенээ тэнцвэржүүлж, улс төр, эрх зүйн хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд ямар нэгэн логик зөрүү үүсэхгүйгээр зохион байгуулагдах ёстой гэж үзэж байна.

Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэж заасан нь Засгийн газрын шийдвэр болох Ерөнхий сайдын захирамжийг хүчингүй болгох эрх бүхий байгууллагыг шууд тодорхойлсон заалт бөгөөд үүнтэй адил зохицуулалтыг Үндсэн хуулийн бусад зүйл, заалтуудаас харж болно. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Ерөнхийлөгч өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно”, мөн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно” гэжээ.

Энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх гэсэн Үндсэн хуулийн байгууллагууд буюу эрх мэдлийн харилцан зааг хязгаар, эрх хэмжээ, хариуцлагыг Үндсэн хуульд хуульчлан тогтоож өгсөн заалт юм.

Дээрх байдлыг нотлон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.1, 4.1.6 нь Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн гэж үзэж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 2/02 дугаар дүгнэлт гаргаж, улмаар уг хуулинд Улсын Их Хурал өөрчлөлт оруулжээ.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.2 дахь хэсгийн “.../Ерөнхий сайд/...” гэсэн нь мөн хуулийн 4.1.1 дэх /Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/02 дугаар дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаас хүчингүй болгосон/ хэсгийн заалтын нэгэн адил Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалттай нийцэхгүй байгаа тул Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.2 дахь заалтын “.../Ерөнхий сайд/...” гэснийг хүчингүй болгох шаардлагатай гэж үзэж байна.

Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна” гэсний дагуу захирамжид Ерөнхий сайд, сайд гарын үсэг зурж баталгаажуулдаг хамтын шийдвэр бөгөөд Ерөнхий сайдын захирамж нь Засгийн газрын шийдвэр юм.

Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д “...Засгийн газрын шийдвэр...”, мөн Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлд “...Засгийн газрын шийдвэр...” гэж тус тус заасан бөгөөд зарим маргааныг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхдээ Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1.2-т

заасны дагуу Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдол сүүлийн үед гарах болсон нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуулинд нийцээгүй, ... хуулийг хэрэглэх эрхгүй” гэсэн заалт мөн адил зөрчигдөхөд хүргэж байна.

Иймд дээр дурдсан нөхцөл байдал, үндэслэлүүдийг харгалзан үзэж Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.2-т тусгагдсан “.../Ерөнхий сайд/...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгтэй тус тус зөрчилдөж байгааг хянан үзэж, Үндсэн хуульд нийцүүлэх талаар дүгнэлт гаргаж өгөхийг хүсье” гэжээ.

Хоёр.Иргэн Ц.Банзрагч, Б.Үнэнбат нар 2006 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаан дээр гаргасан нэмэлт тайлбартаа:

1. Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1-д зааснаар Монгол Улсын Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага болохынх нь хувьд түүний шийдвэр хуульд нийцээгүй тохиолдолд хүчингүй болгох эрх бүхий субъектыг тусгайлан тогтоосон. Улсын Их Хурал, Засгийн газар энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд хандаж шийдвэр шийдвэрлүүлж болох нь нээлттэй.

Хууль тогтоогчоос Засгийн газрын шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянахаар хуульчилсан нь Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон Засгийн газар, Улсын Их Хурлын эрх хэмжээнд халдсан хэрэг болж байна. Өөрөөр хэлбэл Захиргааны хэргийн шүүхэд төрийн гүйцэтгэх дээд байгууллагын шийдвэрийг хянах эрх хэмжээг Үндсэн хуулиар олгоогүй гэж үзэж байна.

Ер нь, төрийн дээд байгууллагуудын шийдвэрийн халдашгүй байдлын хүрээ буюу “дархлаа” гэж байдаг. Засгийн газар нь шийдвэрээ хууль биелүүлэх зорилгоор хуульд нийцүүлэн гаргадаг ба тэр нь тодорхой хувь иргэнд шууд чиглэх биш улс орны тодорхой хүрээ, салбарт үйлчлэхээр гардаг. Тэр утгаараа Засгийн газар, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч зэрэг байгууллагын шийдвэрийн дархлаа, баталгаа нь нийтийн ашиг сонирхол байдаг. Хэрэв Засгийн газар үнэхээр хууль тогтоомжид нийцэхгүй шийдвэр гаргавал Улсын Их Хурал Үндсэн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрхийнхээ дагуу хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах, улс төрийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн: “1.Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.

2.Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана” гэснээр тодорхойлогдож байна. Тэрчлэн Ерөнхий сайд тодорхой хувь этгээдийн ашиг сонирхлыг зөрчсөн шийдвэр гаргадаггүй нь “Ерөнхий сайдын бүрэн эрх” гэсэн Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлээс тодорхой байгаа билээ.

3.Засгийн газрын шийдвэр хууль тогтоомжид нийцээгүй гэж иргэн, хуулийн этгээд үзвэл Засгийн газарт өөрт нь, эсхүл Улсын Их Хурлын гишүүнд буюу шууд Улсын Их Хуралд өөрт нь хандан шийдвэрлүүлэх эрх Үндсэн хууль, бусад хуулиар иргэдэд

нээлтэй юм. Хэрэв хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгох эрхийг Улсын Их Хуралд хүлээлгэсэн байна. Үүнээс гадна, Засгийн газар Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг үндэслэн Засгийн газрын хууль тогтоомжид нийцээгүй шийдвэрийг Үндсэн хуулийн цэцэд хандан шүүхийн журмаар шийдвэрлүүлэх боломжтой юм.

4.Монгол Улсын иргэн Засгийн газрын хууль бус шийдвэрийн талаар Засгийн газар, Улсын Их Хурал, Үндсэн хуулийн цэц /Цэц өөрөө шүүх/-д гомдол гарган шийдвэрлүүлэх эрхтэй байгаа тул Үндсэн хуульд заасан шударга шүүхээр шүүлгэх эрх хязгаарлагдсан гэдгийг зөвшөөрөх боломжгүй байна, нөгөө талаас, бидний өргөдлийн агуулга нь эл үндсэн эрхийг хязгаарласан тухай биш, харин Засгийн газрын шийдвэрийг Үндсэн хуулиас гадуур журмаар хүчингүй болгох эрхийг захиргааны шүүхэд олгосон тухай асуудал юм.

5.Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 14 дэх хэсэгт "Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна" гэж зааснаас харахад Ерөнхий сайдын захирамж нь хамтаар гаргаж буй Засгийн газрын шийдвэр юм.

Гурав. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, Улсын Их Хурлын гишүүн З.Энхболд Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно" гэсэн заалт нь нэгдүгээрт, төрийн гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага болох Засгийн газарт гаргасан алдаагаа өөрөө засах боломж олгож байгаа, хоёрдугаарт, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлаас Засгийн газрын гаргасан алдааг залруулах явдлыг зохицуулсан зүйл гэж үзэж байна.

Өргөдөл гаргагч нар өргөдөлдөө төрийн эрх мэдлийг хууль тогтоох /Улсын Их Хурал/, гүйцэтгэх /Засгийн газар/, шүүх эрх мэдэл гэсэн салаа мөчирт хуваарилан тодорхойлсон талаар дурдахдаа шүүх эрх мэдлийг засгийн гурван салааг хооронд нь тэнцвэржүүлэгч хүч болдог талаар анхаарахыг хүссэнгүй.

Захиргааны аливаа байгууллага зөвхөн хуулиар олгосон бүрэн эрхийн дотор шийдвэр гаргаж байна. Харин хүний эрхийн хүрээнд хөндлөнгөөс оролцож, хуулийг өөрчилж ч, зөрчиж ч болохгүй юм.

Ийнхүү дэлхийн улс орнуудад захиргааны шүүхээс захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд /хөндлөнгийн/ шүүхийн хяналт тогтоож, хэрэг маргааныг шийдэж, улмаар хүний эрхийг хамгаалах, байгууллага, албан тушаалтнаас хууль ёсыг сахин биелүүлэхэд чиглэсэн механизм болгох явдал түгээмэл байна.

Шүүхийн хяналт бол захиргааны эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд шаардлагатай процессийн эрх зүйн хэлбэр мөн бөгөөд ийнхүү хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын /нэг талаас гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага нөгөө талаас иргэн, хуулийн этгээд/ тэгш байдлыг хангаж байна.

Практик дээр иргэний гаргасан гомдлын дагуу Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамжийг Улсын Их Хурлаар хэлэлцэж байсан тохиолдол нэг ч гараагүй болно.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу иргэн, хуулийн этгээд нь захиргааны хууль бус гэж үзэж байгаа актын талаархи нэхэмжлэлээ захиргааны хэргийн шүүхэд гаргахын өмнө гомдлоо тухайн байгууллага, албан тушаалтныг харъяалах дээд шатны байгууллага, албан тушаалтнаар урьдчилан шийдвэрлүүлж байхаар хуульчилсан билээ. Улсын Их Хурал нь гомдол, маргаан хянан шийдвэрлэдэг байгууллага биш учраас иргэн, хуулийн этгээдийн гаргасан гомдлыг хянан барагдуулах боломжгүй юм.

2. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12-т Монгол Улсын иргэн “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй”, мөн зүйлийн 14-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх эрхтэй” гэсэн заалтыг иш үндэс болгож, улмаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцийн тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын “Үндсэн хууль бусад хуулиар олгосон эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй” гэсэн наймдугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаварлан гадуурхалтгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй...” гэсэн хорин зургадугаар зүйлийн заалтуудыг баримтлан Монгол Улсын Ерөнхий сайдаас гаргасан захиргааны хууль бус акттай холбогдсон маргааныг захиргааны хэргийн шүүхээс хянан шийдвэрлэх тухай асуудлыг хуульчилсан билээ.

Хэрэв Монгол Улсын Ерөнхий сайдаас гаргасан захиргааны хууль бус акттай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн байдал нь тохирохгүй гэж үзэж байгаа бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасныг баримтлан Улсын дээд шүүх шаардлагатай гэж үзвэл ямар ч хэргийг татан авч анхан шатны журмаар хянан шийдвэрлэх эрхтэй билээ.

3. Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн дагуу “Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ”... үйл ажиллагаагаа танхимын зохион байгуулалтаар хэрэгжүүлнэ. Танхимын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь Засгийн газрын хуралдаан мөн”.

Мөн Үндсэн хуулийн Дөчинтавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргана”, Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлд “Засгийн газар бүрэн эрхийнхээ асуудлаар хуралдаанаас тогтоол, нэг удаагийн чанартай буюу шуурхай асуудлаар Ерөнхий сайд захирамж гаргана” гэж тус тус заажээ. Үүнээс үзэхэд Ерөнхий сайдын захирамж

заавал Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудлаар гарах шаардлагагүй байна.

Өөрөөр хэлбэл Ерөнхий сайдын захирамж нь нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар захиргааны албан тушаалтнаас бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр /захиргааны акт/ болж байна. Иймд иргэн, хуулийн этгээд хууль бус захиргааны акттай холбоотой нэхэмжлэлээ захиргааны хэргийн шүүхэд гаргаж зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулна” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасан “/...Ерөнхий сайд.../” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1; Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй болох нь дор дурдсан үндэслэлээр тогтоогдож байна.

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдөр гаргасан 2/02 дугаар дүгнэлтдээ “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаан” гэсэн 4 дүгээр зүйлийн “...дараахь байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны хууль бус актад холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ” гэсэн 1 дэх хэсгийн 4.1.1-д “Монгол Улсын Засгийн газар” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн”, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна” гэж заажээ.

2.Дээрх дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлын 2005 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-ийн “Монгол Улсын Засгийн газар” гэснийг хүчингүй болгосон байна.

3.Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1-д “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах...”, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1-д “Засгийн газар бүрэн эрхийнхээ асуудлаар хуралдаанаас тогтоол, нэг удаагийн чанартай буюу шуурхай асуудлаар Ерөнхий сайд захирамж гаргана” гэж заажээ.

4.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын тухай хууль болон Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн холбогдох заалт ёсоор Засгийн газрын шийдвэрт тогтоол, захирамжийг хамааруулан ойлгоно.

5.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-ын “/...Ерөнхий сайд.../” гэсэн заалтад уг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5, 3.1.6 дахь заалт нэгэн адил хамаарч байна. Өөрөөр хэлбэл Ерөнхий сайд эрх хэмжээнийхээ хүрээнд захирамжаас гадна амаар буюу бичгээр захиргааны акт, мөн түүнчилэн эрх

зүйн үр дагавар шууд бий болгодог нэг удаагийн захирамжилсан бусад арга хэмжээ /үйлдэл, эс үйлдэхүй/-г явуулж болохоор хуульчилсан тул дээрхи хуулийн 4.1.2-т заасан “/...Ерөнхий сайд.../” гэснийг хүчингүй болгох үндэслэлгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “/...Ерөнхий сайд.../” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1; Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2.Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГА
ГИШҮҮД

Ж.БЯМБАДОРЖ
Л.РЭНЧИН
П.ОЧИРБАТ
Ж.АМАРСАНАА
Ч.ДАШНЯМ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

2005 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар
хот

Төрийн албаны тухай хуулийн зарим
зүйл, заалтыг тайлбарлах тухай

Төрийн албаны тухай Монгол Улсын хуулийн 17 дугаар зүйлийн 17.11 дэх заалтыг нэг мөр ойлгох явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1.Төрийн албаны тухай Монгол Улсын хуулийн 17 дугаар зүйлийн 17.11-дэх заалтын “төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж болно” гэсэн ажиллагаа 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн хийгдэх боловч энэхүү жагсаалтанд бүртгэгдэх хүмүүст тавигдах шаардлага буюу “төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаал эрхэлж байсан төрийн албан хаагч” гэдэгт 2003 оны 1 дүгээр сарын 2-ноос өмнө тухайн албан тушаалыг эрхэлж байсан хүмүүсийг нэгэн адил хамааруулан ойлговол зохино.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Ч.ГАНБАТ

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Ц.АМАРСАЙХАН

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

2006 оны 02 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар
хот

**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн
зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай**

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг нэг мөр ойлгох, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд Шүүхээс ТОГТООХ нь:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль (цаашид “хууль”-гэх)-ийн зарим зүйл, хэсэг, заалтыг дор дурьдсанаар тайлбарласугай.

1.Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.6-д <<Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан>> гэдэгт Хуулийн этгээдийн өөрийн үйл ажиллагааг явуулахад ашиглах оноосон нэр нь бичвэр, хэлбэр авиан дуудлагын хувьд Улсын татварын Ерөнхий газрын дэргэдэх Улсын бүртгэлийн албаны Хуулийн этгээдийн нэрийн нэгдсэн жагсаалтанд бүртгэгдсэн бусад хуулийн этгээдийн нэртэй ижил байхыг ойлгоно.

2. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т <<Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль тогтоомжийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн>> гэсний <<удаа дараа>> гэдгийг энэ хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д заасан хууль, тогтоомжийн актанд заасан шаардлагыг

Хуулийн этгээд үл биелүүлэн гурав буюу түүнээс дээш зөрчснийг, <<ноцтой зөрчсөн>> гэдгийг Хуулийн этгээдийг үүсгэн байгуулах баримт бичиг, өөрийн хөрөнгө болон улсын бүртгэлийн жагсаалтыг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл үүсгэн байгуулах баримт бичигт заасан үйл ажиллагааны зорилгоос гажсан, мөн бусдад төлөх өр төлбөрөөс зайлсхийж, хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах зэргээр төр, иргэд, хуулийн этгээдэд их хэмжээний хохирол учруулсан буюу учруулж болох зөрчлийг ойлгоно.

3. Хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-т зааснаар хууль хүчин төгөлдөр болсноос хойш арван найман сарын буюу 2005 оны 4 дүгээр сарын 1-ний дотор Хуулийн этгээд нь хуульд заасан баримт бичгийг бүртгэх байгууллагад ирүүлээгүй бол тухайн хуулийн этгээдийг татан буулгах эсэх асуудлыг бүртгэх эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн анхан шатны шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1.1, 135 дугаар зүйлийн 135.2.14-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэнэ.

Шүүхийн шийдвэрт Иргэний хуулийн 32 дугаар зүйлд заасан журмын дагуу ажиллагаа хийхийг бүртгэх байгууллагуудад даалгасан байвал зохино.

Хуулиар тусгайлан харьяалуулсан тул Улс төрийн намыг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбоотой асуудлыг Улсын Дээд шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР
Д.ТУНГАЛАГ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

2006 оны 03 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙГ МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГААР
ХАНГАХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 16 дугаар зүйлийн 16.3.3-т зааснаар шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах үүрэг бүхий Улсын Дээд шүүх, аймаг, Нийслэлийн шүүхүүдээс улсын хэмжээнд шүүн таслах ажиллагааны нэгдсэн бодлого, чиглэлийг тодорхойлж хэрэгжүүлэх, үр дүнг дээшлүүлэх, шүүхийн практик судлах ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор нийт шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах хуульд заасан ажиллагааг хэрэгжүүлэх арга, хэлбэр, аргачлалыг нэгтгэн тодорхойлох шаардлагатай гэж үзэн Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Шүүхийн мэргэжлийн удирдлага ба түүний хэлбэрүүд.

Шүүхийн мэргэжлийн удирдлага нь давж заалдах болон хяналтын шатны шүүхүүдээс доод шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны талаар хийсэн судалгаа, дүгнэлтийн үндсэн

дээр явуулдаг, тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэхэд хамааралгүй, материаллаг болон процессийн эрх зүйн хууль тогтоомжийг нэг мөр зөв ойлгож, оновчтой тайлбарлан хэрэглэхэд чиглэгдсэн, шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх зорилготой, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын дотоод зохион байгуулалтын ажиллагаа юм.

Шүүхийн мэргэжлийн удирдлага нь Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.-т зааснаар хууль тайлбарлах, сургалт явуулах, шүүхийн практикийг нэгтгэн судлаж, зөвлөмж гаргах хэлбэртэй байна.

1.1. Хууль тайлбарлах ажиллагаа нь аливаа хуулийн зүйл, заалт буюу эрхийн хэм хэмжээнд туссан эрх зүйн харилцааны зохицуулалтыг нэг мөр, зөв ойлгож хэрэглэх зорилготой, эрх зүйн ухамсар, хууль хэрэглээний үндсэн зарчим, зүй тогтолд тулгуурласан, логик дүгнэлт бүхий танин мэдэхүйн ажиллагаа юм.

Хуулийн тайлбар нь албан ёсны ба албан бус гэж ангилагдана.

Албан ёсны тайлбар нь Монгол Улсын үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 ,Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5.-д зааснаар Үндсэн хуулиас бусад хуулийн талаар Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаас гарсан тогтоол хэлбэртэй байна.

Албан ёсны тайлбарыг тодорхой бус, салаа утгатай, хоёрдмол санаа агуулсан, хэрэглэхэд хүндрэл учруулсан хуулийн зүйл, заалтыг тухайн хэм хэмжээний агуулгад багтаан, хуулийн бусад зохицуулалттай харьцуулсны үндсэн дээр гаргана. Албан ёсны тайлбараар тухайн эрхийн хэм хэмжээнд тусгагдаагүй шинэ хэм хэмжээг тодорхойлж болохгүй.

Албан ёсны тайлбарын төслийг боловсруулах, батлах, тайлбарыг дагаж мөрдөх журмыг Шүүхийн тухай хуулиар зохицуулна.

Албан бус тайлбар нь шинжлэх ухааны, онолын, сэдэвчилсэн, дэлгэрэнгүй, үзэл баримтлалын гэх мэт хэлбэртэй байж болох бөгөөд тэдгээр нь хуулийн зохицуулалтыг зөв ойлгож, хэрэглэхэд тус дөхөм болох, эрх зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилго бүхий байна.

Шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагааны хүрээнд албан ёсны тайлбар нь шүүн таслах ажиллагаанд заавал хэрэгжүүлэх хуулийн хүчинтэй байдаг бол албан бус тайлбарыг шүүгчдийн мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх зорилготойгоор ашиглах боломжтой хэлбэр юм.

1.2.Сургалт явуулах нь шүүхийн мэргэжлийн удирдлагын нэг хэлбэр мөн.

Шүүхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд зааснаар бүх шатны шүүхийн шүүгч жил тутам 14 хоногоос доошгүй хугацаагаар мэргэшлээ дээшлүүлэх, давтан сургалтанд хамрагдах эрхтэй тул шүүгчдийн албан ёсны сургалтыг Улсын Дээд шүүх, Шүүхийн Ерөнхий зөвлөл зохион байгуулах бөгөөд хууль зүйн үргэлжилсэн сургалт хийх эрх бүхий байгууллагын боловсруулсан хөтөлбөрийн дагуу явуулна.

Шүүгчдийн үргэлжилсэн сургалт нь онол, практик, хууль хэрэглэх арга зүйн чиглэлээр төвлөрсөн, бүсчилсэн, зайны, сэдэвчилсэн гэх мэт хэлбэртэй байна.

Шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажилд сургалтын бүх хэлбэрийг хэрэглэж болно.

1.3. Шүүхийн практик судлал нь шүүн таслах ажиллагааны үндсэн үзүүлэлт, дүн мэдээнд тулгуурлан хууль хэрэглээний зүгшрэл, тодорхой төрлийн хэрэг маргааны шийдвэрлэлт, шүүн таслах ажиллагааны чанар, үр дүнг судалгааны үндсэн дээр тодорхойлж, дүгнэх танин мэдэхүйн ажиллагаа юм.

Шүүхийн практик судалгааг шүүхийн статистик мэдээ, шүүхээс гарч буй эрхийн актууд болон тодорхой төрлийн хэрэг маргааны шийдвэрлэлтийн байдлыг үндэслэн явуулж болох бөгөөд шүүхийн практикийг улсын хэмжээнд нэгтгэн судлаж, дүн шинжилгээ хийх үүрэг бүхий Шүүхийн Судалгааны төв Улсын Дээд шүүхийн дэргэд ажиллана.

Шүүн таслах ажиллагааны байдлыг тоон үзүүлэлтээр харуулсан судалгааг статистик судалгаа гэнэ.

Статистик судалгаа болон тодорхой хэрэг маргааны шийдвэрлэлтийн байдлын талаар гарсан дүгнэлт бүхий мэдээллийг тойм гэнэ.

Статистик судалгаа, тойм, шүүн таслах ажиллагааны цаг үеийн шаардлагын дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хууль хэрэглээний тодорхой асуудлаар үйл ажиллагааны аргачлал, арга барилыг тодорхойлсон зааварчилгааг зөвлөмж гэнэ.

Шүүхийн мэргэжлийн удирдлагын нэг хэлбэр болох шүүхийн практик судлалыг дээрх гурван үндсэн судалгааны аргаар явуулахаас гадна өөр аргыг сонгон хэрэглэж болно.

2. Улсын Дээд шүүхээс мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагаа.

2.1. Улсын Дээд шүүх нь Монгол Улсын шүүхийн дээд байгууллага бөгөөд хяналтын шатны шүүх мөн тул шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагаа нь түүний үндсэн чиг үүргийн нэг юм.

Улсын Дээд шүүх шүүхийн мэргэжлийн удирдлагын үндсэн зорилго, чиглэл, хэлбэр, аргуудыг тодорхойлж, энэ ажлыг зохион байгуулахаас гадна түүний хэрэгжилтэд хяналт тавих, арга, хэлбэрийг боловсронгуй болгох, үр дүнг нь дээшлүүлэхэд анхаарч ажиллана.

Мөн Шүүхийн Судалгааны төвөөс гаргасан улсын хэмжээний шүүн таслах ажиллагааны үр дүнг үндэслэн шүүхийн мэргэжлийн удирдлагын хэтийн болон ойрын зорилтыг тодорхойлохын зэрэгцээ цаг үеийн шаардлага, нөхцлийг харгалзан шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагааг мэдрэмжтэй, хүртээмжтэй төлөвлөж хэрэгжүүлнэ.

2.2. Шүүн таслах ажиллагаа, хууль хэрэглээний талаар гарч буй алдаа дутагдал, хүндрэл, бэрхшээлийг тухай бүрт нь тогтоон тодорхойлж, даган мөрдөгдөж байгаа болон шинээр гарч буй хуулиудын албан ёсны тайлбар гаргах, хуулийн зарим зүйл, заалт Монгол Улсын Үндсэн хуульд харшилсан гэж үзвэл доод шатны шүүхийн санал болон өөрийн санаачилгаар Үндсэн хуулийн Цэцэд хуульд заасан журмын дагуу хүсэлт гаргах, шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор шүүхүүдэд шаардагдах зөвлөмжүүдийг боловсруулна.

Албан ёсны тайлбар болон Үндсэн хуулийн Цэцэд хүсэлт гаргах ажиллагаа хуульд заасан журмын дагуу Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэгдэж, батлагдах ба тойм, зөвлөмжийг Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын зөвлөлгөөнөөр хэлэлцэн гаргана.

Хуулийн тайлбар, шүүхийн практик судалгааны дүн, тойм, зөвлөмжийг доод шатны шүүхүүдэд хүргүүлэх болон иргэд, байгууллагад шуурхай хүртээмжтэй хүргүүлэх ажиллагааг Улсын Дээд шүүхийн Тамгын газар зохион байгуулна.

2.3. Шүүхийн практикийг судлаж, нэгтгэн ижил төрлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх жишиг тогтоох, шүүгчдийн хууль хэрэглэх үр чадварыг дээшлүүлэх болон хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх зорилгоор гарсан Улсын Дээд шүүхийн тогтоолуудыг "Улсын Дээд шүүхийн мэдээлэл" сэтгүүл, "Шүүхийн шийдвэрийн эмхэтгэл" ном болон мэргэжлийн чиглэлийн сонин, сэтгүүлд нийтлүүлнэ

2.4. Шүүхийн мэргэжлийн удирдлагын талаар тусгайлан гаргасан жил, улирлын төлөвлөгөөний дагуу аймаг, Нийслэлийн шүүхүүдийн ажилтай танилцаж, шалган туслах ажилд Шүүхийн тухай хууль болон энэ тогтоолд заасан арга хэлбэрийг хэрэглэн, үр дүнг нь илтгэх хуудсаар Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанд танилцуулна.

Шалган туслах ажлын хүрээнд:

а) давж заалдах шатны шүүх сүүлийн 3 жилийн байдлаар хянан хэлэлцсэн хэрэг, маргааны тоо, тухайн шатны шүүхэд ажиллаж буй шүүгчийн орон тоо зэргийг харгалзан шүүгчийн ажлын ачааллыг тодорхойлж, улмаар тухайн шүүх анхан шатны шүүх, шүүгчийг мэргэжлийн удирдлагаар хангах оновчтой хэлбэрийг болон шалган туслах ажлын хүрээг тодорхойлно.

б) шүүхийн статистик мэдээ, давж заалдах шатны шүүхийн магадлал, анхан шатны шүүхийн зарим шийдвэрүүдийг түүвэрлэн хянаж материалаг хууль хэрэглээний болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ямар төрлийн алдаа түгээмэл байгааг тогтоосны эцэст тухайн шүүхэд зохион байгуулах сургалтын сэдвийг тодорхойлж, шүүн таслах ажиллагааны чиглэл тус бүрээр 3 цагаас доошгүй хугацааны сургалтыг зохион байгуулна.

в) давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагааны талаар дурдсан хугацаанд хэрэгжүүлсэн ажлыг баримтаар шалгаж, биелэлтийг нь дүгнэнэ. Ингэхдээ мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагааны хэлбэр, сэдэв нь оновчтой эсэх, цаг үеийн тулгамдсан шаардлагад нийцсэн эсэхийг анхаарна.

г) анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нэг бүртэй ганцаарчилсан уулзалт зохион байгуулж, шүүн таслах ажиллагаа, хууль хэрэглээ болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гарч буй хүндрэл, бэрхшээлийн талаар санал бодлыг нь сонсож, шаардлагатай зөвлөлгөө өгнө.

д) шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нартай ганцаарчилсан болон хамтарсан уулзалт, ярилцлагыг зохион байгуулж, шүүхийн болон хэргийн менежментийг боловсронгуй болгох асуудлаар санал бодлыг нь сонсож, зөвлөлгөө өгнө.

е) анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчид тухайн шатны шүүхийг тэргүүлэх, энэ тогтоолын 3.4-д болон 4.2.-т заасан хүрээнд мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагааг хэрхэн зохион байгуулж буйг тусгайлан шалгана.

3. Аймаг, Нийслэлийн давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагаа.

3.1. Аймаг, Нийслэлийн давж заалдах шатны шүүхүүд нь Шүүхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.3.-т зааснаар сум буюу сум дундын, дүүргийн шүүхүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах бүрэн эрх, үүрэгтэй ба энэ ажиллагааг нийт шүүгчдийн зөвлөлгөөнөөр хэлэлцэж баталсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

3.2. Давж заалдах шатны шүүхийн магадлал нь ижил төрлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүхийн практик тогтооход ач холбогдол бүхий эрхийн актын хувьд хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцсэн, шүүхийн мэргэжлийн удирдлагын томоохон хэсгийг бүрдүүлэх баримт юм. Иймд давж заалдах шатны шүүх нь хянагдаж буй хэрэг, маргааны талаар гарах эрхийн актанд анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилж, хүчингүй болгож байгаа үндэслэл, шалтгааныг тусгаж байхаас гадна анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж байгаа тохиолдолд давж заалдах гомдлын үндэслэл тус бүрийг няцаах, шүүхийн дүгнэлтийг оновчтой тодорхойлж байвал зохино.

3.3. Давж заалдах шатны шүүхүүд нь тухайн аймаг, Нийслэлийн хэмжээнд хянан шийдвэрлэсэн хэргийн статистик мэдээ, тодорхой төрлийн хэрэг, маргааны шийдвэрлэлтийн байдал зэрэгт үндэслэн хууль хэрэглээ болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар энэ тогтоолын 1.3-т зааснаар судалгаа, мэдээлэл, тойм, зөвлөмж гаргана.

Шүүхийн мэргэжлийн удирдлагын хүрээнд гаргасан судалгаа, мэдээлэл, тойм, зөвлөмж зэргийг аймгийн давж заалдах шатны шүүх шүүгчдийн зөвлөлгөөнөөр, Нийслэлийн шүүх эрүү, иргэний хэргийн танхимын зөвлөлгөөнөөр хэлэлцэж батална.

Давж заалдах шатны шүүхээс гарсан судалгаа, мэдээлэл, тойм, зөвлөмжийг анхан шатны шүүхүүдэд болон иргэд, байгууллагад мэдээлж, хүргүүлэх ажлыг тухайн шүүхийн тамгын хэлтэс хариуцан зохион байгуулна.

3.4. Давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн ажлыг жил, улирлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тогтмол шалган туслаж, үр дүнг нь илтгэх хуудсаар тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнд танилцуулна.

Шалган туслах ажлын хүрээнд:

а) анхан шатны шүүлээс дурдсан хугацаанд гарсан бүх төрлийн эрхийн актуудтай танилцаж, алдаа, зөрчлийг илрүүлэн, илтэх хуудаст тусгана. Хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргадаг шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын хууль зүйн үндэслэл, боловсруулалт зэргийг онцгой анхаарна.

б) анхан шатны тухайн шүүхийн хэмжээнд хянан шийдвэрлэгдэж буй нийт хэргийн статистик мэдээ, тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэж буй байдал зэргийг үндэслэн шүүн таслах ажиллагааны ямар чиглэл, асуудалд онцгой анхаарах шаардлагатай байгааг тухай бүрт нь тогтоож, шүүхийн практик судалгааны ямар арга, хэлбэрийг сонгохоо давж заалдах шатны шүүх өөрөө тодорхойлно.

в) анхан шатны шүүхийн шүүгч тус бүртэй ганцаарчилсан болон хамтарсан уулзалт зохион байгуулж, хууль хэрэглээний болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тулгамдсан асуудлуудаар ярилцлага хийж, санал солилцоно.

г)анхан шатны шүүхийн шүүгч, ажилтнуудын дунд тусгай төлөвлөгөөний дагуу тогтмол сургалт зохион байгуулна.

д)аймаг, Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч, Нийслэлийн шүүхийн эрүү, иргэний хэргийн танхимын тэргүүнүүд харьяалах нутаг дэвсгэрийн анхан шатны шүүхүүдэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, шалган туслах ажлыг удирдан зохион байгуулна.

е)давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлын үр дүнг тооцох, биелэлтэнд нь хяналт тавина.

4. Шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагаанд анхан шатны шүүхүүд хэрхэн оролцох талаар.

4.1. Анхан шатны шүүх нь эрүү, иргэн, захиргааны шүүн таслах ажиллагааны чиглэлээр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэдэг, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх анхдагч байгууллагын хувьд давж заалдах болон хяналтын шатны шүүхээс явуулж буй мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагааны үндсэн хэрэглэгч байна.

4.2. Анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч нь дээд шатны шүүхээс хэрэгжүүлж буй мэргэжлийн удирдлагын аливаа ажлыг өөрийн тэргүүлж буй шүүхийн хэмжээнд удирдан зохион байгуулж, гарсан судалгаа, мэдээлэл, тойм, зөвлөмж, тайлбарыг шүүгч, ажилтнуудын хүртээл болгох эдгээрийг тухайн шүүхийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, дээд шатны шүүхүүдэд хариу мэдэгдэх үүрэг хүлээнэ.

4.3. Анхан шатны шүүхүүд нь шүүхийн мэргэжлийн удирдлагын хүрээнд хийгдэж буй аливаа судалгааг үнэн зөв, шуурхай гаргаж өгөх үүрэгтэй.

Дээд шатны шүүхээс ирсэн судалгааны дүн, мэдээлэл, тойм, зөвлөмж, тайлбар зэргийг цаг тухайд нь шүүгчдийн зөвлөлгөөнөөр хэлэлцэж, тэдгээрийн мөрөөр авах арга хэмжээ, хугацааг тогтоож, дотоодын хяналттай ажиллана.

Шүүхийн мэргэжлийн удирдлагын хүрээнд зохиогдож буй аливаа ажилд шүүгч, шүүхийн ажилтан бүр идэвхитэй оролцож, санал бодлоо илэрхийлэх үүрэгтэй байна.

5.Энэхүү тогтоолыг шүүх, шүүгчийг мэргэжлийн удирдлагаар хангахад даган мөрдөж ажиллахыг бүх шатны шүүхүүдэд үүрэг болгосугай.

6."Шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг сайжруулах тухай" Улсын Дээд шүүхийн 2003 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 12 дугаар тогтоол, уг тогтоолын хавсралт болох "Шүүхийн практикийг нэгтгэн судлаж, тогтоол, тэмдэглэл, зөвлөмж гаргах журам"-ыг энэ тогтоол батлагдсан өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Д.БАТСАЙХАН

**ИРГЭНИЙ ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

Ц.АМАРСАЙХАН

**ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

О.ЗАНДРАА

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

2006 оны 04 дүгээр
Улаанбаатар
сарын 24-ний өдөр

Дугаар 21

ХОТ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ТУХАЙ

Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх төрийн онцгой үйл ажиллагааны эцсийн үр дүн бөгөөд зөрчигдсөн эрхийн хамгаалалтын илэрхийлэл болсон шүүхийн шийдвэрийг хууль хэрэглээний эрх зүйн актын хувьд хууль зүйн үндэслэлтэй, шударга ёсонд нийцсэн, процессийн болон материаллаг эрх зүйн зарчим, хэм хэмжээнд зохицсон агуулга, хэлбэртэй байлгах, эрүү, иргэн, захиргааны шүүн таслах ажиллагаанд бүх шатны шүүхээс гарч буй аливаа шийдвэрийг хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцүүлэх, шүүхийн шийдвэрийн боловсруулалтыг сайжруулж, шүүхийн шийдвэрийн талаар Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад туссан зохицуулалтыг нэг мөр, зөв ойлгож хэрэглэх явдлыг хангах зорилгоор Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.3-т заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:

1. Шүүхийн шийдвэр ба түүний төрлүүд

Шүүхийн шийдвэрийн төрлүүдийг Шүүхийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар ангилна. Үүнд:

- эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж гаргасан шийтгэх, эсхүл цагаатгах тогтоол;
- иргэний болон захиргааны эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэж гаргасан шийдвэр;
- баривчлах, цагдан хорих албадлагын арга хэмжээ авахад гаргасан шүүгчийн захирамж;
- захиргааны зөрчлийг хянан хэлэлцэж гаргасан шүүгчийн шийтгэвэр;
- давж заалдах шатны шүүхийн магадлал;
- хяналтын шатны шүүхийн тогтоол;
- хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж хамаарна.

Шийтгэвэр, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолоос бусад шийдвэр нь хэрэг маргааны талаар дүгнэлт бүхий шийдлийг агуулдаг, хууль хэрэглээний эрх зүйн актын нэг төрөл болох албан ёсны бичиг баримт юм.

Шүүхийн шийдвэр нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч эрх бүхий төрийн байгууллагаас гаргадаг, эрх зүйн харилцааг тодорхойлох, түүнийг зохицуулсан хэм хэмжээг хэрэглэх хэлбэрээр тухайн хэрэг маргаанд хамааралтай этгээдэд хуулиар тодорхойлогдсон төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг акт юм.

Шүүхийн шийдвэр нь:

- ерөнхий утгаараа нэг удаагийн үйлчлэлтэй;
- төрийн хүсэл зоригийг илэрхийлсэн эрх бүхий байгууллагын баримт бичгийн хэлбэртэй;

-хууль зүйн нэгдмэл үйл ажиллагааны эцсийн бүрэлдэхүүн хэсэг болдгийн хувьд тодорхой хууль зүйн үр дагавар үүсгэдэг;

-эрх зүйн хэм хэмжээний зохицуулалтаар тодорхой хүрээний этгээдүүдийн зан үйлийн зохих хэмжээ, хязгаарыг тодорхойлдог;

-тодорхой хэрэг, маргааны талаархи хууль хэрэглээний үр дүнг хэлбэржүүлсэн;

- хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд тавигдсан шаардлагад нийцсэн;

-төрийн албадлагыг амьдралд хэрэгжүүлэх арга хэрэгсэл мөн.

Шүүхийн шийдвэр нь зөрчигдсэн буюу маргаантай эрхийг сэргээх, түүнийг зохих ёсоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхээс гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болон нийт иргэдэд хүмүүжлийн үр нөлөө үзүүлэх зорилготой болно.

2. Шүүхийн шийдвэрт тавигдах шаардлага

Шүүхийн шийдвэр нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлийн 284.1., Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.2., Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.3.-т тус тус зааснаар хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна.

2.1. Хэрэг, маргааны талаар материаллаг болон процессийн эрх зүйн хэм хэмжээг тэдгээрийн агуулга, зорилгод нийцүүлэн, шүүхээс оновчтой, зөв хэрэглэсэн тохиолдолд шүүхийн шийдвэрийн хууль ёсны байх шаардлага хангагдана.

Шүүх нь Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн, хүчин төгөлдөр бусад хууль, Монгол Улсын соёрхон баталж, нэгдэн орсон олон улсын гэрээг хэрэглэхээс гадна Үндсэн хуульд харшлахгүй бол олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг төсөөтэй хэрэглэж болно.

Шүүх Үндсэн хуульд нийцээгүй хууль, олон улсын гэрээг хэрэглэхгүй бөгөөд хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж үзвэл Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 8 дугаар зүйлийн 8.4., Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2., Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.-д заасан журмын дагуу саналаа Улсын Дээд шүүхэд гаргана.

Тухайн харилцааг зохицуулсан хуулийн зүйл, заалт хоорондоо зөрчилтэй байвал шүүх нарийвчилсан зохицуулалттай хэм хэмжээг хэрэглэнэ. Нарийвчилсан зохицуулалт гэдэг нь хэлэлцэж буй тухайн асуудлын ерөнхий зарчим, онцлог, ухагдахууныг тодорхойлсон хэм хэмжээг хэлэх ба энэхүү зохицуулалтын үйлчлэл нь тухайн асуудалтай холбоотой тохиолдол бүрт хамаарна. Жишээлбэл, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 25 дугаар зүйлийн 25.1.-д заасан гэм буруугийн хэлбэрийн талаархи зохицуулалт мөн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн төрөл бүрт хамаарна. Иргэний хуулийн 110 дугаар зүйлийн 110.1.-д заасан үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх хэлцлийн дагуу үүсэх үндэслэл өмчлөх эрх шилжих гэрээний үүргийн төрөл бүрт нарийвчилсан зохицуулалт болно.

Иргэний болон захиргааны эрх зүйн маргаантай харилцааг зохицуулсан хууль байхгүй бол шүүх төсөөтэй харилцааг зохицуулж байгаа хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ. Харин эрүүгийн эрх зүйн харилцаанд хуулийг төсөөтэй хэрэглэх зарчим үйлчлэхгүй.

Тухайн маргаантай харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ байхгүй, эсхүл байгаа нь тодорхой бус, түүнчлэн хуулийн зүйл, заалт хоорондоо зөрчилтэй, шударга ёсонд нийцэхгүй байна гэсэн үндэслэлээр шүүх хуулийн хэм хэмжээг хэрэглэхээс, хэргийг шийдвэрлэхээс татгалзаж болохгүй.

Хэрэг, маргааныг шийдвэрлэж буй шүүх Үндсэн хуулиас бусад хуулийн талаархи Үлсын Дээд шүүхийн албан ёсны тайлбарыг хуулийн зүйл, заалтыг оновчтой зөв тайлбарлан хэрэглэхэд ашиглах ба харин тэрхүү тайлбарыг хэрэг, маргааны талаар шийдвэр гаргах үндэслэл болгож баримтлахгүй.

2.2.Хэрэгт хамааралтай бөгөөд хуульд заасан арга хэрэгслээр олж авсан, хэрэгт авагдсан ба шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, шүүхээр судлан шинжлэгдсэн нотлох баримтаар хэрэгт ач холбогдол бүхий бүх нөхцөл байдал тогтоогдсон хийгээд эдгээр нөхцөл байдлын талаар шүүхийн бүрэн, бодитой дүгнэлтийг агуулсан шийдвэр үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангана.

Шүүх хэрэгт цугларсан нотлох баримтуудаас шийдвэрийн үндэслэл болж буй баримт болон тэдгээрийг тал бүрээс нь бүрэн, бодитойгоор харьцуулан үзсэн өөрийн хууль зүйн дүгнэлт бүхий үнэлгээг шийдвэртээ тусгаснаар шүүхээс гарч буй эрхийн актын үндэслэлийг тодорхойлно.

2.2.1.Шүүхийн шийдвэрийн үндэслэл болж буй нотлох баримтууд нь тухайн хэрэгт хамааралтай байх гэдэг нь нэхэмжлэлийн шаардлага болон түүнийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа татгалзлыг, эрүүгийн гэмт хэргийн үйл баримт, шүүгдэгчийн гэм буруугийн хэлбэр, хэмжээ, гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгаан, нөхцлийг тогтооход ач холбогдолтой бөгөөд шалтгаант холбоотой байх шинжийг илэрхийлнэ.

2.2.2.Хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтууд нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 11,12 дугаар бүлэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр бүлэг, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан журмын дагуу хуулиар зөвшөөрөгдсөн арга хэрэгсэл, хэлбэрээр гаргасан, цугларсан, бүрдсэн тохиолдолд шүүхийн шийдвэрийн үндэслэл болох боломжтой болно. Хуулиар зөвшөөрөгдөөгүй арга хэрэгслээр олж авсан, хуульд заасан хэлбэрээр бэхжүүлэгдээгүй, гэрчлэгдээгүй баримтыг шүүх нотлох баримт гэж үзэж, шийдвэрийн үндэслэл болгож болохгүй.

2.2.3.Дахин нотлох шаардлагагүй баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болж болно. Энэ нь “шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тооцогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй” гэсэн зарчимд харшлахгүй.

А.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.-т зааснаар нийтэд илэрхий үйл баримт хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй. Нийтэд илэрхий үйл баримт гэдэг нь шүүхэд болон хэргийн оролцогчдод илэрхий байхаас гадна тухайн үйл баримтын талаар мэдээлэлтэй байх боломжтой тодорхой хүрээний хүмүүст илэрхий байхыг хэлнэ. Тухайлбал, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байрлаж байсан “Бөмбөгөр” худалдааны төв шатсан гэх үйл баримтыг нотлох шаардлагагүй юм. Мөн жил бүрийн 7 дугаар сарын 11-нээс 13-ны өдрийн хооронд Нийслэлд баяр наадмын үйл ажиллагаа зохион байгуулагддаг болохыг нотлох шаардлагагүй болно.

Б.Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон үйл баримтыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4., Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.4.-т зааснаар өөр хэрэгт дахин нотлох шаардлагагүй.

-Хүчин төгөлдөр болсон эрүүгийн хэргийн шийтгэх болон цагаатгах тогтоолын гэмт хэрэг гарсан эсэх, холбогдох этгээд гэм буруутай эсэхийг шийдвэрлэсэн хэсэг нь иргэний

болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэж буй шүүхэд дахин нотлох шаардлагагүй зүйлд хамаарна. Энэ утгаараа эрүүгийн хэргээс үүдэн гарсан нэхэмжлэлтэй иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчийн гэм буруугийн асуудлыг шүүх хянан хэлэлцэхгүй ба харин учирсан хохирлын хэмжээний асуудлыг л хэлэлцэнэ.

-Иргэний болон захиргааны хэргийн талаар гаргасан хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон үйл баримтыг иргэний болон захиргааны өөр хэргийг шийдвэрлэхэд нотлогдсон гэж тооцно. Гэхдээ эдгээр үйл баримт нь түрүүчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон этгээдийн хувьд өөр хэрэгт хэргийн оролцогчоор орж байгаа тохиолдолд нотлогдсон гэж үзнэ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй этгээдийн хувьд хүчин төгөлдөр шийдвэрээр нотлогдсон үйл баримтын талаар өөр хэрэгт маргах эрх нь нээлттэй ба шүүх тухайн хэрэгт цугларсан баримтыг хянан хэлэлцэж, шийдвэр гаргана.

-Арбитрын хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт нотлогдсон үйл баримтыг тухайн этгээдүүдийн оролцоотой иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дахин нотлохгүй.

-Иргэний болон захиргааны хэргийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон үйл баримтыг эрүүгийн хэрэгт дахин нотлох шаардлагагүй.

2.2.4. Шинжээчийн дүгнэлт нь нотлох баримтын бусад төрлийн адил хүчин чадалтай ба шүүх хэрэгт цугларсан бусад нотлох баримттай тал бүрээс нь бүрэн, бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр түүнийг үнэлнэ. Шинжээчийн дүгнэлт бусад нотлох баримтаар давхар нотлогдоогүй, тэдгээрээр үгүйсгэгдэж байгаа тохиолдолд түүнийг нотолгооны бусад хэрэгслээс илүүд авч үзэх үндэсгүй юм. Шинжээчийн дүгнэлтийн талаархи шүүхийн дүгнэлт бүхий үнэлгээ шийдвэрт бүрэн тусгагдсан байх ёстой. Ингэхдээ шинжээчийн дүгнэлт юунд тулгуурласан, шинжилгээнд гаргаж өгсөн бүх баримт судлагдсан эсэх, шүүхээс тавигдсан асуулт бүрт хариу өгөгдсөн эсэхийг шүүх дүгнэлтэндээ тусгасан байвал зохино.

2.2.5. Шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримт нь хуульд заасан журмын дагуу бэхжигдэж, гэрчлэгдсэн байхаас гадна хуулиар зөвшөөрөгдсөн хэлбэрээр хэрэгт авагдсан байна. Хэрэгт авагдаагүй нотлох баримтанд үндэслэгдсэн шийдвэр үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангахгүй гэж үзнэ.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл болж буй нотлох баримт шүүх хуралдаанаар заавал хянан хэлэлцэгдсэн байна. Хэрэгт авагдсан боловч шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдээгүй нотлох баримт шийдвэрийн үндэслэл болсон байвал шүүх хуралдааныг шууд явуулах шүүн таслах ажиллагааны үндсэн зарчмын нэг зөрчигдсөнд тооцно.

3. Шүүхийн шийдвэрийн агуулга.

Шүүхийн шийдвэрийн агуулгыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 35 дугаар бүлэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйл, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлд зааснаар тодорхойлно. Хуулийн эдгээр зүйл, заалт нь шийдвэрийн хэлбэрийг мөн тодорхойлсон гэж үзнэ.

Шүүхийн шийдвэр нь удиртгах, тодорхойлох, үндэслэх, тогтоох гэсэн дөрвөн хэсгээс бүрдэнэ. Бүх шатны шүүхээс гарч буй шийдвэр ийм бүтэцтэй байх бөгөөд анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхүүдийн бүрэн эрхийн дагуу хянан шийдвэрлэгдсэн асуудал тус бүр шийдвэрийн агуулгад тусгагдсан байна.

3.1. Шийдвэрийн удиртгал хэсэгт шийдвэр гаргасан он, сар, өдөр, газар, шийдвэрийг гаргаж буй шүүхийн нэр, шүүх бүрэлдэхүүн, шүүгчийн нэр, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, хэргийн болон шүүх хуралдааны оролцогчид, тэдгээрийн төлөөлөгчид, маргааны зүйл болон шаардлага, хэлэлцэгдэж буй эрүүгийн хэргийн зүйлчлэл тусгагдсан байна.

Шийдвэрийн удиртгал хэсэг нь хэзээ, хаана, хэн, ямар асуудлыг хэлэлцэж байгааг товч илэрхийлсэн байх учиртай ба эдгээр асуудлууд тодорхой бус, эргэлзээтэй, буруу тусгагдсан тохиолдолд шүүхийн шийдвэрийн үндэслэл ойлгомжгүй болно.

3.2. Шийдвэрийн тодорхойлох хэсэгт эрх зүйн маргааны болон эрүүгийн хэргийн талаар тусгасан байна.

3.2.1. Нэхэмжлэлийн шаардлага, шаардлагын талаар нэхэмжлэгч болон түүний төлөөлөгчийн шүүх хуралдаанд гаргасан тайлбар, хариуцагчийн татгалзал, татгалзлын талаар хариуцагч болон түүний төлөөлөгчийн гаргасан тайлбар, гуравдагч этгээдийн тайлбарыг шүүх анхааралтай судалсны эцэст тэдгээрийн агуулгыг шийдвэрт тусгана.

Шаардлага, татгалзал, тайлбаруудад дурьдагдаагүй зүйлийг шийдвэрт нэмж бичих, тэдгээрийн агуулгыг зөв тодорхойлохгүй байх нь шүүхийн алдаанд тооцогдоно.

Нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн шүүх хуралдаанд гаргасан тайлбарыг шүүх хуралдааны тэмдэглэлд үгчлэн тусгах тул шийдвэрийн тодорхойлох хэсэгт шаардлага, татгалзал, тайлбарын агуулгыг илэрхийлээгүй, хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолгүй, хамааралгүй илүү зүйл тусгахыг хориглоно.

Нэхэмжлэлийн шаардлагыг нэхэмжлэлийн өргөдөлд байгаа агуулгаар шийдвэрт тусгана. Хэрвээ нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болон зүйлийг өөрчилж, шаардлагын хэмжээг нэмэгдүүлсэн эсхүл багасгасан бол энэ талаар шийдвэрийн тодорхойлох хэсэгт тусгана. Нэхэмжлэлийн шаардлагын талаар гаргасан хариуцагчийн татгалзал, бүхэлд нь буюу хэсэгчлэн хүлээн зөвшөөрсөн тайлбар зэргийг мөн агуулгаар нь тодорхойлох хэсэгт дурьдана.

Шүүх хуралдаанд оролцоогүй боловч өөрийн шаардлага, татгалзал бүхий тайлбарыг шүүхэд гаргаж өгсөн хэргийн оролцогчийн шүүх хуралдаанаас өмнө гаргасан тайлбарын агуулгыг шийдвэрийн тодорхойлох хэсэгт тусгана.

3.2.2. Эрүүгийн хэргийн талаар гаргасан шийтгэх болон цагаатгах тогтоолын тодорхойлох хэсэг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 296 дугаар зүйлд зааснаар үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд:

-яллагдагчийг шүүхэд шилжүүлсэн хэргийн агуулгыг тусгасан хэсэг

-шүүхээс хэргийн талаар тогтоосон байдал болон тэдгээрийн талаархи шүүхийн дүгнэлтийн хэсэг хамаарна.

Шүүхийн шийтгэх болон цагаатгах тогтоол нь иргэний болон захиргааны хэргийн талаар гаргасан шийдвэрээс бүтцийн хувьд өөр байхаар хуульд заасан хэдий ч тогтоолын тодорхойлох хэсэг нь зайлшгүй дээрх хоёр хэсгээс бүрдсэн байхыг шаардана.

Яллагдагчийг шүүхэд шилжүүлсэн хэргийн агуулгыг тусгахдаа шүүх гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, газар, арга, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хэмжээ, гэмт хэргийн шалтгаан нөхцөл зэргийг зааснаар эрүүгийн хэрэгт холбогдсон этгээдийн үйлдсэн гэх гэмт хэргийн бүрэлдэхүүний тодорхойлолтыг гаргаж байгаа болно.

Ялах дүгнэлтэнд тусгагдсан дээрхи байдлын талаар хэрэгт авагдсан болон шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн нотлох баримтыг тал бүрээс нь, бүрэн, бодитойгоор

харьцуулан шинжлэн судалсны эцэст шүүх тэдгээрийг хэрхэн үнэлж, ямар дүгнэлт хийснээ, энэхүү дүгнэлт нь Эрүүгийн хуулийн ямар хэм хэмжээнд тулгуурлаж байгаа талаар тогтоолын тодорхойлох хэсгийн хоёр дахь хэсэгт дэлгэрэнгүй, тодорхой заасан байвал зохино.

3.2.3. Захиргааны хэргийн талаар гарч буй шийдвэрийн тодорхойлох хэсэгт Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.3.-т зааснаар нэхэмжлэлийн шаардлагын агуулга, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, прокурорын болон иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт тусгагдсан байна.

Захиргааны хэргийн талаар гарч буй шийдвэрийн тодорхойлох хэсэг иргэний хэргийн шийдвэрээс ялгаатай ба иргэний хэргийн шийдвэрт нотлох баримт, түүний үнэлгээг үндэслэх хэсэгт заадаг бол захиргааны хэргийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт гэрчийн мэдүүлгийг тусгахаар заажээ. Гэхдээ хуулийн энэхүү заалтын агуулгаас өмгөөлөгч, прокурор, иргэдийн төлөөлөгчийн шүүх хуралдаанд гаргасан тайлбар, дүгнэлтийг шийдвэрийн тодорхойлох хэсэгт тусгахаар ойлгогдож байгаа тул гэрчийн мэдүүлгийн хувьд мөн шүүх хуралдаан дээр гаргасан тохиолдолд хамааралтай гэж ойлговол зохино.

3.3. Шийдвэрийн үндэслэх хэсэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.4., Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.-т зааснаар шүүхийн шийдвэрийн үндэслэл болж буй нотлох баримтуудын хууль зүйн болон бодит үндэслэлийг зааж, тэдгээрийн талаар шүүхийн хийж буй дүгнэлтийг тусгана.

Шийдвэрийн үндэслэх хэсэг нь шүүхээр хэлэлцэгдэж буй эрх зүйн маргааны талаар шүүх ямар дүгнэлт гаргаж байгаа, энэхүү дүгнэлт нь ямар бодит нөхцөл байдалд тулгуурлаж, хуулийн ямар зүйл, заалтанд үндэслэсэн гэдгийг илэрхийлдэг тул чухал ач холбогдолтой юм.

Шүүх шийдвэрийн үндэслэх хэсэгт нэхэмжлэлийн шаардлага тус бүрийн талаар дүгнэлт өгөх үүрэгтэй ба хариуцагчаас гарсан шаардлагыг сөрөг нэхэмжлэл гэж үзсэн тохиолдолд түүний талаар мөн дүгнэсэн байвал зохино. Шүүхэд гаргаагүй шаардлага, үндэслэлийн талаар шүүх дүгнэлт хийх эрхгүйн зэрэгцээ шаардлагын үндэслэл, зүйлээс өөр үндэслэл, зүйлийг шийдвэрлэх, шаардлагын хэмжээнээс илүү хэмжээгээр шийдвэр гаргах эрх шүүхэд байхгүй болно.

Хэргийн оролцогчид шаардлага гаргаагүй асуудлаар шүүх зөвхөн хуульд заасан үндэслэлээр дүгнэлт хийх эрхтэй. Тухайлбал, хэлцлийг Иргэний хуулийн 56 дугаар зүйлд заасан үндэслэлээр хүчин төгөлдөр бус гэж үзэх, хэргийн оролцогч биш бусад этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд хэргийн оролцогчдоос тавигдаагүй асуудлаар шүүх дүгнэлт хийх бүрэн эрхтэй юм.

Шүүхийн дүгнэлт нь зөвхөн хуулиар зөвшөөрөгдсөн, хэрэгт хамааралтай, шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн нотлох баримтанд тулгуурласан байх учиртай бөгөөд нотлох баримтаар тогтоогдоогүй үйл баримтыг шүүх тогтоогдсон гэж үзэх, хэрэгт цугларсан баримтаар хангалттай бүрэн тогтоогдсон үйл баримтыг тогтоогдоогүй гэж үзэх нь шийдвэрийн үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг зөрчиж буй явдал мөн.

3.4. Шүүхийн шийдвэр нь хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэж буй шүүх эрх мэдлийн акт учир түүний тогтоох хэсэгт Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 297 дугаар зүйл, Иргэний

хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.5., Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.5.-д зааснаар шийдвэрийн үндэслэх хэсэгт дурьдсан дүгнэлтийн үр дагаварыг тусгахаас гадна шүүхийн шийдвэр ойлгомжтой, тодорхой, биелэгдэх боломжтой байх бүх нөхцлийг заасан байвал зохино.

3.4.1. Иргэний болон захиргааны хэргийн талаар гаргасан шийдвэрийн тогтоох хэсэгт тусгагдах асуудлын хүрээг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.5, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.5-д тодорхой заажээ.

Шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг, сөрөг нэхэмжлэл гаргасан бол сөрөг шаардлагыг шүүх хэрхэн шийдвэрлэсэн, хэн ямар үйлдлийг хэнд ашигтайгаар гүйцэтгэх үүрэгтэйг, мөн маргаантай байсан эрхийг хэн эдлэх талаар шийдвэрийн тогтоох хэсэгт тодорхой тусгасан байна.

Шүүх эдгээр болон хуульд заасан бусад асуудлыг шийдвэрийн тогтоох хэсэгт тусгахдаа тухайн шийдвэрийг биелүүлэхэд ямар нэгэн хүндрэл учруулахгүй байхад онцгой анхаарвал зохино.

Хэргийн оролцогчдын шаардлагыг бүхэлд нь эсхүл заримыг нь хэрэгсэхгүй болгож байгаа бол шүүх хэнд хамааралтай, хэний, ямар шаардлагыг хэрэгсэхгүй болгож байгааг тодорхой заахаас гадна хуулийн холбогдох зүйл, заалтыг баримтлана.

Тогтоох хэсэгт шийдвэрийг биелүүлэх арга, журам, хугацааг зөвхөн шаардлагатай тохиолдолд заана.

Шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн харилцаа үүссэн эсэх, тодорхой эрхийг хүлээн зөвшөөрөх эсэхийг тогтоож байгаа бол шүүх энэхүү тогтоосны эрх зүйн үр дагаварыг мөн тогтоох хэсэгт заана. Тухайлбал, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж үзсэн бол гэрлэлтийн бүртгэлийг хүчингүй болгох, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлсэн хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үзсэн бол энэ талаархи улсын бүртгэлийг хүчингүй болгох г.м.

3.4.2. Эрүүгийн хэргийн талаар гаргасан шийтгэх болон цагаатгах тогтоолын тогтоох хэсэгт тусгагдах асуудлын хүрээг Эрүүгийн Байцаан шийтгэх хуулийн 297 дугаар зүйлд тодорхой заасан ба тэдгээрийг нэгтгэж тодорхойлбол:

А.Тухайн гэмт хэрэгт хамаарах асуудлууд:

- шүүгдэгчийн үйлдсэн гэх гэмт үйлдэл гарсан эсэх;
- энэхүү үйлдэл нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй эсэх, бүрэлдэхүүнтэй бол Эрүүгийн хуулийн ямар зүйл, заалтад хамаарах;
- уг хэргийг шүүгдэгч үйлдсэн эсэх;
- шүүгдэгчийн гэм буруугийн асуудал;

Б.Ял шийтгэлд хамаарах асуудлууд:

- шүүгдэгч үйлдсэн гэмт хэрэгтээ ял шийтгүүлэх үндэслэлтэй эсэх;
- шүүгдэгчид ямар төрөл, хэмжээний ял оногдуулах, түүнийг биечлэн эдлүүлэх эсэх;
- шүүгдэгчийг онц аюултай гэмт хэрэгтэн гэж тооцох үндэслэл байгаа эсэх;
- ялыг ямар дэглэмтэй хорих ангид эдлүүлэх;

В.Эрүүгийн хэрэгт гаргасан иргэний нэхэмжлэлд хамаарах асуудлууд:

- нэхэмжлэлийг хангах эсэх;

- нэхэмжлэл гараагүй хохирлын асуудлыг шийдвэрлэх эсэх;
- эдийн бус хохиролын талаар нэхэмжлэлийн шаардлага гарсан бол түүнийг хэрхэх;

Г.Бусад асуудал:

- эд мөрийн баримтыг хэрхэх;
- шүүхийн зардлыг хэн хариуцах;
- шүүгдэгчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг хэрхэх зэрэг асуудлууд болно.

4.Шүүхийн шийдвэрийн агуулга, хэлбэр, бүтцийн талаар хуульд заасан шаардлагуудыг бүх шатны шүүхийн шүүгчид хэлбэрэлтгүй баримталж, шүүхээс гарч буй аливаа эрхийн актын боловсруулалт, найруулгад онцгой анхаарч ажиллахыг нийт шүүхүүдэд үүрэг болгон, шүүхийн шийдвэр боловсруулах аргачлалын талаар шүүн таслах ажиллагааны чиглэл тус бүрээр зөвлөмж гаргахыг Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимуудад даалгасугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

**ИРГЭНИЙ ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

Ц.АМАРСАЙХАН

**ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

Д.БАТСАЙХАН

**ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

О.ЗАНДРАА

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

2006 оны 07 дугаар
Улаанбаатар
сарын 03-ны өдөр

Дугаар 36

хот

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай
зөвшөөрлийн тухай хуулийн зарим зүйл,
заалтыг тайлбарлах тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсгийн "Казиногийн үйл ажиллагаа эрхлэх"-ийг хориглох гэдэгт мөнгө буюу түүнийг орлогч металл (токенс) хэрэглэн тоглодог электрон хэрэгсэл, слот машин, мөн тоглоомын үйл ажиллагаанд мөнгийг орлуулан хэрэглэх зориулалтын тусгай хуванцар зоос (чип) буюу шоо, хөзөр, тэдгээрт зориулсан тоглоомын тусгай ширээ зэрэг казиногийн зориулалтаар өрөө, тасалгаа, тоног, төхөөрөмжийг ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй. аз туршсан тоглоом тоглуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэж ойлгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ТАНХИМЫН ТЭРГҮҮН

С.БАТДЭЛГЭР
О.ЗАНДРАА

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

2006 оны 7 дугаар
Улаанбаатар
сарын 3-ны өдөр

Дугаар 37

хот

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн
зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн /цаашид “хуулийн” гэх/ зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тухай болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж, Төрийн албаны зөвлөлөөс нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар гаргасан, түүнчлэн нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон аливаа захиргааны акттай холбоотой маргааныг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д зааснаар захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэнэ.

Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, мөн уг албанд нэр дэвшигчийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэсэн Төрийн албаны салбар зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрсөн иргэн гомдлоо Төрийн албаны зөвлөлөөр, эсхүл Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлүүлэх эсэхээ өөрөө сонгоно.

2. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д заасан “...давж гомдол гаргах...” гэдэг нь мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан “Хугацаа сэргээхтэй холбогдсон гомдлыг шүүхэд гаргана” гэсэн заалтад хамаарна.

3. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан “...хөөн хэлэлцэх хугацаа...” нь мөн зүйлийн 6.1-д заасан “холбогдох захиргааны актыг хүлээн авснаас, эсхүл мэдсэнээс хойш 30 хоног” гэсэн хугацаагаар тодорхойлогдоно. Энэ хугацаанд гомдлоо хүндэтгэн үзэх шалтгааны улмаас гаргаж чадаагүй иргэн, хуулийн этгээд, байгууллага нь зөвхөн “хөөн хэлэлцэх хугацаа”-г сэргээлгэхээр урьдчилан шийдвэрлэх эрх бүхий захиргааны байгууллага, албан тушаалтанд хандана.

Мөн зүйл, хэсэгт зааснаар шүүхэд гомдол гаргасан тохиолдолд шүүх зөвхөн хөөн хэлэлцэх хугацааг сэргээлгэхтэй холбогдсон гомдол нь үндэслэлтэй эсэхийг хянаж, шүүгч захирамж гаргана.

Хуулийн 12 дугаар зүйлд заасан захиргааны хэргийн шүүхэд шууд гаргах нэхэмжлэлийг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хугацаанд нь гаргаж чадаагүй бол

иргэн, хуулийн этгээд, байгууллага нь хөөн хэлэлцэх хугацааг сэргээлгэх тухай гомдлоо шүүхэд гаргах бөгөөд шүүх уг гомдлыг ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

4. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д заасан “захиргааны акт утга агуулгын илэрхий алдаатай” гэдэгт актыг гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтны хүсэл зориг тухайн актад бүрэн гүйцэд илэрхийлэгдээгүй, актын заалтууд нь хоорондоо зөрчилдсөнөөс хоёрдмол утгатайгаар ойлгогдож болохоор агуулга нь тодорхой бус байхыг хэлнэ. Түүнчлэн найруулга зүйн болон үг, үсэг, тооны алдаа нь үр дагаврын хувьд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихөөр байвал тухайн актыг утга агуулгын хувьд илэрхий алдаатайд тооцож болно.

5. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6-д заасан “...нийтийн ёс зүйн хэм хэмжээг илт зөрчсөн” гэдэгт эрх, үүрэг тодорхой хэмжээгээр бий болгон уламжлагдан хэрэглэгдэж байгаа, нийтээр дагаж мөрдөн дадал хэвшил болсон зан заншил, ёс суртахууны хэм хэмжээг тухайн захиргааны байгууллага, албан тушаалтан зөрчсөн байхыг ойлгоно.

6. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.7-д заасан “захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй” гэдэгт захиргааны байгууллага, албан тушаалтан тухайн харилцааг хуулиар зохицуулаагүй байхад болон хуулиар тогтоосон хязгаарлалтыг зөрчих, түүнчлэн хуулиас гадуур нэмэлт хязгаарлалт тогтоох, бүрэн эрхээ хэтрүүлэх зэргээр захиргааны акт гаргасныг ойлгоно.

Түүнчлэн тухайн харилцааг зохицуулсан хуулийн тодорхой заалтыг хэрэглээгүй буюу хуулийн ерөнхий заалтыг хэрэглэсэн, эсхүл хуулийн заалтыг хэрэглэхгүйгээр захиргааны акт гаргасан зэргийг “захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй” гэдэгт хамааруулж үзнэ.

Мөн зүйлийн 9.1.9-д заасан “...өөр бусад байдлаар холбогдох хууль зөрчсөн” гэдэгт хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-9.1.8-д тодорхойлон зааснаас бусад хэлбэрээр хууль зөрчсөн байхыг ойлгоно.

7. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан “нэхэмжлэлийг тухайн шийдвэр гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтны оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүхэд гаргана” гэдэгт иргэн, хуулийн этгээд, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэж байгаа “анхны” захиргааны актыг гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтны оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэлээ гаргахыг ойлгоно.

Тухайн захиргааны актыг иргэн, хуулийн этгээд, байгууллагаас гаргасан гомдлын дагуу дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан урьдчилан шийдвэрлэх журмаар хянан шийдвэрлэсэн тохиолдолд тэдгээрийн оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэлийг гаргаж болохгүй.

Харин “эс үйлдэхүй”-тэй холбоотой нэхэмжлэлийг тухайн шийдвэр гаргавал зохих захиргааны байгууллага, албан тушаалтны оршин байгаа газрын, “эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоож, хүлээн зөвшөөрүүлэх” талаарх нэхэмжлэлийг нэхэмжлэгч нь өөрийн оршин байгаа газрын, эсхүл тухайн үйл явдал болсон газрын захиргааны хэргийн шүүхэд тус тус гаргана.

8. Хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасан “...холбоо, сан зэрэг нэгтгэл...”-д Иргэний хуулийн 36 дугаар зүйлд заасан “Хоршоо, сан, холбоо” хамаарахгүй.

9. Хуулийн 23 дугаар зүйлд заасан “Хамтран хариуцагч” гэдэгт нэхэмжлэлийн нэг буюу хэд хэдэн шаардлагад холбогдож байгаа, бие даан үйл ажиллагаа явуулдаг, тус

тусдаа захиргааны акт гаргасан хоёр буюу түүнээс дээш захиргааны байгууллага, албан тушаалтныг хэлнэ.

Хуулийн 6-10 дугаар зүйлд зааснаар доод шатны захиргааны байгууллага, албан тушаалтны актыг сонирхогч этгээдийн гомдлоор урьдчилан шийдвэрлэх журмаар хянаж шийдвэрлэсэн дээд шатны байгууллага, албан тушаалтан хамтран хариуцагч болохгүй. Харин доод ба дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан нь бие дааж үйл ажиллагаа явуулсан, тодорхой үр дагавар бий болгосон захиргааны акт гаргасныхаа хувьд хамтран хариуцагч байж болно.

Хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан "...бие даан оролцох эрхтэй" гэдгийг хамтран хариуцагч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, нэхэмжлэлийн шаардлагад тайлбар өгөх, нэхэмжлэгчтэй эвлэрэх, нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх эсхүл татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаанд оролцож мэтгэлцэх, шүүхийн шийдвэрт гомдол гаргах зэрэг эрхтэй гэж ойлгоно.

10.Хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.7-д заасан эрхийг төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлд тусгайлан заасан тохиолдолд л төлөөлөгч эдлэнэ. Түүнчлэн мөн зүйл, хэсэгт заасан төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлийг бусдад шилжүүлэхдээ төлөөлөгч нь түүний зөвшөөрлийг заавал авсан байвал зохино.

11.Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4-т заасан "... хуульд заасан журмыг зөрчиж авсан нотлох баримт..." гэдгийг "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" Улсын Дээд шүүхийн 2002 оны 263 дугаар тогтоолын 11 дэх заалтын дагуу ойлгоно.

Мөн зүйлийн 31.8-д заасан "...хуулиар зөвшөөрөгдөөгүй баримт..." гэдэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т тодорхойлон зааснаас бусад баримт сэлтийг хэлнэ.

Хуулиар зөвшөөрөгдөөгүй нотлох баримтыг шүүх шаардан гаргуулж болохгүй бөгөөд хэргийн оролцогчдоос уг баримтыг бүрдүүлж ирүүлсэн тохиолдолд шүүгч захирамж гарган тэдгээрийг нотлох баримтаас хасна.

12.Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.7-д зааснаар "... шинээр нотлох баримт зайлшгүй шаардагдал ..." шүүх хуралдааныг зөвхөн нэг удаа хойшлуулна. Шүүх хуралдааныг хойшлуулахдаа хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2-т заасан хугацааг баримтлана.

13.Хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т зааснаар нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангуулахаар шүүгч 7-14 хоногийн хугацаа тогтоосон нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаанд орохгүй.

Шүүхээс тогтоосон хугацаанд нэхэмжлэгч нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаж, шүүх нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа тоологдоно.

14.Хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т заасан "... шүүгчээс тогтоосон хугацаа..." гэдгийг хуулиар тогтоосон 14 хоногоос дээш хугацаа тогтоохыг ойлгоно.

15.Хуулийн 38 дугаар зүйлийн 38.4-т заасан захиргааны шийтгэлийг тухайн захиргааны хэргийг хянан шийдвэрлэж байгаа захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн шийтгэврээр ногдуулна.

16.Хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 43 дугаар зүйлийн 43.3-т заасан "...бусад этгээд..." гэдэгт тухайн хэргийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж болохоор байгаа, захиргааны хэргийн шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие даасан шаардлагатайгаар оролцуулах нь зүйтэй гэж үзсэн гуравдагч этгээдийг хэлнэ.

17.Хуулийн 41, 42, 43 дугаар зүйлд заасан журмаар хэрэг хянан шийдвэрлэж байгаа тохиолдолд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх эсэхийг заавал шалган тогтоож байвал зохино.

18.Хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.1-д заасан "маргаан бүхий захиргааны акт" гэдэгт нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болгосон захиргааны актыг хэлнэ.

Мөн зүйл, хэсгийн "...акт хууль бус болох..." гэдэгт мөн хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас бусад байдлаар хуулийг зөрчсөнөөс иргэн, хуулийн этгээд, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн байхыг ойлгоно.

19.Хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.3-т заасан " ...акт нь илт хүчин төгөлдөр бус болох..." гэдэгт мөн хуулийн 9 дүгээр зүйлд заасан үндэслэлүүд хамаарах бөгөөд илт хүчин төгөлдөр бус захиргааны актын улмаас бусдын нийтлэг эрх зөрчигдсэн байхыг хэлнэ.

20.Хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.7-д заасан "...хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай гэж үзвэл захиргааны байгууллага, албан тушаалтнаас дахин шинэ акт гартал захиргааны уг актыг түдгэлзүүлэх" ажиллагааг хариуцагч өөрөө маргаан бүхий захиргааны актыг алдаатай гарсныг хүлээн зөвшөөрч, нөхцөл байдлыг шалган тогтоож, шинээр захиргааны акт гаргах боломжтой гэж үзсэн тохиолдолд хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд шүүх маргаан бүхий захиргааны актын хэрэгжилтийг түдгэлзүүлэх бөгөөд захиргааны байгууллага, албан тушаалтнаас шинээр гаргасан захиргааны актад хуульд заасан ердийн журмаар гомдол гаргаж болно.

21. Хуулийн 78 дугаар зүйлийн 78.2-т заасан "захиргааны хэргийн шүүх шийдвэрээ биелүүлэх арга, журмыг гаргасан шийдвэртээ тодорхойлно" гэдэгт захиргааны хэргийн шүүхийн шийдвэр /шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шийдвэр, магадлал/-ийн зөвхөн тогтоох хэсгийн заалтыг хэн, хэзээ, яаж биелүүлэх болон биелэлтийг нь хэрхэн тооцох талаар шийдвэрийн тогтоох хэсэгт тодорхой тусгахыг ойлгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР
Д.ПУНЦАГ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

2006 оны 07 дугаар
Улаанбаатар
сарын 03-ны өдөр

Дугаар 34

ХОТ

Нэмэгдсэн өртгийн албан татварын
тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.18, 9.2.19 дахь
заалтыг тайлбарлах тухай*

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.18, 9.2.19 дахь заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн зарим заалтыг дор дураснаар тайлбарласугай.

1. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.18.-д заасан “дотоодын программ хангамжийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээс худалдан авсан бараа” гэдэгт Монгол улсад үйлдвэрлэгдсэн, дотоодын зах зээлд борлуулагдаж байгаа, зөвхөн программ хангамжийн бүтээгдэхүүн хамаарна.

2. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.19.-д “импортоор нийлүүлж байгаа компьютер, принтер, скайнер тэдгээрийн эд ангиуд” гэдэгт Монгол улсад импортоор нийлүүлсэн дотоодын зах зээлд борлуулагдаж байгаа компьютер, принтер, скайнер, тэдгээрийн эд ангиудыг хамааруулан ойлгоно.

Харин импортоор нийлүүлсэн боловч дотоодын зах зээлд борлуулахгүй экспортод гаргасан компьютер, принтер, скайнер, тэдгээрийн эд ангиуд нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх бараанд хамаарахгүй.

* Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол улсын хууль төрийн мэдээлэл сэтгүүл, 2005 оны №22, 470 дугаар тал

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

А.ДОРЖГОТОВ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

2007 оны 03 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар
хот

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай
хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн /цаашид хуулийн гэх/ зарим зүйл, заалтыг дараах байдлаар тайлбарласугай.

1.1. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-т заасан "...хөрөнгө оруулалт..." нь үйлдвэрлэл, үйлчилгээг шинээр бий болгох, эсхүл эрхэлж байгаа үйлдвэрлэл үйлчилгээг өргөтгөх, шинэчлэх зорилгоор үндсэн хөрөнгөд бодитой хийгдсэн байна.

1.2. Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9-д заасан "...техник..." гэдэгт газрын тосны хайгуул, өрөмдлөг хийх, цооног гаргах, олборлох, ашиглах зэрэг зориулалттай, тусгай тоноглол бүхий автомашин, өөрөө явагч машин хамаарна.

Мөн зүйл, хэсэгт заасан "...тоног төхөөрөмж, материал, түүхий эд, сэлбэг хэрэгсэл, автобензин, дизелийн түлш" нь зөвхөн газрын тос хайх, олборлох, ашиглах үйл ажиллагаанд зориулагдсан байвал зохино.

1.3. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т заасан "хувийн...хэрэгцээ..." гэдэгт нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч иргэн зөвхөн өөртөө болон гэр бүлдээ;

"...ажиллагчдын хэрэгцээ..." гэдэгт нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээтэй шууд холбоогүй, гэрээгээр ажиллагчдад хувьд нь зориулан худалдан авсан бараа, үйлчилгээ тус тус хамаарна.

1.4. Хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2, 17.3-т заасан "...эрх бүхий улсын байцаагч..." гэж хууль, тогтоомжоор тусгайлан эрх олгогдсон татварын улсын байцаагчийг хэлнэ.

1.5. Мөн зүйлийн 17.1.2-т заасан "...төлбөл зохих албан татварын дүнгийн..." гэдгийг нөхөн төлбөл зохих нэмэгдсэн өртгийн албан татварын нийт дүнгийн гэж ойлгоно.

Мөн хэсгийн "...50 хувиас илүүгүй..." гэдгийг 50 болон түүнээс доош хувиар гэж ойлгож хэрэглэнэ.

1.6.Хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т заасан зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдэд татварын улсын байцаагч төлбөл зохих нэмэгдсэн өртгийн албан татварыг нөхөн төлүүлэхээс гадна

а. мөн зүйлийн 17.1.1-д заасан хүү;

б. торгууль тус тус ногдуулна.

Харин нөхөн төлбөл зохих нэмэгдсэн өртгийн албан татварын дүнгээс тооцох торгуульд хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д заасан хүү орж тооцогдохгүй.

Торгуулийг нөхөн төлбөл зохих нэмэгдсэн өртгийн албан татварын дүнгээр болон түүнээс доош хэмжээгээр ногдуулна.

1.7.Хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.3-т заасан торгуулийн хэмжээг тогтоохдоо зөрчлийн шинж, шалтгааныг харгалзан үзвэл зохино.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

Л.АТАРЦЭЦЭГ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

2007 оны 3 дугаар
Улаанбаатар
сарын 12-ны өдөр

Дугаар 12

хот

Хувь хүний орлогын албан татварын тухай
хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан "Монгол Улсад оршин суух байртай" гэдгийг Монгол Улсад байнга оршин суугч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга амьдрах өөрийн өмчлөлийн болон хууль ёсны эзэмшлийн орон байртай байхыг хэлнэ.

2. Хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан "Тогтмол бус үйл ажиллагаа ..." гэдэгт тухайн хувь хүний хууль буюу гэрээгээр байнга эрхлэх албан үүрэгтэй нь холбоогүй, орлогын тогтмол эх үүсвэр болдоггүй ажил, үйлчилгээг хамааруулна.

3. Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12-т заасан "... анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад ..." гэдгийг энэ хууль хүчин төгөлдөр болсон өдөр

буюу 2007 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш зөвхөн нэг удаа хувьдаа орон сууцны барилга барьсан, эсхүл худалдаж авсны аль нэгийг гэж ойлгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

Д.ПУНЦАГ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

2007 оны 03 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар
хот

Онцгой албан татварын тухай хуулийн
зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай

Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Нэг. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т заасан “Суудлын автомашин” гэдэгт Монгол Улсын нэгдэн орсон “Барааг тодорхойлох, коджуулах уялдсан системийн тухай” 1983 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн Олон Улсын конвенцийн 87.03 ангилалд хамаардаг, хүн тээвэрлэх болон хүн ба ачаа аль алиныг нь тээвэрлэх хосолмол зориулалттай, нэг бүхээгтэй автомашиныг ойлгоно. Түүнчлэн автомашины үндсэн онцлог шинжийг хадгалж буй бүрэн бус суудлын автомашин болон суудлын автомашины анхны зориулалтыг өөрчилсөн тээврийн хэрэгсэл мөн үүнд хамаарна.

Жолоочийг оруулаад 9 ба түүнээс дээш хүн тээвэрлэх зориулалттай боловч нийтийн тээврийн хэрэгслийн ангилалд хамааруулаагүй, “Jeep”, “Station wagon” загварын автомашинууд суудлын автомашины ангилалд орно.

Хоёр. Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5-д заасан “Хос тэжээлт автомашин” гэдэгт дотоод шаталтын хөдөлгүүрээс гадна зай хураагуураас цэнэг авч цахилгаан эрчим хүчийг механик энерги болгон хувиргах цахилгаан хөдөлгүүртэй хосолмол ажиллагаа бүхий /гибрид/ автомашиныг ойлгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР
Ч.ТУНГАЛАГ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

2007 оны 03 дугаар
Улаанбаатар
сарын 12-ны өдөр

Дугаар 14

хот

Аж ахуйн нэгжийн орлогын
албан татварын тухай хуулийн зарим
зүйл, заалтыг тайлбарлах тухай

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн /цаашид хуулийн гэх/ зарим зүйл, заалтыг дараах байдлаар тайлбарласугай.

1.1. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8-д заасан орлогын “техникийн ...” гэдэгт шинэ технологи нэвтрүүлэх, хөдөлмөр, техникийн аюулгүй ажиллагааны болон үйлдвэрлэл, ажил, үйлчилгээнд мөрдөх хөдөлмөр зарцуулалтын норм, материал түүхий эдийн зарцуулалтын хэмжээг тооцож тогтоосон баримт бичгийг бэлтгэж боловсруулах, нийгэм эдийн засгийн судалгаа явуулах, аудитын үйлчилгээ үзүүлэх, тоног төхөөрөмж угсарч суурилуулах, засвар үйлчилгээ, дээж сорьцын шинжилгээ хийх, инженер техникийн ажилтан, ажилчдыг сургах, дадлагажуулах, мэргэжлийг нь дээшлүүлэхтэй холбогдсон ажил, үйлчилгээнээс олсон орлогыг;

“удирдлагын ...” гэдэгт аж ахуйн үйл ажиллагаа /үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ/-г үр ашигтай хэвийн явуулахад нь туслалцаа үзүүлэх зорилгоор аж ахуйн нэгж өөрийн мэргэжилтнийг гэрээгээр буюу харилцан тохиролцож ажиллуулсны үр дүнд олсон орлогыг;

“...зөвлөх ...-ийн ...” гэдэгт аж ахуйн нэгжид менежмент, зах зээл, хөрөнгө оруулалтын орчин, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үе шатны талаар мэргэжил, арга зүйн тусалцаа үзүүлэх, баримт бичиг боловсруулах зэрэг ажил, үйлчилгээ үзүүлснээс олсон орлогыг тус тус хамааруулж ойлгоно.

1.2. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-т заасан “...хүүгийн орлого...” гэдэгт банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны хувьд мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6-д заасан 10 хувийн албан татварыг суутгахгүйгээр бүртгэсэн орлогыг хэлнэ.

1.3. Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан “...албан татвар төлөгчийн 1 жилээс дээш хугацаанд ашиглах хөрөнгөд энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5-д заасан элэгдэл, хорогдлын шимтгэл тооцно...” гэдгийг мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т заасан хөнгөлөлтийг эдэлж байгаа аж ахуйн нэгжийн хувьд Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт үйлдвэрлэл, үйлчилгээг шинээр бий болгох, эрхэлж байгаа үйлдвэрлэл үйлчилгээг өргөтгөх, шинэчлэхэд зориулсан элэгдэл байгуулах үндсэн хөрөнгийг данс, бүртгэлд бүртгэж, элэгдэл хорогдлын шимтгэл тооцно гэж ойлгож хэрэгжүүлнэ.

1.4. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасан “...өмнө нь оруулсан хөрөнгө оруулалт...” гэдэгт хөрөнгө оруулагч этгээдээс энгийн хувьцаа, давуу эрхийн хувьцаа, алтан хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгийг худалдан авах, хувь нийлүүлэх замаар тухайн аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт, мөн эргэж төлөгдөх нөхцөлгүйгээр шилжүүлсэн мөнгө, бүх төрлийн эд хөрөнгө, эрх зэргийг хамааруулна.

1.5. Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасан “...элэгдэл байгуулах үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт ...” гэдгийг Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт үйлдвэрлэл, үйлчилгээг шинээр бий болгох, өргөтгөх, шинэчлэхэд зориулсан орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх үндсэн хөрөнгөд хамаарах, тухайн аж ахуйн нэгжийн удирдах дээд байгууллагын баталсан бизнесийн болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын жилийн төлөвлөгөөнд тусгасны дагуу бодиттой хийгдсэн хөрөнгө оруулалт гэж ойлгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

П.ЦЭЦГЭЭ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

2007 оны 4 дүгээр
Улаанбаатар
сарын 23-ны өдөр

Дугаар 22

хот

Нийгмийн даатгалын тухай хуулийн
16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн зарим
заалтыг тайлбарлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-д заасан "...хөдөлмөрийн хөлс" гэдэгт төрийн албан хаагчийн хувьд төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т зааснаар төрөөс олгож буй цалин хөлсийг ойлгоно.

Харин хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтанд ажил олгогчоос олгож буй "хөдөлмөрийн хөлс" гэдэгт үндсэн цалин, ажлын үр дүнгээр олгосон нэмэгдэл хөлс, ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил үүргийг биелүүлсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан тохиолдолд үндсэн цалингаас нь тооцож олгосон нэмэгдэл хөлснөөс гадна мэргэжлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцөлийн болон бусад нэмэгдэл хамаарна.

2. Мөн зүйл, хэсгийн "... хөдөлмөрийн хөлстэй адилгах орлого" гэдэгт цалин хөлснөөс гадна Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлд тодорхойлсноор ажил олгогчоос олгож байгаа байнгын шинжтэй орлогыг ойлгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

Ч.ТУНГАЛАГ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

2007 оны 5 дугаар
Улаанбаатар
сарын 14-ний өдөр

Дугаар 23

ХОТ

Нийгмийн даатгалын сангаас олгох
ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн
1 дэх хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1-д заасан "Даатгуулагч..." гэж энэ зүйл, хэсэг болон Нийгмийн даатгалын тухай хуулийн 2¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-д тодорхойлсон болзол, шаардлагыг хангасан, ажил хөдөлмөр эрхлээгүй хүнийг хэлнэ.

Мөн зүйл, хэсэгт заасан "...ажилгүйдлийн тэтгэмж..." гэдэгт ажилгүй болохоосоо өмнө ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг энэ хуульд заасан болзол, журмын дагуу төлсөн ажилгүй хүнд нийгмийн даатгалын сангаас амьжиргааны эх үүсвэр болгож, эргэж төлөгдөх нөхцөлгүйгээр олгох мөнгөн хөрөнгийг ойлгоно.

2. Ажилгүйдлийн тэтгэмжийг энэ хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан болзол, шаардлагыг хангасан, хөдөлмөрийн насны, ажил хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэлтийн алба, уг алба байхгүй бол нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлсэн хүнд олгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

П.ЦЭЦГЭЭ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

2007 оны 5 дугаар
Улаанбаатар
сарын 14 өдөр

Дугаар 25

хот

Боловсролын тухай хуулийн зарим зүйл,
заалтыг тайлбарлах тухай

Боловсролын тухай хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:

Боловсролын тухай хуулийн /цаашид хуулийн гэх/ зарим зүйл, заалтыг дараах байдлаар тайлбарласугай.

1. "Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хууль 2007 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр болж, мөрдөгдөж эхэлсэн үеэс боловсролын байгууллага нь хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасны дагуу ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байж болно.

Ашгийн төлөө бус боловсролын байгууллага ашгийн төлөө, ашгийн төлөө боловсролын байгууллага ашгийн төлөө бус болж өөрчлөгдөн зохион байгуулагдах нь холбогдох хууль, тогтоомжид заасан журмаар зохицуулагдана.

2. Энэ хуульд заасан “үүсгэн байгуулагч” нь төр, Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, Монгол Улсын болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд байна.

Боловсролын байгууллагыг төр, хуулийн этгээд, иргэн хамтран байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд үүсгэн байгуулагчид нь хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан гэрээг заавал байгуулна.

Хэд хэдэн этгээд боловсролын байгууллагыг үүсгэн байгуулах тохиолдолд үүсгэн байгуулагч тус бүр хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-т заасан удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 51-60 хувийн чухам хэдэн хувийг эзэмшихээ гэрээндээ заавал тусгасан байвал зохино.

Үүсгэн байгуулагчийн эдлэх эрхийг бусдад шилжүүлэх, бүрэлдэхүүнд шинээр өөр этгээд нэмж оруулах, үүсгэн байгуулагчийг бүрэлдэхүүнээс гаргах тухай асуудлыг гэрээ болон дүрэмд заасны дагуу зохицуулна.

3. Хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т заасан “...5 жилийн хугацаагаар томилох...” тухай зохицуулалт нь “Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль” хүчин төгөлдөр болж, мөрдөгдөж эхлэхээс өмнө захирлаар ажиллаж байсан этгээдэд хамаарахгүй.

Мөн зүйл, хэсэгт заасан “...энэ хугацааг дахин нэг удаа сунгаж болно.” гэдгийг зөвхөн тухайн ажиллаж байгаа их сургууль, дээд сургууль, коллежийн захирлаар дахин томилогдох гэж ойлгоно.

Харин өөр их сургууль, дээд сургууль, коллежид захирлаар томилогдсоныг дахин нэг удаа хугацааг сунгасан гэж үзэхгүй.

Төрийн өмчит их сургууль, дээд сургууль, коллежийн захирлыг томилох бүрд хугацааг 5 жил гэж ойлгох бөгөөд тухайн захирлын бүрэн эрхийн хугацаа дуусаагүй байхад өөр их сургууль, дээд сургууль, коллежийн захирлаар томилсон тохиолдолд 5 жилийн хугацааг сүүлчийн томилогдсон хугацаанаас тооцно.

4. Хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.12, 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан “...улсын хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг ерөнхий боловсролын сургууль...” гэдэгт Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан ерөнхий боловсролын тусгай сургууль, мөн хуулийн 14 дүгээр зүйлд заасан мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургуулиуд тус тус хамаарна.

5. Хуулийн 28¹ дүгээр зүйлийн 28¹.2, 30 дугаар зүйлийн 30.1.11-д заасан “...зөвшилцөн...” гэдгийг “Ерөнхийлөгчийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” Улсын Дээд шүүхийн 1996 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 216 дугаар тогтоолд зааснаар ойлгоно.

6. Хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан “...төлөөлөл...” гэдэгт багш, ажилтан, сурагч, эцэг, эхийн хурлын шийдвэрээр тухайн хамт олныг “сургууль болон цэцэрлэгийн зөвлөл”-д төлөөлөхөөр сонгогдсон этгээдийг;

мөн зүйлийн 35.2-т заасан “...тэдгээрийн хамт олны хурлаас...” гэдгийг багш, ажилтан, сурагч, эцэг, эхийн төлөөлөгчдийн тус тусын хурал гэж ойлговол зохино.

7. Хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д заасан "...төлөөлөл..." гэдэгт үүсгэн байгуулагч, багш, суралцагч, төгсөгчдийн хурлаас тухайн хамт олныг төлөөлөхөөр "удирдах зөвлөл"-д сонгогдсон этгээдийг;

мөн зүйлийн 36.3-т заасан "...багш, суралцагчийн төлөөллийг хамт олны хурлаас..." гэдгийг багш, суралцагчийн тус тусын хурал гэж ойлгоно.

8. Хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.4-т заасан "...үүнээс сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан бол..." гэж өндөр насны тэтгэвэр тогтоолгох үед 25 ба түүнээс дээш жил ажилласнаас сум, баг, тосгоны цэцэрлэг, сургуульд ажилласан нийт хугацааны нийлбэр нь дээрх газруудад тасралтгүй ажилласан эсэхээс үл хамааран 10 ба түүнээс дээш жил байхыг хэлнэ.

Мөн зүйл, хэсэгт заасан "...ажиллаж байгаа байгууллагаас нь олгох..." гэдгийг тэтгэмжийг тухайн этгээдийн тэтгэвэрт гарах үед ажиллаж байгаа байгууллага олгоно гэж ойлгоно.

9. Мөн зүйлийн 43.1.5-д заасан "...нэмэгдэл цалин..." гэдэгт Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 50, 51 дүгээр зүйлд заасан нэмэгдэл хөлс, нэмэгдэл;

"...урамшил, бусад дэмжлэг..." гэдэгт Төрийн албаны тухай хуулийн 27, 30, 31 дүгээр зүйлүүдэд заасан шагнал, урамшил, тусламж тус тус хамаарна.

10. Мөн зүйлийн 43.1.6-д заасан "сум, тосгон, багийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчээр тогтвор суурьшилтай ажилласан бол..." гэж тухайн сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгт ажилласан эсэхээс үл хамааран сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгт сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчээр 5 жилээс доошгүй хугацаанд тасралтгүй ажилласныг хэлнэ.

11. Мөн зүйлийн 43.1.7-д заасан мөнгөн тэтгэмжийг тухайн сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгт ажилласан эсэхээс үл хамааран сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгт багшаар тасралтгүй 5 жил ажилласан нөхцөлд олгоно.

12. Мөн зүйлийн 43.1.6, 43.1.7-д заасан нэмэгдэл, мөнгөн тэтгэмжийг "Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хууль хүчин төгөлдөр болж, мөрдөгдөж эхэлсэн үеэс тооцно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

Л.АТАРЦЭЦЭГ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТОГТООЛ

2007 оны 7 дугаар
Улаанбаатар
сарын 02 өдөр

Дугаар 32

хот

**Иргэний зарим хэргийн харьяаллыг
захиргааны хэргийн харьяалаас зааглан ялгах тухай**

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4, 36 дугаар зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4.-т заасан захиргааны болон иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхэд учирч буй бэрхшээлийг арилгах, дээрх хуулиудын холбогдох зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5.-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:

Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах нь иргэдэд Үндсэн хуулиар олгогдсон эрх тул дагнасан болон ерөнхий харьяаллын шүүхүүд хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэд, хуулийн этгээдийн гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэхдээ тухайн шүүхүүдийн хянан шийдвэрлэх маргааны харьяаллын талаар нэгдсэн ойлголттой байж, бусдыг чирэгдүүлэхгүй, шүүн таслах ажиллагааны чиглэл тус бүрээр үйл ажиллагаа явуулахыг онцгой анхаарах нь зүйтэй юм.

Монгол Улсын Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуульд зааснаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэдэг дагнасан шүүх байгуулагдсан явдал нь иргэдийн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалах, хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа болох шүүхийн үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн тул хэргийн харьяаллын талаар шүүхүүд үл ойлголцох, хэрэг, маргааныг шийдвэрлэх шат, дамжлагыг нэмэгдүүлэх, бусдыг чирэгдүүлэх үндэслэл, шалтгааныг үүсгэж болохгүй.

1. Шүүхэд мэдүүлэх эрх

1.1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.-д “Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй”, **Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлд** “хуульд тусгайлан заасан, дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтнаас хуулийн 8 дугаар зүйлд заасан журмын дагуу гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн, захиргааны байгууллага албан тушаалтан энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан журмын дагуу гаргасан шийдвэрийг биелүүлээгүй, шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан гомдлыг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлээгүй, харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан байхгүй бол...иргэн, хуулийн этгээд захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд шүүхэд эрхээ хамгаалуулахаар хандах эрхтэй.

Иргэний хэрэг үүсгүүлэх тухай гомдол, захиргааны хэрэг үүсгүүлэх тухай нэхэмжлэлийг зөвхөн иргэн гаргах эрхтэй гэж үзэх хууль зүйн үндэслэлгүй болно.

1.2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4.-т заасан “захиргааны байгууллага, албан тушаалтан”, мөн хуулийн 156 дугаар зүйлийн 156.1.1.-д заасан “төрийн захиргааны байгууллага, тэдгээрийн албан тушаалтан” гэдэгт:

а/ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д зааснаас бусад байгууллага, албан тушаалтныг;

б/ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д заасан байгууллага, албан тушаалтныг зөвхөн мөн зүйлийн 4.2.-т зааснаас бусад эрхийн акт гаргасан тохиолдолд тус тус хамааруулна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дээрх зүйл, заалтад туссан “эрх зүйн акт”, “шийдвэр, үйл ажиллагаа” гэдэгт Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.-т заасан “зөвхөн гадагш /бусдаас/ дагаж мөрдөх буюу заавал биелүүлэх”, нийтийн эрх зүйн захиргааны актаас бусад шийдвэр, үйл ажиллагааг багтаан ойлгоно.

1.3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4.-т заасан үндэслэлээр иргэний хэрэг үүсгэх “гомдол” нь мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.-д зааснаар “нэхэмжлэл” гэх нэгдсэн нэр томъёонд багтаж байгаа тул иргэний хэрэг үүсгэх үндэслэл болох гомдолд энэ хуульд заасан нэхэмжлэлд тавигддаг бүх шаардлага нэгэн адил хамааралтай байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7., 3.1.8.-д “нэхэмжлэл” болон “гомдол” гэсэн нэр томъёог тус тус тодорхойлсны дагуу захиргааны хэрэг үүсгүүлж, зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар шүүхэд хандаж гаргасан өргөдлийг нэхэмжлэл гэнэ.

2. Нэхэмжлэл хүлээн авах

Захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж буй этгээдийн нэхэмжлэлийг дагнасан болон ерөнхий харьяаллын шүүхүүд хүлээн авахдаа тухайн нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хэргийн болон шүүхийн харьяаллын дагуу гаргасан эсэхийг шалган шийдвэрлэж байвал зохино.

2.1. Хэргийн харьяалал

Хэргийн харьяалал гэж тухайн маргаан ямар байгууллагаар шийдвэрлэгдэхийг тодорхойлдог, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бол шүүх уг асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй эсэхийг тогтоодог ойлголт юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлд иргэний хэрэг шийдвэрлэх ерөнхий харьяаллын шүүхэд энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан нэхэмжлэлтэй маргаан шийдвэрлэгдэхийг зааснаас гадна шүүх болон арбитрын харьяаллыг зааглах тухай тусгасан байна.

Харин иргэний хэрэг хянан шийдвэрлэх ерөнхий харьяалмын шүүх болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх дагнасан шүүхэд хамаарах асуудлын хүрээг заагласан зохицуулалт уг зүйлд тусгагдаагүй хэдий ч энэ асуудал нь шүүхийн биш харин хэргийн харьяалалд хамаарах болно.

2.1.1. Иргэний хэрэг хянан шийдвэрлэдэг ерөнхий харьяалмын шүүхүүд нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1., 4.2.-т зааснаас бусад этгээдэд холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4., 13 дугаар зүйлд зааснаар хүлээн авч, мөн хуулийн арвандөрөвдүгээр бүлэгт заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

а/ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д зааснаас бусад байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой нэхэмжлэл.

Эдгээрт төрийн захиргааны бусад байгууллага, тэдгээрийн албан тушаалтан хамаарахаас гадна төрийн захиргааны бус бусад байгууллага, хуулийн этгээд, тэдгээрийн албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа хамаарна.

б/ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.-т зааснаар мөн зүйлийн 4.1.-д заасан байгууллага, албан тушаалтны гадагш чиглэгдсэн, нийтийн эрх зүйн хүрээний актаас бусад шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой нэхэмжлэл тус тус хамаарна.

2.1.2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх дагнасан шүүхүүд нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12, 13 дугаар зүйлүүдэд заасан иргэний шүүн таслах ажиллагааны журмаар шийдвэрлэгдэх хэргээс бусад Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ.

а/ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д заасан байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанаас учирсан эд хөрөнгийн хохирлын талаар нэхэмжлэлийн шаардлага гарсан, хохирлын хэмжээ тогтоогдсон бөгөөд энэ талаар маргаангүй бол захиргааны хэргийн шүүх энэ хуулийн 70 дугаар зүйлийн 70.4.-т зааснаар уг шаардлагыг үндсэн нэхэмжлэлийн хамт шийдвэрлэнэ.

б/ Байгууллага, албан тушаалтны хууль бус ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах талаарх шаардлага захиргааны хэргийн шүүхэд үндсэн нэхэмжлэлийн хамт гараагүй бөгөөд захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гарснаас хойш хохирлын талаар гаргасан нэхэмжлэлийг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэнэ.

Энэ тохиолдолд уг нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн арван дөрөвдүгээр бүлэгт заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн 18 дугаар зүйлийн 1-ийн 5 дахь заалт нэгэн адил хамаарна.

2.1.3. Иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хэргийн харьяалал зөрчигдсэн тохиолдолд дагнасан болон ерөнхий харьяалмын шүүхүүд нь Иргэний хэрэг

шүүхэд хянан шийдвэрлэх болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад заасны дагуу асуудлыг шийдвэрлэнэ.

а/ Захиргааны хэргийн шүүхэд харьяалагдах нэхэмжлэлийг хүлээн авсан ерөнхий харьяалмын шүүх иргэний хэрэг үүсгээгүй бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1.-д зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.

Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тухай шүүгчийн захирамжид хэргийн харьяалал зөрчигдсөн байдал, үндэслэлийг заахын зэрэгцээ захиргааны хэргийн шүүхэд хандах эрхийг мөн хуулийн 65 дугаар зүйлийн 65.2.-т зааснаар тусгасан байвал зохино.

б/ Захиргааны хэргийн шүүхэд харьяалагдах нэхэмжлэлийг хүлээн авсан ерөнхий харьяалмын шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзалгүй иргэний хэрэг үүсгэсэн бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.1.-д зааснаар шүүх хуралдаанаар хэргийг хэрэгсэхгүй болгох тухай шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж гаргана.

Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид хэргийн харьяалал зөрчигдсөн байдал, үндэслэл, захиргааны хэргийн шүүхэд хандах эрхийг тусгана.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2.-т заасан хэрэг шилжүүлэх ажиллагаа нь шүүхийн харьяалал зөрчигдсөн тохиолдолд хамааралтай тул хэргийн харьяалал зөрчигдсөн тухайн нөхцөлд хамааралгүй болно.

в/ Ерөнхий харьяалмын шүүхэд харьяалагдах нэхэмжлэлийг хүлээн авсан захиргааны хэргийн шүүх хэрэг үүсгээгүй бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1.-д зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана. Харин энэ хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.-д зааснаар нэхэмжлэлийг холбогдох ерөнхий харьяалмын шүүхэд “шилжүүлэнэ” гэдгийг тухайн асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй ерөнхий харьяалмын шүүхийг захирамжид заана гэж ойлгоно.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.-д зааснаар нэхэмжлэлийг ерөнхий харьяалмын шүүхэд шилжүүлэх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1.-д заасан шаардлагыг зөрчих тул мөн хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.11.-д зааснаар ерөнхий харьяалмын шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл үүсэж, нэг нэхэмжлэлийг хоёр шүүх хэргийн харьяалаас шалтгаалан хүлээн авахаас давхар татгалзсанаар шүүхэд эрхээ хамгаалуулахаар хандсан иргэн, хуулийн этгээдийг чирэгдүүлэх шалтгаан болно.

Нөгөө талаар эрхээ хамгаалуулахаар тухайн шүүхэд хандах эсэхийг нэхэмжлэгч өөрөө шийдвэрлэдэг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны диспозитив зарчим зөрчигдөж болзошгүйг шүүхүүд анхаарах учиртай.

г/ Ерөнхий харьяалмын шүүхэд харьяалагдах нэхэмжлэлийг хүлээн авсан захиргааны хэргийн шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзалгүй захиргааны хэрэг үүсгэсэн бөгөөд хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад энэ байдал илэрсэн бол:

- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д заасан байгууллага, албан тушаалтанд холбогдолгүй асуудлаар гарсан нэхэмжлэл бол тэдгээрт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэнэ. Харин шүүх шийдвэртээ нэхэмжлэлийг ямар шүүхэд хэрхэн мэдүүлэх талаар тусгасан байна;

- Нэхэмжлэгчийн сонгосон хариуцагч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д заасан байгууллага, албан тушаалтан биш, мөн зүйлийн 4.2.-т заасан захиргааны актаас бусад шийдвэр, үйл ажиллагааны талаар гаргасан нэхэмжлэлийг шүүх нэгэнт хүлээн авч, захиргааны хэрэг үүсгэсэн тул хүлээн авахаас татгалзаж болохгүй. Харин үүсгэгдсэн захиргааны хэргийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 79 дүгээр зүйлийн дагуу шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж гаргаж, хэрэгсэхгүй болгоно. Тухайн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлд заасан журам хамаарахгүй болно.

д/ Хэргийн харьяалал зөрчигдсөн байдал дагнасан болон ерөнхий харьяаллын давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад илэрвэл:

-захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.3.-т зааснаар шийдвэрийг хүчингүй болгоно.

Ингэхдээ “хэргийг харьяалагдах шүүхэд нь шилжүүлнэ” гэдэг нь зөвхөн шүүхийн харьяалал зөрчигдсөн тохиолдолд хамаарах тул холбогдох захиргааны хэргийн шүүхэд шилжүүлнэ.

Харин тухайн нэхэмжлэл ерөнхий харьяаллын шүүхээр шийдвэрлэгдэх ёстой бөгөөд хэргийн харьяалал зөрчигдсэн бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.1-д зааснаар шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгоно.

Нэхэмжлэлийн дагуу захиргааны хэрэг үүсгэгдэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг анхан болон давж заалдах шатны шүүх явуулж дууссан үед нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж болохгүй.

Шүүхийн магадлалд хэргийн харьяалал зөрчигдсөн байдал, үндэслэлийг тодорхой зааж, харьяалах шүүхэд хандах эрхийг тусгана.

-иргэний хэргийн давж заалдах шатны шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 167 дугаар зүйлийн 167.1.4.-т зааснаар шийдвэрийг хүчингүй болгож, мөн хуулийн 117 дугаар зүйлд зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгоно.

Шүүхийн магадлалд хэргийн харьяалал зөрчигдсөн байдал, үндэслэлийг тодорхой зааж, харьяалах шүүхэд хандах эрхийг тодорхой тусгана.

е/ Хэргийн харьяалал зөрчигдсөн байдал дагнасан болон ерөнхий харьяаллын хяналтын шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад илэрвэл шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 178 дугаар зүйлийн 178.1.4.-т зааснаар шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгоно.

2.1.4.Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болсон захиргааны актын хууль зүйн үндэслэлийн талаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гарсан болох нь илэрвэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4., 80 дугаар зүйлийн 80.1.4.-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гарсан үед мөн зүйлийн 80.3.-т зааснаар сэргээх ажиллагааг гүйцэтгэнэ.

2.2. Шүүхийн харьяалал

Хэргийн харьяаллын хувьд дагнасан эсхүл ерөнхий харьяаллын шүүхэд хамаарч байгаа тухайн нэхэмжлэлийг дагнасан буюу ерөнхий харьяаллын ямар шүүх хянан шийдвэрлэхийг шүүхийн харьяалал тодорхойлно.

Тухайн нэхэмжлэлийг дагнасан эсхүл ерөнхий харьяаллын шүүх хянан шийдвэрлэх асуудал шүүхийн харьяалмаар бус харин хэргийн харьяалмаар тодорхойлогдоно.

3. Зарим төрлийн маргааны харьяалал

3.1. Хөдөлмөрийн эрх зүйн маргаан

Хөдөлмөрийн тухай хуулийн 128 дугаар зүйлд заасан хөдөлмөрийн эрх зүйн маргаан нь шүүхэд харьяалагдах бөгөөд тэдгээрийн дотор ажил олгогчийн санаачилгаар ажлаас буруу халсан буюу өөр ажилд буруу шилжүүлсэн тухай ажилтны гомдлыг ерөнхий харьяаллын шүүхүүд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн арвандөрөвдүгээр бүлэгт заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.-д заасан төрийн улс төрийн, тусгай, захиргааны албан хаагчдын ажлаас үндэслэлгүй халагдсан тухай маргаантай хэргийг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх бөгөөд энэ тохиолдолд ажлаас халах шийдвэрийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д заасан байгууллага, албан тушаалтан гаргасан байх шаардлагатай. Бусад тохиолдолд төрийн улс төрийн, тусгай, захиргааны албан хаагчийг ажлаас халсан асуудлыг ерөнхий харьяаллын шүүх хянан шийдвэрлэнэ.

Төрийн үйлчилгээний албан хаагчийг ажлаас халах шийдвэрийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д заасан байгууллага, албан тушаалтан гаргасан хэдий ч хөдөлмөрийн эрхийн харилцаа хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр үүсдэг тул тухайн асуудлаарх маргааныг ерөнхий харьяаллын шүүх хянан шийдвэрлэнэ.

Төрийн жинхэнэ албан хаагч ажлаас үндэслэлгүй халагдсан гэж үзвэл гомдлоо Төрийн албаны салбар зөвлөл болон төрийн албаны төв байгууллагад гаргах боломжтой бол улс төрийн болон үйлчилгээний албан хаагчийн хувьд ийм боломж байдаггүйг шүүхүүд анхаарвал зохино.

Захиргааны хэргийн шүүх төрийн албан хаагчийн ажлаас халагдсан асуудлыг хянан шийдвэрлэхдээ Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.-д зааснаар төрийн албан хаагчийн хөдөлмөрийн тухайн харилцаатай холбоотой бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулийн зохицуулалтаар нэг мөр шийдвэрлэнэ.

3.2. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой маргаан

Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгэлийн байгууллагад холбогдох асуудлыг

захиргааны болон ерөнхий харьяаллын шүүхүүд тухайн нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлээс хамааран өөр өөрийн харьяалаар хянан шийдвэрлэнэ.

Бүртгэлийн байгууллага, түүний албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас эд хөрөнгийн улсын бүртгэл буруу хийгдсэн тул бүртгэлийг хууль бус гэж тооцуулах, бүртгэл болон түүний үндсэн дээр олгогдсон гэрчилгээг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэнэ.

Харин өмчийн болон гэрээний эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг хянан шийдвэрлэсний үр дүнд хууль ёсоор хийгдсэн улсын бүртгэлийг өөрчлөх, хүчингүй болгох асуудал иргэний хэрэг хянан шийдвэрлэх ерөнхий харьяаллын шүүхийн ажиллагаанд хамаарна. Энэ тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага иргэний хэрэгт хариуцагчаар оролцохгүй.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон эд хөрөнгийн улсын бүртгэл, түүний үндсэн дээр олгогдсон гэрчилгээ хууль бус байсныг захиргааны хэргийн шүүхийн шийдвэрээр хожим тогтоож, хүчингүй болговол энэ шийдвэр нь иргэний хэргийн шийдвэрт шинээр илэрсэн нөхцөл байдал болно.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эд хөрөнгийн улсын бүртгэл илтэд үндэслэлгүй, хууль бус болох нь илэрхий байвал ерөнхий харьяаллын шүүх эд хөрөнгийн бүртгэлд үндэслэгдсэн иргэний эрх зүйн маргааныг шийдвэрлэж, захиргааны хэргийн шүүхэд хандах хэргийн оролцогчийн эрхийг шийдвэртээ заавал тусгасан байна.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дээрх бүртгэлийн хууль зүйн үндэслэлийн талаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргавал шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4., 80 дугаар зүйлийн 80.1.4.-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гарсан үед мөн зүйлийн 80.3.-т зааснаар сэргээх ажиллагааг гүйцэтгэнэ.

3.3.Татварын харилцаанаас үүсэх маргаан

Татварын Ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 10 дахь хэсгийн е-д зааснаар татварын өр, төлбөрийг барагдуулах тухай татварын улсын байцаагчийн нэхэмжлэлийг ерөнхий харьяаллын шүүх иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ.

Татварын улсын байцаагчийн актад татвар төлөгч шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх журмын дагуу Татварын маргаан таслах зөвлөлд гомдол, Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаагүй тохиолдолд уг актын хууль зүйн үндэслэлийн талаарх хариуцагчийн сөрөг шаардлагыг ерөнхий харьяаллын шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 73 дугаар зүйлд заасан сөрөг нэхэмжлэл гэж үзэхгүй.

Харин татварын улсын байцаагчийн акт хууль зүйн үндэслэлгүй болох нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрээр хожим тогтоогдвол захиргааны хэргийн шүүхийн шийдвэр иргэний хэргийн шийдвэрт шинээр илэрсэн нөхцөл байдал болно.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад татварын улсын байцаагчийн акт илтэд үндэслэлгүй, хууль бус болох нь илэрхий байвал ерөнхий харьяаллын шүүх татвар төлөгчийн захиргааны хэргийн шүүхэд хандах эрхийг шийдвэртээ заавал тусгана.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад татварын улсын байцаагчийн актын хууль зүйн үндэслэлийн талаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гарвал шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4., 80 дугаар зүйлийн 80.1.4.-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гарсан үед мөн зүйлийн 80.3.-т зааснаар сэргээх ажиллагааг гүйцэтгэнэ.

3.4. Сонгуулийн холбогдолтой маргаан

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6.-д заасан “Сонгуулийн Ерөнхий хороо” гэсэн заалтыг Үндсэн хуулийн Цэц 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 2/02 дугаар дүгнэлтээр Үндсэн хууль зөрчсөн болохыг тогтоож, Улсын Их Хурал 2005 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар уг заалтыг хүчингүй болсонд тооцсон тул Сонгуулийн Ерөнхий хорооны шийдвэр, үйл ажиллагааны талаарх нэхэмжлэл захиргааны хэргийн шүүхийн харьяалалд хамаарахгүй.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Ерөнхийлөгчийн сонгуулийн болон Сонгуулийн төв байгууллагын тухай, Орон нутгийн хурлын сонгуулийн тухай, Ард нийтийн санал асуулгын тухай хуулиудад Сонгуулийн Ерөнхий хороонд холбогдох маргааны харьяаллын талаар тусгайлсан зохицуулалт байхгүй бол энэ талаар гаргасан нэхэмжлэлийг ерөнхий харьяаллын шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн арван дөрөвдүгээр зүйлд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

Дээрх хуулиудад Сонгуулийн Ерөнхий хорооноос бусад байгууллага, албан тушаалтанд холбогдох маргааны харьяаллыг тусгайлан заагаагүй бол нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүх Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1., 4.2.-т заасан үндэслэлээр өөрийн харьяаллаар, бусад тохиолдолд ерөнхий харьяаллын шүүхүүд өөрийн харьяаллаар тус тус хүлээн авч, хянан хэлэлцэнэ.

3.5. Ашигт малтмалын хууль тогтоомжтой холбоотой маргаан

Ашигт малтмалын тухай хуульд зааснаар төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны талаарх нэхэмжлэл захиргааны хэргийн шүүхэд харьяалагдана.

Иргэд, хуулийн этгээдүүдийн хоорондох гэрээний харилцаанаас үүссэн маргааныг иргэний журмаар хянан шийдвэрлэсний үр дүнд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, тэдгээртэй холбоотой бүртгэлийг өөрчлөх асуудлыг ерөнхий харьяаллын шүүх тухайн иргэний хэрэгт нэг мөр шийдвэрлэнэ. Энэ асуудлыг шийдвэрлэхэд төрийн захиргааны байгууллага иргэний хэрэгт хариуцагчаар оролцохгүй.

4.Хэргийн болон шүүхийн харьяалмын талаар шүүхүүд маргаж болохгүй бөгөөд хэргийн харьяаллыг тогтооход хүндрэлтэй тохиолдолд уг асуудлыг Шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.4.-т зааснаар Улсын Дээд шүүхийн иргэний болон захиргааны хэргийн танхимын тэргүүн шийдвэрлэнэ.

Түүнчлэн Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ” гэж заасны дагуу хэргийн харьяаллыг Үндсэн хуулийн Цэц тогтоосон бол дагнасан болон ерөнхий харьяалмын шүүх түүний шийдвэрийг дагаж мөрдөнө.

5. Энэ тогтоолын хавсралт болох хүчин төгөлдөр үйлчилж байгаа 357 хуульд заагдсан хэргийн харьяалмын талаарх зохицуулалтын жагсаалтыг захиргааны болон ерөнхий харьяалмын шүүхүүд Улсын Дээд шүүхийн зөвлөмж хэлбэрээр ашиглах нь зүйтэйг дурасугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

**ИРГЭНИЙ ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

Ц.АМАРСАЙХАН

**ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

О.ЗАНДРАА

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ЗӨВЛӨМЖ

2005 оны 4 дүгээр сарын
06-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүгч нар 2004 оны 11 дүгээр сарын 25-наас 2005 оны 3 дугаар сарын 01-ний хооронд Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын давж заалдах, хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн хэргүүд болон давж заалдах, хяналтын журмаар гомдол гараагүй Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрлэсэн хэргүүдийг хянав.

Нийт шүүхүүд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэхдээ дараах зүйлүүдийг анхаарах нь зүйтэй байгааг тэмдэглэн Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.4-д заасныг үндэслэн ЗӨВЛӨМЖЛӨХ нь:

НЭГ. Шүүхэд нэхэмжлэл гаргах, түүнийг хүлээн авах ажиллагааны талаар

1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн /цаашид хуулийн гэх/ 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх хэсэгт “хуульд тусгайлан заасан” гэдэг нь иргэн, хуулийн этгээд захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны хууль бус акт нь түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл урьдчилан шийдвэрлэх ажиллагаагүйгээр нэхэмжлэлээ шүүхэд шууд гаргаж болохыг заажээ. Ингэж заасан 26 хууль /хавсралт №1/ байгаа ба тухайн хуульд маргаан бүхий захиргааны актын талаар шүүхэд нэхэмжлэлээ гаргах хугацааг тусгайлан заагаагүй тохиолдолд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан “...холбогдох захиргааны актыг хүлээн авснаас, эсхүл мэдсэнээс хойш 30 хоногийн дотор... ” гэж ойлговол зохино.

Энэ хугацааг зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтрүүлсэн нь тогтоогдвол мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан хугацааны дотор шүүгч захирамж гаргаж нөхөн сэргээж болох юм.

2. Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т заасан “шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан гомдлыг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлээгүй” гэдгийг тухайн хуульд гомдол хянан шийдвэрлэх тусгайлсан хугацаа тогтоогоогүй бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасны дагуу Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан 30 хоног гэж ойлгоно.

Хугацааг өөрөөр заасан хуулиуд байгааг анхаарах нь зүйтэй. Тухайлбал: Орон сууц хувьчлах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Сууц эзэмшигч нь сууц хувьчлахтай холбоотой гомдлыг орон сууц хувьчлах товчоонд гаргах ба уг гомдлыг 14 хоногийн дотор шийдвэрлэнэ”; 2 дахь хэсэгт “сууц эзэмшигч орон сууц хувьчлах товчооны шийдвэрийг эс зөвшөөрвөл Төрийн өмчийн хороонд гомдол гаргаж болно. Төрийн өмчийн хороо гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 20 хоногийн дотор хянан шийдвэрлэж хариу өгнө”. Патентын тухай хуулийн 27 дугаар зүйлд “Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт шүүлт хийхтэй холбогдон гарсан гомдлыг оюуны өмчийн газар 6 сарын дотор хянан шийдвэрлэж хариуг бичгээр мэдэгдэнэ. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл маргалдагч тал шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргах эрхтэй” гэсэн байна.

3. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Нэхэмжлэлийг тухайн шийдвэр гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтны оршин байгаа газрын Захиргааны хэргийн шүүхэд гаргана” гэснийг анхны шийдвэр гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа явуулж байгаа газрын Захиргааны хэргийн шүүхэд гэж ойлговол зохино.

Жишээ нь: Орхон аймгийн Газрын албаны эрхийн бүртгэгчийн хийсэн бүртгэлийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг Орхон аймгийн Захиргааны хэргийн шүүхэд гаргахаас биш уг бүртгэлийн талаарх иргэн, хуулийн этгээдийн гомдлыг хянан шийдвэрлэсэн улсын ерөнхий бүртгэгчийн ажилладаг буюу эрхийн улсын бүртгэлийн албаны оршин байгаа Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхэд гаргахгүй юм.

4. Хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д зааснаар нэхэмжлэлийг тухайн Захиргааны хэргийн шүүхийн нарийн бичгийн дарга хүлээн авах бөгөөд хүлээн авсан тухайгаа баталгаажуулна.

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний төвийн Зөвлөлийн 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 17 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Стандартын 2 дугаар хэсэг /Баримт бичгийн бүрдлүүд, тэдгээрт тавигдах шаардлага/-ийн 6.26-д заасны дагуу нэхэмжлэлийн эхний хуудасны ар талын зүүн доод буланд хүлээн авсан нэхэмжлэлийн бүртгэлийн дэс дугаар, түүнд хавсаргасан материалын хуудасны тоо, хүлээн авсан огноо, цаг, минутыг тэмдэглэж, нэхэмжлэл бүртгэх дэвтэрт бүртгэнэ. Ингэж баталгаажуулах нь хөөн хэлэлцэх хугацаа тоолох, түүнийг тасалдсан эсэхийг тодорхойлох, нэхэмжлэлийг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэх болон уул хугацаанд хяналт тавихад ач холбогдолтой. Хянагдсан хэргүүдээс үзэхэд ихэнх шүүхүүд хуульд заасан энэ ажиллагааг гүйцэт хийгээгүй байна.

5. Хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т “Нэхэмжлэл нь энэ хуулийн 32.2-т заасан бүрдүүлбэр хангаагүй бол хүлээн авсан шүүгч 7-14 хоногийн хугацаа тогтоон нэхэмжлэгчид уг шаардлагыг хангах боломж олгоно” гэснийг нэхэмжлэлтэй танилцсан шүүгч нэхэмжлэлд мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т тодорхойлон заасан зүйлүүдийг дутуу тусгасан байна гэж үзвэл бүрдүүлбэл зохих шаардлагуудыг нэхэмжлэл бүртгэх дэвтэрт тоочин бичиж, тогтоосон хугацаанд нэхэмжлэгч бүрдүүлбэрийг хангаж ирүүлээгүй тохиолдолд гарах үр дагаврыг нь тайлбарлаж, нэхэмжлэгчээр гарын үсгийг нь зуруулж байвал зохино.

Тогтоосон хугацаанд нэхэмжлэгч нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаж ирүүлээгүй бол шүүгч хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д зааснаар захирамж гаргаж нэхэмжлэлийг нэхэмжлэгчид буцаана. Энэ захирамжид хэргийн оролцогч хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1-д зааснаар гомдол гаргах эрхгүй гэж ойлгоно.

6. Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 /захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус/, 34.1.2 /тухайн захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус/, 34.1.8 /захиргааны акт нь Үндсэн хууль зөрчсөн нь тогтоогдсон бөгөөд Үндсэн хуулийн Цэцийн харьяаллын маргаан бол/, 34.1.9 /захиргааны акт нь эрүүгийн эрх зүйн маргаан бол/, 34.1.10 /захиргааны акт нь иргэний эрх зүйн маргаан бол/-т заасан тохиолдлуудад шүүгч захирамж гарган татгалзсан шалтгааныг зааж, 35 дугаар зүйлийн 35.1-д заасны дагуу нэхэмжлэлийг харьяалах шүүхэд буюу Үндсэн хуулийн Цэц, прокурорт тус тус шилжүүлэхээр заажээ. Нэгэнт шүүгч захиргааны хэрэг үүсгээгүй учраас тухайн нэхэмжлэлийг шүүхийн тогтоолоор татгалзаж шилжүүлэх боломжгүй юм.

Харин хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 35 дугаар зүйлийн 35.2-т заасан шүүхийн тогтоолыг шүүх нэхэмжлэлийг харьяалмын журмаар хүлээн авсан боловч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасан үндэслэл шүүх хуралдааны явцад тогтоогдвол хэргийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.1, 52.1.2-т зааснаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байгаа тохиолдолд гаргана.

Хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-д “нэхэмжлэлийг Захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж хүчин төгөлдөр болсны дараа шилжүүлнэ” гэж заасан бөгөөд мөн хуулийн 79 дүгээр зүйлийн 79.4-т “Захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж нь гармагц хүчин төгөлдөр болно” гэснийг анхаарах нь зүйтэй.

Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буй захирамжид хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1-д зааснаар хэргийн оролцогчоос гомдол гаргаж болохгүй байх тул гармагц хүчин төгөлдөр болох захирамж гэж ойлговол зохино.

Харин хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1-д заасан захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах, хойшлуулах, түдгэлзүүлэх талаар гарсан Захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор Улсын Дээд шүүхэд гомдол гаргах эрхтэй тул эдгээр захирамж гармагц хүчин төгөлдөр болохгүй гэж ойлгоно.

7. Захиргааны хэрэг үүсгэсэн захирамжид ямар байгууллага, хэн гэдэг албан тушаалтанд холбогдуулж, хэний ямар шаардлагын агуулгад хэрэг үүсгэж байгаа тухайгаа тодорхой бичсэн байвал зохино. Нийслэлийн Захиргааны хэргийн шүүгч нар, хэрэг үүсгэсэн захирамждаа хэргийн хариуцагч нь чухам хэн болохыг заагаагүй, “нэхэмжлэлд иргэний хэрэг үүсгэсүгэй” гэж буруу томъёолж бичсэн байв.

Шүүхүүд, тэр тусмаа тодорхой нэг шүүхийн шүүгч нарын бичсэн захиргааны хэрэг үүсгэсэн захирамжийн агуулга, бүтэц, баримталсан хуулийн зүйл, хэсэг өөр өөр байна. Зарим захирамж нь “хянах, захирамжлах” хэсэгтэй байхад зарим нь “тодорхойлох, үндэслэх, захирамжлах” хэсгээс бүрдсэн, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 37 дугаар зүйлийн 37.1, 79 дүгээр зүйлүүдийг баримталсан байна.

Иймд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудад шүүгчээс гарах захирамж /хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамжаас бусад/-ийн бүтцийн талаар тодорхойлоогүй боловч хэрэг үүсгэсэн захирамж нь “удиртгал, хянах, захирамжлах” хэсгээс бүрдэж, “удиртгал” хэсэгт ямар шүүхийн хэн гэдэг шүүгч, хэний нэхэмжлэлтэй, хэнд холбогдох ямар шаардлага бүхий нэхэмжлэлийг хэзээ хүлээж авсныг бичиж, “хянах” хэсэгт тухайн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байхгүйг тодорхойлж, “захирамжлах” хэсэгт удиртгал болгосон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийг бичиж байвал зохино. Хэрэг үүсгэсэн захирамжид хариуцагчийг зөв тодорхойлох шаардлагатай юм.

Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12-т заасан албан тушаалтны гаргасан захиргааны актад гомдол гаргасан байхад түүний ажилладаг захиргааны байгууллагыг хариуцагчаар татсан, шүүгч тухайн албан тушаалтанд холбогдуулан хэрэг үүсгэж, захирамж гаргасан атлаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад захиргааны байгууллага нь хариуцагч болж өөрчлөгдсөн зөрчлүүд гарч байна.

Харин Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасан үндэслэл тогтоогдвол шүүгч захирамж гарган хариуцагчийг солих бөгөөд нэхэмжлэгч үүнийг зөвшөөрөөгүй бол хамтран хариуцагчаар татан оролцуулах юм.

Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д зааснаар захиргааны хэргийн нотлох баримтыг цуглуулах үүргийг Захиргааны хэргийн шүүх гүйцэтгэдэг учраас шүүгч хэрэг үүсгэсэн захирамждаа тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий ямар нотлох баримтыг цуглуулах тухайгаа тодорхойлон бичиж байх нь зүйтэй байна.

8. Хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3-д заасан "...Хэргийн оролцогчид эрх, үүргийг нь амаар тайлбарлан өгч энэ тухай тэмдэглэлд бичиж, гарын үсэг зуруулах" гэснийг шүүгч амаар тайлбарлахаас гадна холбогдох зүйл, заалтуудыг тоочин бичсэн баримт бичиг ашиглаж болохыг ойлгоно. Гагцхүү эрх, үүргийг нь тайлбарласан тухайгаа баримт үйлдэж, хэргийн оролцогчдоор гарын үсэг зуруулж, хэрэгт хавсаргах шаардлагатай. Хэргийн оролцогчийн эрхийг ноцтой зөрчсөн зөрчил нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохоор хуульд заасныг анхаарвал зохино.

9. Хуулийн 41, 42, 43 дугаар зүйлүүдэд заасан нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, нэхэмжлэгч хариуцагч нар эвлэрсэн тохиолдолд шүүгч эдгээр хүсэл зоригийг баталгаажуулж дурьдан хэргийг хэрэгсэхгүй болгосон захирамж гаргах бөгөөд энэ захирамжийг хэргийн оролцогч давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлүүлэхээр гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй. Мөн энэ тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.5-д заасны дагуу улсын тэмдэгтийн хурсаамжийн хэмжээг тал хувиар бууруулан тогтооно.

10. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нөхцөлийн талаар хуулийн 46 дугаар зүйлд тоочин зааснаас гадна өөр хуулиар хориглосон заалт байгааг анхаарах. Тухайлбал: Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Тухайн банкны хувь нийлүүлэгч онцгой дэглэм тогтоох тухай Монгол банкны шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй. Гомдол гаргасан нь онцгой дэглэм тогтоох шийдвэрийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй" гэж заажээ.

ХОЁР. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааны талаар

1. Хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг тухайн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс тогтоол гаргаж, сунгах ёстой. Тогтоолд зөвлөлгөөнд оролцсон захиргааны хэргийн шүүгчид гарын үсэг зурна. Нийслэл, Завхан, Хөвсгөл аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрлэсэн зарим хэргүүдийн хэрэг хянан шийдвэрлэх хугацааг Ерөнхий шүүгчийн захирамжаар сунгасан тохиолдол гарсан нь хуульд нийцээгүй байна.

ГУРАВ. Хэргийн оролцогчийн талаар

1. Хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдийг зөвхөн бие даасан шаардлагатайгаас гадна маргаан бүхий захиргааны актын талаар шүүхээс гарах шийдвэр нь бие даасан

шаардлага гаргаагүй этгээдийн эрх, үүрэгт муугаар нөлөөлөхөөр байвал шүүхийн шийдвэр гарахаас өмнө уг этгээдийг өөрийнх нь эсхүл шүүхийн санаачилгаар болон оролцогчийн хүсэлтээр бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн хувиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна гэж ойлговол зохино. Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд нь хариуцагчийн талд оролцож буй тохиолдол бөгөөд нэхэмжлэгчийн хувьд гуравдагч этгээд зөвхөн бие даасан шаардлагатайгаар оролцоно.

2. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.1-27.2.8-д дурьдсан төлөөлөгчийн эрхийг түүнд төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлд заавал заасан тохиолдолд эдэлнэ гэж ойлгоно.

3. Иргэдийн төлөөлөгч хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.4-т заасан “нэмэлт нотлох баримт цуглуулах талаар гаргах хүсэлт” нь шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцэж эхлэхийн өмнөх буюу шүүгч хэргийн талаар танилцуулахын өмнөх үе шатанд хэрэгжинэ. Хуулийн 58 дугаар зүйлийн 58.1-д захиргааны хэргийг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд 3 хүртэл иргэдийн төлөөлөгч оролцуулахаар заасан бөгөөд энэ нь 1, 2, 3 байж болно. Харин оролцсон төлөөлөгч нар хэргийн үйл баримт, оролцогчийн гэм буруугийн талаар өөр өөр саналтай байгаа тохиолдолд дүгнэлтээ тус тусдаа гаргана.

ДӨРӨВ. Шүүх хуралдааны тэмдэглэл

1. Хуулийн 68 дугаар зүйлийн 68.1-д зааснаар шүүх хуралдааны тэмдэглэлд Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн агуулгыг бичих ёстой байтал зарим тэмдэглэлд шийдвэрийн “тогтоох” хэсгийг тэр чигт нь хуулан бичиж тэмдэглэлийг захиран тушаах хэлбэртэй болгосон нь буруу байна.

Мөн Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн нарийн бичгийн дарга нар хэргийн оролцогчийн нэр, зарим үгийг хэтэрхий товчилж “нэх Б”, “хар Ц”, “гур.төл А” гэх зэргээр бичсэн нь ойлгомжгүй болжээ.

2. Хуулийн 68 дугаар зүйлийн 68.4-т заасан “тэмдэглэлтэй холбогдон гарсан саналын талаар шүүгч захирамж гаргана” гэснийг шүүх хуралдааны тэмдэглэл алдаатай бичигдсэн талаар шүүх хуралдаан даргалагч буюу шүүх хуралдааны оролцогчийн хэн нэгний гаргасан саналыг шүүх хэрхэх талаар захирамж гаргах бөгөөд саналыг хүлээн авсан тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.3-т заасны дагуу тэмдэглэлд засвар хийж баталгаажуулна. Шүүх хуралдааны тэмдэглэл нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т зааснаар тухайн хэргийг нотлох баримт болдгийг анхаарч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1-д заасан шаардлагыг биелүүлж үйлдэж байх нь зүйтэй.

ТАВ. Шүүх хуралдааны дэг

1. Хэргийн зарим оролцогч шүүх хуралдаанд ирээгүйгээс гарах холбогдлын талаар хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2, 69.3-т заасан журмаар зохицуулахаар заажээ. Хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 100 дугаар зүйлийн 100.2-100.4-т заасан журмыг хэрэглэхээр заасан зохицуулалт нь хэргийн зарим оролцогч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол ирсэн талын хүсэлтийг үндэслэн шүүх хуралдааныг оролцогчийн эзгүйд хийж болох зохицуулалт юм. Харин хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2, 69.3-т заасан тохиолдолд зөвхөн нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй үед шүүх өөрийн санаачилгаар шүүх хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэх асуудлыг зохицуулна гэж ойлговол зохино.

ЗҮРГАА. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн талаар

1. Хуулийн 9 дүгээр зүйлд заасан тохиолдлуудад шүүх мөн хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.3-т зааснаар тухайн захиргааны актыг илт хүчин төгөлдөр бус болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргана.

2. Хуулийн 70 дугаар зүйлийн 70.4-т заасан “Захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны улмаас нэхэмжлэгчид хохирол учирсан нь тогтоогдвол нөхөн төлүүлэх ба хохирлын хэмжээний талаар маргаан гарсан бол иргэний хэргийн шүүхэд шийдвэрлүүлнэ” гэснийг шүүх мөн хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.6-д зааснаар шийдвэр гаргах үед хохирлын хэмжээний талаар маргаан гарсан тохиолдолд гэж ойлгоно. Энэ тохиолдолд Захиргааны хэргийн шүүх шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж гаргаж хэргийг иргэний хэргийн шүүхэд шилжүүлнэ.

3. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн агуулга ямар байх талаар хуулийн 72 дугаар зүйлд заажээ. Шүүхийн шийдвэр бүрэн ойлгомжтой, логик уялдаа холбоотой, эрх зүйн сэтгэлгээний өндөр түвшинд бичигдсэн байх ёстой. “Шүүхийн шийдвэр бүрэн байна” гэдэг нь шийдвэрт хэргийн оролцогчдын тайлбар, шаардлага, татгалзал, хэлэлцсэн баримтыг бүрэн тусгахыг ойлгох бөгөөд түүнийг хэргийн нөхцөл байдлыг бүрэн тогтоогоогүй байдлаас ялгаж ойлгох нь зүйтэй. Шийдвэрт нэмэлт тайлбар шаардагдахгүй бүх нийтэд тодорхой бөгөөд ойлгомжтой нэр, томьёо үг хэллэг хэрэглэсэн, тодорхой бус томьёолол, албан баримт бичиг үйлдэхэд хэрэглэгддэг үг, товчлол ашиглаагүй, хэрэгт ач холбогдолгүй үйл явдлыг бичээгүй байвал зохино. Хянагдсан шийдвэрүүдээс үзэхэд ялангуяа Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхээс гаргаж буй шийдвэрүүд нь хэтэрхий нуршуу, олон урт өгүүлбэртэй, ойлгомж муутай, хууль зүйн нэр томьёо, утга, найрлагын хувьд оновчтой биш бичигдсэн байсныг анхаарах нь зүйтэй.

4. Хуулийн 70 дугаар зүйлийн 70.3-т “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр нь хэрэгт авагдсан бөгөөд шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримт болон хуульд үндэслэсэн байна” гэж заасан бөгөөд энэ шаардлага нь шийдвэрт тавигдах үндсэн шаардлага юм. “Шийдвэр хуульд үндэслэгдсэн байна” гэдэг нь шүүх, хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг зөв хэрэглэж, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шаардлагад нийцсэн шийдвэр гаргахыг ойлгоно.

5. Хуулийн 75 дугаар зүйлийн 75.1-д заасан тохиолдолд шүүхийн шийдвэрт засвар оруулахыг заажээ. Гэтэл Орхон аймгийн Захиргааны хэргийн шүүх захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн шүүгчийн захирамждаа засвар оруулсан нь буруу байна. Хавтаст хэрэгт анхны гаргасан шийдвэр болон нэмэлт оруулсан шийдвэрийг засвар оруулсан тухай шүүх бүрэлдэхүүний тогтоол, шүүгчийн захирамжийн хамт үдэж байвал зохино. Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн 2004 оны 01 дүгээр шийдвэртэй хэрэгт засвар оруулсан анхны шийдвэрийг үдэж хавсаргаагүй нь буруу байв.

Түүнчлэн захиргааны хэрэг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль, энэ хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль болон Монгол Улсын олон улсын гэрээ, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, уг хуулийг тайлбарласан Монгол Улсын Дээд шүүхийн 2002 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 263 дугаар тогтоолыг сайтар судалж, баримталж ажиллах шаардлагатай байна.

**ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

О.ЗАНДРАА

2005 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн
01 дүгээр зөвлөмжийн хавсралт №1

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
2. Ард нийтийн санал асуулгын тухай хууль
3. Байгууллагын нууцын тухай хууль
4. Векселийн тухай хууль
5. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль
6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль
7. Зар сурталчилгааны тухай хууль
8. Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль
9. Иргэний бүртгэлийн тухай хууль
10. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн хууль
11. Согтууруулах, мансууруулах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль
12. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль
13. Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хууль
14. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль
15. Технологи дамжуулах тухай хууль
16. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль
17. Улс төрийн намуудын тухай БНМАУ-ын хууль
18. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хууль
19. Тэмдэгтийн хураамжийн хууль
20. Харьяатын тухай хууль
21. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль
22. Хувь хүний нууцын тухай хууль
23. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль
24. Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хууль
25. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль
26. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ТАНХИМЫН ЗӨВЛӨМЖ

2006 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр
хот

Улаанбаатар

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 79, 90 дүгээр
зүйлийг хэрэглэж буй шүүхийн практикийн тухай

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны шүүх хуралдаанаар 2004 оны 6-н сараас 2006 оны 1, 2 дугаар сард Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн /цаашид хуулийн гэх/ 90 дүгээр зүйлд заасан үндэслэлээр хянагдсан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол /цаашид захирамж, тогтоол гэх/ болон дээрх хугацаанд Нийслэлийн захиргааны хэргийн шүүхээс гаргасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолуудыг /давж заалдах шатны журмаар хянагдаагүй/ хянаж, шүүхийн практикийг судлав.

Судалгаанаас үзвэл хуулийн 90 дүгээр зүйлд зааснаар давж заалдах шатны шүүхээр хянагдсан 14 шүүгчийн захирамжаас 8 нь хүчингүй болж, 2 шүүхийн тогтоол хянагдсанаас 1 нь хүчингүй болжээ.

Нийт шүүхүүд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх явцад тодорхой асуудлаар шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол гаргахад дараах зүйлийг анхаарах нь зүйтэй байгааг тэмдэглэж Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3; 15.4-т заасныг үндэслэн ЗӨВЛӨМЖЛӨХ НЬ:

1. Захирамж, тогтоол нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс гаргах шийдвэрийн нэг төрөл тул шийдвэрлэж буй асуудлын зорилгод нийцүүлж, хуулийн хэм хэмжээг оновчтой зөв хэрэглэн, цугларсан баримтыг үндэслэн зөв дүгнэлт хийх нь зүйтэй ба тэдгээрт хуулийн 70 дугаар зүйлийн 70.3 дахь хэсэгт заасан хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлага нэгэн адил тавигдана.

Захирамж, тогтоол гаргах үндэслэлийг хуулийн 79 дүгээр зүйлээр тодорхой зохицуулжээ.

Гэтэл аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчид захирамж, тогтоол гаргахдаа хуулийн заалтыг өөр өөрөөр хэрэглэж байгаагаас үзвэл энэ талаар нэгдсэн практик тогтоогүй байна.

Тухайлбал: зарим шүүгчид ямар ч төрлийн захирамж гаргасан зөвхөн хуулийн 79 дүгээр зүйлийг дангаар нь, зарим нь 79 дүгээр зүйлийг тухайн төрлийн захирамж гаргахад холбогдох өөр зүйлтэй давхар хэрэглэж байхад нөгөө хэсэг нь 79 дүгээр зүйлийг огт хэрэглэхгүйгээр зөвхөн тухайн асуудлаар гаргах захирамжтай холбоотой зүйл заалтыг баримталжээ.

Иймд цаашид захирамж, тогтоол гаргахдаа хуулийн 79 дүгээр зүйлийг удирдлага болгож, захирамжлах, тогтоох хэсэгт тухайн асуудлаар захирамж, тогтоол гаргахад тусгайлан заасан хуулийн зүйл, хэсгийг баримталж байвал зохино.

Жишээ нь: Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1; 79.2-т заасныг удирдлага болгон ЗАХИРАМЖЛАХ НЬ /хэрэв тогтоол бол ТОГТООХ НЬ/

1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4-т заасныг баримтлан ... нэхэмжлэгчийн төлөөлөгчөөр томилсугай” гэх мэт.

Мөн зарим шүүгчид хуулийн 45 дугаар зүйлд зааснаар “Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай” захирамж гаргахдаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 158 дугаар зүйлийг давхар баримталж байгаа нь буруу тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулах тухай Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгайлан заагаагүй тохиолдолд тухайн шийдвэрлэж буй асуудлыг зөвхөн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл, хэсгийг баримтлан шийдвэрлэж байх нь зүйтэй.

Хөвсгөл аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн гаргасан захирамжаас үзвэл тэрээр “нэхэмжлэлийн шаардлагыг нэгтгэсэн атлаа” Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасныг баримталж , мөн зүйлийн 44.1-д заасныг зөрчжээ. Энэ мэт хууль буруу хэрэглэж байгаа алдааг дахин давтахгүй байвал зохино.

2. Захирамж, тогтоолд шийдвэрлэж буй асуудлыг аль болох товч, тодорхой, хуулийн үг хэллэгээр хэргийн оролцогчдоод ойлгомжтой байхаар тусгах ёстойгоос гадна үг, найруулгын алдааг сайтар хянаж, захирамж, тогтоолын ард боловсруулж, хянасан шүүгч гарын үсгээ зурж баталгаажуулах шаардлагатай.

Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн 2006 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буцаасан захирамжид нэхэмжлэлийг хүлээн авсан оныг 2006 гэхийг 2005 он гэж буруу тэмдэглэснээс шүүх нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш бүтэн 1 жилийн дараа түүнийг хүлээн авахаас татгалзах захирамж гаргасан гэж ойлгогдохоор болжээ.

Захиргааны хэрэг үүсгэх захирамжид ихэнх шүүгчид “...нэхэмжлэлд холбогдуулж захиргааны хэрэг үүсгэсүгэй” , зарим нь “...-ны нэхэмжлэлтэй ...-д холбогдох хэрэгт /хэрэг үүсгээгүй байхад/ захиргааны хэрэг үүсгэсүгэй”, “...-ний нэхэмжлэлээр захиргааны хэрэг үүсгэсүгэй” гэх мэтээр оновчтой бус томъёолсон байгааг анхаарч, цаашид “...-ний нэхэмжлэлээр-д холбогдуулан захиргааны хэрэг үүсгэсүгэй” гэж томъёолох нь зүйтэй.

3. “Шүүхийн тогтоол” гэдэг нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх аливаа ажиллагааны талаар шүүх бүрэлдэхүүнээс гаргасан шийдвэр юм.

“Шүүх бүрэлдэхүүн” гэдэгт хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1-д зааснаас үзвэл 3 шүүгч /анхан шатны шүүхийн хувьд/ байх ёстой тул шүүхийн тогтоолыг ямар ч тохиолдолд 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй гаргах ёстой.

Харин шүүх бүрэлдэхүүнд орж байгаа шүүгчийг татгалзан гаргах тухай асуудлыг хэлэлцээд гаргасан шүүхийн тогтоол үүнд хамаарагдахгүй. / хуулийн 65 дугаар зүйл/

Гэтэл Нийслэл, Хөвсгөл аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчид шүүх бүрэлдэхүүнд томилогдсон шүүгч “өвчтэй, гадаадад явсан, Улаанбаатар хотод сургалтад оролцож байгаа” гэх мэт үндэслэлээр товлогдсон шүүх хуралдааныг хойшлуулж, шүүхийн тогтоолыг 2 шүүгчийн бүрэлдэхүүнтэй гаргаж хууль буруу хэрэглэжээ.

Түүнчлэн шүүх хуралдаанаар тухайн асуудлыг хэлэлцэхэд хэргийн оролцогчид оролцож байгаа тохиолдолд шүүх хуралдааны тэмдэглэлийг зайлшгүй хөтөлнө.

4. Хуулийн 79 дүгээр зүйлийн 79.2 дахь хэсэгт “...шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг бичгээр гаргана”

79.3-т “Хуульд тусгайлан заасан бол захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг тэмдэглэлд тусгах замаар “амаар” гаргаж болно.” гэж зааснаас үзвэл “ам захирамж, тогтоол” гаргахад 3 шаардлага тавигдаж байна.

Үүнд:

а) тухайн асуудлын талаар хуульд тусгайлан заасан байх;

б) Шүүх хуралдааны тэмдэглэлд заавал тусгах;

в) “ам захирамж, тогтоол”-ыг зөвхөн шүүх хуралдааны явцад гаргах зэрэг болно.

Тухайлбал, хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт “Шүүх хуралдааны журам зөрчсөн этгээдэд эхний удаа хуралдаан даргалагч урьдчилан сануулна” гэж заасан байх бөгөөд шүүх бүрэлдэхүүн эсхүл шүүх хуралдаан даргалагч хуулийн уг заалтыг хэрэгжүүлэхдээ “ам захирамж, тогтоол” гаргаж болох юм.

5. Шүүх ямар тохиолдолд “хэргийг хэрэгсэхгүй болгох”, ямар тохиолдолд “нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох” талаар шүүгчид нэгдсэн ойлголтгүй байгаа нь судалгаанаас тодорхой ажиглагдаж байна.

“Нэхэмжлэл үндэслэлгүй” гэж үзвэл “нэхэмжлэлийг хэрэгсэхгүй” болгох нь зүйтэй бөгөөд үүнийг гагцхүү шүүх хуралдаанаас “шийдвэрээр”, харин шүүх хуралдааны үед Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1-д заасан үндэслэл, мөн 34 дүгээр зүйлд заасан нөхцөл байдал тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгоно гэж ойлговол зохино.

Үр дагаврын хувьд “нэхэмжлэлийг хэрэгсэхгүй” болгосон тохиолдолд тухайн асуудлаар шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй болдог бол харин хэргийг хэрэгсэхгүй болгосон нөхцөлд тухайн этгээдийн уг асуудлаар шүүхэд дахин хандах эрх нь нээлттэй юм.

Хуулийн 74 дүгээр зүйлд шүүх хуралдааны үед мөн хуулийн 41-43 дугаар зүйлд заасан нөхцөл байдал илэрвэл хэргийг хэрэгсэхгүй болгох талаар тодорхой заажээ. Иймд энэ тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгохдоо хуулийн 74 дүгээр зүйлийг

удирдлага болгож, мөн хуулийн 41-43 дугаар зүйлийн холбогдох заалтыг баримталж байх нь зүйтэй.

Харин шүүх хуралдааны үед “нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл” тогтоогдвол шүүх ямар хуулиар шийдвэрлэх асуудлыг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулаагүй байхад энэ тохиолдолд шүүгчид Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 117 дугаар зүйлийг хэрэглэж байгаа нь буруу юм.

Иймд цаашид дээрх нөхцөл байдал шүүх хуралдааны үед үүсвэл хуульд нэмэлт, өөрчлөлт ортол хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсгийг удирдлага болгож, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн холбогдох заалтыг баримтлан, “хэргийг хэрэгсэхгүй болгон, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж” байвал зохино.

6. Хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1 дэх хэсэгт “Хэргийн оролцогч нь захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах, хойшлуулах, түдгэлзүүлэх талаар гарсан захиргааны хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гарсан өдрөөс нь хойш 10 хоног дотор Улсын Дээд шүүхэд гомдол гаргаж болно” гэж заажээ.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан ямар төрлийн захирамж, тогтоолд гомдол гаргах эрхтэй талаар хуульд тодорхой заагаагүй байгаа боловч үүнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргаж буй бүх захирамж, тогтоолд гомдол гаргах эрхтэй гэж ойлгож болохгүй. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд энэ талаар тодорхой тусгасан болно.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, хойшлуулах асуудлын хувьд тодорхой бол “явуулах” гэдэгт хуулийн 37 дугаар зүйлд зааснаар хэрэг үүсгэсний дараа шүүгчээс явуулах үйл ажиллагаатай холбогдон гаргасан захирамж, тогтоол гэж ойлгох нь зүйтэй.

“Захиргааны хэрэг үүсгэсэн захирамжид гомдол гаргаж болно” гэж практикт ойлгож буй нь буруу юм. Хэрэг үүсгэх захирамж нь зөвхөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлж буй явдал бөгөөд цаашид үргэлжлүүлэн явуулах үндэс суурь нь болдог. Өөрөөр хэлбэл зөвхөн дотоод харилцаанд хамааралтай, уг захирамжийн талаар оролцогчдод заавал мэдэгдэх шаардлагагүй ба уг захирамжид гомдол гаргахгүй. Иймд захиргааны хэрэг үүсгэсэн шүүгчийн захирамжид “гомдол гаргах эрхтэй” гэж зааж болохгүй.

Цаашид шүүхээс гаргаж байгаа аливаа захирамж, тогтоолд аль шүүхэд, ямар хугацаанд гомдол гаргах эрхтэйг эсхүл гомдол гаргах эрхгүй талаар заавал зааж, энэ тухай хэргийн оролцогчдод танилцуулж байх нь зүйтэй.

7. Хуулийн заалтаас үзэхэд захирамж, тогтоолын талаарх гомдлыг зөвхөн Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимд гаргах нь тодорхой байна.

Гэтэл Нийслэлийн захиргааны хэргийн шүүх хуульд заагаагүй үндэслэлээр тухайлбал “хамтран хариуцагчаар татах”, “нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах”, “хялбаршуулсан журмаар шийдвэрлэж гаргасан шүүгчийн захирамж” зэрэг захирамж, тогтоолыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийг үндэслэн өөрөө хянаж, хууль зөрчиж байгааг тэмдэглэж байна.

8. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлтийг шүүх хүлээн авч, хянан шийдвэрлэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмыг баримталбал зохино.

Хүсэлтийг тухайн хэргийг хамгийн сүүлд хянан шийдвэрлэсэн шүүхийн харьяалаар хүлээн авна гэж ойлгох нь зүйтэй ба шүүх шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцох үндэслэлтэй гэж үзвэл шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг ердийн журмаар дахин хянан шийдвэрлэнэ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 181 дүгээр зүйлийн 181.2-т зааснаар шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянахад анхны шийдвэр гаргасан шүүгч буюу шүүх бүрэлдэхүүнийг оролцуулахгүйгээр өөр 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэх бөгөөд уг шүүхийн тогтоол нь эцсийн байх тул түүнд гомдол гаргахгүй.

9. Шүүх хуралдааны үед оролцогчдоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэсэн захирамж, тогтоолд гомдол гаргасан тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулах байтал Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 80 дугаар зүйлд зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж байгаа нь буруу юм.

Хуулийн 47 дугаар зүйлд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа дуусаж байвал, шүүх хуралдааныг хойшлуулж, хэргийн хугацааг мөн зүйлийн 47.3 дахь хэсэгт заасан журмын дагуу сунгаж байх нь зүйтэй.

10. Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, нэхэмжлэлийг буцаах, хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэх тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг хэрхэх асуудлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52-60 дугаар зүйлд заасан журмын дагуу зохицуулна.

Уг асуудлыг шийдвэрлэхдээ Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас 2003 оны 11 дүгээр сард гаргасан зөвлөмжийг /Монгол Улсын Дээд шүүхийн мэдээлэл 2003 он, дугаар 4/ дахин сайтар судлан үзвэл зохино.

Түүнчлэн хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлээд гаргасан захирамж, тогтоол нь тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэж байгаа эрхийн акт тул шийдвэрийн дугаар авч байх нь зүйтэй.

Цаашид захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс тогтоол, шүүгчээс захирамж гаргахдаа Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, уг хуулийг тайлбарласан Улсын Дээд шүүхийн 2002 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 263 дугаар тогтоол, Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимаас 2005 онд гаргасан зөвлөмжийг анхааралтай судалж, хуулийг зөв хэрэглэж ажиллахыг зөвлөж байна.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗӨВЛӨМЖ

2006 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр
хот

Улаанбаатар

Газрын тухай хуулийг шүүхийн практикт
нэг мөр ойлгож, зөв хэрэглэх тухай

Аймаг, нийслэлийн Захиргааны хэргийн шүүхүүд 2004, 2005 онд газрын талаарх маргаантай хэргүүдийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх шүүхийн практикийг нэгтгэн судалж үзлээ.

Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Газрын тухай хуулиар 2004 онд 20, 2005 онд 73 хэрэг тус тус хянан шийдвэрлэсэн нь нийт шийдвэрлэсэн 531 хэргийн 17,5 хувийг эзэлж байгаагаас үзэхэд энэ төрлийн хэрэг цаашид өсөх хандлагатай байна.

Газрыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу зориулалтаар нь үр ашигтай, зохистой эзэмших, ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулсан материаллаг хуулийн заалтуудыг шүүхүүд үндсэнд нь зөв тайлбарлан хэрэглэж байна.

Нийт шүүх, шүүгчид Газрын тухай хуулийг хэрэглэхдээ дараах зүйлүүдийг анхаарах нь зүйтэй гэж үзэж Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.4-т заасныг үндэслэн ЗӨВЛӨМЖЛӨХ нь:

1. Гомдол гаргах харъяалал. Газрын тухай хуулийн /Цаашид “хуулийн” гэх/ 60 дугаар зүйлийн 60.1.1-д заасан маргааныг дээд шатны Засаг дарга, 60.1.3-т заасан маргааныг мэргэжлийн байгууллагын хяналт хариуцсан /Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч/ албан тушаалтан буюу тухайн шатны Засаг дарга заавал урьдчилан шийдвэрлэнэ. Харин мөн хуулийн 60.2 дах хэсэгт зааснаас үзэхэд гомдол гаргагч этгээд нь маргааныг дахин урьдчилан шийдвэрлүүлэх эсхүл шүүхэд шууд хандах эрхээ сонгох эрхтэй байна. Иймд урьд нь маргааныг нэг удаа урьдчилан шийдвэрлүүлсний дараа шүүхэд гомдлоо гаргасан тохиолдолд шүүх түүнийг нь хүлээн авахаас татгалзаж болохгүй.

Мөн зүйлийн 60.1.1, 60.1.3-д заасан маргааны хувьд анхдагч актыг аймаг, нийслэлийн Засаг дарга гаргасан эсхүл урьдчилан шийдвэрлэх журмаар доод шатны Засаг даргын шийдвэрийг хянаад гаргасан шийдвэрт гомдол гаргаж байгаа бол Захиргааны хэргийн шүүх шууд хүлээн авч шийдвэрлэж байх нь зүйтэй.

Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3-т зааснаар газар ашиглах эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон Засаг даргын захирамжийг зөвшөөрөөгүй эрхийн гэрчилгээ эзэмшигчийн гаргасан гомдлыг шүүх шууд хүлээн авч шийдвэрлэнэ.

Хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1-63.1.15-д заасан зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэсэн байгаль орчны улсын

байцаагчийн шийдвэрт гаргасан гомдол нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар урьдчилан шийдвэрлэгдсэн байвал зохино.

Харин бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглахтай холбогдсон аливаа маргааныг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхгүй.

2. Газар эзэмшүүлэх, ашиглуулахад тавигдах шаардлага. Газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон маргааныг шүүх хянан шийдвэрлэхдээ захиргааны байгууллага, албан тушаалтан нь анх газар эзэмших, ашиглах эрх олгохдоо хуулийн 31, 33 дугаар зүйлд заасан шаардлагыг хэрхэн хангасныг голлон анхаарвал зохино. Эрх олгогдсоны дараа тухайн газар дээрээ үйл ажиллагаа явуулж эхлэхээр нь оршин суугчид болон сонирхогч бусад этгээдүүд үндэслэл муутай нэхэмжлэл, гомдол гаргах, элдэв шахалт, шаардлага тавьдаг явдал олонтоо ажиглагдсаныг тэмдэглэж байна.

Газрын талаарх маргаантай хэрэг бүрт Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл, аймаг, нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө /хуваарь/ зэргийг бүгдийг нь нотлох баримт болгон авч хэрэгт хавсаргах боломж муутай байдаг. Энэ тохиолдолд тухайн орон нутагт үйлчилдэг төлөвлөгөө, төсөл, хуваарийн эх хувийг /Нийтэд илэрхий үйл, баримттай адилтган үзэх/ аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн ажлын хэрэгцээнд авах шаардлагатай бөгөөд маргаан бүхий газар нь төлөвлөгөөнд тусгагдсан, тусгагдаагүй гэсэн тодорхой маргаантай хэрэгт дээрх баримтуудад үзлэг хийж, холбогдох заалт, хэсгийг нотлох баримт болгон хавсаргаж байх нь зүйтэй.

3. Шугам сүлжээ бүхий болон нийтийн эдэлбэрийн газар. Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.3, 21.3.2 дах хэсгийг адил утгаар буюу аймгийн төв, хотын суурьшлын бүсийн инженерийн шугам, сүлжээ бүхий болон сүлжээнд холбогдохоор төлөвлөгдсөн газруудад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг зөвхөн аймаг, нийслэлийн Засаг шийдвэрлэнэ гэж ойлгох нь зүйтэй бөгөөд бусад газарт иргэн, аж ахуйн нэгжид газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг мөн зүйлийн 21.4.3, 21.5.3-т зааснаар сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ.

Инженерийн шугам сүлжээ бүхий болон нийтийн эдэлбэрийн газар болох нь эрх бүхий этгээдийн шийдвэрээр баталгаажсан, зураглал, төлөвлөгөө, түүний техник эдийн засгийн үндэслэл, газар зохион байгуулалтын зураг, төсөл, газрын кадастрын зураглалд тусгагдсан эсэхийг шүүх анхаарч үзэх нь зүйтэй бөгөөд ийм баримт үгүй бол тодорхой байгууламж баригдаж, зориулалтаараа ашиглагдаж байгаа эсэхийг үзлэг хийж тодруулах, шинжээч томилж дүгнэлт гаргуулах зэргээр тодорхой ажиллагаа хийсний эцэст хэргийг хянан шийдвэрлэж байвал зохино.

4. Газар эзэмших гэрээ, гэрчилгээ. Хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Газрыг энэ хуульд заасан зориулалт, хугацаа, болзолтойгоор гэрээний үндсэн дээр зөвхөн эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлнэ” гэж зааснаас үзэхэд хуульд заасан журмаар гаргасан Засаг даргын захирамж, газрын алба /даамал/-тай байгуулсан гэрээ,

тэдгээрээс олгосон гэрчилгээ нь цогцоороо газар эзэмших эрхийг баталгаажуулж байгаа юм. Иймд захирамж гаргах, гэрээ байгуулж ёсчлох, гэрчилгээ олгох ажиллагаа нь хуулийн хүрээнд хэрхэн зөв явагдсан нь газар эзэмшүүлэх, ашиглуулахад тавигдах шаардлагатайгаа хэр нийцэж байгааг шүүх нотлох баримтанд тулгуурлан тогтоох үүрэгтэй.

Захирамж гаргасны дараа гэрээ хийгээгүй, гэрчилгээ аваагүй /олгоогүй/ явдал нь хэний буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан талаар маргаан гардаг. Хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, 34 дүгээр зүйлийн 34.2, 35 дугаар зүйлийн 35.3.3, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт тус тус зааснаар бол Засаг даргын захирамж гаргасны дараа гэрээ байгуулах, гэрчилгээ авах асуудлыг хүсэлт гаргагч этгээд санаачлан шийдвэрлүүлэхээр байгаа хэдий ч захиргааны байгууллага, албан тушаалтан гэрээ байгуулахгүйгээр шууд гэрчилгээ олгох явдал гарах хандлагатай байна.

Ийм тохиолдолд гэрээ хийгдээгүй байна гэдгээр хүсэлт гаргагчийг буруутгах биш харин тэрээр зохих үүргээ биелүүлсээр байтал захиргааны байгууллага, албан тушаалтны хууль зөрчсөн үйл ажиллагааны талаар дүгнэлт хийвэл зохино.

5. Газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болох. Хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д зааснаар газар эзэмшиж, ашиглах эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч нь хугацаа сунгуулах тухай хүсэлтээ шаардагдах баримт бичгийн хамт тухайн шатны Засаг даргад гаргасан бол Засаг дарга, мөн зүйлийн 37.2-т заасан 15 хоногийн дотор уг асуудлыг шийдвэрлэх ёстой. Хуулийн дээрх заалтыг эзэмшигч зөрчвөл эрх дуусгавар болох, Засаг дарга зөрчвөл эрх хүчин төгөлдөр байх нөхцлийг тус тус бүрэлдүүлнэ. Хуулийн энэхүү зорицуулалт туйлын тодорхой боловч энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэхдээ шүүх тухайн тохиолдолд хүндэтгэн үзвэл зохих нөхцөл, шалтгаан байсан эсэхийг л шалгаж, нотлох баримтаар тогтоосон байвал зохино.

Харин гэрээнд сунгуулах хүсэлтийн талаар тусгайлан хугацаа зааж зохицуулсан тохиолдолд хүсэлтийг эрх бүхий албан тушаалтан шийдвэрлээгүй бол өмнөх гэрээнд заасан хугацаагаар гэрээг сунгагдсанд тооцох нь зүйтэй.

Хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5-д "...эзэмшигч сунгуулах эрхтэй" гэж заасан нь заавал сунгах ёстой гэсэн санааг агуулаагүй болох нь хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, 37 дугаар зүйлийн 37.2 дах хэсэгт тодорхой байгаа болно.

Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1 дэх хэсэгт заасан "эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг ... зөрчсөн" гэдэгт гэрчилгээгээ бусдад ашиглуулах, шилжүүлэх, барьцаалах журмыг зөрчсөн, газрыг зориулалтын бусаар ашигласан, бусдын газар эзэмшихтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн зэрэг үйлдэл, эс үйлдэхүй хамаарах бөгөөд "Удаа дараа" "Ноцтой" зөрчсөн гэдгийг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэж байгаа практиктай адилаар ойлгох нь зүйтэй.

Зөрчил нь газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эсхүл мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлтээр заавал урьдчилан тогтоогдсон байх бөгөөд түүнийг үндэслэж Засаг дарга эрхийн гэрчилгээг хүчингүй болгох захирамж гаргасан байх ёстой.

Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дах хэсгийн "газрыг 2 жил дараалан ашиглаагүй" гэдэг ойлголтийг газар эзэмших гэрээний хугацаатай хамааралгүй гагцхүү

гэрээ хийгдсэн өдрөөс хойш бүтэн 2 жилийн хугацаанд тухайн газар дээрээ зориулалтын дагуу барилга, байгууламж, зам талбай зэрэг нүдэнд харагдаж хэмжиж, тооцоолж болохуйц объект бий болгоогүй байхыг ойлгох нь зүйтэй. Харин газар дээрээ хашаа барьсан, манаач байрлуулсан, эзэмшүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад ашиглуулсан зэргийг зориулалтын дагуу ашигласан гэж үзэхгүй байвал зохино.

Хуулийн дээрх зүйл, хэсгийн “хүндэтгэн үзэх шалтгаан” гэсэн заалт нь газрыг зориулалтаар ашиглаагүй, 2 жил ашиглаагүй гэдэг заалттай шууд хамааралтай юм. Гэрээ хийгдсэний дараа бусдын буруугаас эсхүл давагдашгүй хүчний улмаас байгалийн тогтолцооны өөрчлөлт гарсан, эвдрэл, элэгдэл бий болсон болон эзэмшигч өвчтэй байсан, гадаадад ажилласан зэрэг зайлшгүй шалтгаанаар газраа зориулалтаар нь 2 жилийн хугацаанд ашиглаж чадахгүйд хүрсэн зэргийг хүндэтгэн үзэх шалтгаан гэж үзнэ. Эзэмшигч энэ тухайгаа эрх олгосон байгууллага, албан тушаалтанд албан ёсоор мэдэгдсэн, зориулалтыг өөрчлүүлэх, хугацааг сунгуулах арга хэмжээ авсан эсэхийг шүүх заавал шалгаж тогтоосон байвал зохино.

Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дах хэсэгт “...мэдэгдэнэ” гэж заасан нь мөн зүйлийн 40.3 дах хэсэгт “...шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй” гэсэнтэй зөрчилддөг. Энэ тохиолдолд мэдэгдсэн ч, мэдэгдээгүй ч шийдвэр гарснаас хойш 10 өдөр өнгөрсөн бол гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэж үзэж болохгүй. Уг асуудалд эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаас нь хандаж гэрчилгээг хүчингүй болгосон захирамжийг мэдэгдсэн эсэхийг шалгаж, мэдсэн өдрөөс хойш 10 өдөр өнгөрсөн /хөөн хэлэлцэх хугацааг/ эсэхийг тоолох нь зүйтэй.

“Мэдэгдсэн” гэдгийг гардуулан өгсөн гэдгээс өргөн утгаар ойлгож захирамжийг эсвэл түүний утгыг илэрхийлсэн мэдэгдлийг тухайн этгээдэд гардуулан өгөх, хаягаар болон бусад аргаар хүргүүлэх, факс, И-мэйл болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, зарлах зэргээр сонирхогч этгээдийг тодорхой ойлголттой болгосон байхыг хэлнэ. Гэхдээ ийм ажиллагаа хийгдсэн гэдгийг нотлох баримтаар тогтоосон байвал зохино.

6. Газар ашиглах. Хуулийн 44 дугаар зүйлийн 44.8 дах хэсэг нь Монгол Улсын иргэн, манай улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан нийтлэг заалт юм.

Эрх бүхий байгууллага, албан тушаалтны зохих зөвшөөрөлгүйгээр газар дээр барилга байгууламж барих, хайгуул хийх, ашигт малтмал олборлох, хадлан бэлчээрийн зэрэг зориулалтаар хууль бусаар газар ашиглах явдал түгээмэл байгаа бөгөөд Засаг дарга энэ үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор газар чөлөөлүүлэх мэдэгдэл, байгаль орчны улсын байцаагч хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.11-д зааснаар хариуцлага хүлээлгэж акт гаргана.

Судалгаанаас үзвэл зөрчил гаргагч этгээд ихэнх тохиолдолд газар эзэмших, ашиглах эрхтэй байдаг бөгөөд түүнийхээ зориулалт, хэмжээ, байршлыг зөрчсөнөөс маргаан гардаг тул зөвшөөрөгдсөн эрхтэй газар, зөвшөөрөлгүй ашигласан гэх газар нь хаана байрлалтай болохыг шүүх зөв тогтоох учиртай.

Ямарч зөвшөөрөлгүйгээр газар ашигласан талаарх маргааны хувьд газар ашигласан, ашиглаагүйг л тогтооход хангалттай.

7. Нэхэмжлэлийн шаардлага нь маргааны зүйлийг тодорхойлдог. Газрын талаарх маргаан хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийг судлаж үзэхэд талуудын гаргасан хүсэлт, гомдолд дурьдсан нэхэмжлэлийн шаардлагад хамааралгүй асуудлыг шалгаж Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлээр шийдвэрлэх явдал олонтаа ажиглагдаж байгааг зориуд цохон тэмдэглэх нь зүйтэй гэж үзнэ.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗӨВЛӨМЖ

2006 оны 6 дугаар сарын 23-ны өдөр
хот

Улаанбаатар

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал, хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоолд үндэслэн 2005 он, 2006 оны эхний 5 сарын байдлаар аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгосон захиргааны акттай холбогдох маргааныг шийдвэрлэж буй шүүхийн практикийг судлав.

Судалгаанаас үзэхэд ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал ашиглах, хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх зэрэг аж ахуйн үйл ажиллагааны зөвшөөрөл олгохтой холбогдсон маргаан нилээн хувийг эзэлж байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн заалтаас үзэхэд Төрийн захиргааны төв байгууллага болон хуулиар эрх олгосон байгууллагаас 90 орчим, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Мэргэжлийн хяналтын байгууллагаас 10 орчим төрлийн аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл тус тус олгохоор хуульчлагджээ.

Шүүхүүд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан бусад хуулийн зүйл, заалтыг хэрэглэхдээ дараах зүйлүүдийг анхаарах шаардлагатай болохыг тэмдэглэн Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.4-д заасныг үндэслэн ЗӨВЛӨМЖЛӨХ нь:

1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан "тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа"-нд энэ хуулийн 15, 16 дугаар зүйлд заасан аж ахуйн үйл ажиллагааны төрлүүд хамаарах ба уг зүйлд заасан аж ахуйн үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл заавал авсан байхыг шүүх анхаарвал зохино.

2. Бусад хуулиудад аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийн талаар заагаагүй буюу нэмэлт шаардлага тавиагүй бол Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан баримт бичгийг бүрдүүлснээр тусгай зөвшөөрөл олгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх баримт бичгийн бүрдэл хангагдсан гэж үзнэ.

3. Захиргааны байгууллага албан тушаалтнаас аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг ямар хугацаагаар олгосон нь тодорхойгүй болон бусад хуульд тусгай зөвшөөрлийн хугацааны доод хязгаарыг заагаагүй зэргээс маргаан гарч байгаа тул анх удаа тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу 3 жилийн хугацаагаар олгоно гэж ойлгох ба "...тусгай зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгоно" гэсэн хуулийн энэ

шаардлага зөрчигдсөн тохиолдолд захиргааны акт хүчингүй болох нөхцөл болохыг анхаарвал зохино.

Харин Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар тогтоосон энэ хугацаа нь газар, байгалийн баялгийг ашиглахтай холбогдон олгох зөвшөөрөлд хамаарахгүй болохыг анхаарах нь зүйтэй.

4. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд зааснаар Төрийн Захиргааны төв байгууллага, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр томилогдсон зохицуулах хороо, зөвлөл, Мэргэжлийн хяналтын байгууллага, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох эрхтэй боловч эдгээр субъектүүд өөрт хамаарахгүй аж ахуйн үйл ажиллагааны төрлөөр тусгай зөвшөөрөл олгосон маргаан гарсан байна.

Энэ зөрчил нь захиргааны акт хүчингүй болох үндэслэл тул шүүх тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон маргааныг шийдвэрлэхдээ дээрх байгууллага, албан тушаалтны эрх хэмжээнд аж ахуйн үйл ажиллагааны тухайн төрлийн тусгай зөвшөөрөл олгох асуудал хамаарч байгаа эсэх, уг зөвшөөрөлийг олгох эрх бүхий захиргааны байгууллага албан тушаалтан нь мөн эсэхийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан ажиллагааг гүйцэтгэх явцдаа анхаарч шалгаж байх нь зүйтэй.

5. Захиргааны албан тушаалтан “Хуулбар үнэн” гэсэн тэмдэглэл бүхий захиргааны шийдвэр /тусгай зөвшөөрөл олгох асуудлыг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, захирамж, тушаал гэх мэт/-ийн хуулбарыг шүүхэд ирүүлэхдээ захиргааны актыг засварласан зөрчил гарч байгааг анхаарч бичмэл нотлох баримтад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасан шаардлагыг заавал хангуулж байвал зохино.

Мөн шүүхэд ирүүлсэн баримт бичгийн хуулбар нь тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад байгаа захиргааны актын эх хувьтай тохирч буй эсэхэд хуульд заасан журмын дагуу үзлэг хийн баталгаажуулж байх нь зүйтэй.

6. Захиргааны байгууллага албан үүргийн хувьд тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон асуудлыг хариуцдаг ажилтныг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилж байгаагаас шалтгаалан хэргийн оролцогчдоос түүний үйл ажиллагаатай холбогдсон гомдол гаргасан тохиолдолд уг томилогдсон этгээдийг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах эсэхийг анхаарч, энэ талаар төлөөлүүлэгчид мэдэгдэж байх шаардлагатай.

7. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон гомдлоо дээд шатны байгууллага, албан тушаалтанд гаргахаар заасан тул нарийвчилсан зохицуулалттай бусад хуульд үүнээс өөрөөр заагаагүй бол энэ талаар гаргасан гомдлыг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх журмыг заавал хангуулах ба дээд шатны байгууллага,

албан тушаалтанд гомдол гаргах хугацаа нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан 30 хоногийн хугацаатай адил болохыг анхаарвал зохино.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗӨВЛӨМЖ

2007 оны 7 дугаар сарын 05-ны өдөр
хот

Улаанбаатар

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн
зарим зүйлийг зөв хэрэглэх талаар

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг нийт шүүхүүд үндсэндээ зөв хэрэглэж байгаа боловч хэрэг хянан шийдвэрлэх явцад дараах алдааг түгээмэл гаргаж байгааг цаашид анхаарах шаардлагатайг тэмдэглэн, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.4-д заасныг үндэслэн ЗӨВЛӨМЖЛӨХ нь:

1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасны дагуу хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүргийг мөрдөн шалгах зарчмын дагуу захиргааны хэргийн шүүх өөрөө гүйцэтгэх ёстой байхад хэргийн оролцогчоос хүсэлт гаргаснаар хийгдэх ажиллагаа гэж буруу ойлгож, зөвхөн тэдний гаргасан нотлох баримтаар хязгаарлах, нэмэлт нотлох баримт цуглуулах талаар гаргасан хүсэлтийг нь “шаардлага багатай” гэсэн буруу дүгнэлт хийж, хангахгүй орхигдуулах, хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тодруулахын тулд үзлэг хийх тухай хуульд заасан ажиллагааг хийхгүй байх зэргээр алдаа гаргасан байна. Тухайлбал: 2006 онд давж заалдах журмаар хянагдсан 159 хэргийн 26 хэрэгт дээрх алдааг гаргасан тул “шийдвэрийг хүчингүй болгож, шаардлагатай нотлох баримтыг цуглуулсны эцэст хэргийг шийдвэрлэх нь зүйтэй” гэж анхан шатны шүүхэд буцааж байжээ.

Мөн дээрх зүйл, заалтын нотлох баримтыг үнэлэх үүргийг шүүх хангалтгүй гүйцэтгэснээс 2006 онд давж заалдах журмаар хянагдсан хэргийн 15 шийдвэр, 2007 онд давж заалдах журмаар хянагдсан хэргийн 30 шийдвэр тус тус хүчингүй болсон байна. Нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор шинжлэн судалж, хооронд нь харьцуулан үзсэний үндсэн дээр өөрийн дотоод итгэлээр үнэлдэг. Гэтэл нэг нотлох баримтыг нөгөөгөөс илүүд үзэх, огт үнэлэхгүй байх, хуулийн шаардлага хангаагүй нотлох баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгосон зэрэг алдаа нийтлэг гаргажээ.

Тухайлбал: бичмэл нотлох баримтын он, сар, өдөр засвартай, хуулбар хувийн бичвэр уншигдахгүй байхад нотариатаар гэрчлэгдсэн бол “хуулийн шаардлага хангагдсан” гэж өрөөсгөл ойлгож, ийм нотлох баримтыг үнэлж, шүүхийн шийдвэрийн үндэслэл болгож байгаа нь буруу юм.

Архив, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газар болон хариуцагч захиргааны байгууллага “хуулбар үнэн” гэсэн тэмдэг дарсан бичмэл нотлох баримтыг шүүх хуулийн шаардлага хангасан нотлох баримтад тооцож үнэлэх явдал нийтлэг байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2, 48 дугаар зүйлийн 48.2-т заасан “шүүх үзлэг явуулах” гэдгийг тухайн хэргийг хянан шийдвэрлэж байгаа “шүүгч буюу шүүх бүрэлдэхүүн үзлэг явуулах” гэж ойлгох бөгөөд шүүгчийн туслахын үйлдсэн үзлэгийн тэмдэглэл хуулийн шаардлага хангасан нотлох баримтад хамаарахгүй.

Захиргааны хэргийн шүүх бичмэл нотлох баримтын эх хувийг шаардан авахад бэрхшээлтэй байвал мөн зүйлд заасны дагуу хадгалагдаж байгаа газарт нь хөндлөнгийн хоёроос доошгүй гэрчийг байлцуулан хэргийн оролцогчдыг оролцуулан үзлэг хийж, тэмдэглэл үйлдэж, байлцсан, оролцсон хүмүүсээр гарын үсэг зуруулж баталгаажуулж байх шаардлагатай.

2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т “...Захиргааны байгууллагын зөвхөн гадагш чиглэсэн бусдаас дагаж, мөрдөх буюу заавал биелүүлэх захиргааны акт нь захиргааны хэргийн шүүхэд хамаарна”, 4.3-т “Шүүх, прокурорын байгууллага, түүнчлэн эрүүгийн хэрэг бүртгэх ...байгууллагын байцаан шийтгэх ...хуулийн дагуу явуулсан үйл ажиллагааны талаар иргэн, хуулийн этгээдээс шүүхэд гаргасан гомдлыг эрүүгийн болон иргэний шүүх шийдвэрлэнэ” гэж тус тус заасныг зөрчиж байна. Тухайлбал: Хэнтий аймгийн Захиргааны хэргийн шүүх /2007 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03 дугаар шийдвэр/ Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.1-д заасны дагуу нөхөн төлбөр гаргуулах тухай, Өвөрхангай аймгийн Захиргааны хэргийн шүүх /2007 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр шийдвэр/ Замын цагдаагийн тасгийн байцаагчийн зам тээврийн осол дээр тогтоосон актыг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэж, хэргийн харьяалал зөрчжээ.

Захиргааны хэргийн шүүхэд харьяалагдах маргааны хувьд хариуцагч нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан захиргааны байгууллага, албан тушаалтан байхаас гадна маргааны зүйл болох захиргааны акт нь мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т заасан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагаатай холбоогүй, хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 4 дүгээр зүйлийн 4.2-т заасан шаардлагыг хангасан захиргааны акт Захиргааны хэргийн шүүхийн хэргийн харьяалалд хамаарахыг анхаарвал зохино.

3. Нэхэмжлэлд заагаагүй этгээдийг шүүх өөрийн санаачлагаар хариуцагчаар татах, нэхэмжлэлийн дагуу хэрэг үүсгэсэн хариуцагчаас өөр этгээдэд нэхэмжлэлийг гардуулж тайлбар авч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах,

нэхэмжлэгчийг төлөөлөх эрхгүй этгээдийн нэхэмжлэлээр хэрэг үүсгэх зэрэг зөрчил илэрлээ.

Мөн нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан тохиолдолд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5-д заасан журмаар шүүгчийн захирамж гаргаж татгалзах ёстой байтал хэрэг үүсгэсний дараа итгэмжлэлийг нөхөн бүрдүүлсэн шүүхийн буруу практик байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Хариуцагч нь ямар этгээд болохыг нэхэмжлэгч өөрөө шийдвэрлэж нэхэмжлэлдээ тодорхойлон заадаг бөгөөд хариуцагчаар татагдсан этгээд нь тухайн хэргийн жинхэнэ хариуцагч биш болох нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тогтоогдвол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан үндэслэл, журмын дагуу хариуцагчийг солих ажиллагааг нэхэмжлэгчийн хүсэлт болон шүүх өөрийн санаачлагаар хийж болно. Үүсгэгдсэн хэрэгт хариуцагчаар татсан этгээдэд биш харин өөр этгээдэд нэхэмжлэл гардуулж тайлбар авч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж байгаа нь мөн хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчиж байгаа хэлбэр болно.

4.Захиргааны тухайн хэргийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн этгээдийг бие даасан шаардлагатайгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахгүйгээр Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийг зөрчсөний улмаас нэг бус шийдвэр хүчингүй болжээ.

Шүүх тухайн хэргийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээдийг гуравдагч этгээдээр оролцуулахгүйгээр хэргийг шийдвэрлэснээс тухайн этгээд нь хэргийн оролцогч биш болж, шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрх нь хязгаарлагдах ба зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо шүүхээр хамгаалуулах боломжгүйд хүрдэг тул шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн захиргааны хэргийн улмаас эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн этгээдийг бие даасан шаардлагатайгаар заавал оролцуулж, захиргааны хэргийг шийдвэрлэж байвал зохино.

5.Шүүхүүд гуравдагч этгээдийн гаргасан бие даасан шаардлагыг нэхэмжлэлийн шаардлага гэж ойлгож, түүний шаардлагыг тусгаарлан өөр хэрэг үүсгэн шийдвэрлэсэн зөрчил гаргажээ. Тухайлбал: Баян-Өлгий аймгийн Захиргааны хэргийн шүүхийн 2007 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 12 дугаар шийдвэр.

Нэхэмжлэлийн шаардлага болон тухайн хэргийн улмаас эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн гуравдагч этгээдийн гаргаж буй бие даасан шаардлага хоёр нь өөр зүйл бөгөөд гуравдагч этгээдийн шаардлагыг нэхэмжлэлийн шаардлагатай адилтган үзэхгүй тул хэргийг тусгаарлахгүйгээр гуравдагч этгээдийн бие даасан шаардлагыг тухайн хэрэгтэй хамт нэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар эцэслэн шийдвэрлэж байвал зохино.

6. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.7, 69 дүгээр зүйлийн 69.2, 74 дүгээр зүйлийн 74.2-т зааснаар шүүх хуралдааны явцад шинээр буюу нэмэлт нотлох баримт цуглуулах, гэрчийн мэдүүлэг авах, ирээгүй оролцогчийг шүүх хуралдаанд оролцуулах, нэхэмжлэгч, түүний төлөөлөгч, өмгөөлөгчийг шүүх хуралдаанд заавал байлцуулах шаардлагатай тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулах ёстой байхад шүүх хуралдаан хойшлуулах тухай хүсэлтийн шалтгааныг нотолсон баримтгүйгээр буюу үндэслэлгүй шалтгаан зааж, шүүх хуралдааныг удаа дараа хойшлуулж байгааг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн гэж үзнэ.

Тухайлбал: Нийслэлийн Захиргааны хэргийн шүүх 2007 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 58 дугаар шийдвэртэй Техник технологийн коллежийн нэхэмжлэлтэй хэргийн шүүх хуралдааныг 6 удаа, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн 2007 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн захирамжтай “Хүдэр Эрдэнэ” ХХК-ийн нэхэмжлэлтэй хэргийн шүүх хуралдааныг 16 удаа хойшлуулж захирамж гаргасан байна.

Хэргийн оролцогчид шүүх хуралдаанд хүрэлцэн ирж оролцох боломжтой хугацааны өмнө шүүх хуралдааны товыг тогтоож, хэргийн оролцогчид мэдэгдэх, хэргийн оролцогчийн шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг /Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2, 20 дугаар зүйлийн 20.2.2, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйл/ хангах, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.7, 69 дүгээр зүйлийн 69.2, 74 дүгээр зүйлийн 74.2-т зааснаас өөр “үндэслэлгүй” шалтгаанаар шүүх хуралдааныг хойшлуулахгүй байх, хэргийн оролцогчдыг чирэгдүүлэхгүйгээр хэргийг хуулийн хугацаанд шийдвэрлэж байвал зохино.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗӨВЛӨМЖ

2007 оны 7 дугаар сарын 05 өдөр
хот

Улаанбаатар

Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай
холбоотой маргааныг хянан шийдвэрлэх талаар

Захиргааны хэргийн шүүх байгуулагдаж, үйл ажиллагаа явуулсан 2004 оны 6 дугаар сараас хойш анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхээр Төрийн албаны тухай хуулийг баримтлан шийдвэрлэгдсэн захиргааны хэргүүдтэй танилцаж, шүүхийн пактикийг судлаж үзлээ.

Аймаг, нийслэлийн Захиргааны хэргийн шүүхүүд төрийн жинхэнэ, улс төрийн үйлчилгээний албан хаагчийг төрийн албанаас үндэслэлгүйгээр огцруулсан, халсан,

чөлөөлсөн, өөр ажилд шилжүүлсэн, сахилгын шийтгэлийг хууль бусаар ногдуулсан, сонгон шалгаруулалтыг буруу явуулсан тухай маргаантай 148 хэргийг Төрийн албаны тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг баримтлан шийдвэрлэжээ. Энэ нь захиргааны хэргийн шүүхийн нийт шийдвэлэсэн хэргийн 13.6 хувийг эзэлж байгаа бөгөөд төрийн албан хаагчийн эрх зүйн байдалтай холбоотой маргаан цаашид ч нэмэгдэх төлөвтэй байна.

Судалгаанаас үзэхэд шүүхийн харьяалмын бус хэргийг хянан шийдвэрлэх, шүүх нотлох үүргээ бүрэн биелүүлэхгүй байх, хуулийг оновчтой зөв тайлбарлаж хэрэглээгүй, хэрэгт авагдсан нотлох баримтыг буруу үнэлсэн зэрэг шалтгаанаас шүүхийн шийдвэр өөрчлөгдөж, хүчингүй болжээ.

Иймд төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой маргааны хянан шийдвэрлэхдээ дараах зүйлийг анхаарах нь зүйлтэй гэж үзэж Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.4-т заасныг үндэлэн ЗӨВЛӨМЖЛӨХ нь:

1. Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой маргааныг захиргааны хэргийн болон ерөнхий харьяаллыг зөв тогтоох нь чухал юм.

Үүний тулд ажил олгогч, /Төрийн болон захиргааны байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар/ ажилтан хоёрын хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээ¹⁴² байгаа эсэхийг тогтоох хэрэгтэй. Нэг талаас ажил олгогч нөгөө талаас ажилтны хооронд хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн гэрээний харилцаатай холбоотой маргааныг ерөнхий харьяаллын шүүх хянан шийдвэрлэнэ.

Хөдөлмөрийн гэрээгүй сонгууль томилолт эрх олгосноор ажиллаж байгаа төрийн жинхэнэ болон улс төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой маргааныг захиргааны хэргийн шүүх шийдвэрлэж байх нь зүйтэй. Гэхдээ төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 11.6-д төрийн албан хаагчийн ангилалаас хамаарч тэдний эрх зүйн байдлыг зохицуулах хууль, тогтоомжийг ялгамжтайгаар заасныг анхаарч, хэрэглэх хуулиа оновчтой сонгох шаардлагатай юм.

Түүнчлэн төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон төрийн албан тушаалийн ангилал, төрлийг тогтоосон Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолууд, “Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” Улсын Дээд шүүхийн 2006 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 33 дугаар тогтоол, “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” Улсын Дээд шүүхийн 2006 оны 7 дугаар сарын 03-ны

¹⁴² Улсын Дээд шүүхийн 2006 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 33 дугаар тогтоолын 5.1-д “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой /хөрөнгийн 51 буюу түүнээс дээш хувьтай/ хуулийн этгээд болон түүний ерөнхий менежерийн хооронд байгуулсан үр дүнгийн гэрээг контрактын нэгэн адил үзнэ” гэж заажээ.

өдрийн 37 дугаар тогтоолуудыг сайтар судалж, шүүхийн харьяаллыг зөв тогтоож байвал зохино.

2. Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөл нь урьдчилан шийдвэрлүүлэх журмаар төрийн албан хаагчийн маргааныг хянан шийдвэрлэснийхээ төлөө шүүхэд хариуцагч болохгүй. Гэтэл шүүх түүнийг хамтран хариуцагчаар өөрөө санаачлагаараа татаж байгаа буруу жишгийг таслан зогсоох шаардлагатай.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д зааснаар төрийн албаны зөвлөл өөрөө бие даан гаргасан анхны шийдвэр болон төрийн албан хаагчдын эрх зүйн байдалтай холбоотой асуудлаар нийтээр дагаж мөрдөх заавар, журам гаргасныхаа төлөө Захиргааны хэргийн шүүхэд шууд хариуцагч байж болно.

3. Захиргааны эрх зүйн харилцаанд орж байгаа нэхэмжлэгч, хариуцагчийг заавал “төрийн жинхэнэ албан хаагч” буюу төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагч байна гэж хязгаарлаж болохгүй. Үүнд: Төрийн улс төрийн албан хаагч мөн адил хамаарна.

4. Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлд албан тушаалаас нь чөлөөлөх, түр чөлөөлөх, захиргааны санаачлагаар албан тушаалаас нь бууруулах, 24 дүгээр зүйлд төрийн албанаас чөлөөлөгдөх, 25 дугаар зүйлд төрийн жинхэнэ албанаас халах, 26 дугаар зүйлд сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл, журмыг тодорхой заажээ.

А/ Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1-д заасан үндэслэлээр захиргааны санаачлагаар төрийн албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсантай холбоотой маргааныг хянан шийдвэрлэхэд:

-тухайн албан тушаалтны албан тушаал, ажлын байрны тодорхойлолт байгаа эсэх, түүнд талуудын эрх, үүргийг хэрхэн тодорхойлсныг;

-уг ажлын байрны тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хангалтгүй биелүүлсэн гэдэг нь ямар баримтаар хэрхэн тогтоогдож байгааг, төрийн албанд баримтлах зарчмыг хэрэгжүүлээгүй, тогтоосон горим, журмыг зөрчсөн байх тохиолдлын шинж байдлыг харгалзан нотлож тогтоосон байх хэрэгтэй.

Мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2-т заасан үндэслэлээр арга хэмжээ авах гол шалгуур нь эрх бүхий этгээдээс авсан мэргэшлийн шалгалтын дүн, Төрийн албаны зөвлөлийн 2003 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээг дүгнэх журам”-ын дагууд хийсэн үнэлгээгээр албан тушаал эрхлэх шаардлага хангахгүй байгаа нь нотлогдсон байх ёстой.

Б/ Хуулийн 24 дүгээр зүйлд заасан төрийн албанаас чөлөөлөгдсөн тухай маргаантай хэргийг хянан шийдвэрлэхэд гол нь тэтгэвэрт гарах насыг зөв тогтоох явдал

юм. Үүний тулд иргэний үнэмлэх түүнтэй адилтгах баримтыг¹⁴³ эсхүл архивын лавлагааг хэрэгт заавал хавсаргасан байх шаардлагатай.

Мөн зүйлийн 24.2-т зааснаар Төрийн албан хаагч нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц төрийн албанаас чөлөөлөгдөх тухай хүсэлтэй гаргасан эсэх, түүнийг захиргааны байгууллага, албан тушаалтан хэрхэн шийдвэрлэсэн, хариу өгсөн эсэхийг шүүх нотолсон байвал зохино.

Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн боловч төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэл ажиллах талаар хүсэлтээ албан ёсоор гаргаагүй нь захиргааны санаачлагаар ажлаас чөлөөлөх үндэслэл болно.

Төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлтийг бусдын шахалт шаардлагаар¹⁴⁴ бус зөвхөн тухайн этгээд өөрийн санаачилгаар, бичгээр гаргасан байна.

Бичгээр гаргасан хүсэлтийг Захиргааны байгууллага хүлээн авч үргэлжлүүлэн ажиллуулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Хэрэв Захиргааны байгууллагын шийдвэрийг зөвшөөрөхгүй гомдол, нэхэмжлэл гаргасан тохиолдолд уг асуудлыг Захиргааны хэргийн шүүх хянан хэлэлцэнэ.

В/ Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан төрийн албан хаагч удаа дараа /2 ба түүнээс дээш/ албан үүргээ хангалтгүй биелүүлсэн гэдгийг “Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” Улсын Дээд шүүхийн 2006 оны 7 дугаар сарын 03-ын өдрийн 33 дугаар тогтоолын 15 дугаар зүйлийн 15.4, 15.4.13-д заасны дагуу ойлгож хэрэгжүүлнэ.

Төрийн улс төрийн болон үйлчилгээний албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлээр хориглосон үйлдэл, үйл ажиллагаа хамаарахгүй. Харин материаллаг хуульд зарим албан тушаал, түүнд хориглох үйл ажиллагааг нарийвчлан заасан эсэхийг анхаарах нь зүйтэй.

Мөн хуулийн 26 дугаар зүйлийн “албан үүргээ биелүүлээгүй” гэдэгт төрийн албан хаагч албаны үүргийнхээ заримыг болон бүгдийг гүйцэтгээгүй, хангалтгүй биелүүлсэн аль алийг нь хамааруулна.

¹⁴³ Улсын Дээд шүүхийн 2000 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 196 дугаар тогтоолын 1-д “Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн хуулийн 34 дүгээр зүйлийн 3 дахь заалтын “... иргэний паспорт, түүнтэй адилтгах баримт” гэдэгт Иргэний паспорт /БНМАУ-ын/, түүнтэй адил хүчинтэй Монгол Улсын иргэний үнэмлэх болон Монгол Улсын иргэний үнэмлэх олгох хүртэл хүчинтэй түр баримт /энэ баримт нь төрсний гэрчилгээний хамт хүчинтэй/, мөн цэргийн албан хаагчийн хувийн үнэмлэх зэрэг баримт бичгийг хамааруулан ойлгоно” гэж заажээ.

¹⁴⁴ Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 33 дугаар тогтоолын 14-д “Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай тогтоолд Хөдөлмөрийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасан “хөдөлмөрийн гэрээг цуцлах ажилтны өргөдөл” гэдэгт ажил олгогчийн шахалт шаардлага, зүй бус нөлөөлөл зэрэг хөндлөнгийн оролцоогүйгээр хугацаатай ба хугацаагүй хөдөлмөрийн гэрээг цуцлах тухай ажилтнаас зөвхөн өөрийн хүсэл зоригийн дагуу, сайн дурын үндсэн дээр гарагсан бичгийн хүсэлтийг хэлнэ” гэж заажээ.

“Албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн” гэдэгт тухайн албан тушаалтны албан тушаал, ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй үйл ажиллагаа гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтоор хориглосон /Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн заалт үүнд хамаарагдахгүй/ үйл ажиллагаа явуулсан, эрх, албан тушаалаа ашиглан хууль бус үйлдэл хийсэн зэргээр албаны болон бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн байхаар ойлгох нь зүйтэй.

Хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн гэдгийг нотлох баримтаар хөдөлбөргүй тогтоогдсон байхын дээр Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-т заасан хугацаа, журмыг хатуу баримтлах хэрэгтэй.

5. Төрийн албан хаагчийн эрх зүйн байдалтай холбоотой гомдлыг шүүхэд гаргах хугацаа, журмыг анхаарах нь чухал. Үүнийг Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.8, 39 дүгээр зүйлүүдэд өөр өөрөөр зохицуулсан.

Тухайлбал мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.8-д “... сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг “мэдсэн”-ээс хойш 1 сарын дотор дээд шатны байгууллага, эсхүл шүүхэд гомлоо гаргаж байхаар”, хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-т “... ажлаас үндэслэлгүйгээр халагдсан гэж үзвэл гомдлоо төрийн албаны салбар зөвлөл болон төрийн албаны төв байгууллагад 1 сарын дотор, уг шийдвэрийг зөвшөөрөхгүй бол шүүхэд 15 хоногийн дотор тус тус гаргана” гэж заажээ.

Иймд Төрийн жинхэнэ албан хаагч Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд зааснаар сахилгын шийтгэл ногдуулсан тохиолдолд мөн зүйлийн 26.8-д заасан хугацаа, журмаар, харин хуулийн 24, 25 дугаар зүйлд заасан үндэслэлээр ажлаас чөлөөлөгдсөн эсхүл халагдсан тохиолдолд хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-т заасан хугацаа, журмыг баримтласан эсэхийг анхаарах нь зүйтэй.

Хөдөлмөрийн тухай хуулиар шийдвэрийг “хүлээн авсан”-аар гомдол гаргах эрх үүсдэг бол төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг “мэдсэн” өдрөөс хойш 1 сарын дотор холбогдох этгээдэд гомдлоо гаргах эрхтэй.

“Мэдсэн” гэдгийг шийдвэрийг зохих албан тушаалтанд танилцуулсан буюу нэг хувийг нь өгсөн, ингэж албан ёсоор түүнд хандаагүй ч арга хэмжээ авагдсан гэдгээ уг албан хаагч бусдаас сонсох, өөр бусад байдлаар ч мэдсэн байж болно. Энэ талаар маргаан гарвал гарсан шийдвэрийг мэдсэн хугацааг шүүх нотлох үүргийнхээ дагуу шалгаж тогтоох боломжтой юм.

Харин дээрх хугацаа, журмыг өөр хуулиар тусгайлан заасан бол тухайн хуульд заасан хугацаа, журмыг баримтлана.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗӨВЛӨМЖ

2008 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр
хот

Улаанбаатар

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн зарим зүйл, заалтыг шүүхийн практикт зөв хэрэглэх тухай

Захиргааны хэргийн анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхээр 2004-2007 онд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг хэрэглэж шийдвэрлэсэн захиргааны хэргүүдтэй танилцаж, шүүхийн практикийг судалж үзлээ.

Анхан шатны шүүхүүд Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар 2004 онд 2, 2005 онд 9, 2006 онд 12, 2007 онд 24, нийт 47 захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн байна.

Энэ нь нийт шүүхүүдийн шийдвэрлэсэн захиргааны хэргийн 3%-ийг эзэлж байгаа хэдий ч жилээс жилд 1.5-2 дахин өсчээ.

Судалгаанаас үзэхэд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг шүүхүүд үндсэнд нь зөв тайлбарлан хэрэглэж байгаа боловч улсын байцаагчийн акт, дүгнэлтийг үндэслэлгүйгээр хүчингүй болгох, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгох явдал нилээд гарч байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг /цаашид “хуулийн” гэх/ хэрэглэх талаар дараах зүйлийг анхаарах нь зүйтэй гэж үзэж, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.4-т заасныг үндэслэн зөвлөх нь:

1. Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь шалгасан асуудлаар тухайн этгээдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдлын шалтгааныг тогтоон, түүнийг арилгах арга хэмжээг авахуулж, шаардлагатай бол зохих хариуцлага хүлээлгэх тухай асуудлыг энэ хууль болон бусад

хууль тогтоомжид заасны дагуу өөрсдийн эрх хэмжээний хүрээнд дүгнэлт бичих, акт, албан шаардлага гаргах зэргээр шийдвэрлэх эрхтэй байна.

Улсын байцаагчдын бичсэн дүгнэлт, албан шаардлага, актын талаарх маргааныг шүүхүүд хянан шийдвэрлэхдээ хяналт шалгалт хийсэн байгууллага, албан тушаалтнууд хуулийн 5 дугаар зүйлд заасан хяналт шалгалт хийх нийтлэг үндэслэл, журмыг хэрхэн хангасныг голлон анхаарах нь зүйтэй.

2. Хяналт шалгалтын дүнгийн тухай танилцуулаагүй гэх буюу шалгуулсан этгээд хяналт шалгалтын баримт бичигт /акт, дүгнэлт, албан шаардлага, торгуулийн хуудас, шийтгэвэр г.м/ заасан зүйлийг зөвшөөрөөгүй, гарын үсэг зураагүй, учрыг нь сайн ойлголгүй гарын үсэг зурсан гэсэн гомдол, тайлбар гаргах явдал ихээхэн ажиглагдаж байна.

Хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасан хяналт шалгалтын дүнгийн тухай танилцуулга гэдэг нь хяналт шалгалтын үйл явц, хамрагдсан хүрээ, цаг хугацаа, үр дүн, өгсөн заавар, зөвлөгөө, авсан арга хэмжээ, цаашид авах арга хэмжээний тухай тусгасан шалгалтын баримт бичиг юм.

Эдгээрийг хяналт шалгалтад хамрагдсан байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдэд заавал албан ёсоор танилцуулж, гарын үсэг зуруулсан байхаар хуулийн дээрх заалтад зохицуулжээ.

Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага стандартыг Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т заасныг үндэслэн, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдын 2007 оны 23 дугаар тушаалаар баталж, 2007 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсөн бөгөөд Мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагч нар үйл ажиллагаандаа энэхүү стандартыг баримталж ажиллах үүрэгтэйг анхаарвал зохино.

Дээрх стандартад зааснаар “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр буюу бүрмөсөн, эсхүл хэсэгчлэн буюу бүхэлд нь зогсоох, тэдний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг улсын орлогод оруулах, хураан авах, нөхөн төлбөр ногдуулах, улсын хилээр нэвтэрсэн бараа бүтээгдэхүүнийг холбогдох хууль тогтоомжийн дагуу саатуулах, буцаах, мөн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх, шаардлагатай зүйлийг ариутгах, хоргүйжүүлж цэвэршүүлэх, тухайн барилга байгууламж, машин тоног төхөөрөмжийн ашиглалтыг зогсоох, бараа бүтээгдэхүүнийг худалдах, борлуулахыг хориглох, устгахад болон актын үйлчлэлийг дуусгавар болгоход чиглэгдсэн баримт бичгийг “улсын байцаагчийн акт” гэж тодорхойлжээ.

Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, түүний шалтгаан нөхцөлийг арилгуулахаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтнаас шаардаж, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах зорилгоор улсын байцаагч “албан шаардлага” үйлдэнэ.

Улсын байцаагч нь бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийн бодит байдлыг тодорхойлоход “дүгнэлт” гаргана.

Мөн зөрчлийн байдал, учруулсан хохирол, хураан авсан эд зүйлийн тоо хэмжээ, нэр төрөл, үнэ болон зөрчигдсэн хууль тогтоомжийн талаар дэлгэрэнгүй дэс дарааллын дагуу тодорхойлон “тэмдэглэл” үйлддэг байна.

Тэмдэглэлийг шалгалтын явцад амаар гаргасан гомдол, хүсэлт, шаардлагыг хүлээн авах, зөрчил гаргасан этгээдийг асуух, үзлэг, шинжилгээ хийх, эд зүйл хураан авах, торгууль, шийтгэвэр ногдуулахад бичнэ.

Хяналт шалгалтын баримт бичиг нь Улсын байцаагчийн гарын үсэг зурж, тэмдэг дарж, нэгдсэн дугаар авснаар хүчин төгөлдөр болох бөгөөд улсын байцаагчийн акт, албан шаардлага, дүгнэлт, торгууль, шийтгэвэр нь хэвлэмэл хуудсан дээр үйлдэгдсэн албан хэрэг хөтлөлтийн журам, зааварт нийцэж, бичиг хэргийн стандартын шаардлага хангасан байх учиртай.

Хяналт шалгалтын дүнг зөвшөөрөхгүй байгаа буюу хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан гомдлоо хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу тухайн хяналт шалгалт хийсэн буюу акт, дүгнэлт гаргасан, албан шаардлага бичсэн албан тушаалтны дээд шатны эрх баригчид гаргана.

Эрх баригч нь тухайн гомдлыг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6-11 дүгээр зүйлд заасны дагуу хүлээн авч хянан шийдвэрлэнэ. Хяналт шалгалтын байгууллагаас гаргасан шийдвэрийг гомдол гаргагч эс зөвшөөрсөн, эрх баригч гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлээгүй, эсхүл түүний гаргасан шийдвэрийг холбогдох албан тушаалтан биелүүлээгүй бол шалгуулсан иргэн, хуулийн этгээд Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

3. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд гомдол гаргах хугацааг тодорхой заагаагүй учраас Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан 30 хоногийн хугацааг баримтлах нь зүйтэй.

4. Судалгаанаас үзэхэд хяналт шалгалт хийсэн байгууллага, албан тушаалтны акт, дүгнэлтийг албан ёсоор хүлээж аваагүй, танилцуулаагүй гэх буюу зөвшөөрөөгүй учраас гарын үсгээ зураагүй, шалгалтад хамрагдсан байгууллага, албан тушаалтныг төлөөлөх эрхгүй хүмүүс гарын үсэг зурсан гэсэн гомдол нилээд гарч байна.

Хуулийн 5 дугаар зүйлийн 5.8-д “Хяналт шалгалтын дүнг шалгуулсан этгээдэд танилцуулж, холбогдох баримт бичигт гарын үсэг зуруулна. Хэрэв шалгуулсан этгээд хяналт, шалгалтын баримт бичигт заасан зүйлийг зөвшөөрөөгүй буюу гарын үсэг зурахаас татгалзсан бол энэ тухай тайлбараа бичиж гарын үсэг зурна” гэж заасан бөгөөд хуулийн дээрх шаардлагыг албан ёсоор тайлбарлан өгч ойлгуулах, энэ тухай тэмдэглэл хөтөлж, шалгалтын баримт бичигт хавсаргах зэргээр шалгалтын байгууллага, албан тушаалтнууд өөрсдийн гаргасан шийдвэрийг аль болохоор баримтжуулах үүрэгтэй.

Энэхүү үүргээ биелүүлсэн эсэх, акт, дүгнэлт зэрэг шалгалтын баримт бичгүүд нь хуульд заасан шаардлагыг хангаж чадсан эсэхийг үзлэг хийж, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2-т зааснаар тодруулах, шаардлагатай гэж үзвэл Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлд зааснаар /шинжээч томилж/ дүгнэлт гаргуулах зэргээр тодорхой ажиллагаа хийсний эцэст хэргийг хянан шийдвэрлэх нь ач холбогдолтой юм.

5. Шүүхүүд улсын байцаагчийн акт, дүгнэлттэй холбогдсон маргааныг хянан шийдвэрлэхдээ тухайн харилцааг зохицуулсан материаллаг хуулийг баримтлахаас гадна Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн зохих зүйл, хэсгийг хамт хэрэглэж байх нь зүйтэй.

Жишээ нь: Иргэн "Б"-гийн нэхэмжлэлтэй аймгийн Мэргэжлийн хяналтын газрын мал эмнэлгийн улсын байцаагч "Д"-д холбогдох Улсын байцаагчийн .. дугаар актыг хүчингүй болгуулах тухай захиргааны хэргийг аймгийн Захиргааны хэргийн шүүх шийдвэрлэхдээ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.11.8, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 7 дугаар зүйлийн 7.2, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.7 дахь хэсгийн заалтуудыг баримтлан хэргийг шийдвэрлэсэн нь зөв байна.

6. Хуулийн 10 дугаар зүйлд заасан мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн нийтлэг бүрэн эрх, үүргийг хэрхэн хангаж биелүүлснийг сайтар анхаарч, тэдний гаргасан захиргааны акт хуульд нийцсэн эсэхийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шалган, шийдвэрлэж байвал зохино.

Улсын байцаагчийн гаргасан акт, дүгнэлт нь хуулийн шаардлага хангаагүйгээс байгууллага, албан тушаалтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн тохиолдолд тэдгээрийг хүчингүй болгохдоо хэргийн оролцогчдын эрхийг сэргээж, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.4-д зааснаар учирсан хохирлын талаар маргаан гараагүй бол хохирол нөхөн төлүүлэх асуудлыг хамт шийдвэрлэх нь зүйтэй.

Тухайлбал: Аймгийн Захиргааны хэргийн шүүх "Б"-гийн нэхэмжлэлтэй аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн загас хураах тухай .. дугаар актуудыг хүчингүй болгуулж, хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэл бүхий захиргааны хэргийг хянан хэлэлцээд Ан агнуурын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасныг үндэслэн улсын байцаагчийн актуудыг хүчингүй болгож, 1.6 сая төгрөгийг нэхэмжлэгчид буцаан олгосон нь үндэслэлтэй боловч Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн холбогдох заалтыг хэрэглээгүй нь буруу болжээ.

7. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.11-д "...хэрэв улсын байцаагчийн албан шаардлагыг хүлээж авахаас татгалзсан буюу тогтоосон хугацаанд хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй бол буруутай албан тушаалтанд энэ хуульд заасны дагуу захиргааны шийтгэл ногдуулах, эсхүл уг асуудлыг шүүхэд тавьж шийдвэрлүүлэхээр" заажээ.

Энэ нь хяналт шалгалтын байгууллага, албан тушаалтнаас хэрэгжүүлэх үйл ажиллагаа бөгөөд улсын байцаагчийн тавьсан акт, дүгнэлт, албан шаардлагыг биелүүлээгүй бол уг асуудлыг хяналт шалгалтын байгууллага, албан тушаалтны гаргасан нэхэмжлэлээр ерөнхий харьяаллын шүүх хянан шийдвэрлэх юм. Харин улсын байцаагчийн гаргасан акт, дүгнэлтийг хууль бус гэж үзэж маргаан үүсгэсэн тохиолдолд Захиргааны хэргийн шүүхүүд шийдвэрлэнэ.

8. Хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Төрийн хяналт шалгалтын тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд захиргааны шийтгэл ногдуулсан Улсын ерөнхий, ахлах болон улсын байцаагчийн торгуулийн хуудас, шийтгэвэр зэргийг зөрчил гаргасан этгээд эс зөвшөөрвөл энэ хуульд тусгайлан заагаагүй учир Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6-11 дүгээр зүйлд заасны дагуу дээд шатных нь байгууллага, албан тушаалтанд гомдлоо гаргаж урьдчилан шийдвэрлүүлсний дараа Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэлээ гаргаж, зөрчигдсэн эрхээ хамгаалуулах боломжтой юм.

Энэ тохиолдолд Захиргааны хэргийн шүүхүүд хуульд заасны дагуу хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗӨВЛӨМЖ

2008 оны 7 дугаар сарын 03-ны өдөр
хот

Улаанбаатар

Анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхээс сүүлийн 3 жилд Ашигт малтмалын тухай хуулийг хэрэглэж хянан шийдвэрлэсэн хэргүүдийн талаар шүүхийн практикийг судалж үзлээ.

Аймаг, нийслэлийн Захиргааны хэргийн шүүхүүдийн хянан шийдвэрлэсэн нийт хэргийн 6.9 хувь нь Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын Кадастрын бүртгэлийн төвөөс ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл олгох, түүнийг цуцлах, дуусгавар болох үйл ажиллагаатай холбогдсон харилцаанаас үүссэн маргаан бөгөөд эдгээр хэргийн 65.9 хувь нь давж заалдах, 27.8 хувь нь хяналтын шатны шүүхээр хянагджээ.

Анхан шатны шүүхээр 2005 онд хянан шийдвэрлэсэн нийт хэргийн 7.3 хувь, 2006 онд 7.5 хувь, 2007 онд 8.4 хувь нь дээрх маргаантай холбоотой байгаагаас үзэхэд энэ төрлийн маргаан өсөх хандлагатай байна.

Цаашид энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэхэд шүүхийн практикт гарч байгаа алдаа, зөрчлийг арилгах, хуулийн зохицуулалтыг нэг мөр зөв ойлгох, хэрэглэх явдлыг хангах зорилгоор Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.4 дэх заалтыг үндэслэн Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимаас нийт шүүхүүдэд ЗӨВЛӨХ нь:

Нэг. Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1, 2 дугаар зүйлд зааснаар лиценз эзэмшигч иргэд нь компани, нөхөрлөл байгуулж 2007 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр хүртэлх хугацаанд, аж ахуйн нэгж 2007 оны 2 дугаар сарын 26-ны өдөр хүртэлх хугацаанд Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын

Кадастрын бүртгэлийн төвд тусгай зөвшөөрлөө шинэчлэн бүртгүүлсэн байх ёстой бөгөөд энэ хугацаанд бүртгүүлээгүй аж ахуйн нэгж болон иргэд тусгай зөвшөөрөл эзэмших эрхтэй этгээдэд лицензээ шилжүүлээгүй бол цуцлагдсанд тооцогдох болно.

Мөн хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар цуцлагдсанд тооцогдсон талбайд, эрх бүхий захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр гарснаас үл хамааран Ашигт малтмалын тухай /цаашид хуулийн гэх/ хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т зааснаар эрх олгогдсон байгууллагаас баталсан журмыг баримтлан сонгон шалгаруулалт явуулна.

Харин лиценз эзэмшигч дээрх хугацааг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтрүүлсэн гэж үзвэл төрийн захиргааны төв байгууллагад гомдол гаргаж болно.

Хоёр. Хуулийн 12 дугаар зүйлд заасан үүргийнхээ дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн гаргасан шийдвэрийг аж ахуйн нэгж, захиргааны байгууллага, албан тушаалтан биелүүлэхгүй байх тохиолдлууд гарч байна. Иймд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж байна гэсэн үндэслэлээр Засаг дарга нар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдээс шүүхэд гаргасан нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүх харъяалан шийдвэрлэх нь зүйтэй.

Гурав. Талбайн давхцыг хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, 17.2.3-т “ямар нэг байдлаар давхцаагүй”, 19 дүгээр зүйлийн 19.2.2-т “давхцаагүй”, 19.2.3-т “бүхэлдээ буюу хэсэгчлэн давхцсан”, 23 дугаар зүйлийн 23.4.3-т “талбайн аль нэг хэсэгт давхцсан” гэж өөр өөрөөр томъёолон заажээ. Ийнхүү талбайн давхцын талаар ялгамжтай заасан нь тус бүрдээ өөр өөр үр дагавар бий болгох тул тухайн зүйл, хэсгийн утга агуулгатай нь сайтар харьцуулан үзэж, дүгнэлт хийх хэрэгтэй.

Дөрөв. Хуулийн олон зүйл, хэсэгт Кадастрын бүртгэлийн төвөөс холбогдох этгээдэд мэдээлэл өгөх аргыг заажээ. Тухайлбал:

Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1, 19.2.3, 19.2.4, 19.3, 19.7, 20 дугаар зүйлийн 20.2, 22 дугаар зүйлийн 22.4, 26 дугаар зүйлийн 26.3.1, 26.3.4, 26.4, 45 дугаар зүйлийн 45.1, 62 дугаар зүйлийн 62.2-д заасан “бичгээр мэдэгдэх” гэдгийг Кадастрын бүртгэлийн төвийн эрх бүхий этгээд гарын үзэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан албан бичгийг хүлээн авагч талд гардуулсан эсхүл хүргүүлснийг;

Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6, 26 дугаар зүйлийн 26.3, 28 дугаар зүйлийн 28.2, 30 дугаар зүйлийн 30.2, 39 дүгээр зүйлийн 39.5, 51 дүгээр зүйлийн 51.7, 51.8, 56 дугаар зүйлийн 56.2, 56.4, 62 дугаар зүйлийн 62.6-д заасан “мэдэгдэнэ” гэдгийг Кадастрын бүртгэлийн төвийн даргын шийдвэр эсхүл түүний утгыг илэрхийлсэн мэдээллийг сонирхогч этгээдэд биечлэн гардуулах, эсхүл баталгаат шуудангаар хүргүүлэх, утас, факс, e-майл, цахилгаан зэргээр мэдээлж, түүнийгээ баталгаажуулсан байхыг;

Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10, 22 дугаар зүйлийн 22.3, 26 дугаар зүйлийн 26.7, 28 дугаар зүйлийн 28.3, 49 дүгээр зүйлийн 49.11, 50 дугаар зүйлийн 50.6, 51 дүгээр зүйлийн 51.1, 51.8, 54 дүгээр зүйлийн 54.5, 55 дугаар зүйлийн 55.6, 56 дугаар зүйлийн 56.2, 56.7-д заасан “сонинд нийтлэнэ” гэдгийг Кадастрын бүртгэлийн төв өөрийн гаргасан шийдвэрийн талаар нийтэд мэдээлэхээр хуульчилсан болон зайлшгүй нийтэд сонордуулах шаардлагатай гэж үзсэн мэдээллийг өдөр тутмын сонинд хэвлүүлэхийг;

Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1, 26 дугаар зүйлийн 26.1.1-д заасан “тодорхойлолтыг өргөдөл гаргасан этгээдэд өгнө” гэдгийг Хуульд заасан мэдээллийг ойлгомжтой бичиж, сонирхогч этгээдэд гардуулан өгснийг тус тус ойлговол зохино.

Тав. Хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 28 дугаар зүйлийн 28.1-д заасан хугацаанд тусгай зөвшөөрлийг сунгуулах хүсэлтээ хүндэтгэн үзэх шалтгааны улмаас төрийн захиргааны төв байгууллагад гаргаагүй талаарх маргаан их гарч байна. Энэ талаар хуулиар тусгайлан зохицуулаагүй тул шүүх уг маргааныг хянан шийдвэрлэхдээ тухайн тохиолдол нь хүндэтгэн үзэх шалтгаан мөн эсэх, хуулийн 51 дүгээр зүйлийн 51.7, 56 дугаар зүйлийн 56.2-т зааснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч болон барьцаалагчид тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч байгаа талаар Кадастрын бүртгэлийн төв урьдчилан мэдэгдсэн эсэх зэргийг заавал шалгаж тогтоох шаардлагатай.

Зургаа. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмших сонирхол бүхий этгээд албан бус мэдээлэл олж аваад тусгай зөвшөөрөл дуусгавар болсон, цуцлагдсан, нөөцөд авсан талбай чөлөөлөгдсөн тухай албан ёсны шийдвэр гараагүй байхад тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг Кадастрын бүртгэлийн төвд өгдөг байна.

Кадастрын бүртгэлийн төвөөс мэдээллийн сан, зураг зүйн бүртгэлд авч, компьютерт оруулан, тухайн талбай чөлөөлөгдсөн талаар албан ёсоор нийтэд зарласан үеэс тусгай зөвшөөрөл эзэмшихийг хүсч, төрийн захиргааны төв байгууллагад өргөдөл гаргах эрхтэй болохыг анхаарвал зохино.

Долоо. Хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.2-т зааснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөөгүй бол тусгай зөвшөөрлийг цуцлах нэг үндэслэл болдог. Тусгай зөвшөөрлийг дээрх үндэслэлээр цуцалсан талаарх маргаантай хэргийг шүүх хянан шийдвэрлэхдээ төрийн захиргааны төв байгууллага хуулийн 56 дугаар зүйлийн 56.2, 56.3, 56.4, 56.5-д заасан журмыг хангаж ажилласан эсэхийг тухайлбал тусгай зөвшөөрөл эзэмшигчийн лицензээ хүчинтэй байлгах хуулиар олгогдсон эрхийг хангасан эсэхийг сайтар шалгаж, нягтлан үзэх нь зүйтэй.

Найм. Хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 26 дугаар зүйлийн 26.9-д зааснаар сонгон шалгаруулалт явуулахгүйгээр тусгай зөвшөөрөл олгож байгаа талаарх маргаан нэлээд гарч байна. Энэ төрлийн маргаантай хэргийг хянан шийдвэрлэхдээ шүүх тухайн нэхэмжлэл гаргасан этгээдийн өөрийнх нь эрх зөрчигдсөн эсэх, нэхэмжлэл гаргах эрх үүссэн зэргийг анхаарах шаардлагатай.

Ес. Хуулийн 64 дүгээр зүйлд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан захиргааны байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүхэд гомдол гаргаж болохоор тусгайлан заажээ.

Гэтэл шүүхүүд энэ талаарх нэхэмжлэлийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.3-т заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж байгаа нь буруу тул ийм төрлийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байвал зохино.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗӨВЛӨМЖ

2008 оны 7 дугаар сарын 7-ны өдөр
хот

Улаанбаатар

Тендерийн харилцаатай холбогдсон захиргааны актын талаарх хэрэг маргаан өсөх хандлагатай буйг харгалзан энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэхэд холбогдох хуулийн заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.4-т заасныг үндэслэн Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимаас нийт шүүхүүдэд ЗӨВЛӨХ НЬ:

Нэг. Улсын Их Хурлаас 2005 онд баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар нэг удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Маргааныг хянан шийдвэрлэхдээ тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийг дагаж мөрдөх хугацаа болон хуульд зааснаас бусад тохиолдолд шинээр мөрдсөн хуулийг буцаан хэрэглэхгүй байхад анхаарч ажиллах нь зүйтэй.

Хоёр. Хуулийн үйлчлэх хүрээг зөв тодорхойлж хэрэглэх шаардлагатай гэж үзнэ. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т "Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг Монгол улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг дагаж мөрдөнө", Улсын Их Хурлаас 2003 онд батлагдсан Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Төсөл боловсруулах, түүний гүйцэтгэгийг сонгох үйл ажиллагааг явуулахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний

гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль, хэрэв талууд тохиролцсон бол зээл, тусламж олгож буй талын тогтоосон журмыг баримтална” гэж тус тус заасан байна. Хуулийн энэ заалтад тендерийн харилцааг зохицуулж байсан 2003 оны хуулийн нэр бичигдсэнийг 2006 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж буй Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль гэж ойлгож хэрэглэвэл зохино.

Нөгөө талаар 2000 онд батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийн /цаашид хуулийн гэх/ 3 дугаар зүйлийн 3.2-т “Гадаадын зээл, тусламжаар бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тохиолдолд худалдан авах ажиллагааны нөхцөлийг олон улсын гэрээнд тусгайлан заагаагүй бол энэ хуулийг дагаж мөрдөнө” гэж заасантай, дээр дурдсан Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн заалт нийцэж байсан болно.

Харин одоо үйлчилж буй Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т заасантай Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “талуудын тохиролцооны асуудал” нь зөрчилтэй байх тул, илүү нарийвчилсан, мөн сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийг хэрэглэх нийтлэг зарчмыг үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтыг хэрэглэнэ.

Ингэхдээ Монгол улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай Монгол Улсын Дээд шүүхийн 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 9 дүгээр тогтоолыг сайтар судалж, мөрдөн ажиллавал зохино.

Гурав. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т “Эрх бүхий байгууллага шаардлагатай гэж үзвэл сонгон шалгаруулалтын үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгож болно” гэж заасан бөгөөд энэ сонгон шалгаруулалтыг Иргэний хуулийн 421 дүгээр зүйлд заасан уралдаант шалгаруулалтын хэлбэрээр явуулна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиар тогтоосон тендерийн ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих, гомдол гаргаж шийдвэрлүүлэх зохицуулалт нь тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгох харилцаанд үйлчлэхгүй.

Харин Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулж буй зарим үйл ажиллагааг эрхлэхэд олгох тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны холбогдох төв байгууллага сонгон шалгаруулалтын журмаар олгохтой холбогдсон маргааныг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, тухайн төрлийн аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах хуулийг баримтлан шийдвэрлэж байвал зохино.

Дөрөв. Хуульд заасан тендер ирүүлэх болон хүчинтэй байх, тендер нээх, тендер шалгаруулалтыг онцгой журмаар явуулахад баримтлах хугацаа зэргийг хуульд заагаагүй үндэслэлээр богиносгон тогтоох эрх захиалагчид байхгүйг анхаарах нь зүйтэй.

“Монгол даатгал” ХК-ийн нэхэмжлэлтэй, “МИАТ” ХК-ийн Тендерийн хороонд холбогдох захиргааны хэргийг Нийслэлийн захиргааны хэргийн шүүх 2006 онд хянан шийдвэрлэхдээ “хугацаа хожимдсон” тендер тул нээлгүй буцааж тендерээс хассан тендерийн хорооны шийдвэрийг зөв гэж дүгнэсэн байна.

Гэтэл Тендерийн хороо, богиносгосон хугацааг тогтоохдоо тендер хүлээж авах эхний хугацааг тендерийн урилга тараасан өдрөөс хойш 15 ба түүнээс дээш хоног байхаар заасан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай /2000 оны/ хуулийн 25 дугаар зүйлийн 25.8-д заасныг зөрчсөн байжээ. Яг ийм байдлаар одоо мөрдөж буй Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан хугацаа нь өөр хоорондоо хамааралтай, уялдаатай болохыг анхаарах шаардлагатай.

Тухайлбал; Энэ хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т захиалагч тендер хүлээж авах эцсийн хугацааг тендер шалгаруулалтыг анх зарлан мэдээлсэн өдрөөс эхлэн тооцож тогтооно. Мөн зүйлийн 24.3-т нээлттэй тендер шалгаруулалтын тухайд тендер хүлээн авах эцсийн хугацааг 30 буюу түүнээс дээш хоногоор, хязгаарлагдмал тендер шалгаруулалтын талаарх хугацаа буюу хуулийн 32 дугаар зүйлийн 32.5-д тендерийг хүлээн авах эцсийн хугацааг тендерийн урилга тараасан өдрөөс хойш 15 буюу түүнээс дээш хоногоор тогтооно гэж тус тус заасан байна.

Тав. Хуулийн 55 дугаар зүйлийн 55.2-т зааснаар төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвхөн гэрээ байгуулахаас өмнө гаргасан гомдлыг хянан хэлэлцэх эрхтэй тул гэрээ байгуулахаас өмнөх шатны захиалагчийн үйл ажиллагаанд шүүхэд гаргасан гомдлын тухайд маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхэд мөн зүйлийн 55.4-т заасан шаардлагыг анхаарвал зохино.

Энэ зүйлийн 55.4.1-т Тендерт оролцогчийн гомдлыг хангах нь илүү үндэслэлтэй байгаа бол;

55.4.2-т Түдгэлзүүлээгүй тохиолдолд тендерт оролцогчид их хэмжээний хохирол учрахаар бол;

55.4.3-т Түдгэлзүүлэх нь төрийн эрх бүхий байгууллага, эсхүл захиалагч болон бусад тендерт оролцогчдод илтэд хохиролтой биш бол түдгэлзүүлэх шийдвэр гаргаж болно гэж тус тус заасан нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-д тодорхойлсноос өөрөөр зохицуулжээ. Иймд маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхэд хуулийн дээрх заалт болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан үндэслэлийг харьцуулан үзэж, Захиргааны актыг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэж байх нь чухал. Харин гэрээ байгуулах эрх олгосноос хойш болон гэрээнд гарын үсэг зурснаас хойш гомдлыг шүүхэд гаргах тул шүүх маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхэд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан үндэслэл бий эсэхийг анхаарч шийдвэрлэх нь зүйтэй.

Зургаа. Хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-т “Шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь тендерийн үнэ байна” гэж заажээ. Гэвч тендерт оролцогч хэдийгээр хамгийн бага үнийн санал өгсөн боловч тендерийн баримт бичигт заасан

захиалагчаас тендерт оролцогчдоод зориулан гаргасан тендер шалгаруулалтын нөхцөл шаардлагыг хангаагүй тохиолдолд хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, 28 дугаар зүйлийн 28.1-д зааснаар захиалагч уг тендерээс татгалзах, үнэлгээ хийхгүй байх үндэслэл болгожээ.

Жишээлбэл: “Отгонтэнгэр трейд” ХХК-ийн нэхэмжлэлтэй, “Дулааны 3 дугаар цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компанид холбогдох захиргааны хэргийг 2007 онд анхан болон давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэхдээ тендерийн баримт бичигт заагдсан тухайн ажлыг гүйцэтгэхэд тавигдах шаардлагыг биш өөр шаардлага тусгасан тендер ирүүлсэн гэж дүгнэж, тендерээс хассан захиалагчийн шийдвэрийг хуульд нийцсэн гэж нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон байна.

Тендерийн харилцаатай холбогдсон захиргааны актын талаарх маргаан ээдрээ түвэгтэй, иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд сөрөг үр дагавар учруулахуйц байдаг тул шүүхүүд хэргийг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэж байх талаар анхаарч ажилмавал зохино.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

Ном зүй

Нэг. Үзэл баримтлал, хөтөлбөр

1. Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө, Улсын Их Хурлын 2000 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор батлагдсан.
2. Монгол Улсын шүүхийн менежментийг боловсронгуй болгох үзэл баримтлал, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2004 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан.

Хоёр. Хуулиуд болон эрх зүйн баримт бичгүүд

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хууль, 2002 он.
3. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он.
4. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2005 он.
5. Шүүхийн тухай хууль, 2002 он.
6. Иргэний хууль, 2002 он.
7. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он.
8. Эрүүгийн хууль, 2002 он.
9. Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002 он.
10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2002 он.
11. Аж ахуйн үйл, ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль,
12. Ашигт малтмалын тухай хууль, 2006 он.
13. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль.

14. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, 2004 он.
15. Захиргааны хариуцлагын тухай хууль, 1992 он.
16. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, 1995 он.
17. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, 2004 он.
18. Төрийн албаны тухай хууль, 2002 он.
19. Өмгөөлийн тухай хууль, 2002 он.
20. Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл, УБ хот, 2004 он
21. Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл, УБ хот, 2008 он.

Гурав: Ном зохиол, сэтгүүл

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ хот, 2007 он.
2. Б.Чимид, Монгол Улсын захиргааны хэргийн шүүхийн мөн чанар, нийгэм- эрх зүйн ач холбогдол – “Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг”, УБ., 2004 он.
3. С. Нарангэрэл, Эрх зүйн толь бичиг 2007 он
4. П.Одгэрэл. “Захиргааны эрх зүйн ерөнхий анги”, УБ хот, 2004 он.
5. А.Эрдэнэцогт, Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй, УБ хот, 2006 он.
6. Ю.Н.Старилов, Административная юстиция (Проблемы теории), ВГУ, 1998 он.
7. Т.Мөнхжаргал. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй (Ерөнхий анги), УБ хот, 2004 он.
8. Д.Баярсайхан. “Эрх зүйн онол”, УБ хот, 2000 он.
9. Г.Совд нар. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ хот, 2000 он.
10. Г.Батзориг. “Гэмт хэргийн нотолгооны ерөнхий онол”, УБ хот, 2002 он.
11. Б.Галдаа. “Монгол Улсын Нотолгооны эрх зүйн үндсэн асуудал”, УБ хот, 2001 он.
12. Friedhelm Hufen. Verwaltungsprozessrecht., 5.Auflage Verlag C.H.Beck Muenchen 2003.
13. В.Дурнер, “Монгол Улсын захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”, /Ханнс-Зайделийн сан/, УБ, 2004 он.
14. P.Lehmann, “Allgemeines Verwaltungsrecht”, Mьnchen, 1998.
15. E.Eyermann, Verwaltungsgerichtsordnung Kommentar, Verlag C.H.Beck, Mьnchen, 2000.
16. U.Battis, “Allgemeines Verwaltungsrecht”, C.F.Mьller Verlag, Heidelberg, 2002.
17. Ю.Ёоахимски. “Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар”, Мюнхен хот, 2004 он.
18. Хууль зүйн үндэсний төвөөс эрхлэн гаргасан цуврал гарын авлага, №7, УБ хот, 2005 он.
19. Хууль зүйн үндэсний төвөөс эрхлэн гаргасан “Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн” гарын авлага, УБ хот, 2004 он.
20. Төрийн мэдээлэл, Nr. 3., 2003.
21. Chimid, Das Wesen der Verwaltungsgerichtsbarkeit in der Mongolei, deren gesellschaftliche und rechtliche Bedeutung, in: HSS, Reformen in der Mongolei und Weltpraxis, Ulaanbaatar, 2004.

22. Developing Mongolia's Legal Framework A Needs Analysis, Hrsg. Asian Development Bank, 1995.
23. Scholler, Die Kontrolle der Verwaltung durch die Verwaltungsgerichtsbarkeit, in: „Ergezyel“ (Hintergrund), Ausgabe No. 3, Ulaan Bataar 1998.)

Хэрэглэгчдийн анхааралд:

Энэ ном нь Монгол Улсын шүүхийн шүүгчид, хуульчид, захиргааны байгууллагын ажилтнууд, ХБНГУлсын эрдэмтэн багш нар хамтран гаргасан анхны бүтээл учир номын талаархи саналаа 15170 Улаанбаатар хот, 40, 50 мянгат-1, Ж.Самбуугийн гудамж, Улсын Дээд шүүхийн байр, Захиргааны хэргийн танхим, утас: 261793, факс: 322699, и-мэйл: zandraa@supremecourt.gov.mn, <http://www.supremecourt.gov.mn/> хаягаар бидэнд ирүүлэхийг хүсье